



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



"ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ НЬ САЛБАР ДУНДЫН ШИНЖЛЭХ УХААН БОЛОХ НЬ - 2019"

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХТГЭЛ

УЛААНБААТАР
2019

ГАРЧИГ

ХӨГЖЛИЙН БЭРШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРГЭХ НЬ
Б.Луубаатар, Т.Амартүвшин 7

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СУРЧ,
БОЛОВСРОХ ЭРХИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА
Ш.Цэрэндолгор 11

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ
О.Хишигмөнх 16

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ
Р.Энхчулуун /МА/, Э.Агь-Марал 22

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
Б.Доржлагма 29

ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ХАМГААЛАЛД ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨЛӨӨЛӨХ НЬ
Б.Маргад-Эрдэнэ 32

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА
Э.Нинжбадгар, Б.Болороо, А.Азжаргал 35

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ АРГА ЗАМ
Б.Намсрай 44

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛТАЙ БАЙДЛЫН ЗОЛИОС НЬ ХҮНИЙ
ЭРҮҮЛ МЭНД ХОХИРОХ ЯВДАЛ ХЭРХЭВЧ БАЙХ ЁСГҮЙ
Э.Энхболд 47

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛД ҮЛ ХАЙХРАХ БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ
Б.Баясгалан, Н.Нандинцэцэг, Ч.Тамир 51

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ТҮҮНИЙ АСРАН ХАМГААЛАГЧИД
ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТУРШИХ НЬ
Э.Хэрлэнтуяа, Б.Оюун-Эрдэнэ 58

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
Э.Самбуу, С.Мягмарсүрэн, Э.Орхонтуул 63

ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН СЭРГЭЭН ЗАСАХ АМБУЛАТОРИЙН ТАСГИЙН
ХЯНАЛТАНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН НИЙГМИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА
Р.Отгонсайхан, Х.Циендолгор, Н.Баяржаргал 66

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТЭГШ ЭРХИЙН БАЙДАЛ
Ж.Ганболд 69

БОЛОВСРОЛ

БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАЛЦАГЧИЙН ОЮУНЫ ХӨГЖЛИЙГ ҮНЭЛЭХ ТАНАКА БИНЕ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН <i>Кенжи Номура, Д.Одгэрэл, Г.Энхжаргал, Г.Батжаргал, Д.Баяраа</i>	78
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ <i>М.Мөнхзул, Ц.Цэцэнбаатар</i>	85
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ СУРГУУЛИЙН ОРЧИНД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СУРГАЖ, ХӨГЖҮҮЛЭХ НЬ <i>Б.Аминдаваа</i>	92
ХҮҮХДИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ СУРГАЛТАНД ХАРГАЛЗАХ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА - ҮР ДҮН <i>Ч.Наранцэцэг</i>	96
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙГ СУДАЛСАН НЬ <i>Ж.Нямцэцэг, Г.Уянга, Б.Туяа, П.Лхагваторгох, Р.Нэнсэндэн, Д.Цогзолмаа</i>	98
ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА <i>Ч.Нямдорж</i>	102
СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛЭЭР ХӨГЖҮҮЛЭХ НЬ <i>Г.Ням-Осор, Х.Нямсүрэн</i>	108
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛД <i>Ц.Цэвэгмид, Б.Гэрэлтуяа</i>	115
АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГИЙН ДАВУУ ТАЛЫГ СУРГАЛТАД ХАРГАЛЗАХ НЬ <i>Б.Сарантуяа, Л.Мөнгөнцэцэг</i>	122
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ <i>М.Номин-Эрдэнэ, Г.Бадамханд</i>	126
ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАГЧДЫГ ХҮЛЭЭН АВАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СОЁЛЫН ОРЧНЫ БЭЛЭН БАЙДАЛ <i>Г.Жаргалмаа, А.Очбадрал, Д.Одгэрэл (Ph.D)</i>	129
СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ, ОНЦЛОГ <i>Ц.Алтанцэцэг</i>	136
ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ХАМТАРСАН СПОРТООР ДАМЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ НЬ <i>Б.Ганболд, С.Эрдэнэбаатар</i>	138
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧНЫ ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ <i>Ч.Жаргал</i>	142
ИРГЭДИЙГ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ <i>Б.Баттуяа, Ж.Нарантуяа, Г.Батням</i>	148

ЭРҮҮЛ МЭНД

ГУЯНЫ АРЫН БУЛЧИНГИЙН ЧАНГАРАЛ НЬ НУРУУНЫ ӨВДӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ SITSMART АШИГЛАН СУУХ БОЛОН ЭНГИЙН СУУХ ҮЕИЙН НУРУУН ДЭЭР ИРЭХ АЧААЛАЛ БОЛОН ААРЦАГНЫ ЭРГЭЛТИЙГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ <i>Н.Цэсэнжав, М.Эрдэнэтуяа</i>	154
СУРГУУЛИЙН ӨМНӨХ АХЛАХ НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ЭРТ ҮЕИЙН ИЛРҮҮЛЭГ, ДЭМЖЛЭГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН <i>Х.Алтанхундага, Б.Туяа</i>	159
ГУЯНЫ АРЫН БУЛЧИНГИЙН (M.HAMSTRING) ЧАНГАРАЛ НЬ АЛХАА БОЛОН ТӨРХ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ <i>Э.Баасанхүү, Д.Батлхам</i>	166
ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ХЭЛ ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНД ГАРСАН ҮР ДҮНГ СУДЛАХ <i>Б.Золбоо, Т.Цэцэгмаа, Б.Эрдэнэцэцэг, Г.Буянжаргал</i>	169
ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДЭД УРТ ХУГАЦААНД ХИЙГДСЭН ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ СУДЛАХ <i>А.Батчимэг, Т.Уянга, Т.Батгэрэл, Г.Буянжаргал</i>	172
ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ЧАДВАРЫГ СУДАЛСАН НЬ <i>Т.Лхагвасүрэн, Д.Гэрэлмаа, Д.Жандаулет, Б.Анхбаяр, Г.Буянжаргал</i>	174
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД <i>Г.Ганбаатар</i>	176
СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ХӨТӨЛБӨР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН ХООЛ ШИМ ТЭЖЭЭЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДИТ НЭГЭН ИЛРЭЛ БОЛОХ НЬ <i>М.Пүрэвжав, С.Нямцэцэг, Ж.Нямцэцэг, Д.Энхмягмар, Н.Ууганцэцэг, Ч.Өлзийбүрэн, Ж.Балжинням</i>	178
ТӨРӨЛХИЙН ДҮЛИЙ БОЛОН СОНСГОЛ БУУРАЛТЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮР ДҮН <i>Ч.Саруул, Г.Оюун, Д.Ариунтуяа, Ц.Золзаяа, Л.Раднаацэрэн, Б.Дэлгэрмаа, М.Баялаг, Пэйж Стрингер</i>	184
АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН ТУРШЛАГААС <i>Г.Нямпагма</i>	188
ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГАНЦААРДАХ МЭДРЭМЖ НЬ ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БУЙГ СУДАЛСАН НЬ <i>Л.Номин-Эрдэнэ, Н.Оюунжаргал, Д.Дарьмаа</i>	193
ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН <i>Ц.Батчимэг, Д.Тэгшжаргал, Д.Билгүүн, О.Эрдэнэтуяа, Ц.Наранцэцэг</i>	197
НАСНЫ ДОРОЙТОЛ ХӨГЖЛИЙН БЭХШЭЭЛД ХҮРГЭХ НЬ <i>Д.Болор, Б.Золзаяа, Т.Дулмаа, Б.Эрдэнэчимэг</i>	200

ТЕХНИК, ТЕХНОЛОГИ

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН УХААЛАГ ТАЯГ <i>Б.Билгүүн, Х.Гомбо, Б.Дорж, Т.Амартүвшин</i>	203
ХЭЛ ЯРИАНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН УХААЛАГ БЭЭЛИЙ <i>Ө.Өлзийбадрах, Н.Мягмаржав, Т.Амартүвшин, Б.Дорж</i>	208

ХҮРТЭЭМЖ

ХОТ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СУРАХ ОРЧИН, АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ХҮРТЭМЖИЙН СУДАЛГАА <i>Н.Нарантуяа, И.Гончигбат</i>	211
О.ТЛЕЙХАНЫ НЭРЭМЖИТ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН БАРИЛГЫН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА <i>Н.Шаарийбуу, С.Батцэрэн, А.Дөлгөөнхангай, А.Өэлүн</i>	218

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ХАМРУУЛАН СУРГАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ <i>Магистр Б.Дэлгэржаргал</i>	229
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ <i>Б.Одончимэг</i>	234
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ <i>Д.Энхжаргал, Н.Баяртуяа, Б.Батбаяр</i>	238
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ БАЙНГЫН ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙРТАЙ БОЛГОХОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ИЛРҮҮЛЭХ, ХОЙШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ <i>Б.Гүнжилмаа, Г.Осоржалам, М.Чулуун-Эрдэнэ</i>	241
ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ СУДЛАХ НЬ <i>Г.Уянга</i>	246
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА <i>М.Уянга, Т.Золзаяа</i>	253

Огнох үр



Хөгжлийн бэрхшээлийн салбар нь нэг салбарын асуудал байдаггүй харин хүний амьдралыг тойрсон бүхий л үйл ажиллагаатай холбоотой асуудал байдаг гэдгийг салбар тус бүрийн хийж байгаа ажил, үйл ажиллагаа болон үйлчилгээнээс харах боломжтой. Тийм ч учраас салбаруудын уялдаа холбоо, төлөвлөлт зохион байгуулалтыг бүрэн ханган ажиллаж чадсанаар бид илүү “Хүртээмжтэй ирээдүй”-г цогцлоож чадах юм.

Энэхүү уялдаа холбоог бий болгоход тухайн салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, оюутан залуусын дэвшүүлж байгаа асуудал, хийгдэж байгаа судалгаа болон гаргасан үр дүнгүүд нь илүү оновчтой шийдлүүдийг гаргах суурь үзүүлэлт болж өгдөг.

Мөн өнөө цагт шинжлэх ухаан, техник технологи асар хурдтай хөгжиж бүх салбарт өөрчлөлт, шинэчлэлтийг авчирч байгаа бөгөөд манай салбарын хувьд ч бас нөлөөгөө үзүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илүү хүртээмжтэйгээр нийгмийн амьдралд оролцох боломжуудыг бий болгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тойрсон асуудлуудад ч бас

шинжлэх ухаан, техник технологийн шийдлүүдийг ашиглах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймээс бид энэ салбарт хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажлуудыг нэгтгэх, олон нийтийн хүртээл болгох, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, шинэ ололт, санааг дэмжих, эрдэмтэн, судлаач, оюутан залуусыг идэвхжүүлэх зорилгоор 2013 оноос хойш жил бүр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж ирсэн.

Жил бүр бидэнд илгээж байгаа эрдэм шинжилгээний өгүүллүүд илүү чанаржиж, илүү олон оролцогчид хамрагдах болсон нь энэ салбарт анхаарлаа хандуулж, мөн асуудал дэвшүүлэх бус түүнийхээ шийдлийг олж харж байгаа залуус нэмэгдэж байгаад туйлын их баяртай байна.

Эрдэм шинжилгээний хуралд жил бүр идэвхтэйгээр оролцдог болон шинээр судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлж оролцож байгаа нийт багш, эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, оюутан залуусдаа талархлаа илэрхийлж, цааш цаашдынх нь ажил үйлсэд өндөр амжилтыг хүсэж байна.

Мөн тус эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад хамтран ажилласан Монгол Улсын Их Сургууль болон туслалцаа, дэмжлэг үзүүлсэн Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам, Боловсролын хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн хамт олонд талархал илэрхийлье.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНЧИМЭГ



ХӨГЖЛИЙН БЭРШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРГЭХ НЬ

Б.Луубаатар¹, Т.Амартүвшин²

^{1,2} ШУТИС, МХТС-ийн Электроникийн салбар

luubaatar@must.edu.mn

amartuvshin@must.edu.mn

Хураангуй:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр тутмын амьдралын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тэдэнд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл саадыг арилгахад туслах нь инженер, судлаач бидний нийгэмд хүлээж буй үүрэг юм. НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц (UNCRPD)-ийн түвшинд улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бодлогыг хэрэгжүүлэхэд ухаалаг гар утас, эмбэддэд систем, ухаалаг орчин зэрэг тоон технологи, мэдээлэл харилцаа холбооны технологийн шинэ дэвшлүүдийг ашиглахаар зорьж байна [1]. Бодлоороо удирддаг хиймэл гар, аутизмтай хүүхдэд зориулсан тайвшруулах дэлгэц бүхий төхөөрөмж, хүний тархины цахилгаан бичлэгийг унших төхөөрөмж, ухаалаг цагаан таяг зэрэг дэвшилтэт технологид суурилсан төхөөрөмжүүдийг бүтээх боломж ч манай улсад бий. Өнөөдрийн байдлаар монгол инженерүүд бид юу хийж байна вэ? Бодлоороо удирдах боломжтой хиймэл гар, дохионы хэлийг дуу авиа болгон хөрвүүлэх бээлий бүхий төхөөрөмж, текстийг дуу авиа болгох төхөөрөмж, хараагүй хүнд зориулсан ухаалаг таяг, мэдрэгч орчин үүсгэн хүний хөдөлгөөн болон биеийн байдлыг хянан мэдээлэх системийг бүтээхээр судалгаа, туршилтын ажлуудыг оюутнуудтайгаа хамтран гүйцэтгэж байна. Эдгээр судалгааны ажлуудын үр дүнг танилцуулахын зэрэгцээ цаашид бид юу хийж чадах вэ гэдэгт өөрсдийн дүгнэлт хийлээ.

Түлхүүр үг:

Ухаалаг таяг, мэдрэгч бүхий орчин, хиймэл гар, хиймэл хөл

Үндэслэл:

Хүн нийгэм, хүрээлэн буй орчинтойгоо үйл хөдлөл болон хэл яриагаараа чөлөөтэй харьцаж үзэл бодлоо илэрхийлэн сэтгэл ханамж, таашаал хүртдэг. Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөлийг сайжруулах, тэдэнд тавих

халамж, анхаарал хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор олон жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан системтэйгээр ажилладаг [2-4]. Манай улсын хувьд Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна [5]. Хөтөлбөрийн долдугаар бүлэгт 2017-2025 онд мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цахим хуудас боловсруулах, програм хангамж боловсруулах 7 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Бодлого тодорхойлдог яам, нэгж хэсгээс өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй тоног төхөөрөмж, монгол хэл дээр дэлгэц уншигч, өнгө, дүрс, дулаан, гэрэл, мөнгө таних тусгай хэрэгцээт програм хангамж зэргийг бүтээх, хөгжүүлэхэд шинжлэх ухааны салбар салбарын эрдэмтэн, инженерүүдийг нэгтгэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн төдийгүй хувь хүний хэрэгцээг хангах ажил илүү үр дүнтэй болно.

Бид юу хийж байна вэ?

Хиймэл гар, хөл

Өнөөдрийн зах зээлд хиймэл гар, хөл стандартын хэлбэр хэмжээ, зориулалтын материал, хийцээс хамааран ойролцоогоор 5000-50000 ам.долларын үнэтэй байдаг. Иймээс аль болох хямд өртгөөр асуудлыг шийдэх зорилгоор олон бүтээл, туршилтуудыг хийсээр байна. Жишээлбэл, 2018 оны эхээр Испанийн 19 настай залуу инженер Дэвид Агилар “Lego” тоглоом ашиглан өөртөө хиймэл гар анх бүтээснээс хойш нэг жилийн хугацаанд МК загварын дөрвөн хиймэл гараа бүтээжээ. Уг хиймэл гараар хүчний ажил хийхгүй ч өдөр тутмын амьдралд хангалттай үйлдлийг хийх боломжтой. Мэдээж түүний бүтээсэн гарын өртөг хиймэл гарын зах зээлийн үнээс маш бага юм [6]. Их Британийн Open Bionics компанийн бүтээсэн Hero Arm хиймэл гар 8 наснаас дээш хүүхдүүдэд зориулагдсан бөгөөд сарвууны олон функцтэйгээс гадна гаднах дизайныг

хүүхдүүдийн дуртай киноны баатруудын өмсгөлтэй ижил байхаар хэвлэсэн нь гоо зүйн мэдрэмжийг нэмэгдүүлдэг [7]. Него Arm хиймэл гарыг зах зээлд 149-519 фунт стерлингээр худалдаалж байна.


Харин бидний хувьд дараах судалгааны ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:

- Доктор Ц.Тэнгисийн удирдаж буй “Бионик гарын хөгжүүлэлт” ажлаар нийт жин 700гр-аас хэтрэхгүй ч 5кг ачаа даах, хуруу тус бүрийг удирдах боломжтой, тасралтгүй хөдөлгөөнтэй үед 2 цаг, idle горимд 10 цаг барих батарейтай, тэжээл дуусах дөхсөнг мэдээлдэг хиймэл гарыг бүтээхээр ажиллаж байна (Зураг 1). Цаашлаад Neurosky Mindwave болон булчингийн мэдрүүрийг хослуулан хуруу, бугуйн хөдөлгөөнийг удирдах, хөдөлгөөний зэргийг нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байна.



Зураг 1. “Бионик” гарын эхний загвар

- Т.Амартүвшингийн удирдаж буй “Хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд зориулсан төхөөрөмж” ажлаар хуруу бүр дээр байрлах уян мэдрэгч, хурдатгал болон өнцөг хэмжигч мэдрүүрүүдтэй бээлий бүхий төхөөрөмж бүтээхээр ажиллаж байна (Зураг 2). Зурагт үзүүлснээр бээлий өмссөн хэрэглэгчийн гарын хөдөлгөөний дохиог гар утас хүлээн авснаар ухаалаг утсанд суулгасан хэрэглэгчийн програмаас тухайн хөдөлгөөнд тохирох авиа гаргах юм. Одоогийн байдлаар эхний загвар гарч 35 үсэг болон өргөн хэрэглэдэг цөөн үгнүүдийг таних ажил хийгдэж байна. Энэхүү судалгааны ажилд дохионы багш Б.Саранчимэгийн зөвлөгөөг авч байгаа юм.




Зураг 2. Хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд зориулсан төхөөрөмжийн ерөнхий бүтэц

Өндөр настай хүмүүсийг хянах төхөөрөмжүүд

Дэлхий ойрын хэдэн арван жилд асран хүмүүжүүлэгчдийн хомсдол, өндөр настай хүн амын тоо нэмэгдэх болно. НҮБ-ын мэдээлснээр 2017 онд ахмад настны тоо дэлхийн хэмжээнд 962 сая байсан бөгөөд 2050 он гэхэд хоёр дахин (2.1 тэрбум), 2100 тэрбумаас 3.1 тэрбумаар нэмэгдэх төлөвтэй байна. Судлаачид RGB/depth камер [8] ба өмсөх төхөөрөмж [9] ашиглан олон төрлийн хөдөлгөөн, уналт таних системийг санал болгон хэрэгжүүлсээр байна. Үүний нэгэн адил доктор Г.Мөнхжаргал 2013 оноос хойш Тайваны их сургуулийн эрдэмтэдтэй хамтран мэдрэгч бүхий орчин үүсгэн туршилт, судалгааны ажлууд хийж байна. Заримаас нь дурьдвал:

- “Андройд дээр суурилсан өндөр настай хүмүүсийн уналтыг илрүүлэх платформ” нь гурван хэмжээст хурдатгал хэмжигчийг ашиглан уналтыг илрүүлэх, уналт илэрсэн үед цаг алдалгүй эмнэлгийн тусламж хүргэх боломжийг олгоно. Уналт илрүүлэлт 92.5% үзүүлэлттэй байв [10].
- “Гурван имфра улаан мэдрэгчтэй орчинд хүний хөдөлгөөнийг таних” судалгааны ажлаараа утасгүй мэдрэгч сүлжээ үүсгэн, мэдрүүрүүдийн мэдээллээс машин сургалтын арга ашиглан хүний хөдөлгөөний төрлийг таньсан нь шинэлэг ажил болсон. Уг систем нь гэртээ ганцаараа байдаг өндөр настан хүмүүсийн хөдөлгөөний хэмнэлийг хянах, ойр дотны хүмүүст нь мэдээлэл өгөх үүрэгтэй. Зураг 3-т системийн ерөнхий бүтэц, дохио боловсруулалтын аргыг харуулав [11].




Зураг 3. Инфра улаан туяаны мэдрэгч бүхий орчны мэдээллээс хүний хөдөлгөөний төрлийг таних систем

Ухаалаг, цагаан таяг

Хүн, хүрээлэн буй орчны мэдээллийн 75-90 хувийг нүдээрээ хүлээн авдаг. 2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад 16610 харааны бэрхшээлтэй иргэн байгаагийн Улаанбаатар хотод 4600 иргэн амьдарч байна гэсэн судалгаа бий [12]. Тэдэнд зориулсан, ухаалаг үйлдэлтэй таяг хийх нь олон улсад яригддаг асуудал бөгөөд энэ чиглэлээр дэлхийн томоохон компани, их дээд сургуулиуд судалгааны ажил гүйцэтгэн төрөл бүрийн загвартай бүтээхээр оролдож байна. Жишээлбэл, 2018 оны 11 сард Туркийн инженер, харааны бэрхшээлтэй Курсат Цейлан (Kursat Ceylan) нь өөрт тохиолддог хүндрэлээ шийдэх зорилгоор WeWalk таягийг бүтээсэн бөгөөд худалдаанд 449 ам.долларын үнэтэй борлуулагддаг [13]. Уг таягийн тусламжтайгаар хэрэглэгч 160 см зайнаас саадыг мэдрэх, гар утасны WeWalk програмын тусламжтайгаар явж буй байршлаа мэдэх боломжтой. Харин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төхөөрөмжүүд зохион бүтээдэг Энэтхэг улсын Phoenix компанийн 90 ам.доллараар борлуулагдаж буй таяг нь зөвхөн саадыг мэдрэх боломжтой ч жирийн таяганд угсарч суурилуулдаг, хэрэглэгч өндрөөсөө хамааран мэдрүүрийн байрлалыг өөрчлөх боломжийг олгодог [14].

Доктор Б.Дорж, Т.Амартүвшин нарын удирдаж буй “Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан ухаалаг таяг” судалгааны ажлаар Phoenix таягтай ижил таяган суурилуулах зориулалттай, хэрэглэгч төөрсөн үед “Аваарын товч” дарснаар түүний ойр дотны хүнд байрлалын мэдээллийг мессежээр илгээх боломжтой төхөөрөмжийн техник, програм

хангамжийн гаргахаар ажиллаж байна. Зураг 4-т ухаалаг таягийн ерөнхий бүтэц, Зураг 5-д төхөөрөмж, түүнийг таяганд суурилуулсанг харуулав.



Зураг 4. Саад мэдрэгч, байршил мэдээлэгч системийн бүтэц



Зураг 4. Төхөөрөмжийн бодит хэмжээ, таяганд суурилуулсан байдал

Бид юу хийж чадах вэ?

Өнөөгийн технологийн дэвшилүүд болон монгол инженерүүдийн хүрсэн түвшин, тэдний

хийж байгаа, хийж гүйцэтгэсэн төслүүдийг тооцож үзвэл бид ч бас тодорхой зүйлсийг хэрэгжүүлэх чадвартай болох нь харагдаж байна. Дээр дурьдсан төхөөрөмжүүдээс гадна дүрсийн боловсруулалт, машин сургалтын арга зэргийг ашиглан дохио таних хэрэгсэл, текстийг дуу авиагаар уншигч төхөөрөмж, Брайлийн машин мөн, хүний тархины цахилгаан бичлэгийг уншиж чадсанаар хүссэн хөдөлгөөнөө хийх, удирдах төхөөрөмжүүд (гар, хөл болон бусад)-ийг бүтээх боломжтой болно. Мөн, механикийн инженерүүд, сэргээн засах эмч нартай хамтран нугасны гэмтэлтэй хүмүүст зориулсан өөрөө явдаг хөл, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэргэнцэр бүтээх боломж бидэнд бий. Төхөөрөмж бүтээнэ гэдэг нь маш их хөрөнгө, цаг хугацаа шаардсан, судалгаа, туршилт, хөгжүүлэлтийн ажил байдаг учраас олон талт үйл ажиллагааны хүрээнд зөв менежменттэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Хэдийгээр технологийн дэвшлийг шингээсэн гадаадын өндөр чанартай бүтээгдэхүүнүүд бий болсон ч монгол хүний онцлогт тохирсон бүтээгдэхүүнүүд хэрэгцээтэй байгаа нь харагддаг. Ялангуяа, хэл яриа харилцаатай холбоотой асуудлууд нь монгол хэлээр байх ёстой учраас дотоодын нөөцөөр үүнийг шийдвэрлэх нь зайлсхийх аргагүй асуудал юм. Иймээс технологийн дэвшил түүнийг эзэмшсэн, эзэмшиж байгаа инженерүүдийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлуудыг шийдвэрлэхэд өргөнөөр ашиглах шаардлагатай нь зүй ёсоор харагдаж байна.

Ном зүй

- [1] “United Nations Convention on the Rights of Persons with Disabilities”, Dec. 2008.
- [2] “Commonwealth of Australia, National Disability Strategy”, 2010–2020, 2011.
- [3] “New Zealand Disability Strategy”, 2016-2026.
- [4] “European disability strategy”, 2010-2020.
- [5] “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, Мэдээллийн лавлах, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, 2017.
- [6] “Prosthetic Arms From LEGO Bricks”, David Aguilar, 2019.
- [7] <https://openbionics.com>
- [8] K. Adhikari, et al., “Activity Recognition for Indoor Fall Detection Using Convolutional Neural Network,” in Proc. 15th Int. Conf. on Machine Vision Applications, 2017, pp. 81–84.
- [9] J. Wang, et al., “Wearable Sensor Based Human Posture Recognition,” in Proc. IEEE Int. Conf. on Big Data, 2016, pp. 3432–3438.
- [10] TH Tan, M Gochoo, CS Chang, CT Wu, “Fall detection for elderly persons using android-based platform”, JY Chiang - Energy, 2013
- [11] M Gochoo, TH Tan, T Batjargal, SC Huang, “Non-Intrusive device-free posture recognition for elderly people using deep learning and infrared sensors”, 2017.
- [12] Ч.Даариймаа, С.Байгалтөрс, “Харааны бэрхшээлтэй залуучуудад цахим хэлбэрээр боловсролыг хүргэх арга зам”, Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь-2018 ЭШХ-ын эмхтгэл, х100, 2018.
- [13] <https://wewalk.io/en/product/wewalk-smart-cane>
- [14] <https://www.phoenixmedicalsystems.com>

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СУРЧ, БОЛОВСРОХ ЭРХИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Ш.Цэрэндолгор^{1,2}

¹МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн магистрант,
²“Ундрах гэгээн үйлс” ТББ-ын ажилтан

Түлхүүр үг:

Хүний эрх, конвенц, тусгай сургууль, ангилал, ялгагварлан гадуурхалт

Хураангуй:

Хүний эрхийг тунхаглан, хүндэтгэн дээдлэх болсон өнөө үед дэлхий нийтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хөндөн, авч үзэх болсон бөгөөд энэ нь дан ганц манай улсын асуудал биш олон улсын асуудал болон хөндөгдөж байгаа билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас /цаашид “НҮБ” гэх/ 2006 онд баталсан бөгөөд манай улс тус конвенцид 2009 онд нэгдэн орсон билээ.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2018 оны эцэст Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46,0 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээс үзэхэд 2018 онд манай улсын нийт хүн амын тоо 3.238.479 байсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо ойролцоогоор Монгол Улсын нийт хүн амын 3.2%-ийг эзэлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй бөгөөд төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Өөрөөр хэлбэл сурч боловсрох эрх нь Монголчууд бидний зайлшгүй эдлэх үндсэн эрхийн нэг юм. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд боловсрол эзэмшихэд бусадтай адил тэгш боловсрол эзэмшихэд эрх зүйн орчин бүрдсэн боловч хэрэгжилт хангалтгүй, ялгагварлан гадуурхах, үл тоомсорлох хандлага байсаар, эрх ашиг нь зөрчигдсэн хэвээр байна.

Үндэслэл

Сэдвийн судлагдсан байдал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг боловсрол, нийгэм, анагаах ухааны талаас судалсан ном, бүтээл, судалгааны ажлууд их байдаг ч хууль эрх зүйн орчны хөгжил, хэрэгжилтийг гадаад орны туршлагатай харьцуулан судалсан судалгааны бүтээл харахан гараагүй байна.

Харин Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 2009, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэл” зэрэг цөөхөн бүтээлд л зөвхөн хууль, эрх зүйн зохицуулалт болон хэрэгжилт талаас нь судалсан байна.

Судалгааны ажлын зорилго

Уг судалгааны ажлын гол зорилго нь өөрийн орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаарх хууль, эрх зүйн орчны зохицуулалтыг олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад орны зохицуулалтуудтай харьцуулан судалж, өөрийн орны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах арга замыг эрэлхийлэх юм.

Судалгааны ажлын зорилт

Дээрх судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

- Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаарх эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалыг судлах
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн талаарх эрх зүйн зохицуулалтыг судлах
- Гадаад орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаарх

эрх зүйн зохицуулалтыг судлах

- Харьцуулсан судалгааны үр дүнд өөрийн дүгнэлтийг дэвшүүлэх

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажилд түүхчилэн судлах ба харьцуулах, баримт бичиг судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэнэ. Мөн гадаадын болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын эрхлэн гаргасан ном, товхимол, өгүүлэл, тоон баримт буюу бодит практик дээр үндэслэн дүгнэлт хийсэн буюу дискриптив арга, хууль эрх зүйн заалт, түүний хэрэгжилтийн гарч буй хүндрэл бэрхшээл зэргийг онол арга зүйн хэрэглүүр болгон ашигласан болно.

Үр дүн, Хэлцэмж

1. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаарх эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

Боловсролын салбар нь өргөн хүрээтэй, Боловсролын багц хууль болон бусад хуулиудаар зохицуулагддаг харилцаа билээ. Энэ хэсэгт зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай бие даасан хуулиудын талаар авч үзсэн болно.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг анх 1995 онд батлагдсан “Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль”-иар зохицуулсан гэж үзэж байна. Энэхүү хууль нь 15 зүйлтэй, бие эрхтний нөхөн сэргээлт, боловсрол сургалт, хөдөлмөр эрхлэлт, соёл, урлаг, биеийн тамирын арга хэмжээ зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээ, асрамж, халамжийн үйлчилгээ авах эрхийг зохицуулсан. Тус хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараахь хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ.

2005 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” нь 13 зүйлтэй, 6 удаа томоохон

нэмэлт өөрчлөлт орсон, нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, сэргээн засал, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдлэх эрхүүдийг утгаж өгсөн байна. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж тодорхойлсон бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох эрхийг хуульчилж өгсөн байна.

Тухайлбал тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсэгт “Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтад оруулахаас татгалзахыг хориглоно” гэж заасан бөгөөд 7.4 дэх хэсэгт “Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардлыг сургалтын төрийн сан хариуцна” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэгүй, чөлөөтэй сурч боловсрох, хүссэн мэргэжлээ эзэмших боломжийг олгосон байна. Эдгээр хуулиуд нь анагаахын шинжлэх ухааны загвар буюу хамт олонд түшиглэн сэргээн засах (CBR) хандлагад тулгуурласан болохыг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлсон тодорхойлолтоос харж болох юм.

Манай улс НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцийг соёрхон баталсны дараа 2016 онд бие даасан хуулийг баталсан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” нь хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтын шинэ хандлагыг нэвтрүүлж, нэгдэн орсон олон улсын баримт бичгийн үзэл баримтлалд нийцүүлэн баталсан хууль юм. Тус хуулинд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн

амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно.

Тус хуулийн 14, 15 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хуульчилсан байх бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулахад сурч боловсрох эрхийг тунхаглахаас гадна төрийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сурч боловсрох нөхцөл зэрэг илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй зохицуулалттай хууль болсон гэж үзэж байна. Мөн энэ хууль нь дээр дурдсанчлан олон улсын баримт бичгийг соёрхон баталсны дараа гарсан хууль тул орчин үеийн олон улсын хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх (CBID) хандлагад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өвчтөн, аймшигтай зүйл мэт үзэхээс илүү бие даан амьдрах боломжит нөхцлийг нь бүрдүүлээд өгвөл бусадтай л адил үнэ цэнэтэй хүн гэдэг талаас нь тодорхойлсон өргөн цар хүрээтэй хууль болсон гэж үзэж байна.

Дээд боловсролын тухайд Монгол Улсын Их Сургуульд гэхэд 2017-2018 оны хичээлийн жилд нийт 107, 2019-2020 оны хичээлийн жилд нийт 111 хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцаж байна гэсэн мэдээлэл байна. Гэвч энэ тоо нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоотой харьцуулахад маш цөөхөн байна.

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1599 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна.

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1087 хүүхэд цэцэрлэгт, 6518 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна.

Дээрх тоон судалгаануудыг харьцуулан үзэхэд ерөнхий боловсрол болон дээд боловсрол эзэмшиж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдийн тоо маш цөөхөн байна. Ялангуяа бакалавр, магистр, докторын сургалтын төлбөрийг төрийн сангаас хариуцдаг, хөнгөлөлт эдлэх боломж байдгийг оюутнууд төдийлөн мэддэггүй, төрийн сангийн буцалтгүй тусламжийн талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй байна.

2. Олон улсын баримт бичиг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэгт тархины саажилт, нугасны ивэрхий, булчингийн сулрал, нуруу нугасны гэмтэл, Дауны хам шинж, мөн хараа, сонсгол, бие бялдар, харилцааны болон оюун ухааны эмгэг зэрэг эрүүл мэндийн нөхцөл байдалтай хүүхэд багтана. Зарим хүүхэд төрөлхийн эрүүл мэндийн байдал, эмгэгийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй байдаг бол зарим нь гэмтэл, бэртэл, өвчин, хоол тэжээлийн дутагдал зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болдог

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг тунхагласан байна. Үүнд:

- Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчилалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараахь зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно;
- Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тулд оролцогч улсууд нь дараахь зүйлийг оролцуулан шаардлагатай бусад арга хэмжээг авна:
 - а) брайль үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон сурагч нараас үзүүлэх туслалцаанд дэмжлэг үзүүлэх
 - б) дохионы хэл сурахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих
 - в) мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хүмүүс, ялангуяа хараагүй, дүлий, хараагүй-дүлий хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маягаар олгох явдлыг хангах

Конвенцийн уг заалт нь тэгш хамруулан хөгжүүлэх хандлагыг тунхагласан, хөгжлийн бэрхшээлтэй бүх иргэдийг бага, дунд, дээд бүх төвшний боловсролд тэгш хамрагдах боломжоор хангахыг оролцогч улсуудад даалгасан, хөгжлийн бэрхшээлийн төрлөөс үл хамаарч бүх иргэдийг боловсролтой болгох ёстой гэсэн зарчмыг агуулсан байна. Иймд оролцогч улсуудын буюу манай улсын үндэсний хууль тогтоомж нь конвенцийн уг заалтын гол зарчмыг баримталж, хуулиндаа тусгах шаардлагатай байна.

3. Гадаад орны эрх зүйн зохицуулалт

АНУ-ын эрх зүйн зохицуулалтын онцлог

Одоогоос 15 гаруй жилийн өмнө АНУ-ын сурган хүмүүжүүлэх ухааны сэтгүүлүүдэд тусгай боловсрол, бүх нийтийн боловсролын хамтын ажиллагааны талаар боловсролын нэг тогтолцоо нөгөө тогтолцооноос салангид, ЕБС-ийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурган хүмүүжүүлэх тусламж үзүүлэхийн тулд тусгай сурганы арга зүй, технологийг эзэмших сонирхолгүй байгаа талаар бичиж тэмдэглэх болсон байна. Түүнээс гадна ЕБС-ийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тусгай сургуульд тусгай багш нар ажилладаг, тэд л ажиллах ёстой гэсэн байр сууринаас хандаж байсан байна.

АНУ-д 1975 онд батлагдаж үйлчилж байсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хуулийг 1990 онд шинэчлэн өөрчилж Чадварын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хуулийг /Individuals with Disabilities Education Act/ баталсан юм. Энэхүү хуулийн дагуу хүүхдийн хөгжлийг үнэлж тусгай хэрэгцээг илрүүлэх, тодруулах, оношлох, тодорхойлох, ганцаарчилсан хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулах гэсэн дэд томоохон үйл явцуудыг хамааруулан үзэж хэн, хэзээ, хаана, хэрхэн яаж үүнийг хэрэгүүлэх талаар нэлээд дэлгэрэнгүй, маш тодорхой зааж өгсөн байна.

АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлийг аутизмын хүрээний эмгэг, сонсгол-харааны хам бэрхшээл, сонсголын бүрэн алдагдал, хөгжлийн хоцрогдол, сэтгэл хөдлөлийн эмгэг, сонсголын бэрхшээл, оюуны хөгжлийн бэрхшээл, оюуны хөгжлийн бэрхшээл хосолсон хам шинж, тулах эрхтний бэрхшээл, эрүүл

мэндийн бусад эмгэг, сурах үйлийн бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, гэмтлийн гаралтай тархины гэмтэл, харааны бэрхшээл, харааны бүрэн алдагдал хэмээн ангилсан байна.

Япон улсын эрх зүйн зохицуулалтын онцлог

Япон улс өөрийн үндэсний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож 2011 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон байна. Тус улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, ашгийг хамгаалсан 30 гаруй хууль тогтоомж байдаг байна. Япон улс “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай суурь хууль”-г 1970 онд баталсан бөгөөд тус хуулийн 2 дугаар зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие махбодийн, оюун ухааны болон бие махбодийн хөгжлийн бэрхшээл, оюун санааны үйл ажиллагаанд нөлөөлөх бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тахир дутуу буюу нийгмийн саад бэрхшээлээс болоод өдөр тутмын амьдрал нь хязгаарлагдсан, хүнд байдалд байгаа хүмүүсийг хэлнэ гэж заасан байна.

Тухайлбал 1947 онд батлагдсан “Сургуулийн боловсролын тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох ерөнхий боловсрол, тусгай анги, дотуур байргүй сургууль, тусгай сургууль болон явуулын багш нарын боловсрол олгох эрх зүйн харилцааны талаар хуульчилж өгсөн байна. Мөн 1954 онд батлагдсан хараа, сонсгол, тулгуур эрхтний, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд хамрагдах, тусгай боловсролыг дэмжих тухай хуулиар хуулиар тусгай сургуульд суралцаж буй хүүхдүүдийг ном, үдийн хоол, сургуулийн аялал болон боловсролын хангамжийн хураамж зэргээр дамжуулан дэмжлэг үзүүлдэг байна.

Хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоохоос өмнө “илрүүлэх” гэсэн үе шат байх ба хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх гэдэг нь оношилохоос өмнө байх ёстой чухал үе шат юм. Мөн Боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу сургуульд элсэх насны бүх хүүхдүүдийг сургуульд элсэх эрүүл мэндийн үзлэгт хамруулан хүүхдийг үнэлэхдээ мэргэжлийн баг асуумж, ярилцлага, ажиглалт, сорил зэрэг аргачлалыг ашиглан хийдэг байна. Энэ баг хүүхэд цаашид ямар сургуульд суралцах тухай дүгнэлт гаргаж, эцэг эх асран хамгаалагч нартай зөвлөлдсөний үндсэн дээр хүүхдийн сургууль сонголтын асуудлыг шийддэг байна.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаарх эрх зүйг орчин тодорхой хэмжээнд бүрэлдэн тогтсон байна. Гэвч хуулийн зохицуулалт хэт ерөнхий, мэргэжлийн боловсон хүчин цөөн, ард иргэдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэг мэдээлэл муу зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалаад эдгээр хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл тоодог өнөө үед боловсрол гэдэг тэдний хувьд нийгмийн дунд бусадтай харилцах хамгийн чухал зэвсэг болдог. Мэргэжилтэй, боловсролтой, гадаад хэлтэй байхад ажил, хөдөлмөр эрхлэх зэрэг бусад хүмүүстэй харилцаа холбоо тогтооход хялбар болдог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих тухай хуулийн заалт байдаг боловч ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулдаггүй нэг шалтгаан нь мэргэжил, боловсрол байдаг.

Иймд манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн ерөнхий хуулиас гадна Америк, Япон зэрэг улс орнуудын адил хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлх, хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамааран сургуульд элсүүлэх, сургуульд элсүүлэх процессыг илүү нарийвчилан зохицуулсан, бие даасан хууль шаардлагатай гэж үзэж байна.

Ном зүй:

1. Г.Батцэнгэл “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс”, УБ, 2018 он
2. Д.Одгэрэл, Б.Намираа “Тусгай боловсрол”, УБ, 2018 он
3. Монгол Улс “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэл”, УБ, 2011 он
4. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 2009”, УБ, 2009
5. Монгол Улсын нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих бодлогын хөгжүүлэх” төсөл “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

- эрхийн тухай НҮБ-ын конвенц”, УБ, 2011 он
6. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Монгол Улсын Үндсэн хууль”, УБ, 2014 он
7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, УБ, 2016 он “Төрийн мэдээлэл эмхтгэл” 2016 оны №9
8. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, УБ, 2017 он
9. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа 2019”, УБ, 2019 он
10. https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03 - Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
11. <https://www.legalinfo.mn/law/details/562-> “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хууль”
12. World Health Organization ‘DEVELOPMENTAL DIFFICULTIES IN EARLY CHILDHOOD Prevention, early identification, assessment and intervention in low- and middle-income countries’, 2012
13. <http://www.dinf.ne.jp/doc/english/law/japan/30select.html>
14. file:///C:/Users/Mon/Downloads/s45Aa000840205en8.0_h23A90.pdf- Basic Act for Persons with Disabilities

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

О.Хишигмөнх¹

¹Отгонтэнгэр их сургууль

Түлхүүр үг:

Ажил олгогч, Ялгаварлан гадуурхалт, Цалин хөлс, Тэгш эрх, Хөдөлмөрийн харилцаа

Хураангуй:

Хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан ялгаварлах нь угаас заяасан хувь хүний нэр төр болон нандин чанарыг үгүйсгэж буй явдал гэж олон улсад хүлээн зөвшөөрч бүхий л харилцаанд ялгаварлал үүсгэхгүй байх бүх нөхцлийг бүрдүүлэхийг Нэгдсэн Үндэстний байгууллагаас гишүүн улсууддаа үүрэг болгосон. Мөн чанартаа бусдаас ялгаатай байдал нь ялгаварлан гадуурагдах үндэслэл биш юм. Монгол Улс Үндсэн хуулиндаа хүн бүр эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй гэж заасан боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд энгийн иргэдийн адил нийгэмд нээлттэй байж дуу хоолойгоо хүргэж эрхээ хамгаалуулж чадахгүй байгаа нь Монгол Улсын хувьд шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудлын нэг мөн. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаатай байдлыг харж өрөөдөх, юу хийхээ мэдэхгүй тэднийг хаалттай хаалганы цаана үлдэх сонголт руу түлхэж байна. Учир нь тэд алхам тутамдаа хөгжлийн бэрхшээлтэй, бусдаас дутуу гэдгээ мэдрэх орчин нөхцөлтэй тулгарч өөрийгөө тусгаарлан хэн ч ойлгохгүй, би хэнд ч хэрэггүй гэх ойлголттой болох нь нийгмээс өөрийгөө тусгаарлах үндсэн шалтгаан болж байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж улмаар орлоготой, хамт олонтой, нийгмийн идэвхтэй, баялаг бүтээгч болохыг дэмжснээр олон асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

Судалгааны зорилго, зорилт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх. Ажил олгогчийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллуулахаас татгалздаг үндэслэл дээр тулгуурлан ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэх болон

ажлын байрны тохируулга хийх боломжийг бүрдүүлэх талаар төрийн дэмжлэгийг судлах, улмаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвхтэй оролцоотой, орлоготой, хамт олонтой болж хүн ёсоор амьдрах боломжийг бүрдүүлэхэд оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлох зорилготой.

Судалгааны арга зүй:

Судалгааны ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувийг тодорхойлох, хөдөлмөр эрхлэхэд саад болж буй хүчин зүйлийг практик болон хуулийн зохицуулалтын талаас судлах, олон улсын туршлагыг харьцуулах, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглав.

Үндсэн ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт

Хөгжлийн бэрхшээлийн тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг тодорхойлох ойлголт хөгжлийн явцад нилээдгүй өөрчлөгдөж иржээ. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт улс бүрт өөр өөр төдийгүй тухайн улсын хөгжлийн түвшингөөс хамаарч хүлээн зөвшөөрөгдөх байдал харилцан адилгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хөгжиж байгаа, буурай хөгжилтэй улсуудад илүүтэй зөрчигдөж эрхээ хамгаалах, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох боломж хязгаарлагдмал байдаг нь ядууралд өртөх шалтгаан болж байна. Зарим судлаачид хөгжлийн бэрхшээл гэдэг нь хувь хүндээ биш нийгэмдээ байна гэж үздэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сул дорой, ажил хөдөлмөр эрхлэх чадваргүй, хөгжих боломжгүй гэсэн ойлголт давамгайлж нийгмийн оролцоо бодит байдал дээр хангалтгүй байгааг харуулна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал: Хүүхэд залуучуудын хувилбар”-т хөгжлийн бэрхшээлийг цэвэр биологийн эсвэл нийгэм талаас нь харах

хандлагаас татгалзаж, эрүүл мэндийн байдал, орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэж үздэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хэмээх ойлголтыг олон улсад нийтлэг байдлаар бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ хэмээн тодорхойлсон бөгөөд Монгол Улс уг тодорхойлолтонд нийцүүлж 2016 онд Улсын Их Хурлаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батласан. Монгол Улс нийт гурван сая гаруй хүн амтай, үүний 105730 нь хөгжлийн бэрхшээлтэй ба тэдний 30748 хөдөлмөр эрхэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44 хувь нь төрөлхийн 56 хувь нь олдмол бол эдгээрийн 20.4 хувь нь хөдөлгөөний, 19.3 хувь сэтгэцийн, 12.1 хувь хэл, яриа сонсголын, 10.9 хувь нь харааны бэрхшээлтэй байна. Үүнээс үзэхэд олдмол хөгжлийн бэрхшээлийн эзлэх хувь хэмжээ нилээдгүй их хувийг эзлэж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй болоход нөлөөлөх хүчин зүйлийг судлах, урьдчилан сэргийлэх, хамгаалах шаардлагатайг илтгэнэ. Хөдөлмөр эрхлэж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь хэмжээ бага байгаа нь нийгмийн халамжаас өөр орлогогүй эдийн засгийн хараат байдалд байх, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох боломж хязгаарлагдах шалтгаан болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (2016-2018)



Жил ирэх тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо хүн амын өсөлтийг дагаж нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа хүчин зүйл нөлөөлж байгаа төдийгүй аж ахуй нэгжүүд хөдөлмөрийн аюулгүй байдлын сахиулах, хууль дүрэм журмыг хангалтгүй хэрэгжүүлж байгаатай ч холбоотой. Мөн иргэдийн өөрсдийн анхаарал болгоомжгүй байдал болон зам тээврийн осол,

агаарын бохирдол, эмийн зохисгүй хэрэглээ зэрэг нь нөлөөлдөг болохыг дурьдахгүй өнгөрч болохгүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нийт иргэдийн 10 хувьд хүрэхгүй байгаа нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болоод хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгжилт хангалтгүйг харуулж байна.

Монгол Улсын хэмжээнд 20-49 ажилтантай 4180, 50 дээш ажилтантай 2488 аж ахуй нэгж байгууллага нийт 6668 байгаа нь хөдөлмөрийн тухай хуульд заасан 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах боломжтой байгууллага цөөнгүй болох нь тогтоогдож байна. Дээрх аж ахуй нэгжүүдийн ихэнх нь үйлчилгээ болон худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 2017 оны сүүлээр хийсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд 636 аж ахуй нэгжид шалгалт хийхэд 192 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, зохих төлбөрийг төлөөгүй нь тогтоогдож акт үйлдэж 348 сая төгрөгийн торгууль ногдуулж зохих зөвлөмжийг өгч ажилласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах зохих орон тоонд ажиллуулаагүй ажил олгогчид жилд дундажаар 1 тэрбум орчин төгрөгийн төлбөрийг төлдөг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг санд төвлөрч буй мөнгөнөөс илүү тогтвортой ажлын байр, тогтмол орлого, хамт олон чухал. Ажил олгогчийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулдаггүй төлбөр төлж буй шалтгааны ихэнх хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний ур чадвар шаардлагад нийцдэггүй, ажиллах боломжтой ажлын байр байхгүй, ажилд орохоор хандаж байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой ажлын байр цөөн ажиллах боломжит орчин нөхцлийг бүрдүүлсэн тохируулга хийдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс ажил олоход энгийн иргэнээс илүү цаг хугацаа зарцуулдаг нь сэтгэл зүйн хувьд шантрах, өөртөө итгэлгүй болоход хүргэж байна.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай

хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенци, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенци, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай тухай 159 дүгээр конвенци, Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенци, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенциор тус тус зохицуулж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байна.

Дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулан мөрдөж ажиллаж тогтвортой хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхиүлэн дэмжих, 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улс ч мөн адил хэрэгжилтийг хангах зорилготой бүх түвшинд хамтарч хүртээмжтэй ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого барина, суралцах болон шаардлагатай дэд бүтцийг сайжруулна, хөгжих боломж үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлнэ гэж заасан. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” баталж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байртай болгох зорилгоор холбогдох хуулинд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил албан тушаалынхаа 4 түүнээс дээш орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулна, аж ахуй нэгж 25 дээш ажилтантай, нийт ажиллагсдын гуравны хоёроос дээш хувийг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бол татварын хөнгөлөлт үзүүлнэ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуй нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмээний хандивыг татвараас чөлөөлөхөөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох тухай зохицуулалтууд бий. Эдгээр заалтуудыг бодит амьдралд дээр хэрэгжүүлэх, бусадтай тэгш эрхтэйгээр хөдөлмөрийн харилцаанд оролцож цалин хөлс авч амьдралаа авч явах, гэр бүлийн орлогыг нэмэгдүүлж ядууралд өртөхөөс сэргийлэх маш зорилт болж байна. Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа 4, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500.000 төгрөгөөр торгодог. Аж ахуй нэгжүүд зохих торгуулийн хэмжээ нь төдийлэн үр нөлөөтэй биш байна. Ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахаас татгалзах үндэслэлээ ажлын байрны тохируулга хийх шаардлага тулгардаг, ажлын ачаалал даах чадвар муу, хурд удаан, бүтээмж бага, мэргэжлийн ур чадвар дутмаг, ар гэрийн асуудал их, өвдөх, чөлөө авах тохиолдол элбэг гэсэн бол ажилуулахын давуу талыг татварын хөнгөлөлт эдэлдэг, тогтвортой ажилладаг, хуулиа сахин биелүүлдэг, хариуцлагатай гэж үзсэн байна. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд тогтвортой хөдөлмөр эрхлэхэд эрүүл мэндийн асуудал болон боловсролын асуудал чухал байр суурь эзэлдэг болохыг харж болно.

Олон улсын туршлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдсан асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчилалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ хэмээн заасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг үзүүлж, боловсрол эрүүл мэнд, нийгэм хамгаалалын цогц үйл ажиллагааг үзүүлснээр энгийн иргэдтэй тэгш нийгмийн амьдралд оролцох боломж бүрдэх юм. Дэлхийн улсууд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, боловсролд тэгш хамруулах бодлогыг нэн тэргүүнд баримтласнаар хөдөлмөр эрхлэхэд саад болж буй хүчин зүйлүүдийг арилгах боломжтой болж улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлдэг байна. Дэлхий дээр нэг тэрбум гаруй хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй иргэд амьдарч байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанаас үзвэл арван таваас дээш насны үйл ажиллагааны ноцтой алдагдалтай 110-190 сая хүн байгаа бол хорин хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Амьд үлдэх, бүтээлч хөдөлмөр эрхлэх, хувийнхаа үүргийг гүйцэтгэхэд маш хүнд цаг хугацааг өнгөрөөдөг, саад бэрхшээлийг арилгаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулж, хангалттай санхүүжилт болон тэдний чадавхыг нээх туршлага, үйл ажиллагаанд хөрөнгө оруулах нь бидний ёс зүйн үүрэг юм. Дэлхийн засгийн газрууд эрүүл мэнд, сэргээн засалт, дэмжлэн туслалцаа, хөдөлмөр эрхлэлт шаардлагатай сая сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ анхаарч үзэхгүйн улмаас тэдэнд гялалзах боломж олдоггүй гэсэн нь дэлхийн хаана ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрхээ эдлэх, хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байгааг илтгэнэ.

Европын холбооны улсуудад ч мөн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байдалд нөлөөлөх хүчин зүйл бол боловсролын түвшин байдаг. Хөдөлмөр эрхлэхэд ур чадвар дутмаг учраас ажил хийх боломж нөхцөл бүрдэхгүй байна, мөн ажил олгогч орчин нөхцлийг бүрдүүлэхэд хүчин чармайлт гаргахгүй байгаа нь нөлөөлдөг хэмээн хэлсэн нь Монгол улсад ч ижил байгаа асуудал юм. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх

нөхцлийг зохих хэмжээнд бүрдүүлсэн хууль эрх зүйн орчин байгаа боловч хөдөлмөр эрхлэлтийг бодитоор нэмэгдүүлж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхэд тулгамдсан асуудлуудыг авч үзвэл:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулдаггүй төлбөр төлдөг аж ахуй нэгжүүдийн 42.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилд орохоор хандаж байгаагүй гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хайх, хэрхэн ажлын байранд зуучлуулах талаар мэдээлэл дутмаг, бусдын тусламжгүй чөлөөтэй зорчих, явах дэд бүтэц дутмаг нь гэртээ л байх сонголтыг үлдээж байна. Ажил олгогчийн зүгээс нааз захын цэвэрлэгч, жижүүрийн ажлын байранд дээд боловсрол, бие эрхтний төрх, өндөр нам, нас харгалзах болсон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд ажил хийх тухай ойлголт нь мөрөөдөл төдий л болж үлддэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бага наснаас нь боловсрол эзэмшүүлэх, хөгжүүлэх, цогц байдлаар бодлогоо хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 50 орчим хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бага наснаасаа боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна. Энэ нь насанд хүрсний дараа хөдөлмөр эрхлэхэд тавигдах шаардлагыг хангахгүй байх үндэслэл болж байна.
- Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авч буй цалин улсын дундажаас 90.1 хувь нь доогуур байгаа нь ихэнхдээ цалин багатай ажлын байранд ажилладагтай холбоотой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өрх толгойлсон эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн орлого бага ядууралд өртөмтгий байдаг нь авч буй цалин, өрхийн хэмжээнээс хамаарч байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулах, ажлын байрны тохируулга хийх хэрэгтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн цогц бодлого, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байдаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туулсан амьдралын замналаас тодорхой харагддаг. Тэдний цөөхөн нь нөхцөл байдалтайгаа тэмцэж их хэмжээний тэсвэр тэвчээр гаргаж хөгжиж

улмаар ажлын байртай болдог бол ихэнх нь нийгмийн сөрөг хүчин зүйлүүдийг даван туулж чадалгүй хаалттай хаалганы цаана үлдэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сэргээн засах эмчилгээг сайн хийх нь чухал юм. Ингэснээр бага багаар хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн хувьд сайн үр дүн гардаг байна. Манай улсын хувьд сэргээн засах эмчилгээ хангалтгүй байна. Бусад улсын жишгээс харахад сэргээн засах эмчилгээг сайн хийж хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлдэг байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлсноор “Хүний чадвар алдалтыг бууруулж нийгмийн хэвийн харилцаанд оруулах зорилгоор хийж буй бүхий л аргыг сэргээн засалт” гэнэ. Эмнэлзүйн сэргээн засах эмчилгээтэй хамааралтай боловч гол нь чадвар алдалттай хүмүүст шаардлагатай байдаг нийгмийн таатай орчинг бүрдүүлж нийгмийн сөрөг нөлөөлөл, саадыг багасгахад дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56 хувь нь олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болж буйг анхаарч бууруулах арга хэмжээг авахгүй бол цаашид нэмэгдэх хандлагатай нь зайлшгүй анхаарах ёстой асуудал.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургалтын төвүүд цөөн байна, одоогоор сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, хараагүй иргэдийн холбооны мэргэжлийн сургалтын төв болон бусад төрийн бус байгууллагуудаас сургалтыг явуулдаг аж. Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг дэмжих зорилгоор 2016 оноос европын холбооны SECiM төслийг 4 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн идэвхтэй харилцаанд оруулж, нийгмийн идэвхтэй гишүүн болоход хөдөлмөр эрхлэх нь маш чухал үр нөлөө үзүүлдэг бөгөөд өөрийгөө бусдын адил гэж хүлээн зөвшөөрч өөртөө итгэх итгэлийг олж авдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь өөртөө итгэлтэй болох, амьдралаа авч явах боломжтой болох, нийгэмших, бусадтай харилцаж өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх, орлоготой болох, эдийн засгийн хараат байдлаас гарах зэрэг олон эерэг үр дагавартай.

Дүгнэлт, санал

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Аж ахуй нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах зохих орон тоонд ажиллуулахгүй, зарим ажиллуулаагүй төлбөрөө төлөхгүй байгаа нь хуулийг үл ойшоон биелүүлдэггүй байдлыг илтгэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн мөнгө өгөөд гэрт байлгах хуучин сэтгэхүй энэ нийгэмд бөх бат оршин тогтнож байгаа нь тэднийг зөвхөн авагч, хүртэгч болгож хувиргасан гэж дүгнэж болохоор байна. Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил хийх чадваргүй, хөгжих боломжгүй гэх өнцгөөс хардаг нь хөдөлмөр эрхэлж өөрийн амьдралаа авч явах, орлого болж эдийн засгийн хараат байдлаас гарахад сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлага ардчилсан хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгэмд бүрэн төлөвшөөгүй байгаа нь тэднийг алхам тутамдаа ялгаварлалд өртөх, хөгжих боломжийг хязгаарлах үндсэн шалтгаан болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь энгийн хүнээс хэд дахин илүү тэсвэр тэвчээр, цаг хугацаа зарцуулж суралцах болон хөдөлмөр эрхлэх боломжийг олж авч байгаа нь Үндсэн хуульд заасан хүн бүр эрх тэгш байх эрх хэрэгжихгүй байгааг харуулж байна. Хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ядууралд өртөх гол шалтгаан болж байна. Үүнээс Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж буй ядуурлын асуудлыг шийдвэрлэх үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж үзэж болох юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагын үндсэн дээр дараах ажлуудыг хийх нь үр нөлөөтэй гэж үзэв. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлийг зөв ойлгож хүлээж авах нийгмийн болон хүмүүсийн сэтгэл зүй бүрэн төлөвшөөгүй өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ нуудаг, гэрээс гаргадаггүй, зөвлөгөө, тусалцаа авдаггүй байдлаас болж олон хөгжлийн бэрхшээлтэй иргэн хаалттай хаалганы цаана хаалга нээгдэхийг хүлээсээр сууна. Иймээс бид бүгд хүн тиймээс хүний ёсоор хүн бүрт ижил тэгш хандах сэтгэлгээг өөрсдөөсөө эхэлж

- бий болгох шаардлагатай байна.
 - Аж ахуй нэгжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулвал зохих дэмжлэг урамшууллыг олгох эрх зүйн зохицуулалт байгаа боловч татварын хөнгөлөлт үзүүлэхээс өөр бодитой биелэлээ олж буй зохицуулалт дутмаг байна. Тиймээс аж ахуй нэгжүүдэд олгох урамшуулал болон санхүүгийн дэмжлэгийг тодорхой хуульчлах нь зүйтэй. Ингэснээр илүү ажил олгогч илүү санаачилга гаргаж ажлын байрны тохируулга хийх, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх боломжтой.
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сэргээн засах үйлчилгээг цогцоор нь бүрдүүлэх зөвхөн хөдөлгөөний засал хийхэд бус сэтгэл зүйн засал болон амьдралын нөхцөл байдлыг даван туулах хэрэгтэй чадвар дадлын олгох нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илүү нийгмийн амьдралд идэвхтэй оролцох өөрсдийн хууль ёсны эрх, ашгаа хамгаалахад сайн үр нөлөө үзүүлэх юм.
 - Олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болж буй нөхцөл байдлыг нарийвчлан судалж бууруулах арга хэмжээг авах шаардлагатай байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо буурахад бодитой нөлөөлнө.
- бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа УБ.,2017 он
- World report on disability 2011. WHO & WB
 - Report The State of the World's Children 2013 UNICEF
 - www.1212.mn

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль 1992
- Хөдөлмөрийн тухай хууль 1999
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль 2016
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хууль 2011
- Татварын ерөнхий хууль 2008
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль 2006
- Тогтвортой хөгжил 2030 2015
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020
- Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоол 2017
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци 2006
- Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хийсэн “Хөгжлийн

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ (Нугасны ивэрхийтэй хүүхдийн жишээн дээр)

Р.Энхчулуун¹ МА, Э.Агь-Марал¹
¹ “Марал-Элч” сан

Хураангуй

Нугасны ивэрхийтэй хүүхдийн хөгжлийн онцлогийн талаар өмнө нь “Нугасны ивэрхийтэй хүүхдийн оюун ухааны хөгжлийг судалсан нь”¹ Р.Энхчулуун Сэтгэл судлалын магистрын зэрэг горилсон ажил хийгдэж байсан ба одоогоор өөр хийгдсэн судалгаа Монгол улсад байхгүй байна. Үүнд үндэслэж монгол дахь нугасны ивэрхийтэй хүүхдийн хөгжлийн харьцуулсан судалгаанууд, эрүүл мэнд боловсрол нийгмийн халамж хамгааллын нөхцөл байдлыг судлах шаардлагатай байна. Судалгааны ажлыг хийхдээ нэгтгэн дүгнэх задлан шинжлэх судалгааны түгээмэл аргуудыг хэрэглэснээс гадна судалгааны онцлогоос хамаарч социологийн судалгааны зарим аргыг хэрэглэв. Бичиг баримтын судалгаа, асуулгын судалгаа, кейс анализ, ярилцлагын арга, ажиглалтын аргуудыг ашигласан. Нугасны ивэрхийтэй хүүхдүүд эрүүл мэндийн, боловсролын, нийгмийн халамжийн чанартай үйлчилгээ авах нэн чухал хэрэгцээ байгааг бүхий л түвшинд ойлгуулах нь чухал байна. Эрүүл мэнд боловсрол, нийгмийн халамжийн чанартай үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөж хөгжих нийгэмших амьдралын чанарыг сайжруулах чухал хүчин зүйл юм.

Түлхүүр үг

Нугасны ивэрхий, ургийн гажиг, фолийн хүчил, тэгш хамруулан сургах

Үндэслэл

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн талаар хийгдсэн судалгаа тэр дундаа тодорхой өвчнөөс үүссэн хөгжлийн бэрхшээл дээр хийсэн судалгаа ховор байдаг. Тодорхой өвчнөөс үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг судлах нь хүүхдийн хөгжил төлөвшил, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг судлах үнэлэх арга зүй, хэрэглэгдэхүүн, зөвлөмжийг боловсруулах болон боловсролд хамруулах эрүүл мэнд

сэргээн засах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлоход чухал юм. Мөн хүүхдийн нийгэмшүүлэх үйл явцыг дэмжих, өвчнөөс үүдэлтэй хөгжлийн бэрхшээл нь хүүхдийн сурах хөгжих үйл явцад ямар нөлөө үзүүлж байгааг илрүүлэн судлахад ач холбогдолтой юм. Нугасны ивэрхийтэй хүүхдийн хөгжлийн онцлогийн талаар өмнө нь “нугасны ивэрхийтэй хүүхдийн оюун ухааны хөгжлийг судалсан нь” Р.Энхчулуун Сэтгэл судлалын магистрын зэрэг горилсон ажил хийгдэж байсан ба одоогоор өөр хийгдсэн судалгаа Монгол улсад байхгүй байна.

Нугасны ивэрхий гэж юу вэ

Хүний биеийн дотор талд байх ёстой ямар нэг эрхтэн ямар нэг шалтгаанаар гадагшаа цүлхийж гарахыг ивэрхий гэж нэрлэдэг. Ивэрч гардаг гэсэн үгнээс үүдэлтэй. Ивэрхий ихэнхидээ төрөлхийн байдаг. Хаана ивэрсэн тэрчлэн ивэрхий дотор ямар эрхтэн цүлхийж гарснаас нэршил өөр өөр байдаг. Жишээлбэл гавлын яс цөмөрсөн тохиолдолд тархи иврэх, өрц цөмөрснөөс хэвлийн хөндийн аль нэг эрхтэн хэвлий рүү эсвэл гэдэс цээжний хөндий рүү ивэрч болно²

Нугасны ивэрхий нь үр хөврөлийн үед мэдрэлийн гуурс гүйцэд хөгжөөгүйтэй холбоотойгоор нугалам ясны төрөлхийн дутуу хөгжил бөгөөд нугас шингэний хамт гадагш ивэрч гардаг. Үүний улмаас төв мэдрэлийн тогтолцооны төрөлхийн гаж хөгжлийн эмгэг үүсдэг байна.

Spina bifida гэсэн нэр томъёо нь латин хэлнээс гаралтай бөгөөд “хуваах” эсвэл “нээлттэй” нуруу гэсэн утгатай.

Ургийн нуруу нугасны гаж хөгжил 1000-д нэг тохиолддог бөгөөд хамгийн элбэг тохиолддог нь нуруу-нугасны ивэрхий юм.

Монгол улсад 1000 амьд төрөлтөд 0,01 хувь тохиолддог бөгөөд 50 хувь нь хүндэрдэг байна³. Түүнчлэн нугасны ивэрхийн эмгэгтэй төрсөн хүүхдүүдийн 80 орчим хувь нь амьдралын эхний жилүүддээ нас бардаг.

Насны ангиллаар авч үзвэл 0-10 насанд 84,6 хувь, 11-20 насанд 15,4 хувь тохиолдож байгаа юм байна⁴. Нугасны ивэрхий нь тохиолдлоороо зүрхний гажгийн дараа 2-р байранд ордог. Нугасны ивэрхий нь төрөлхийн гажгууд дотроос амьд ахуйдаа хамгийн их зардал гаргадгаараа 3-р ордог.

Нугасны ивэрхий нь хүүхдийг насан туршийн хөгжлийн бэрхшээлтэй болгох боловч эмчилгээ, асаргаа, нийгмийн халамж, хамгаалал сайн нөхцөлд урт удаан насалж нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжтой.

Нугасны ивэрхий нь тодорхой бус шалтгаантай бөгөөд зонхилох шалтгаан нь эхийн биед фолийн хүчлийн дутагдах гэж үздэг. Сүүлийн үед 3,4D ЭХО-гоор ураг байхад нь нуруу, нугасны ивэрхий, тархины усыг оношилж байна.

² Эрүүл мэнд. 103.тп


³ Марал-Элч сан судалгаа 2014 он

⁴ Марал-Элч сан судалгаа 2014 он

Жирэмсэн эхэд AFP өндөр тодорхойлогдох нь урагт мэдрэлийн сувгийн гаж хөгжил буюу нугасны ивэрхийн эмгэг сэжигтэйг заадаг⁵.

Нугасны ивэрхийтэй хүүхдүүд бие махбодын болоод нийгмийн ноцтой сөрөг үр дагавруудтай тулгардаг. Жишээлбэл: Хөлний саажилтаас болж таяг тэргэнцэр хэрэглэх шаардлагатай болох, арьсны харшилтай болох, хоол боловсруулах эрхтний хямрал, өтгөн шингэний хяналт алдагдсанаас болж бөөрний хүндрэл бий болох, нийгмийн зүгээс гадуурхалд өртөх гэх мэт.

Олон улсын түвшинд анагаахын шинжлэх ухааны хөгжил дэвшилтэй холбоотойгоор ихэнхи хүүхдүүд амьд үлдэх амьдрах боломжтой болсон бөгөөд үр бүтээлтэйгээр амьдрах хөгжих сурах хөдөлмөрлөх боломжууд улам нэмэгдсээр байгаа. Нугасны ивэрхийтэй хүний дундаж наслалт 30-40 байсан бол мөн жилээс жилд насжилт уртсаж байна. Нас баралтын хамгийн түгээмэл шалтгаан нь бөөрний үрэвсэл, бөөрний дутагдал болж байна. Цаг хугацаа өнгөрөх тусам нурууны гажиг муруйлт үе мөчний эмгэг, булчингийн саажилт агшилт үүсгэдэг.



© MAYO FOUNDATION FOR MEDICAL EDUCATION AND RESEARCH. ALL RIGHTS RESERVED.

⁵ ЭХЭМҮТ. эрүүл мэндийн зөвлөгөө

Нугасны ивэрхийн хэлбэрүүд

1. Spina bifida occulta

“Occulta” нь далд гэсэн үг юм. Хөнгөн хэлбэрийн болох энэ нугасны ивэрхий нь нурууны нугаламын нэг буюу хэд хэдэн ясанд жижиг цоорхой үүүсдэг ба ил харагдах юмгүй тул хүмүүс мэдэгддэггүй.

2. Meningocele

Нурууны нугасны эргэн тойрон дахь хамгаалалтын мембран нь нугаламын нүхээр дамжин шингэнээр дүүрсэн уут үүсгэдэг. Гэхдээ энэ уутанд нугасны суваг ороогүй тул мэдрэлийн гэмтэл нь бага байх боловч дараа нь хүндрэл гарах боломжтой байдаг.

3. Myelomeningocele

Нээлттэй нугасны ивэрхий гэгддэг миеломенигоцеле нь хамгийн хүнд рхэлбэр нь юм. Нугасны суваг нь доод дунд эсвэл арын хэд хэдэн нугламын дагуу нээгддэг. Төрөх үед нярайн нуруун дээр уут, түүн дотор нугасны эд мэдрэл ил гарсан байдаг. Энэ нь хүүхдийн амь насанд аюултай бөгөөд цаашид олон хүндрэлийг дагуулдаг.



Нугасны ивэрхийд тохиолдох хүндрэлүүд

- Ихэнхи тохиолдолд тархи усжина
- Нуруунд муруйлт үүснэ.
- Доод мөчинд хөлд саажилт үүснэ
- Түнхний мултрал элбэг тохиолдоно
- Нүдний хараанд өөрчлөлт орно
- Хоол боловсруулах замын хямрал үүснэ
- Оюун ухаан танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол
- Давсаг шулуун гэдэсний үйл ажиллагаа алдагдаж өтгөн шингэний хяналт алдагдана
- Бөөрний үрэвсэл, дутагдал

Зан төлөв, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн хөгжлийн онцлог

- Эелдэг найрсаг зантай байдаг
- Ялангуяа хэл ярианы гялалзсан чадвараараа гайхшруулдаг
- Уур уцаар багатай, яриасаг, чалчаа
- Амьдралын баяр баясгалан ихтэй
- Цөхөрдөггүй өөдрөг
- Харилцаанд түрүүлж санаачлага гарган орох хандлагатай
- Яриагаа чиглүүлэх чадвар дутмаг
- Зааврыг сайн ойлгодог
- Дүрэм журмыг дагах дургүй
- Шаардлагатай үед ээлж дараалал хүлээх чадвар сул
- Өөртэй нь ажиллаж байгаа багш, эмч, эцэг эх, бусад мэргэжилтнүүдтэй сайн харилцаа тогтооход хэзээд бэлэн байдаг.

Оюун ухааны хөгжил

- Ихэнхи нугасны ивэрхийтэй хүүхдүүд дундаж IQ тэй байдаг.
- Хэл яриа харилцааны чадвар сайтай
- Тархи усжсан тохиолдолд оюун ухааны хоцрогдол үүсэх нь бий

Судалгааны зорилго

Нугасны ивэрхийтэй хүүхдүүд эрүүл мэнд боловсрол нийгмийн халамжийн үйлчилгээ авахад тулгамдаж буй асуудал, цаашид анхаарах шийдвэрлэх зарим асуудлыг судлан тодорхойлох

Судалгааны зорилтууд

- Нугасны ивэрхийтэй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн оношийг үнэн зөв тодорхойлоход тулгарч буй асуудлыг судлан тодорхойлох

- Нугасны ивэрхийтэй хүүхдүүдийн сэргээн засалтын /ортопед/ үйлчилгээ авахад тулгамдаж буй асуудлыг судлан тодорхойлох
- Тэгш хамруулах боловсролд хамрагдахад тулгарч буй бэрхшээлүүдийг судлах
- Нугасны ивэрхийтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдээс нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах
- Судалгааны ажилд дүн шинжилгээ хийж санал зөвлөмж боловсруулах

Судалгааны ач холбогдол

Монголын хөгжлийн бэрхшээл судлалын салбарын бүрэн шийдэгдээгүй асуудлын нэг болох нэг төрлийн төрөлхийн гажгаас үүдэлтэй бэрхшээлийн асуудлыг судлан нөхцөл байдлын талаар бодит мэдээлэл өгөх цаашлаад хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлж шийдвэрлэх арга замыг тодорхойлох ач холбогдолтой гэж үзэж байна.

Судалгааны ач холбогдол шинэтгэл

Энэ сэдвийг дагнан судалснаар нугасны ивэрхийтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг танин мэдэх ойлгох нугасны ивэрхийтэй монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг судлан тогтоох, боловсрол эрүүл мэнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл явцад онцлогийг харгалзан үзэхэд эмч эрүүл мэндийн ажилтан багш нийгмийн ажилтан мэргэжилтнүүдэд дөхөм болох юм. Урьд өмнө төдийлөн судлагдаж байгаагүй нийт хөгжлийн бэрхшээлийн асуудлын дунд цухас дурдагдаад өнгөрч байсан уг сэдвийг сонгож жишээ баримт хууль эрхзүйн хүрээнд нотлон харуулахыг оролдсоноороо шинэлэг юм.

Судалгааны арга зүй

Судалгааны ажлыг хийхдээ нэгтгэн дүгнэх задлан шинжлэх судалгааны түгээмэл аргуудыг хэрэглэснээс гадна судалгааны онцлогоос хамаарч социологийн судалгааны зарим аргыг хэрэглэв.

Бичиг баримтын судалгаа

Холбогдох хууль эрхзүйн актууд, урьд өмнө хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ, илтгэл, бусад орнуудын туршлага

Асуулгын судалгаа

Нугасны ивэрхийтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, нугасны ивэрхийтэй хүүхдийг ангидаа сургаж байгаа багш нараас санал

асуулгын асуумж ганцаарчилсан ярилцлагын аргачлалаар тоон болон чанарын мэдээллийг цуглуулсан.


Кейс анализ

Эцэг эхчүүдээс тулгамдаж буй асуудлаар ганцаарчилсан ярилцлага хийж кейс авлаа.

Ярилцлагын арга

Ажиглалтын арга

Үр дүн



Боловсролын асуудал

Судалгаанд хамрагдсан нугасны ивэрхийтэй хүүхдүүд бүгд ердийн сургууль, цэцэрлэгт элсэн орж байгаа нь сайшаалтай тал юм. Хэдийгээр сургууль цэцэрлэгийн дэд бүтэц орчин хүндрэлтэй ч сургууль, багш нар, үе тэнгийнхний зүгээс сайн дэмжлэг үзүүлж байгаа нь судалгаанд оролцсон хүүхдүүдийн

ангийн багш, нийгмийн ажилтан, ангийн хүүхдүүдийн хандлагаас эцэг эхчүүд болон хүүхдүүдийн өөрсдийн ярианаас харагдаж байна.

Нөгөө талаас өөртөө эерэг хандлага олж авч чаддаг нь нугасны ивэрхийтэй хүүхдүүдийн төрөлх зан төлвийн эерэг шинжүүд, харилцааны чадвартай нь холбоотой гэж бас хэлж болох юм.

Нугасны ивэрхийтэй олон хүүхэд сургуульд сайн сурдаг. Гэхдээ зарим бэрхшээлүүдтэй тулгардаг. Ялангуяа тархинд усжилттай бол сурахад бэрхшээл үүснэ. Анхаарал төвлөрөлт, ой тогтоолт удаашрах, асуудал шийдвэрлэх чадвар сул, удаан хугацаагаар хичээллэхэд ядрах зэрэг хүндрэл бэрхшээлтэй тулгардаг.

Нугасны ивэрхийтэй 2 хүүхэд хөгжлийн хувьд яг адилхан байдаггүй. Хүүхэд бүрт бие махбодийн болоод оюун ухааны хөгжлийн ялгаа өөр өөр байдаг.

Нас ахих тусам хүндрэл ихэсч хоёрдогч гуравдагч хүндрэлүүд гарч ирдэг тул хүүхэд сургуулиас завсардах үзэгдэл их байна. Ийм нөхцөлд гэрийн багш авах асуудал зөвхөн эцэг эхийн санхүүгийн чадавхиас хамаарч байна. Бага ангийн зарим багш гэрээр ирж заах боловч байнга үргэлжлэх боломж хомс байдаг.

Кейс5: Багшийн яриа. Хүүхэд бусад сурагчдаа гүйцэж чадахгүй хоцордог ч чадварт нь тохирсон ганцаарчилсан хөтөлбөрөөр явж байгаа. удаан сууж чадахгүй амархан ядардаг, ангийн ширээ сандал нь тохирохгүй байх, сургуульд тэргэнцэртэй хүүхдэд зориулсан бие засах газар, зам байдаггүй багш заавал туслах шаардлага гардаг, памперс нь нэвтрэх ходоод гэдэс нь хямрах үед эвгүй үнэр гарах зэргээс хүүхэд өөрөө бусдаас ичиж санаа нь зовдог. Багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг ур чадвар дутмаг байдаг учраас мэдэхгүй зүйл нилээн гардаг. Аль болох сурагчаа дэмжиж сургаж хамт олон дунд нь суралцуулахыг хичээдэг.

Оношилгоо эмчилгээнд тулгамдаж буй асуудал

1. Илрүүлэлт оношлогооны асуудал.

Нугасны ивэрхий нь ургийн үед жирэмсний хяналтаар илэрч болох эмгэг юм. Илэрсэн тохиолдолд ургийн үеийн мэс заслаар / prenatal surgery/ сэхийн хэвлий дотор

хагалгаа хийн гажгийг засаж нөхцөл байдлыг хөнгөрүүлэн засаж төрүүлэх боломжтой юм.

Өрхийн болон аймаг сум дүүргийн эмч нарын мэдлэг ур чадвар дутмагаас онош буруу тавигддаг. Далд ивэрхийг давсагны гаж, хөгжил бөөрний үрэвсэлтэй андуурах зэргээр буруу эмчилгээ хийж явсаар цаг алдах байдал тохиолддог.

Нугасны ивэрхийтэй хүүхдийн оношийг эрүүл мэндийн дэвтэрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэрт зөв бичдэггүйгээс хүүхдүүд сэргээн засахад шаардлагатай ортопедын хэрэгслээ авч чадахгүй болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисстой болж хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг үнэлэх тогтоох шалгуур үзүүлэлт, өвчний жагсаалттай болсон нь илүү ойлгомжтой хялбар болсон боловч ХБХЭМБНХК-ын гишүүдийн мэдлэг ур чадвар дутмаг, нэгдсэн нэг ойлголт байхгүйгээс мөн нугасны ивэрхий нь зарим талаараа нэгээс дээш кодлолтой, эсвэл хавсарсан өвчний код таарахгүй зэрэг бэрхшээл тулгарч байна.

Ортопед туслах хэрэгслээ авахад нилээдгүй хүндрэл бэрхшээл тулгарч байна.

ХБХЭМБНХК-оос нугасны ивэрхийтэй хүүхдэд олгогдох ёстой ортопед туслах хэрэгслийг бичиж өгөхгүй байх, хасаж бичих зэрэг асуудал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд протез ортопед асаргааны туслах хэрэгсэл нийлүүлэхээр тендерт шалгарч эрх авсан зарим компани хүүхдэд таарах чиг, тэргэнцэр таяг алхуулагч гэх мэт байдаггүй, үйлдвэрлэдэггүй эсвэл нэг юм авахын тулд хүүхдэд хэрэггүй зарим зүйлсийг эд нарыг авбал бичиж өгнө, манайхаас заавал ав гэж тулгадаг асуудал байдаг байна.

Кейс 7. Хүүхдэдээ стомын уут авах гээд хүүхдэд стомын уут олгоно гэж эрх авсан компанид очтол стомын уут гэж юу юм хүүхдийн катетер стом гэж юу юм огт сонсоогүй мэдэхгүй юм байна гэсэн.

Кейс1: Хүү маань 14 настай. Нугасны хүнд хэлбэрийн ивэрхий, Арнольд-Куарын гажигтай, тархины усжилттай, доод

мөчдийн саажилттай. Өрхийн болон дүүргийн эмч нар харилцан адилгүй онош бичдэгээс болж авах ёстой зарим хөнгөлөлтөө авч чадахгүй байна. Би өөрөө байнга хажуугаас нь хэлж байж хүүхдийн маань үндсэн оношуудыг заавал бичээрэй гэж хэлж байж бичүүлдэг. Хамгийн сүүлийн жишээ гэхэд энэ оны 3р сард байнгын асаргаа сунгуулах комиссын хуралд орсон. Гэтэл комиссын гишүүн мэдрэлийн эмч стомын уут олгогдохгүй гэсний улмаас хүүхдэд маань олгогдох ёстой стомын уутны хөнгөлөлтөө авч чадахгүй байна. Нөгөө талаас мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез ортопедын хэрэгсэл авахад хөнгөлөлт үзүүлэх журамд стомын уутыг ерөнхийлсөн ганц үгээр “стом”-ын уут гэж оруулсан нь бөөр давсагны эмгэгтэй нефростом, цистостомын гуурс уут хэрэглэх заалттай хүүхдүүд хохирох бас нэг нөхцөл болж байна. Эмч нарын мэдлэг дутмаг ур чадвар сул байна. Стом гэдгийг зөвхөн колостомын уут гэж ойлгодог, нугасны хүнд хэлбэрийн ивэрхий миеломенингоцеле оноштой, бүсэлхий нурууны L4.5 үеэс доош нугас тайрагдсан хүүхэд өтгөн шингэнээ аль алийг барих хянах чадваргүй болдог гэдгийг мэддэггүй мэдрэлийн нарийн мэргэжлийн эмч ажиллаж байгаа нь үнэхээр харамсалтай. Хүүхэд маань удаа дараалан хохирч байгаа нь гомдолтой байна.

Кейс 3: Стомын уут гэж одоо л сонсож байна. Хэн ч нугасны идэрхийтэй хүүхэд авах ёстой гэж хэлж өгөөгүй. Бас хөлийн чиг тэргэнцэр авах гэж бөөн юм болж байж арай гэж бичүүлдэг. Уг нь зөндөө л юм авах ёстой юм билээ. Аймгийн халамжийнхний хэл амнаас айгаад дуугай л ганц нэг юм авдаг. Уг нь тэрийг нь авбал ядаж байнга өмсдөг памперс катетерийг нь авах юмсан. Том болсон хүүхдийн шээс дийлдэхгүй хэцүү байна. Бас бөөр нь үрэвсээд эмчилгээнд орсон.

Сүүлийн жилүүдэд нугасны ивэрхийтэй хүүхэд төрөнгүүтээ хийгдэх ёстой ивэрхий оёх мэс заслын эмчилгээний тусламжийг авч чадаж байгаа боловч манай улсад хүүхдийн мэдрэлийн мэс заслын салбарын хөгжил сул хэвээр байсаар байна. Хуучин зөвхөн Шастины улсын 3-р эмнэлгийн мэдрэлийн мэс

заслын тасагт ганцхан энэ хагалгааг хийдэг байсан бол одоо ЭХЭМҮТ-ийн мэс заслын тасагт хийдэг болсон нь дэвшилттэй тал юм. Хөдөө орон нутагт төрсөн нугасны ивэрхийтэй нярай нийслэл хот руу ирж хагалгаанд орох замын зардал, мөн хүнд хэлбэрийн ивэрхийтэй төрсөн нөхцөлд холоос зөөх тээвэрлэх явцад хүндрэл гарах асуудал гардаг байна. Орон нутагт сэргээн засах үйлчилгээ авах мөн л дутагдалтай хэвээр.

Кейс 4: Хөдөө орон нутагт байдаг болохоор тэр бүр мэдээллээс хол байхымаа. Өрхийн эмч халамжийн ажилтан л энийг тэрийг авдаг олгодог гэхгүй бол бидэн шиг улс мэдэхгүй л өнгөрөх юм. Орон нутгаас сар бүр давсагны гуурсаа солиулах гэж 2 хүүхдээ аваад хот руу өвөл зунгүй орж ирдэг. Зардал мөнгө ихтэй халамжийн мөнгө хаанаа ч хүрэлцэхгүй амаргүй л байдаг юм. Стомын уут гэж ёстой сонсож байгаагүй юм байна.

Нугасны ивэрхий нь Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/67, 48 дугаар хамтарсан тушаалын 2-р хавсралт Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтын 5.6-д заасан Нугасны хүнд хэлбэрийн ивэрхий Q06,

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/67, 48 дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралт Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалтын 5.17 Q70 Үлдэц бүхий органик тархи, тархи, нугасны гаж хөгжил, гидроцефали, нугас хөндийтөл (сирингомиели) Арнольд-Киарын гажиг, ивэрхий (Танин мэдэхүй, оюуны хомсдол, мөчний саажил, хатангирал, мэдрэхүйн өөрчлөлт, тагнай, залгиурын саа, шээс задгайрах) гэдэг заалтаар орсон байдаг байна. Энэ ангиллын онош кодыг мөрддөггүйгээс хүүхэд хохирох асуудал гарч байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид хамрагдахад гарч буй бэрхшээл

Кейс 2 Миний хүү 6 настай. Нугасны ивэрхийтэй бөөрний үрэвсэл хүндрэл явагдаж байгаа. Шээс баасаа барьдаггүй.

Давсаганд гуурс тавина гэсэн. Миний хүү нугасны ивэрхий оношоор нь оруулдаггүй бөөрний үрэвсэл гэж дагалдах оношоор нь бичээд байдаг. Энэ оны сунгалтаа хийлгэх гээд хурлаар ортол хүүхэд чинь хөл дээрээ явж чадаж байна гээд байнгын асаргаанаас хасчихсан.

Өрхийн эмчийн буруутай үйл ажиллагаа, аймаг дүүргийн нарийн мэргэжлийн эмч нарын мэдлэг дутуу хайнга сэтгэлгүй байдлаас нугасны ивэрхийтэй зарим хүүхдүүд нийгмийн халамжийн тэтгэмжээ авч чаддаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын алдаатай үйл ажиллагаа, комиссын зарим гишүүдийн мэдлэг чадвар дутуу байдал мөн үүнд нөлөөлж байна.

Хэлцэмж

Судалгаа нь одоогийн байдлаар зөвхөн ЕБС-ийн насны нугасны ивэрхийтэй хүүхдүүдийн хүрээнд тэдний эцэг эх асран хамгаалагчдийг хамруулан хийгдсэн ба цаашид олон чиглэлээр нугасны ивэрхийтэй монгол хүүхдүүдийн бие махбодын болоод оюун ухааны хөгжлийн онцлогийг судлах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн:

- Өрхийн болон аймаг сум дүүргийн эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх, ур чадварыг сайжруулах
- Хороо, дүүргийн нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтнүүдийн мэргэжил, ур чадвар, хандлагыг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааг сайжруулах, сургах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний протез ортопед нийлүүлэх компаниудын тендерийн сонгон шалгаруулалтыг чанаржуулах
- Хүнд бэрхшээлтэй хүүхдэд гэрийн сургалт, явуулын багшийн үйлчилгээ бий болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт, семинарыг тогтмол системтэйгээр явуулах
- Сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг сайжруулах
- Төрийн бус байгууллагууд нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлж байгаа сайн туршлага үр дүнтэй хөтөлбөрүүдийг судлах сурталчлах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгцээ шаардлагууд байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Дүгнэлт

Нугасны ивэрхийтэй хүүхдүүд эрүүл мэндийн, боловсролын, нийгмийн халамжийн чанартай үйлчилгээ авах нэн чухал хэрэгцээ байгааг бүхий л түвшинд ойлгуулах нь чухал байна.

Эрүүл мэнд боловсрол, нийгмийн халамжийн чанартай үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөж хөгжих нийгэмших амьдралын чанарыг сайжруулах чухал хүчин зүйл юм.

Ном зүй

1. Р.Энхчулуун. Нугасны ивэрхийтэй хүүхдийн оюун ухааны хөгжлийг судалсан нь. Сэтгэл судлалын магистрын зэрэг горилсон судалгааны ажил 2012 он
2. М.Нарантуяа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэлзүй онол ба хэрэглээ 2013
3. Г.Батцэнгэл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэлзүйн зарим асуудал 2007
4. Я.Цэвээнлхазал, Б.Туяа, Ц.Батцэцэг, Д.Хорлоо, Ц.Гэрэлтуяа Хөгжлийн бэрхшээл тэдгээрийн онцлог 2006 он
5. Neural tube defects between folate metabolism and genetics. 2011 paper
6. Maternal-fetal surgery for myelomeningocele | acog committee opinion | 2017
7. De Jong. Treatment of the neurogenic bladder in spina bifida 2008
8. Nora Shields PhD; Nicholas F Taylor PhD; Karen J Dodd PhD. Self-concept in children with spina bifida compared with typically developing children 2014
9. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/69, 48 дугаар хамтарсан тушаал
10. Монгол улсын хуулиуд холбогдох журам тушаалууд

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Б.Доржпагма¹, Бадамханд¹

¹Монголын үндэсний их сургууль-Хууль зүйн удирдлагын сургууль

Хураангуй:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн харьцаж, бусдын адил, тэгш эрх эдлэх боломж нь хүний эрхийн зарчим юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц болон ICF ангилал нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэмд оролцох оролцоог хязгаарладаг орчны үүргийг дараах байдлаар онцолсон байна. Үүнд:

1. Бодлого стандарт тохиромжгүй
2. Хандлага сөрөг
3. Үйлчилгээний хангамж дутмаг
4. Боловсрол дутмаг
5. Санхүүжилт тохиромжгүй
6. Хараат байдал ихэссэнээс нийгмийн харилцаанд оролцоход хязгаарлалттай байдаг гэсэн дүгнэлт гарсан байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц 12 дугаар зүйлд хуулийн өмнө тэгш байх эрх тусгагдсан байдаг. Онцолбол “Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалт бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон байж болох хмагинь богино хугацаатай байх бөгөөд бүрэн эрхт хараат бус бие даасан байгууллага эсвэл зохих шүүхийн шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдий чинээ хэмжээтэй байна” гэж заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмд оролцоход саад учруулдаг орчны үүргүүд, дээр дурдсан зүйл заалттай хэр нийцэж байна вэ? Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд дээрх зүйл заалт тусгагдсан байдаг эсэх, биеллээ олдог эсэх зэрэг асуудлуудыг

үндэслэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль зүйн зохицуулалтын тухай асуудал хөндөгдөх хэрэгтэй байгаа юм.

Судалгааны зорилго:

Өнөөгийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэдийн өмнө тулгамдаж буй гол асуудал нь юу болох, Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалт хэрэгжилт, хүртээмжийн хувьд ямар байгааг нийтэд түгээх, нийгэмд эерэг байдлыг бий болгоход чиглэнэ.

Судалгааны зорилт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөндөгдөж байгаа эрхийг тодорхойлох, түүнтэй холбоотой хуулийн зохицуулалтанд дүгнэлт гаргах, нийгэмд тусгах, хууль зүйн талаас нь нийтэд эерэг мэдээлэл хүргэх.


Судалгааны арга зүй:

Түүвэрлэх, зайнаас тандан судлах

Үр дүн:

Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд:

- Нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх
- Хөдөлмөрлөх эрх
- Сурч боловсрох эрх
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх**
- **Хууль зүйн туслалцаа авах эрх**
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх
- Бие даан амьдрах эрх гэсэн эрхүүд хуульчлагдсан байдаг. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ямар эрх зөрчигдөж эсхүл хэрэгжихгүй байна вэ? Гэсэн асуулт тавьж 2-3 хувилбар сонгох боломжтой асуултанд давхардсан сонголтоор хууль зүйн туслалцаа вах эрх, нийгмийн харилцаан тэгш оролцох эрх гэсэн 2 эрх хөндөгдөв.



Хуулийн этгээдэд ч мөн үүрэг бий. Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 43-р зүйл(Хуулийн этгээдийн нийтлэг эрх үүрэг:

43.1 Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах нийтлэг эрх **үүрэгтэй.**

43.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх

43.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхдээ олон улсын чиг хандлагын дагуу түгээмэл загвар хэрэглэх

43.1.3 Нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх

43.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхитэй оролцоо түүний амжилт бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах

43.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж дэмжлэг үзүүлэх

43.1.6 Өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээн авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэх


43.1.7 Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих

43.1.8 Ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх


43.1.9 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах

43.1.10 хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг) - д энэ талаар тусгаж өгсөн байдаг. Хуульд заасан энэ үүргийн биелэлтийн талаар асууж лавлахад:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах, сурч боловсрох орчины талаар хөндөж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчин, сурч боловсрох орчин, нийгмийн харилцаанд оролцох орчин хуульд заасны дагуу хангагдаж чадаж байгаа эсэхийг лавлахад судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 90% нь тийм ч сайн биш ч ажиллаж амьдарч болохуйц боломжийн гэсэн хариулт өгсөн. Яг энэ асуултаар түүвэрлэх аргаар зарим ард иргэдээс судалгаа авахад хөндлөнгөөс харахад хүндрэлтэй юм шиг санагддаг гэсэн хариулттай байсан.



Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль байдаг ч шинээр нэмж оруулах шаардлагатай гэж үздэг санал, хэрэгждэггүй хуулийн зүйл заалт, нэмэлтээр оруулах бичих зүйл байгаа эсэх талаар асуухад судалгааны материаллын 50% нь хоосон ирсэн. Судалгаад санал оруулсан хүмүүс орчины тал дээр гудамж талбай, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гадуур явахад саадгүй болгох тохижилтыг, нийгмийн хамгааллын тал дээр нийгэмд оролцох идэвхийг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилтийг илүү сайжруулах зэрэг санал гаргасан. Нийт мэдээллийг ажиглавал:



Хэлцэмж:

Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний:

1. Хуулийн биелэлт, эрхийн талаар асуудал хөндөгдөхөөр байна гэсэн дүгнэлт гаргахуйц хариулт гарч ирж байгаа юм.
2. Амьдрах, ажиллах, сурч боловсрох орчны асуудал яригдахаар ажиглагдав. Энэ асуудал нь ICF-н гаргасан орчны үүргүүдийн тусгал Монгол улсад хөндөгдөж байгаа нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль эрх зүйн талаарх асуудалд орчин болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх яригдана. Хууль зүйн хараат байдал сайжрах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашиг хамгаалагдах амьдрах ажиллах, сурч боловсрох, нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцох орчин хангагдана.

Дүгнэлт:

Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, ажилчид, Булган аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албын ажилчид нийлсэн 47 хүн оролцсон. Судалгаанаас үзэхэд

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх хамгийн их зөрчигдөж хууль зүйн туслалцаа авах эрхээ бүрэн ашиглаж, эдэлж чаддаггүй эсвэл мэддэггүй
2. Төрийн байгууллага, хуулийн этгээдийн хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнө хүлээдэг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч энгийн иргэд ч сайн мэдэхгүй байгаа нь энэ зүйл заалтын хэрэгжилт сайн биш байна гэдгийг нотолж байна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах, сурч боловсрох орчинг хөндлөнгөөс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн материаллаг орчинг цогц шийдэж чадаагүй байна.
4. Зам талбай, нийгмийн орчны асуудал судалгаан дээр хамгийн их хөндөгдсөн.

Судалгааны нэг онцлог тал байсан нь Булган аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас авсан судалгаанд 50% орчим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрийнх нь эрх, бусад хуулийн этгээдийн үүрэг, хууль зүйн туслалцааг сургалт зэрэг аргаар хуулийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа

явуулах нь зөв гэсэн санал ирсэн. Энэ саналыг хэрэгжүүлэхэд Улаанбаатар төдийгүй орон даяар тус асуудалтай холбогдсон аян зарлаж энгийн иргэд, хүүхэд багачууд гэх мэтчилэн аль болох өргөн хүрээгээр хамруулж идэвхитэй зохион байгуулах нь чухал хэмээн үзэж байна.

ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ХАМГААЛАЛД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Маргад-Эрдэнэ
¹МУИС-Хууль Зүйн Сургууль

Түлхүүр үг

Оюуны бэрхшээл, тэгш эрх, ялгаварлан гадуурхалт, зохицуулалт

Хураангуй

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаарх судалгаанууд цөөн тоогоор хийгдсэн байдаг бөгөөд УИХ Тамгын газрын судалгааны төвөөс гаргасан төрийн баримтлах бодлого болоод ЖСА, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны хамтарсан төсөл, судалгаа цөөн тоогоор байна. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгаалалд олон улсын гэрээ конвенцийн гүйцэтгэх үүрэг” магистрын ажлаас өөр оюуны бэрхшээлтэй холбоотой нарийвчилсан судалгаа хангалттай хэмжээнд байхгүй байгаатай холбогдуулан илтгэлээ тус сэдвээр бичихээр шийдсэн болно. Бичиг баримт судлах аргад үндэслэн сэдвийн хүрэн дэх эх сурвалжуудад дүн шинжилгээ хийх замаар тус эрдэм шинжилгээний ажлыг бичиж бэлтгэсэн. Дээрх аргыг ашиглан оюуны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, түүний эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын Үндсэн Хуульд заасан ялгаварлан гадуурхагдахгүй байх болон 16 дугаар зүйлийн эрхүүдийг бүрэн эдлэх боломж бүхий эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг дараах илтгэлээр дамжуулан тодруулсан.

Судалгааны зорилго

Тус судалгаагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэг төрөл болох оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангалттай хангасан эрх зүйн зохицуулалт Монгол улсын хүрээнд байгаа эсэхийг судлах зорилготой.

Судалгааны зорилт

Судалгааны зорилгод хүрэхийн тулд нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг онцгойлон авч үзэх шалтгааныг шинжлэх,

хоёрдугаарт, Монгол улсын хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хэр хэмжээнд хамгаалсан байгааг, гуравдугаарт, оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан эсэхийг судлана. Цаашид хэрхэн зохицуулвал тохиромжтой талаар өөрийн саналаа хэлцэмж хэсэгт оруулна.

Судалгааны арга зүй

Эмпирик судалгааны аргын шинжлэн судлах аргад үндэслэн дедукци болон синтезийн замаар шинжилгээний ажлыг бичиж бэлтгэсэн.

Үр дүн

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулан ойлгодог. Тэгвэл дээр дурдагдсан оюун санааны согогтой хүнийг оюуны бэрхшээлтэй хүн гэж ойлгохоор байна. Онолын үүднээс танин мэдэхүйн чадвар, нийгмийн харилцаа холбоо, биеэ авч явах зэрэг нь хязгаарлагдмал хүнийг оюуны бэрхшээлтэй хүн гэдэг. Оюуны бэрхшээл нь төрөлхийн эсвэл олдмолоор буюу өвчний улмаас бий болдог. Дээрх шалтгааны улмаас оюуны бэрхшээлтэй хүн нь энгийн буюу түгээмэл загвартай орчинд бусадтай хамт хөгжих боломжгүй байдаг тул тэдгээрийг тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчинд байлгах ёстой болдог бөгөөд энэ харилцааны үндсийг хуулиар зохицуулдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг ялгаварлан гадуурхахгүй, бүх хүн эрх зүйн этгээд байхаар хуульчилсан бөгөөд 16 дугаар зүйлд хүн бүрийн эдлэх эрхийг хуульчилж өгсөн байдаг. Эдгээр эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил эдлэх эрхтэй. Монгол улс нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

эрхийн тухай” конвенцийг 2009 онд соёрхон баталсан ба 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан байдаг. Эдгээр хоёр хэм хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах суурь хэм хэмжээ болж өгдөг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрүүд, төслүүдийг их хэмжээгээр баталдаг жишиг манай улсад тогтсон байна. Ийнхүү үндэсний хөтөлбөрүүд бий болсон нь сайшаалтай ч тэдгээрийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг хянах субъект байхгүй байхаар зохицуулсан байгаа нь учир дутагдалтай харагдаж байна.

Төр баримтлах бодлогын үндсийг тодорхойлон, хууль баталж нийгмийн харилцааг зохицуулдаг журамтай. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хамгааллын харилцааг авч үзвэл боловсролын, нийгмийн халамжийн зэрэг салбарын хуулинд “...ялгаварлан гадуурхаж үл болно..” гэж заасан байгаа бөгөөд энэ нь хангалтгүй зохицуулалт гэж үзэх үндэслэлтэй. Ийнхүү ерөнхий зохицуулалт бус 2005 оны 12 дугаар сарын 8-ны өдөр батлагдаж, 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр бус болсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуультай дүйцэхүйц нарийн зохицуулалт бүхий хууль хэрэгцээт шаардлагатай байна. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн даатгал, халамж, хамгааллын асуудлыг нэг дор, нарийвчлан хуульчилсан байсан боловч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталснаар тус хууль хүчин төгөлдөр бус болсон.

Олон улсын зохицуулалттай харьцуулж үзвэл, ХБНГУ нь манай улсын адил Үндсэн хуулиндаа бүх хүнийг ялгаварлан гадуурхахгүй гэж заасан байдаг бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш эрхийн тухай хууль гэх хууль баталсан байдаг. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн байдлыг түлхүү зохицуулсан байдаг байна. Харин оюуны бэрхшээлтэй хүний хуулийг хуульчлаагүй байдаг ба бусад хуулиар зохицуулдаг байна.

Америкийн нэгдсэн улс мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хууль байдаг бөгөөд тус хуулиар оюуны бэрхшээлтэй хүний эрх зүйн байдлыг нарийвчлан хуульчилсан

байдаг. PTSD буюу сэтгэцийн өвчтэй хүмүүсийг бусадтай адил эрх эдлүүлэхийн тулд зохицуулалтыг хангалттай хэмжээнд хийсэн байна.

Оюуны бэрхшээлтэй хүмүүсийн тухай хууль нь дотроо иргэний, эрүүгийн, захиргааны эрх зүйн асуудлыг бүгдийг нь хамарсан байдаг тул үүнийг тусад нь авч хэлэлцэх шаардлагатай байдаг. Тэгвэл Монгол улсад буй 105,730 хүний дунд буй оюуны бэрхшээлтэй хүмүүсийн эрх зүйн зохицуулалтыг нарийн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хэлцэмж

Одоогийн байдлаар оюуны бэрхшээлтэй хүмүүсийн тухай судалгаа олон тоогоор гараагүй байгаатай холбогдуулан энэ талын судалгааг олшруулах, оюуны бэрхшээлтэй хүмүүсийн онцлог, тэдгээрийн эрхийн хамгааллын талаар мэдээллийг түгээх шаардлагатай. Тэдний онцлог шинжид тулгуурлан бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс ялгаатай талыг харгалзан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиас гадна Оюуны бэрхшээлтэй иргэдийн тухай хуулийг тусад нь батлах шаардлага эрх зүйн хүрээнд гарч ирж байна.

Иймд Оюуны бэрхшээлтэй иргэдийн эрхийн хамгааллын тухай хуулийг батлах, тэрхүү хуулийн хэрэгжилтийг хянах байгууллагыг тогтоох, ийнхүү хууль тогтох явцад олон улсын хууль тогтоомжууд, бусад улсын жишгээс суралцан тэдгээр хүмүүсийн эрхийг бүрэн хамгаалахын тулд хууль боловсруулах шаардлагатай гэх саналыг оруулж байна.

Дүгнэлт

Энэ илтгэлийн хүрээнд оюуны бэрхшээлтэй хүнийг онцлон авч байгаагийн учир нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийн онцлог болох IQ нь 70-аас доош, нийгэмд амьдрах чадвар нь хязгаарлагдмал байдагтай холбогдуулан ялгамжтай зохицуулах шаардлагатай гэж үзэж байна. Олон улсын тохирохуйц, хэрэгцээт хууль тогтоомжоос жишээ татан авч Оюуны бэрхшээлтэй хүмүүсийн тухай хуулийг батлах, хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Ном зүй

Хууль:

Монгол Улсын Үндсэн хууль

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Боловсролын тухай хууль

Нийгмийн халамжийн тухай хууль

Ном, сурах бичиг, судалгаа:

“Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, стандарт, төсөв санхүүжилт, багшлах боловсон хүчний талаар төрөөс баримталж буй бодлого”, Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төв, УБ, 2011

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, JICA, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, УБ, 2017

Интернет дэх эх сурвалж:

http://www.specialolympics.org/Sections/Who_We_Are/What_Is_Intellectual_Disability.apx

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА

Э.Нинжбадгар¹, Б.Болороо², А.Азжаргал³
¹Монголын Үндэсний Их Сургуулийн ХЗУС

Түлхүүр үг

Хүүхдийн эрх, хууль эрх зүй, боловсролын хүртээмж, тусгай боловсрол, эцэг эхийн хандлага

Хураангуй

Монгол улсад ХБХ сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй хүүхдийн тэгш эрхийн асуудал зөрчигдөж байна. Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль зэрэг нь тунхаг төдий байгаад анхаарал хандуулж хуулийн хэрэгжилтийг сайжруулах. ХБХ-н тоо дүн мэдээг бодитой болгох, ЕБС-ийн сургалтанд бүрэн хамруулах, сургалтын орчинг бэлдэж сайжруулах мөн тусгай багш бэлтгэх хичээлийн хэрэглэгдэхүүний хүрэлцээг сайжруулах, эцэг эхийн хандлагыг дээшлүүлэх, мэдээ мэдээллээр хангах талаар судалгаанд үндэслэж санал зөвлөмж боловсруулсан болно.

Судалгааны зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгаатай холбогдуулан Үндсэн хуулийн 16-р зүйлийн 7-д “Монгол улсын иргэн сурч боловсрох эрхтэй”, 19-р зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтуудын хэрэгжилт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх хэрхэн зөрчигдөж байгааг тогтоох нь судалгааны ажлын зорилго юм.

Судалгааны зорилт

1. ХБХ-ийг сургах талаарх хууль эрх зүйн орчинг судлах
2. ХБХ-тэй хүүхдүүдийн суралцах боломж сургуулийн хүрэлцээг судлах
3. Багшлах боловсон хүчин болон сургалтын орчинг судлах
4. Эцэг эхийн хандлагыг судлах

Судалгааны арга

Эрх зүйн баримт бичгийн судалгаа, социологийн судалгаа, асуулга, анкет, нэгтгэх, дүгнэх аргуудыг хэрэглэх.

Судлагдсан байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох орчин нөхцлийн талаарх судалгааг Д.Батжаргал, доктор Д.Одгэрэл, доктор Г.Батцэнгэл гэх мэт олон эрдэмтэн судлаач нар судалсан болон Дэлхийн банк, Юнеско, НҮБ, НХХЯ, ЭМЯ болон бусад газруудын санхүүжилтээр хийгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд заах сургалтын арга зүй, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах цогц бодлогуудын талаар мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах хэрэгцээ шаардлагын тухай олон арван судалгааны ажил байдаг ч практик хэрэглээнд төдийлөн хэрэгжээгүй байна.

Судалгааны үндэслэл

Зайлшгүй тусгайлсан сургалтанд хамрагдах ёстой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо бүртгэл тодорхойгүй, тэдгээр хүүхдүүдийг бүрэн дүүрэн боловсролын үйлчилгээнд хамруулж сургахад сургууль болон мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ муу, сургалтанд зориулсан ном, сурах бичиг, гарын авлага хүртээмжгүй мөн тэдгээрийн агуулга, стандарт, орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд хүүхдүүдээ сургах, боловсролтой болгох нийгэмшүүлэх талаар хангалттай мэдлэг мэдээлэл байхгүй буюу ийм асуудалтай хүүхдийг сургалтанд хамруулахад эцэг, эхэд тохиолддог нийтлэг бэрхшээл гэх мэт олон асуудал нийгэмд тулгараад байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн адил сурах, боловсрол эзэмших үйл явцад тулгараад байгаа асуудлыг тодруулах, цаашид санал, зөвлөмж гаргах үүднээс энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Үндсэн ойлголт

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэн бэ?

Төрөлхийн болон удамшлын эмгэг, өөрчлөлт, эсвэл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдэрхүйн чадавхи алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно.¹

Бэрхшээл гэж юу вэ? Хүний эрүүл хөгжих зүй тогтолд саад тотгор учрахыг бэрхшээл гэнэ. Бэрхшээлийг үүссэн байдал, заслынх нь хувьд 3 ангилдаг.²

1. Ерөнхий бэрхшээл /голчлон эрүүл хүүхдэд тохиолдоно./
2. Тодорхой бэрхшээл/тодорхой нэг төрлийн үйл ажиллагаанд учирсан саад бэрхшээлийг хэлнэ. Тухайлбал: унших, бичих ярих, явах зэрэгт үүсч танин үйлд саад тотгор болж байдаг./
3. Тусгай бэрхшээл /Өвчний үед тохиолдоно./ илрэлээр нь 3 ангилж үздэг
 - А. Үндсэн бэрхшээл /хараагүй, сонсголгүй /
 - Б. Дагалдах бэрхшээл /энэ нь нэг буюу хэд хэдэн бэрхшээл нэгэн зэрэг илэрсэн хам шинж юм./
- В. Хүндрэх бэрхшээл /энэ нь өвчний явц илүү даамжирч хүндэрсэн үеийн бэрхшээл³

График 1

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан




График 2

Хөгжлийн бэрхшээлийн төрөл



Дэлхийн хүн амын нэг тэрбум гаруй буюу 15 орчим хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлийн хэлбэртэй амьдарч байна гэсэн судалгааг ДЭМБ-ын 2010 оны дэлхийн хүн амын тооцоон дээр үндэслэн гаргасан байна.⁴

Дэлхий дээр 200 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдгийн 80 хувь нь хөгжиж буй орнуудад амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 90 хувь нь боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байгаа нь тун харамсалтай⁵.

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ. Мөн хүүхэд бүр 16 нас хүртлээ заавал суралцах ёстой бөгөөд төрийн өмчийн сургууль ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгодог.

Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хуулийн зүйл заалт нь нилээн олон хуулийг хамран зохицуулагддаг.

Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ эрхийг хангаж, хамгаалах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг нэмэлт протоколын хамт 2008 оны 12 сарын 19-ны өдөр УИХ-аар баталсан. 2009 оны 5 сарын 3-ны өдөр НҮБ албан ёсоор Монгол улсыг бүртгэснээр энэ конвенц Монгол улсад хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж байна.

1 УИХ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” 2005 он
 2 МУБИС-ийн БС, “Бага боловсролын сурган хүмүүжүүлэх арга зүй” УБ, 2010 он, 64-р тал,
 3 МУБИС БС” Бага боловсролын сурган хүмүүжүүлэх зүй УБ, 2010 он 65-р тал

4 “ХБ судлал нь салбар дундын ШУ болох нь” сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл, УБ 2017 он. 7-р тал
 5 Handicap International and Save the Children, “Out from the Shadows” Study Rep

Мөн Монгол Улсын Засгийн газар хүний эрх, хүний хөгжил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаарх дэлхий нийтийн зорилтуудыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг амлалтыг хүлээсэн байдаг. Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Бивакогийн Мянганы Хөтөлбөрийн хүрээнд бүрэн оролцоог хангасан ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлоон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч 2002 онд баталсан.

Мөн Монгол улсын хувьд Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2006 оны 283-р тогтоол, УИХ-аас баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-аас гаргасан оюуны хомсдолтой хүний эрхийн тухай тунхаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаг, Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүний тунхаг, Дакарын тунхаг зэрэг олон хууль, эрх зүйн актуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулж, орчин нөхцлийн хамаарлыг сайжруулах ажлыг цогц бодлогын хүрээнд дэвшүүлэн тавьсан байдаг.

Эрх зүйн баримт бичгүүдэд заасан ХБХ-ийн талаарх эдгээр олон эрх нь амьдрал дээр хэрэгжихгүй зөрчигдөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 гаруй хувь ерөнхий боловсролын сургуульд элсэн ордог ч суурь боловсрол эзэмшиж байгаа нь 14 хувь болтлоо буурсан байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчин, нөхцөл боломж муу байгаатай холбоотой⁶.

Мөн “Тэгш хамруулах боловсрол” гэсэн ойлголтоор ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралтгүй үйл явц юм гэж заасан нь хэрэгжилт үр дүн муутай байна. (Женев, ОУ-ын Боловсролын бага хурал, 2008).

6 НБГ-ийн мэдээ 2017 он

Судалгааны хэсэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон үзүүлэлт

Монголд ХБХ-ийн тоо баримт зөрүүтэй ба ХБ-тэй иргэдийн талаарх нэгдсэн судалгаа байхгүй нь дараах баримтаас харагдаж байна.

Монгол улсын албан ёсны статистик тоон мэдээгээр 68971 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд Монголд байгаа тухай дурьдсан байхад БСШУЯ-ны мэдээнд 35899 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд Монголд байна гэсэн мэдээ байна.

Мөн НХХЯ, ҮСГ, ЭМЯ-аас гаргаж буй тоон мэдээлэл зөрүүтэй байдаг. Тухайлбал ЭМЯ-ны судалгаагаар 115 мянган ХБ-тэй иргэн үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн гурван жилийн байдлаар 34 мянгаас 41 мянга болтлоо нэмэгдсэн гэсэн тоо баримт байна⁷.

ҮСГ-ийн мэдээгээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүйс, аймаг, нийслэлээр⁸

График 3

Аймаг	Хүйс	2018 он
Улсын дүн	Нийт	105,730
Улсын дүн	Эрэгтэй	59,6910
Улсын дүн	Эмэгтэй	46,039
Улаанбаатар	Нийт	35,589
Улаанбаатар	Эрэгтэй	19,728
Улаанбаатар	Эмэгтэй	15,861

Нийт хөгжлийн бэрхшээлтэй 105 630 орчим иргэн байгаагаас 30 000 орчим нь хүүхэд байна гэсэн тоо мөн улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 22000 гаруй хүүхэд сургуульд суралцаж байгаа гэсэн тойм судалгаа ч бий.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдсан байдал

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, ЕБС, СӨБ хамрагдалт, хүйсээр 2018 он						
Дүүрэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Эрэгтэй	Эмэгтэй	Сургуульд сурдаг	Цэцэрлэгт хамрагддаг	Цэцэрлэг, сургуульд хамрагддаггүй
Багахангай	25	13	12	13	1	11
Налайх	172	73	99	90	6	76
Багануур	133	53	80	31	5	77

7 ЭМЯ-ны судалгаа тоо баримт

8 Статистикийн мэдээллийн нээсэн сан 2017 он

Сонгино-хайрхан	953	414	539	299	69	585
Баянзүрх	785	366	419	229	45	511
Баянгол	622	268	354	226	90	306
Сүхбаатар	264	112	152	95	45	124
Чингэлтэй	585	269	316	258	39	288
Хан-Уул	0	0	0	0	0	0
Нийслэлийн нийт дүн	3 539	1 568	1 971	1 241	300	1 978

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, энгийн хүүхэд, залуучуудаас ялгаатай ч сурч, боловсрон, мэргэжил эзэмших эрх бүрэн нээлттэй.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, оюутан залуусын сурах орчин нөхцөл хангалтгүйгээс тэд сургууль завсардах, нийгмээс тусгаарлагдмал нэгэн болох хандлага нэмэгдэж байгаа юм.

Нийслэлийн 225 сургуульд 3232 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 623 цэцэрлэгт 694 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байна. Нийт боловсролын үйлчилгээнд 3926 хүүхэд хамрагдаж байна.

Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын газраас авсан судалгаа мэдээллээс харахад:

Тусгай хэрэгцээт боловсрол гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй оюун ухааны хөгжил дутуу, хэл, хараа, сонсголын эрхтний согогтой хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан тусгаарлан боловсрол олгох⁹ сургах тогтолцоо юм. Иймээс тусгай сургууль болон ердийн сургуулийн дэргэд тусгай анги бүлэг хэлбэрээр оршиж байдаг.¹⁰

НХХЯ авсан тоон мэдээллээс үзэхэд Монгол улсад зөвхөн Улаанбаатар хотод

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад чиглэсэн үндэсний зургаан сургууль үйл ажиллагаа явуулж, тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлж байна.

График 4




График 5

Сургуульд хамрагдсан байдал

Монгол улсын статистик мэдээлэл 2018 он¹¹

График 6

Сургууль	Сургуулийн төрөл	Сургуулийн тоо	Хүүхдийн тоо
Сургуулийн өмнөх боловсрол			1438
Бага дунд боловсрол			12673
Ерөнхий боловсрол			1889
Тусгай сургууль	Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль	4	
	Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургууль	1	
	Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн	1	
Их, дээд сургууль, коллеж			1563

Одоогоор нийслэлийн хэмжээний 241 сургуульд нийт хөгжлийн бэрхшээлтэй 2836 суралцагч байна¹².

1990 оноос хойш Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмд тэгш хамруулах, нийгэмшүүлэх байр сууринаас тэднийг ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд (ЕБС) сургаж, бусад хүүхдүүдтэй хамт боловсрол эзэмшүүлэх бодлого голлох болсон.

Одоогийн байдлаар Монгол улс хөнгөн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй

9 УИХ “Бага дунд боловсролын тухай хууль” 2002 оны 05сарын 03-ны өдөр

10 МУБИС БС “Бага боловсролын сурган хүмүүжүүлэх зүй УБ, 2010 он, 65-р тал

11 Статистикийн ерөнхий газар мэдээллийн сан 2015 он

12 Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхэтгэл VI. 2017-2018 хичээлийн жил

хүүхдүүдийг гурван чиглэлээр боловсрол эзэмшүүлж байна:


- Ердийн сургалттай ЕБС-д
- Тусгай сургалттай ЕБС-д
- ЕБС болон албан бус сургалтын төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээл, нас харгалзалгүй нэг ангид “сургаж” байна.

Хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх

Манай улсад эцэг, эх, багш нар хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг хомс, хүүхэддээ хайхрамжгүй ханддаг, эсвэл амьдрал хүнд ядуу, хаана хандаж хүүхэддээ үнэлгээ хийлгэх тухай мэдэхгүй, зарим нь анхаарч хөөцөлддөг ч очих газар хомс олдохгүй байх, чирэгдэлтэй хорооны нийгмийн ажилтан, өрхийн эмчийн тандалт судалгаа, муу хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулахгүй байгаа зэргээс шалтгаалж хөгжлийн бэрхшээлийг оройтож илрүүлж байна. Энэ байдал нь эцэг эх, асран хамгаалагчдаас авсан анкет, асуулгын дүнгээс харагдаж байна. Иймээс хөгжлийн бэрхшээлийг оройтож илрүүлэх нь тухайн хүүхдийн сурч боловсрох болон бүх талаар хөгжихөд муугаар нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотроос хөдөлгөөний бэрхшээл, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүд нь сургууль, цэцэрлэгт явах, бие даан очиж чадахгүй, багш нар дургүйцдэг, хичээлээ ойлгодоггүй, хаана хэнд хандаж боловсролын ямар үйлчилгээ авахаа мэдэхгүй байсаар байна.

График 7




Гэтэл улсын хэмжээнд байгаа 6 тусгай сургуульд ердөө 1670 хүүхэд л суралцаж байна. Нийслэлд дараах ХБ хүүхдүүд сурах эрхээ эдлэж чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо Улаанбаатар хотын дүүрэг тус бүрээр (2015-2016 оны хичээлийн жил)¹³

¹³ Боловсролын статистик эмхэтгэл 2015 он. Нийслэлийн боловсролын газар

График 8



Сургалтын орчин

ХБ хүүхдэд сурах боломжийг нээлттэй, хүртээмжтэй болгоход сургууль, цэцэрлэгийн сургалтын орчны таатай нөхцөл маш чухал юм.

Монгол улсад тусгай сургуулийг оролцуулан тэргэнцэртэй хүүхэд орох гарах налуу замтай сургууль нийслэл хотод нь гэхэд л 2 байдаг, брайль болон ярьдаг сурах бичгээр бүрэн хангагдсан сургууль байхгүй, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн авианы сонсголыг хөгжүүлэх, сул сонсголтой хүүхдийн сонсох чадварыг хөгжүүлэх сургалтын орчин бүрдээгүй байна.

Хэвлэмэл материал ашиглах бэрхшээлтэй, мөн сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд ашиглах сурах бичиг олддоггүй учир, аль олдсон номыг хичээл дээрээ сурах бичиг болгон ашиглах явдал тохиолдож байна. Хөгжлийн бэрхшээлгүй эрүүл хүүхдүүд сурах бичгийг олон хувилбартай сонгох боломжтой байхад ХБ-тэй хүүхдүүдэд сурах бичиг олдохгүй байна.

Өнөөдрийн байдлаар зохих хууль тогтоомжид брайль үсэг, ярьдаг ном, дохионы хэлийг заах, сурах явдлыг дэмжих талаар зохицуулаагүй байна. Энэ нь сурах орчныг бүрдүүлэх, хүртээмжтэй болгох талаар төр өөрөө Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа илрэл юм.

ХБ хүүхдүүдийн ихэнх нь бага насаа гэр бүлийн орчинд өнгөрүүлж байгаа учраас бусадтай харьцахад хүндрэл учрах, ичих, айх эмээх бэрхшээл тулгардаг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн энэ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, үе тэнгийнхэн болон сургуулийн удирдлага, багш нарын зүгээс тэдний нэр төрийг нь хүндэтгэн харьцах хандлага төлөвшөөгүй байна.

Хүнд хэлбэрийн ХБ хүүхэд их, дээд сургууль, коллеж, МСҮТ-тэд сурахад мөн л сурах бичиг, барилга байгууламж, зам талбай орох гарахад саадтай, нийтийн ариун цэврийн

өрөө, номын сан зэрэг нь хүртээмжгүй байгаа нь тэднийг сурахад бэрхшээл учруулдаг нь мөн судалгаанаас харагдаж байна.

Багшлах боловсон хүчин

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах орчин бүрдээгүй, багш нар бэлтгэгдээгүй, багш нарт урамшуулал олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж байгаа багшийн ажлын үр дүнг дүгнэх тусгай механизм байхгүй байна.

Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах сургах багш бэлтгэгдээгүй байна. Одоогоор багш бэлтгэж буй их, дээд сургуулийн боловсролын стандартад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээний талаар, тэдгээр хүүхдүүдтэй харилцах, харилцааны ур чадварын талаар сургалтын хөтөлбөр байхгүй тул шинээр бэлтгэгдэж буй боловсон хүчнүүд энэ талаар ямар ч мэдлэг ойлголтгүй төгсөж байна. Энэ нь тэднийг ХБ-тэй хүүхэдтэй ажиллах арга зүйг мэдэхгүй, улмаар тэднээс татгалзахад хүргэдэг байна.

Хуулинд нэмэлт өөрчлөлт хийж Боловсролын тухай хуулийн 43.1.8-ыг “Ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох”¹⁵ гэж өөрчилсөн нь бага, дунд боловсролын сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс төвөгшөөж, цааргалдаг байсан явдлыг эдийн засгийн аргаар өөрчлөх нэгэн томоохон хөшүүрэг болсон ач холбогдолтой.

Түүнчлэн бага, дунд боловсролын тухай хуулийн 13.6-г “Ерөнхий боловсролын тусгай сургуульд энэ хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллана”¹⁶ гэж өөрчилсөн нь дунд болон хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхэд бусад эрүүл хүүхэдтэй нэг түвшинд суралцах боломжийг хангаж өгсөн онцлогтой.

Энэ мэтчилэн хуулийн хэм хэмжээнд өөрчлөлт оруулах ажлыг эрчимтэй хийж

хэрэгжүүлсээр байгаа ч цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ сургах боловсруулах талаар төрөөс ямар чиглэл баримталж байгаа нь тодорхой биш.

Сургалтын орчин нөхцөл хуульэрх зүй бодит байдал хоорондоо хол зөрүүтэй байгаа нь ХБХ-ийн сурч боловсрох эрх зөрчигдөх суурь болж байна.

Нийгмийн хандлага

Ядуурал Хөгжлийн бэрхшээл хоёр нь хоорондоо хүчтэй харилцан холбоотой байдаг. Ядуурал нь хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг нэмэгдүүлдэг бол мөн хөгжлийн бэрхшээлээс үүсэх ядуурал байх боломжтой.

Ядуу амьдралтай жирэмсэн эмэгтэй эрүүл мэндийн доройтол, хоол тэжээлийн дутагдал, бодисын нөлөө, орчны бохирдолтод өртөх магадлалтай ба амьдралын нөхцөл байдал зэрэг нь ургийн хөгжилд шууд нөлөөлнө.

Ядуу амьдралтай хүүхдүүд хоол тэжээлийн дутагдалд орох, ариун цэвэр, эрүүл ахуйн таагүй нөхцөлд амьдрах, халдвар авах, өвчлөх нөхцөл үүсэх, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх, зарим нь орон гэргүй, асрамж, арчилгаа дутагдах, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх, сэтгэл санааны хямралд орох, хөгжлийг нь дэмжиж өдөөх сэдэл, орчин дутагдах зэрэг олон янзын эрсдэлд өртөж байдаг. Мөн хүүхдэд асаргаа халамж үзүүлэхийн тулд эцэг эх нь орлого олоход зарцуулах цагаа багасгахын зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлийн улмаас үүсэх эрүүл мэнд, тээврийн зэрэг нэмэлт зардал үүсэж, өрхийн түвшний ядуурлыг даамжруулах магадлалтай хүчин зүйл юм.

Харьцуулсан судалгаа

МОНГОЛ УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол улс НҮБ-ын гишүүн орныхоо хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол улсын үндсэн хуулиа дээдэлж, хүүхэд багачуудынхаа хөгжих, боловсрох эрхийг хамгаалан 1996 онд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хууль баталснаас гадна Боловсролын багц хуулинд бүх хүн суурь боловсрол эзэмшсэн байх ёстой гэж заасан байдаг.

Хууль эрх зүйн талаас нь авч үзвэл, Монгол Улсын Үндсэн хуульд бүх хүүхэд сурч боловсрох эрхтэйг баталгаажуулсан байдаг.

Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцэд Монгол улс нэгдэн орсон бөгөөд тус конвенцэд гарын үсэг зурсан улс орнууд хүүхэд бүрийн боловсрол эзэмших эрхийг хангахын төлөө ажиллах үүрэг хүлээдэг билээ.

Бүх нийтэд боловсрол олгох олон улсын хөдөлгөөн, Боловсрол эзэмших тусгай хэрэгцээний тухай Саламанкагийн мэдэгдэлд Монгол улс нэгдсэн бөгөөд Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боловсролд тэгш хамруулдаг, саад бэрхшээлийг арилгасан, эрхэд тулгуурласан нийгэм байгуулах талаар авах арга хэмжээний Бивакогийн ерөнхий хүрээний төслийг гаргахад оролцсон билээ. Эдгээр гэрээнд тулгуурлан Засгийн газраас бүх хүүхдэд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чанартай боловсрол олгох зорилт тавин ажиллаж байгаа ч үр дүн муу байна.

ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудал нь маш ярвигтай, зарим үед маргаантай асуудал хэвээр байна..

Хөнгөн болон хүндэвтэр зэргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг нь харгалзан ердийн сургуульд сургах нь эдийн засаг, нийгэм, хүний эрхийн талаас нь авч үзвэл тун зохимжтой, үр өгөөжтэй байдгийг дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрөөд байгаа боловч тусгай сургуулийн гүйцэтгэх үүргийн талаар болон хүнд буюу давхар хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж болох эсэх, ер нь боловсролд хамруулах ёстой юу гэдэг асуудал нь боловсролын салбарт ажиллагчдын дунд нэлээд маргаантай асуудал хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудал нь Азийн ихэнх оронд харьцангуй шинэ ойлголт бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын хувь ерөнхийдөө маш хангалтгүй, доогуур байдаг.

- Солонгос улсын туршлагаас авч үзэхэд Солонгос улсын Үндсэн хуулийн 23-р хэсэгт “Бүх хүн өөрийн чадварт тохирсон боловсролыг эзэмших эрхтэй” гэж заасан байдаг. Солонгос улсад тусгай сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөр /харааны

бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, оюун ухааны бэрхшээлтэй, хүнд өвчтэй гэх зэргээр төрөлжсөн байдаг бөгөөд Тусгай боловсрол хөгжихөд Солонгосын Боловсролын Яамнаас 1977 онд байгуулсан Тусгай хэрэгцээт боловсролын үндэсний хүрээлэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Солонгос улсад дараах хуулиуд хэрэгжиж байна.

- Солонгосын тусгай боловсролын тухай хууль
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбогдох тусгай боловсролын тухай хууль
 - Бага, дунд, дээд боловсролын тухай хууль
 - Бага насны хүүхдийн боловсролын тухай хууль
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн хууль
 - Нялх хүүхдийн асран хамгаалалтын тухай хууль
 - Хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан, Жирэмсэн эхчүүдийн тав тухыг нэмэгдүүлэх хууль
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн эрхлэлтийн тухай хууль
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль Эдгээр хуулиуд
1. **Багшийн бэлтгэл:** Багшийн үнэмлэх: Багшийн дээд сургууль нь Тусгай боловсролын анги (4 жилтэй их, дээд сургууль) төгссөний дараа шалгалт өгч тусгай боловсролд багшлах эрх авдаг.
 2. **Багш томилолт:** цэцэрлэг /бага сургууль/ дунд сургуулиар хуваагдан томилогдоно. Жил бүр улсаас багш томилолт явуулна.
 3. **Багшийн шалгалт нь:** (1 үеийн шалгалт тестийн шалгалт, 2 үеийн шалгалт ярилцлага авч түүний үндсэн дээр томилдог.)

Тусгай боловсролын байгууллагын одоогийн нөхцөл

Багшлах бүрэлдэхүүний хувьд /Хамтарсан багийн бүрэлдэхүүн/ Явуулын багшийн сургалтын онцлог

Хөгжлийн бэрхшээлийн хүнд алдагдалтай хүүхдүүдэд явуулын багш очиж боловсрол олгодог системтэй. Явуулын багш нь эмнэлэг, асрамжийн газар, гэрээр очиж боловсрол олгодог байна. Боловсролд тэгш хамруулах асуудал нь нийгэмд хамгийн их ялгаварлан гадуурхагддаг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чанартай

боловсрол эзэмших эрхийг хангахад практик ач холбогдолтой, өртөг багатай арга болох нь улам бүр нотлогдсоор байгаа билээ. Иймээс ч ихэнх улс орон бүх хүүхдийг ялгаварлалгүйгээр боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй хэрэгжүүлж, боловсролд хамрагдах хүүхдийн тоо жил бүр өссөөр байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын хувьд ХБХ-ийн тоо жилээс жилд өсөж байгаа нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэргээн засах тусламж, боловсролын хүртээмж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг үндэслэлтэйгээр судалж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох шаардлагатай болж байна.

Монгол улс эрх зүйн олон баримт бичигт ХБХ эрхийн талаар тусган өгсөн байдаг ч хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй, зөвхөн тунхагийн шинжтэй байдаг бол хүний эрхийн талаар зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хариуцлагын механизм сул, хууль хэрэгжүүлэх явдал төрийн зүгээс шаардлага хангах түвшинд хүрэхгүй байна.

ХБХ-ийн эрхийг хангах үүднээс үндэсний эрх зүйн баримт бичгүүдээ ОУ-ын байгууллагын зөвлөмж, бусад орны туршлагыг нэвтрүүлэх замаар шинээр боловсруулан гаргах шаардлагатай.

ХБХ-ийг ялгаварлан үзэх хандлагыг өөрчлөхийн тулд Засгийн газарт ХБ-ын талаарх асуудлыг нэгтгэн зохион байгуулах зорилго бүхий тогтмол ажиллагаатай орон тооны бүтэцтэй байх шаардлагатай.

Явган хүний зам, нийтийн тээврийн дэд бүтэц хангалттай бүрдээгүйн улмаас тэргэнцэртэй иргэд, хараагүйчүүд гадуур явах, нийтийн тээврээр зорчих боломжгүй нөхцөл бүрдээгүй, ХБИ-ний галт тэрэг, онгоц, хот хооронд зорчих талаар зохицуулсан ямар ч хууль тогтоомж үгүй нь ХБ хүмүүс нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох эрхийг хаасаар байна.

Сургалтын орчин муу, анги дүүргэлт хэт их, сургалтын материал, техник хэрэгсэл дутагдалтай байгааг анхаарч Брайль үсгийн ном, ярьдаг ном, дохионы хэлний талаар хуульчлах, стандартчилах, түүнийг

хэрэглэх тухай заавар, дэмжлэг туслалцаа шаардлагатай байна.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн байгууллагын харилцан уялдаа холбоо муу, мөн ХБ-ийн талаарх мэдээлэл гэр бүл ба нийгэмд хангалтгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аль болох эрүүл хүмүүсийн дунд байлгаж, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зориулалтын сургууль цэцэрлэгт нь явуулахаас илүү энгийн сургууль, цэцэрлэгт хамрагдуулж, аль болох нийгмийн бүхий л үйл ажиллагаанд жирийн хүүхдүүдийн адил ороцуулж байх нь тухайн хүүхдийг өөртөө итгэх итгэлтэй болгох, цаашлаад нийгэмд өөрийн гэсэн байр суурьтай бие хүн болон төлөвшихөд нь маш том түлхэц болно.

Гэтэл эцэг эх, асран хамгаалагчид нь ажил эрхлэхэд хүндрэлтэйн улмаас ядууралд өртөмтгий, ХБХ-ийг хүлээн авах сургууль хомс, тусгай сургуулийнх нь сургалтын агуулга нь хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцдэггүй, багш нарын арга зүй хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарыг урамшуулах тогтолцоо бүрдээгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн бодлогын хэрэгжилтийг жигд хангаж ажилладаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулахын тулд дан ганц төр засаг гэлтгүй хувь хүн бүр сэтгэл гарган оролцох хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад дараах асуудлууд дэвшүүлж байна.

1. Хууль, Эрхзүйн бодлогын хэрэгжилтийг жигд хангаж ажиллах, хариуцах эзэнтэй байх.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тэдний мэдээлэл хүртэх эрх чөлөөг хангахад чиглүүлж “Боловсролын тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, Үндэсний хөтөлбөрүүдэд зохих засвар хийж тодорхой болгох.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, хамт олон дунд нийгэмшүүлэх асуудлыг тодорхой тусгасан зүйл заалтыг

- “Боловсролын тухай Мэргэжлийн сургалт, боловсролын тухай” хуулиудад нэмж оруулах
- Олон заалт хэрэгжихгүй байгаа нэг үндсэн шалтгаан болж байгаа хуулиудад /санкци/ хариуцлагыг орхигдуулсан буюу дутуу, хангалтгүй заасан зүйлийг нөхөх, чангатгахад чиглэсэн арга хэмжээ авах
 - Хуулийн хэрэгжилт хангалтгүй, тунхаг төдий байгаатай холбогдуулан хуулийн хэрэгжилтийн хяналтыг хүчтэй болгох, дүгнэх, хариулага тооцох.
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар бодитой ажил зохион байгуулахыг хариуцсан яамд онцгой анхаарах.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэднийг өөрсдийнх нь боломжид тулгуурлан сурах боломжийг хөгжүүлэх нь үр дүнтэй байдалд хүрэх
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин бүрдсэн сургуулийн тоог нэмэгдүүлэх, шаардлага хангасан багшлах боловсон хүчний бэлтгэн гаргах.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн Холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан зохицуулах арга хэмжээ авах
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, гэртээ хүрэх зам гэх мэт хэрэгцээ шаардлагад нийцсэн дэд бүтэц бий болгож байгаа олон улсын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх
 - Хөгжлийн бэрхшээлийн алдагдлын түвшинд тохирсон сургалтын гарын авлагыг тогтмол шинэчлэн хэвлүүлэх, хүртээмж хангамжийг сайжруулах тал дээр анхаарах
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш, сурган хүмүүжүүлэгч нар луу чиглэсэн сургалт, семинарыг тогтмол системтэйгээр явуулах
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж буй сургуулийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах
 - Бэрхшээлийн дагнасан хэлбэрээр тусгай ангийг бий болгох
 - Хөгжлийн бэрхшээл бүрийн онцлог хэрэгцээг хангах боловсролын тогтолцоог бүрдүүлэх цогц хуультай болох
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгмийн харилцаанд тэгш оролцож үе тэнгийнхэнтэйгээ чөлөөтэй харилцахын тулд ерөнхий боловсролын сургуулиудад дохионы хэлний хичээлийг нэвтрүүлэх
 - Бэрхшээл нь хүндэрсэн сургуульд явж чадахгүй байгаа хүүхдүүдэд явуулын багштай болж боловсрол эзэмшүүлэх
 - ХБ-тэй хүүхдийн талаарх статистик тоо баримт зөрүүтэй, буруу байгаа нь тэдний талаар төр засгаас гарах шийдвэр оновчтой бус байснаар эцэстээ хүүхдүүдийн эрхийг зөрчихөд ч хүргэх тул ХБХ-үүдээ эрт оношлон, бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлэх шаардлагатай юм.

НОМ ЗҮЙ

- Хүүхдийн Эрхийн Конвенц (1989) 2-р бүлэг, 23-р зүйл, 28, 29-р зүйл
- Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2013 он
- Бага, дунд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2013 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай”
- Дакарын үйл ажиллагааны хөтөлбөр (2000) 6-р бүлэг
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн дүн мэдээ
- Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэсээс ирүүлсэн судалгаа
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга ба дүн шинжилгээ УБ хот 2011он

Цахим эх сурвалж

- www.fcy.gov.mn/data/main/main1492657220.pptx
- hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514_02.pdf
- www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=TAILAN_2011
- Legalinfo
- <http://child.gov.mn/>
- www.fcy.gov.mn/data/main/main

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ АРГА ЗАМ

Б.Намсрай¹

¹Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Түлхүүр үг:

Хохирогч, мэдээлэл, хамгаалалт, дэд бүтэц

Хураангуй:

Өнөөгийн нийгэм, иргэдийн өмнө тулгамдаж буй гэр бүлийн хүчирхийллийн асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд илүү хүндээр тусч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бие дааж эрхээ хамгаалах чадвар дутмаг байдгаас хүчирхийлэлд удаа дараа өртөх эрсдэл илүү өндөр байдаг. Цагдаагийн байгууллагад жил тутам бүртгэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 0.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн өртөж хохирсон тохиолдол эзэлж байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл нийгэмд хир нуугдмал байгааг илэрхийлж байна. Учир нь аливаа хүчирхийллийн үндсэн шалтгаан нь хохирогчийн сул дорой байдал юм. Гэр бүл, ахуйн хүрээнд үл зөвшөөрөгдөх, гоочлогдох, албаар эрхээ хязгаарлуулах, бусдын гарыг харах, түүнтэйгээ эвлэрэх, юу бодож хүсэж байгаа нь түүний ойр дотныхонд сонин биш зэрэг таагүй хандлагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн нийтлэг хэлбэр гэж олон улсад үздэг байна. Харж хандахгүй, хамгаалахгүй, дэмжлэг үзүүлэхгүй, санаа бодлыг нь үл хайхарна гэдэг нь эдгээр хүмүүсийн эсрэг төгс хүчирхийлэл билээ. Энэхүү хүчирхийлэл газар авах суурь шалтгаан нь нуун дарагдуулах явдал билээ. Судалгааг статистикийн дүн шинжилгээ, гомдол мэдээлэлд түүвэр судалгаа хийх, эрэн сурвалжлах, цаг хугацааны хүснэгт зохиох, харьцуулах зэрэг арга аргачлалаар явууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирох тохиолдлыг бууруулах, хохирогч бүрийг бүртгэж авах, улмаар тэднийг хүчирхийлэгчийн нөлөөнөөс холдуулах, хүчирхийлэгчид хуулийн хариуцлага хүлээлгэх асуудал тулгамдсан байна. Уг асуудлыг шийдвэрлэх гарц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хүссэн мэдээллийг хүлээн авах шугам харилцааг бий болгох явдал юм.

Судалгааны зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөж буй нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар санал дэвшүүлэх.

Судалгааны зорилтууд

- Хохирогчдын бүтэц, тархац;
- Хүчирхийлэгч, хохирогч нарын хамаарал;
- Хохирогчдын сэтгэл зүйн байдлыг тус тус судлах;
- Хохирогчоос гэмт хэргийн тухай мэдээллийг авах арга замыг тодорхойлох.

Судалгааны арга зүй

Хохирогчдын бүтэц, тархац, хүчирхийлэгч, хохирогч нарын хамаарлын талаарх судалгааг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд (ОД программ) бүртгэгдсэн гэмт хэргийн болон гомдол мэдээллийн тоон үзүүлэлт, товч утгад дүн шинжилгээ, харьцуулалт хийх аргаар явуулсан.

Хохирогчдоос гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авах, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах арга замыг тодорхойлох судалгааг баримт бичигт түүвэр хийх, дуудлага, мэдээллийн санд (EIN программ) анализ хийх аргаар явуулсан.

Үр дүн

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн статистик мэдээгээр гэмт хэргийн улмаас 2018 онд 240, 2019 оны эхний 10 сард 236 хөгжлийн бэрхшээлтэй хүн хохирсон байна.

Үүнээс:

д/д	Нас/хүйс	2018 он	2019 оны эхний 10 сар
Хүйс	Эрэгтэй	142	132
	Эмэгтэй	98	104
Нас	60-85	33	16
	50-60	29	41
	40-50	57	49
	30-40	54	50
	18-30	49	55
	0-18 хүртэлх	18	25

д/д	Хохирогч нарын хөгжлийн бэрхшээлийн төрөл	2018 он	2019 оны эхний 10 сар
1	Харааны бэрхшээлтэй	60	59
2	Сонсголын бэрхшээлтэй	54	57
3	Тахир дутуу	40	39
4	Оюуны хомсдолтой	37	57
5	Давхар бэрхшээлтэй	51	24

д/д	Өртөж хохирсон гэмт хэргийн төрөл	2018 он	2019 оны эхний 10 сар
1	Хүнийг санаатай алах	2	3
2	Хүнийг амиа хорлох нөхцөлд хүргэх	7	15
3	Хүнийг болгоомжгүйгээр алах	3	-
4	Хүний биед хүнд, хөнгөн гэмтэл учруулах	61	64
5	Хучиндэх	26	30
6	Хулгайлах, дээрэмдэх, залилах	92	69
7	Бусад	49	55

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2018 онд 9, 2019 оны эхний 10 сард 10 хүн хохирсон. Үүнээс:

д/д	Нас/хүйс	2018 он	2019 оны эхний 10 сар
Хүйс	Эрэгтэй	2	2
	Эмэгтэй	7	8
Нас	60-85	2	1
	50-60	2	2
	40-50	1	1
	30-40	2	3
	18-30	1	2
	0-18 хүртэлх	1	1

д/д	Хохирогч нарын хөгжлийн бэрхшээлийн төрөл	2018 он	2019 оны эхний 10 сар
1	Харааны бэрхшээлтэй	3	3
2	Сонсголын бэрхшээлтэй	-	1
3	Тахир дутуу	3	2
4	Оюуны хомсдолтой	1	2
5	Давхар бэрхшээлтэй	2	2

д/д	Хүчирхийлэгчтэй ямар холбоотой болох	2018 он	2019 оны эхний 10 сар
1	Эхнэр	3	2
2	Нөхөр	-	1
3	Төрсөн эх	1	-
4	Төрсөн эцэг	1	-
5	Төрсөн хүү	-	1
6	Дагавар охин	1	-
7	Эмээ	1	-
8	Төрсөн ах эгч	-	2
9	Хүргэн	-	1
10	Хамтран амьдрагч	2	2
11	Гэр бүлийн бусад гишүүн	-	1

Хэлцэмж

2018 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдын байршлыг хувьд авч үзвэл Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд тус бүр 1, бусад нь орон нутагт, 2019 онд хүчирхийлэлд өртсөн хохирогчдын хувьд

Сонгинохайрхан, Баянгол, Багануур дүүрэгт тус бүр 1, бусад нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүн өртөж хохирсон гэр бүлийн хүчирхийлэл орон нутгийн түвшинд өндөр хувьтай байна. Энэ нь гэр бүлийн харилцааны уламжлалт хэв хандлагатай холбоотой байж болзошгүй бөгөөд ирэх жилүүдэд орон нутаг руу чиглэсэн ажил хийхийг шаардаж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, “Монголын дүлий иргэдийн үндэсний холбоо” төрийн бус байгууллагын 2015 оны 05 дугаар сарын 19-нд байгуулсан хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийн хүрээнд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, утасны дугаарыг шилжүүлэн авч, яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг богино зурвас /SMS/-аар цагдаагийн байгууллага хүлээн авах үйл ажиллагаа эхэлж 2017 оныг хүртэлх хугацаанд нийт 35 дуудлага, мэдээлэл хүлээн авсан байдаг.

Сүүлийн жилүүдэд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс богино зурвас /sms/-аар дуудлага, мэдээлэл ирээгүй тул уг ажлыг идэвхижүүлэх зорилгоор дээрх иргэдийн утасны дугаарын бүртгэлийг дахин шинэчлэх хүсэлтийг “Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагад 2019 оны 05 дугаар сард хүргүүлсэн.

Улмаар энэ оны 10 дугаар сарын 10-ны өдөр ЦЕГ болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга нарын баталсан 03/2019 дугаартай “Санамж бичиг” байгуулагдсан. Уг санамж бичгийн хүрээнд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн утасны дугаарын бүртгэлийг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.

Энэхүү үйл ажиллагааг үргэлжлүүлэн хууль сахиулах байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын стандартыг батлуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өртөж хохирсон гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг хүлээн авах (сэтгэл зүйн төв) дэд бүтэц, арга замыг тодорхойлох ажлууд хүлээгдэж байна.

Дүгнэлт

Статистик судалгаагаар 0-85 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй (бүх төрлийн) хүмүүс өөрийн ойр дотны хүнийхээ гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон байна. Тэд хүнийг алах, хулгай дээрэм, ялангуяа гэр бүлийн

орчиндоо зодуулах, амиа хорлоход хүргэх, хүчингийн гэмт хэргийн улмаас хохирчээ.

Гэр бүлийн хүчирхийлэл ялангуяа сэтгэл санаа, эд хөрөнгийн дарамтыг тооцох эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч нийгмийн сэтгэлгээ төлөвшөөгүйн улмаас энэ төрлийн хүчирхийлэлд өртөгч нар цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг гэр бүлийн хүчирхийлэл нь зориуд санаатайгаар хорьж, хясах, эмзэг, сул байдлыг нь далимдуулах, наад захын хэрэгцээг нь хангахгүй байх тухайлбал: эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэлийг нь авч өгдөггүй, усанд оруулахгүй, хумс, үсийг нь засуулахгүй, шинэ хувцас, гар утас авч өгөхгүй, хэн нэгэнтэй уулзуулахгүй, найзлуулахгүй зэргээр харилцаа, холбоог нь хязгаарлах хэлбэрээр үйлдэгдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл сонирхолыг гэр бүлийн гишүүд нь анхаардаггүй, орлого нь бага, тэтгэмжийн орлогыг нь шимэж амьдардаг, яг үнэндээ гэр бүлийнхэндээ дараа, ачаа мэт санагддаг /эмчилгээний зардал, харгалзаж явах гм/ нь цаашид энэ хүмүүс эрүүл хүнтэй адилхан сурч боловсрох, асаргаа дэмжлэг авах боломжийг улам бүр хумигдахад хүргэх эрсдэлтэй юм.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон “Юнител” групп хамтран 2017 оны 09 дүгээр сараас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Миний туслах 104” үйлчилгээг нэвтрүүлж, тус төвд дүрсээр дуудлага, мэдээлэл хүлээн авах зорилгоор “Юнител” группын 1 ажилтныг ажиллуулсан боловч уг үйлчилгээг харилцаа холбооны зардал шийдвэрлэгдээгүй, хэрэглэгч болон хандалт бага, Юнител групп технологийн шинэчлэл хийх шаардлагатай зэрэг шалтгааны улмаас 2018 оны 02 дугаар сард зогсоож байсан. Уг үйлчилгээний хүрээнд дээрх иргэдээс ямар нэгэн яаралтай тусламжийн дуудлага мэдээлэл ирээгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл маш бага ирж байгаа нь уг иргэд яаралтай тусламжийн дуудлага хэрхэн өгөх талаар мэдлэг мэдээлэл бага, төрийн байгууллагын зүгээс явуулж байгаа сургалт, сурталчилгаа хангалтгүй, уг иргэдийн нэгдсэн бүртгэл судалгаа байхгүй зэргээс

шалтгаалж байна. Иймд эдгээр тулгамдсан асуудлыг шат дараалан шийдэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ эхний ээлжинд гэр бүлийн хүчирхийллээс ангид байлгая.

Ном зүй

1. Цагдаагийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газрын хооронд солилцсон албан бичгүүд, 2015-2019 он;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн өртөж хохирсон гэмт хэргийн статистик 2017-2019 он;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон гэмт хэргийн статистик, 2017-2019 он;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон тохиолдолд хууль сахиулах байгууллагаас хэрэгжүүлэх олон улсын стандартууд, 2001-2016 он;
5. Иргэдэд үйлчлэх сэтгэл зүйн төвийн танилцуулга, 2017 он;
6. Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдэд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн судалгаа, 2018 он;

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛТАЙ БАЙДЛЫН ЗОЛИОС НЬ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД ХОХИРОХ ЯВДАЛ ХЭРХЭВЧ БАЙХ ЁСГҮЙ

Э.Энхболд¹

¹Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Зам цагдаагийн газрын Техник, замын хяналтын хэлтсийн чиглэлийн ахлах зохицуулагч

Түлхүүр үг:

Замын хөдөлгөөн, зам тээврийн осол, гэмтэл, хохирол, автозам, тээврийн хэрэгсэл.

Хураангуй:

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг эрх зүйн хувьд тодорхойлохдоо “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг” ойлгоно гэжээ.

Тэгвэл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадаагүйн улмаас жил бүр дэлхийн хэмжээнд 1.2 сая хүний амь нас хохирч, 50 сая орчим хүн бие, эрүүл мэндийн хувьд бэртэл гэмтэл авч оршин буй нийгмийнхээ амьдралд эрх чөлөөтэй, хүссэнээ хийж, зорьсноо бүтээх боломжгүй нэгэн болж бусдын тусламжгүйгээр, нийгмийн дэмжлэггүйгээр амьдрах, аж төрөх, сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх чадваргүй болсоор байна.

Зам дээрх чимээгүй хар дайны улмаас тухайлбал манай улсад сүүлийн 5 жил /2014 оноос 2018 он/-ийн хугацаанд 27080 хүн хүндэвтэр, хүнд бэртэл, гэмтэл авч хөдөлмөрийн чадвараа бүр болон тодорхой хугацаанд алдсан хамарсалтай тоо мэдээ байна. 2018 онд манай улсад 105730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байгаа бол 2014 онд энэ тоо 99573 байжээ. Зам тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон олон иргэдийн маань хүсэл мөрөөдөл талаар болж, улс эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулах боломж хязгаарлагдаж байгааг тооцохын арга үгүй юм.


Учир нь ослын улмаас хохирсон иргэдийн насны байдлыг авч үзвэл 18-34 насны идэр залуус байгаа бөгөөд хүнд гэмтлийн улмаас эргээд хэзээч эрүүл мэндээ нөхөн сэргээж чадахгүйд хүрч байна. Монгол Улсын үндсэн хуулинд зааснаар иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, зорчих, эрх тэгш нөхцөлөөр хангагдах эрхтэй гэж заасан байдаг. Энэ

үүргээ төр, иргэн аль аль нь биелүүлдэг байж гэмтэнээ эрдэнэт хүний амь нас, эрүүл мэнд энхийн цагт авто зам дээр эрсдэх учиргүй билээ. Иймийн тулд иргэдээ эрүүл мэндээрээ хохирч, хөдөлмөрлөх, хөгжих чадвараа алдахаас урьдчилан сэргийлэх боломж төрийн бодлого, нийгмийн амьдрал, иргэдийн ухамсар, хариуцлагад оршин байдгийг энэхүү илтгэлийг бичих явцдаа ойлгож мэдлээ.

Үндэслэл:

Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар мэдэмхийрдэг болсон өнөө цаг үед нийгмийг бүрдүүлэгч нэгээхэн хэсэг болсон 100 орчим мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар “Замын хөдөлгөөний аюултай байдлын золиос нь хүний эрүүл мэнд хохирох явдал хэрхэвч байх ёсгүй” гэсэн сэдвийн хүрээнд энэхүү илтгэлийг бичихээр зориг шулуудсан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг эрх зүйн хувьд тодорхойлохдоо “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг” ойлгоно гэжээ.




Тэгвэл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадаагүйн улмаас жил бүр дэлхийн хэмжээнд 1.2 сая хүний амь нас хохирч, 50 сая орчим хүн бие, эрүүл мэндийн хувьд бэртэл гэмтэл авч оршин буй нийгмийнхээ амьдралд

эрх чөлөөтэй, хүссэнээ хийж, зорьсноо бүтээх боломжгүй нэгэн болж бусдын тусламжгүйгээр, нийгмийн дэмжлэггүйгээр амьдрах, аж төрөх, сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх чадваргүй болсоор байна.

Зам дээрх чимээгүй хар дайны улмаас тухайлбал манай улсад сүүлийн 5 жил /2014 оноос 2018 он/-ийн хугацаанд 27080 хүн хүндэвтэр, хүнд бэртэл, гэмтэл авч хөдөлмөрийн чадвараа бүр болон тодорхой хугацаанд алдсан хамарсалтай тоо мэдээ байна. 2018 онд манай улсад 105730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байгаа бол 2014 онд энэ тоо 99573 байжээ. Зам тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон олон иргэдийн маань хүсэл мөрөөдөл талаар болж, улс эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулах боломж хязгаарлагдаж байгааг тооцохын арга үгүй юм.

График. Зам тээврийн улмаас гэмтэж, бэртсэн хүний тоо 2014-2018 он

ОСЛЫН УЛМААС ГЭМТЭЖ, БЭРТСЭН ХҮНИЙ ТОО



Учир нь ослын улмаас хохирсон иргэдийн насны байдлыг авч үзвэл 18-34 насны идэр залуус байгаа бөгөөд хүнд гэмтлийн улмаас эргээд хэзээч эрүүл мэндээ нөхөн сэргээж чадахгүйд хүрч байна. Монгол Улсын үндсэн хуулинд зааснаар иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, зорчих, эрх тэгш нөхцөлөөр хангагдах эрхтэй гэж заасан байдаг. Энэ үүргээ төр, иргэн аль аль нь биелүүлдэг байж гэмээнэ эрдэнэт хүний амь нас, эрүүл мэнд энхийн цагт авто зам дээр эрсдэх учиргүй билээ. Иймийн тулд иргэдээ эрүүл мэндээрээ хохирч, хөдөлмөрлөх, хөгжих чадвараа алдахаас урьдчилан сэргийлэх боломж төрийн бодлого, нийгмийн амьдрал, иргэдийн ухамсар, хариуцлагатай салшгүй холбоотой юм.

Автомашин гэдэг нэр томьёо хүн төрөлхтний үгсийн санд орсон өдрөөс хойш өнөөдрийг хүртэл 130 орчим жил өнгөрчээ. Өнөөдөр манай улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшин маш муу байгааг бид өөрсдөө хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ энэ төрлийн аюулгүй байдлын судалгааг жил бүр гаргадаг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын илтгэлд дурьдагдсан үзүүлэлтүүдээс харж болох юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг эрдэмтэд тодорхойлохдоо “Хүн-автомашин- зам- орчин” гэсэн эрсдэлт 4 хүчин зүйлсийн хоорондын нарын уялдаа холбоо, найдварт ажиллагааны үр дүнд бий болж буй аюулгүйн түвшин юм гэж тодорхойлсон. Тиймээс эдгээр 4 эрсдэлт хүчин зүйлсийн найдварт үйл ажиллагаанд хотжилт буюу хүн амын нягтралшил, автомашины бөөгнөрөл, зохион байгуулалтгүй зам талбайн хийц хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьд явах, чөлөөтэй зорчих эрхэд хэрхэн сөргөөр нөлөөлж буй талаар судлах хэрэгцээ шаардлагатай тулгамдсан асуудал болсон байна.

Юун түрүүнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” гэж чухам юуг ойлгох вэ? гэдгийг тодорхойлох нь чухал юм. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичигт замын хөдөлгөөний аюулгүй байдал гэдгийг тодорхойлохдоо замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осолд өртүүлэхгүй, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалагдсан байдлыг ойлгоно” гэж заасан байна. Энэ нь замын хөдөлгөөнд оролцогч жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчид хөдөлгөөнд оролцохдоо аливаа хэлбэрээр замын хөдөлгөөний дүрэм, журам зөрчихөөс урьдчилан сэргийлэгдсэн байдал, мөн эдгээр хөдөлгөөнд оролцогчдыг зам тээврийн осолд өртүүлэхгүй байх үйл ажиллагааны цогц юм гэж ойлгогдож байна.

Хот, суурин амьдралын нөхцөлд тээврийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг үлэмж их байдагтай холбоотойгоор сүүлийн жилүүдэд манай улсад тэр дундаа Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж байгаа нь энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудын судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал сүүлийн 10 жилийн хугацаанд манай улсад тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдсэн байна.

График. Тээврийн хэрэгслийн тоо
2006-2016 он



Ийнхүү жил дараалан нэмэгдэж байгаа тээврийн хэрэгслийн тоо, эрчимтэй хөдөлгөөний өсөлт нь манай улсын хот суурин газрын гудамж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, журам сахиулахад ихээхэд хүндрэл учруулж байна. Тухайлбал: Эдийн засгийн хохирол, цаг хугацааны алдагдал, эрүүл мэндэд учруулах хохирол, экологийн хохирол, сэтгэл санааны хохирол зэргийг авч үзэх ба эдгээр сөрөг нөлөөллөөс шалтгаалан жолооч нар түрэмгий, явган зорчигч нар хэнэггүй болж үүний үр дүнд зам тээврийн осол нэмэгдэж байна.



Ийнхүү өсөн нэмэгдэж байгаа автомашины тооны улмаас замын түгжрэл үүсч байгаа юм. Замын хөдөлгөөний энэ түгжрэлийг шуурхай зохицуулах үйл ажиллагаа, хөдөлгөөнд

оролцогч нарт тавих хяналтын үйл ажиллагааны доголдолтой байдал, замын хөдөлгөөнд оролцогчдын ухамсар, ёс зүй хандлага муу, замын хүрэлцээ муу, уулзварууд нь хөдөлгөөний нэвтрүүлэх, тосон хүлээн авах автозам хангалтгүй зэргээс үхэх төрөхийн онол зөрчигдөх зэрэг сөрөг үзэгдлүүд улам хурцатгаж байна.

Дүгнэлт:

Манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор замын хөдөлгөөнд оролцогч нар амиа алдах явдал өсөх хандлагатай байна. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоо хэмжээ нэмэгдэхэд “Хотжих” үйл явцын сөрөг нөлөөлөл их байна.

Хүн амын нэг газарт олноороо суурьшин амьдрах амьдралын хэв маягийн өөрчлөлт нь өнөөдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад хамгийн их бэрхшээлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Иргэдийн дунд явуулсан судалгаа, өнөөдрийн байгаа замын хөдөлгөөний дүр зургаас ямар байдалтай байгаа нь тодорхой харагдаж байна. Тухайлбал манай хот нь Дэлхийн бусад томоохон хотуудад оршин суудаг иргэдийн адил эрүүл аюулгүй орчинд амьдрах, осол эндэгдэлгүй зорчих эрхээ эдэлж чадахгүй байна. Эрүүл иргэдийн эрх ийнхүү зөрчигдөж байхад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн зөрчлийг дурьдах шаардлагагүй юм.

Улс орны төдийгүй хот, суурин газруудад зам барилга, хот төлөвлөлтийн бодлого алдагдсан, ирээдүйгээ оновчтой харж, зөв түгжрэлийг бууруулах техник, технологийн шийдлийг нэвтрүүлж чадаагүй, анх төлөвлөгдсөн тооцоот ачааллаасаа хэт их хүн ам, тээврийн хэрэгслийг шавсан, хөдөө орон нутгаас шилжин суурьших хүн амын тоо хурдацтай өсөн нэмэгдэж байгаа, байгалийн зүй зохистой харьцааны тэнцэл алдагдаж, агаар, хөрс, ундны усны гачигдалд орсон, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдран суух, аюулгүй зорчих эрхийг хангаж чадахааргүй нөхцөл байдал бий болж замын хөдөлгөөний аюултай байдлын золиос нь хүний эрүүл мэнд хохирох явдал их байна.

Санал:

Өнөөгийн нийгэмд Дэлхийн томоохон хот, суурин газруудад автомашины хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байгаа боловч эдгээр хотуудын

автозамын түгжрэл, ачааллыг бууруулах чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаан нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэж хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгааг судлаач бидний зүгээс харгалзан үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Улаанбаатар хотод хөдөлгөөнд оролцож байгаа нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээг сайжруулж, аюул, эрсдэлгүй хөдөлгөөнд оролцох боломжийг хөгжүүлж, хувийн автомашинтай өрсөлдөхүйц шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ, маршрут, чиглэлийг бий болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Монгол улсын хувьд нэгэнт үйлдвэрлэгч улс биш тул хөдөлгөөнд ололцож байгаа тээврийн хэрэгслүүдийг үйлдвэрлэсэн оноор нь хязгаарлах боломжгүй. Иймд хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдийн техникийн стандарт шаардлагыг бүрэн дүүрэн хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн байгууллагууд нь өндөр технологийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар оношилж техникийн хувьд бүрэн бус, стандартын шаардлага хангахгүй, өнгө үзэмж муутай тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасч, цаашид хөдөлгөөнд оролцуулахгүй байх эрх зүйн орчинг бий болгох.
- Хотод хувийн автомашины хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор хотын зарим төвийн гудамж замуудыг автомашингүй гудамж болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Ийнхүү аль болох олон гудамж замуудад автомашины хөдөлгөөнийг тодорхой цаг, өдрүүдэд бүр мөсөн болон хэсэгчлэн хязгаарлах замаар гадаадын олон хотуудад хэрэгжүүлэн хотын төвийн автозамын ачааллаа тодорхой хувиар багасгах замаар зам тээврийн осол, зөрчлийг бууруулсан туршлагыг судлан өөрийн улсын хэв маягт тохирсон загварыг гарган хэрэгжүүлэх.
- Хотод шинээр автомашины зогсоол байгуулах, газар чөлөөлж зам барих, төв замуудын хоорондын гудамжны хөдөлгөөнийг боловсронгуй болгох шаардлагатай байна.
- Гудамжны замын сүлжээг хөгжүүлэх чиглэлээр орон сууцны хорооллуудыг хооронд нь холбосон нарийн замуудыг

шинээр барьж байгуулах замаар, иргэдийн цаг зав, мөнгө, шатахууныг хэмнэх замаар иргэдэд үүсдэг буруу сэдлийг арилгах арга хэмжээг судалгаатай хийх.

- Хөдөлгөөнийг хүний хүчээр бус онолын үндэслэлтэй судалгаа шинжилгээний ажлыг явуулсны үр дүнгээр гэрлэн дохиог нэмж байрлуулах, уулзварын хэлбэр хийцийг өөрчлөх байдлаар осолтой цэгүүдийн тоог багасгах чиглэлээр ажиллах.
- Замын цагдаагийн албыг зөвхөн хөдөлгөөнд оролцогч нарын дүрмийн зөрчилд анхаарч ажиллах, эрх зүйн орчинг бий болгох зэрэг санал дэвшүүлж байна.

НОМ ЗҮЙ

1. Ред Г.Баасанжав “16-19 дүгээр Зууны европын түүх”, УБ, 2000 он
2. Cambridge “INTERNAMIONAL DICTIONARY of ENGLISH” 1995 он
3. Leese A. Cities Pereveiced Urban Sociaty in Europan nad American Thought. New York, 1985
4. Монгол улсын үндсэн хууль. УБ.,1992 он
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. УБ.,2015 он
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. УБ.,1996 он
7. Б.Энхболд “Хотжилт ба гэмт явдал” УБ. 2011он
8. Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхтгэл 6. УБ.,2017он
9. Монгол улсын цагдаагийн ерөнхий газар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудал”. УБ.,2010 он
10. Ч.Нямсүрэн. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж буй өнөөгийн практик, тулгамдсан зарим асуудал” замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд сэдэвт онол, практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2010 он

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛД ҮЛ ХАЙХРАХ БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Баясгалан¹, Н.Нандинцэцэг, Ч.Тамир¹
¹МУИС-ийн ШУС-ийн

Сэдвийн үндэслэл

Аливаа гэмтэл өвчлөлийн улмаас сонсголыг дамжуулах эрхтэн болох чих нь үүргээ гүйцэтгэж чадахгүй болсны улмаас сонсголын алдагдал буюу сонсголын бэрхшээл бий болдог. Үндэсний статистикийн хорооны 2017 оны албан ёсны тайланд дурдсанаар Монгол улсын хүн амын 3.2 хувь нь /103630/ ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 7.4 хувь нь хэл ярианы, 7.4 хувь нь сонсголын бэрхшээлтэй гэсэн мэдээлэл байдаг. Монгол улсын хэмжээнд 12600 сонсголгүй хүн байдаг. (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018). Улсын хэмжээнд сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан нэг сургууль, нэг цэцэрлэг байдаг. Энэхүү тусгай хэрэгцээт боловсролын байгууллагуудаар дамжин сонсголын бэрхшээлтэй хүүхэд(СБХ) өөрсдийн тусгай хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг авч байна. Хотод амьдардаг сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн 403 нь 0-16 насны хүүхэд байдаг. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р сургууль, 138-р цэцэрлэгт суралцдаг нийт хүүхдийн тоо 145 байна. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь бусад хүүхэдтэй адилхан ойлгож ухаарах чадвартай байдаг. Гэсэн хэдий ч нийгмийн харилцаанд оролцож, бусдад санаа бодлоо ойлгуулах, ойлголцох үйл явцад бэрхшээл тулгардаг. Тиймээс сонсголын бэрхшээлтэй хүүхэд төдийгүй тэдний гэр бүл орчин тойронд дохионы хэл сурах шаардлага гардаг. Гэхдээ энэ нь хүүхдийн асуудлыг бүрэн шийдвэрлэж байна гэсэн үг хараахан биш юм.

СБХ-ийн нийгэмшил зөвхөн боловсролын байгууллагаас хамааралтай байгаа нь насанд хүрэхэд бусадтай харилцаанд орж чадахгүй байдалд хүргэж байгаа юм. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Нэгдсэн Үндэсний Байгууллагын(НҮБ) конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, алагчлалыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох талаар тодорхой тэмдэглэсэн байна. (Хөдөлмөр, 2018)

Үүний дагуу манай улсад тусгай хэрэгцээт боловсрол(ТХБ) шаардлагатай хүүхдийг “Хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг тэгш хамран сургах журам”-ыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яамны сайдын 2019 оны 5-р сарын 14-ний А/292 журмаар баталсан. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл энэхүү журмыг хэрэгжүүлэх нөхцөл муу байна. Тэгш хамруулан сургах журмын хүрээнд ЕБС-т суралцахаар бэлтгэж буй сурагчдын амжилтад олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал багшийн хүүхэдтэй ажиллах арга зүй, анги хамт олны харилцаа, хүүхдийн дасан зохицох чадвар гэх мэт орно. Бага ангийн хүүхдийн боловсролд эцэг эхийн анхаарал халамж, оролцоо хамгийн ихээр шаардагддаг үе юм. Учир нь энэ үед хүүхдийн боловсролын үндэс суурь тавигддаг. Хүүхдийн боловсрол эзэмших, сурч боловсроход таатай нөхцөлөөр хангагдаж байгаа эсэхийг хангаж чадсан байдлыг олж мэдэх, хэрэгжүүлэх нь эцэг эхийн зүгээс хүүхдийн боловсролыг анхаарч байгаагийн илрэл болно. Тиймээс хүүхдийн боловсролоор дамжин бусад хүмүүстэй нийгэмших боломжид эцэг эхийн үл хайхрах байдал илэрч байгаа бол боловсролын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаагаар хэрхэн сайжруулж болох, сайжруулахад ямар асуудал бэрхшээл тулгарч буйг судлах хэрэгтэй юм.

Судалгааны зорилго

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нийгэмшилд боловсролын орчин дахь үл хайхрах байдал хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилготой

Судалгааны зорилт

- Боловсролын орчин дахь үл хайхрах байдал нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нийгэмшилд хэрхэн нөлөөлж буйг судлах
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах боловсролд тулгарч буй асуудлыг ангилах
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах боловсролын орчныг сайжруулах салбар дундын шинэлэг арга замыг олох

Сэдвийн судлагдсан байдал

1. IRIM судалгааны хүрээлэн, Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь судалгаа (IRIM, 2019)

Энэхүү судалгаа нь дараах үр дүнгүүдийг гаргасан байна.

- ЕБС-д тэгш хамруулан сургалтыг хэрэгжүүлэхэд бэлэн буй байдалд гарч буй хэд хэдэн бэрхшээлүүдийг илрүүлсэн байна. ТХХ-ийг үнэлэх тодорхой үнэлгээний аргачлал байхгүй.
- НТБТ-ийн багш нар ТХХ шаардлагатай хүүхдүүдийг тусгай сургуульд явуулах хэрэгтэй гэдэг байр суурьтай хэвээрээ байгаа бөгөөд өөрсдийн мэргэшсэн байдлыг хангалтгүй байна гэж үзэж байна.
- Эцэг эхчүүдийн хувьд ТХСБ-ийн талаар ойлголт хандлага бага, ач холбогдлыг мэдэхгүй байна.
- Энэ талаарх хууль тогтоомж хэрэгжилтийг хангах зохицуулалт, журам хангалтгүй, хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй байгаа тул нарийвчилсан заалт, зохицуулалт, журам хэрэгтэй байгаа.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулан сургахад нийгмийн байдлын нөлөөлөл түүнийг шийдвэрлэх арга зам / Архангай аймгийн жишээгээр/ (Д.Эрдэнэцэцэг)

- ХБ хүнийг нийгмийн амьдралд татан оруулахад сэтгэл зүйн дарамт учирдаг бөгөөд үүнийгээ ихэвчэн гэр бүлийн гишүүддээ илэрхийлдэг байна. Сэтгэл зүйчдэд энэ талаараа хэрхэн илэрхийлэх талаараа мэддэггүй байна. ХБИ-ийн нийгмийн харилцаанд ороход тулгарч буй бэрхшээл нь 57% хүмүүстэй харилцах харилцаа хандлага, 60% гаруй нь ХБИ бусад хүмүүс ялгаварлан гадуурхдаг гэж үзсэн байна. Мөн ХБ иргэний бие даан нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай дэд бүтэц бүрдээгүй байгаа юм.

Үндсэн ойлголтын тайлбар

Хөгжлийн бэрхшээл - ДЭМБ-ын “Үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилал: Хүүхэд залуучуудын хувилбар”-т хөгжлийн бэрхшээлийг цэвэр биологийн эсвэл нийгэм талаас нь харах хандлагаас татгалзаж, харин эрүүл мэндийн байдал, орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэж үздэг. (Хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018)

Сонсголын бэрхшээл - Аливаа гэмтэл, өвчлөлийн улмаас сонсголыг дамжуулах эрхтэн болох чих нь үүргээ гүйцэтгэж чадахгүй болсны улмаас сонсголын алдагдал буюу сонсголын бэрхшээл бий болдог.

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд - Сонсгох чадвараа тодорхой хэмжээгээр алдсаны улмаас хэл ярианы хөгжил нь хоцрогдсон эсвэл хэл яриа нь огт хөгжөөгүй буюу бие даан хөгжүүлэх боломжгүй болсон хүүхдийг хэлнэ.

Тусгай хэрэгцээт боловсрол - Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц юм.

Тэгш хамруулах боловсрол - Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог, шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн үйл явц юм.

Боловсролын үл хайхрах байдал (Л.Нямбаяр, 2018) – Хүүхдийн насанд нь тохирсон сургууль юмуу тусгай боловсрол эзэмшүүлэхгүй байх. Ямар ч боловсролгүй байхыг хүлээн зөвшөөрөх.

Таамаглал

СБХ-ийн онцлогийг ойлгож, хүлээн зөвшөөрөх байдал дутагдалтай байгаагаас хүүхэд чанартай боловсрол эзэмшихгүй байна.

Судалгааны шинэлэг тал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Тэгш хамруулан сургах” талаар тухайлбал сонсголын бэрхшээлтэй хүүхдийг боловсролын орчинд үл хайхрах байдлыг судалснаараа шинэлэг болно.

Хууль эрх зүйн орчин

Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, түүнтэй адилтгах баримт бичгүүдэд

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, алагчлалыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох талаар тодорхой тэмдэглэсэн байдаг.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 7 дугаар зүйл

3. НҮБ-ын ерөнхий ассамблейн 61-р чуулганаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдэд

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
2. Бага, дунд, боловсролын тухай хууль
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар
4. Хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг тэгш хамран сургах журам
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр

Арга зүй

Онолын тайлбарлал

Сонсголгүй хүүхдийн боловсрол олгоход дэлхий дахинд гурван аргыг хэрэглэдэг байна.

- Аман хэлний арга зүй
- Хавсарсан хэлний арга зүй
- Хос хэл, соёлын арга зүй

Эдгээрээс хос хэл, соёлын арга зүйг нарийвчлан авч үзье.

Энэ арга зүй нь Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн орчин тойронд дохионы, бичгийн хэлийг хоёуланг нь эзэмшүүлэхэд оршино. Түүний нийгэмтэй харилцах бүхий л төрлийн харилцааг хангахын тулд төрөлх дохионы хэлний хамтаар бичгийн хэлийг хоёрдогч байдлаар сургадаг байна. Ингэснээр хүүхэд дохионы хэл мэдэхгүй хүмүүстэй бичгээр харилцах боломж бүрдэнэ. Мөн хүүхдийн дохионы хэлний чадвар сайн байх тусмаа бичгийн хэлний чадвар сайжирдаг байна.

Хүүхдэд хос хэл, соёлыг эзэмшүүлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

1. Гэр бүлийн орчинд харилцдаг хэл
2. Нийгмийн анги, бүлгийн хэл
3. Сургуулийн орчны хэл, хос хэл соёлын орчин дах хэл
4. Багшийн хэлний чадвар
5. Тухайн хүүхдийн хэлний чадвар ордог байна.


Тэгш хамруулах боловсрол: Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралтгүй үйл явц юм (Женев, ОУ-ын Боловсролын бага хурал, 2008).

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь өөрийн амьдарч буй нутаг дэвсгэртээ боловсрол эзэмших боломжгүй байна. Үүнд дараах шалтгаанууд нөлөөлж байна.

- Багшийн хандлага
- Сургуулийн орчин нөхцөл
- Сургалтын хөтөлбөр
- Сургалтын арга зүй
- Сургалтын хэрэглэгдэхүүн
- Үнэлгээ

Судалгааны хамрах хүрээ, түүвэр

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль болох 29-р сургуулийн 1-5-р ангид суралцдаг 8 эцэг эх, 2 багш, 1 мэргэжилтэнээс чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан.



Судалгааны үр дүн

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн бусадтай харилцах харилцаа

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн харилцаа болоод орчин нөхцлийг дүрсэлбэл дараах дүр зураг харагдана. СБХ-ийн сонсгол алдагдалтын зэргээс нь шалтгаалан эцэг эхчүүдийн дохионы хэл сурах нь ялгаатай байна. Дохионы хэл бол сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн хувьд харилцааны төрөлх хэрэгсэл нь байдаг. Гэтэл хүүхдийн орчин тойрон бүхэлдээ дохионы хэл мэдэхгүй байна. Үүний шалтгаан нь сургалт болдог газар ховор, сурахыг хүссэн ч бүрэн сонсголгүй ангийн эцэг эхчүүдийн дийлэнх нь настай хүмүүс байдаг тул физиологийн хувьд боломж нь бага байдагтай холбоотой. Гэр бүлийн хүрээнд, тэдэнтэй харилцдаг багш нар, нийгмийн орчин ч гэсэн үүнд хамаарна. Хүүхэддээ цаг зав гарган харилцдаг эсэхийг үл хамааран эцэг эхийн дохионы хэлний чадвар

муу байгаа нь энэ талд анхаарах хэрэгтэйг харуулж байна. Хэдий багш өөрийн үүргээ хүлээж хүүхдүүдэд хичээлийг нь заадаг ч нийгмийн анхдагч орчин болох гэр бүлийн хүрээнд дохионы хэл ашиглагдахгүй байгаа учраас хүүхдүүд заасан зүйлсийг мартаж байна. Тиймээс эцэг эхчүүд оролцоогоо нэмэгдүүлэн дохионы хэлийг сурах хэрэгцээ байгаа нь ажиглагдаж байна.

Эцэг эхийн хувьд хүүхэдтэйгээ аль болох харилцах арга замыг эрэлхийлдэг. Гэвч харилцах арга барил нь харилцан адилгүй ч тодорхой хэмжээний асуудал, саад бэрхшээлүүд тулгардаг. Амны хайрцагаар ойлголцох, бичгээр харилцах, алдаг оног харилцах, аяг нь олж харьцах зэргээр харилцдаг. Сул сонсголтой хүүхдийн бичгийн болоод, үгийн санг нэмэгдүүлэхийн тулд дохионы хэлээр харилцах нь тустай байдаг. Энэ нь ямар ч үед хүүхэд өөрийгөө бусдад ойлгуулдаг, асуудал бэрхшээлээ бусадтай хуваалцаж, ярилцаж, асуудал бэрхшээлийг ганцаараа мэдрээд, нуугаад явахгүй байх нөхцлийг бүрдүүлэх юм. Хүүхдийг сонсголын бэрхшээлтэй учраас ойлгож харьцах хэрэгтэй, сонсголын бэрхшээлээс нь шалтгаалаад яалт ч үгүй үл ойлголцол байнга гардаг гэж эцэг эхчүүд үзэж байна. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ойлголцож чадахгүй үед хүүхэд уурлаж стресстдэг тухай эцэг эхчүүд ярьж байлаа. Энэ нь эцэг эхийн анхаарал халамж их багаас шалтгаалахгүйгээр адилхан байв.

Шигтгээ: Ойлгоогүй тохиолдолд уурлаж, бухимдах үе гарна. Хүүхэд маш их стресстдэг. Гадуур хамт явж байхад өөрийг нь ойлгоогүй юм уу, анхаарч сонсохгүй байх үе гарна. Хүнтэй таван үг сольдог ч юм уу? Тэр үед өөрөө л юм хэлэх гээд татаж чангаагаад нэг, хоёр, гурав оролдоно. Тэгээд сонсохгүй бол орилоод унана.

Хүүхэд бие даан нийгмийн харилцаанд орох үед яаралтай тусламж дэмжлэг хэрэгтэй болсон үедээ өөрийгөө илэрхийлж чадаж байгаа эсэх нь чухал. Энэ талаар мэддэг олгох хэрэгтэй юм байна гэж эцэг эхчүүд үзэж байсан. Хүүхэддээ тусламж хэрэгтэй болсон тохиолдолд авах арга хэмжээг ойлгуулах хэрэгцээ тулгардаг бөгөөд бичгийн хэлбэрээр тусламж авахыг заадаг аж. яаралтай тусламж хэрэгтэй болсон үедээ бусдад өөрийгөө илэрхийлж чаддаг болох аргуудыг хүүхэддээ заах хэрэгтэй байна. Бодит

байдал дээр гэр бүлийнхнийхээ утасны дугаарыг цээжлэх, янз бүрээр дуугарахаас хэтэрдэггүй талаар эцэг эхчүүд хэлж байсан. Үргэлж дэргэд нь харж байдаг гэж байгаа нь нэг талаар сайн хэрэг боловч энэ нь хүүхдийг эцэг эхээс хараат болгох эрсдэлтэй. Тиймээс СБ бүхий хүүхдэд өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа тохиолдолд илэрхийлэх арга зам хэрэгтэй байна. Үүнд: Надад хэлэх зүйл байна, Надад яаралтай тусламж хэрэгтэй байна, Би үүнийг хийж чадахгүй байна гэх мэт таних тэмдэгтүүд байж болох юм.

Шигтгээ: Одоо бид хоёр нэрээ хэлээд, тоо цээжлүүлж байгаа. Мурий, сарий ч хамаагүй ээжийнхээ утасны дугаарыг бичиж чаддаг бол! Алга болбол миний хүү утасны дугаараа хүнд өгнө шүү гээд давтаад л байгаа. Хэдий хугацаанд тогтоох нь хэцүү. Явж, явж сурах талдаа л хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд. Уг нь их сэргэлэн хөөрхөн шүү дээ. Уул нь зөв хөгжүүлбэл хүн болно гэж бодож байгаа.

Ажлын онцлогоос шалтгаалан хүүхэддээ гаргах эцэг эхийн цаг зав харилцан адилгүй байдаг. Ихэвчлэн хүүхэддээ анхаарал халамж гаргаж буй эцэг эхчүүд нь ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байгаа тул тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Мөн нөгөө талаар ажлын улмаас хүүхэддээ цаг зав гаргах боломжгүй нөхцөлд ажилладаг хүмүүст хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цаг олгодог болоход зохицуулалт хийх хэрэгтэй. Эдгээр хүмүүс нь ихэвчлэн улирлын чанартай болон төрийн байгууллагад ажил эрхэлдэг хүмүүс байгаа юм.

Үе тэнгийнхэн

Хамаатан садан, хөрш, цэцэрлэгийн үе тэнгийн хүүхдүүдтэй тоглуулж нөхөрлүүлэх хүсэл хүүхэд, эцэг эх бүрт байдаг. Найз нөхөд нь ойлгож харилцдаг ч тэдний эцэг эх дургүйцдэг. Насны хувьд зөрүү бага, үе тэнгийн хүүхдүүд бол бие биенээ сонсголтой үгүйг ялгалгүй ойлголцоод харилцах нь бий. Үүнд хамаатан садан, ах эгч дүү, хөршийн хүүхдүүдтэйгээ багаасаа харьцдаг тул ойлголцдог. ЕБС-д явуулж, энгийн хүүхдүүдтэй найзлуулж, нийгэмшүүлэхийн төлөө ямар нэгэн оролдлого хийдэг ч амжилтанд хүрэх нь ховор байна. Тиймээс нийгэмшил, бусадтай харилцах чадварыг хүүхэддээ суулгахын тулд ТХСБ-т хандаж байна.

СБХ бага насандаа эргэн тойронд байдаг хүүхдүүдтэй тоглож өсдөг. Харин томрох тусам хүүхдүүдийн хооронд ялгаа гарч харилцаа нь улам хөндийрдэг байна. Эндээс харахад СБХ-үүд энгийн хүмүүстэй хамт байхын тулд шат дамжлага давах шаардлагагүй гэдгийг харуулж байгаа юм. СӨБ-д хамрагдаж байсан хүүхэд бусад хүүхдүүдтэй илүү нийцтэй байх бөгөөд зан авирын хувьд илүү тайван байдаг аж.

Шигтгээ: Энэ чинь энгийн цэцэрлэгт явдаг байсан. Энгийн хүүхдүүдийг сайн ойлгоно. Тэр хүүхдүүд нь манай хүүхдэд бүжиг энэ тэр зааж өгөөд сайн ойлгодог. Өөрөө ч бас хүнтэй гайгүй харьцдаг, уур уцаар багатай.

Мөн хүүхдийг ЕБС-д ороход хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг ойлголт өгсөнөөр бусад хүүхэд тухайн хүүхэдтэй зөв харьцаж хүмүүжихэд нь туслалцаа үзүүлэх юм.

Тэгш хамруулан сургах боловсрол

СБХ-ийг өөрийгөө илэрхийлж, бусадтай харилцдаг болсны дараагаар ЕБС-д явуулах хандлагатай байна. Хүүхэд том болсон хэдий ч бусадтай харилцах чадвар суугаагүй бол энгийн хүмүүстэй харилцах орчноос тусгаарлагдаж өсдөг. Тиймээс бүрэн сонсгол алдагдалтай, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн насандаа тохирсон боловсрол эзэмших үе шатанд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байгаа юм. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх гол арга зам нь Ерөнхий боловсролын сургууль юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн харилцаанд оруулахын тулд “Тэгш хамруулан сургах” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт бодит амьдрал дээр хүүхэд бүрт ялгаатай байна. Ерөнхий боловсролын сургуульд хүүхдээ сургаад улам дордуулсан тул буцаагаад тусгай боловсролын сургуульд явуулдаг. Тусгай боловсролын сургуульд явуулж байгаад тодорхой хэмжээнд бусадтай харилцах чадвартай болмогц ЕБС-т явуулж байна. Гэвч тохирох нөхцөл бүрдээгүй тохиромжгүй арга хэмжээ авах тохиолдол цөөнгүй байдаг. Багшийн арга барил дутмаг, ангийнхны хүлээн авах байдал бэлэн бус зэрэг шалтгаанаар хүүхэд ердийн сургуулиас илүүтэй тусгай хэрэгцээт боловсролын сургуульд явах нь тааламжтай байна.

ХБ хүүхэдтэй ажиллах тусгай багш болон

дохионы хэлмэрч бэлтгэх шаардлага хэрэгцээ байгаа бөгөөд тухайн багшийн цалин хөлсийг өндөр байх тухай санал бодлоо ярилцлагын явцад илэрхийлж байсан юм.

Шигтгээ: Тэгэхээр бүх сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах тусгай багш бэлдмээр юм байна лээ. Тэр багш нарын цалин хангамж өндөр байх хэрэгтэй юм байна лээ. Тэгээд ердийн сургуульдаа оруулчихад давхар ард нь хяналт тавих боловсон хүчин Монгол улс бэлдэх хэрэгтэй.

Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт нь их байдаг. Тиймээс багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тулж ажиллах чадамж болон боломж бага байдаг тухай эцэг эхчүүд ярьж байлаа.

Шигтгээ: Саяхан сургуулийн захирал бид нарыг цуглуулж хурал хийсэн. 40 хүүхэдтэй нэг ангид хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2-3 байх боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ ЕБС чинь хэцүү. 40 хүүхдийн дунд нэг багш гэхээр чинь, нөгөө нэг ч юмуу гурван хүүхэдтэй чинь тулж ажиллаж чадахгүй шүү дээ. Яг нийт дунд л хичээлээ заагаад явдаг болохоор багшийн буруу биш болчхож байгаа юм. Энэ сургуульд доод тал нь 6-7 хүүхэд, дээд тал нь 12-13 хүүхэд байвал яг тулж ажиллана шүү дээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг ойлгох, хүлээн зөвшөөрөх

ЕБС-ийн багш ХБ хүүхэдтэй урьд өмнө нь ажиллаж байгаагүй тул арга зүйн хувьд дутагдалтай байна. Үүнээс үүдэн СБХ ердийн сургуульд элсэн орсон ч багшийн хэлснийг ойлгодоггүй учраас эргэн ТХС-д буцан орж байна. Мөн ангийн хүүхдүүд нь дохионы хэл мэдэхгүй тул харилцах боломж хязгаарлагдаж байна. Сул сонсголтой хүүхэд үгийн баялаг муу тул зарим үгийг ойлгодоггүй бол бүрэн сонсголгүй хүүхэд мэдээллийг нүдээрээ авдаг тул бичгээр эсвэл дохионы хэлээр харилцах шаардлага гардаг. Гэвч бага ангийн хүүхдүүд унших болон бичихдээ учир дутагдалтай байдаг.

Шигтгээ: Манай ангийн сурагч Т ангидаа гайгүй ярьдаг, хичээлдээ ч гайгүй хүүхэд нэгдүгээр ангиа төгсөөд ЕБС рүү явсан. Ээж

нь үнэхээр барахгүй юм байна аа. Багш нь чээж бичлэг хийлгэхээр, багшийнхаа хэлж ярьж байгааг сонсохгүй. Тэрнээсээ болоод хичээлээ ойлгохгүй. Тэгээд олон хүүхдүүдийн дотор орчихоороо бэрхшээл гараад үнэхээр болохгүй юм байна гээд 2-р ангид нь аваад ирсэн.

СБХ-ийг ердийн сургуулд оруулснаар нийгэмшилт, сэтгэл санаа, боловсролын олон ач холбогдолтой. Эдгээр хүүхдэд боловсрол олгохын тулд багшийн сэтгэл хийгээд аргагүй чухал ач холбогдолтой. Тухайн багш СБ хүүхэдтэй ажиллаж үзээгүй тул арга барилын хувьд думтаг байна. СБХ-д хичээл зааж буй багш арга барилаа судалбал хүүхэд хөгжих боломжтой юм. Тиймээс эцэг эх, багш, ангийн хамт олон хамтран ажиллах хэрэгтэй.

Шигтгээ: Манай ангийн нэг хүүхэд ЕБС рүү Хэнтий рүү шилжээд явсан. Тэр хүүхдийн багш нь нээлттэй хаалганы өдөрлөгт ирсэн. Манай хуучин сургалтын менежер согог зүйч багш байсан. Түүнээс танай сургуулиас манай ангийн Ч гэдэг хүүхэд очсон. Энэ хүүхэдтэй яаж ажиллах вэ? үнэхээр хэцүү юм, яг ямар арга барилаар ажилладаг юм бэ? гээд асуугаад явж байна гэсэн. Тиймэрхүү бэрхшээл бас гарах байх.

Тэгш хамруулан сургах журмын дагуу хүүхдээ ЕБС-д өгөхөд бусад хүүхдүүдийн ХБ талаарх ойлголт хийгээд хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогийн тухай мэдлэг дутмаг байна. Үүнээс үүдэн СБХ гадуурхагдсанаар ЕБС-иас илүүтэйгээр тусгай хэрэгцээт боловсролын сургуульд явах нь тааламжтай байна.

Шигтгээ: Ноднин хоёр дугаар ангид нь ЕБС-д оруулъя гэхэд өвөө нь яах юм хүүхэд шоолно гээд больсон. Тиймээс энэ жил тусгай сургуульд нь явуулъя гэсэн. Гэхдээ дараа жил явуулах эсэхийг шийдээгүй л байна. Бас ах нь жоохон хэл ярианы бэрхшээлтэй байсан юм. Хүүхэд шоолоод, дээрэлхээд мөнгө нэхээд байхаар нь тусгай сургуульд нь оруулсан. Тэгээд л гайгүй болсон. Бас ялгагдаг юм байна. Хүүхдүүд шоолоод хэл муутай гээд байхаар нь хичээлд явдаггүй юм байна.

Дүгнэлт

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нийгэмшлийн тухай асуудал нь тэдгээрийг

ердийн хүмүүс хоорондоо ямар нэгэн бэрхшээл саадгүй харилцах харилцааны асуудал юм. Энэхүү судалгаагаар СБ хүүхдүүд гэр бүлийн болон сургуулийн орчинд бусадтай бүрэн ойлголцож, өөрийгөө илэрхийлэх, хөгжлийн бэрхшээл нь бусад хүмүүстэй харилцахад түвэг учруулж, цаашилбал, энэхүү бэрхшээл нь хүүхэд хамгааллын зөрчлийн ноцтой хэлбэр болох үл хайхрах байдалд хүргэж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьж, тусгайлан судаллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн харилцаанд оруулах “Тэгш хамран сургах”, боловсрол олгох тухай заасан байдаг. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад “Хос хэл соёлын арга зүй” илүү үр дүнтэй байдаг байна. Энэ дагуу сонсголын бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хамруулах эцэг эхийн хандлага, байр суурийг тодорхойлж, дараах тулгамдсан асуудлуудыг гаргаж байна. Үүнд:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт заах арга зүй, туршлага дутмаг байна. Хүүхдийг ердийн хүүхдүүдтэй харьцуулан суралцах байдлыг нь тодорхойлох боломжгүй юм. Гагцхүү хүүхдэд шаардлагатай дохионы хэл, бичгийн чадварыг суулгах нь тохиромжтой.
2. Сонсголын бэрхшээлээсээ шалтгаалан нийгэмших чадвар харилцан адилгүй байдаг. Сул сонсголттой хүүхэд нь бусадтай ойлголцож, харилцахад зайлшгүй дохионы хэл сурах шаардлагагүй буюу авиагаар харилцах боломжтой юм.
3. Бага наснаас нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхэдтэй харилцаанд оруулж байх хэрэгтэй. Гэхдээ тусгай хэрэгцээт сургуульд бага ангид нь сургаж суурийг нь тавих нь хүүхдэд илүү үр дүнтэй. Сургалтын ганцаарчилсан төлөвлөгөөгөөр хүүхдийн чадварыг дээшлүүлж сайжруулах хэрэгтэй байна. Мөн энэ талаарх мэдээллийг эцэг эх, багш нарт олгох хэрэгтэй.
4. Хүүхэд хамгааллын үндсэн ойлголтын хүрээнд үл хайхрах байдлыг хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан чанартай боловсрол олгохгүй байх хэлбэрт СБХ шууд ертөн, хохирогч болдог байна.

Санал, зөвлөмж

Анги хамт олны оролцоо

Хүүхдийн нийгэмшилд хүрээлэн буй орчин чухал нөлөөтэй. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах арга барил ижил түвшинтэй хүүхдүүд нэг ангид суралцдаггүй гэдгийг ойлгох мэдэх хэрэгтэй.

Эцэг эхийн оролцоо

Эцэг эх хүүхдээ бага наснаас нь нийгэмшүүлэх арга хэмжээг авахдаа аль болох ердийн хүүхдүүдтэй өсгөх боломжийг эрэлхийлж байх хэрэгтэй. Хүүхдийг боловсролын байгууллагад хамруулахдаа тодорхой арга зүйн үндсэн дээр ТХБ, ЕБС-д явуулахыг шийдэх хэрэгтэй.

Согог зүйч, хэлмэрч

Гадаадын орнуудад тэгш хамруулан сургах боловсролоор ЕБС-т орохоос өмнө эцэг эх нь сургуультай холбогдож уулздаг. Тийнхүү дүүргийн боловсролын хэлтсээс дохионы хэлмэрчийг хүүхдийн суралцах сургуульд томилдог. Тус хэлмэрч багш нь суурь хичээлүүдэд хүүхдэд дохионы хэлээр хэлмэрч хийдэг байна.

Багш нарын оролцоо

ЕБС-ийн хүүхдийн анги дүүргэлт өндөр байдаг нь багшийн ХБ хүүхэдтэй ажиллах нөхцлийн хувьд хүндрэлтэй байдаг гэсэн хэдий ч хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлогт арга зүйгээ тохируулан ажиллавал үр дүнтэй. ЕБС-ийн багш нь эцэг эх болон ТХББ-тай хамтран арга зүйн зөвлөгөө авах шаардлагатай. Ангийн эцэг эхчүүдэд дохионы хэлний сургалт, СБХ-тэй харилцах арга зүйг зааж өгөх, ганцаарчлан ажиллах, хүүхдийн давуу тал дээр суурилсан сурах аргын арга зүй бий болгох, анги хамт олныг зөв чиглүүлэх, СБ сурагчийг дагалдуулан сургах найз нөхдийг дэмжих

ИНБ ба Сайн дурынхны оролцоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд татан оролцуулах чиглэлээр идэвхтэй, дэмжин ажиллах сайн дурын гишүүдийн оролцоо шаардлагатай байна.

Нийгмийн оролцоо

Нийгэм нь өөрөө сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн өөрсөдтэйгээ харилцах чадварыг хүлээхгүйгээр дохионы хэл сурж, харилцан бие биенээ ойлгодог болох хэрэгтэй байна.

Төрийн оролцоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэгийг ЕБС-ийн хичээлийн сургалтын агуулгад оруулж хүүхдэд багаас нь төлөвшүүлэх

хэрэгтэй юм. Т өрөөс хэрэгжүүлдэг бодлого, хөтөлбөрүүдийн хүрээнд дээрх чиглэлээр сайжруулах үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна.

Ном зүй

1. Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, 2011 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулан сургахад нийгмийн байдлын нөлөөлөл түүнийг шийдвэрлэх арга зам, Д.Эрдэнэцэцэг, Д.Эрдэнэтуяа, 2018 он
4. Хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг тэгш хамран сугах журам, 2019 он
5. Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь, IRIM, 2019 он
6. Тусгай хэрэгцээт боловсрол, Д. Одгэрэл, Б. Намираа
7. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхэд үл хайхрах явдлын зарим нөлөөг авч үзэх нь, Л.Нямбаяр, 2018 он
8. Бага, дунд, боловсролын тухай хууль, 2002 он
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018 он
10. үзэх нь, Г.Нямбаяр, 2018 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ТҮҮНИЙ АСРАН ХАМГААЛАГЧИД ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТУРШИХ НЬ

Э.Хэрлэнтуяа¹, Б.Оюун-эрдэнэ¹
¹Дорнод их сургууль

Хураангуй:

Энэхүү илтгэлдээ бид орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчдыг чадваржуулах зорилгоор хэрэгжүүлсэн төсөлт ажлынхаа үр дүнд үндэслэн гэр бүлд суурилсан хамтарсан багийн үйлчилгээг үзүүлэх арга зүйн зарим асуудлыг хөндөж бичлээ.

Өнөөдөр манай оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчидтай ажиллах эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн үйлчилгээг цогцоор үзүүлж үр дүнг үнэлэх аргачлал нь тодорхойгүй байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний асран хамгаалагчийг чадваржуулах үйлчилгээ нь гэр бүлд суурилсан, хамтарсан багаар үзүүлэх цогц үйлчилгээ байх шаардлагатай байна. Энэхүү үйлчилгээний кейс менежер нь нийгмийн ажилтан байх бөгөөд үйлчилгээг хүргэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нөхөн сэргээх, эрх мэдэлжүүлэх, идэвхжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээнд хамруулна. Мөн асран хамгаалагчийг хууль эрх зүй, асран сувилах, нөхөн сэргээх арга зүйгээр ханган чадваржуулах, эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүй, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог тогтвортой, тодорхой болгох хэрэгцээ шаардлагатай байна.

Түлхүүр үг:

Асран хамгаалагч, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хоёр үйлчлүүлэгчийн зарчим, эрх мэдэлжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх

Үндэслэл:

Дэлхийн хүн амын 10 хувь орчим нь буюу 650 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байдаг гэсэн тооцоог 2010 онд дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан. Энэ тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн дотны хүнээ харж хандахын тулд суралцаж, хөдөлмөрлөж, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа гэр бүлийн гишүүд, асран

хамгаалагчдын тоог нэмж үзвэл ойролцоогоор 2 сая хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдарч байна.

Монгол улсын хэмжээнд 2018 оны байдлаар 103,630 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Дорнод аймагт 2016 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 4137 иргэн байсан бол 2017 онд 257 хүнээр өссөн, 2018 онд 63 буурч 4328 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Эдгээр хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь ангилж үзвэл 13.3 хувь нь харааны 20.6 хувь нь хөдөлгөөний, 4.2 хувь нь хавсарсан буюу хүнд хэлбэрийн бэрхшээлтэй, 61.9 хувь нь бусад бэрхшээлтэй хүмүүс байна (1212.mn). Үүнээс Хэрлэн сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 2265 байгаагаас байнгын асаргаатай 133 иргэн байна. (Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, 2016, 12.28) Хэрлэн сумын 10-р багт хөгжлийн бэрхшээлтэй иргэн 390 үүнээс байнгын асаргаа шаардлагатай 63 иргэн бүртгэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадваржуулахад засаг захиргааны анхан шатны нэгжээс үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмж чухал үүрэгтэй бөгөөд багийн нийгмийн ажилтан цогц үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах нь илүү үр дүнтэй байдаг олон улсын туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй байгааг харуулж байна. Энэ утгаараа ирээдүйн нийгмийн ажилтан мэргэжилтнээр бэлтгэгдэж буй бид хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний асран хамгаалагчид үзүүлэх гэр бүлд суурилсан нийгмийн ажлын үйлчилгээний шинэ загварыг орон нутагтаа туршиж үзлээ. Энэхүү туршилт судалгаа нь нийгмийн ажлын хоёр үйлчлүүлэгчийн зарчимд суурилсан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийцсэн, зэрэгцэн суралцсан хамтарсан багийн практик үйл явц байна.

Хамтарсан багийн үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нөхөн сэргээгдэх, хөгжин дэвших, нийгмийн нэг гишүүн болж төлөвших, асран хамгаалагчдыг чадваржуулах тэдний өмнө тулгамдаж буй нийгмийн хамгаалал, сэтгэл зүй, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх гарцыг тодорхойлох

мэргэжлийн багийн хамтын үйл ажиллагааг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний асран хамгаалагчид яагаад хамтарсан багийн үйлчилгээ хэрэгтэй вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд: Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй бөгөөд бие даан амьдрах эрх нь хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хангагдана гэж заасан. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох нөхцлийг бүрдүүлэхэд хамтарсан багийн үйлчилгээ шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, түүний дагалдах журмуудад асран хамгаалагчийн эрх үүрэг, түүнд үзүүлэх нийгмийн дэмжлэг, түүний чиг үүрэг, хөгжүүлэх, чадваржуулах талаар тодорхой заасан заалт байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч нь өөрийн ахуй амьдрал болон нөхөн сэргээх мэдлэг чадварт суралцаж бэлтгэгдсэн асран хамгаалагчид хангалттай байна уу? Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ? гэсэн олон олон асуултууд гарч ирж байна.

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даах чадварыг нэмэгдүүлэх, эрх мэдэлжүүлэх, нийгэмшүүлэх тэдний асран хамгаалагчдын эрх зүйн мэдлэг, асран сувилах арга зүйг дээшлүүлэх, чадваржуулах үйлчилгээг цогцоор нь үзүүлэх үйлчилгээний шинэ загварыг орон нутагтаа анх удаа туршиж үзсэн. байна.

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчийг хөгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүйг туршин шинэ туршлагыг бий болгоход чиглэнэ.

Сэдвийн судлагдсан байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ нөхөн сэргээгдэх боломжийг нэмэгдүүлэх, бие даан амьдрах чадварт суралцахад нь туслах зорилго бүхий үйлчилгээг гэр бүлийн гишүүд, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, нийгмийн ажилтны бүрэлдэхүүнтэй баг үзүүлдэг сайн туршлага япон улсад байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие махбодь,

сэтгэц, сэтгэл зүйд гарч буй сөрөг өөрчлөлтийг цаг хугацаа алдалгүй оношлуулж түүнд тохирсон эрүүл мэндийн өргөн хүрээтэй үйлчилгээ авч чадахгүй байна. Урт удаан эрүүл амьдрах нь хүний чадавхийн маш чухал суурь асуудлуудын нэг бөгөөд үүнийг анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбон тайлбарладаг. Дорнод их сургуулийн нийгмийн ажлын багш оюутнууд хамтран 2016-2017 онд Хэрлэн сумын 10-р багийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчдаас сонгон авч “Халуун сэтгэл-1” төслийг хэрэгжүүлсэн. 2016 оны байдлаар Хэрлэн сумын 10-р багийн нийт хүн амын 70 орчим хувь нь өрхийн эрүүл мэндийн төвөөс анхан шатны үйлчилгээ авсан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд энэ тоон үзүүлэлт их харьцангуй бага байна. тухайлбал бидний хамтарч ажилласан иргэдийн 30 хүрэхгүй хувь нь л анхан шатны үйлчилгээг авсан байна. Мөн хиймэл эрхтэн, туслах хэрэгслийг ашиглах, арчлах, хамгаалах, засан сэлбэх, шинэчлэх тухай зөвлөгөө, сургалт үгүйлэгдэж байна. /Б.Оюун-Эрдэнэ. 2017 он /

Асуудал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагчид хангалттай сайн бэлтгэгдсэн үү? Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш хүртээмжтэй байж чадаж байна уу?, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчийг дэмжсэн нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний тогтолцоо тодорхой байна уу?, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд, түүний гэр бүлд өгөх, сургалт сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах гэсэн хуулийн заалт хэрэгжиж байна уу? хүртээмжтэй байж чадаж байна уу?

Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралт ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР батлагдсан гэвч мөн л энд хбгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчийн эрх үүрэг, хөгжих, боловсрол нийгмийн баталгааг хангасан зүйл заалт, зорилго зорилт байхгүй байна. хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хүнд ба хавсарсан бэрхшээлтэй төрлхийн бэрхшээлтэй иргэдийг асран хамгаалагчгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Судалгааны арга зүй:

Бид 2016-2017 онд “Халуун сэтгэл 1” төслийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р багийн байнгын асаргаа шаардлагатай 63-н хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болон асран хамгаалагч тогтоолгосон 8-н өрхийн 16 иргэнийг тогтолцооны түүврийн аргаар сонгон авсан.

Бид энэхүү судалгааны ажлын үр дүнгээ Дорнод их сургууль болон өөрийн аймаг орон нутаг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд танилцуулж, дараагийн төслийн ажлын танилцуулгыг хүргүүлснээр 2018-2019 онд 2-р шатны хэрэгжилтэнд 5,0 сая төгрөгний санхүүжилт авч чадсанаар бид 2 дахь шатны судалгааны ажилаа ЕБ-ын 11- дүгээр сургуулийн тусгай ангийн 13 хүүхэд, тэдний асран хамгаалагч нарыг системчилсэн түүврийн аргаар сонгон авч ажиллаж байна.

Судалгааны хамрах хүрээ:

Олон улсын практик, онол арга зүй, монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, үндэсний болон орон нутгийн хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагч.

Судалгааны арга:

1. Нийгмийн судалгаанд түгээмэл ашиглагддаг баримт бичигт дүн шинжилгээ хийх, ажиглалт, туршилт хийх, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага зохион байгуулах, анализ, синтезийн арга

2. Нийгмийн ажлын шинжлэх ухааны кейс судлал, зэрэгцэн суралцах, өвчтний түүх судлах, амьдралын түүхийн зураглал гаргах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, генограмм, экозураглал хийх зэрэг мэдээлэл цуглуулах хэрэгслэлийг ашиглан ажиллаа.

Судалгааны үр дүн

Суралцах үе шат: Суралцах үе шатанд оюутнууд хөдөлгөөн засал, хөдөлмөр засал болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүл асран хамгаалагчидтай ажиллах арга зүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, тусламж дэмжлэг, хөнгөлөлт, тусгай хэрэгслийн ач холбогдол гадаад болон дотоодын туршлагауудыг судлан арга зүйн мэдлэг мэдээлэлийг хуримтлуулж, БОЭТ-ийн

Б.Ундрам эмч, 11-р сургуулийн тусгай ангийн багш, Япон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүй, онцлог дасгал хөдөлгөөн, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнээс танхимийн сургалт авч цаашдын шатанд бэлтгэгдэн ажиллаж байна.

Үйлчилгээ үзүүлэх үе шат: “Халуун сэтгэл 1” төслийн хүрээнд Хэрлэн сумын 10-р багийн байнгын асаргаатай 8-н хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэдгээрийн 8-н асран хамгаалагч, “Халуун сэтгэл 2” төслийн хүрээнд тусгай ангийн хүнд ба хавсарсан бэрхшээлтэй 13хүүхэд тэдний асран хамгаалагчид хамтран ажиллах нэг сарын гэрээ байгуулан ажилласан.

Нэг сарын хугацаанд удирдагч багш нар, Япон мэргэжилтэн, багийн нийгмийн ажилтан, чиглүүлэгч 2 оюутан 2-3 удаагийн давтамжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрээр очиж, үйлчилгээ үзүүлж буй оюутнуудын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө мэдээлэлээр хангаж ажилласан. Мөн БОЭТ-ийн их эмч Б.Ундрам эмчтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэрээр очиж гурван удаагийн үзлэг оношилгоо хийж, тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон ахуйн засал, хөдөлмөр заслын үйлчилгээг оюутанд заан зөвлөсөнөөр оюутан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон түүний асран хамгаалагч нарт зэрэгцэн суралцах гэсэн арга зүйг ашиглан чадавхжин ажилласан.

Үйлчлүүлэгчтэй ажиллаж байх хугацаанд ажиглалт, ярилцлагын судалгааны үндсэн дээр асран хамгаалагч нь хууль эрх зүйн мэдээ мэдээлэл, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, туслах хэрэгслийн хэрэгцээ шаардлага, болон эрүүл мэндийн үйлчилгээгээр дутмаг байдгийг нээн илрүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг үр дүнтэйгээр хүргэн хамтран ажилласан.

Бидний хамтын ажиллагааны үр дүнд:

- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах, цогц арга хэмжээ
- БОЭТ-ийн нөхөн сэргээх тасгийн үйлчилгээнд холбон зуучлах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар,

оюуны болон бие бялдарын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох

- Хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхтэй, бие даасан гишүүн болохыг дэмжих
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангах.
- Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах
- Асран хамгаалагчийн хэрэгцээ шаардлагыг илрүүлэх
- Асран хамгаалагчийг төрийн болон төрийн бус үйлчилгээний байгууллага хувь хүн харилцах нийгмийн харилцаанд оролцох идэвхи оролцоог дэмжих арга зүйг судлан тодорхойллоо.

Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчийг хөгжүүлэх ажлын хүрээнд:

- Өвчин, эмгэг, гэмтэл бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдал оруулахад чиглэсэн эрүүл мэндийн чиглэл
- Хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, явдлыг бэхжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд, түүний гэр бүлд өгөх, сургалт сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах ажлуудыг туршин судлах.

Мөн асран хамгаалагчдад зориулсан сургалтын хүрээнд нийгмийн ажлын хоёр үйлчлүүлэгчийн зарчмыг хэрэгжүүлэх боломжыг судлан тодорхойлсон.

Дүгнэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүний асран хамгаалагчдыг чадваржуулах үйлчилгээ байхгүй, асран халамжлах үйл ажиллагаанд нь мэргэжлийн байгууллагын зүгээс үнэлэлт

дүгнэлт хийдэггүйгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд давхар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болж, зөвхөн халамж хүртэгч болох хандлага байна. Тухайлбал, зөвхөн харааны бэрхшээлтэй байсан хүүхэд удаан хугацаанд хэвтэрт байснаас ясны сийрэгжилт явагдаж хөл дээрээ зогсох чадваргүй болсон, эцэг эхийн хайр халамж дутагдсанаас ясны бүтцэд эргэн эмчлэгдэхээргүй өөрчлөлт орж эмгэгтэй болсон, хэлж ярих чадвар султайгаас бусдын нүүрийг эгцлэн харж харилцаа тогтоох чадваргүй болсон гэх зэрэг нийгэм хамт олноос тусгаарлагдсан, давхар давхар эмзэг байдалтай байгаа эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхцөлийг илүү хүнд байдалд оруулахгүй байхын тулд гэр бүлд суурилсан хамтарсан багаар ажиллах, чадваржуулах, эдийн засаг, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай байна. Мөн асран хамгаалагчийн оролцоог хөхиүлэн дэмжиж, тэдний чадамжийг нэмэгдүүлэх стратеги баримтлан ажиллах юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч, халамжлах тухайн гэр бүлийн чадавх сайжрах юм.

Дэвшүүлж буй санал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь тусалдаг, асаргаа үзүүлдэг төвийг аймаг бүрт бий болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд асран хамгаалагчийн эрх, үүргийг тодорхой зааж өгөх
- Олон улсын туршлагаас суралцан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний асран хамгаалагчтай ажиллах мэргэжилтэн, хамтарсан багийг бэлтгэх, үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлгөөн болон хөдөлмөр заслын үйлчилгээ, туслах болон тусгай хэрэгслийг сурталчлан таниулах
- Эцэг эх асран хамгаалагч нарт зориулсан сургалт, зөвлөн туслах үйлчилгээг улиралд нэг удаа аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газраас явуулдаг байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч нарын холбоо байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэмтэл бэрхшээл даамжирахаас урьдчилан сэргийлэх, хэрэгцээ шаардлагатай тусгай хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг гэрийн нөхцөлд хийх арга зүйд асран хамгаалагч, гэр бүлийн

- гишүүдийг сургах, олон нийтийн сургалт зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон түүний асран хамгаалагчдад зориулсан гарын авлагыг олшруулах
 - Асран хамгаалагчийн боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, хангах
 - Хууль эрх зүй, журамд асран хамгаалагчдын эрх, үүрэг нийгмийн асуудлыг хамгаалах, нэмэгдүүлэх тал дээр заалт оруулт оруулах:
19. С.Гансүх, ДИС-ийн нийгэм хүмүүнлэгийн салбарын гадаад хэлний багш

Ашигласан материал

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 2016 он
2. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2012 онд “Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл
3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1996 онд Нуруу нугасны гэмтэлтэй хүмүүсийн бие даах чадварыг дээшлүүлэхэд туслах гарын авлага
4. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. Женев. 1989 он
5. Дорнод аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөр., Чойбалсан хот., 2016 он
6. Оюун-Эрдэнэ,Б.(2017) Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах нийгмийн ажлын онол арга зүйн зарим асуудал
7. Батдулам,С .(2015) Магистрын судалгааны ажлыг хэрхэн гүйцэтгэх вэ?
8. Дорнод их сургууль (2015) эрдэм шинжилгээний ажилд тавигдах нийтлэг шаардлага
9. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар <http://hudulmur-halamj.gov.mn/page/contact>
10. Монгол улсын хүний эрхийн комисс <http://www.mn-nhrc.gov.mn/day/7>
11. Статистикийн нэгдсэн сайт 1212.mn
12. Оюунбилэг,т. (2008) Сэтгэл заслын 48 аргууд. Улаанбаатар хот
13. <http://www.legalinfo.mn/annex/details/5747?lawid=8950>
14. <http://www.legalinfo.mn/law/details/11711>
15. <http://www.dornod.gov.mn/content/16636>
16. <http://www.legalinfo.mn/annex/details/5647?lawid=8790>
17. Ким Ген Чой , БОЭТ-ийн номын санч
18. Оно Юки, ДИС-ийн нийгмийн ажил хөтөлбөрийн сайн дурын мэргэжилтэн

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Э.Самбуу¹, С.Мягмарсүрэн¹, Э.Орхонтуул¹

¹Монголын Үндэсний Их Сургууль, Хууль Зүйн Удирдлагын Сургууль

Үндэслэл

Хүүхдийн төлөвшил гэж юу вэ?

Хүүхэд эцэг эхийн “толь” гэдэг. Тухайн гэр бүлийн уур амьсгал болон гэр бүлийн дотоод харилцааг хүүхдийн хүмүүжлээс харж болдог. Үүний нэг тод жишээ бол хүүхэд хэл сурах. Хүүхэд ямар хэлний орчинд байна тэр хэлийг л сурдаг. Тиймээс эцэг, эхчүүд хүүхдэд ярьж хэлж буй зүйл дээрээ анхаарал болгоомжтой байх ёстой. Эцэг, эх нь хоорондоо эвтэй, найрсаг, бие биенээ хүндэлдэг айлын хүүхэд илүү “хүмүүжилтэй”, өөртөө итгэлтэй, аз жаргалтай байдаг.

Үлгэр дуурайлал гэж юу вэ?

Хүүхдийн зан төлөвт хамгийн их нөлөө үзүүлдэг зүйл бол амьдарч буй орчин юм. Бүр тодруулбал өөрийг нь хүрээлж буй эргэн тойрны байдал, хамт амьдардаг хүмүүсийнх нь амьдралын хэв маяг, ааш араншин, зан чанар, элдэв янзын зуршлууд, хэлж ярьж буй үг яриа, зааж сургаж буй зүйлс, хийж буй үйлдлүүд нь хамгийн ихээр нөлөөлдөг. Зарим хүүхэд яг тийм арга барилыг хуулбарлан өсдөг. Тиймээс хүүхдийг өсөж өндийхийн хэрээр төлөвшилд нь сайтар анхаарах нь чухал. Хүүхдийг багаас нь ахмад хүмүүсийг хүндэлж, тэдний үгийг сонсдог болгох нь хүмүүжлийн хамгийн чухал алхам юм. Хүний үгийг анхааралтай сонсож, өөртөө тусгаж чаддаг бол амьдралдаа тохиолдох ямар ч асуудалд тулгамдахгүй, барьц алдахгүй байж чадна гэдгийг хүүхдийн ой тойнд ортол нь хэлж ярьж төлөвшүүлэх нь маш чухал юм. Таны хүүхдийг цав цагаан цаастай ном гэж бодвол эхний хуудсанд бичиж, зурах, өнгө будаг нэмэх бийр нь та өөрөө юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хэнийг хэлэх вэ?

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно. Хөгжлийн бэрхшээлийн 18 төрөл байдагаас хамгийн түгээмэл шинжүүд нь **Аутизм, Даун, Танин мэдэхүйн өөрчлөлт болон оюуны бэрхшээл** гэдэг 3 шинж байдаг.

Аутизм: Энэ бол сэтгэцийн эмгэг биш хөгжлийн эмгэг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Даун: Махбодын хувьд намхан, богино хүзүү болон богино хуруутай байдаг. Өсөлт эрүүл хүнээс удаан явагддаг. Дауны синдромтой эрэгтэй хүн дунджаар 154 см байдаг бол эмэгтэй хүн дунджаар 142 см байдаг.

Оюуны бэрхшээл

Оюуны бэрхшээл гэдэг нь танин мэдэхүйн чадвар, нийгмийн харилцаа холбоо, биеэ авч явах чадвар нь хязгаарлагдмал хүнийг хэлнэ. Энэ хязгаарлагдмал байдал хөгжих насан дээрээ байгаа хүүхдийг суралцах болон хөгжихөд бэрхшээл болдог. Оюуны бэрхшээл нь хүүхдийг төрөхөөс өмнө эсвэл 18 нас хүрэхээс өмнө бий болдог. Оюуны бэрхшээл бол хамгийн их тохиолддог хөгжлийн бэрхшээлийн төрөл юм. Америкийн оюуны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэгийн судалснаар дараах 3 шинжээр оюуны хомсдолыг таньж болох аж.

1. Тухайн хүний IQ 70-с доош
2. Нийгэмд амьдрах, ажиллах, харилцах чадвар хязгаарлагдмал
3. 18 нас хүрэхээс өмнө энэ байдал нь илэрсэн бол оюуны бэрхшээл байх магадлалтай

МУҮХ-ийн 2р бүлгийн 16.7 мөн МУ-ын иргэний тэгш эдлэх 18 эрх дээр сурч боловсрох эрхтэй гэж заасан байдаг. Эдгээр хүмүүс тусгай хэрэгцээт боловсролыг эзэмшдэг.

Тусгай хэрэгцээт боловсрол гэж юу вэ?

Тусгай хэрэгцээт боловсрол гэдэг нь ерөнхий боловсрол эзэмшүүлэх аргаар удирдан чиглүүлэхэд онцгой хэрэгцээг хангахын тулд тусгайлан боловсруулсан боловсролын сургалтын арга юм.

Нийслэлийн хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролыг эзэмшүүлдэг 6 сургууль байдаг. Үүний **Оюуны бэрхшээлийн чиглэлээр** Нийслэлийн тусгай боловсролын **70,63,55,25** сургуулиуд үйл ажиллагаагаа явуулдаг бол үлдсэн 2 сургууль болох **116,29р** сургуулиуд нь **Хараагүй хэлгүй, Сонсголгүй дүлүй** гэсэн **Биеийн хөгжлийн чиглэлээр** үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Зорилго:

Хүүхэд бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургуулийн эрүүл, аюулгүй ээлтэй орчныг сайжруулах


Зорилт:

Сургуулийн эрүүл аюулгүй орчны байдлыг үнэлэх шаардлага үзүүлэлтийг боловсруулах
Судалгааны үр дүн, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргаж сургуулийн хүүхдэд ээлтэй орчныг сайжруулах талаар санал зөвлөмж гаргах.


Судалгааны боловсруулалт: ”1-р бүлэг”

Багш нараас авсан санал асуулга

1.Хүүхдийн хөгжил төлөвшилд нөлөөлж буй гол хүчин зүйлс




2.Та хүүхдийнхээ эцэг эхтэй хэрхэн хамтарч ажилладаг вэ?




Эцэг эхээс авсан санал асуулга

1.Та хүүхдийнхээ сургууль ангийн ажилд тогтмол оролцдог уу?




2.Та хүүхдийнхээ төлөвшилд хэрхэн анхаардаг вэ?



Судалгаа боловсруулалт: “2-р бүлэг”


Сургуулийн дотоод орчин

1.Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлүүд анги бүрт байдаг уу?



Сургуулийн эмчийн өрөөг бүрэн тоног төхөөрөмжөөр хангах

2.Гараа угаах хэрэгсэл бүрэн байгаа юу? (Саван, гар ариутгагч,хатаагч байдаг уу?)



Ариун цэврийн өрөөнд саван байхгүй мөн хатаагч байдаг ажилладаггүй гэсэн саналыг тэмдэглэсэн байна.

Сургуулийн гадаад орчин

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдал

№	Үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Сургууль орчмын бүс эхлэл	*	
2	Сургууль орчмын бүс төгсгөл	*	
3	Хүүхэд тэмдэг	*	
4	Хурд сааруулагч	*	
5	Явган хүний гарц	*	

Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь стандартын дагуу тэмдэглэгээнүүдийг байрлуулсан ч хангалттай биш үүнийг School

Police 8:00-19:00 хүртэл 2 ээлжээр ажиллан зохицуулж байна. School police хэрэгжсэнээр зам тээврийн осол 25% иар буурсан байна.

2. Сургуулийн гадаад орчны тохижилт

№	Үзүүлэлт	Хангалттай	Дунд	Хангалтгүй
1	Сургуулийн гадаа суух сандал сүүдрэвч байдаг уу?	44%	44%	12%
2	Суруулийн гадаа талбайн гэрэлтүүлэг хангалттай байдаг уу?	54%	32%	14%
3	Сургуулийн гадаад орчин аюулгүй байдалыг хангасан гэж үздэг үү?	30%	56%	14%

Сандал байдагч сүүдрэвч байдаггүй, яг сургуулийн гадаа гэрэл байдаг ч хангалттай тусдаггүй хажуу замын болон урд талбайн гэрэл илүү тусдаг мөн талбайг тохижуулах хэрэгтэй гэж үзсэн байна. Мөн сургуулийн эргэн тойронг камержуулаж шаардлагатай.

Дүгнэлт

Нийгэм хамгаалал гэсэн сэдвийн хүрээнд ТБС-ийн хүүхдүүдийг авч уг сэдвийн доор судалгаа хийсэн. Гадаадын зарим оронд Жишээлбэл: Америк Австрали зэрэг оронд Тусгай боловсролын сурагчдыг хөгжлийн хоцрогдолтой бүлэгт хамааруулдаг бол Монгол улсд 2018 оны Эрүүл мэндийн сайд Нийгмийн хамгаалалын сайдын хамтарсан тушаалын дагуу Оюун санааны хомосдолтой бүлэгт хамааруулдаг байна. Хөгжлийн бэрхшээлийн 18 төрөл байдагаас хамгийн их давамгайлдаг шинжүүд нь Аутизм, Даун гэсэн эмгэгүүд байдаг. Жил ирэх тусам ТБС-д Аутизмтай хүүхдүүд нэмэгдэж байгааг Нийслэлийн тусгай боловсролийн 70-р сургуулийн нийгмийн ажилтан мэдээллэж байна. 2017 оны 9 сарын 1-ээс ЕБС-ийн үдийн цай хөтөлбөр нь 600 төгрөг бол ТБС-ийн үдийн цай хөтөлбөр нь 2400 төгрөг болон нэмэгдсэн. ТБС нь 1-9-р анги хүртэл үдийн цай хөтөлбөрт хамрагддаг. ТБС-ийн хичээлийн хөтөлбөр нь өглөөний 9:00-14:00 хүртэл хичээллэдэг. Хүүхдийн төлөвшилд голлон нөлөөлж буй хүчин зүйлсүүд нь Багш, Эцэг эхийн үлгэр дуурайлал, сургаал зааварчилгаа зөвөлгөө, хамтын үйл ажиллагаа нь хүүхдийг хөгжиж хүмүүжиж төлөвшихөд хамгийн ихээр нөлөөлж байна.

Санал зөвлөгөө, Шийдэл

Тусгай боловсролын сургууль

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль

14.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдарын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох.

- 1. ТБС-ийн сурагчдын хөгжлийн танхим:** Энэ нь нийт тусгай боловсролын сургуулийн хүүхдүүдийг нийгмийн төлөвшилтэй илүү танилцуулах үүднээс хөгжлийн танхимыг сургуулийн зүгээс бий болгоно.
- 2. Эрүүл мэндийн өрөөний тохижилт:** Энэ нь хүүхдүүдийг эмчээс эмээхгүй өөрийн дураар ирж үзүүлдэг байх.
- 3. Туслах багш нэмэгдүүлэх:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заах багшийн ноором нь 4-5 хүүхдэд 1 багш байдаг, гэтэл манай улсад туслах багшийн орон тоо цөөн байдаг тул тусгай боловсролын сургуулийн багш нар хамгийн багадаа 15 хүүхдэд хичээл орж хүнд ачаалалтай ажиллаж байна.

Ном зүй

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль
- Нийгмийн ажилтайн
- Үндэсний статистикийн хороо

ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН СЭРГЭЭН ЗАСАХ АМБУЛАТОРИЙН ТАСГИЙН ХЯНАЛТАНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН НИЙГМИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Р.Отгонсайхан¹, Х.Циендолгор¹, Н.Баяржаргал¹
¹Хүүхдийн төв сувилал

Үндэслэл

Албан ёсны статистик буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн 2017 оны мэдээллээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 103.6 мянган иргэн (нийт хүн амын 3.3 хувь) байгаагийн 44384 буюу 42.8 хувь нь төрөлхийн, 59246 буюу 57.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. 0-14 насны хүүхэд 8 835, 14-17 насны хүүхэд 2618 байна. Нийт хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их 20.6 мянга буюу 19.9 хувь байна¹.

“Хүн амын амьжиргааны доод түвшин гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ” гэж хуулинд заасан байдаг. Хэрэглээний доод хэмжээ гэдэн нь хүний нэн тэргүүний зайлгшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний тоо хэмжээ байдаг. Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэрийн доод хэмжээ 243000 төгрөг байгаа нь нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой амьдарч байна гэсэн үг.²

Амьжиргааны баталгаат түвшинг харьцуулахад хүүхдүүдийн хувь нь доогуур байна. эцэг эхийн ажил эрхлэлтийг харахад ээжүүдийн ажил эрхлэлтийн түвшин доогуур буюу ажилгүй хүүхдээ хардаг байна.

Монгол улсын үндэсний статистикийн хорооноос амьжиргааны доод түвшинг бүс нутгаар авч үзсэн бөгөөд Улаанбаатар хотын хувьд өрхийн 1 хүнд оногдох орлогын доод хэмжээ 185300/196000 төгрөг тогтоогдсон байна.

2017 оноос ХТС-ын СЗАТ-аар тархины саатай, хөдөлгөөний хоцрогдолтой, Дауны хам шинжтэй хүүхдүүдийг хяналтанд авч эмчилгээг графикаар хийж эхэлсэн. Эмчилгээний явцад эцэг эхчүүд хүүхдээ эмчилгээнд бүрэн хамруулахгүй, хүүхэд өвдөх, гэр хол, унааны

мөнгө байхгүй гэх мэт тохиолдлууд байсан. Ар гэрийн байдал боломжтой эцэг эхчүүд хүүхдээ эмчилгээнд тогтмол цагтаа авч ирдэг, харин боломж муутай эцэг эхчүүд хүүхдийнхээ эмчилгээг тасалдаг байдал ажиглагдсан. Зарим тохиолдолд удаа дараа утсаар дуудуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар ихэнхдээ яригддаг боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн талаарх судалгаа ховор байдаг тул бид энэ талаар судлах болсон юм.

Түлхүүр үг

Хөгжлийн бэрхшээл, тархины саажилт, хөдөлгөөний хоцрогдол, Дауны хам шинж, амьжиргааны түвшин.

Зорилго

ХТС-ын СЗАТ-т хяналтанд эмчлүүлж байгаа хүүхдүүдийн нийгмийн байдлыг судлах

Зорилт

1. Хяналтын хүүхдүүдийн нийгмийн байдлын талаар судалгаа авч, үнэлгээ өгөх
2. Амьдралын нөхцөл, өрхийн орлого, харьяалал зэрэг нь хоорондоо хамааралтай эсэхийг судлах

Судалгааны арга аргачилал

Судалгаанд хяналтын 67 хүүхдийн эцэг эхээс нийгмийн байдлын талаар асуумж авч нэг агшины судалгаа хийж, Word, Excel, SPSS-25 программууд ашиглан боловсруулалт хийлээ.


Судалгааны ажлын үр дүн

ХТС-ын СЗАТ-ийн хяналтанд нийт 126 хүүхэд хамрагддаг. Үүнээс судалгаанд 67 /53%/ хүүхэд хамрагдсан ба бусад хүүхдүүдийн эцэг эхтэй тухайн үед холбогдох боломжгүй байлаа.

Судалгаанд хамрагдсан 67 хүүхдийн эрэгтэй 42 /62.7%, эмэгтэй 25 /37,3% байлаа. Насны байдлаас авч үзэхэд хамгийн бага нь 1наснаас доош хүүхэд 3 /4,5% , 1-2настай 20 / 29,9%, 2н1с-3настай 19 / 28,4%, хамгийн их 3-аас дээш насны хүүхэд 25/ 37,3% байлаа.

1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа Мэдээллийн лавлах. 2017 он
2 “Сонсгол хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг олон улсын үйл ажиллагааны ангиллаар үнэлсэн нь” Т.Цэрэннадмид, П.Мөнхтулга 2019 он

График 1



Оношийн бүлгээр харахад хүүхдийн тархины саа хамгийн өндөр 47 /68,7% байсан бол хамгийн бага нь Дауны хам шинж өвчний эзлэх хувь 8 /11,9%, хөдөлгөөний хоцрогдол 13 /19,4% тус тус гарлаа.

Хөдөө орон нутгаас 10 /14,9% хүүхэд хамрагдсан ба дүүргүүдээс хамгийн их хамрагдсан нь СХД 19 /28,4% хүүхэд байсан ба хамгийн бага нь СБД 2 /3% хүүхэд байлаа. Хөдөө орон нутгаас 14,9% хүүхэд хамрагдсан нь тус сувилал нь улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нь харагдаж байна.

График 2



	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
хөдөө	10	14.9	14.9	14.9
СХД	19	28.4	28.4	43.3
БЗД	10	14.9	14.9	58.2
БГД	13	19.4	19.4	77.6
ЧД	6	9.0	9.0	86.6
ХУД	7	10.4	10.4	97.0
СБД	2	3.0	3.0	100.0
Total	67	100.0	100.0	

Цалингийн доод хэмжээ 310.000т байдаг ба манай хяналтын хүүхдүүдийн 11нь ямар ч орлогогүй, эцэг эх нь ажилгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн аль нэг нь ажил эрхлэх боломжгүй хүүхдээ асарч гэртээ байдаг нь өрхийн орлогод нөлөөлдөг байна.

График 3




График 4



Өрхийн орлогын байдлаас харахад Монгол улсын үндэсний статистикийн хорооноос амьжиргааны доод түвшин Улаанбаатар хотын хувьд өрхийн 1 хүнд оногдох орлогын доод хэмжээ 196.000 төгрөг бол бидний судалгаагаар орлогогүй 11 /16,4%, 196.000т хүртэлх 30/ 44,6%, 196-300.000т 9/ 13,4%, 301-500.000т 12/ 17,9%, 501.000т дээш 5/ 7,5% байлаа. Энэ нь судалгаагд хамрагдсан хүүхдүүдийн 41 буюу 61,2% нь өрхийн орлогын нэг хүнд ноогдох орлогын түвшинд хүрэхгүй байгааг харуулж байна.

График 5



Түүнчлэн гэр бүлийн байдлыг судлахад эцэг эхтэйгээ хамт байдаг 55 /82,1% хүүхэд, эх нь ганцаараа асардаг 8 /11,9%, эцэг нь ганцаараа асардаг 3/ 4,5%, эмээ өвөө дээрээ байдаг 1/1,5% хүүхэд гэж гарсан байна. Үүнээс харахад 12 /17,9% хүүхэд хагас болон бүтэн өнчин байгаа нь амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлнө.

График 6





График 7



Харьяалал ба ахуйн нөхцөл хоорондоо хамааралтай эсэхийг харахад орон сууцанд амьдардаг хүүхэд 39 / 58,2% ихэнх хувийг эзэлж байгаа ба гэрт 13 /19,4%, байшинд 14 /20,9%, бусад буюу нийгмийн халамжийн байранд 1 /1,5% гэсэн байна. Үүнээс орон сууцанд бус цөөнгүй хувь эзэлж 28 /41,8% байгаа нь анхаарал татаж байна.



Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан 67 хүүхдийн эрэгтэй 42 /62.7%, эмэгтэй 25 /37,3% байлаа. Насны байдлаас авч үзэхэд хамгийн бага нь 1наснаас доош хүүхэд 3 /4,5% , хамгийн их 3-аас дээш насны хүүхэд 25/ 37,3% байлаа. Оношийн бүлгээр харахад хүүхдийн тархины саа хамгийн өндөр 47 /68,7% байсан. Хөдөө орон нутгаас 10 /14,9% хүүхэд хамрагдсан ба дүүргүүдээс хамгийн их хамрагдсан нь СХД 19 /28,4% хүүхэд байлаа.
2. Манай хяналтын хүүхдүүдийн 11/16,4% нь эцэг эх нь ажилгүй, ямар ч орлогогүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн аль нэг нь ажил эрхлэх боломжгүй хүүхдээ асарч гэртээ байдаг нь өрхийн орлогод нөлөөлдөг байна.

Гэр бүлийн байдлыг судлахад 12 /17,9% хүүхэд хагас болон бүтэн өнчин байгаа нь амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлнө. Ахуй нөхцөлөөс харахад “орон сууцанд бус” цөөнгүй хувь эзэлж 28 /41,8% байгаа нь анхаарал татаж байна.

Судалгаагд хамрагдсан хүүхдүүдийн 41 буюу 61,2% нь өрхийн орлогын нэг хүнд ноогдох орлогын түвшинд хүрэхгүй байгааг харуулж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТЭГШ ЭРХИЙН БАЙДАЛ

Хуульч Ж.Ганболд¹

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрхийн хамгаалах Ирээдүй төв

Хураангуй

Хүн төрөлхтний түүхэнд хөгжлийн бэрхшээлийн тухай асуудал байсаар ирсэн. Энэ асуудлыг шийдвэрлэх гол арга замын нэг бол тухай улсын хууль эрх зүйн орчин юм.

Бид хуулийн эрх зүйн асуудлын талаар ярьж эхлэхийн өмнө Ардчилсан тодотголтой үндсэн хуулийн талаар дурьдах нь зүйтэй.

Анх хүн төрөлхтний түүхэнд 1787 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр АНУ-ын Үндсэн хууль батлагдсан нь олон улсын тавцанд хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг тунхаглан зарласан анхны бичмэл хууль болж, ардчилсан тодотголтой, үндсэн хуультай улс орон үүсэн бий болсон түүхтэй.

Монгол Улс хөгжлийнхөө түүхэнд анх удаа 1992 онд Хүний эрхийн тухай асуудлыг улс орны дотоод амьдаралын хүрээнд тавьж, түүнийг хүлээн зөвшөөрсөн нь ардчилсан тэмцлийн гол ололт болсон юм.

Хүний эрхийн тухай асуудал бол тэгш эрхийн тухай асуудалтай салшгүй холбоотой бөгөөд уг асуудлыг салгаж үл болно.

НҮБ-ын үндсэн зорилгын нэг нь арьс, үндэс, хүйс, шашин шүтлэгээр нь үл ялгагварлан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг сайшаан хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх явдал гэж тодорхойлсон байдаг.

НҮБ-ын Ерөнхий ассамблей 1946 оны 12 дүгээр сарын 10-ны өдөр Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталж, хүний эрх, эрх чөлөөг нэгтгэн тодорхойлсон нь улс орнууд хүний эрхийн талаар баримтлах үндсэн удирдамж болсон юм. Манай улс 1961 онд НҮБ-д элссэнээс хойш хүний эрхийн салбар дахь үйл ажиллагаанд оролцож 30 гаруй конвенцид нэгдэн орсон үүнээс дурдвал:

Иргэний болон улс төрийн эрхий тухай олон улсын пакт 1960, Монгол улс 1974 онд нэгдэн орсон, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улс 1990 онд нэгдэн орсон,

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц НҮБ-ын конвенцийг Монгол Улс

2009 онд соёрхон баталсан... гэх мэт олон конвенцид нэгдэн орсон байна. Монгол Улсын Их Хурлаас 1995 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэм хамгааллын тухай хуулийг баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн харилцааг зохицуулж байсан бөгөөд

2016 онд Улсын Их Хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан гаргасан нь НҮБ-ын конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэх суурь хууль болж байна. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, эрх чөлөө тэгш байдлын талаар зохицуулалт хангалтгүй, хариуцлагын механизм тодорхой бус байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, эрх чөлөө тэгш байдал зөрчигдөж байгаа тул энэ сэдвийг сонгон судлах шалтгаан болсон юм.

Түлхүүр үг:

Эрх чөлөө, тэгш байдал

Судлагдсан байдал

Монгол Улсад Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг 70 орчим салбар хуулийн хүрээнд зохицуулж байгаагаас гадна Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр гэх мэт зорилтод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Гэвч эдгээр хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлэх аргачлал тодорхойгүй, санхүүгийн нөөц хангалтгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч чадахгүй байна гэх шүүмжлэлүүд байнга гарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш эрхийн асуудлаар дагнан нарийвчлан судалсан судалгааны тайлан байдаггүй бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо яг хэд вэ гэдэг нь тодорхойгүй байгаагаас харж болно.

Судалгааны зорилго

Манай гариг дээр нэг тэрбум гаруй хүн хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй амьдарч байгаагаас 15 хүртэлх насны 20 хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Монгол Улсад 11.500 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Улсын ирээдүй хүүхдээс, хүүхдийн ирээдүй биднээс шалтгаалдаг. Тиймээс хүүхдийнхээ ирээдүйн өөрчлөлтийг төлөө өнөөдрөөс эхлэн тэмцэх нь эцэг, эх бидний үүрэг билээ.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьд явах эрх, сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зэрэг эрхүүд хэрхэн хангагдаж байгаа эсэх, нийгмийн харилцаанд тэгш оролцож байгаа эсэх асуултын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Авто замын тухай хууль, Барилгын тухай хуулиудын зохицуулалт, уялдаа холбоо, Замын хөдөлгөөний


дүрэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг зөрчсөн байдал, боловсролын салбарт тулгамдаж буй хүүхэд харах, өдөр өнжүүлэх, хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжлүүлэх үйлчилгээг бодит амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг судалж үзэхийг зорьсон болно.

Судалгааны арга зүй

Энэхүү илтгэлийг бэлтгэхэд судалгааны арга зүйн үндэс, танин мэдэхүйн диалектик аргуудад тулгуурласан. Задлан шинжлэх нэгтгэн дүгнэх, статистик судалгаа болон харьцуулалтыг аргыг голлон ашигласан болно.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, төрлөөр, 2018 он



Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хэлбэрээр, 2017-2018

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	2017				2018			
	Улсын хэмжээнд		Улаанбаатар хот		Улсын хэмжээнд		Улаанбаатар хот	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
Бүгд	103 630	100.0	32 246	100.0	105 691	100.0	35 589	100.0
Хараа	11 071	10.6	3 068	8.9	11 519	10.9	3 336	9.4
Яриа	4 228	4.0	1 588	4.6	4 312	4.1	1 698	4.8
Сонсгол	8 554	8.2	2 810	8.2	8 439	8.0	2 759	7.7
Хөдөлгөөн	20 688	19.9	5 638	116.4	21 598	20.4	6 207	17.4
Сэтгэц	19 733	19.0	6 093	17.7	20 364	19.3	6 679	18.8
Хавсарсан	7 842	7.5	3 502	10.2	7 278	6.9	3 244	9.1
Бусад	31 514	30.4	11 547	33.7	32 181	30.4	11 666	32.8

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 35,6 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33,7 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 70,1 мянга буюу 66,3 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, насны бүлэг, төрлөөр, 2018

Насны бүлэг	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр			
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Төрөлхийн		Олдмол	
			Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
Бүгд	105 691	100.0	46 958	44.4	58 733	55.6
0-4	2 026	1.9	1 700	3.6	326	0.5
5-9	3 551	3.3	2 831	6.0	720	1.2
10-14	3 431	3.2	2 581	5.5	850	1.4

15	755	0.7	573	1.2	182	0.3
16	749	0.7	520	1.1	229	0.4
17	825	0.78	548	1.7	277	0.5
18	889	0.8	559	1.2	330	0.6
19	1 188	1.2	723	1.5	465	0.8
20-34	21 918	20.7	11 681	24.8	10 237	17.4
35-64	64 335	60.8	23 293	49.6	41 042	69.8
65, түүнээс дээш	6 024	5.6	1 949	4.1	4 075	6.9
Улаанбаатар	35 589	100.0	15 956	34.0	19 633	33.4
0-4	877	2.4	754	4.7	123	0.6
5-9	1 498	4.2	1 223	7.6	275	1.4
10-14	1 278	3.6	982	6.1	296	1.5
15	255	0.7	204	1.2	51	0.2
16	210	0.6	145	0.9	65	0.3
17	254	0.7	173	1.0	81	0.4
18	280	0.8	190	1.2	90	0.4
19	361	1.0	220	1.4	141	0.7
20-34	7 399	20.7	3 668	23.0	3 731	19.0
35-64	21 414	60.0	7 930	50.0	13 484	68.6
65түүнээс дээш	1 763	5.0	467	2.9	1 296	6.6

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 20,4 хувь /21.6 мянга/, ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4,1 хувь /4,3 мянга/ байна. Харин Улаанбаатар хотод сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 18,8 хувь /6,7 мянга/, ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 18,8 хувь буюу /6,7 мянга/, ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хамгийн бага буюу 4,8 хувь /1,7 мянга/ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2014-2018

№	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	2014	2015	2016	2017	2018
1	Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	99573	101730	100993	103630	105691
2	-Төрөлхийн	35681	41550	43082	44384	46958
3	-Олдмол	61379	57888	55809	57137	56136
4	0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	11365	7840	8151	8835	9008
5	Хараа	9652	10925	11001	11071	11519
6	сонсгол	8304	8406	8560	8554	8439
7	Хэл яриа	5294	4491	4367	4228	4312
8	Хөдөлгөөн	18411	20110	20127	20688	21598
9	Сэтгэц	16997	18433	18359	19733	20364
10	Хавсарсан	10116	7912	8052	7842	7278
11	Бусад	30799	31453	30527	31514	32181

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 2014-2018 оны байдлаар харахад 6118 буюу 6,1 хувиар өссөн байна. Төрөлхийн бэрхшээлтэй хүний тоо 11277 буюу 31,6 хувиар нэмэгдсэн, олдмол бэрхшээлтэй хүний тоо 5243 буюу 8,5 хувиар буурсан байна.

Түүнчлэн 0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2357 буюу 20,7 хувиар буурсан, харааны бэрхшээлтэй хүний тоо 1867 буюу 19,3 хувиар нэмэгдсэн, сонсголын бэрхшээлтэй хүний тоо 135 буюу 1,6 хувиар нэмэгдсэн, хэл ярианы бэрхшээлтэй хүний тоо 982 буюу 18,5 хувиар буурсан, хөдөлгөөний бэрхшээлтэй хүний тоо 3187 буюу 17,3 хувиар нэмэгдсэн, сэтгэцийн бэрхшээлтэй хүний тоо 3367 буюу 19,8 хувиар нэмэгдсэн, хавсарсан бэрхшээлтэй хүний тоо 2838 буюу 28 хувиар буурсан бусад төрлийн бэрхшээлтэй хүний тоо 1382 буюу 404 хувиар нэмэгдсэн тус тус үзүүлттэй байна.

Тусгай сургуулийн мэдээ, тоо баримт

№	Тусгай сургуулиуд	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бага анги	Дунд	Ахлах
1	55-р сургууль	478	200	278	247	182	49
2	63-р сургууль	233	97	136	116	117	-
3	29-р сургууль	315	140	175	133	120	62
4	116-р сургууль	104	42	62	65	34	5
5	25-р сургууль	208	83	125	106	103	-
6	70-р сургууль	299	113	186	189	110	-
		1637	675	962	856	665	116
	Нийт	1637					

Тусгай боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтний	Хавсарсан
2012-2013	1300	255	59	232	110	354	290
2013-2014	1368	246	71	242	118	389	302
2014-2015	1437	242	82	288	119	514	192
2015-2016	1369	218	81	252	151	390	277
2016-2017	1517	241	102	282	170	451	267
2017-2018	1637						

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенц, болон Монгол Улсын Үндсэн хуулинд хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийн талаарх зохицуулалтын талаар

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцын 1 дүгээр зүйлд заасан “Энэхүү конвенцын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах хөхиүлэн дэмжих, тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.”

2 дугаар зүйлд “**Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт** бие махбодь оюун санаа сэтгэл мэдрэл, мэдэрхүйн байгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсэний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.”

5 дугаар зүйлийн 1-д “Адил тэгш байдал, үл алагчилал, Хүн бүр адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн алагчилалгүйгээр тэгш хамгаалуулж адил тэгш, үр дүнтэй хуулийн хамгаалалт бий болгохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.”

5 дугаар зүйлийн 2-д “Оролцогч улсууд нь хүнийг бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн

алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалт бий болгоно,”

7 дугаар зүйлийн 1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах, бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.” гэсэн заалтууд,

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2 дугаар бүлэгт **ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ** гэж тусдаа бүлэг болгож зохицуулсан.

Үүнд:

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, гэжээ.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 1/ амьд явах эрхтэй. 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх,

өв залгамжлуулах эрхтэй. 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. 5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй; 6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. 7/ сурч боловсрох эрхтэй. 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. 10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. 11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. 13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй; 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.” гэжээ,

2016 онд Улсын Их Хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд

бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг”.

4.1.2-т “Хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүй” ойлгоно гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал

Монгол Улсад 1964 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль байгуулах ажлын эхлэл тавигдсан. Одоогоор нийслэлд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай 6 сургууль ажиллаж байгаагийн дөрөв нь (25, 55, 63, 70 дугаар сургуулиуд) оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй нийт 1637 хүүхдүүдэд тусгай хэрэгцээт хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлж байгаа хэдий ч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийнхээ бусад хүүхдийн адил сурч боловсрох эрхтэй, Хүүхэд бүр өөрийн харъяалагдаж буй нутаг дэвсгэртээ боловсрол эзэмших ёстой боловч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна.

Монгол Улсын хэмжээнд тусгай сургуулийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн өдөр өнжүүлэх, хүүхэд харах, хүүхдийг хамт олон түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ байхгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр боловсролын үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй, бүрэн, дүүрэн хамрагдаж чадахгүй байна.

Тусгай сургуулиудын дэргэд хүүхдийн өдөр өнжүүлэх төв ажилладаг боловч дээрх төв нь хууль, эрх зүйн ямар зохицуулалтын хүрээнд ажиллаж байгаа болох, өдөр өнжүүлэх төвийн багш нь хаанаас цалин хөлс авдаг болох, нэг хүүхдэд ногдох багшийн тоо, талбайн хэмжээ, хүүхдийн насны ангилал... гэх мэт олон асуудлууд хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж байна.

Жишээ нь: Тусгай 25 дугаар сургуульд хичээлийн танхимын хажууд 18 м² орчим

талбайтай байранд насны ангилалгүйгээр 6-16 насны 10-20 орчим хүүхдийг хичээлийн бус цагаар өдрийн 3.500 төгрөгийн төлбөртэй харах үйлчилгээ үзүүлж байна.

Замын хөдөлгөөний дүрэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг зөрчиж буй байдал

2018 оны байдлаар Нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль, цэцэрлэгт 1757 хүүхэд хамрагдаж байгаагаас сургуульд 1637 хүүхэд, сувилалын цэцэрлэгт 120 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Сургууль, цэцэрлэгт суралцаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь өөрөө биеэ даан явж чадахгүй, тулгуур эрхтэний бэрхшээлтэй, хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нь хувийн тээврийн хэрэгсэлээр сургууль, цэцэрлэгт нь тогтмол хүргэж өгдөг боловч авто машины дугаарын хязгаарлалттай өдөр нийтийн тээврийн хэрэгсэл болон таксийгаар хүүхэдтэйгээ зорчдог.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.1 дүгээр зүйлд заасан “Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараахь бичиг баримттай байна”: Д-д заасан “«Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл жолоодоход тулгуур эрхтний бэрхшээлтэйг нотлох бичиг баримт...” гэсэн заалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Тулгуур эрхтний бэрхшээлтэй болохыг тогтоож, таних шар тэмдэг олгож байгаа юм.

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд үйлчлэхгүй байгаа нь дараах хууль тогтоомжийг зөрчиж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш эрхийг зөрчиж байна гэж үзэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан “... Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж хөхүүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор оролцогч улсууд дараах үүрэг хүлээнэ: ...b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдал үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, журам дүрэм, зан заншил, уламжлалыг арилгах өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна” гэсэн,

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан “хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Авто замын тухай хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг зөрчиж буй байдал

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан “Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д заасан “Бүх төрлийн гүүр, тавилан, гүүр гарц, ундаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг ойлгоно”. Мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан “... авто зам, замын байгууламжийг барих,... хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих ... мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны засаг дарга...бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Авто замын хууль тогтоомж зөрчсөн этгээд Зөрчлийн хуулийн 14.4, 14,5 дугаар зүйлүүдэд “авто замын тэмдэг тэмдэглэгээ болон авто замыг ашиглахдаа эвдэж гэмтээсэн тохиолдолд цагдаагийн эрх бүхий албан хаагч хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан”. Харин авто зам, замын байгууламжийг барихдаа стандарт нормотивийг зөрчсөн бол ямар хариуцлага хүлээлгэх зохицуулалт зөрчлийн тухай хуулинд

тусгагдаагүй нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэгш байдлыг зөрчиж байна.

Барилгын тухай хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг зөрчсөн байдал 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “механик аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх” **12 дугаар зүйлийн 12.1-д** “Барилгын зураг төсөл дараахь шаардлагыг хангасан байна”, 12.1.6-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх” **15 дугаар зүйлийн 15.1-д** “Барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлагыг тусгана” 15.2-т “Энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг барилгын норм, дүрэм, стандартаар зохицуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 5,6,7-д зүйлд зааснаар хүнийг 500 нэгж, хуулийн этгээдийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлийн Мэргэжлийн хяналтын байцаагч ногдуулахаар хуульчилсан байна.

Барилгын тухай хуулийн зохицуулалт нь 2017 оноос өмнө баригдсан барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ норм стандартыг хангаагүй тохиолдолд хэрхэн хэнд ямар шийтгэл ногдуулах нь тодорхой бус, энэ талаар зөрчлийн хуулинд ямар нэгэн зохицуулалт байхгүй байна.

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй болон тэргэнцэртэй хүүхэд, тулгуур эрхтэний бэрхшээлтэй хүүхдүүд барилга байшинд чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлаж, тэгш эрхийг хязгаарлаж, тэгш эрхийг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

Дүгнэлт

Улсын Их Хурлаас 1995 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэм хамгааллын тухай хуулийг баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн харилцааг анх зохицуулж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улс 2009 онд соёрхон баталж, 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан гаргаж хөгжлийн

бэрхшээлтэй хүнийг үндсэн эрхээ эдлэх боломж олгох эрх зүйн үндэсийг тавьсан боловч хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хүүхдийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөл бүрдүүлж чадахгүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, авто зам, барилга байгууламж гэх мэт бүх л салбарт тэдний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчигдсэн хэвээр байна.

Миний энэхүү итгэлийн зорилго бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийн оролцоог нэмэгдүүлэх явдал бөгөөд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусгайлан нарийвчлан тусгах, холбогдох хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах талаарх саналыг дэвшүүлж байна.

Санал зөвлөмж:

Нэгдүгээрт

Тэгш эрх бол /англи-equality/, / Орос-Равенство/ гэдэг ойлголт нь харьцангуй тэнцвэртэй зохистой тэнцлийг хангах гэсэн утгаас эх авч аливаа хүн ямар ялгаваргүйгээр өөрийн эрх чөлөөг хангах, тэгш боломж нөхцөлөөр хангагдах гэсэн агуулгыг тусгана. МЭӨ 500 онд Грекийн түрүү үеийн нэрт сэтгэгч Пифагор эрх тэгш байдлын танин мэдэхүйн онол боловсруулжээ.

Эрх зүйн нь нийгэм дэх тэгш ба тэгш бус байдлыг хязгаарлан тогтоогч болохын хувьд тэгш эрхийн зарчмыг хуульчлан тогтоож, төрийн зүгээс хамгаалж бататгасан байдаг.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 онд баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 2 дугаар зүйлд “Хүн бүр...бүхийл эрх чөлөөг ямарч ялгаваргүйгээр, арьс өнгө, хүйс, хэл шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, язгуур угсаа, **бусад ялгааг эс харгалзан** эдлэх ёстой...” гэж тунхагласан.

Монгол Улсын Үндсэн хуулинд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой, түүнтэй ойролцоо утгатай мэдээлэл байхгүй байгаа нь үндсэн хуулиараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхаж байна гэж үзэхээр байгаа тул тэдэнд нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг олгох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулинд тусгаж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Дэлхийн улс орнуудын Үндсэн хуулиас

судалгаа хийж үзэхэд дэлхийн 198 улсын 39¹ улс нь Үндсэн хуулиндаа хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг тусгасан байна².

Хоёрдугаарт

2016 онд батлан мөрдөж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 8 дах хэсэгт зааснаар “хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ялгаварлан гадуурхсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснээс өөр хариуцлага хүлээлгэх зохицуулалт байхгүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гадуурхсан гэж үзэхээр байна.

Тухайлбал: Манай улсад 2019 оны байдлаар Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 8 дах хэсэгт заасан зохицуулалтаар зөрчлийн хэрэг үүсгэж хариуцлага тооцсон тохиолдол байхгүй байгаа бөгөөд хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ямар эрхийг хэн зөрчсөн, зөрчсөн этгээдэд Зөрчлийн хуулийн ямар заалтаар хариуцлага тооцдог болохыг тодорхой ялгаж дэлгэрэнгүй оруулах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх” гэж тусгай бүлэг болгон зохицуулсан боловч дээрх зохицуулалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд ямар хариуцлага хүлээх зохицуулалт хуулинд байхгүй байна.

Жишээ нь: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан “ Бүх шатны сургалтын байгууллага ... дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ”, 15.1.2- т заасан “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэглээнд тохирсон ном сурах бичиг, гарын авлага материал, тусгай хэрэглээний суралтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах,” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн сургалтын байгууллагад хариуцлага хүлээлгэх боломжгүй юм.

Гуравдугаарт

Авто замын тухай хуулиас жишээ дурьдвал:

Авто замын хууль тогтоомж зөрчсөн этгээд Зөрчлийн хуулийн 14.4, 14.5 дугаар зүйлүүдэд

“авто замын тэмдэг тэмдэглэгээ болон авто замыг ашиглахдаа эвдэж гэмтээсэн тохиолдолд цагдаагийн эрх бүхий албан хаагч хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан”. Харин авто зам, замын байгууламжийг барихдаа стандарт нормотивыг зөрчсөн бол иргэн, хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт Зөрчлийн тухай хуулинд байхгүй байна.

Дөрөвдүгээрт

Барилгын тухай хуулиас жишээ дурьдвал:

Барилгын тухай хуулийн зохицуулалт нь 2017 оноос өмнө баригдсан барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ норм стандартыг хангаагүй тохиолдолд хэрхэн хэнд ямар шийтгэл ногдуулах нь тодорхой бус хуулийн зохицуулалтгүй байна.

Тиймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Авто замын тухай хууль, Барилгын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхсан зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ зөрчил үйлдсэн этгээдийн нийгмийн хор аюулын шинж чанарт тохирсон шийтгэлийг оногдуулах талаар тусгах шаардлагатай.

Тавдугаарт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд байнгын согог, хөдөлгөөний бэрхшээл, сургалтын орчин гэх мэт олон хүчин зүйлээс болж бусад хүүхдийн адил сурч боловсрох нөхцөл хязгаарлагдмал байдаг бөгөөд сургуулиас гадуур хүүхдийг хамт олон түшиглэн хөгжүүлэх, сургах, харах үйлчилгээний эрх зохицуулалт байхгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эмнэлгийн тусламж авах эрхүүд зөрчигдсөөр байгаа билээ.

Энэ талаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон Боловсролын тухай хуулинд зохицуулт байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч нарт тулгамдаж буй асуудлыг нэг болоод байна.

Тодруулбал: Судалгаагаар Монгол Улсад 11.500 орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа бөгөөд эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг асран хамгаалахад өрхийн гишүүний нэг нь хөдөлмөр эрхлэх боломжгүй болж хүүхдээ байнга асардагаас гадна хүүхдээ цэцэрлэг сургуульд нь өөрийн өмчлөлийн авто машин буюу нийтийн тээврийн хэрэгсэлээр хүргэж өгөх, эрүүл мэнд, эм тариа, рашаан сувилал, эмчилгээ асаргаанд байнга мөнгө

зарцуулдаг боловч одоогийн байдлаар улсаас авдаг асаргаа болон халамжийн тэтгэмж нийт 288.000 төгрөг нь тэдний хэрэгцээнд хүрэлцдэггүй бөгөөд нийгмийн эмзэг бүлгийн өрх болж байна

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс хүүхдийг эрүүл аюулгүй, тав тухтай орчинд хөгжүүлэх, асрах, харах, өндөр өнжүүлэх үйлчилгээний талаар хууль эрх зүйн орчин бүрдүүлж, Засгийн газрын бодлого, хөтөлбөрт тусгаж, тэдний нууруун дээрх ачааг хөнгөлөх нь зүйтэй.

Зургаадугаарт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Замын хөдөлгөөний дүрмийн 3.1 дүгээр зүйлд заасан “Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараах бичиг баримттай байна”: Д-д заасан “«Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл жолоодоход тулгуур эрхтний бэрхшээлтэйг нотлох бичиг баримт..” гэсэн заалт нь:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн асуудлын нэг хэсгийг шийдвэрлэсэн нь талархалтай хэдий ч Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхаад зогсохгүй Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл заасан “... Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Иймд Замын хөдөлгөөний дүрмийн дээрх заалтанд өөрчлөлт оруулж, Нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль, цэцэрлэгт суралцаж байгаа 1757 хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид шар тэмдэг олгуулах зүйтэй нь гэж үзэж байна.

Ном зүй

1. НҮБ-ын ерөнхий ассамблей 1946 оны 12 сарын 10-ны өдөр баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Манай улс 1961 онд НҮБ-д элссэн,
2. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он, Монгол Улс 1981 онд нэгдэн орсон,
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2009 онд нэгдсэн,
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, ЗГ-ын 2017 оны 321-р тогтоол,
5. Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Замын хөдөлгөөний дүрэм,
6. Боловсролын статистикийн эмхэтгэл 2017-2019 он,
7. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он,
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он,
9. Боловсролын тухай хууль, 2002 он,
10. Авто замын тухай хууль, 2017 он,
11. Барилгын хууль, 2016 он,
12. Зөрчлийн тухай хууль, 2017 он,
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он

БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАЛЦАГЧИЙН ОЮУНЫ ХӨГЖЛИЙГ ҮНЭЛЭХ ТАНАКА БИНЕ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Кенжи Номура 1, Д. Одгэрэл², Г.Энхжаргал², Г.Батжаргал² Д.Баяраа²

¹ Нагоя Их Сургууль,

² Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

“Хүүхдийн хөгжлийг дэмжих төв”

Хураангуй

Энэхүү нийтлэлд “Танака Бине оюун ухааны сорил V”-ын монгол хувилбар боловсруулах судалгааны ажлын зохион байгуулалт болон судалгааны боловсруулалт, агуулгын өөрчлөлт, шинэчлэлтийн талаар өгүүлсэн болно. Тэгш хамруулах боловсролын тогтолцоо хөгжсөн улс орнуудад боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг баталгаатай, найдвартай сорилоор үнэлж зохих боловсролын үйлчилгээнд хамруулдаг. Энэхүү сорил нь Япон улсын боловсрол, сэтгэл зүйн үнэлгээ-оношлогооны практикт хамгийн өргөн хэрэглэгддэг аргачлал бөгөөд энэхүү оюуны бүтээлийг нутагшуулах, ашиглах албан ёсны зөвшөөрөлтэйгээр МУБИС, Нагоя Их сургуулийн судлаачдын хамтарсан баг хэрэгжүүлж байна. “Танака Бине оюун ухааны сорил V”-ын даалгавруудад сорилын агуулга, зураг, хэрэглэгдэхүүнд өөрчлөлт оруулж, шинэчлэх ажлыг монгол хүүхдийн хөгжлийн онцлог, хот хөдөөгийн ялгаатай байдал, нийгэм-соёлын онцлог зэргийг харгалзан олон талаас нь задлан шинжилгээ хийж, сорилын гүйцэтгэлийн хувийг нас насны ангилалд гаргах, сорилын баталгаат чанар, найдварын зэргийг тогтоох, норм, стандартыг боловсруулан гаргах ажлын шатанд ороод байна. 2016 оноос хойш МУБИС, НИС-ийн хамтарсан судлаачдын баг нь энэхүү сорилыг нутагшуулахдаа монгол хүүхдийн онцлогийг харгалзахаас гадна зохиогч, Токио дах Танака Бине судлалын хүрээлэнгийн заавар, зөвлөгөөг удиртгал болгон ажиллаж байгаа бөгөөд энэ судалгааны ажлын үр дүнд албан ёсны зөвшөөрөл бүхий Монгол “Танака Бине оюун ухааны сорил V”-ын аргачлалтай болох юм.

Түлхүүр үг:

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүд, оюун ухааны сорил, нутагшуулах, гүйцэтгэлийн оноо, насны хөгжил

Удиртгал

МУБИС нь Япон улсын Нагоя их сургуультай гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх зорилго дэвшүүлэн монголын боловсролын шинэчлэл, өөрчлөлт, хөгжлийг дэмжихэд чиглэн ажиллаж байна. Эдгээр үйл ажиллагааны хүрээнд тус сургуулиудын судлаачдын хамтарсан баг монголын тусгай сургуулиудын практик үйл ажиллагаа, оношлогоо, судалгаа, ердийн ба тусгай сургуулийн багш нарын тусгай боловсролын талаарх ойлголт, дэмжлэг үзүүлж ажиллаж буй арга туршлагатай танилцан сурагчдын эрэлт хэрэгцээ, тулгамдсан асуудлыг илрүүлэх ажлын чиглэлийг гарган ажилласан юм.

Иймээс МУБИС, Нагоя их сургуулийн судлаачдын баг монголын тусгай сургуулиуд, багш нартай уулзалт, ярилцлагыг арав гаруй удаа зохион байгуулж, Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт 383 багшаас тусгай хэрэгцээт боловсролын талаарх ойлголт, тусгайлан дэмжих сурагчидтай ажиллаж буй арга зүйн талаарх тандах судалгааг (МУБИС, НИС-ийн төслийн баг, 2016) явуулж, дүн шинжилгээ хийхэд тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх багш нарын ойлголт дутмаг байгаагаас гадна, оношилгоо үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх шаардлагатай нь тогтоогдсон.

Энэхүү судалгаа болон бусад эх сурвалжийн судалгааны үр дүнд тулгуурлан (D.Odgerel, H.Maekawa, 2003) монгол хүүхдийн хөгжлийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохируулан хүүхдийн хөгжлийг үнэлэх, зарим арга, аргачлалыг нэвтрүүлэх шаардлага урган гарч байгаатай уялдуулан МУБИС-ийн Багшийн сургууль дээр “Хүүхдийн хөгжлийг дэмжих төв”-ийг Нагоя их сургуулийн Хүний хөгжил, сэтгэл зүйн төвийн дэмжлэгтэйгээр 2017 онд байгуулж тусгай хэрэгцээт боловсролын талаарх онол арга зүйн сургалт зохион байгуулах, оношилгоо, үнэлгээний үр дүнд эцэг эх, хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх,

сэтгэц сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгөхөөс гадна “Танака Бине оюун ухааны сорил V”-ын монгол хувилбарыг боловсруулах судалгааны ажлыг хоёр улсын судлаачдын хамтарсан багаар явуулж байна. Өнгөрсөн хугацаанд хэт хөдөлгөөнтэй, анхаарлын дутмагшил, аутизмын хам шинж, суралцахуйн бэрхшээл, оюун ухааны сорил, Танака Бине сорил гэсэн сэдвээр нийт 5 удаагийн семинар, сургалтыг багш, эмч, сэтгэл судлаач, нийгмийн ажилтан гэх мэт 200 гаруй хүнийг хамруулан зохион байгуулснаас гадна Япон, Монгол, Финлянд, Америкийн эрдэмтдийг хамруулан “Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, оношилгоо”, “Япон, Монгол хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал”, “Оюун ухааны бэрхшээл: судалгаа, бодлого ба хэрэгжилт” зэрэг сэдвээр эрдэм шинжилгээний хурлыг танхимийн болон онлайн хэлбэрээр зохион байгуулсан байна.

Судалгааны ажлын зохион байгуулалт

Монголын тусгай хэрэгцээт боловсролын салбарт юуны өмнө хүүхдийн хөгжлийн үнэлгээ, оношилгоо хийх цогц аргачлал дутмаг байна гэж үзэн “Танака Бине сорил-V”-ийг Монголын боловсролын салбарт нутагшуулах буюу монгол хувилбарыг боловсруулах судалгааны ажлыг хийх нь зүйтэй гэж үзсэн юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэхийн тулд “Танака Бине оюун ухааны сорил V монгол хувилбар”-ыг хамтарсан багаар боловсруулан Монголын боловсролын практик үйл ажиллагаанд оюун ухааны олон талт чадварын үнэлгээ оношилгооны нэгэн цогц арга зүй болгон хэрэглэхэд оршино.

“Танака Бине оюун ухааны сорил V”-ын монгол хувилбарыг боловсруулах судалгааны ажлыг бэлтгэл ажил, туршилт судалгаа, урьдчилсан судалгаа, үндсэн судалгаа гэсэн үе шатаар төлөвлөн зохион байгуулж байна.

А.Бине, Т. Симон нарын оюун ухааны сорил боловсруулсан онол үзэл баримтлал, зарчмыг үндэслэн Танака Бине оюун ухааны сорилыг 1947 онд Японд анх боловсруулсан. Энэ сорилыг өнөө хүртэл 5 удаа шинэчлэн боловсруулж, эрүүл мэнд, сэтгэл судлал, боловсрол, нийгмийн халамж зэрэг салбарт хамгийн түгээмэл, найдвартай аргачлал гэж үзэн өргөн хэрэглэж байна (Ж.Накамура нар, 2003).

Танака Бине оюун ухааны сорилын

зориулалт нь 1-16 насны ангилалын дагуу (± 3) даалгаврыг гүйцэтгүүлэн хүүхдийн оюун ухааны хөгжлийг оюун ухаан ба биологийн насаар тодорхойлж, сул ба давуу талыг нь илрүүлж, үүн дээр үндэслэн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхэд оршдог. Уг сорил нь хэрэглэгдэхүүний хувьд: сорил авагчийн гарын авлага, сорилын онолын гарын авлага, үнэлгээ оноожуулалтын гарын авлага гэсэн 3 үндсэн гарын авлагатайгаас гадна модон тоглоом, зурган карт, сорилын дэвтэр, тэмдэглэл хөтлөх маягт зэргээс бүрддэг.

Уг сорил нь даалгаврын гарчиг ижил боловч насны ангилалаас хамаарч агуулгын багтаамж, төвшингөөрөө ялгаатай багтаамжтай, тэнцэх шалгуур нь өөр өөр, хүүхдийн гүйцэтгэх хугацааг нь хэмжих хугацаа заасан даалгаврууд, нэмэлт асуулттай зэрэг 96 даалгавраас бүрддэг.

Хүснэгт 1. “Танака Бине оюун ухааны сорил V”-ын даалгавруудын хувиарилалт (насны ангилалаар)

Нас	1 нас	2 нас	3 нас	4 нас	5 нас	6 нас	7 нас	8 нас	9 нас	10 нас	11 нас	12 нас	13 нас	Нийт
Даалгаврын тоо	12	12	12	6	6	6	6	6	6	6	6	6	6	96

“Танака Бине оюун ухааны сорил V”-ын монгол хувилбарыг боловсруулах ажлыг төлөвлөгөө хүснэгт 2-т үзүүлсэний дагуу гүйцэтгэж байна.

Хүснэгт 2. ТБ сорилын Монгол хувилбар боловсруулах судалгааны үйл ажиллагаа, төлөвлөлт:

№	Хугацаа	Үйл ажиллагаа
1	2016 он 7 сар	ТБ сорилын монгол хувилбарыг боловсруулах гэрээг НИС, МУБИС-ийн хамтын ажиллагааны хүрээнд / ТБ хүрээлэнгийн албан ёсны зөвшөөрөлтэй/ байгуулсан
2	2017 он 1-6 сар	1 сар: Сорилын орчуулагдсан даалгавруудыг хэлэлцэх 4 сар: Монгол хувилбарт хөрвүүлсэн сорилын даалгавар боловсруулсан 6 сар: Асуулгын тохироцыг шалгахын тулд 68 хүүхдээс туршилт судалгаа авах
3	2017 он 11 сар	Туршилтын судалгааны үр дүнгийн боловсруулалт Урьдчилсан судалгааг Улаанбаатар хот, Архангай аймгаас 320 хүүхдээс судалгаа авах /монгол хүүхдүүдийн өдөр тутмын амьдралд нийцэхүйц агуулга бүхий даалгаваруудыг туршиж тухайн насанд тохирсон эсэхийг дахин нягталж үзэх зорилготой/

4	2018 он	Урьдчилсан судалгааны үр дүнгийн боловсруулалт сорилын дүнг нэгтгэн, боловсруулалт хийх, хэрэглэгдэхүүний судалгаа хийж захиалах, үйлдвэрлүүлэх, гарын авлагаа дээр ажиллах, шинээр хэвлүүлэх. Сорил авагч, тэмдэглэл хөтлөгч нарт зориулсан сургалтын модуль боловсруулж, сургалт явуулах. УБ, Өмнөговь, Завхан, Хэнтий, Сэлэнгэ аймгуудаас 544 хүүхдээс, ЖАЙКА баг: УБ хот, Хөвсгөл аймгийн 256 хүүхдээс авав. Үндсэн судалгааг нийт 800 хүүхдээс авсан.
5	2019 он	ТБ сорилын “Оюуны өмчийг ашиглах зөвшөөрөл олгох” гэрээг байгуулах Датаг ангилах, өгөгдлийг шивж оруулах, кодлох, орчуулах, оноожуулах, боловсруулах ажлуудыг хийж байна (Давтан судалгаа авах, баталгаат чанарыг шалгах, стандарчилах) Сорилын гарын авлага, онолын гарын авлага, оноожуулах гарын авлага гаргах, хэрэглэгдэхүүнээ эцэслэх
6	2020 он	ТБ сорилын Монгол хувилбар, хэрэглэгдэхүүнийг ашиглах сургалт явуулах, түгээх

Судалгааны бэлтгэл ажил

Энэ үеийн судалгааны ажлын зорилго нь “Танака Бине-V”-оюун ухааны сорилын япон хувилбарыг монгол хэлнээ хөрвүүлэн агуулга, найруулга, нийгэм соёлын онцлог гэсэн үзүүлэлтийн дагуу өөрчлөлт хийж, эхний монгол хувилбарыг гаргах, дүн шинжилгээ хийх, судалгааны төлөвлөгөө, хамрах хүрээг тогтоох, онол арга зүйн семинар явуулах, МУБИС-ийн сорил авагч, тэмдэглэл хөтлөгчийг бэлтгэх, туршилт судалгааг явуулахад чиглэсэн болно.

Мөн сорилын орчуулга болох япон хэлнээс монгол хэл руу, монгол хэлнээс япон хэл рүү хөрвүүлсэн байдалд хамтарсан хэлэлцүүлэг, дүн шинжилгээ хийж ажилласан. Түүнчлэн ТБ хүрээлэнгийн зааварчилгааны дагуу япон хувилбар дах даалгаврын хэрэглэгдэхүүн, аргачлал, анхаарах зүйл, нэмэлт даалгавар, тэнцэх шалгуур болон зөв хариулт гэсэн бүтцийг баримталсан болно. Үүнээс гадна сорилыг үгэн ба үгэн бус ангилалд авч үзэн, хэл – соёл, найруулга болон нийгэм – соёлын онцлог гэсэн үзүүлэлтээр авч үзсэнийг даалгавруудад өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 3. Туршилт судалгаа авах сорилын даалгавруудад өөрчлөлт оруулсан байдал

Бүтэц Узүүлэлт	Үгэн				Үгэн бус			
	Хэл-соёл найруулга		Нийгэм соёл		Хэл-соёл найруулга		Нийгэм соёл	
	Найруулга	Хэлний онцлог	Соёлын онцлог	Сур/хөт харгалзсан	Найруулга	Хэлний онцлог	Соёлын онцлог	Сур/хөт Харгалзсан
Хэрэглэгдэхүүн	Q7, Q10, Q14, Q78	Q59, Q60, Q62, Q63, Q79, Q85	Q3, Q10, Q12, Q74, Q16, Q69, Q27, Q28, Q32, Q44, Q52, Q56, Q60, Q64, Q77, Q81, Q96, Q95, Q91	Q42, Q55	Q93	Q83, Q89, Q91, Q92	Q21, Q23, Q24, Q25, Q28, Q37	Q46, Q68, Q76, Q82
Аргачлал	Q74, Q6, Q11, Q30, Q64, Q70, Q33, Q36, Q53, Q58	Q31, Q39, Q79, Q85	Q27, Q28, Q32, Q64, Q35, Q44, Q49, Q60, Q69, Q81, Q91, Q77	Q50, Q55	Q80, Q41, Q42, Q45, Q51, Q75, Q2, Q5, Q20, Q26, Q34, Q38, Q40	Q1, Q13, Q17, Q22, Q89, Q92	Q21, Q23, Q24, Q25, Q28, Q37, Q84	Q19, Q46, Q60, Q76
Анхаарах зүйл	Q11, Q32		Q6, Q12, Q56		Q13, Q45, Q56			
Нэмэлт даалгавар		Q73, Q79, Q85	Q9, Q12, Q14, Q35, Q52, Q64, Q69			Q83, Q89	Q82, Q8	Q82
Тэнцэх шалгуур		Q59, Q60, Q62, Q73, Q79, Q85	Q10, Q12, Q14, Q27, Q28, Q35, Q44, Q49, Q52, Q56, Q60, Q64, Q69, Q77	Q42, Q55		Q89, Q92	Q21, Q23, Q24, Q25, Q37, Q82, Q84	Q46, Q68, Q82
Зөв хариулт			Q44, Q49, Q52, Q74, Q77					Q68
Нийт	16	19	60	6	17	14	22	13

Хүснэгт 3-с харахад сорилын 19.7%-д найруулга, 19.7%-д нь хэлний онцлог, 49.1%-д соёлын ялгаатай байдал, 11.3%-д сургуулийн өмнөх, бага болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, стандартын үндэс, хэрэгжилт зэргийг харгалзан шинэчлэн боловсруулсан байна. Боловсруулалтад ихээхэн анхаарсан үзүүлэлт болох соёлын онцлог, ялгаатай байдлыг (49.1%) харгалзсан шалтгаан нь монгол хүүхдийн ахуй амьдрал, соёл, хүрээлэн байгаа орчин, хөгжлийн онцлог, төвшинг үнэлэхэд чиглэсэн аргачлал боловсруулах судалгааны зорилготой холбоотой.

График 1. Туршилт судалгааны даалгаварт өөрчлөлт оруулсан байдал




График 1-ээс харахад сургалтын хөтөлбөртэй хамааруулж даалгавруудад өөрчлөлт оруулсан байдал нь бага хувьтай байсан. Үгэн бус даалгаврын өөрчлөлт (68.4%) үгэн даалгаврынхаас (31.6%) их байгаа нь өдөр тутмын ахуй амьдралын хэрэглээ, хүрээлэн байгаа орчин, дүр дүрслэл зэргийг илэрхийлэх зорилго бүхий даалгавар байсантай холбоотой. Харин соёлын онцлогоос хамаарсан өөрчлөлт бусад үзүүлэлтээс (49.1%) үнэмлэхүй их байгаа

нь сорилд орсон даалгавруудын утга санаа, агуулга нь хүүхдийн өссөн орчин, өдөр тутмын ахуй амьдрал, хэрэглээ соёл, зан заншил зэргийг тусгасантай холбоотой гэж үзэж байна.

Туршилт судалгаа

Судалгааны баримт, аргачлалыг монгол хэл рүү хөрвүүлэн боловсруулалт хийсний дараа гүйцэтгэлийн хувийг 1-16 насны ангилалаар даалгавар тус бүрээр тэнцэх шалгуур гаргаж 2017 оны 6-р сард УБ хотын цэцэрлэг, ЕБС-ийн нийт 68 хүүхдийг хамруулан авсан. Сорилыг авахдаа хүүхдийн биологийн насыг ± 3 -аар тооцоолон даалгаврыг гүйцэтгүүлж, даалгавар тус бүрийн гүйцэтгэл, хүүхдийн сорил өгч байх хугацаанд үзүүлсэн хариу үйлдэл, зан үйлийн илрэл зэргийг тэмдэглэл хийсэн.

Сорилын дүнгээс үзэхэд оноожуулах аргачлалд заасан 50-60 онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 23 даалгавар, 60-с дээш онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 33 даалгавар, 50-с доош онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 31 даалгавар байсан. Нийт даалгавруудаас 79 (үгэн), 80 (үгэн бус), 85 (үгэн) дугаар даалгаврын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд зөв шалгуурт нийцэхгүй байсан нь шалгуурыг эргэж харах, дахин боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Дээр дурьдсан үзүүлэлтийн дагуу монгол дах судалгааны баг япон дах судалгааны багууд тусдаа болон хамтарсан онлайн хэлэлцүүлэг, сургалтыг нийт 20 гаруй удаа зохион байгуулж, сорилын үр дүнг хэлэлцсэн. Хэлэлцүүлгийн үр дүнд сорилын хувилбарт өөрчлөлт оруулсан байдлыг Хүснэгт 4-д харуулсан болно.

Хүснэгт 4. Туршилт судалгааны дараа сорилын даалгавруудад өөрчлөлт оруулсан байдал

Бүтэц / Үзүүлэлт	Үгэн				Үгэн бус			
	Хэл- соёл найруулга		Нийгэм соёл		Хэл- соёл найруулга		Нийгэм соёл	
	Найруулга	Хэлний онцлог	Соёлын онцлог	Сур/ хөт Харгалзсан	Найруулга	Хэлний онцлог	Соёлын онцлог	Сур/ хөт харгалзсан
Хэрэглэг дэхүүн	Q61, Q77	Q55	Q44, Q46, Q67, Q85	Q42, Q61, Q74, Q96	Q1	Q33, Q35	Q6, Q9, Q10, Q23, Q25, Q29, Q30	Q32, Q66
Аргачлал	Q27, Q31, Q52, Q77	Q52, Q67,	Q52	Q40, Q50, Q57, Q58, Q60, Q64	Q6, Q34, Q36		Q9, Q17, Q23	Q26
Анхаарах зүйл	Q50,	Q65		Q64			Q35	
Нэмэлт даалгавар		Q3	Q4	Q60	Q25			
Тэнцэх шалгуур				Q63				Q30
Зөв хариулт			Q44	Q76, Q82				
Нийт	7	5	7	15	4	2	10	3

Хүснэгт 4-с үзэхэд өөрчлөлт оруулсан нийт 53 даалгавраас 34 буюу 64,1%-ийг үгэн даалгавар, 19 буюу 35.9%-ийг үгэн бус даалгавар эзэлж байгаа бөгөөд үгсийн ижил ба ялгаатай тал, утгыг тайлбарлах, эхийн утга санааг ойлгох, зураг нэрлэх, сэдэвт зургийн алдааг тайлбарлах зэрэг даалгавруудыг түлхүү өөрчилсөн нь харагдаж байна. Ийнхүү хамтарсан судалгааны баг сорил авагчийн гарын авлага, сорилын дэвтэр, судалгааны ажилд шаардлагатай материалуудыг шинэчлэн хэвлүүлж, урьдчилсан судалгааны бэлтгэл ажлаа ханган ажилласанаас гадна туршилт судалгааны эцэст “Танака Бине оюун ухааны сорил-V” эхний монгол хувилбар боловсруулж, судалгаа авснаас гадна монгол судлаачдын оюун ухааны сорилын талаарх онол, арга зүйн мэдлэг, туршлагад үнэтэй хувь, нэмэр оруулсан гэж үзэж байна.

Урьдчилсан судалгаа:

Энэхүү шатны судалгааны зорилго нь туршилт судалгааны үр дүнд дахин шинэчлэн боловсруулсан монгол хувилбараар УБ хот болон хөдөө орон нутгийн нийт 320 хүүхдээс сорил авч, тэдгээрийн гүйцэтгэлийн хувийг болон онцлогийг илрүүлэн гаргах, даалгаваруудын сонголт ба тохиромжтой насны ангилалыг тогтоох ажлыг гүйцэтгэж үндсэн судалгааны монгол хувилбар боловсруулахад чиглэгдэнэ.

Судалгаа авах сорил авагч, тэмдэглэл хөтөлгөч нарыг бэлтгэх сургалтыг япон монголын хамтарсан судалгааны баг 2017 оны 10 сард 70 гаруй хүнийг хамруулан МУБИС дээр зохион байгуулав. Судалгааг 2017 оны 10, 11 саруудад УБ хотын Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн болон Архангай аймгийн Их тамир, Батцэнгэл, Цэнхэр сумдуудын цэцэрлэг, ЕБС-ийн нийт 320 хүүхдийг хамруулан авсан. Судалгааны материалыг япон хэлэнд

хөрвүүлэн боловсруулалт хийж, хамтарсан багууд онлайн хэлэлцүүлэг хийж, үр дүнг 10 гаруй удаа хэлэлцсэн. Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, дүгнэлтийг Токио дах Танака-Бинегийн судалгааны хүрээлэнд танилцуулан зөвлөгөө авч, сорилын боловсруулалт, гүйцэтгэлийн үр дүнд шинжилгээ хийж ажилласан.

Урьдчилсан судалгааны гүйцэтгэлийн хувийг даалгавар нэг бүрээр, япон-монгол тэнцэх шалгуураар, 1-13 насны ангилалаар, хот ба хөдөөгийн онцлог, ялгаатай байдлаар тэдгээрийн дундаж үзүүлэлт, гүйцэтгэлийн хувийг гаргасан. Судалгааны гүйцэтгэлийн хувиас харахад, үнэлгээ оноожуулалтын зааврын дагуу 50-60 онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 22 сорил, 60-с дээш онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 43 сорил, 50 -с доош онооны гүйцэтгэлийн хувьд тэнцсэн 28 сорил байна. Энэ нь монгол хүүхдийн ахуй амьдрал, соёл, сургалтын хөтөлбөрийн ялгаатай байдлаас гадна тэмдэглэл хөтөлгөч, сорил авагч нарын даалгаврын гүйцэтгэлд субъектив хандлага нөлөөлсөн байж болзошгүй гэж үзэж байна. Үүнээс гадна Токио дах Танака Бинегийн хүрээлэнгээс өгсөн “япон хувилбарын даалгаврыг чухалчлах”, “нэмэлт асуулттай даалгаврын хувьд нэмсэн асуултуудын төрлүүдийг чухалчлах”, “зарим даалгавруудын хувьд сэтгэхүйн аль нэгэн чадвар шалгахаасаа шалтгаалан өөрчлөлт оруулж болно” зэрэг зөвлөмжүүдийг баримтлан урьдчилсан судалгааны 53 даалгаварын 20% -ийг найруулга, 16,3%-ийг хэлний онцлог байдал, 30,9%-ийг нь соёлын онцлог, ялгаатай байдал, 32,7% -ийг сургуулийн өмнөх, бага болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, стандартын үндэс, хэрэгжилт зэргийг тус тус харгалзан өөрчилсөн болно.

Энэхүү урьдчилсан судалгааны дах сорилын даалгавруудад өөрчлөлт оруулсан шалтгаан тэдгээрийн тоог хүснэгт 5-аар үзүүлбэл:


Хүснэгт 5. Урьдчилсан судалгаан дахь сорилын даалгавруудад өөрчлөлт оруулсан шалтгаан

Даалгаврын дугаар	Нэмэлт асуултын талаар		Өөрчлөлт оруулсан шалтгаан						Нийт
	Нэмэлт асуулттай	Нэмэлт даалгавруудад нэмсэн асуулттай	Хүүхдийн өдөр тутмын ахуй амьдрал, нийгэм соёлын онцлог, ялгаатай байдлыг харгалзсан			Монгол болон япон хэлний онцлог, ялгааг харгалзсан			
	Нэмэлт асуулттай	Нэмэлт даалгавруудад нэмсэн асуулттай	Хэрэглэгдэхүүн болон асуулт өөрчилсөн	Зураг болон асуулт өөрчилсөн	Үг өөрчилсөн	Сургалтын хөтөлбөр харгалзсан	Монгол хэлэн бэх хүндрэлийн түвшинг хянах зорилгоор	Монгол хэлний онцлогт тохируулан	
Урьдчилсан судалгаанд өөрчлөлт оруулсан даалгаврын тоо	15	1	1	10	25	9	6	4	71

Хүснэгт 5-с үзэхэд нийт өөрчлөлтийн 63,3%-ийг хүүхдийн өдөр тутмын амьдрал ахуй, нийгэм соёлын онцлогийг харгалзан, 14%-ийг япон, монгол хэлний онцлог, ялгааг харгалзсан бол 22,5% нь нэмэлт асуулттай даалгаврууд эзэлж байна.

Туршилт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн даалгаврын гүйцэтгэлд суурилан урьдчилсан судалгааны даалгавруудад өөрчлөлт оруулахдаа япон хувилбарын даалгаврыг чухалчлах, нэмэлт асуулттай даалгаврын хувьд нэмсэн асуултын төрлүүдийг чухалчилсан. Тухайлбал, 1 насны Q10 “Эд юмсыг нэрлэх” даалгаварт “өргөст хэмх”-ийг нэрлэсэн гүйцэтгэлийн хувиас шалтгаалан зургийг хасаж, “цэцэг”, “ор”-ны зургийг оруулсан нь монгол хүүхдийн ахуй, нийгэм-соёлын ялгаатай байдлыг харгалзаж үзсэн нэг жишээ мөн. Эдгээрийг график № 2-оор үзүүлбэл:

График 2. Урьдчилсан судалгааны даалгаварт өөрчлөлт оруулсан байдал



Түүнчлэн урьдчилсан судалгааны явцад зарим математик-логик сэтгэлгээний даалгаврууд боловсруулалтын хувьд тоо тооллын энгийн үйлдэл хийх, тооцоолох чадвар шалгах даалгаврууд байсан бөгөөд эдгээр даалгавруудыг дахин хэлэлцэж, монгол хүүхдийн өдөр тутмын амьдралд математикийн мэдлэгээ хэрхэн зөв зохистой хэрэглэж буйг илрүүлэхэд чиглэсэн байдлаар өөрчлөлт оруулсан.

Логик сэтгэлгэлээ, зүй тогтолыг илрүүлэх 9-16 насны хүүхдийн гүйцэтгэх даалгавар буюу япон хэл, дүрс үсгийн онцлогт суурилан боловсрогдсон тухайн үндэсний онцлог бүхий даалгаврыг монгол хэл, цагаан толгойн үсэг, үсгийн дараалал, үеэс үг бүтээх үйлдэл бүхий даалгавраар боловсруулан урьдчилсан судалгааны үр дүнгийн боловсруулалтаас харахад даалгаврын гүйцэтгэл насны ангилалын тохирцоос шалтгаалан өөрчлөлт оруулсан болно. Туршилт судалгаа болон урьдчилсан судалгаанд хийсэн өөрчлөлтийг харьцуулан авч үзвэл:

График 3. Туршилт болон урьдчилсан судалгааны даалгаварт өөрчлөлт оруулсан байдлын харьцуулалт




График 3-т туршилт болон урьдчилсан судалгааны дараа сорилын даалгаварт өөрчлөлт оруулсан байдлыг харуулсан ба үзүүлэлт тус бүрийн хувьд буурсан байгаа нь монгол хувилбарын тохироц байдал өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Мөн судалгааны явцад хүүхдийн үзүүлж буй хариу үйлдэлд дүн шинжилгээ хийхэд хүүхдийн богино хугацааны ой тогтоолт, хэл ярианы чадвар буюу танин мэдэхүйн процесс түүнчлэн хийсвэр сэтгэхүй, төсөөлөн бодох, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг сэтгэхүйн үйл шаардсан даалгавруудын гүйцэтгэлийн үр дүн хэт өндөр, хэт доогуур байгаа байдал илэрсэн тул эдгээр даалгавруудын тэнцэх шалгуурыг өөрчлөн урьдчилсан судалгаанд туршсан болно. Эдгээр чадваруудаас гадна юмс үзэгдлийн мөн чанар, зүй тогтол, холбоо хамаарлыг олж тайлбарлах чадварыг хүүхдүүийн зурагт дүн шинжилгээ хийсэн байдлаас үнэлэх боломжтой байсан. Тэгэхдээ туршилт, урьдчилсан, үндсэн судалгааны явцад эдгээр зургийг боловсруулахдаа монгол үндэсний ахуй соёл, дүр дүрслэл, хот, орон нутгийн онцлог байдлыг харгалзсан болно.

Үүнээс гадна урьдчилсан судалгааны үр дүнд даалгавруудын асуултуудыг хооронд нь сольж үндсэн судалгаанд турших шаардлага гарч байсан бөгөөд энэ нь “Эсрэг утгатай үг” гэсэн ойлголтыг монгол хүүхдүүд ойлгож байгаа эсэхийг илрүүлэх зорилго бүхий даалгаврууд байсан. Эдгээр даалгавруудын хувьд нас ахих тусам үгийн утга санаа, агуулгын түвшин ахисан хэдий ч асуултуудыг хооронд нь сольж туршсанаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ахисан түвшний даалгавар гүйцэтгэх чадварт үнэлгээ хийх боломж гарч ирсэн бөгөөд үүгээр даалгаврын найдварын зэрэг, нийцэмжийг илрүүлэх боломж бий болсон.

Дүгнэлт

- Монгол улсад анх удаа албан ёсны зохиогчийн эрхтэй, зохиогчдын зөвлөмж, зааврын дагуу боловсрол, сэтгэл судлалын багш, сэтгэц мэдрэлийн эмч нараас бүрдсэн судалгааны баг оюун ухааны сорилын монгол хувилбарын боловсруулалтыг үе шат бүрт нарийвчлан төлөвлөж, хэрэгжүүлж байна.
- Сорилын даалгавруудыг монголын нийгэм, хэл соёлын онцлог, монгол хүүхдийн хөгжлийн онцлог, хот хөдөөгийн ялгаатай байдал зэргийг харгалзан өөрчилж, шинэчлэх ажлыг хийж байна.
- “Танака Бине оюун ухааны сорил V” монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийг тодорхойлох стандарт үзүүлэлтийг тооцоолон гаргахын тулд сэтгэл зүйн болоод боловсролын сорил боловсруулах онол, зарчим дээр тулгуурлан сорилын баталгаат чанар, найдварын зэрэг болон бусад статистик үзүүлэлтүүдийг тооцоолон гаргаж байна.
- Судалгааны үе шат бүрийн хэрэгжилт, үр дүнгийн боловсруулалт хийх явцад мөн сорил авагч, тэмдэглэл хөтлөгч нарыг бэлтгэх сургалтуудыг зохион байгуулах явцад монгол судлаачдын мэргэжлийн болон мэргэшлийн мэдлэг, ур чадвар нэмэгдсээр байна.
- Энэхүү судалгааны ажлын үр дүнд албан ёсны зөвшөөрөл бүхий Монгол “Танака Бине оюун ухааны сорил V”-ын аргачлалтай болох юм.

Ашигласан материал:

1. МУБИС, Нагоя ИС-ийн төслийн баг (2016) “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг дэмжих” төслийн тайлан, Улаанбаатар, Содпресс ХХК
2. Накамура, Оокава, Нохара, Серизава (2003) Танака Бинэ оюун ухааны сорилын онолын гарын авлага, Токио, Таакен хэвлэлийн компани
3. Odgerel, D. and Maekawa, H. (2003) A study on assessment of mental abilities of special school children in Mongolia with Raven's Colored Progressive Matrices. Bulletin of Disability Science. Japan: University of Tsukuba. Institute of Disability Science.
4. 石倉健二、他(2015)「モンゴルの特別支援教育に関する状況報告」兵庫教育大学研究紀要、47、pp.19-25

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

М.Мөнхзул¹ Ц.Цэцэнбаатар¹

¹“Транс континентал” ХХК-ийн хуулийн мэргэжилтэн

Түлхүүр үг:

Боловсрол, Хөгжил, Багш, Сургууль

Хураангуй

Хүн бүр л аз жаргалтай, сайн сайхан амьдралыг хүсдэг боловч энэ нь амьдрал дунд бий болсон олдмол болон төрөлхийн байдлаас болж хязгаарлагдах тохиодол байдаг. Энэ бол хөгжлийн бэрхшээл хэмээх нэр томъёонд хамаарагдах иргэд.

Хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгох ёстой вэ?

Энэ нь хувь хүндээ биш, нийгэмдээ гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт манай улсад нийтлэг болоогүй байгаа нь нийгэмд уг иргэдийг сул дорой, өвчтөн, нийгмийн халамж л хүртэж амьдардаг гэсэн ойлголт давамгайлж, тэдний оролцоо бодит байдал дээр хангагдаж чадахгүй байсаар байна. Иймээс Монгол Улсын иргэн бүр эрх тэгш байж, эрхээ эдэлж, нийгэмд оролцох оролцоо нь хангагдаасай гэж хүсч, нийгэм дэх “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэх ойлголтыг өөрчилж, энэ салбарт хувь нэмрээ оруулах алхам болно хэмээн итгэж энэхүү илтгэлээ бичлээ. Үндэсний статистикийн хороо, бусад байгууллагаас гаргасан судалгаа, тоон баримтанд үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх зүйлсийг гаргаж, арга замыг тодорхойлон дүн шинжилгээ хийсэн болно. Хүн бүр адил, тэгш эрхтэй гэдгийг Монгол улсын Үндсэн хуулинд тусгасан байдаг. Үүнийг бусад салбарын хууль тогтоомжууд мөн адил гол зарчмаа болгох ёстой. Хууль гэгч нь эрхээ эдлэх, үүргээ хэрэгжүүлэх, нийгмийг сайн сайхан байдлыг хангах боломжийг олгодог тул энэ зарчим маш чухал.

Нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж авдаг тогтолцооноос илүүтэй тэдний хөгжлийн асуудал яригдах ёстой. Хөгжлийн асуудал яригдах ёстой бол боловсролын асуудал нэн тэргүүнд.

Энэ салбарын хөгжилд хүн бүрийн оролцоо, хамтын ажиллагаа маш чухал юм. Ялангуяа

нийгмийн сөрөг ойлголтыг өөрчлөхөд хамтын ажиллагаа шаардлагатай байна. Өнөөдөр бид өөрсдийн үнэ цэнээ мэддэг, зорилготой, тэмүүлэлтэй, үүнийхээ төлөө амьдарч чадах чадвартай иргэнийг бэлдэж чадаж байна уу? Дээрх судалгаа, нөхцөл байдлаас харахад эсрэгээр нь...

Иймээс энэ салбарын хөгжлийн төлөө **Хамтдаа өөрчлөө.**

Оршил

Хүн бүр л аз жаргалтай, сайн сайхан амьдралыг хүсдэг боловч энэ нь амьдрал дунд бий болсон олдмол болон төрөлхийн байдлаас болж хязгаарлагдах тохиодол байдаг. Энэ бол хөгжлийн бэрхшээл хэмээх нэр томъёонд хамаарагдах иргэд. Үндэсний статистикийн хорооноос 2018 онд гаргасан тоон судалгаагаар Монгол улсын хэмжээнд 105,730 иргэн уг бүлэгт хамаарагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд “хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээн тунхагласан. Гэвч энэ нь бодит байдалтай хэр нийцдэг бол гэсэн бодол өөрийн эрхгүй төрнө.

Хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгох ёстой вэ?

Энэ нь хувь хүндээ биш, нийгэмдээ гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” -ын ойлголт манай улсад нийтлэг болоогүй байгаа нь нийгэмд уг иргэдийг сул дорой, өвчтөн, нийгмийн халамж л хүртэж амьдардаг гэсэн ойлголт давамгайлж, тэдний оролцоо бодит байдал дээр хангагдаж чадахгүй байсаар байна.

Иймээс Монгол Улсын иргэн бүр эрх тэгш байж, эрхээ эдэлж, нийгэмд оролцох оролцоо нь хангагдаасай гэж хүсч, нийгэм дэх “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэх ойлголтыг өөрчилж, энэ салбарт хувь нэмрээ оруулах алхам болно хэмээн итгэж энэхүү илтгэлээ бичлээ.

Судалгааны зорилго: Нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй гэх иргэдийн нийгмийн хамгаалал, түүний тулгамдсан асуудлыг судлан, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Зорилт: Зорилгод хүрэхийн тулд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэрэгжилтийн талаар
- Тэдгээрийн тулгамдсан асуудлыг тодорхойлон дүгнэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал юм.

Жич: Хөгжлийн бэрхшээл бол бэрхшээл биш, нийгмийнх гэж үздэг боловч нийгэмд уг нэр томъёо хэрэглэгдэж хэвшсэн тул энэ нэр томъёог ашиглахад хүрсэн болно./цаашид “ХБИ” гэх/

Үндсэн хэсэг

Энэхүү илтгэлд аливаа онолын суурь ойлголт, нийгмийн институтын тайлбар, хууль, эрх зүйн орчинд тусгагдсан байдал зэргийг нэг бүрчлэн тайлбарлах нь шаардлагагүй хэмээн үзсэн бөгөөд гагцхүү судалгааны зорилгын хүрээнд дараах нэр томъёог тайлбарлах нь зүйтэй.

Хөгжлийн бэрхшээл

Энэхүү нэр томъёоны тайлбарыг тодруулан авч үзвэл “...махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна” гэж заасан байх бөгөөд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор “хөгжлийн бэрхшээлтэй” гэж тодорхойлогдсон хүнийг албан ёсны статистикийн мэдээлэлд хамруулдаг.

2017 оны Үндэсний статистикийн хорооны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 42.8% нь төрөлхийн, **57.1% нь олдмол** байгаагаас үзэхэд олдмол байдлаар уг бүлэгт хамаарагдах эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны нэг нь **осол болж байгаатай холбоотой** байна.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл:

- Хөдөлгөөний 19.9%
- Ярианы 4%
- Харааны 10.6%
- Сонсголын 8.2%

- Сэтгэцийн 19%
- Хавсарсан 7.5%
- Бусад 30.4%

Эдгээр иргэдэд төрийн зүгээс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхээс нь үл хамааран **нийгмийн хамгаалалд** тодорхой үндэслэл, зохицуулалтын дагуу бүх нийтийг хамруулах зарчимтайгаар ажилладаг. Өөрөөр хэлбэл: Энэ нь эрсдлээс өөрийгөө хамгаалах чадвар бүхий болон бусдын туслалцаа шаардлагатай байгаа иргэдэд үзүүлж байгаа эдийн /тэтгэвэр, тэтгэмж олгох / болон сэтгэл санааны тусламж, дэмжлэг үзүүлэх, асран халамжлах, туслалцаа авах нөхцөлийг бүрдүүлдэг юм.

Ялангуяа хүн хөгшрөх, хүүхэд төрөх зэрэгт тэдгээрийг асрамжлан хамгаалах, ажиллаж, амьдрах чадварыг нь сэргээх, халамжлах нь аль ч төрийн хэрэгжүүлэх үүргийн нэг бөгөөд энэ нь нийгмийн хамгааллын хүрээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан болон асрамж тэтгэмж шаардлагатай тохиолдолд үзүүлэх туслалцаа төдийгөөр хязгаарлаж болохгүй юм. **Харин ч тэдний хөгжлийн асуудал илүү яригдах ёстой.**

Хөгжлийн асуудал...

Хүн гэгч байгалиасаа аливаа зүйл рүү хүсэн тэмүүлж, өсөн хөгжиж байхаар бүтээгдсэн байдаг бөгөөд дээрх бэрхшээлээс болж энэ байдал нь үгүй болох боломжгүй, харин ч бидний оюун ухаан, бие махбодь, сэтгэл зүй ямагт энэ зүйлийг шаардаж байдаг. Гэвч бодит байдалд ХБИ-ийн хэд нь хүслийнхээ дагуу амьдарч чадаж байна вэ?

Хүний эрхийн төлөөх хөдөлгөөнийг дагалдан хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар үүсэн бий болсон. ХБИ эх орныхоо нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцоход нийгэм өөрөө бэрхшээлийг учруулж байна. Өөрөөр хэлбэл, нийгэм өөрөө бэрхшээл болж байна гэсэн үг. Эдгээр саадыг арилгах үүрэг нь нийгэмд байгаа ба үүнийг арилгах үйл явцад ХБИ гол үүргийг гүйцэтгэх ёстой.

Гэтэл ХБИ-ийн талаарх сөрөг ойлголт нийгэмд байгаагийн улмаас тэднийг ялгаварлан гадуурхах асуудлууд өдөр тутам гарсаар байгаа нь тэдний хөгжих эрх, нийгэмд оролцох оролцоо хангагдаж чадахгүйд хүрч байна. Үнэхээр бодит байдал дээр тэдний хөгжих эрх хангагдаж чадахгүй байна гэж үү?

Оролцоо гэдэг нь агуулгын хувьд өргөн ойлголт ба ХБИ-Энгийн иргэдтэй нэг цаг хугацаанд нэг зүйлийг хийж, туршлага солилцох тухай юм. Учир нь оролцоо нь хүний амьдралын зайлшгүй нэг хэсэг. ХБИ, энгийн иргэд хамтарч аливаа зүйлийг хамтарч хийхдээ аль аль талын оролцоог бүрэн хангаж байдаг.

Иймд тэтгэмж авдаг нийгмийн хамгааллын тогтолцооноос илүүтэй тэдний хөгжлийн асуудлыг ярих ёстой учир тэдний боловсролын асуудлыг нэн тэргүүнд тавих ёстой.

Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Тэгвэл нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх хангагдаж чадаж байна уу?

Сургуулийн өмнөх боловсрол ба ерөнхий боловсрол

Сурч боловсрох эрх:

Үндэсний статистикийн хорооны 2017 оны албан ёсны тайланд хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 11 орчим хувийг /11.453/ 0-17 насны хүүхэд эзэлж байна. Үүнээс:

Үндэсний статистикийн хорооны тайлан, 2017 он

11.1%	харааны
7.4%	хэл ярианы
7.4%	сонсголын
17.4%	сэтгэцийн
22.4%	хөдөлгөөний
23.6%	хавсарсан бэрхшээлтэй

Комиссын тайлангаас үзвэл 2017 оны байдлаар аймаг, дүүргийн салбар комиссууд нийт 3949 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг, 3487 хүүхэд байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлж, 239 хүүхдийг СӨБ-д, 314 хүүхдийг ЕБС-д, 11 хүүхдийг боловсролын бусад үйлчилгээнд холбон зуучилж, хамруулсан байна.

Мөн одоогоор нийслэлд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай 6 сургууль байгаагийн 4 /25, 55, 63, 70/ нь оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хэрэгцээт боловсролын дагуу боловсрол эзэмшүүлж байгаа хэдий ч мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй байна.

2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг харвал хөгжлийн бэрхшээлтэй 1597 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ЕБС-д суралцаж байгаагаас 1637 хүүхэд Ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байгааг дурдсан байна.

2017 оны тоон үзүүлэлтийг харвал улсын хэмжээнд 11 мянга гаруй хүүхэд байгаагаас цэцэрлэг, сургуульд хамрагдаж байгаа хүүхдүүдийг тоог хасвал 7 мянга гаруй хүүхэд цэцэрлэг, сургуульд хамрагдаж чадалгүй, гадна орхигдсон гэсэн үг юм. **/СӨБ болон ЕБС хамрагдагсдын тоо 2019 оны 3 сарын байдлаар 25% нь л бүх шатны боловсролд хамрагдаж байгаа гэх тоо баримт бий./**

Жишээлбэл, Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 1,087 хүүхэд сургуулийн өмнөх насны боловсролд хамрагдсан үзүүлэлттэй байгаа нь 2017 оныхтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Мөн Ерөнхий боловсролын сургуульд боловсрол эзэмшиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцаж байгаа байдлаас авч үзвэл 10 хүүхэд тутмын 6-7 нь ЕБС-д элсэн орж, 4-р анги хүртээ сурч байгаад дунд ангид ороход тэдний 1-2 нь, ахлах ангид 1-2 нь сургуулиас завсардсанаар тэд бага, суурь цаашлаад бүрэн дунд боловсролыг эзэмшиж чадахгүйд хүрч байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн 2019 оны эхний 6 сарын байдлаар гаргасан 2015-2018 онд ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоог авч үзвэл дээрх тоон баримт үндэслэлтэй буюу жил ирэх тусам энэ тоо буурсан үзүүлэлттэй байна.

№	Аймаг	2015	2016	2017	2018
1	Улсын дүн	9143	8362	7279	6518

Ийнхүү буурч байгаа нь эдгээр хүүхдүүд нас ахих тутам сургуульд суралцах нь багасч байгаа нь ичиж зовох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцохоос айж эмээх гэх мэт шалтгаантай холбоотой. Өөрөөр хэлбэл, нийгэм эдгээр иргэдэд ингэх бэрхшээлийг үүсгэж байна гэсэн үг юм.

Жишээ 1: 2017 оны 3 сард 29-р тусгай сургуульд багш нар сурагчдадаа бэлгийн дарамт үзүүлж, сургуулийн чанаргүй, багш нарын чадваргүй байдлаас болж эрх нь зөрчигдсөн ноцтой хэрэг гарсан.

Жишээ 2: 2019 оны 10 сарын 25-ны мэдээллээр 51 дүгээр сургууль 1 дүгээр ангийн аутизмтай хүүхдийг сургаж чадахгүй гэсэн

тохиолдол гарсан нь хүүхдийг ялгаварлан гадуурхаж, сурч боловсрох эрхийг нь зөрчсөн ноцтой үйлдэл юм. Гэтэл энэ хэргийг хаасан.

Ийм учраас Тусгай хэрэгцээт боловсролыг хүртээмжтэй, чанартай олгох, мөн цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах асуудал шийдвэрлэх зохистой чухал асуудлуудын нэг мөнөөс мөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг “ялгаварлан гадуурхаж, доромжилж, тохуурхсан бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүндэтгэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад 14 хоногоос доошгүй хугацаагаар хамруулна”, “хуулийг зөрчсөн буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хууль, зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” хэмээн заасан хэдий ч бодит байдалд хэрэгжихгүй байгаа учраас энэ салбар мартагдаж, доройтсоор байна. Үүнийг дагаад нийгмийн сөрөг хандлага байсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд сурах эрмэлзэл байвч төр, нийгмийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хэрэгжилт, саадгүй, чөлөөтэй зорчих гудамж, талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, сургалтын материаллаг орчин хангалтгүй байгаа явдал нь тэдний суралцах эрхийг хязгаарлаж, нийгэмд боловсролгүй, “үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцөлийг бүрдүүлсээр байна.

Эдгээр тоон баримтаас харахад СӨБ болон ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалтад анхаарч, тэдний оролцоог хангах нь чухал байгаа нь харагдаж байна.

Сургалтын орчин, чанар, хэрэглэгдэхүүн:

Жишээлбэл, Иракийн сургалтын хөтөлбөрийг илүү оролцоотой болгоход Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс туслалцаа үзүүлсэн бөгөөд тэр үед нийт элсэгчдэд анхан шатны боловсролтой байх ёстой гэсэн шаардлагыг хянаж үзсэн байна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр уг шаардлагыг хангаж чаддаггүй. Ийнхүү үүний оронд унших, бичих шаардлага нэмж оруулсан нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүн хамрагдах боломжийг нээж өгсөн байдаг.

Монгол улсын хувьд авч үзэхэд 2017 онд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бага ангийн 4 нэр төрлийн сурах бичгийг 175 сая

төгрөгийн санхүүжилтээр улсын төсвөөс хэвлэн түгээсэн байна.

- Бодит байдалд 2017 онд 29 дүгээр сургуульд болсон хэрэг явдлаас сөхвөл багш нарын заах арга барил хангалтгүй буюу дохионы хэл мэддэггүйн улмаас дунд, ахлах ангийн сурагчид нь бага ангийн сурах бичиг хэрэглэдэг талаарх нотлох баримт бий. Шалтгаан нь багш нарын чадвар чадамж муу, үүний хэрээр анги, насанд нь тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй тул өдийг хүртэл ийм нөхцөл байдалд хүрчээ.

Учир нь өнгөрсөн 30 жилийн турш боловсон хүчнийг бэлдэх, гадаад дотоодод мэргэжлийн чиглэлээр сурган хөгжүүлэх ажил хоцрогдсонтой холбоотой юм.

Багшлах боловсон хүчин:

Тусгай хэрэгцээт боловсролын тэр дундаа дефектологич буюу согог зүйч мэргэжлийн багш нарыг 1960-аад оны дунд үеэс 1990-ээд оны эхэн үе хүртэл гадаадад зохион байгуулалттайгаар бэлтгэж байсан. Тухайлбал, Унгарын Будапештын Эмнэлэг, сурганы дээд сургууль, мөн хуучнаар Оросын Ленинград, Москва, Эрхүүгийн багшийн дээд сургуулиудад хараа, сонсгол, хэл, яриа, оюун ухааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр 100 гаруй багш бэлтгэж, тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн багш, боловсон хүчнээр ханган ирсэн түүх бий. Гэвч өнөөдрийн байдлаар дээрх багш, сурган хүмүүжүүлэгч нарын дийлэнх нь тэтгэвэрт гарсан бөгөөд энэ салбарын хүний нөөцийн бодлого алдагдсан гэж хэлж болно.

2019 оны эхний 3 сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 11.000 гаруй залуучуудын 25% нь л бүх шатны боловсролд хамрагдаж, тусгай сургалттай 6 сургуульд 1531 хүүхэд, 2 тусгай цэцэрлэгт 172 хүүхэд суралцаж байна гэсэн тоо баримт байна. Үүнээс олон төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд 1 ангид сурч, 2 багш л хичээл зааж байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт.

Түүнчлэн тусгай сургуульд ажиллаж байгаа согог зүйч мэргэжлийн багш нарын мэргэжил, мэдлэгийг гадаад дотоодын сургуулиудад сургаж, хөгжүүлэх тогтолцоо бүрэн орхигдсоор ирсэн гэдгийг Ерөнхийлөгч Х.Баттулга онцлон тэмдэглэсэн байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлог байдлаас хамаарч,

тэд нарт тохирсон сургалтын арга барилаар хичээлийг заах, тухайн сургалтын байгууллагын орчныг хүртээмжтэй байдлаар бүрдүүлэх, ажиллах багш боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх асуудал чухал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2017 оны “Мэдээллийн лавлах”-д Хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуульд суралцагчийн сурах үйл явцын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг дурджээ. Үүнд:

- Үдийн хоолтой болсон талаар
- Сурах бичгийн шинэчлэл хийж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон талаар
- Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг дэмжих чиглэлээр
- Тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр
- Сургалтын орчинг сайжруулан дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг дурджээ.

Эдгээр хэрэгжүүлсэн арга хэмжээг харахад өөрчлөлт, ахиц гарсан харагдаж буй боловч уг хэрэгжүүлсэн арга хэмжээ үргэлжлэн явагдсаар байна уу? гэдэг асуудал.

Гадна харагдах өөрчлөлтөөс илүүтэйгээр эдгээр хүүхдүүдийн оюун ухаан, зүрх сэтгэлд нь өөрийн гэсэн үнэ цэнэ, итгэл, хүсэл эрмэлзлийг бий болгож чадах боловсролын тогтолцоо, нийгмийн оюун санааны өөрчлөлт шаардлагатай байна. Францын агуу жанжинг бага байхад эмээ нь “Францын агуу хүү минь сэрээрэй” гэж дууддаг байсан түүх шиг...

Төсөв

2018 оны Улсын нэгдсэн төсөвт Боловсролын салбарт, ялангуяа СӨБ болон ЕБС-д дараах байдлаар төсөвлөжээ.

Монгол улсын нэгдсэн төсөв, 2018 он

Боловсролын салбарт							
Сургуулийн өмнөх боловсрол			Ерөнхий боловсролын сургууль				
322.1 тэрбум төгрөг			651 тэрбум төгрөг				
Улсын цэцэрлэг	Хувийн цэцэрлэг	Хүүхэд харах үйлчилгээ	Улсын сургууль	Хувийн сургууль	Үдийн цай хөтөлбөр	Сурах бичиг	Дотуур байр
281	34.6	6.5	551.4	16.3	32.5	4.2	46.6

Мөн 2018 онд тусгай хэрэгцээт цэцэрлэгт хамрагдах 488 хүүхэд байгааг дурдсан. Дээрх баримтаас харахад тусгай хэрэгцээт цэцэрлэг, сургуульд хэдэн төгрөг төсөвлөдөг нь тодорхойгүй учраас дээрх заасан төсөвт хамааруулан санхүүжилт олгодог байх гэж таамаглаж байна.

Үүний дараа мөн дээд боловсрол эзэмших асуудлыг авч үзэх ёстой. 2017 оны 03 сард гарсан Ийгл телевизийн Чимээгүй хашхираан нэвтрүүлгээр 29-р сургуулийг төгссөн зарим төгсөгчид **дээд боловсрол эзэмшиж чадаагүй**, хөдөлмөр эрхлэхийг хүсдэг ч энгийн унших, бичих чадвар байхгүйн улмаас ажиллаж чаддаггүй тухайгаа хэлсэн байгаа. Шалтгаан нь СӨБ, ЕБС-ын олгож буй хичээлийн хөтөлбөр, орчин, багш нарын чадваргүй байдал зэрэг хангалтгүйн улмаас л хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20% нь л хөдөлмөр эрхэлж байгаа үр дүн байна.

Дүгнэлт

Хүн бүр адил, тэгш эрхтэй гэдгийг Монгол улсын Үндсэн хуулинд тусгасан байдаг. Үүнийг бусад салбарын хууль тогтоомжууд мөн адил гол зарчмаа болгох ёстой. Хууль гэгч нь эрхээ эдлэх, үүргээ хэрэгжүүлэх, нийгмийг сайн сайхан байдлыг хангах боломжийг олгодог тул энэ зарчим маш чухал.

Монгол улсад одоогоор хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголт нийтлэг болоогүйн улмаас тухайн иргэдийг сул дорой гэсэн ойлголт давамгайлж, бодит байдал дээр сурч боловсрох эрх хангагдаж чадахгүй байна.

Нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж авдаг тогтолцооноос илүүтэй тэдний хөгжлийн асуудал яригдах ёстой. Хөгжлийн асуудал яригдах ёстой бол боловсролын асуудал нэн тэргүүнд.

Уг салбарын талаарх дээрх зүйлсийг дүгнэн үзэхэд нэг удаагийн шинжтэй, одоогийн нөхцөл байдалд ямар байгаа талаар мэдэгдэх судалгаа байхгүй зэрэг асуудлууд байна. Гэхдээ ганцхан төрийн байгууллагад даатгаад орхиж болохгүй, эдгээр иргэдийн оролцоог хангахад хүн бүрийн оролцоо, хамтын ажиллагаа маш чухал юм. Ялангуяа нийгмийн сөрөг ойлголтыг өөрчлөхөд хамтын ажиллагаа шаардлагатай байна.

Нийгэмд хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн 20 хувийг эзэлж байгаагаас үзэхэд эл асуудал боловсролтой шууд холбоотой. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсролыг тэгш хүртээмжтэй, чанартай олгож, чадвартай иргэнийг бэлдэхгүй байгаа улмаас эдгээр иргэд нийгэмд сул дорой, идэвхгүй гэсэн ойлголт байсаар л байна.

Өнөөдөр бид өөрсдийн үнэ цэнээ мэддэг, зорилготой, тэмүүлэлтэй, үүнийхээ төлөө амьдарч чадах чадвартай иргэнийг бэлдэж чадаж байна уу? Дээрх судалгаа, нөхцөл байдлаас харахад эсрэгээр нь...

Асуудал байгаа бол шийдэл нь зайлшгүй байх хэрэгтэй. Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд юу хийх ёстой вэ? Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг дэмжсэн, тусгай хэрэгцээт боловсролыг олгох, боловсролд тэгш хамруулах зохицуулалтуудыг нарийн тусгасан бие даасан хуультай болох;

Учир нь энэ талаарх нарийн зохицуулалт байхгүйн улмаас энэ салбар өнгөрсөн 30 жилийн хугацаанд урсгалаараа явж ирсэн. Иймд нарийн зохицуулсан бие даасан хууль батлагдсанаар энэ салбарт онцгой анхаарал хандуулах шаардлагатайг ойлгуулж, салбарын талаас ч нийгмийн талаасаа ч үр дүн, өөрчлөлтийг авчрах чухал ач холбогдолтой.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэй энгийн сургуульд тэгш хамруулан сургах ажлыг идэвхжүүлэх;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмыг баталсан. Үүний хэрэгжилтийн явц ямар байгааг ойлгоё гэвэл аутизмтай хүүхдийг ялгаварлан гадуурхсан хэрэг үүнийг нотолно. Боловсролын байгууллага ямар ч нөхцөл байдалд хүүхдийн эрх ашгийг л хүндэлж хамгаалах ёстой. Иймээс уг асуудал сайдын гаргасан тушаал, журмаар зохицуулагдах энгийн нэг асуудал биш. Иймд дээр дурдсан бие даасан хууль байх шаардлагатай байгааг харж байна. Мэдээж хуулийн процессийг нь илүү нарийвчилсан журам байх нь асуудал биш. Жишээ нь: одоогийн байдлаар Нийслэлд 6 тусгай сургууль, зарим бүс нутаг болон

сургуулиудын хүчин чармайлтаар хэд хэдэн ЕБС-д нээгдсэн тусгай анги, албан бус сургалтууд л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших газар болж байна. Иймд энэ үйл ажиллагааг цаашид төрийн болон төрийн бус байгуулагууд, ЕБС-иудын оролцоотойгоор эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн зан төлөвшилд сайнаар нөлөөлөх үр дүнтэй арга юм.

3. Тусгай хэрэгцээт боловсролыг олгох, тэгш хамруулан сургах боловсон хүчнийг бэлтгэх, сургуулийн орчин, хэрэглэгдэхүүнээр хангах төсвийг нэмэгдүүлэх;

Дээрх жишээ баримтуудаас харахад чанартай боловсрол эзэмшиж, амьдарч чадахгүй байгаа хүүхдүүдийн төлөө энэ салбарын төсвийг нэмэгдүүлэх ёстой.

- Багш нарын чадварыг гадаад, дотоодод дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Энэ салбарт бэлтгэгдэж буй ирээдүйн боловсон хүчнийг чанартай, шат дараалалтай сайн бэлтгэх ;
- Төсвийн зарцуулалтыг үр дүнтэй, нарийн хуваарилан, олон нийтэд шилэн болгох, үүнийг хянах механизмыг Сангийн яам хариуцан тайлагнадаг байх;

4. Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн ойлголтыг өөрчлөх ажлыг эрчимжүүлэх, энэ талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан оролцуулж, санаа бодлыг нь сонсон, асуудлын гарцыг хамтдаа шийдвэрлэх байнгын /улирал тутам/ хэлэлцүүлэг, олон нийтийн ажлуудыг зохион байгуулдаг болох;

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчсөн хэргийг хаах биш, үнэн зөвөөр, шударгаар шийдвэрлэхийн тулд Прокурорын байгууллага хэргийг үнэн, зөв шийдвэрлэж байгаа эсэхэд хатуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Эдгээрээс гадна хийх олон зүйлс бий боловч нэн тэргүүнд чанартай, хүртээмжтэй, үр өгөөжтэй боловсролыг олгон үнэ цэнээ мэддэг, зорилго тэмүүлэлтэй иргэдийг бэлдэж чадвал энэ бэрхшээл гэгч нь бэрхшээл огт биш гэдгийг ойлгох цаг ирнэ.

Хөгжлийн төлөө хамтдаа өөрчлөө...

НОМ ЗҮЙ:

Хууль, конвенц:

1. Үндсэн хууль
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Ном, гарын авлага:

1. Ц.Давхарбаяр, Д.Эрдэнэчимэг Нийгмийн хамгааллын эрх зүйн гарын авлага, УБ 2013 он
2. Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн лавлах, УБ 2017 он
4. Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлага, Женев хот, 2013 он

Цахим нийтлэл:

1. <https://president.mn/7929/>
2. <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/news/general/151222.html>
3. <http://www.mlsp.gov.mn/uploads/news/files/ab2651e843027240b1d120d5ef7746df2ada1b57.pdf>
4. <https://www.youtube.com/watch?v=3uoRbLtlLrrk&feature=youtu.be&fbclid=IwAR07jXeJluaWcDpWHUuzojctYrcmUS-sEeBNXNUTJHoYz0QE77LJnqDjbQs>
5. http://network.mn/post/32345?fbclid=IwAR2Mc98XWIW8k_o-tlBJJ3422rijPAgvNKsJ9mNLfxPUq1yGPP0qY4SUiQg
6. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3300_014V1

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ СУРГУУЛИЙН ОРЧИНД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СУРГАЖ, ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Б.Аминдаваа¹

¹Төв Хүмүүн цогцолбор сургууль

Хураангуй:

Монгол Улсын хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулинд Монгол хүн бүрийн эн тэргүүний зорилго бол Хүүхдийн язгуур эрх ашгийг дээдлэх явдал гэж заасан байдаг. Хүүхдийн язгуур эрх гэдэг нь тэдний эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангахад оршдог. Иймээс бидний гол зорилго хүүхдийн хөгжил болоод байна. Хүүхдийг хөгжүүлэхийн тулд тэднийг тэгш эрхтэйгээр оролцуулж, аливаад хандах мэдрэмжийг нь хөгжүүлснээр эерэг бодлыг дэмжин улмаар хандлагад нь өөрчлөлт оруулах явдал. Ер нь хүүхэд бүр аливааг эерэгээр хүлээж авдаг хандлагатай болсон цагт харилцааны зөрчил үгүй болж “Зөв хүүхэд” өсөн хөгжих юм. Хандлага сэтгэлгээг өөрчлөх гэдэг нь тогтмол хэвшмэл сэтгэлгээг “чөлөөлөх” буюу ойлголт ухагдахууныг гүнзгийрүүлж өргөжүүлэхийн тулд сэтгэлгээний хэв шинждээ өөрчлөлт хийх, ингэснээр аливаа асуудалд шийдэл хайхдаа “харьцах – сонирхох- эргэлзэх- эргэцүүлэх-ухаарах- итгэл- үйлдэж хийх боломжоо ашиглах гэж үзсэн байдаг. Мөн аливаа хийж буй зүйлдээ эзэн болж үр дүнд хүрэхийн тулд өөрчлөлт, шинэчлэлт хийх ур чадвар нь өнөөгийн хүн төрөлхтөнийг хөгжил рүү чиглүүлсэн зан үйлийг ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төлөвшүүлэх нь хамгаас чухал байна.

Түлхүүр үг:

Хөгжил, хандах хандлага, оролцоо

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөв харилцаа хандлагатай болгон төлөвшүүлэх

Судалгааны зорилтууд:

- ✓ Ахлах ангийн сурагчдын хөгжилд хандлага хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох
- ✓ Ахлах ангийн сурагчдын судалгаанд дүн шинжилгээ хийх
- ✓ Төв аймгийн “Иргэний зөвлөл”-ийн судалгаанд дүн шинжилгээ хийж харьцуулсан байдал

Судалгааны арга зүй:

- ✓ Ярилцлагын арга
- ✓ Нээлттэй санал асуулга
- ✓ Мэдээллийн эх сурвалжаас ашиглах
- ✓ Анализ синтезийн арга
- ✓ Харьцуулан, жиших арга
- ✓ Түүврийн арга

Судлах зүйл:

1. Өсвөр насны хүүхдүүдийн хөгжил төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх
2. Ахлах ангийн сурагчдын хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг тогтоох

Судалгааны шинэлэг тал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зөв хандлага төлөвшүүлэх замаар ерөнхий боловсролын ердийн сургууль сургаж хөгжүүлэх боломжтойг олон нийтэд эерэг талаас нь таниулж байгаагаараа онцлог

Судлагдсан байдал:

Улсын сайн хүнээсээ, Хүний сайн хүүхдээсээ. Үнэхээр сайн улс болъё, амжилтанд хүрье, ирээдүйтэй орон болъё гэвэл хүүхдээ л зөв, сайн хүмүүжилтэй болгох хэрэгтэй. Хүний хөгжил гэдэг нь хүний сонголтуудыг өргөжүүлэх үйл явц гэж хамгийн энгийнээр тодорхойлж болно. ¹Хүүхдийн хөгжил гэдэг нь хүүхдийн бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хамааруулан ойлгож болно. Хүүхдийн хөгжлийн энэхүү үндсэн бүрэлдэхүүн хэсэгт бүгдэд хамаатай нийтлэг зүйл орших бөгөөд энэ нь тэдний сэтгэлийн хөдөлгөөн өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжил юм. Хүүхдийн хөгжил төлөвшил нь түүний төрөлх шинж, авьяас, сонирхол, сэтгэл зүй, арга зүй, үнэлгээ зэрэг олон хүчин зүйлийн харилцан хамаарлын цогц үр дүн гэдэг нь харагдаж байна. Хүүхэд хөгжихийн тулд аливаа нийгмийн асуудал, үйл ажиллагаанд оролцож байж хөгжих учиртай. Хүүхэд багачууд өөрийн хүмүүжил боловсрол, хөгжилд хамаатай аливаа асуудлыг

¹ Монгол улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам ., (2007).” Хөгжих цагийн боловсрол”, багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний эмхэтгэл, УБ.

шийдвэрлэхэд дуу хоолойгоо хүргэх санал бодлоо чөлөөтэй илэрхийлж шийдвэр гаргахад оролцох шаардлагатай мэдлэг мэдээллийг олж авах өөрийн болон найз нөхдийнхөө эрх ашгийг хамгаалах зорилгоор нэгдэн нягтарч зөвлөл, клуб холбоод үүсгэн байгуулах тэдгээрт нэгдэж орох эрхээ эдлэхийг хэлнэ.

Хүүхдийн аливаа хандлага нь өөрийн биеэр туулсан туршлага эсвэл ажигласны үндсэн дээр бий болдог. Хандлага үргэлж мэдрэмжээс эхтэй ба мэдрэмж даамжран бодол болж улмаар хандлага болон тогтоно. Иймээс бидэнд аливаа зүйлийн талаарх мэдрэмж маш ихээр нөлөөлдөг ба мэдрэмжиндээ итгэхээс илүү тунгааж бодон бодит дүгнэлт хийх шаардлагатай байдаг. Хандлага нь аливаа хүн тэдний зан үйл болон эд материаллаг зүйлсийн талаар хувь хүний өөрийн эерэг ба сөрөг үнэлэлт дүгнэлт юм. Сөрөг хандлагаас эрсдэлт зан үйлтэй хүүхэд бий болох нь их ажиглагддаг. Хүүхдийн зан үйлд сөргөөр нөлөөлж буй гол “буруутныг” олж, тодорхойлоогүйгээс болж нийгэмд хүүхдийн эрсдэлт зан үйлийн тоо нэмэгдсээр байна.

Сөрөг хандлага ба эрсдэлт зан үйлийн илрэх хэлбэр нь:

- Архи тамхи хэрэглэх
- Бусдын биед санаатай болон санаадгүйгээр хохирол учруулах
- Дарамтлуулах
- Бусдад уруу татагдсаны улмаас хулгай, дээрэм хийх
- Амиа хорлох гэж оролдлох гэх мэт сөрөг үйлдлээр илэрдэг.

Хүүхдүүдийн энэхүү сөрөг үйлдлүүд нь гэнэт төрж үйлдэл болдоггүйг анхаарах нь зүйтэй. Үүнээс сэргийлэхийн тулд өөрийн “БИ”-г таних нь чухал. Би гэж хэн болох, би юуны тулд хэний төлөө сурч, амьдарч байгаагаа ухаарах нь өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын нэн тэргүүний асуудал мөн. Ийм үзлийг хүүхдэд бий болгохын тулд дараах санамжийг хүргэж байна.


- ✓ Хүүхдийн өөртөө болон түүнд хамааралтай хүмүүст хандах хандлага, харилцааны ур чадварыг бэхжүүлэх
- ✓ Хүүхдийг эрсдэлт зан үйлээс сэргийлэх ба нийгэмшилд нь шаардлагатай бусад зан үйлийг сургах
- ✓ Хүүхдийн аливаа хандлага нь өөрийн биеэр туулсан туршлага эсвэл ажигласны үндсэн дээр бий болдог тул хандлагыг эерэгжүүлэхэд чиглэсэн дараах нөхцлүүдийг

бий болгох хэрэгтэй:

- ✓ Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс хийж чаддаг зүйлсийг нь сануулж байх. Ингэснээр ажил хөдөлмөрт болон өөрт хандах хандлага нь эерэгжинэ.
 - ✓ Багаар ажиллах чадварыг нь хөгжүүлэх үүднээс гэрийн ажлыг хамтарч хийх өөрийн хийж буй ажилдаа туслуулах найз нөхөдтэй нь хамтран сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах.
 - ✓ Хүүхэд бүрийг хичээлд идэвхитэй оролцуулах нөхцлийг хангах, урамшуулах, магтах гэх мэт сургалтын нээлттэй аргуудыг өргөн ашиглах.
 - ✓ Шийдвэр гаргалтанд хүүхдийн саналыг харгалзан үзэж байх өөрийнх нь саналыг сонсдог байх нь хүүхдийн олон талын ур чадварыг хөгжүүлж байдаг.
- Оросын сэтгэл судлаач И. В. Кулешована хандлага нь хүүхдийн нийгэмшилтэнд нөлөөлөх үндсэн зүйлийн нэг болдог гэж үзээд өсвөр насны хүүхдэд 7 хандлага төлөвшсөн байх ёстой гэжээ.
1. Өсвөр насны хүүхдийн гэр бүлдээ хандах хандлага - хүүхэд гэр бүлийн үнэ цэнийг хэрхэн ойлгож байгаа болон гэр бүлийн гишүүдийг хүндэлж хайрлах хандлага
 2. Өсвөр насны хүүхдийн эх орондоо хандах хандлага- газар нутаг, эх хэл, ёс заншил, үндэсний үзэл, уламжлалаа хүндлэх, дагах, хадгалах хандлага
 3. Өсвөр насны хүүхдийн ажил хөдөлмөрт хандах хандлага- Хүүхдийн бие болон сэтгэл зүйн онцлогт тохирсон хөдөлмөрийн үйл ажиллагаанд (гэрийн ажил, ном унших, даалгавараа хийх гэх мэт) хандах хандлага
 4. Өсвөр насны хүүхдийн боловсролд хандах хандлага- Ерөнхий мэдлэгийн хичээлийн ач холбогдолыг чухалчлах хандлага
 5. Өсвөр насны хүүхдийн хүнд хандах хандлага- хүнд байгаагаар нь хандах, хүний амьдралын утга учрыг танин, бусдад хүнлэг энэрэнгүй хандах.
 6. Өсвөр насны хүүхдийн хүүхдийн эв найрамдалд хандах хандлага- Хүч хэрэглэхээс зайлс хийх, бусадтай эвтэй байж хүндэтгэлтэй харилцах хандлага
 7. Өсвөр насны хүүхдийн өөрийн физиологи “Би”-д хандах хандлага- Хүний амьдралын утга учрыг таних, бусдад хүнлэг энэрэнгүй хандах.


СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

- Таныг хөгжихөд нөлөөлдөг хүчин зүйлээ нэрлэнэ үү? Түүвэр байдлаар



Хүүхдийн төлөвшил хөгжил хандлагад гэр бүлийн орчин, уур амьсгал ихээхэн нөлөөлдөг юм байна. Хүүхэд гэр бүлээсээ өөрийн гэсэн үнэ цэнийг мэдэрдэг ба эцэг эхдээ хэрэгтэй хүн гэсэн мэдрэмжийг өгөөд зогсохгүй шийдвэр гаргах арга барилд суралцаж байдаг.

- Өсвөр насны хүүхдүүдийн харилцаанд ямар өөрчлөлт гарч байна вэ?



Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс хийж чаддаг зүйлсийг нь сануулж байх.

- ✓ Хэтэрхий түргэн ууртай болох
- ✓ Эцэг эхийн үгийг сонсохгүй байх
- ✓ Бусдын анхаарлын төвд байх


Зарим үед хэтэрхий биет бус зүйлтэй харилцаж, мэдээллийг сөрөг хандлагаар хүлээн авч бусдад би л гэсэн үзлээр хандах хандлага ажиглагдсан.

- Гэр бүлдээ хандах хандлагад ямар өөрчлөлт гарч байна вэ?



Гэрийн ажлыг хамтарч хийх, өөрийн ажилд туслуулах, найз нөхөдтэй нь хамтран сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах. Ингэснээр эв найрамдалд хандах хандлага, хүнд эерэгээр хандах хандлагад суралцуулдаг.

- ✓ Хүүхдийн өсөлт хөгжлийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх
- ✓ Ойр дотно харилцаанд цаг гарга.
- Хичээлийн сонголтоо хэрхэн хийсэн бэ?



Бололвсролд хандах - Ажил хөдөлмөрт хандах хандлага төлөвшиж байдаг.Тиймээс ерөнхий мэдлэгийн хичээлийн ач холбогдлыг ойлгуулах. Хүүхдийн бие болон сэтгэл зүйн онцлогт тохирсон хөдөлмөрийн үйл ажиллагаанд оролцуулах. Цөм хөтөлбөрт нийцэн сурагч бүр өөрийн сонирхсон хичээлээ судалж байгаа нь ирээдүйн ажил хөдөлмөрт хандах хандлагад эерэг нөлөө үзүүлнэ.

Төв аймгийн ИТХ-ийн дэргэдэх Иргэний зөвлөлөөс авсан “ Хүүхдийн төлөвшил хүмүүжлийн төлөв байдлын тандалт судалгаанд дүн шинжилгээ хийсэн байдал

- Асуулга 1. Энэ жилд та өөрийн төлөвшил хүмүүжилд чиглэсэн ямар үйлчилгээ авч байна вэ?

Хичээл сургалтын үйл ажиллагаа-19, дугуйлан-16

Асуулга 2. Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ та нарт хэр зэрэг хүрч байна вэ?

- Хааяа 15

Асуулга 3. Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ авахад таньд хүндрэл учирдаг уу?

- Заримдаа 19

Асуулга 4. Хүүхдүүд та нар чөлөөт цагаа хэрхэн яаж өнгөрөөдөг вэ?

- Гэртээ, найз нөхөдтэйгөө, тоглоомын газар

- Асуулга 5. Таны сурч хүмүүжиж буй орчинд элдэв хүндрэл бэрхшээл тулгардаг уу?

- Үгүй

Асуулга 6. Ямар бэрхшээл хүндрэл тулгарч байна вэ?

- Үе тэнгийхэн харилцаа

Асуулга 7. Хэрвээ таньд дарамт шахалт тулгарч байсан бол ямар хэлбэрээр илэрч байсан бэ?

- Хувцас, хичээлийн хэрэгсэл солиж хэрэглэхийг шаардах

Асуулга 8. Дарамт шахалт илэрч байгаа хүрээ

- Ахлах ангийнхан

Асуулга 9. Дарамт шахалтаас болж таньд ямар хүндрэл бэрхшээл тулгардаг вэ?

- Сэтгэл санааны хохирол учирдаг.

Асуулга 10. Таньд тулгарч байгаа эдгээр асуудлыг таны амьдралын хүрээнийхнээс хэн илүү мэдэрдэг вэ?

- Найз нөхөд

Дээрх санал асуулгаас үзэхэд эцэг эхчүүдийн анхаарал, халамж тавьж буй хэлбэр нь материаллаг буюу мөнгөн дүнгээр хэмжигдэх болсон нь харагдаж байна. Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл зүйн болон дотно халуун дулаан харилцааг гэр бүл, найз нөхөд, сургуулийн орчин бүрдүүлэх нь чухал байна. Сурагчид хичээл, дугуйлангийн үйл ажиллагаанд л оролцож байгаа нь хөгжихөд нь хангалтгүй байна.

Санал зөвлөмж:

- ✓ Аливаа зүйлийг эерэгээр хүлээж авах
- ✓ Сайн сайхан зүйл бодож байх
- ✓ Бусдад байнга талархасан сэтгэгдлээ илэрхийлж байх
- ✓ Бусдын шүүмжлэлийг зөвөөр хүлээн авч өөрийгөө хөгжүүлдэг байх
- ✓ Би-г танин мэдэж хэрэгцээ, хүсэл, тэмүүлэл зорилгыг нь судлах /сэтгэл зүй /
- ✓ Биеэр үлгэрлэх, дууриалган үйлдүүлэх, дадлагажуулах, бие даалгах **МОНГОЛ УХААНААР** хөгжүүлэх

Дүгнэлт:

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага нь хөгжлийн бэрхшээл, ядуурал, хүйсийн ялгаа, яс үндэс, шашин шүтлэг зэргээс шалтгаалан нийгмийн үйлчилгээний гадна үлдэж болзошгүй хүүхдүүдийг бусад хүүхдийн адил чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалсан “Тэгш хамруулан сургах” тогтолцоонд чиглэж байна. Тэгш хамруулан сургах нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд хамруулахаад зогсох биш, тухайн сургууль нь хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нь нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай гэж үздэг боловч харилцаа хандлагад нь анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Хүүхдийн аливаа хандлага нь өөрийн биеэр туулсан туршлага эсвэл ажигласны үндсэн дээр бий болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхийн тулд тэднийг тэгш эрхтэйгээр оролцуулж, аливаад хандах мэдрэмжийг нь хөгжүүлснээр эерэг бодлыг дэмжин улмаар хандлагад нь өөрчлөлт оруулах явдал. Ер нь хүүхэд бүр аливааг эерэгээр хүлээж авдаг хандлагатай болсон цагт харилцааны зөрчил үгүй болж бид бүгдийн хүсээд байгаа “хөгжлийн бэрхшээлийг давуу боломж болгон хөгжүүлэх” боломж байна.

Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд:

Урам өгч, дэмжих

Идэвхжинэ

Оролцоо нэмэгдэнэ.

Ном зүй:

1. Эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга бэлтгэх, түгээх, ажлын нэгдсэн арга зүй, шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлал. УБ. 2018 он
2. Монгол улсын хүүхдийн эрхийн хууль УБ. 2016 он
3. Монгол улсын хүүхэд хамгааллын тухай хууль УБ. 2016 он
4. БШУЯ “2012-2016 Эрдэм боловсролтой монгол хүн” боловсролын, шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөр УБ. 2012 он
5. МУИС “Боловсрол судлал” УБ. 2011 он
6. Монгол улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам .” Хөгжих цагийн боловсрол”, багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний эмхэтгэл, УБ. 2007 он
7. Г.Шүрэнцэцэг “Иргэний оролцооны чадваруудыг хөгжүүлэх сургалтын аргууд” УБ. 2008 он

ХҮҮХДИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ СУРГАЛТАНД ХАРГАЛЗАХ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА- ҮР ДҮН

Ч.Наранцэцэг¹

¹СЦЯ-ийн 10 дугаар цогцолбор

Түлхүүр үг:

Тэгш хамруулах, Ялгаатай байдал, Нийгэмшүүлэх

ОРШИЛ

Тархины саа бол хүүхдийн хөдөлгөөнд нөлөөлж буй удаан хугацааны бие мах бодийн даамжрахгүй согог юм. Энэхүү согог нь зөвхөн нэг гарын хөнгөн хэлбэрийн гэмтлээс эхлээд бүхий л бие эрхтэн системийг хамарсан хөдөлгөөний дутагдлаар илэрч болно. Тархины саа 3 үндсэн хэлбэртэй байдгаас бүгд хүний хөдөлгөөнд нөлөөлдөг. Хөдөлгөөнүүдийг урьдчилан хэлж болшгүй булчингууд хөшүүн буюу чанга салганасан, таталт ба хавсарсан бэрхшээлтэй байдаг.

Тархины саа нь гурван хэлбэртэй. Үүнд:

Тархины саагийн чангаралттай хэлбэр энэ нь тархины саагийн 70-80 % эзэлнэ.

Тархины саагийн эмгэг хэлбэр энэ нь 10-20%-д тохиолддог.

Тархины саагийн тэнцвэргүй хэлбэр энэ нь ховор тохиолдоно.

Тархины саа нь:

Биеийн аль нэг тал нь

Доод мөч \2 хөлний \саажилт\

4 мөчний саажилт Хөнгөн хэлбэрийн тархины саатай хүүхэд ямар нэгэн үйлдэл хийхдээ бусдын туслалцаагүй хийж чаддаг. Харин бусад хэлбэрийн саатай хүүхэд бусдын туслалцаа хэрэгтэй байдаг.

Үндсэн хэсэг \онол\

Дөрвөн настай хүүхдийн онцлог /4 настай хүүхдийг уяанаас алдуурсан нас гэдэг./

Тухайн насны хүүхдийн хөдөлгөөний чадвар

- өлмий дээр гүйх
- нэг хөл дээрээ 5-10 сек зогсох
- Урагшаа, доошоо болон бартаан дээгүүр үсрэх
- Цохиураар бөмбөг зохих, шидэх, барьж авах
- Дөрвөлжин, гурвалжин дүрс болон хэрээс зурж чадах 20 хүртэл тоолох
- Хүүхдүүдтэй тоглохыг хүсэх
- Биеэ дааж хувцасаа өмсөх, шүдээ угаах болон халбага сэрээ хэрэглэж чадах

4-5 үгтэй өгүүлбэрээр ярина. Харилцааны гол хэлбэр нь өөрийгөө магтана, бие биедээ гайхуулж ярина. Ямар нэгэн оноосон нэрийг амархан цээжилнэ. Орон зайн хөдөлгөөний чиглэлийг хурдан хурдан өөрчилнө.

Судалгааны хэсэг

Зорилго:

- Ганцаарчилсан сургалтаар хүүхдийн оролцоог дэмжих

Зорилт:

- Хүүхдийн хөдөлгөөн, танин мэдэхүйг дэмжих тоглоом даалгаврыг боловсруулна.
- Шалгуур үзүүлэлтээр үнэлгээг авна.
- Үнэгээний дагуу дүгнэж, цаашид ажиллах арга замаа тодорхойлно.

Хамрах хүрээ:

- БЗД-ийн СЦЯ-ийн 10-р цогцолборын “Сархан” бүлгийн 4 настай 2 хүүхэд

Судалгааны арга :

- Ажиглалтын арга
- Тоон судалгааны арга
- Дүгнэлтийн арга

Тухайн судалгаанд орж байгаа Л.Ү нь 4 настай оюун ухаан нь ердийн доод мөчний хос саатай хүүхэд юм.

Цэцэрлэгт хамрагдах үедээ 1нас 4 сартай ярьж чаддаггүй өнхөрдөг их уйлдаг байсан ба одоо бага зэрэг өлмийдөж явдаг ярьж чаддаг санаа бодлоо илэрхийлдэг нийгэмшсэн нь эрт үедээ оншлогдож СӨБ-д хамрагдсан нь харагдаж байна. Судалгаанд орж байгаа 2 дахь хүүхэд А.Ц нь 4 настай оюун ухаан ердийн 4 мөчний саажилттай хүүхэд.

Цэцэрлэгт 2019 оны 09 сард 3нас 9 сартай хамрагдсан. Оюун ухаан нь ердийн ойлгоц сайн, нийгэмшихүй болон орчны харилцаа дунд зэрэг толгой даахгүй, эргэж хөрвөөж чадахгүй, дороо нуруугаараа эргэлдэнэ. Гараараа барих чадвар сул хүүхэд ирсэн.

Одоо нийгэмшихүйн харилцаа сайжирсан. Зурган картаар өөрийн санаа бодлоо илэрхийлдэг. Тархины саа нь дээд мөчинд

илүү давамгайлсан учир доод мөчөөрөө буюу хөлөөрөө даалгавар сайн гүйцэтгэдэг юм.

Тархины саатай хүүхдийн нэг эрхтэн нь нөгөө эрхтэний үүргийг орлон гүйцэтгэх нь элбэг тохиолддог. Иймд Тархины саатай 4 настай биеийн хөгжлийн хувьд ялгаатай 2 хүүхдийн хөдөлгөөн, танин мэдэхүйг харьцуулсан судалгааг хийлээ.

Даалгавар 1. Хайрцаганд байгаа 3 өнгийн бөглөөг өнгө өнгөөр ангилан ялгана.
Хэрэглэгдэхүүн: Ундааны 3 ш сав, 3 өнгийн бөглөөнүүд

№	Хүүхдийн нэр	Үнэлгээ	
		Авах оноо	Авсан оноо
1	10 М 4 Л.Ү	3 оноо	1 мин 46 сек 3 оноо
2	10 М 4.А.Ц	3 оноо	2 мин 10 1 оноо




Тайлбар:

Гурван өнгийн бөглөөг ангилан ялгах даалгавар гүйцэтгэхэд эхний хүүхэд 1 мин 46 сек буюу 3 оноо, 2 дахь хүүхэд 3 өнгөнөөс зөвхөн улаан өнгийг 2 мин 10 секундэд гүйцэтгэж 1 оноо авлаа.

Даалгавар-2

Олон өнгийн бөглөөнүүдээс улаан өнгийн бөглөөг түүж саванд ялгаж хийнэ.

№	Хүүхдийн нэр	Үнэлгээ	
		Авах оноо	Авсан оноо
1	10 М 4 Л.Ү	1 оноо	40 сек 1 оноо
2	10 М 4.А.Ц	1 оноо	1 мин 59 1 оноо




Тайлбар:

Судалгаанаас үзэхэд хүүхдүүд улаан өнгийг ялгаж чадаж байгаа боловч тухайн хүүхдийн хөдөлгөөн болон биеийн хөгжлөөс шалтгаалан хугацааны хувьд ялгаатай байсан.

Судалгааны дүгнэлт

№	Хүүхдийн нэр	Үнэлгээ	
		Авах оноо	Авсан оноо
1	10 М 4 Л.Ү	4 оноо	2 мин 26 сек 4 оноо
2	10 М 4.А.Ц	4 оноо	4 мин 9 сек 2 оноо



- Хүүхдүүдийг судалгаанд хамруулахад тухайн даалгаврыг 2 уулаа сайн гүйцэтгэж байгаа боловч бага зэрэг бэрхшээл тулгарч байсан нь биеийн хөгжлийн ялгаатай байдлаас шалтгаалан хугацааны зөрүү гарч байлаа.
- 10М4Л.Ү нь хөнгөн хэлбэрийн саажилттай хүүхэд учраас ердийн цэцэрлэгт буюу ЕБС-д суралцах боломжтой.
- 10М4А.Ц нь 4 мөчний саажилт буюу толгойгоо даахгүй сууж чаддаггүй байгаа нь ердийн цэцэрлэг болон ЕБС-д хамрагдах боломжийг нь хязгаарлаж байна. Бас л сурах боломжтой тохируулгат орчин, тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлдээд өгвөл оюун ухааны хувьд ердийн тул ЕБС-д суралцах боломжтой юм.

Дэвшүүлэх санал:

- ХБХ-ийг тэгш хамруулан сургахын тулд тохируулгат орчин, тохирсон хэрэглэгдэхүүн шаардлагатай.
- Орчинг бүрдүүлээд өгвөл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ЕБС, ердийн цэцэрлэгт ердийн хүүхдүүдтэй хамт суралцах боломжтой гэж үзэж байна.

Ном зүй

1. Тусгай хэрэгцээт боловсролын үндэс \ орчуулгын ном\
2. “Сургалт тоглоом”, Боловсролын хамтын ажилгааны нийгэмлэг

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙГ СУДАЛСАН НЬ

Ж.Нямцэцэг¹, Г.Уянга¹, Б.Туяа¹, П.Лхагватортох¹, Р.Нэнсэндэн², Д.Цогзолмаа³

¹Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

²Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүн амын хөгжлийн газар

³Шинжлэх ухаан технологийн их сургууль

Хураангуй

2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцооны загвар”-ыг баталсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ажиллах тогтолцооны суурийг тавьсан билээ. Энэхүү тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийн оношилгоо, үнэлгээг лавлагаа, шатлалын эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэжлийн баг хийх чиг үүрэгтэй байхаар зааж өгсөн байна. Оношилгоо үнэлгээг мэргэжлийн түвшний арга, аргачлалаар нарийвчлан хийх нь цаашид хөгжлийн дэмжлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх, хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлын суурь болох ач холбогдолтой. Бид энэхүү судалгаанд Ерөнхий боловсролын тусгай сургуульд тархины саажилт болон оюуны бэрхшээлтэй гэсэн оноштой суралцаж буй нийт 120 сурагчдад хийсэн сэтгэл зүйн шинжилгээний үр дүнг танилцуулж байна.

Summary

In 2018 Labor, Social protection, Education, culture, science sport and health ministers agreed on “a comprehensive development support for learning difficulties in children” program which provides children with intellectual disabilities the foundations for their future working life. In this program, it is indicated that specialized team of health professionals perform diagnose and evaluation of the intellectual disabilities. Detailed diagnostic assessment by professionals can be beneficial for future development support of work opportunities to the students. In this study, we present the psychological analysis of 120 students diagnosed with cerebral palsy and intellectual disability studying at a Special Needs Secondary School.

Түлхүүр үг:

Оюун ухааны бэрхшээл, тархины саажилт, сэтгэл зүйн шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа

Оршил

Монгол улсад хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношилгоо үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх, хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ үзүүлэх гэсэн иж бүрэн тогтолцоо хууль эрх зүйн хүрээнд бий болсон бөгөөд, шат шатанд хэрэгжүүлэх, хөгжүүлэх, боловсронгуй болгох шаардлага тулгамдаж байгаа юм. Ялангуяа хөгжлийн бэрхшээлийн үед нарийн мэргэжлийн оношилгоо, үнэлгээ хийх, нэгдсэн арга зүйтэй болох шаардлагатай байна.

Үндэсний Статистикийн Хорооны 2017 оны албан ёсны тайланд дурдсанаар хөгжлийн бэрхшээлтэй 11453 хүүхэд байгаа бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 6518 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл 931 нь сэтгэцийн гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Эдгээр хүүхдүүдийн сэтгэл, оюун ухааны хөгжлийн түвшинг нарийн мэргэжлийн арга, аргачлалаар үнэлэх нь:

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн “хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан загвар төлөвлөгөөний загвар, аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх” гэсэн заалт;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт буюу “хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын орчныг бий болгох” зэрэг заалтыг хэрэгжүүлэх үндэслэл болно гэж үзэж байна.

Судалгааны зорилго:

Ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцагчдын танин мэдэхүйн үйл ажиллагааг сэтгэл зүйн нарийн мэргэжлийн арга, аргачлалаар үнэлэхэд чиглэнэ.

Хамрах хүрээ:

2018 оны 11 дүгээр сараас 2019 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд 25, 70 дугаар сургууль дээр сэтгэл зүйн шинжилгээ хийв. Сэтгэл зүйн шинжилгээнд 6-22 насны нийт 120 суралцагч хамрагдсан ба 6-10 насны хүүхэд 29,4 хувь, 11-15 насны хүүхэд 58,7 хувь, 16 түүнээс дээш насны хүүхэд 11,9 хувийг эзэлж байна. Эдгээрээс 56,4 хувь нь эмэгтэй байв.

Судалгаанд оролцогчдын 50 хувь нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй, 50 хувь тархины саажилт гэсэн оноштой байна.

Судлах зүйл:

Сэтгэл зүйн шинжилгээгээр хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшин, ой тогтоолт, сэтгэхүй, оюуны ажиллах чадварын хурд, анхаарал зэргийг судлан үзэв. Шинжилгээний үр дүнг илүү бодитой болгох үүднээс хүүхдийн ядралт, идэвхийн үзүүлэлтийг давхар хэмжсэн болно.

Судалгааны арга, аргачлал:


Хүүхдийн сэтгэл зүйн шинжилгээнд дараах аргуудыг хэрэглэв.

Хүснэгт 1. Судалгаанд хэрэглэсэн аргачлал

Судлах зүйл	Хэрэглэсэн аргачлал
Ядралт, идэвх	Люшерийн өнгө ялгах сорил, компьютерийн хувилбар
Оюун ухааны хөгжлийн түвшин	Оюун ухааны түвшинг тогтоох Векслерийн сорил (WISC, WAIS)
Ой тогтоолт	Үг цээжлэх сорил
Сэтгэхүй	Утгын хувьд холбоогүй дүрс хасах сорил
Оюуны ажиллах чадварын хурд, анхаарал	Крепелины аргаар тоо бодох сорил


НЭГ. Оюун ухааны хөгжлийн түвшин

Шинжилгээнд хамрагдсан нийт хүүхдүүдийн 20,9 хувьд оюун ухааны ерөнхий түвшинг тогтоох боломжгүй байв. Учир нь хүүхэд сонсгол, хэл ярианы хөгжлийн байдлаас хамааран сорилын даалгаврыг бүрэн биелүүлэх чадвар хангалтгүй байна. Оюун ухааны түвшин тогтоох сорилд хамрагдсан хүүхдүүдийн 28,7 хувь нь оюун ухааны хөгжил хэвийн, 19,6 хувь нь завсрын хоцрогдол, 28,7 хувь нь хөнгөн зэргийн, 23 хувь нь хүндэвтэр хомсдолтой гэсэн үзүүлэлт илрэв.



Зураг 1. Судалгаанд оролцогчдын оюун ухааны хөгжлийн түвшин

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй гэсэн оноштой шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшинг мэргэжлийн аргачлалаар судлан үзэхэд 45,4 хувьд оюуны хөгжлийн бэрхшээл илэрсэнгүй. Харин 27,3 хувь нь хөнгөн, 27,3 хувь нь хүндэвтэр зэргийн хомсдолтой байв. Тархины саа саажилттай хүүхдүүдийн хувьд 50 хувь нь оюун ухааны хомсдолгүй хэвийн, 27,5 хувь нь хөнгөн зэргийн оюуны хомсдол хавсарсан, 22,5 хувь нь оюуны хүндэвтэр хомсдол хавсарсан үзүүлэлт илрэв.



Зураг 2. Оюун ухааны үзүүлэлт, урьдчилсан оношоор

Оюуны хөгжлийн түвшин тогтоох тестийн ерөнхий үзүүлэлтүүд болон дэд сорилууд хоорондын корреляци үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харууллаа. Хүснэгтээс оюун ухааны ерөнхий түвшин нь хэлэхүйн болон хэлэхүйн бус даалгаврын оноотой маш хүчтэй хамааралтай байгааг харж болно.

Хүснэгт 2. Оюун ухааны сорилын дэд даалгаврууд хоорондын корреляци хамаарал

	IQ	VIQ	NIQ	sub 1	sub 2	sub 3	sub 4	sub 5	sub 6	sub 7	sub 8	sub 9	sub 10	sub 11	sub 12
r	,93"	,79"	,82"	,75"	,7"	,73"	,83"	,75"	,69"	,75"	,79"	,57"	,58"	,23"	

ХОЁР. Ой тогтоолтын байдал

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 81,8 хувьд ой тогтоолтын хөгжил сул, 10 хувьд дунд зэрэг, 8,2 хувьд сайн гэсэн үзүүлэлт илрэв.

Оюун ухааны үзүүлэлт болон ой тогтоолтын хоорондын хамаарал $r=0,383$ байна. Тодруулбал, оюуны хөгжлийн ерөнхий үзүүлэлт өндөр байх тусам ой тогтоолт сайн байх хандлагатай.

Ой тогтоолтын байдлыг үг цээжлэх сорилоор судалсан бөгөөд дундаж үзүүлэлтийг оюуны хөгжлийн түвшин тус бүрээр харуулав.

Хүснэгт 3. Үг цээжлэх сорилын дундаж үзүүлэлт, оюун ухааны хөгжлийн түвшингээр

	дундаж	1	2	3	4	5	цагийн дараа
хүндэвтэр	1,15	1	1,05	1,05	1,35	1,45	0,7
хөнгөн	2,28	1,84	2,28	2,28	2,72	2,88	1,68
завсрын	3,92	2,82	3,94	3,88	4,59	4,76	3,53
хэвийн	3,82	2,95	3,62	3,75	4,66	3,54	3,41

Хүснэгтээс харахад оюуны хүндэвтэр хомсдолын үед цээжлүүлэхээр өгөгдсөн үгсээс 1.15, оюуны хөнгөн хомсдолын үед 2.28 үг дунджаар цээжилдэг байна. Эдгээр үзүүлэлт нь оношийн ач холбогдолтой бөгөөд манайд анх удаа тогтоож байгаа үзүүлэлт болно.

ГУРАВ. Оюуны ажиллах чадварын хурд, анхаарал

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн хувьд Крепелины аргаар хялбар тоо нэмэх сорилоор 15 сек тутамд дунджаар 0-3 үйлдэл гүйцэтгэж байгаа бөгөөд оюуны хөгжлийн түвшингээс хамааран ялгаа илэрдэг байна.

Хүснэгт 4. Крепелины сорилын үзүүлэлт, оюун ухааны хөгжлийн түвшингээр

	15 секунд тутамд гүйцэтгэсэн даалгаврын дундаж тоо	Гаргасан алдааны дундаж
хүндэвтэр	0,3	1,85
хөнгөн	1,29	2,76
завсрын	2,26	3,11
хэвийн	5,72	3,24


Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн хувьд оюуны ажиллах чадварын муруй аажим буурсан байгаа бөгөөд 7-р дугаар мөчид өгсөж, эргээд буурсан зүй тогтол ажиглагдаж байна.



Зураг 3. Оюуны ажиллах чадварын муруй


Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд дадлагажих чадвар сул, ядралт их байдаг болохыг илтгэж байна. Хэвийн эрүүл хүний хувьд энэхүү муруй эхлээд өгсөж байгаад эргээд буурч, 7-р мөчид аажим өгсөөд буурдаг зүй тогтолтой байдаг нь тогтоогдсон байдаг билээ (Н.Орёл, 1992). Хүүхдүүдийн 62.5 хувьд оюуны ажиллах чадварын хурд удаан, 27,8 хувьд дундаж, харин 9,7 хувьд өндөр байна.

Анхаарлын алдаа гаргаж буй эсэхийг судлан үзэхэд 69,4 хувьд анхаарал тогтворгүй байдалтай, 19,4 хувьд анхаарлын төвлөрөлт жигд гэсэн үзүүлэлт илрэв.



Зураг 4. Судалгаанд оролцогчдын анхаарлын үзүүлэлт

ДӨРӨВ. Ядралт, идэвх



Хүүхдүүдийн 45 хувь нь сэтгэл зүйн ачаалал дундаж хэмжээнд, 19,2 хувьд сэтгэл зүйн ачаалал ихэссэн, тодруулбал, ядарсан, эрч хүч суларсан байдалтай байв.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын идэвхийн байдал

Хүүхдүүдийн 54,1 хувьд идэвх хэвийн, 15,6 хувьд хэт идэвхжсэн байдалтай, өөрөөр хэлбэл анхаарал тогтворгүй, сайн амарч чадахгүй байгаа, 3,7 хувьд мэдрэл сульдлын, 26,6 хувьд идэвх суларсан үзүүлэлт илрэв.

Хүүхдүүдийн идэвхийн байдал танин мэдэхүйн үйл ажиллагаанд нөлөөлж буй эсэхийг авч үзье.

Хүснэгт 5. Идэвх ба танин мэдэхүйн үзүүлэлтүүдийн корреляци хамаарал

	нас	хүйс	онош	IQ	VIQ	NIQ	CO	ой	оюуны.а.ч	анхаарал	сэтгэхүй
ВК	-.045	.084	-.043	-.002	-.037	.109	.393*	-.027	-.073	.060	.026

Дээрх хүснэгтээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн идэвхийн байдал нь нас, хүйс, өвчний байдал, оюун ухааны хөгжлийн түвшин, ой тогтоолт, оюуны ажиллах чадвар, анхаарал, сэтгэхүй зэрэгтэй хамааралгүй байна.

ТАВ. Сэтгэхүй

Утгын хувьд холбоогүй дүрс хасах сорилын хүүхдэд зориулсан хувилбараар сэтгэхүйн хөгжлийг судлан үзэв. Уг хувилбар нь оюуны хомсдолын үед болон танин мэдэхүйн чадварууд алдагдалтай үед хэрэглэж болдог, түүнчлэн тоон болон чанарын шинжилгээ хийдгээрээ давуу талтай юм. Оюун ухааны хөгжлийн түвшин тус бүрт судлуулагчийн зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж үзүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 6. Сэтгэхүйн даалгаврыг гүйцэтгэсэн байдал

	Зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж/ оноо	Нэг бүлэг даалгаварт зөв гүйцэтгэсэн дундаж тоо
хүндэвтэр	1,95	0,3
хөнгөн	4,48	0,6
завсрын	10,25	1,48
хэвийн	10,8	1,5

Зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж буюу хүүхдийн оноог оюуны хөгжлийн түвшингээр тогтоох нь оношийн ач холбогдолтой үзүүлэлт болж байна.

Дүгнэлт

Ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцагчдын танин мэдэхүйн үйл ажиллагааны онцлогийг судалсан судалгаанаас харахад хүүхдүүдийн 81,8 хувьд ой тогтоолтын хөгжил сул, 10 хувьд дунд зэрэг, 8,2 хувьд сайн гэсэн үзүүлэлт илрэв. Хүүхдүүдийн 54,1 хувьд идэвх хэвийн, 15,6 хувьд хэт идэвхжсэн байдалтай, өөрөөр хэлбэл анхаарал тогтворгүй, сайн амарч чадахгүй байгаа, 3,7 хувьд мэдрэл сульдлын, 26,6 хувьд идэвх суларсан үзүүлэлт илрэв.

Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад оюуны бэрхшээлтэй гэсэн оношоор суралцаж байгаа, сэтгэл зүйн шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 45,4 хувьд оюун ухааны хомсдол илэрсэнгүй. Нөгөө талаар оюуны бэрхшээл гэж ерөнхийд нь онош тавьж байгаа ч хомсдолын зэргийг нарийн тогтоодоггүй байна.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайланд зөвлөмж болгосны дагуу хөгжлийн бэрхшээлийн талаар судалгааны ажил хийхийг цаашид дэмжих шаардлагатай байна.

Ном зүй:

1. БСШУСЯ. 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээ.
2. Заавар, маягт батлах тухай” ХНХ, БСШУС, ЭМ-ийн сайдын А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаал /2018.11.15/
3. Нэнсэндэн Р. Хүүхдийн эмгэг сэтгэл судлалын зарим асуудал. УБ, 2015
4. Н.Орёл, Д.Цогзолмаа. Эмгэг сэтгэл судлал, сэтгэц – физиологийн зарим үндсэн шинжилгээг эмнэл зүйн практикт хэрэглэх арга зүй. УБ.,2006
5. Сарантуяа Г. Сэтгэл судлалын шинжлэх ухааны судалгааны аргууд. УБ, 2015
6. СЭМҮТ, Сэтгэл зүйн оношилгооны баг. Утгын хувьд холбоогүй дүрс олох сорил. УБ.,2017
7. Үндэсний статистикийн хорооны тайлан. 2017
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. УБ, 2016
9. World report on Disability. 2011. WHO, WB

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

(Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчдын жишээн дээр)

Ч.Нямдорж¹

¹Техникийн боловсрол, Ерөнхий эрдмийн тэнхим
Универсал Политехник Коллеж

Хураангуй

Манай улсад тусгай хэрэгцээт боловсролыг тусгайлсан байдалтай бие эрхтний согогийн хүрээд авч үзэж байна. Харин дэлхийн хөгжингүй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангилалд бие эрхтний согогтой хүүхдүүдээс гадна зан төлөвийн өөрчлөлттэй, сурахуйн бэрхшээлтэй, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтэй, аутизмын хүрээний эмгэгтэй... гээд өргөн хүрээнд авч үзэж, “боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүд” гэх нэр томъёог хэрэглэх боллоо. Монголын ЕБС-ийн багш нарын 85 хувь нь анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн талаар төдийлөн сонсож байгаагүй, энэ талаарх мэдлэг хангалтгүй байна [1:11]. Уг судалгаанд олон улсын мэргэжлийн байгууллагуудын тодорхойлсон (DSM-5, 2013) (IDEA, 2004) тодорхойлолтын дагуу олон улсад туршигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг илрүүлэх аргачлалын “Монгол хувилбар”-ын “Анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаарх асуумжыг хэрэглэсэн [1]. Бидний судалгааны үр дүнд МСҮТ, коллежийн багш нарын 83 хувь нь тэгш хамруулах боловсролын талаар ойлголцогүй болох нь илэрсэн. Мөн МСҮТ, Коллежид суралцагчдын 7-10 хувьд анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн шинж тэмдэгүүд “тод илэрч” байна. Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн талаар багш нарын 72,3 хувь нь төдийлөн сонсож байгаагүй, мөн АДХХЭ-тэй хүүхэдтэй ажиллах арга барил эзэмшээгүй байна. Иймд мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нарт “тэгш хамруулах боловсрол”-ын онол, арга зүйн мэдлэг, чадвар олгох мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байна.

Түлхүүр үг

Онцгой анхаарал шаардлагатай суралцагч, анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх

эмгэг (АДХХЭ), тусгай хэрэгцээтэй хүүхэд, мэргэжлийн боловсролын багш

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн чуулганаар хүүхдийн эрх, эрх чөлөөний тухай “Хүүхдийн эрхийн конвенц”-ийг 1989 онд баталсан ба түүнээс хойш гарсан олон улсын баримт бичиг, тунхаглалуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад боловсрол олгох, тэдний эрхийг хамгаалах, нийгэм хамт олон дунд нь нийгэмшүүлэх талаар онцлон заасан билээ. Энэ конвенцийн 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн дүүрэн аз жаргалтай амьдрахын тулд дэмжлэг тусламж, халамж хэрэгтэйгээс гадна сурч боловсрох эрх эдлэх, дээд зэргээр өөртөө итгэх, улмаар нийгмийн интеграцчилалд тэгш эрхээр бүрэн ханган оролцуулах буюу оролцох эрхтэй гэж заасан байдаг. Боловсролд тэгш хамруулах үзэл баримтлалыг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүмүүсийн асуудлаарх 1994 оны дэлхийн бага хурлын үеэр тодорхойлсон. Хүүхэд бүрт өөрийн гэсэн онцлог хэв шинж, сонирхол, авьяас чадвар ба суралцах хэрэгцээ байдаг тул боловсрол эзэмших эрхээ хэрэгжүүлнэ гэдэг нь эдгээр харилцан адилгүй хэв шинж ба хэрэгцээ шаардлагыг нь тусгасан боловсролын хөтөлбөрүүдэд хамрагдахыг хэлнэ (UNESCO, 1994).

Боловсролыг хүртээмжтэй болгох асуудлыг 1990 онд Тайландын Жомтиен хотноо анх хэлэлцэж, 2000 онд Сенегалын Дакар хотод болсон бүх нийтийн боловсролын дэлхийн чуулганаар баталгаажуулсан билээ. Эдгээр бичиг баримтууд нь сүүлийн хэдэн арван жил боловсролын салбарт томоохон ахиц дэвшил гаргахад нөлөөлсөн. 2015 оны 5-р сард БНСУ-ын Инчеон хотноо зохион байгуулагдсан Боловсролын дэлхийн чуулга уулзалтаар “Тэгш хамруулан сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн боловсролоор хангах” зорилгыг дэвшүүлсэн.

ТХСБ-ын зорилго нь ялгаварлалгүй, адил тэгш оролцоог хангасан хүртээмжтэй, хэрэгцээнд суурилсан, чанартай боловсролын үйлчилгээг хүүхэд бүхэнд үзүүлэхэд оршино.

ЮНЕСКО боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олсон ололт амжилтуудыг дэмжиж, тэгш эрхэд суурилсан, чанартай суурь боловсролыг тогтвортой хөгжлийн 4 дэх зорилго болгон “Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн боловсролоор хангах” зорилтыг 2015 оны 2-р сард БНСУ-ын Инcheon хотноо зохион байгуулагдсан Боловсролын дэлхийн чуулга уулзалтаар дэвшүүлсэн байна. (Инcheon тунхаглал, 2015). Монгол улсад тэгш эрхэд суурилсан эрх зүйн талаар Үндсэн Хуулийн 16.7 заалт: Иргэн бүр сурч боловсрох эрхтэй, СӨБ, БДБ тухай хуулийн 9,9 заалт: Цэцэрлэгийн ердийн бүлэгт хөнгөн хэлбэрийн ХБ 2 хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно; БДБ тухай хуулийн 13,3 заалт: ЕБС, ба бусад сургууль нь ХБ хүүхдэд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй; БДБ тухай хуулийн 13,12 заалт: ХБ хүүхэдтэй ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон заах арга эзэмшсэн байна; Монгол Улсын Их Хурлаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийг 2016 оны 2-р сарын 5-нд баталсан. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилготой Засгийн газар 2017 онд 321-р тогтоол гаргаж “ХБХ эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван яамны үйл ажиллагааны төлөвлөгөө ЭМЯ, ХНХЯ, БСШУСЯ-ны хамтарсан тушаал 2018 оны 5-р сарын 21 –ний өдрийн тушаалаар (А/116, А/304, А/197) гарсан байна. Боловсролд тэгш хамруулах, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй болгох зорилготой “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн” тухай хуулийн 16.1-т: Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт *хөгжлийн бэрхшээлтэй* суралцагчтай ажиллах агуулга, арга зүйг тусгана. 16.2-т: “Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна” заалтууд оруулжээ.

Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагчийн хэрэгцээ сонирхол, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон

олон хувилбартай чөлөөтэй, нээлттэй, чанартай ямар нэгэн ялгаварлан гадуурхлаас ангид боловсрол олгоход чиглэсэн үйл явц юм.

Тэгш хамруулан сургах, тусгай хэрэгцээт хүүхдэд боловсрол олгоход тулгарч буй бэрхшээлээс хамгийн их тулгамдаж буй асуудлыг тодруулахад “Тусгай хэрэгцээт хүүхдийг сургах, тэгш хамруулах аргачлал, арга зүй, модуль, хөтөлбөр дутмаг” гэж судалгаанд оролцсон ЕБС-ийн 182 багшийн 81.3 хувь нь үзжээ [6:27]. Иймд тэгш хүртээмжтэй боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдүүдтэй ажилладаг бүх шатны сургалтын байгууллагын багш нарт зориулсан арга зүйн нэмэлт сургалтыг явуулж, хүүхдүүд болон багшийг үнэлэх үнэлгээний тогтолцоог уян хатан болгох, мэдлэг ойлголт, ур чадвар, хандлагыг өөрчлөн сайжруулах хэрэгцээ, шаардлага байна.

Судалгааны зорилго:

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нарт тэгш хамруулах боловсролын онол, арга зүйн сургалтын хэрэгцээ шаардлага байгааг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилт:

- Эх сурвалж-баримтын судалгаа хийх
- Судалгааны аргачлалын дагуу, багш суралцагчдаас судалгаа авах
- Судалгааны үр дүнг боловсруулж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох
- Дүгнэлт гаргах, санал боловсруулах

Судалгааны хамрах хүрээ:

МҮИС-ийн харьяа Универсал Политехник Коллежийн эрэгтэй 10, эмэгтэй 20, нийт 30 багш, мэргэжлийн боловсролын 1 дүгээр курсын эрэгтэй 50, эмэгтэй 50, нийт 100 суралцагчийг тус тус судалгаанд хамруулсан.

Судалгааны арга зүй:

- Олон улсын мэргэжлийн байгууллагуудын тодорхойлсон (DSM-5, 2013) (IDEA, 2004) тодорхойлолтын дагуу олон улсад туршигдаж, найдвартай чанар нь батлагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг


илрүүлэх аргачлалын “Монгол хувилбар”-ын “Анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаарх асуумж. Уг асуумж нь 18 асуултаас бүрдэнэ.

- АДХХ эмгэгтэй хүүхдийг илрүүлэх асуумжийг “багш, суралцагч” гэсэн хоёр хувилбараар авч, үр дүнг тодорхойлсон.
- Багш нараас “Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаарх мэдлэг, ойлголтын түвшинг тодорхойлох асуумж. Уг асуумж нь 11 асуултаас бүрдэнэ.
- Эх сурвалж-баримтын, асуулгын, математик-статистик боловсруулалт, анализ-синтезийн аргуудыг ашигласан.


ҮР ДҮН

Суралцагчдаас авсан судалгаа

Судалгаанд оролцсон нийт 100 суралцагчдын 7.4 хувьд нь анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн шинж тэмдэг тодорхой илэрч байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогч суралцагчдын 7.4 хувьд багш, эцэг эхийн зүгээс “онцгой анхаарал хандуулах шаардлагатай”. Мөн судалгаанд оролцсон суралцагчдын 34.7 хувьд нь анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх эмгэгийн зарим шинж тэмдэгүүд илэрсэн. Иймд багш нар эдгээр суралцагчдад “анхаарал хандуулах” шаардлагатай (Диаграмм 1).



Диаграмм 1. АДХХЭ-ийн илэрц



Диаграмм 2. АДХХЭ-ийн илэрц, хүйсээр


Судалгаанд оролцсон эрэгтэй суралцагчдын 10 хувьд, эмэгтэй суралцагчдын 5 хувьд анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн шинжүүд тод илэрсэн. Судалгаанд оролцсон эрэгтэй суралцагчдын 47 хувь буюу 2 эрэгтэй суралцагч тутмын нэгд, эмэгтэй суралцагчдын 20 хувь буюу 5 эмэгтэй суралцагч тутмын нэгд АДХХЭ-ийн зарим шинжүүд илэрч байна (Диаграмм 2).

Суралцагчдын хариултаас үзвэл АДХХЭ-ийн дараах шинж тэмдгүүд нийтлэг илэрч байна.

- Эрэгтэй суралцагчид:
- Сургууль дээр (хичээл) сайн анхаарал хандуулж чаддаггүй ба болгоомжгүйгээсээ алдаа гаргадаг.
 - Миний гар, хөл байнга хөдөлж суудалдаа тогтвортой сууж чаддаггүй.
 - Ямарваа үйл ажиллагааг гүйцэтгэхдээ зайлшгүй хэрэгцээтэй зүйлээ би мартаж гээдэг.
 - Би хэт их ярьдаг.
 - Анхаарал минь сарнимхай
 - Өдөр тутмын үйл ажиллагаанд мартамхай байдаг.
- Эмэгтэй суралцагчид:
- Сургууль дээр (хичээл) сайн анхаарал хандуулж чаддаггүй ба болгоомжгүйгээсээ алдаа гаргадаг.
 - Би хэт их ярьдаг.
 - Ямарваа үйл ажиллагааг гүйцэтгэхдээ зайлшгүй хэрэгцээтэй зүйлээ би мартаж гээдэг.
 - Анхаарал минь сарнимхай
 - Би оюун ухааны ачаалал шаардсан даалгавраас зайлсхийдэг (жнь: сургуулийн ажил, гэрийн даалгавар)


Багш нараас авсан судалгаа

Судалгаанд оролцсон багш нарын нас, хүйс, багшаар ажилласан жилийг тодруулсан. Нийт судалгаанд оролцсон багш нарын 70 гаруй хувь нь 20-30 насны хооронд байсан бол, 50 гаруй хувь нь эхний жилдээ, 40 гаруй хувь нь 2-5 дахь жилдээ ажиллаж байна (Диаграмм 3, 4).




Диаграмм 3. Багш нарын насны бүтэц

1 МУБИС-ийн Хүүхдийн Хөгжлийн Дэмжих Төв, Японы Нагоя ИС-ийн хамтарсан төслийн баг “Албан ёсны зөвшөөрөл, зохиогчийн эрх”-ийг авч, “Монгол хувилбар”-ыг (Орчуулга хийх: Япон-Монгол, Англи-Монгол, Монгол-Япон, Монгол-Англи) боловсруулсан.




Диаграмм 4. Багш нарын ажилласан жил

Тэгш хамруулах боловсрол болон тусгай хэрэгцээт боловсролын талаарх мэдлэг ойлголтыг судлахад багш нарын 83 хувь нь энэ талаар сонсож байгаагүй, 17 хувь нь анхан шатны ойлголттой гэж хариулсан (Диаграмм 5). Мөн анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн талаар өмнө нь та “сонсож” байсан уу? гэсэн асуултад багш нарын 27,6 хувь нь “сонсож” байсан, үлдсэн 72,4 хувь нь “сонсож байгаагүй” гэжээ (Диаграмм 6).




Диаграмм 5. ТХБ-ын талаарх ойлголт



Диаграмм 6. АДХХЭ-ийн талаарх ойлголт

“Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг илрүүлэх аргачлалын “Анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаарх асуумжын дагуух судалгаанд оролцсон нийт 30 багшийн хариултаас үзвэл: “Универсал Политехник Коллеж”-д суралцаж буй 500 гаруй суралцагчдын 15,2 хувьд анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн шинж тэмдэг тод илэрдэг гэж хариулжээ.



Диаграмм 5. АДХХЭ-тэй суралцагчдийн талаарх багш нарын үнэлгээ

Багш нар суралцагчдад АДХХЭ-ийн дараах шинж тэмдгүүд нийтлэг илэрдэг гэж үзсэн байна.


- Гар нь хөл байнга хөдөлж суудалдаа тогтвортой сууж чаддаггүй.
- “Томоотой байж чадахгүй”, “цахилгаанаар ажиллаж байгаа мэт” хөдөлж байдаг.
- Оюун ухааны ачаалал шаардсан даалгавраас зайлсхийдэг (жнь: сургуулийн ажил, гэрийн даалгавар)
- Хэт их ярьдаг.
- Асуулт асууж дуусаагүй байхад таслан хариулж эхэлдэг.
- Анхаарал нь сарнимхай
- Ээлж хүлээж чаддаггүй.

Анхаарлын төвлөрөл сул, хэт хөдөлгөөнтэй суралцагчийн онцлогийг харгалзан, суралцахууд нь ямар дэмжлэг үзүүлдэг вэ? гэсэн асуултад багш нар дараах байдлаар хариулсан. Үүнд:

- Битгий илүү хөдөлгөөн хийгээд бай, хөдөлгөөнгүй суу
- Наашаа хараад, анхаарлаа төвлөрүүлээрэй
- Хөдлөөд байна, их ярьж байна “бусдадаа битгий садаа бол” гэж зэмлэдэг.
- Чимээгүй, хөдөлгөөнгүй суухыг сануулж хэлдэг, заримдаа “зэмлэдэг”.
- Анхаарлын сарнилт ихтэй хүүхдэд “хөнгөн хэлбэр”-ийн даалгавар өгч хийлгүүлдэг.
- Хэт хөдөлгөөнтэй хүүхдийг ангийн цонх онгойлгох, самбарын арчуур норгуулж, самбар арчуулах гэх зэргээр “хөдөлгөөнд” байлгадаг.
- Чи чадна, тиймээс оролдоод хийвэл болно гэж хэлж “тулж” харьцдаг.
- Тусгай, нэмэлт дэмжлэг шаардлагатай хүүхдэд би ямар арга замаар туслахаа төдийлөн сайн мэддэггүй болохоор хичээлийн явцад туслаж, илүү зааж өгөхийг хичээдэг зэргээр хариулсан.

“Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаарх багш нарын мэдлэг, ойлголтын судалгааг “АДХХЭ”-ийн шинж

тэмдэгүүдийг 11 таних асуулт бүхий асуулгын хуудсаар авсан. Асуулт бүрт багш “тийм”, “үгүй”, “мэдэхгүй” гэсэн хариултаас сонгон хариулсан (Диаграмм 6).



Диаграмм 6. АДХХЭ-ийн талаарх багш нарын мэдлэг, ойлголтын түвшин

Судалгаанд оролцсон багш нарын нийт хариултаас 56.1 хувь нь зөв хариулт, 43.9 нь буруу хариултыг сонгосон байна. Эндээс үзвэл багш нарын хоёр хариулт тутмын нэг нь буруу хариулт өгсөн. Мөн багш нар нийт хариултын 28,3 хувьд “мэдэхгүй” гэсэн хариултыг сонгосон. Эндээс үзвэл судалгаанд оролцсон багш нарын “АДХХЭ”-ийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн “шинэ” төрлүүд, тэдгээрийг бүхэлд нь авч үздэг тусгай хэрэгцээт боловсрол болон тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт сул байгааг харуулж байна.

ХЭЛЦЭМЖ

МУБИС, Японы Нагоя Их Сургуулийн хамтарсан төслийн багийн “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдыг дэмжих төслийн тайлан”-д ЕБС-ийн багш нарын 85 хувь нь анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн талаар төдийлөн сонсож байгаагүй, мэдлэг хангалтгүй гэж дүгнэсэн байна. Бидний судалгаанд хамрагдсан нийт багш нарын 72,4 хувь нь анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн талаар мэдлэг, ойлголтгүй, мөн 83 хувь нь тэгш хамруулах боловсролын талаар мэдлэг, ойлголтгүй байгаа нь илэрч байна. Дээрх судалгааны үр дүнг баталгаажуулж, МСҮТ, Коллежийн багш нарт тэгш хамруулах боловсролын талаар мэдлэг, ойлголт, хөгжлийн онцлогтой суралцагчидтай ажиллах арга зүй, ур чадвар олгох сургалтын хэрэгцээ байгааг илрүүлсэнээрээ судалгааны давуу тал нь оршино. Гэхдээ энэ удаагийн судалгааны хамрах хүрээ зөвхөн нэг сургалтын байгууллагыг

хамруулан хийгдсэн. Энэ нь судалгааны ажлын хязгаарлагдмал тал юм. Иймд:

1. МСҮТ, Коллежийн удирлага болон багш нарт зориулсан “Тэгш хамруулах боловсрол”-ын талаарх онол, арга зүйн сургалтын модуль боловсруулах
2. МСҮТ, Коллежийн багш нарт “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд”-ийн хөгжлийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хөгжлийг нь үнэлэх зэрэг арга зүйн цогц чадварыг олгоход чиглэсэн “мэргэжил дээшлүүлэх сургалт”-ыг зохион байгуулах
3. Монголын нийт МСҮТ, Коллежийн хэмжээнд боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн “илрүүлэлт”-ийн судалгаа хийх, тэднийг тэгш хамруулан сургах бүхий л нөхцлийг бүрдүүлэхийг “боловсролын баримт бичиг, бодлого, үйл ажиллагаанд тодорхой тусгаж өгөх” шаардлагатай

ДҮГНЭЛТ

1. Судалгаанд оролцсон суралцагчдын 7.4 хувьд (7 суралцагч), эрэгтэй суралцагчдын 10 хувьд, эмэгтэй суралцагчдын 5 хувьд тус тус анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийн шинж тэмдэг тод илэрч байна. АДХХЭ-ийн шинж тэмдэг эрэгтэй суралцагчдад, эмэгтэй суралцагчдаас хоёр дахин их байна.
2. Судалгаанд оролцсон багш нар нийт суралцагчдын 15,2 хувьд АДХХЭ-ийн шинж тэмдэг тод илэрдэг гэж үзэж байна.
3. Тэгш хамруулах боловсрол (83%), АДХХЭ-ийн (72,4%) талаарх багш нарын мэдлэг, ойлголтын түвшин, арга зүйн чадвар “хангалтгүй” байна.
4. Анхаарлын сарнилт их, хичээл дээр хэт хөдөлгөөнтэй байдал нь сурагчдыг сурлагаар хоцрох “шалтгаан” болдог. Үүнээс үүдэн суралцагч сурлагаар хоцрох нь “хөгжлийн хоцрогдол”-д орох эрсдэлтэй. Хэрэв багш, эцэг эх “илрүүлэлт”-ийг хийхгүй орхигдуулбал “хүүхэд жинхэнэ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ” болно. Иймд МСҮТ, Коллежийн багш нарт “Тэгш хамруулах боловсрол”-ын талаарх онол, арга зүйн сургалт зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байна.

НОМ ЗҮЙ

1. МУБИС, Нагоя ИС-ын хамтарсан төслийн баг. (2017). Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдыг дэмжих төслийн тайлан. УБ:Содпресс ХХК
2. Одгэрэл, Д., Намираа, Б. (2018). Тусгай боловсрол. УБ:Содпресс ХХК
3. Одгэрэл Д, Намираа Б, Шинкава М. (2016). Тэгш хамруулах боловсрол. УБ. х.7. Мөнхийн үсэг ХХК
4. Одгэрэл, Д., Ганболд., Д, Мөнхцэцэг., О, Нямдорж., Ч, Бадамцэрэн., А, Бат-Оюун., Б. (2018). Тэгш хамруулах боловсрол, ЕБС-ийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. УБ.
5. СЗҮТ. (2017). Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь. ЭШХ-ын эмхтгэл. УБ
6. IRIM. (2018). Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь, төслийн тайлан. УБ
7. Individuals with Disabilities Education Act, 2004

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛЭЭР ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Г.Ням-Осор¹, Х.Нямсүрэн¹
¹ 29 дүгээр сургууль

Оршил

Бие махбодь, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүгд нийгмийн гишүүн болж нийгмийн харилцаанд оролцон бусдын адил ажиллаж амьдрах нь ердийн нийгмийн үзэгдэл болсон. Оюун ухааны бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй, хараа, сонсгол муутай, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэсэн шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл, үе тэнгийн хүүхдээс ялган тусгаарлах хандлага өөрчлөгдөж тэднийг хүнийх нь хувьд бусадтай адил тэгш үзэж өөрийн хэрэгцээг хангахуйц тохирсон боловсрол эзэмшиж бие даан ажиллаж амьдрах, улмаар нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулахад чиглэгдсэн боловсролын бодлогыг хэрэгжүүлж байна.

Түлхүүр үг:

Тусгай хэрэгцээ, арга зүй, сурах арга барил, эцэг эхийн дэмжлэг

Судалгааны үндэслэл:

Хүүхэд янз бүрийн арга барилаар суралцдаг ба суралцагч бүрийн хувийн хэрэгцээг хангаж ажиллахын тулд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах, бэрхшээлийн онцлогт тохирсон арга зүйг нээн илрүүлэх, түгээх дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна. Энэ ч утгаараа “Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” сэдвийн хүрээнд “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг математикийн хичээлээр хөгжүүлэх нь” сэдвийг хөндлөө.

Судалгааны зорилго:

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн онцлогт тулгуурлан тэднийг математикийн хичээлээр хөгжүүлэх.

Судалгааны зорилт:

- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэх онцлогийг судлах

- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэх онцлогт тулгуурлан ажиглалт туршилт хийх туршилтын үр дүнг боловсруулах
- Эцэг эхчүүдэд математикийн хичээлд хэрхэн туслах талаар зөвлөгөө өгөх

Судалгааны объект:

- Сонсголын бэрхшээлтэй хүүхэд
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг математикийн хичээлээр хөгжүүлэх арга зам

Ерөнхий таамаглал:

Судалгааны сэдэвтэй уялдуулан дараах таамаглалуудыг чухалчилж үзлээ. Үүнд:


- ✓ Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүлийн хараа хяналт, халамж анхаарал, гэр бүлийн гишүүдийн харилцаа хандлага чухал нөлөөтэй.
- ✓ Амьдралын боломж, боловсролын түвшин, нас, ажлын ачаалал, хүүхдээсээ тусдаа амьдардаг, хөдөө амьдардаг зэргээс шалтгаалан хүүхдийнхээ хичээл сурлагад анхаарч туслаж чаддаггүй.
- ✓ Дохионы хэлний мэдлэг дутмагаас хүүхэдтэйгээ ойлголцож, хичээлд нь дэмжлэг үзүүлж чаддаггүй.

Судалгааны арга:

- ✓ Асуулгын арга
- ✓ Ном зохиол унших буюу бүтээлийн судалгаа хийх
- ✓ Ажиглалт ба туршилтын арга
- ✓ Microsoft Excel, SPSS программаар боловсруулсан.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэх үйлийн онцлог

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэцийн үйл ажиллагаа энгийн, гадны нөлөөнд үзүүлэх хариу үйлдэл янз бүрийн, сэтгэцийн үйл ажиллагааны харилцан үйлчлэл өөрчлөгдсөн, сэтгэцийн хөгжлийн хурд, хэмнэлд өөрчлөлт ажиглагддаг. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд харагдах, дүрслэлийн сэтгэхүй давамгайлсан байдаг.



Судалгааны хэсэг

Ажиглалт, туршилтын аргаар 6-7 дугаар ангийн сурагчдыг судалсан ба ажиглалт туршилт 2018 оны 9 сараас эхэлсэн. Математикийн хичээлийг сонголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн онцлог буюу харааны хүртэхүйгээр хүлээж авах, даган дуурайх чадварт тулгуурлан хичээлийн хэрэглэгдүүн, биет зүйл, хялбар тооцоолол давамгайлсан сургалтаар үр дүнд хүрэх, мөн хүүхдүүд гэрийн

даалгавраа тогтмол хийж хичээлээ бататгахад эцэг эхчүүд, гэр бүлийнхэн нь хэрхэн тусладаг болохыг илрүүлэхийг зорьлоо.

Тухайлбал энэ хичээлийн жилийн 6 дугаар ангийн “Бүхэл тоон олонлог, зэрэг, язгуур” нэгж хичээлийг ээлжит хичээл бүрээр төлөвлөсөн бөгөөд “Бүхэл тооны нэмэх, хасах, үржих, хуваах үйлдэл” хичээлийг дараах арга зүйгээр туршин зохион явуулсан.

Бүхэл тооны нэмэх үйлдэл	
Бодох дүрэм (хэлбэр)	Жишээ.
$a + b = b + a$	Үйлдлийг сурагчид хялбар гүйцэтгэж байсан. $17 + 58 = 58 + 17 = 75$
$-a + b$ хэрвээ $a > b$ бол $-a + b = -(a - b)$	$-76 + 39 = -(76 - 39) = -37$ Их тооноос бага тоог хасч их тооны тэмдгийг тавьдаг.
$-a + b$ хэрвээ $a < b$ бол $-a + b = +(b - a)$	$-58 + 97 = +(97 - 58) = +39 = 39$ Их тооноос бага тоог хасч их тооны тэмдгийг тавьдаг. Эерэг тоог нэмэх тэмдэггүй бичдэг.
$-a + (-b) = -a - b$ $-a - b = -(a + b)$	Энэ хэлбэр нь үржих үйлдлийг сурсны дараа бодогдох бөгөөд хасах үйлдэлд давтагддаг. $-32 - 21 = -(32 + 21) = -53$
Бүхэл тооны хасах үйлдэл	
$a - b$ хэрвээ $a > b$ бол $a - b = a - b$	$76 - 39 = 37$ Үйлдлийг сурагчид хялбар гүйцэтгэдэг. Их тооноос бага тоог хасч их тооны тэмдгийг тавьдаг.
$a - b$ хэрвээ $a < b$ бол $a - b = -(b - a)$	$58 - 97 = -(97 - 58) = -39$ Их тооноос бага тоог хасч их тооны тэмдгийг тавьдаг.
$-a - b = -(a + b)$	$-67 - 54 = -(67 + 54) = -121$
$a - (-b) = a + b$	Энэ хэлбэр нь үржих үйлдлийг сурсны дараа бодогдох бөгөөд нэмэх үйлдэлд давтагддаг.
$-a - (-b) = -a + b$	Энэ хэлбэр нь үржих үйлдлийг сурсны дараа бодогдох бөгөөд нэмэх үйлдэлд давтагддаг. $-17 - (-86) = -17 + 86 = 86 - 17 = 69$ Их тооноос бага тоог хасч их тооны тэмдгийг тавьдаг.
Бүхэл тооны үржих үйлдэл	
$a \times b = b \times a = ab$	Үйлдлийг сурагчид хялбар гүйцэтгэж байсан. $9 \times 7 = 7 \times 9 = 63$
$-a \times b = -ab$ $a \times (-b) = -ab$	$-3 \times 4 = -12$ $3 \times (-4) = -12$
$(-a) \times (-b) = ab$	$(-5) \times (-9) = 45$
Хуваах үйлдэл үржих үйлдлийн адилаар биелэгддэг.	

Дээрх үйлдлүүдийг гүйцэтгэх дүрмийг өнгөөр ялган тохиолдол тус бүрээр үйлдлийг нүдлүүлэн жишээ даалгавар өгч ажиглахад сурагчид хялбар бодож тогтоож байсан улмаар илэрхийлэлд оруулан өгөхөд амжилттай гүйцэтгэж байгаа нь харагдсан. Энэ мэтчилэн “Алгебрийн илэрхийлэл” нэгж хичээлд энэ арга зүйг хэрэглэхэд сурагчид даалгаврыг хялбар гүйцэтгэж байсан ба тэдний нэгж хичээлийн үнэлгээ ихэнх сурагч дээр ахисан үзүүлэлт ажиглагдсан. (Зураг.1)

“Бүхэл тоон олонлог, зэрэг, язгуур” нэгж хичээлийн үнэлгээ													
№	Сурагчдын нэрс	Үнэлгээний шалгуур									Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
		Зэрэг сөрөг тоог тоон шулуун дээр тэмдэглэх	Зэрэг сөрөг тоог жиших	Бүхэл тоог нэмэх	Бүхэл тоог хасах	Бүхэл тоонуудыг уржүүлэх	Бүхэл тоонуудыг хуваах	Илэрхийллийн утгыг олох	Бүхэл тоог квадрат зэрэгт дэвшүүлэх	Тооноос квадрат язгуур гаргах			
		1	1	3	3	3	3	5	2	2	23	23	
1	6a1	1	1	2	2	2	1	2	2	1	23	14	60.9
2	6a2	1	1	1	1	1	0	1	2	0	23	8	34.8
3	6a3	1	1	3	3	3	3	4	2	1	23	21	91.3
4	6a4	1	1	1	1	1	1	2	2	1	23	11	47.8
5	6a5	1	1	2	2	2	2	3	1	1	23	15	65.2
6	6a6	1	1	3	2	1	1	2	2	1	23	14	60.9
7	6a7	1	1	2	2	2	0	2	1	1	23	12	52.2
8	6a8	1	1	3	3	3	3	3	2	2	23	21	91.3
9	6a9	1	1	3	3	2	1	2	1	1	23	15	65.2
10	6a10	1	1	3	2	2	0	1	2	2	23	14	60.9
11	6a11	1	0	2	2	2	1	1	2	2	23	13	56.5
12	6a12	1	1	1	2	1	0	2	2	2	23	12	52.2
13	6б1	1	1	3	2	2	1	2	2	2	23	16	69.6
14	6б2	1	1	3	2	2	2	2	1	1	23	15	65.2
15	6б3	1	0	2	2	1	0	2	1	1	23	10	43.5
16	6б4	1	1	2	2	2	0	2	1	1	23	12	52.2
17	6б5	1	1	3	2	2	2	2	2	1	23	16	69.6
18	6б6	1	0	2	2	2	1	1	2	1	23	12	52.2
19	6б7	1	1	2	2	2	0	1	1	0	23	10	43.5
20	6б8	1	0	1	1	1	0	1	1	0	23	6	26.1
21	6б9	1	1	3	3	2	2	1	1	0	23	14	60.9
22	6б10	1	1	3	3	3	3	4	2	1	23	21	91.3
23	6б11	1	0	2	2	2	1	2	2	1	23	13	56.5
Авах оноо		23	23	69	69	69	69	115	46	46	529		
Авсан оноо		23	18	52	48	43	25	45	37	24		315	
Гүйцэтгэлийн хувь		100	78.3	75.4	69.6	62.3	36.2	39.1	80.43	52.2			59.5

Зураг.1

Энэ хичээлийн хувьд гүйцэтгэлийн дунджаас харахад сурагчдын мэдлэг ойлголт 60%-тай үнэлэгдсэн. Нэгж хичээлийн үнэлгээг ахиулах цаашлаад сурагчдын сурлагын амжилтанд нөлөөлөх чухал үзүүлэлт бол сурагчдын гэрийн даалгавар гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулах гэж үзэн дээрх ангийн эцэг эхчүүдээс дараах байдлаар асуулга авч дүгнэхэд:

Та хэдэн настай вэ?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid 19	1	2.0	2.0	2.0
20	1	2.0	2.0	3.9
21	1	2.0	2.0	5.9
25	1	2.0	2.0	7.8
27	2	3.9	3.9	11.8
28	1	2.0	2.0	13.7
29	1	2.0	2.0	15.7
30	4	7.8	7.8	23.5
31	3	5.9	5.9	29.4
32	3	5.9	5.9	35.3
33	4	7.8	7.8	43.1
35	1	2.0	2.0	45.1
36	3	5.9	5.9	51.0
37	2	3.9	3.9	54.9
40	1	2.0	2.0	56.9
42	3	5.9	5.9	62.7
44	1	2.0	2.0	64.7
45	1	2.0	2.0	66.7
46	2	3.9	3.9	70.6
47	4	7.8	7.8	78.4
48	3	5.9	5.9	84.3
49	2	3.9	3.9	88.2
50	2	3.9	3.9	92.2
52	1	2.0	2.0	94.1
55	1	2.0	2.0	96.1
59	2	3.9	3.9	100.0
Total	51	100.0	100.0	

Statistics

Та хэдэн настай вэ?

N	Valid	51
	Missing	0
Mean		38.35
Median		36.00
Mode		30 ^a

a. Multiple modes exist. The smallest value is shown

Таны боловсролын түвшин...

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid 1	6	11.8	11.8	11.8
2	12	23.5	23.5	35.3
3	11	21.6	21.6	56.9
4	8	15.7	15.7	72.5
5	14	27.5	27.5	100.0
Total	51	100.0	100.0	

Та хэдэн настай вэ? * Таны боловсролын түвшин... Crosstabulation

Count

		Таны боловсролын түвшин...					Total
		1	2	3	4	5	
Та хэдэн настай вэ?	19	0	0	1	0	0	1
	20	0	0	1	0	0	1
	21	0	1	0	0	0	1
	25	0	0	0	1	0	1
	27	0	0	0	1	1	2
	28	0	0	0	1	0	1
	29	0	1	0	0	0	1
	30	1	2	0	0	1	4
	31	1	0	0	0	2	3
	32	1	1	0	0	1	3
	33	1	1	1	0	1	4
	35	0	1	0	0	0	1
	36	0	1	0	0	2	3
	37	1	0	1	0	0	2
	40	0	1	0	0	0	1
	42	1	0	0	1	1	3
	44	0	0	0	0	1	1
	45	0	0	0	1	0	1
	46	0	0	1	0	1	2
	47	0	0	2	2	0	4
	48	0	0	2	0	1	3
	49	0	1	1	0	0	2
	50	0	1	0	0	1	2
	52	0	0	0	0	1	1
	55	0	0	1	0	0	1
	59	0	1	0	1	0	2
Total		6	12	11	8	14	51

Та хүүхэддээ өдөрт хэдэн цаг зарцуулдаг вэ?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid а	17	33.3	33.3	33.3
б	8	15.7	15.7	49.0
в	14	27.5	27.5	76.5
г	12	23.5	23.5	100.0
Total	51	100.0	100.0	

Таны хүүхэд математикийн хичээлд сонирхолтой юу?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid а	16	31.4	31.4	31.4
б	10	19.6	19.6	51.0
в	9	17.6	17.6	68.6
г	16	31.4	31.4	100.0
Total	51	100.0	100.0	

Таны боловсролын түвшин... * Та хүүхдийнхээ математикийн гэрийн даалгавар хийхэд нь тусладаг уу? Crosstabulation

Count

		Та хүүхдийнхээ математикийн гэрийн даалгавар хийхэд нь тусладаг уу?				Total
		а	б	в	г	
Таны боловсролын түвшин...	1	2	1	2	1	6
	2	0	6	3	3	12
	3	0	3	2	6	11
	4	3	2	1	2	8
	5	2	8	2	2	14
Total		7	20	10	14	51



Хүүхэд математикийн хичээлийн гэрийн даалгавар хийхэд эцэг эхийн оролцоо хангалтгүй байна. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлд туслахад нь байнга бэрхшээл тулгардаг. Ихэнхдээ дохионы хэлээр харилцаж ойлголцож чаддаггүй нь харагдаж байна.

Ажиглалт туршилтаас үзэхэд хичээлийн явцад сурагчдын идэвх оролцоо, хичээлд хандах хандлага, сурагчийн ахиц амжилтад эерэг үр дүн гарсан хэдий ч эцэг эхчүүдийн хүүхэддээ зарцуулж буй цагийн ихэнх нь ахуйн хэрэгцээг хангахад зарцуулагдаж харин хичээл хүмүүжлийн ажилд бага хугацаа оногдож байна. Энэ нь хүүхдээсээ хол амьдардаг, хүүхдийнхээ хичээлд туслахад ажлын ачаалал их, дохионы хэлны мэдлэг, боловсролын түвшин зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Математикийн хичээл бидний өдөр тутмын үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах, ерхийн санхүүгээ төлөвлөхөд чухал нөлөөтэй байдаг. Эдгээр нь тооцоолол хийх, дүрс хэмжигдэхүүнтэй ажиллах, статистик өгөгдлийг задлан шинжлэх үнэлэн дүгнэх чадваруудад суурилдаг. Иймд сонсголын бэрхшээлтэй хүүхдийн математикийн боловсролд анхаарснаар шинжлэх ухааны суурь мэдлэгтэй болох, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, улмаар эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан амьдрах ухаанд суралцана. Иймд сонсголын бэрхшээлтэй хүүхдийн таних мэдэх үйлийн онцлог буюу харааны хүртэхүй болон орчны мэдээллийг ашиглан даган дуурайж маш хурдан суралцдаг чадварт нь тулгуурлан өөрт нь тохирсон мэдлэг чадварыг эзэмшүүлэн хөгжүүлэх нь чухал байна.

Түүнчлэн сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд эцэг эх, асран хамгаалагчийн анхаарал халамж, тусламж дэмжлэг, төдийгүй гэр бүлийн ахуй амьдрал, амьжиргааны түвшин, уламжлал,

эцэг эхийн мэргэжил боловсрол, ухамсар, харилцаа хандлага, соёл хүмүүжил нь хүүхэд ирээдүйд хэрхэн төлөвшиж яаж бие даан амьдрахыг тодорхойлно.

Цаашид багш сурган хүмүүжүүлэгчид бид сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн сурган хүмүүжүүлэх сэтгэлзүйн боловсролыг нэмэгдүүлэх улмаар сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон талт төлөвлөгөөт ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Тухайлбал дунд ангийн хүрээнд математикийн хичээлийг хичээлээс гадуурх үйл ажиллагаа, амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны хичээлийн цагтай уялдуулан эцэг эхийн оролцоог дэмжсэн мөн тэдний дохионы хэлний мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эцэг эх, хүүхдийн хамтын бүтээлч үйл ажиллагаанд тулгуурласан сургалтыг зохион байгуулах хэрэгтэй байна.

Ном зүй

1. МУБИС-ийн багш нарын хамтын бүтээл, “Багш боловсролын үндэс”. УБ, 2011.
2. Г.Батцэнгэл, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс”. УБ, 2018.
3. МУБИС-ийн багш нарын монгол хэлнээ хөрвүүлсэн хамтын бүтээл, “Тусгай хэрэгцээт боловсрол”, УБ, 2018.
4. О.Мягмар, “Судлаач багшийн гарын авлага”, УБ, 2011.
5. Т. Батболд, Д.Ариунаа, Б.Баярмаа, С.Батцэцэг, Д.Зол-Эрдэнэ, “Судалгааны арга зүй”, УБ, 2017.
6. Ч.Алтанцэцэг, Б.Оюунцэцэг, “Хэл ярианы тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөмж”, УБ, 2018.
7. Хаяаши Кензо, “Тэгш хамруулан сургах боловсрол”
8. Д. Эрдэнэчулуун, “Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө”, УБ, 2012
9. Ц.Гэрэлтуяа, Я.Цэвээнлхазал, Ц.Батжаргал, Д.Хорлоо, М.Ганцэцэг, Н. Нямсүрэн, Ч.Ганбилэг нарын хамтын бүтээл, “Хүүхдэд тохиолдох хөгжлийн бэрхшээл ба түүнийг засан сайжруулах аргууд”, (2004). Улаанбаатар. Өнгөт хэвлэл ХК.
10. Цахим эх сурвалж.

Хавсралт

Эцэг эхээс авсан судалгааны асуулга

Нас:.....

Боловсрол: /бага, суурь,
бүрэн дунд, мэргэжлийн, дээд, бус
ад...../

1. Та хүүхэддээ өдөрт хэдэн цаг зарцуулдаг вэ?
а) 6-8 цаг б) 4-5 цаг в) 1-3 цаг г) Хүүхэд дотуур байранд байдаг
2. Таны хүүхэд математикийн хичээлд сонирхолтой юу?
а) Маш их б) Бага зэрэг в) Огт үгүй г) Мэдэхгүй
3. Та хүүхдийнхээ математикийн хичээлийн гэрийн даалгавар хийхэд нь тусладаг уу?
а) Байнга б) Хааяа в) Үгүй г) Хичээлийг нь мэддэггүй
4. Хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийлгэхэд танд ямар хүндрэл тулгардаг вэ?
а) Дохиж ойлголцдогч хичээлийн агуулгыг мэддэггүй
б) Хичээлийг нь дохионы хэлээр ойлгуулж чаддаггүй
в) Хичээл болон дохиог аль алиныг мэддэггүй
г) Огт завгүй байдаг

Эцэг эхчүүдэд хүргэх зөвлөмж

Гэр бүл, эцэг эх нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэр бүлийн хүмүүжил сайн байх нь хүүхдийн төлөвшилд шийдвэрлэх үүрэгтэй.

- ✓ Хүүхэддээ өдөр бүр тогтмол цаг гаргаж халамж анхаарал тавьснаар таны хүүхэд нээлттэй, өөртөө итгэлтэй, ирээдүйн ажил мэргэжлээ оновчтой сонгож итгэл төгс амьдарна.
- ✓ Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахад дохионы хэлний мэдлэг чухал хэдий ч, аман болон бичгийн хэлний чадварт сургах нь бие даан нийгмийн харилцаанд оролцоход бэлтгэнэ.
- ✓ Математикийн хичээлийг судалсанаар математикч болох албагүй ч таны хүүхэд өөрт тулгарсан өдөр тутмын асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛД

Ц.Цэвэгмид¹, Б.Гэрэлтуяа²

¹Боловсролын хүрээлэнгийн ЭША

²БСШУСЯ-ны ЕБ-ын бодлогын газар

Хураангуй

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие бялдар, хөдөлгөөний ур, эв дүйг хөгжүүлэх нь хүүхдийн танин мэдэхүйн болон нийгэмшихүйн хөгжилд ихээхэн хувь нэмрийг оруулдаг. Биеийн тамирын хичээлээр хүүхдийн хөгжлийг дэмжихэд сургалтын хөтөлбөрийн агуулга, багшийн арга зүй, ур чадвар, биеийн тамирын хичээлд тохируулгат хэрэглэгдэхүүнийг ашиглах нь ихээхэн үр дүнтэй байна гэдгийг олон улсын болон манай улсын биеийн тамир, спортын салбарын эрдэмтэн, судлаачдын судалгаа харуулж байна. Иймээс энэхүү өгүүлэлдээ 25, 55, 63, 70 дугаар тусгай сургуулиудын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын хичээлийн өнөөгийн нөхцөл, байдлын талаар багш, эцэг эх, сурагчдаас авсан асуулгын судалгааны дүнд түшиглэн биеийн тамирын хичээлийн чанарт тулгамдаж байгаа асуудлыг дурдахыг зорьсон болно.

Түлхүүр үг:

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, биеийн тамирын хичээл, биеийн тамирын багш, сургалтын тохируулгат хэрэглэгдэхүүн

Оршил

Монгол улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн (2017.07.06) шинэчилсэн найруулгад “Боловсролын сургалтын байгууллага, суралцагчдын сургуулийн орчинд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, үндэсний стандартад нийцсэн биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх (9.2.3), “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход төрийн байгууллага, спортын холбоод дэмжлэг үзүүлж ажиллана(19.1), Спортын тэмцээн, наадам нь хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг бие эрхтэн, хөгжлийн онцлогийн адил түвшинд нь

өрсөлдүүлэх зарчмыг баримтална(19.2) гэж заасан байна.

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие бялдар, хөдөлгөөний ур эв дүйг хөгжүүлэх нь хүүхдийн танин мэдэхүйн болон нийгэмшихүйн хөгжил төлөвшилд биеийн тамирын хичээл чухал үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд Special олимпын төрлүүдээр амжилттай хичээллэж, алт, мөнгө, хүрэл медалиудыг хүртэж байгаа жишээ юм.

Өнөөдөр биеийн тамирын хичээлээр дамжуулан оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд биеийн ерөнхий хөгжлийг дэмжих дасгал хийх, алхах, гүйх, үсрэх харайх, бөмбөг шидэх дамжуулах зэрэг ерөнхий чадваруудыг хөгжүүлнэ. Хөдөлгөөний алдагдалтай, саажилттай, тулгуур мөчдийн хөдөлгөөн хязгаарлагдсан хүүхдүүдэд эмчилгээний биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр тухайн бэрхшээлийг засан сайжруулах чиглэлээр сургалтыг явуулдаг. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудад биеийн тамирын хичээлд хамрагдаж байгаа сурагчдын тоон мэдээллийг харууллаа.

Сургуулийн нэр	Нийт сурагчдын тоо	Бага анги		Дунд анги		Ахлах анги	
		БТ	ЭБТ	БТ	ЭБТ	БТ	ЭБТ
25 дугаар сургууль	324	120	78	103	23		
63 дугаар сургууль	239	116	34	123	34		
70 дугаар сургууль	449	193	63	193	-		
55 дугаар сургууль	482	195	54	169	13	47	4
Нийт хүүхдийн тоо	1494	624	229	588	70	47	4

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сурагчидтай хийсэн асуулгын судалгааг авч үзвэл:


Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 25,55, 63, 70-р сургуулийн биеийн тамирын боловсролын талаарх сурагчдын ойлголт, хандлагыг тодруулах

зорилготой тус судалгаанд 9–18 насны нийт 91 сурагч оролцсоноос бага боловсролд 37.3%, суурь боловсролд 45.1%, бүрэн дунд боловсролд 17.6% буюу хүйсийн хувьд эмэгтэй 38 сурагч болох 42%, эрэгтэй 53 сурагч болох 58% хамрагдсан тоон үзүүлэлт гарсан.

Энэхүү сурагчдаас авсан асуулга судалгааны агуулга нь: 1-т сурагчдын идэвх, сонирхолтой оролцдог хичээл судлагдахууныг тодруулах, 2-т биеийн тамир, спортын төрлүүдийн талаарх сурагчдын ерөнхий мэдлэг, сонирхол болон 3-т биеийн тамирын хичээлийн агуулга цаашлаад сургалтаас гадуурх цаг буюу сонгон, дугуйлангийн талаарх ойлголт, сонирхлыг тодруулах чиглэлтэй ажилласнаас доорхи үр дүн гарсан. Үүнд:


1. Сурагчдын идэвх, сонирхолтой оролцдог хичээл судлагдахуунд ‘Биеийн тамир 19%’ нэгт, ‘Математик 18.5%’ хоёрт, ‘Монгол хэл 15%’ гуравт, ‘Дуу хөгжим 10%’ дөрөвт, ‘Дүрслэх урлаг/Технологи 8%’ тавд, ‘Мэдээлэл зүй 7%’ зургаад, бусад судлагдахуунууд 22.5%-р эрэмблэгдсэн байна.

Идэвхтэй оролцдог хичээл судлагдахуун



2. Биеийн тамир, спортын төрлүүдийн талаарх сурагчдын ерөнхий мэдлэгт ‘Сагсан бөмбөг 26%’ нэгт, ‘Гар бөмбөг 18%’ хоёрт, ‘Теннис 15%’ гуравт, ‘Хөл бөмбөг 12%’ дөрөвт, ‘Гүйлт 7%’ тавд, бусад спортын төрлүүд 22%-р эрэмблэгдсэн бол сурагчдын сонирхдог спортын төрөлд ‘Сагсан бөмбөг 41%’ нэгт, ‘Гар бөмбөг 20%’ хоёрт, ‘Хөл бөмбөг 9%’ гуравт, ‘Теннис 8%’ дөрөвт, бусад спорт 42%-тай гарсан байна.


Мэддэг спортын төрөл




3. Биеийн тамирын хичээлийн агуулгад сагсан бөмбөг 30%, дасгал хөдөлгөөн 24%, гар бөмбөг 20%, буухай 18.5% болон бусад

агуулга 7.5%-ыг эзлэж байгаа тоон үр дүн илэрсэн бөгөөд сургалтыг ганцаарчилсан хэлбэрээр 14.6%, бүлгийн хэлбэрээр 85.4%-тай сурагчид хичээллэх сонирхолтой байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан болно. Цаашлаад сургалтаас гадуурх цаг буюу сонгон, дугуйлангийн талаарх ойлголтод 59.38% нь хичээллэж буй сонгон дугуйланд сайшаалтай ханддаг бол 21.8% нь тааламжгүй, 18.7% нь сонгон дугуйлан хичээллэдэггүй гэж хариулсан бөгөөд цаашид хичээллэхийг хүсэж буй секц дугуйланд ‘Сагсан бөмбөг 33%’ нэгт, ‘Гар бөмбөг 21.5%’ хоёрт, ‘Хөл бөмбөг 9%’ болон ‘Гимнастик 9%’-тай гуравт бусад төрлүүд 27.5%тай дурдагдсан байна.

Агуулга



Дугуйлан секц



Сурагчдын асуулга судалгааны үр дүн:

тус судалгаанд оролцсон сурагчдын идэвх, сонирхолтой оролцдог хичээл судлагдахууны нэгдүгээрт биеийн тамирын хичээл орсон нь тухайн хичээлд хандах сурагчдын эерэг хандлага, хэрэгцээ шаардлагыг илрүүлсэн. Харин биеийн тамирын хичээлийн агуулгад байгаа спортын төрлүүдээс нэрлэнэ үү гэсэн асуултад сагсан бөмбөг, волейбол төдийхнөөр нэрлэж, биеийн тамир, спортын тэр дундаа Special олимпийн төрлүүдийн талаарх ойлголт муу байна. Ширээний теннис, гимнастик, ахуйн хэрэгцээт дасгал, биеийн ерөнхий хөгжлийн дасгалын талаарх мэдлэг муу байгаа учир сонирхож хичээллэж мэдэхгүй байх, биеийн тамирын хичээл, дугуйлан секцийн хичээллэх цаг бага эсвэл байхгүй, байна гэсэн дүгнэлт гарч байна.

Цаашлаад биеийн тамир, спортын төрлүүдийн талаарх сурагчдын ерөнхий мэдлэг, сонирхол болон сургалтаас гадуурх цаг буюу сонгон, дугуйлангийн хувьд сурагчид сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг зэрэг багийн спортыг түлхүү нэрлэсэн бол гимнастик, теннис зэрэг ганцаарчилсан төрлийг мөн дурдсан болно. Биеийн тамирын хичээлийн агуулгад сагсан

бөмбөг, гар бөмбөг багтсан бөгөөд нэмэлтээр дасгал хөдөлгөөн, буухиа уралдааныг тусгадгийг дурдсан байна. Дээрх сурагчдын асуулга судалгаанаас харахад ерөнхий биеийн тамир, спортын төрлүүд дурдагдсаныг харж болох бөгөөд харин оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулгад шинжилгээ хийж үзэхэд ЕБС-ийн биеийн тамирын хичээлийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг шууд авч хэрэгжүүлсэн байна. Биеийн тамирын хичээлийн агуулгад оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хичээллэж амжилт гаргаж болох биеийн тамир спортын төрлийн агуулгаар баяжуулах, чанар үр өгөөжийг нэмэгдүүлэх, Special олимпийн төрлүүдээс агуулгад тусгах шаардлагатай байгаагаас гадна секц, дугуйлангийн чанарыг сайжруулах, тогтмолжуулах шаардлагатай нь харагдаж байна.


Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн биеийн тамирын багш нартай хийсэн асуулга судалгааны дүнгээс:

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 25,55, 63, 70-р сургуулийн биеийн тамирын хичээлийн талаарх багш нарын хандлагыг тодруулах зорилготой тус судалгаанд хүйсийн хувьд эмэгтэй 76.9%, эрэгтэй 23.1% нийт 19 биеийн тамирын багш оролцсоноос ажилласан жилийн хувьд 1-5 жил ажиллаж буй 47%, 6-10 жил 12%, 11-15 жил 12%, 20-с дээш жил ажиллаж байгаа 12% буюу зэргийн хувьд тэргүүлэх зэрэгтэй багш 20%, арга зүйч багш 27%, зэрэггүй багш 53% хамрагдсан тоон үзүүлэлт гарсан.

Ажилласан жил




Зэрэг



1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай хэрэгцээт боловсролын онолын болон практик туршлагатай эсэхэд 65% нь мэргэшсэн, 28% нь мэргэшээгүй, 7%

нь хариулаагүй бол, сурагчдын бэрхшээлийн талаарх ойлголт, тухайн хүүхдийн хэрэгцээнд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхэд бүрийн бэрхшээлийн талаар хийсэн судалгаа байгаа эсэхийг тодруулахад 93.8% нь судалгаа байдаг, 6.3% нь байхгүй гэж хариулсан байна.

Хүйс




■ Эмэгтэй ■ Эрэгтэй

- Сурагчдын бэрхшээлийн хэлбэрт нийцэх биеийн тамир, спортын төрлүүдийн талаарх ойлголтыг тодруулахад хөнгөн атлетик болон спортын бусад төрлүүдийг 5-23% хооронд дурдсан, үүнд сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, гандболл, теннис, гимнастик, гүйлт, усанд сэлэлт, бусад хөнгөн атлетикийн төрлүүдийг дурдсан. Цаашлаад бэрхшээлийн хэлбэрт нийцсэн спортын төрлүүдийг хэрэглэх боломжийг тодруулахад 100%-тай санал зөвшөөрсөн.
- Биеийн тамирын хичээлийн тулгамдаж буй асуудлыг тодруулахад 22.2% нь хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийгддэггүй байдал, 66.7% нь хүүхдийн бэрхшээлийн оношийн талаарх мэдлэг хомс байдал, 11.1% нь мэргэжлийн биш учир хүндрэлтэй байдал гэж хариулсан бол сургалт хөгжлийн дутмаг байдалд хариулт өгөөгүй байна. Түүнчлэн 85% нь хичээлийн хэрэглэгдэхүүний дутмаг байдал, 15% нь сэтгэл зүйн орчны асуудал бэрхшээлд хүргэдэг.


Багш нарын асуулга судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн биеийн тамирын багш нарын хувьд 1-5 жил ажиллаж буй багш 47% буюу зэрэггүй багш 53%-тай байгаа нь тус салбарт залуу мэргэжилтэн бэлтгэгдэж байгаа нь харагдаж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшлийн түвшний хувьд дундаж хэмжээнд бэлтгэгдсэн байна. Багшийн ажлын байранд тулгарч буй бэрхшээлд хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийгдсэн байдал, оношилгооны талаарх мэдлэг хомс байдал болон мэргэжлийн бус байдал нөлөөлж буйг дурдаад хичээлийн хэрэглэгдэхүүн болон сэтгэл зүйн орчин шаардлагатай байгааг тусгасан. Хичээлийн агуулгыг 100% санал

нэгтэйгээр хүүхдийн бэрхшээлийн хэлбэрийг харгалзан, хэрэгцээнд суурилсан байдлаар боловсруулах саналыг тусгасан боловч, агуулгын хувьд тусгай хэрэгцээт сургууль, нэн ялангуяа оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн биеийн тамирын хичээлийн агуулгад багтаж болох тусгай олимпийн спортын төрлүүдийг сургалтын хөтөлбөрт тусгах шаардлагатай байна. Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, хүүхдэд адил тэгш боломж олгох агуулга бүхий сургалтын хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй байгаа ч өөрсдөө практикт сургуулийн хөтөлбөр боловсруулж чадахгүй байгаа нь нууц биш байна. Биеийн тамирын хичээл дээр гарын доорх материал ашиглан тохируулгат хэрэглэгдэхүүнийг хийж, хичээл сургалтад ашиглах зайлшгүй шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна.



Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн биеийн тамирын хичээлийн талаарх эцэг эх, асран хамгаалагчдаас авсан асуулгын судалгааг авч үзвэл:

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 25,55, 63, 70-р сургуулийн биеийн тамирын хичээлийн талаарх эцэг эх, асран хамгаалагчдын санал, бодол, хандлагыг тодруулах зорилгоор авсан судалгаанд 30 хүртэлх насны 10.5%, 31-40 насны 60%, 41-50 насны 16%, 51-с дээш насны 13.5% буюу эмэгтэй 94%, эрэгтэй 6% буюу нийт 39 эцэг эх оролцсон байна.



1. Таны хүүхэд биеийн тамирын хичээлд оролцох сонирхолтой байна уу гэдгийг тодруулахад 100% сонирхолтой гэж

хариулсан бөгөөд хичээллэснээс гарах үр дүн нь 59% нь хөдөлгөөний эвсэлтэй болох, 30% нь бие даасан байдал нэмэгдэх, 11% нь нийгэмшлийн чадвар нэмэгдэнэ гэж хариулсан.

- Биеийн тамирын багш хүүхдийн сонирхол, бие бялдрын хөгжил, хөдөлгөөний ур эв дүйг хөгжүүлэх чиглэлээр хүүхэдтэй ажиллах байдлыг тодруулахад 28% нь дасгал хөдөлгөөний талаарх сургалтын арга зүйг сайжруулах, 35% нь хүүхдийн онцлог хэрэгцээнд тулгуурлан ажиллах арга зүйг сайн мэддэг байх, 14% нь багш хүүхдэд хайртай, хүндэтгэлтэй ханддаг байх, 7.5% нь хүүхэдтэй ганцаарчилж ажилладаг байх, 15.5% нь багшийн мэргэжлийн ур чадвар, харилцаа, дэмжлэг муу байгаа анхаарч ажиллах нь чухлыг дурдсан.
- Биеийн тамир, спортын ямар төрөл тухайн хүүхдэд тохиромжтойг тодруулахад 39% нь гар бөмбөг, 22% нь сагсан бөмбөг, 13% нь дасгал, бусад төрлүүд 24% -тай гарсан бол биеийн тамирын хичээлд оролцоход тулгарч буй хүндрэлийн талаар тодруулахад 32.5% нь тийм, 67.8% үгүй гэж хариулсан. Үүнээс үүсэж буй хүндрэлүүдэд хүүхдийн бэрхшээлтэй холбоотой хүчин зүйлс дурдагдсан болно.

Эцэг эх, асран хамгаалагч нарын асуулга судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагч 31-40 насны эцэг 60%, үүнээс эмэгтэй 94% байна. Тус судалгаанд оролцогчдын хувьд 100% хүүхэд нь биеийн тамирын хичээлд хамрагдах сонирхолтой бөгөөд биеийн тамирын хичээлээс хүүхдийн бие бялдар, нийгэмшил, бие хүний чадварууд нэмэгдэнэ гэдгийг тодотгосон. Цаашлаад биеийн тамирын багш хүүхэдтэй ажиллахдаа дасгал хөдөлгөөний талаарх сургалтын арга зүй, хүүхдийн онцлог хэрэгцээнд тулгуурлан ажиллах арга зүйг анхаарах нь зүйтэй гэж 77% нь үзсэн бөгөөд хүүхдэд тохиромжтой спортын төрөл нь сагсан бөмбөг болон гар бөмбөг дасгал хөдөлгөөнийг 74% чухалд тооцсон байна.

Онолын хувьд олон эрдэмтдийн судалгаагаар оюуны хөгжлийн бэрхшээлийн хөнгөн хэлбэрийн үед хүүхдийн бие бялдрын хөгжил, хөдөлгөөний хувьд харьцангуй чөлөөтэй байна. Хүндэвтэр хэлбэрийн үед бие бялдар, хөдөлгөөний алдагдал илт ажиглагдахаас гадна таргалах хандлагатай байна. Хүнд хэлбэрийн

бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөний болон тэнцвэрийн алдагдал ихээр ажиглагдах нь аливаа хөдөлгөөнийг даган дуурайж хийх чадвар муу байдаг онцлогтой холбоотой байна. Зарим тохиолдолд хөдөлгөөн нь эмх цэгцгүй, тэнцвэр муутай байх тохиолдол ч ажиглагдана гэжээ. Жишээлбэл:

1966 онд судлаач Б.Холл Дауны хам шинжтэй олон хүүхдийн бие бялдрын хөгжил, хөдөлгөөнийг судалж, дараах 10 шинж тэмдгийг хамгийн чухал гэж онцолсны тухайн хүүхдэд 4-5 нь илэрсэн тохиолдолд уг өвчний оношийг баттайд тооцож болно гэж үзжээ. Өргөн хавтгай нүүр 90 хувьд, морогийн рефлексгүйдэл 85 хувь, булчингийн сулрал 85 хувьд нүдний гадна өнцөг дээшээ ташуу 80 хувь, хүзүүний илүүдэл арьс 80 хувь, үеүд хэтэрхий хөдөлгөөнтэй 80 хувь, аарцаг ясны хэлбэр алдагдал 70 хувь, чихний хэлбэр буруу 60 хувь, чигчий хурууны муруйлт 60 хувь, алганы хөндлөн судал 45 хувь байна. Уруул зузаан, олон нугалаа үрчлээс бүхий том хэлтэй, хөдөлгөөний хувьд маш уян, үегүй мэт байна.

Харин саажилттай хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн онцлог нь биеийн ерөнхий үйлдэл болон хөдөлгөөний хэвийн бус байдал, булчингийн үйл ажиллагааны зохицуулга алдагдах, шөрмөсний рефлекс эрчимтэй сулрах, үндсэн рефлекс алдагдах, биеийн тэнцвэр алдагдах шинж тэмдгүүд байна. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудад дээрх бэрхшээлтэй хүүхдүүд анги нийтийн биеийн тамирын хичээлд хамтдаа хамрагддаг ч хүүхэд бүрийн бие бялдрын болон хөдөлгөөний хөгжлийг дэмжихүйц байдлаар хөтөлбөрийг боловсруулж чадахгүй байгаа, бага ангид ихэнхдээ биеийн ерөнхий хөгжлийг дэмжихүйц, хөдөлгөөний алдагдлыг засан сайжруулахад чиглэсэн агуулгыг сонгон оруулах нь олонтоо байна. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд суралцагчдын хөгжлийн бэрхшээлийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн агуулгыг сонгон, арга зүйн зөв шийдлийг тодорхойлж сургалтад хамруулах нь өнөөдөр тулгамдсан асуудлын нэг болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын хичээлд /боловсролд/ хамрагдах зайлшгүй шаардлагатайг заасан олон улсын гэрээ конвенци, актууд:

Нэгдсэн үндэсний байгууллагаас (2006) гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенци”-д дурдсанаар тухайн хүний чадамж, үнэ цэнэ, нэр хүндийг бүхий л түвшинд

хөгжүүлэх, цаашлаад хувь хүний онцлог, авъяас чадвар, бүтээлч байдал, сэтгэц болон бие бялдрын чадварыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай гэж заасан байдаг бөгөөд хүний эрх, нийгмийн эрх тэгш оролцоог хангахад тулгарах бэрхшээлийн талаарх хууль эрх зүй болон боловсролын стандартыг тусгасан байдаг.

Австралийн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх тухай хууль (1992)-д бэрхшээлээс үүдэлтэй аливаа ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоож нийгмийн гишүүдийн нэгэн адил эрх тэгш байх боломжийг бүрдүүлэх гэж заасан байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэгт одоо болон ирээдүйд учирч болох бэрхшээлийн хэлбэр болох бие бялдар, оюун ухаан, сэтгэц, мэдрэхүйн, мэдрэлийн гаралтай, сурах үйлийн бэрхшээл болон өвчин эмгэгээс үүдэлтэй байна.

Боловсролтой холбоотой: бэрхшээлээс үл хамааран боловсролын тэгш хүртээмжийг бий болгох;

Сургалтын хөтөлбөр, сургуулийн үйл ажиллагаатай холбоотой: сургалтын хөтөлбөр, хичээл, түүний агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах онцлог хэрэгцээг харгалзан, сургалтад оролцох адил тэгш боломжийг бүрдүүлсэн байх;

Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг биеийн тамирын бэлтгэлжилт, сургууль дахь спорт, спортын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх нь шууд утгаар ялгаварлан гадуурхалт бөгөөд харин биеийн тамир, спортын үйл ажиллагаанд ХБХ-ийг оролцуулах боломжийг бүрдүүлсэн боловч хөтөлбөрийн агуулга, хүүхдийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээг хангахуйц тохирох хэрэглэгдэхүүн, багшлах нөөц, дэмжлэг байхгүй нөхцөл нь шууд бус ялгаварлан гадуурхалт болно.

Америк

IDEA (2004) баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын боловсролын үйлчилгээг хүлээн авах, шаардлагатай нөхцөлд тохируулгат хөтөлбөр, орчинг хүртэх эрхтэйг дурдсан байдаг. Хэрвээ тухайн сурагч ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр суралцдаг тохиолдолд сургууль нь зайлшгүй биеийн тамирын тусгай хөтөлбөрийг тус сурагчид санал болгох үүрэгтэй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд ерөнхий биеийн тамирын хичээлд нэмэлт

хэрэглэгдэхүүн болон дэмжлэгийн тусламжтай болон тусламжгүйгээр аюулгүй, амжилттай оролцох, суралцах боломжтой байдаг боловч зарим нөхцөлд тохируулгат биеийн тамирын хичээлийн үр өгөөжийг дурдах нь зайлшгүй бөгөөд хүүхдийн одоогийн биеийн тамирын хичээлийн агуулга дахь гүйцэтгэл, биеийн тамирын хичээлийн хичээллэх хугацаа, агуулга дахь хэмжигдэхүйц зорилго, зорилт, хичээлийг зохион байгуулах байршил зэргийг урьдчилан тооцоолон тухайн багш нь тусгай хэрэгцээт боловсролын багийн гишүүн болж ажиллах шаардлагатай болно.

IDEA дахь биеийн тамирын боловсролын агуулга болон шаардлага нь дараах байдлаар томъёологдсон байна. Үүнд:

- Бие бялдар болон булчингийн чадварыг хөгжүүлэх
- Булчингийн суурь чадвар, хэв маяг болох тэнцвэр, хөдөлгөөн, бөмбөгтэй харьцах чадварыг хөгжүүлэх
- Усан спорт, бүжиг болон ганцаарчилсан / бүлгийн спортын төрлүүд/
- Тусгай биеийн тамирын хичээлд багшийн арга зүй ур чадвар, тохируулгат хэрэглэгдэхүүн ашиглах гэжээ.

Европ

Европын холбооны (2013) улсуудын биеийн тамирын боловсролын судалгаанд тусгай хэрэгцээт боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын асуудал нь хүүхдийн хэрэгцээнд суурилсан тохируулгат биеийн тамирын хөтөлбөр байх шаардлагатайг дурдаад үүнд Испани улсын сургалтын хөтөлбөр нь хүүхдийн хэрэгцээнд суурилсан, тэгш хамруулах боловсролын агуулга байгааг дурдсан бол Бельги улсад сургалтаас гадуурх үйл ажиллагааны олон хувилбарт хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад олгох боломжийг бүрдүүлсэн, Грек улсад хөгжлийн бэрхшээлтэй сурагч нь спортын аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох дэмжлэгийг үзүүлэхүйц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар бэрхшээлийн талаарх нийгмийн хандлагыг өөрчлөх, цаашлаад олон талт дэмжлэгийг бий болгоход голчлон анхаарч байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны дүнгээс харахад оюуны хөгжлийн бэрхшээл нь хүүхдийн бие бялдар, хөдөлгөөний ур, эв дүйн хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс биеийн тамирын хичээлээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие бялдрын хөгжил, хөдөлгөөний ур эв дүйг хөгжүүлснээр хүүхдийн оюун ухаан, хэл яриа-харилцаа, нийгэмших чадварууд нэмэгдэх боломжийг бүрдүүлнэ. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрийг хүүхдийн хөгжлийг дэмжихүйц, сурах, хөгжих арга барилын онцлогийг тусгаж боловсруулах, эмчилгээний биеийн тамирын хичээлийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийн чанарыг сайжруулах, багшийн заах арга зүйг сайжруулахад багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, багш нар хүүхдээ судлах, онцлогийг мэдэх, биеийн тамирын хичээлийн сургалтын тохируулгат хэрэглэгдэхүүнийг гарын доорх материалаар бэлтгэх, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллаж биеийн тамир, эмчилгээний биеийн тамирын хичээлийн чанарыг дээшлүүлэх хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Сургууль дээрх дугуйлан секц, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн хүүхдэд сонирхолтой, хэрэгцээг хангахуйц, хүүхдийг ялгаварлахгүй байх, хамтач, нөхөрсөг уур амьсгалыг төлөвшүүлэх, хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зэргийг анхаарч төлөвлөлтийг хийж, зохион байгуулах нь зүйтэй.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бэрхшээлгүй нийгмийг бий болгосноор хүн өөрийн хөгжлийн боломжит дээд нөхцлийг давуу тал болгон хөгжүүлж, гэр бүлийнхээ цаашлаад нийгмийнхээ төлөө амжилттай ажиллаж, амьдарч чадна.

Ном зүй:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”/2006/
2. “Бага, дунд боловсролын тухай хууль” /2013 оны нэмэлт өөрчлөлт/
3. “Биеийн тамир, спортын тухай хууль” /2017 оны шинэчилсэн найруулга/
4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” /2015/
5. “Инчеоны тунхаглал”. Тогтвортой хөгжлийн зорилго-4
6. “Тусгай сургуулиудын биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөр”
7. “Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр” / биеийн тамирын хичээлийн/
8. “Боловсролын хүрээлэнгээс хийсэн тусгай сургуулиудын биеийн тамирын хичээлийн өнөөгийн нөхцөл, байдлын судалгаа”-ны зарим дүнгээс /2017/
9. Guidebook for special education teachers /2014/

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГИЙН ДАВУУ ТАЛЫГ СУРГАЛТАД ХАРГАЛЗАХ НЬ

Б.Сарантуяа, Л.Мөнгөнцэцэ

Хураангуй:

Хүүхдийн хөгжлийг дэмжиж, ойлгож ажиллахын нэг үндэс нь сэтгэл зүйн туршилт судалгаа, оношлогоон дээр тулгуурлан ажиллах явдал билээ. Хүүхдийн сэтгэцийн хөгжлийн ялгаатай байдлыг танин мэдэж сургалтандаа ашиглах явдал нь сэтгэл зүйн туршилт судалгаагаар илрэн гардаг учраас орчин үеийн багш судлаач байх шаардлага өсөн нэмэгдсээр байна. Тиймээс сэтгэл зүйн туршилт, судалгаа нь сурган хүмүүжүүлэх ажлын үндсэн хэсэг, суурь нь байх ёстой.

ТҮЛХҮҮР ҮГ:

Суралцагч, Аутизм, Судалгаа, Үр дүн, Аутизмтай хүүхдийн хөгжил, Сурлагын амжилт / үр дүн/

ОРШИЛ

Дэлхий дахинаа багш бэлэн мэдлэгийг суралцагчдад олгох бус судлаач байх ёстой гэсэн үзэл хандлага гарч ирсэн. Багш судлаач байх тухай ойлголт өргөн утга агуулгатай бөгөөд тухайлбал нэг талаас суралцагчдын онцлог тэдний сурах чадвар, хэрэгцээ зэргийг судлах нөгөө талаас сургалтын явцад гарч буй зөрчлүүд түүний шалтгаан үр дагаварыг илрүүлэх зэрэг сургуулийн өдөр тутмын амьдрал, сургах болон сурах үйл ажиллагааны явцад гарч буй аливаа асуултыг олж, түүнийг шийдвэрлэх гэх мэт янз бүр байна.

Хүүхдийн хөгжлийн сэтгэл судлал нь хүүхдийн сэтгэцийн дотоод ертөнцийг танин мэдэх, сэтгэцийн хөгжлийн онцлогийг судлан тодорхойлох, тэдэнтэй ажиллах арга барилыг эзэмшихэд чухал үүрэгтэй шинжлэх ухаан юм.

Багш сурган хүмүүжүүлэгчид энэхүү шинжлэх ухааныг судалснаар нас бүрийн сэтгэцийн онцлогийг мэдэхийн хамт тэдэнтэй ажиллах арга барил эзэмшиж авна.

ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн хүн амын нэг хувь нь аутизмын эмгэгтэй байна. Аутизмын эмгэг нь дараах шинж тэмдгээр нийтлэг илэрдэг байна. Үүнд:

Хэлд орохгүй байх, өвөрмөц үйлдэл хийх, хүний нүд рүү тогтож харахгүй, зөвхөн хүссэн зүйлээ л сонирхох, нэрээр нь дуудахад харахгүй байх, өвдөлт бага мэдрэх, бусдын хэлснийг давтах гэсэн түгээмэл шинжээр илэрдэг ажээ. Энэ эмгэг эрэгтэй хүнд дөрөв дахин их тохиолддог байна. АНУ-д хийсэн судалгаагаар 59 хүүхэд тутмын нэг нь аутизмтай гэдгийг тогтоожээ. Судалгаанаас үзвэл манай улсын хэмжээнд 18600 хүн аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлалтай гэсэн албан бус тоо байдаг аж. Гэсэн хэдий ч энэ оны шинэчлэгдсэн судалгаагаар нийт 763 хүн аутизмын хүрээний эмгэгтэй гэдгийг гаргажээ. Үүнээс 723 буюу 90-ээс дээш хувь нь 2-15 насных, үлдсэн 40 хүн нь 16- 34 насныхан байгаа аж. Энэ тоог зөвхөн бүртгэлтэй байдаг хүмүүсийг нэгтгэж гаргажээ. Харин бүртгүүлээгүй үлдсэн хэчнээн хүн байгааг мэдэхгүй гэдгийг судлаачид хэлж байлаа. Аутизм судлалын хүрээлэнгийн мэргэжилтэн Б.Оюунчулуун “Аутизмын чиглэлийн анхны төрийн бус байгууллага 2013 онд байгуулагдсан. Давхардсан тоогоор 2017 онд 250, 2018 онд 470 нь аутизмын хүрээний эмгэгтэй хүмүүс байгааг тогтоосон. Энэ жил бараг хоёр дахин нэмэгдсэн байна” гэв. 2011 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс энэ эмгэгийн анхны аутизмын оношийг тавьж байжээ. Тус төвд оношлогдсон 600 орчим хүүхэд бий бөгөөд Япон, Солонгос, Тайланд, Австралиас оношлогдож ирсэн цөөхөн хүүхэд байдаг аж. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэг ч аутизмтай хүүхдийг хүлээж авдаггүй байна. Учир нь, ийм төрлийн өвчтэй хүүхэд тус бүрт нэг багш шаардлагатай байдаг тул одоогоор тэднийг авах боломжгүй юм. Тэрчлэн тусгай оношилгоо эмчилгээний эмнэлэг, мэргэшсэн эмч ч байхгүй ба энэ төрлийн тусламж үйлчилгээ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хамаарч байгаа аж. Тиймээс энэ төрлийн эмгэгтэй хүүхдүүдийг эрт нийгэмшүүлэх тал дээр эрүүл мэндийн салбараас онцгойлон анхаарах хэрэгтэй байгаа талаар өвчтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүд хэлж байгаа юм.

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙГ ЭРТ ОНОШЛУУЛЖ, СУРГАЛТААР ХӨГЖҮҮЛЖ ЧАДВАЛ ЭНГИЙН ХҮНИЙ ЧАДВАРЫН 80 ХУВЬД ДӨХӨЖ ОЧИХ ЧАДВАРТАЙ БОЛДОГ.

Хүүхэд хэдийд хаана хөгждөг вэ?

Сурагч ямар тохиолдолд сурах үйлдлийг ухамсартай, дуртай хийдэг вэ?

Багш бичиг цаасанд дарагдах биш хичээлийн өмнө, хичээлийн явцад, хичээлийн төгсгөлд хүүхдээ судлах, судалгаан дээрээ үндэслэн сургалтын арга, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгох, ажиглалт хийн сонирхолд нь тулгуурлан мэдлэг чадвар олгох үйл хийх нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх том алхам юм.

ЗОРИЛГО:

Аутизмтай хүүхдийн давуу болон сул талыг судалж ялгаатай байдлыг харгалзан хөгжлийг дэмжиж, ойлгож давуу талыг ашиглан сургалтанд тэгш хамруулахад оршино.

ЗОРИЛТ:

- Аутизмтай хүүхдийг судлах
- Хөгжлийг нь дэмжих, ойлгох
- Ялгаатай байдлыг сургалтад харгалзах
- Тэгш хамруулах

СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ

Судалгааны арга зүй: Суралцагсдыг ажиглан судлаж, давуу тал дээр тулгуурлан хөгжүүлэх.

Судалгааны объект: Аутизмтай суралцагч
СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ ДАВУУ ТАЛЫГ АШИГЛАН СУРГАЛТАНД ХАРГАЛЗАХ НЬ


- ✓ Америкийн аутизмтай хүүхдэд бүтэн хотын зургийг ганцхан удаа харуулахад нэг ч байшин алдалгүй зурсан.
- ✓ Дэлхийн сонгодог хөгжимчин Вольфганг Амадей Моцарт
- ✓ Америкийн алдарт жүжигчин Томас Круз Мапотер
АУТИЗМТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ НЬ
АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙН АНХААРАЛ ТӨВЛӨРӨЛТ МАШ СУЛ БАЙДАГ УЧИР ТОГЛООМЫН АРГААР ДАМЖУУЛАН СУРГАХ НЬ ИЛҮҮ ҮР ДҮНТЭЙ ГЭЖ ҮЗСЭН.

Жишээ нь: Математик - Машинаар тоглох дуртай бол машины өнгийг асуух, ижил болон өөр өнгийн машинтай харьцуулан өнгийг

таниулах. Мөн машин хэдэн дугуйтай вэ? Хамтдаа тоолоорой гэх мэт тоо тооллын аргыг ашиглан нэмэх хасах үйлдлийг тогтоолгон аажмаар суулгаж сурган /бага багаар цагаа уртасгах/ бичүүлж, анхаарал төвлөрлийг сайжруулж ахуйн баримжаа олгох тал руу нарийн чиглүүлж бодит юмс дээр тулгуурлан сургалтын үйл ажиллагааг явуулах нь илүү үр дүнтэй. Монгол хэл: Юмсыг хооронд нь харьцуулах тохируулах аргыг ашиглан, карт болон дүрсийн аргаар сургалтын үйл ажиллагааг явуулах нь үр дүнтэй.

Судалгаа

ЕБС-ийн бага ангийн 5-32 жил ажилласан 20 багшаас дараах судалгааг нээлттэй асуулгаар авсан болно.



2019 оны 292 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам батлагдсанаар Налайх дүүргийн хэмжээнд 100% хэрэгжиж байна.



Аутизмын хүрээний эмгэгийн ерөнхий 6 шинжээр асуулга авахад хамгийн өндөр хувьтай буюу 36% нь дуу авианы өнгө ритм хэвийн бус байгаа нь хичээл явуулахад их нөлөөлж байгаа нь харагдаж байна. Аутизмын түгээмэл хэлбэр болох хэтэрхий ганцаардмал шинж нь асуулгын 29%-г эзэлж байгаагаас үзэхэд анги бүрд 1-3 суралцагч байгаа юм. Үүнээс үзэхэд оношлогдоогүй аутизмын хүрээний эмгэгтэй суралцагч байж болзошгүй гэж үзэж байна.

Дээрх шинж илэрсэн сурагчийг хэрхэн оношилж байна вэ? Бэрхшээл мөн үү?







Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан багш нарын 10% нь бэрхшээл биш, 15% нь тийм суралцахуй бэрхшээл, 75% нь мэдэхгүй гэж хариулсан нь аутизмын хүрээний эмгэгийн талаарх мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Голомт цогцолбор, Эрдмийн оргил цогцолбор, 109 дүгээр бага сургууль, лабортори 119 дүгээр сургуулийн нийт 5-32 жил ажилласан 30 багшаас түүврийн аргаар асуулга авахад аутизмын хүрээний эмгэгийн шинж илэрсэн суралцагч 1 ангид 1 хүүхэд дунджаар илэрч байна. Тус хүрээний эмгэг нь бага насандаа оношлогдохгүй явсаар 3-5 дугаар ангид суралцах насандаа хүнд хэлбэрээр илэрч байгаа нь судалгаанаас харагдаж байна. Манай төвийн хэмжээнд аутизмын хүрээний эмгэгтэй 5 суралцагч 2017 оноос хойш элсэн суралцаж байгаа. Тэдгээр хүүхдүүдийн аутизмын хүрээний эмгэгийг эрт илрүүлээгүйн улмаас сургууль завсардаж, суралцахуйн анхан шатны чадваргүйгээр манай төвд хамрагдаж давуу тал дээр нь тулгуурлан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж ажилласанаар ахиц гарч байна.

Жишээ нь: Суралцагч Н.Ө 10 настай /хүндэвтэр/ 2019 оны 09 сарын 01-ий өдөр элссэн. Суралцагч Н.Ө нь анх суралцахуйн анхан шатны мэдлэггүй, өнгө ялгахгүй, орон зайн баримжаагүй, үзэг барих чадваргүй, нийгэм ахуйн баримжаа маш муу суралцагч элсэн орсон.

Багш, эцэг эх, сурагч хамтран ажилласанаар 1 дүгээр улирлын төгсгөлд 1-4 хүртэлх тоог бие даан бичиж, тоолж, улаан, хар, цагаан өнгүүдийг ялган таньж, нийгэмшихүйн тал дээр ахиц гарч, анги хамт олноос найзаа сонгон нөхөрлөж, аливааг танин мэдэх тал дээр суралцаж байна. Жишээ нь: Өглөө бүр багштайгаа мэндлэн ангидаа орж ирдэг бөгөөд ойр зуурын энгийн яриагаар харилцдаг болсон.



Суралцагч М.М 9 настай /хүнд/ 2017 оны 09 сарын 01-ий өдөр элсэн суралцсан СӨБ, ЕБС-д хамрагдаж байгаагүй. Суралцагч М.М нь зохисгүй үйл хөдлөл, үг яриа, дуу авиатай. Нийгэм ахуйн баримжаа асар муу, ээж, ааваас бусадтай харилцаа үүсгэдэггүй, шалтгаангүй чангаар орилон, хувцасаа нэгд нэгэнгүй тайлах бөгөөд сурах арга барил эзэмших анхан шатны мэдлэггүй суралцагч байсан. 2017-2019 онуудад ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг явуулсанаар танхимд ирж суралцах сонирхолтой, зөв бурууг мэдэж, анги хамт олонтойгоо зөв харилцаж, бие даах чадварт суралцан үзэг зөв барих, зурлага зурах чадварт суралцаж байна.

Үүнээс үзэхэд: Иргэд, олон нийт аутизмын хүрээний эмгэгийн 8 шинжүүдийг мэдэж авснаар хүүхдээ эрт оношлох, улмаар шаардлагатай боловсролын үйлчилгээг тохирсон хэлбэрээр авах боломжтой юм. Үүний үр дүнд энгийн хүний чадварын 80%-д дөхөх боломжтой.

63 дугаар тусгай сургуулийн анги дүүргэлтэд 1 ангид аутизмтай хүүхэд 2-оос илүүгүй байснаар удаан хугацааны туршид үр дүн гарсан. Үүнд: эцэг эх, асран хамгаалагчийн хариуцлага, эрт оношлогоо, багшийн ажиглалт судалгаа, давуу тал дээр нь тулгуурлан ажилласан байдал юм. судалгааны явцад манай төвийн бага боловсрол ангид 4 суралцагч хамрагдаж байна. Ингэснээр аутизмтай хүүхдийг эрт оношлох, хөгжлийн явцыг дэмжих, боловсролд тэгш хамруулах боломж нээгдэнэ. Дүүргийн хэмжээнд төрийн болон төрийн бус ЕБС, АБ-НТБТөвд нийт 103 хүүхэд суралцаж байгаагаас 42 хүүхэд буюу 40,7% нь манай төвд гэрээр болон танхимаар боловсролын үйлчилгээ авч байна. Тэдгээрийн 27 суралцагч буюу 64% нь хүнд хэлбэрийн бэрхшээлтэй байна. Үүнээс үзвэл дүүрэгт зайлшгүй тусгай сургууль байх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ЦААШИД ДЭВШҮҮЛЭХ САНАЛ:

- Аутизмын хүрээний эмгэгийг ЕБС-ийн багш нар судлах, анхан шатны мэдлэгтэй байх, эцэг эхчүүдийг чиглүүлэх
- Аутизмын хүрээний эмгэгийг иргэдэд таниулах
- Тусгай хэрэгцээт сургууль /танхим /

НОМ ЗҮЙ:

- БСШУСЯ-ны сайдын тушаал А-43
- “Хүүхэд бүрийн хөгжил” туршлага амжилт үр дүн **БСШУЯ** УБ 2016
- “Тэгш хамруулах боловсрол” ADRA Mongolia 2016 УБ
- “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй” UNICEF НҮБ-ын хүүхдийн сан УБ 2019
- “Тэгш хамруулах боловсрол” БСШУСЯ УБ 2019
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ” ADRA Mongolia УБ 2016
- “Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй” БСШУЯ УБ 2007
- “Суралцахуйг дэмжсэн хичээл үйл ажиллагааны төлөвлөлт” сайн хичээл үйл ажиллагааны улсын зөвлөгөөн
- News.gogo.mn
- www.itpd.mn
- www.legalinfo

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ

М. Номин-Эрдэнэ¹, Г. Бадамханд¹

¹Монголын үндэсний их сургууль- Хууль зүйн удирдлагын их сургууль

Түлхүүр үг:

Сургалтын орчин, ном сурах бичиг, нэмэлт хөтөлбөр, орчин, боловсон хүчин

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлыг хөндөн илтгэлээ бэлдлээ. Би ахлах ангийн сурагч байхдаа хөгжлийн бэрхшээлтэй дүү нар, нас чацуу найзууд маань яах суралцдаг юм бол? Гэж боддог байсан. Яг л бид нар шиг орчинд, ном сурах бичигтэй, олон найзуудтай, өдөр бүрийг ангидаа хөгжилтэй өнгөрүүлдэг байх хэмээн бодож байсан. Харин дээрх асуултынхаа хариултыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн орчинд очиж байж л бүр илүү ихээр ойлгож эхэлсэн. Тэд жирийн хүүхдүүд шиг гүйж харайхгүй, хөдөлгөөний асар их хорионд байдаг, хоорондоо хүссэнээрэй ярилцаж, бие биенээ харж мэдэрч чаддаггүй, хүссэнээрэй санаа бодлоо хэлж, саналаа дэвшүүлэх нь тэр бүр тохиолдоод байдаггүй ийм л хүүхдүүд. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмээс гадуурахлаа гэхээс илүүтэй ойлгодог хүмүүс цөөн байдаг болохоор тэрүүхэн алга дарамхан хүрээлэлд суралцах, амьдрах орчин нь байдаг энэ улсын эд, эсүүд.

Тэгвэл монгол улсад нийт 105730 / зуун таван мянга долоон зуун гуч/ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг буюу хүн амын 3.5% нь юм. Түүнээс 17626 / арван долоон мянга зургаан зуун хорин зургаа/ хүүхдүүд байдаг бол үүний 16373/арван зургаан мянга гурван зуун далан гурав/ нь ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүд байдаг байна. Харин ерөнхий боловсролийн сургуульд суран боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн тоо 1600 /мянга зургаан зуу/ буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 9.7% нь юм.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хөндөж, тэдний эрх тэгш онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт хэрэгжиж буйг судалж тэдний өчүүхэн ч гэсэн дуу хоолой болоход оршино.

Судалгааны зорилт:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцаж байгаа хүүхдүүдийн суралцах эрх зөрчигдөж байгаа эсэхийг хөндөж;
- Тэдний суралцах орчин, ном сурах бичгийн хүртээмжтэй байдлын дурдах;
- Нийгэмд /боловсролын салбарт/ эзлэх байр суурийг нэмэгдүүлэх;

Судалгааны арга зүй: зайнаас тандан судлах, түүвэрлэх арга

Судалгааны үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хөндөж, зөрчигдөж буй эрхийг бусдад таниулж, тэдний нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн¹ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Сүрье зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд” энэ хуулийн 3 дугаар зүйлд “заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд тэднийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ” хэмээн заасан байдаг. Тэгвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох эрхийг төр хэрхэн хангаж, хамгаалдаг вэ?

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь Бага, дунд боловсролын тухай хуульд² зааснаар “Ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бага, дунд боловсрол эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд суралцах нөхцөл бололцог хангахад анхаарч ажилладаг.
2. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд, дээд боловсрол олгох асуудлыг Боловсрол шинжлэх ухааны яам хариуцдаг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлж хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээ үйлчилгээг Хөдөлмөрийн яам хариуцдаг.

¹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль;

² Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага дунд боловсролын тухай хууль;

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээний хүрээ, төрөл, чанарыг нэмэгдүүлэх тэдэнд үзүүлэх үйлчилгээг илүү боловсронгуй болгох, бие даан ажиллах, амьдрах чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд төр засгаас дараах байдлыг онцгойлон авч үзэж, анхаарлаа хандуулж байна. Үүнд:

- Эрх зүйн орчны шинчлэл
- Ном сурах бичиг
- Боловсон хүчин
- Сургалтын орчин

Эрх зүйн орчны шинчлэл

Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид цалингийн нэмэгдэл олгох, мөн тусгай мэргэжлийн багш, туслах багш, сэтгэл зүйч, сувилагч, нийгмийн ажилтан ажиллуулах олон асуудлыг шийдвэрлэсэн.

Ном, сурах бичиг

2012 онд тусгай хэрэгцээт боловсролын сурах бичгийг анх хэвлэн гаргаж байсан.

Боловсон хүчин

Бага, дунд боловсролын тухай хуульд тусгай сургуулийн бага ангиуд туслах багштай болсон. Ингэснээр ангийн багш хичээл сургалтандаа илүү их ахнаарч, нэг сурагчид зарцуулах цаг ихсэхээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тавих анхаарал халамж сайжрах зэрэг давуу талтай.


Сургалтын орчин


Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бүх сурагчдын үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан байдаг. Мөн тусгай 6 сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд тохирсон зориулалтын автобусаар хангах арга хэмжээг авч эхлэсэн.

Үр дүн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох сургалтын орчин, тэдэнд зориулсан ном сурах бичгийг тандах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай сургууль болон багш ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэд буюу 46 /18 багш 28 сурагч/ хүнээс судалгаа авсан.

Сурагчдаас авсан судалгаагаар:





Судалгаанаас үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан номын тоог ихэсгэж, өөр утга агуулгатай уран зориолын, танин мэдэхүйн ном хэвлэгдээсэй хэмээн хүсдэгээс гадна сургууль орчмын хоорондийн зүй зохисгүй харилцааг эерэг болж биднийг энгийн хүмүүс хараад гайхаж цочирддог биш ойлгодог байгаасай хэмээн хүсэж байна гэж хэлсэн. Нөгөөтэйгүүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй харилцах харилцааг нийгэм даяар эерэг болгохын хувьд энгийн хүүхдүүдийн ойр дотны хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зөвөөр ойлгуулж тайлбарлаж өгөх

нь зөв хэмээн үзэж байна. Боловсролын тал дээр гэвэл багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эзэмших ёстой боловсролоо хангалттай сурч байгаа хэмээн үздэг хэдийч тэд нэмэлт хөгжлийн хөтөлбөрүүд оруулж өгөөсэй хэмээн боддог гэж судалгааг бөглөж байсан. Тэхээр эрх бүхий байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бага, дунд боловсрол эзэмшүүлэхээс гадна бие даан амьдрах ухаан, өөр өөрийн онцлог шаардлагад нийцсэн хөтөлбөрүүдийг нэмэлтээр оруулж өгөх нь зүйтэй хэмээн үзсэн.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАГЧДЫГ ХҮЛЭЭН АВАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СОЁЛЫН ОРЧНЫ БЭЛЭН БАЙДАЛ

Г.Жаргалмаа¹, А.Очбадрал¹, Д.Одгэрэл (Ph.D)²

¹Хараат Бус Судалгааны Хүрээлэн,

²Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Түлхүүр үг:

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэд, тэгш хамруулах боловсрол, боловсролын соёлын орчин

Хураангуй

Тусгай хэрэгцээтэй сурагчдыг хүлээн авах сургуулийн тэгш хамруулах соёлын орчны бэлэн байдал, түүний зэрэг өөрчлөлт рүү чиглэсэн ажлуудыг авч хэрэгжүүлэхгүйгээр тэгш хамруулсан бодлого болон практик үйл ажиллагааны талаар ярих боломжгүй юм. Олон улсад ерөнхий боловсролын салбарын өөрчлөлт шинэчлэлд хамгийн өргөн ашиглагддаг Тони Бүүт, Мэл Аинсков нарын боловсруулсан “Тэгш хамруулах зарчимд суурилсан үйл ажиллагааны индекс”-д тодорхойлсон тэгш хамруулсан соёлын орчныг тодорхойлж болох суурь шалгуур үзүүлэлтийг ашиглан Нийслэлийн болон орон нутгийн 545 суралцагчийн эцэг эхийн байр сууринд үндэслэн сургуулийн соёлын орчныг хэмжих оролдлогыг хийж гүйцэтгэлээ. Сургуулийн соёлын орчныг тодорхойлж болох наад захын суурь үзүүлэлтүүдийн дагуу судалж үзэхэд сургуулийн соёлын орчин тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хүлээн авахад бэлэн бус байгаа үр дүн гарсан. Тэр дундаа сургуулийн орчинд бусдын ялгаатай байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхлаас хамгаалах сургуулийн соёлын орчны дархлаа хамгийн сул байна.

Үндэслэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журам батлагдан, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж байна. Тус тушаал батлагдах хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах эрхзүйн орчныг бүрэн тодорхойлоогүйгээс салбарын мэргэжилтнүүд, эцэг эхчүүдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрхэн, хаана сургах талаар ойлголт харилцан адилгүй байлаа.

2018 онд Хүүхдийг ивээх сангийн гүйцэтгэсэн судалгаа (ХИС, 2018)-ны дүнгээр судалгаанд хамрагдсан тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эхийн (N=376) 82 хувь нь хүүхдээ тусгай сургуульд хамруулж чадвал хүүхэд нь илүү үр дүнтэй суралцаж чадна, 68 хувь нь тусгай сургуульд бусдын дарамт, доромжлолоос ангид байж чадна гэж хариулсан байна. Харин судалгаанд хамрагдсан багш нарын (N=254) 80% нь хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг ангидаа авахад бэлэн биш гээд түүний гол шалтгаан нь аргазүйн хувьд бэлтгэгдээгүй, үр чадвар, туршлага дутмаг гэсэн хариултыг өгсөн байна. Эдгээр хариулт нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг үр дүнтэй ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д тэгш хамруулан сургахын тулд олон талын бэлтгэл ажил шаардлагатайг харуулж байна. Өмнө хийгдсэн олон судалгааны үр дүнгээр сургуулийн дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүн, материал хүрэлцээгүй, сургалтын орчин бэлэн биш болохыг харуулсан байдаг. Гэвч Мэл Аинсков, Тони Бүүт нарын “Тэгш хамруулах зарчимд суурилсан үйл ажиллагааны индекс”-д авч үзсэнээр сургуульд тэгш хамруулах соёлын орчныг нэн тэргүүнд бүрдүүлэх нь сургуулийн орчин дахь тэгш хамруулах хөгжлийн суурь болдог гэж үзсэн байна. Гэвч тусгай хэрэгцээтэй хүүхдийг хүлээн авах, хамт олныхоо нэг хэсэг болгох, тэгш хамруулсан үнэт зүйлийн төлөвшил ямар түвшинд байгааг авч үзсэн судалгааны ажил ховор байгаа бөгөөд тус хэрэгцээнд үндэслэн энэхүү ажлыг гүйцэтгэв.

Тус өгүүллийг Азийн хөгжлийн банкны захиалгаар 2019 онд гүйцэтгэсэн “Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь” төслийн судалгааны үр дүнд ашиглан боловсруулав.

Судалгааны зорилго, зорилт

ЕБС-уудын тусгай хэрэгцээтэй хүүхдийг хүлээн авах тэгш хамруулах боловсролын соёлын орчны бэлэн байдлыг үнэлж тодорхойлоход оршино. Үүний тулд дараах зорилтуудад хүрэхээр ажилласан:

1. Сонгогдсон орон нутаг дахь 6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийг илрүүлэх.
2. Үйлдлийн чадварын хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдүүдийн хамран сургах тойргийн ЕБС-ийг “Тэгш хамруулсан соёлын орчныг хэмжих шалгуур үзүүлэлтүүд”-ээр үнэлж тодорхойлох.
3. Тэгш хамруулах боловсролын соёлын орчны шалгуур үзүүлэлтийн үр дүнг судалгаанд оролцогчдын нийгэм эдийн засгийн үзүүлэлтээр харьцуулан шинжлэх.

Судалгааны арга зүй

Тус судалгааг хоёр үе шаттай зохион байгуулагдсан. Үүнд:

1. Нэгдсэн үндэсний байгууллагын Статистикийн Комиссын дэргэд байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтоны бүлэг”-ээс боловсруулсан “Хүүхдийн үйлдлийн чадвар” модулийн 6-17 насны хүүхдийн асуултуудад суурилан сонгогдсон орон нутаг дахь үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийг илрүүлэв. Тус асуулгаар хүүхдийн **харах, сонсох, явах, өөртөө үйлчлэх, харилцах, сурах, санах, төвлөрөх, өөрчлөлтийг хүлээн авах, өөрийгөө хянах, бусадтай найзлах, санаа зовох, сэтгэл гутрал** зэрэг 13 үйлдлийн чадварыг авч үздэг. Эдгээр үйлдлийн чадварууд нь хүртээмжгүй орчин нөхцөлд хүүхдийн нийгмийн оролцоо, суралцах үйл явцад шууд саад учруулахуйц өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагддаг суурь чадварууд болно.


Тус аргачлал нь НҮБ-ын гишүүн бүх улс орнуудад хүүхдийн үйлдлийн чадварын хүндрэл, хөгжлийн бэрхшээлийн эрсдэлийг анхан шатны түвшинд илрүүлэх зорилгоор ашиглахыг санал болгож буй аргачлал юм. Манай улсын Үндэсний статистикийн хороо тус Вашингтон бүлгийн гишүүн бөгөөд хамгийн сүүлийн байдлаар 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС)-нд тус асуулгыг ашиглаад байна (ҮСХ, 2018).

2. Нэгдүгээр шатнаас үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдүүдийн сурдаг сургуулийн соёлын орчныг үнэлэхдээ Тони Бүүт, Мэл Аинсков нарын боловсруулсан “Тэгш хамруулах боловсролын зарчимд суурилсан үйл

ажиллагааны индекс”-д тодорхойлсон 3 гол хэмжигдэхүүний нэг болох “Тэгш хамруулах соёл”-ын орчны хэмжигдэхүүнийг ашигласан. Тус аргачлал нь дэлхийн 70-аад оронд орчуулагдан гарсан, сургууль өөрийнхөө дотоод орчныг хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн, тэгш хамруулсан боловсролын орчныг бүрдүүлэхэд ашиглахад санал болгож буй гол хэрэглэгдэхүүн болно (Behluli, 2014)

Тус аргачлалаар “Тэгш хамруулах хөгжлийг сургуулийг орчинд төлөвшүүлэхийн тулд сургуулийн дотоод соёл, бодлого ба үйл ажиллагаа гэсэн гурван хэмжигдэхүүнийг авч үздэг (Дүрс 1). Хэмжигдэхүүн тус бүрийн хүрээг тоймловол:

Тэгш хамруулах боловсролын соёлын хүрээнд - Тухайн сургуульд бүх хүүхдийг хүлээн зөвшөөрсөн, хамтач найрсаг орчин, тэгш хамруулах үнэт зүйл төлөвшсөн эсэхийг авч үзсэн. Ингэхдээ тухайн сургуулийн орчинд хүүхэд бүр өөрийнхөө боломжит дээд хэмжээнд хүртэл суралцах, хөгжих боломжтой, хүүхэд бүр өөрийнхөө үнэ цэнийг мэдэрдэг орчин бүрдсэн байх нь соёлын орчны асуултуудын гол агуулга болно.



Дүрс 1. Тэгш хамруулах боловсролын үндсэн 3 хэмжигдэхүүн

Тэгш хамруулах боловсролын бодлогын хүрээнд - Сургуулийн дотоод бодлого, журам, төлөвлөгөө нь бүх ажилтан болон суралцагчийн оролцоог сургуульд элсэн орсон цагаас эхлэн дэмжих, хүүхэд бүрд хүрч ажиллах, ялгаварлан гадуурхалтыг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн эсэхийг тодорхойлдог.

Тэгш хамруулах боловсролын практик туршлагын хүрээнд - Сургууль дээр дурдсан тэгш хамруулах зарчмыг дэмжсэн бодлого, соёлын хүчин зүйлээ үйл ажиллагааны хэрэгжилтдээ хэрхэн буулгаж, ханган ажиллаж

байгааг авч үздэг. Тухайлбал, багш хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллаж чаддаг эсэх, сурагчдын ялгаатай байдал, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулдаг эсэх, хүүхэд бүр сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог эсэх нь гол шалгуур болдог.

Индексд дурдсанаар дээрх 3 хэмжигдэхүүн нь сургуулийн өөрчлөлтөд нэн тэргүүнд анхаарч үзэх ёстой гурван орчин бөгөөд харилцан хамааралтай хэрэгждэг. Гэвч үүнээс “Тэгш хамруулсан соёлын орчин”-г төлөвшүүлэх, соёлын орчны өөрчлөлтийг авч үзэх нь “Тэгш хамруулах боловсролыг бүрдүүлж буй гурвалжны суурь болдог байна (Ainskow, 2002). Өөрөөр хэлбэл сургуулийн соёлын орчны бэлэн байдал, түүний эерэг өөрчлөлт рүү чиглэсэн ажлуудыг авч хэрэгжүүлэхгүйгээр тэгш хамруулсан бодлого болон практик үйл

ажиллагааны талаар ярих боломжгүй юм. Тэгш хамруулах соёлын орчин бүрдсэнээр сургуулийн удирдлага солигдох, шинэ багш ажилтан, сурагч орж ирсэн ч сургуулийн бодлого, практик үйл ажиллагааны хэрэгжилт илүү тогтвортой үргэлжилдэг гэжээ (Ainskow, 2002).

Дээрх үндэслэлээр энэхүү судалгаанд “Сургуулийн тэгш хамруулах соёлын орчин”-г онцолж авч үзсэн. Тус орчныг хоёр ерөнхий шалгуур үзүүлэлтээр хэмждэг:

- Тэгш хамруулсан хамт олон бүрдсэн эсэх
- Тэгш хамруулах үнэт зүйл төлөвшсөн эсэх үзүүлэлтүүд юм. Тус бүр нь 4-5 дэд индикатороор хэмжив (Дүрс 2).

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийн тоон үр дүнг нэгтгэн соёлын орчны индекс тооцож үр дүнг боловсруулав. Индекс тооцоо хийхдээ НҮТС-ны Бага насны хүүхдийн хөгжлийн индекс тооцох аргачлалын дагуу боловсруулалт хийсэн болно.

1. Тэгш хамруулах хамт олон бүрдсэн эсэх

- Сургуулийн орчинд хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг эсэх
- Багш нар хүүхэд бүрийн онцлог тусгай хэрэгцээг харгалзаж хүүхэд бүртэй эелдэг найрсаг харилцдаг эсэх
- Сургуулийн соёлын орчин хүүхдийг өөрийнхөө боломжийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн суралцах боломжийг хангасан аюулгүй орчин эсэх
- Сургуулийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэх
- Сургуулийн бүх хүүхдийг бие биедээ туслахыг дэмждэг эсэх

2. Тэгш хамруулах үнэт зүйл бүрдсэн эсэх

- Сургуулийн орчинд бүх хүүхдэд эрх тэгш хандахыг чухалчилдаг
- Сургуулийн багш нар бүх талаараа хүүхдэд үлгэр жишээ болохуйц ёс зүйтэй
- Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг
- Сургууль хүүхэд бүр ялгаатайг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажилладаг

Дүрс 2. Шалгуур, дэд шалгуур үзүүлэлтүүд

Судалгааны газарзүйн хүрээ

Судалгааны мэдээлэл цуглуулалт Азийн хөгжлийн банкны төслийн зорилтот сургуулийн хамран сургах тойргийн орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд явагдсан. Үүнд, Дархан-

Уул аймгийн Дархан сум, Ховд аймгийн Жаргалант сум, Дундговь аймгийн Мандалговь сум, Хөвсгөл аймгийн Цагааннуур сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 9 байршил (баг, хороо)-д зохион байгуулагдсан.

Судалгааны түүвэр

Хүснэгт 1. Судалгааны түүвэр

Байршил	Хороо/Баг	1-р шат			2-р шат		
		6-17 насны хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	Хамрагдалтын хувь	Илэрсэн хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	Хамрагдалтын хувьд
Дорнод, Хэрлэн	6-р баг	1417	999	70.5	77	55	71.4
	9-р баг	1446	725	50.1	63	36	57.1
Дархан уул, Дархан	7-р баг	1639	1028	62.7	100	74	74
	8-р баг	1760	831	47.2	80	37	46.3
Дундговь, Сайншанд	6-р баг	521	256	49.1	49	44	89.8
	7-р баг	975	451	46.3	47	33	70.2
Хөвсгөл, Цагааннуур	1-р баг	249	182	73.1	20	18	90
Улаанбаатар, СХД	8-р хороо	1941	855	44.04	160	120	66.7
	28-р хороо	2066	1092	52.9	171	128	74.9

Нэгдүгээр шатны илрүүлэх үнэлгээгээр сонгогдсон орон нутгийн нийт 4066 өрхөөр зочилж 6-17 насны 6419 хүүхдийн мэдээллийг цуглуулсан ба үүнээс 768 хүүхэд буюу 12 хувь нь ямар нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй болох нь илэрсэн. Тэдгээр илэрсэн хүүхдийн эцэг эхийг хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтад хамруулахыг зорьсон. Нийт илэрсэн түүврийн хэмжээнд хоёр дахь шатны хандалтыг гүйцэтгэж нийт түүврийн 71 хувь (N=545)-иас мэдээлэл цуглуулалт гүйцэтгэв.

Үр дүн

Тэгш хамруулах соёлын орчин бүрдсэн эсэхийг “Тэгш хамруулах зарчимд суурилсан үйл ажиллагааны индекс”-д санал болгосон хүрээгээр индекс тооцон хэмжиж үзэхэд эцэг эхийн хариултаар:

1. “Тэгш хамруулах хамт олон төлөвшсөн эсэх” шалгуур үзүүлэлт 7 хувь,
2. “Тэгш хамруулах үнэт зүйл төлөвшсөн эсэх” 16,7 хувьтай үнэлэгджээ.

Энэ нь тэгш хамруулах соёлын орчны төлөвшил аль аль шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй байгааг харуулж байв. Үр дүнг дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Тэгш хамруулах хамт олон бүрдсэн эсэх

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн үнэлгээгээр сургуулийн орчинд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийг хүлээж аван нэг хамт олон болж чадаж буй эсэхийг хэмжиж буй бүх 5 индикатор бүрэн биелсэн байх утгыг тооцоход¹ нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 7 хувь нь л хэмжсэн бүх индикаторт бүгдэд нь эерэг байх хариултыг өгчээ.

Хэмжсэн дэд шалгуур үзүүлэлтүүдээс нийлбэр индекс үзүүлэлтэд хамгийн сөргөөр нөлөөлж буй нөхцөл байдал нь хүүхэд сургуулийн орчинд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэхтэй холбоотой асуулт байв. Тус индикатор судалгаа явагдсан бүх байршилд жигд бага үзүүлэлтэй байна. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 90 орчим хувь нь хүүхдээ ямар нэг хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг сургуулийн орчинд мэдэрч байсан гэж хариулжээ. Насны хувьд авч үзвэл 6-9 насны хүүхэдтэй эцэг эхчүүд бусдаасаа илүү сөрөг хариултыг өгсөн байгаагаас үзэхэд бага ангийн түвшинд дээрх байдал илүү ажиглагддаг байна.

¹ Судалгааны үр дүнд индекс тооцоходоо индикатор бүрийн биелэлт хамгийн баагаа нийт тооцогдож байгаа асуултын тооноос нэгээр бага байж болохоор тооцсон. Тухайлбал, Тэгш хамруулсан хамт олон бүрдсэн эсэхийг 5 дэд шалгуураар хэмжихдээ 4 ба түүнээс дээш утгат эерэг хариулт өгсөн оролцогчдын хувиар нийлбэр индекс тооцсон.

Үр дүнг авч үзэхдээ тодорхойлсон индикаторуудын биелэлт тухайн боловсролын байгууллагад 40 хувиас бага бол тэгш хамруулсан соёлын орчин хангалттай бүрдээгүй, 40-60 бол бий болж байгаа, 60-80 хувь бол сайжруулах шаардлагатай, 80 хувиас их бол хангалттай бүрдсэн гэсэн шкалаар тооцов.

Хүснэгт 2. Сургуулийн орчинд тэгш хамруулах хамтын бүлэг
бүрдсэн эсэх шалгуур үзүүлэлтийн үр дүн

	Сургуулийн орчинд хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг	Багш нар хүүхэд бүрийн онцлог тусгай хэрэгцээг харгалзаж хүүхэд бүртэй эелдэг найрсаг харилцдаг	Сургуулийн соёлын орчин хүүхдийг өөрийнхөө боломжийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн суралцах боломжийг хангасан аюулгүй орчин	Сургуулийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг	Сургуулийн бүх хүмүүсийг бие биедээ туслахыг дэмждэг	Соёлын орчны индекс оноо
Байршлаар						
Дорнод	45.7	73.9	79.3	6.5	89.1	5.4
Дархан	47.8	69.0	82.3	6.2	90.3	3.5
Дундговь	79.7	88.6	86.1	32.9	88.6	25.3
Хөвсгөл	50.0	83.3	77.8	5.6	83.3	5.6
СХД	56.7	77.2	86.6	6.3	88.6	3.5
Нийт	56.1	76.8	84.2	10.1	88.8	7.0
Үйлдлийн чадварын төрлөөр						
1.Харах	60.0	93.3	93.3	6.7	100.0	6.7
2.Сонсох	83.3	100.0	83.3	16.7	100.0	16.7
3.Алхах	54.5	81.8	100.0	18.2	90.9	18.2
4.Өөртөө үйлчлэх	100.0	100.0	50.0	0.0	100.0	0.0
5.Хэл яриа	0.0	0.0	100.0	0.0	100.0	0.0
6.Суралцах	50.0	66.7	66.7	0.0	83.3	0.0
7.Сэргээн санах		33.3	33.3	33.3	0.0	33.3
8.Төвлөрөх	75.0	100.0	100.0	25.0	75.0	0.0
9.Өөрчлөлтөд дасан зохицох	66.7	66.7	66.7	0.0	83.3	0.0
10.Зан авираа удирдах	0.0	66.7	66.7	33.3	33.3	0.0
11.Бусадтай нөхөрлөх	11.1	33.3	11.1	0.0	33.3	0.0
12.Сэтгэлийн түгшүүр	54.4	74.5	88.7	7.8	91.2	6.4
13.Сэтгэл гутрал	58.0	78.0	84.0	11.2	90.0	7.2

Хүүхэд нь сургуулийн орчинд ямар нэг хэлбэрийн гадуурхал мэдэрч байсан гэж хариулсан эцэг эхчүүдийг өрхийн нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтээр харьцуулж харахад өрхийн аж байдлын хувьд доогуур эсвэл дунджаас дээгүүр, дээгүүр² өрхийн хүүхдүүд тус шалгуур үзүүлэлтэд илүү мэдрэг байна.

Тус индикаторыг хэмжсэн дэд асуултуудын үр дүнг харахад хүүхдийн хүйсээс хамааруулан ялгаж хандах тохиолдол харьцангуй бага, харин гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, бусдаас ялгарах бусад байдлаас нь хамааран ялгаж хандах тохиолдол гардаг гэжээ.

Сургуульд хамтын соёл бүрдсэн эсэх шалгуур үзүүлэлтийг хүүхдийн үйлдлийн чадварын төрлөөр харьцуулан авч үзвэл 1. Сэтгэл гутралд өртөмтгий 2. Орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул 3.Сэтгэл түгших 4.Сэргээн санах 5.Анхаарлаа төвлөрөх чадвар султай хүүхдүүдийн хувьд доогуур үнэлгээтэй байна.

Энэ нь дээр дурдсан үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд сургууль, анги, үе тэнгийнхэн болон багш нартайгаа харилцахдаа ойлголцол, ойр дотно харилцаа үүсгэж чадахгүй, өөрийгөө илэрхийлэх, бусдын тусламж дэмжлэг авах зэргээр хамтран суралцах чадвар сул, сургуулийн орчинд дасан зохицож чадахгүй байх зэрэг бэрхшээлтэй тулгарч байгааг харуулж байна.

2.Тэгш хамруулах боловсролын үнэт зүйл төлөвшсөн эсэх:

Тэгш хамруулсан үнэт зүйл төлөвшсөн эсэх шалгуурыг түүнийг тодорхойлж болох дөрвөн дэд шалгуур үзүүлэлтээр хэмжихэд сургуулийн орчин хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажиллах байдал хамгийн сул байна. Газарзүйн хувьд судалгаа явагдсан бүх байршлуудад жигд бага үзүүлэлттэй байгаа нь дээрх нөхцөл байдал нийтлэг дүр зураг болохыг харуулж байна.

2 Аж байдлын индексийг 5 түвшинд авч үзэв: Доогуур, Дунджаас доогуур, Дундаж, Дунджаас дээгүүр, Дээгүүр

Хүснэгт 3. Тэгш хамруулах боловсролын үнэт зүйлийн төлөвшлийг хэмжсэн индикаторын үр дүн

	Сургуулийн орчинд бүх хүүхдэд эрх тэгш хандахыг чухалчилдаг	Сургуулийн багш нар бүх талаараа хүүхдэд үлгэр жишээ болохуйц мэргэжлийн өндөр ёс зүйтэй	Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг	Сургуулийн орчин хүүхэд бүрийн ялгаатайг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалздаг	Соёлын орчны индекс оноо
Байршлаар					
Дорнод	55.4	71.7	72.8	37.0	14.1
Дархан	60.2	76.1	79.6	47.8	26.5
Дундговь	74.7	89.9	83.5	17.7	11.4
Хөвсгөл	50.0	61.1	61.1	44.4	11.1
СХД	61.4	75.2	81.1	30.7	15.0
Нийт	62.1	77.0	79.7	33.5	16.7
Үйлдлийн чадвараар					
1.Харах	60.0	93.3	100.0	40.0	20.0
2.Сонсох	50.0	83.3	100.0	16.7	16.7
3.Алхах	45.5	90.9	81.8	36.4	9.1
4.Өөртөө үйлчлэх	100.0	100.0	100.0	0.0	0.0
5.Хэл яриа	0.0	100.0	100.0	0.0	0.0
6.Суралцах	83.3	66.7	83.3	16.7	16.7
7.Сэргээн санах	33.3	33.3	0.0	0.0	0.0
8.Төвлөрөх	75.0	100.0	50.0	50.0	25.0
9.Өөрчлөлтөд дасан зохицох	66.7	33.3	66.7	33.3	33.3
10.Зан авираа удирдах	100.0	33.3	66.7	66.7	33.3
11.Бусадтай нөхөрлөх	22.2	22.2	33.3	33.3	22.2
12.Сэтгэлийн түгшүүр	64.2	82.8	78.9	27.5	13.7
13.Сэтгэл гутрал	62.0	72.8	80.4	39.2	17.2

Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх үнэт зүйлийн төлөвшил хүүхдийнх нь хүйс болон наснаас хамаараад ялгаагүй байгаа бол харин тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн түвшин, шашин, яс үндсийн ялгаатай байдлаас хамаарсан ялгаа ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлийн хүнд хөнгөн эсэх, үндэсний цөөнх (халхаас бусад) болон шашны хувьд ялгаатай (буддизмаас бусад) байхаас хамаарсан ялгааг хүлээн зөвшөөрөхгүй байдал сургуулийн орчинд байна.

Хүүхдийн үйлдлийн чадварын төрлөөр харвал (1) хэл яриа, харилцаа холбоо тогтоохдоо сул, (2) аливаа зүйлийг тогтоох болон (3) өөртөө үйлчлэх чадвар багатай хүүхдүүдийн эцэг эх “ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх” тус шалгуурыг хамгийн багаар үнэлжээ. Өөрөөр хэлбэл ямар нэгэн шалтгаанаас үүдэн өөрийгөө илэрхийлэх, биеэ даах чадвар сул хүүхдүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх байдал сургуулийн орчинд сул байна.

Соёлын орчныг хэмжсэн индикатор, түүнийг шалгасан шалгуур асуулт бүрийн

дан тоололтын үр дүнгээр нийт судалгаанд хамрагдсан үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн 5-7 орчим хувь нь сургууль дээрээ найз нөхөдгүй, сургуульдаа явах дургүй байгаа үр дүнг харуулсан байгаа нь анхаарал татахуйц онцлох үр дүн байв. Ингэхдээ дээрх хариултыг өгсөн хүүхдүүд соёлын орчны хамгийн сул шалгуур үзүүлэлтүүд болж буй “Сургуулийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэх”, “Сургуулийн орчин хүүхэд бүрийн ялгаатайг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалздаг эсэх” индикаторуудад хамгийн бага үнэлгээг өгсөн байна. Иймд дээрх шалгуур үзүүлэлт нь эдгээр хүүхдүүдийн сургуульд явахад дургүй болоход нөлөөлж буй шалтгааны нэг болохыг харуулж байна.

Мөн дээрх индикаторуудыг хэмжсэн шалгуур асуултын хувьд эцэг эхчүүд “мэдэхгүй” гэсэн хариултыг олон өгч байсныг дурдах хэрэгтэй. Энэ үр дүн нь эцэг эхчүүд сургуулийн дотоод амьдрал, сурагчдын хоорондын харилцаа, тэдний аливаа зөрчилтэй холбоотой асуудлуудыг үнэлж мэдэхгүй, сургууль, ангид

хүүхдэд нийцтэй сэтгэл зүйн орчин бүрдсэн эсэх талаар мэдээлэл, ойлголтгүй байгааг харуулж байсан нь нэг чухал үр дүн юм.

Хэлцэмж

Тус судалгаанд ашигласан Тони Бүүт, Мэл Аинсков нарын аргагүйгээр тэгш хамруулсан боловсролын орчныг төлөвшүүлэх нь өөрөө үйл явцын шинжтэй бөгөөд тэгш хамруулсан орчныг бүрэн төлөвшүллээ гэж хатуу тогтоох шалгуур үгүй ч тус судалгаанд хэмжихийг оролдсон гол үзүүлэлтүүд нь сургуулийн соёлын орчныг тодорхойлж болох наад захын суурь үзүүлэлтүүд юм. Иймд соёлын үзүүлэлтийг тоон утгаар хэмжих, түүнд хамааралтай нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийг тодорхойлохыг зорьсон нь цаашдын боловсролын шинэчлэлийн их ажилд хувь нэмэр болно хэмээн найдаж байна. Гэвч үүний тулд судалгааны хязгаарлагдмал талуудыг сануулах нь зүй ёсны хэрэг.

Нэгдүгээрт, тус судалгааг үр дүнтэй суралцахад хүндрэл учруулахуйц үйлдлийн чадварын аль нэг төрөл дээр хүндрэлтэй тулгардаг хүүхдүүдийн эцэг эхчүүдийн байр суурьт үндэслэн боловсруулсан. Сургуулийн орчныг хөндлөнгөөс үнэлэхэд багш, сургуулийн ажилчид бодит нөхцөл байдлаас илүү эерэг хариултыг өгөх хандлагатай байдаг тул хүүхдүүдийн нөхцөл байдлыг хамгийн сайн мэдэх эцэг эхчүүдийн хариулт илүү ач холбогдолтой гэж судалгааны багийн зүгээс тооцсон. Гэвч дээрх үр дүнг багш, сургуулийн ажилчид төдийгүй сурагчдын байр сууринаас үнэлж баталгаажуулж болохыг судлаачийн зүгээс үгүйсгэхгүй.

Хоёрдугаарт, уг судалгааны түүврийн дизайныг боловсруулах явцад мэдээллийн хязгаарлагдмал байдал, судалгааны төсөв зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан магадлалт түүврийн аргын оронд зорилтот түүврийн аргыг ашигласан. Энэ нь судалгааны эх олонлогийн хүрээг тодорхой байдлаар хумьж өгсөн бөгөөд тогтсон нэгжийн түвшинд screening буюу илрүүлэх үнэлгээ хийж өөрсдийн сонирхсон зорилтот эх олонлогийг бүрдүүлж нэлэнхий ажиглалтын аргаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Иймд тус судалгааны үр дүнгийн тооцооллыг боловсруулахдаа ямар нэгэн төлөөллийг илтгэх түүврийн жин ашиглаагүй бөгөөд зөвхөн сонгогдсон нэгжийн түвшинд судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хийсэн болно.

Дүгнэлт

“Тэгш хамруулах боловсролын үйл ажиллагааны индекс”-д тодорхойлсон хүрээгээр авч үзэхэд сонгогдсон сургуулиудын хувьд тусгай хэрэгцээтэй сурагчдыг хүлээж авах тэгш хамруулсан соёлын орчин маш сул байна. Түүн дотроо сургуулийн орчинд хүүхдүүд болон багш ажилчид бие биеийнхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх үзүүлэлт хамгийн сул байгаа үр дүн гарлаа.

Дээр дурдсан соёлын орчны таагүй нөлөөг хэл ярианы бэрхшээлтэй, өөртөө үйлчлэх чадвар сул, өөрчлөлтөд дасан зохицохдоо удаан, аливаа зүйлийг тогтоох, сэргээн санахдаа хүндрэлтэй хүүхдүүд хамгийн их мэдэрч байна.

Хэдийгээр судалгаанд оролцсон үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн дунд харьяа орон нутгийнхаа ЕБС-д үе тэнгийн хүүхдүүдтэйгээ хамт амжилттай суралцан хичээллэж байгаа хүүхдүүд олон байсан хэдий ч цаашид тусгай хэрэгцээтэй сурагчдыг ЕБС-д илүү амжилттай тэгш хамруулан сургахын тулд дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын аргагүй зэрэг бодлогын болон үйл ажиллагааны шинжтэй ажлуудад анхаарахаас гадна боловсролын оролцогч талуудад *бусдын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх харилцааны зөв, зохистой хэв маягийг төлөвшүүлэх* ажлуудад анхаарах хэрэгцээ шаардлага тус судалгааны үр дүнгээс харагдлаа.

Ашигласан материал

БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”

БСШУС-ын сайдын 2018 оны А/425 тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”

Ainskow, T. B. (2002). Index for Inclusion. CSIE.

Behluli, D. N. (2014). INDEX FOR INCLUSION - FACTS AND OPINIONS. Prishtina: Save the Children in Kosovo.

ҮСХ, Н. (2018). Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. Улаанбаатар.

Хүүхдийг ивээх сан. (2018). “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан. Улаанбаатар.

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ, ОНЦЛОГ

Ц.Алтанцэцэг¹
¹29-р сургууль

ТҮЛХҮҮР ҮГ:

Сонсгол, тулгуур эрхтэн, ур чадвар

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

Сонсголын бэрхшээлтэй сурагчдын бие бялдрын хөгжлийн онцлогийг тодорхойлох

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн бие бялдрын хөгжлийг тогтоох
2. Сонсголын болон давхар бэрхшээлтэй хүүхдийн цогц чадамжийг тогтоох

ҮНДЭСЛЭЛ

Орчин үед сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тоо эрс нэмэгдэж байгаа төдийгүй бие бялдар, оюун ухааны болон эрүүл мэндийн хөгжлийн бэрхшээл нилээд тулгарч байна. Энэ нь нийгэм, эдийн засаг, экологийн тааламжгүй хүчин зүйлтэй холбоотой.

Сонсголын бэрхшээлтэй сурагчдын хувьд бие бялдрын хөгжил, хүмүүжил нь зөвхөн эрүүл мэндэд ач холбогдолтой төдийгүй хөдөлгөөний уян хатан чанарыг сайжруулах, алдагдсан үйл ажиллагааг сэргээх том хүчин зүйл болдог.

Манай орны хувьд сурагчдад бие бялдрын хөгжлийг засан сайжруулах, нөхөн сэргээх хөдөлгөөний зөв дадал хэвшилтэй болгоход чиглэгдсэн ажил зайлшгүй хийх шаардлагатай, энэ талаар хийсэн судалгаа хомс байгаа зэрэг нь уг судалгааны үндэслэл болсон.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

29-р тусгай сургуулийн сонсголын бэрхшээлтэй, 3-12-р ангийн сонсголын бэрхшээлтэй 112 сурагчийг бие бялдрын түвшин тогтоох сорилын судалгаанд хамрууллаа. Уг сорилын шалгуурт байрнаас уртад харайлт, гар дээр суниалт\30сек\, гэдэсний суниалт\30сек\, уян хатан чанар, 50м-ийн гүйлт, хөдөлгөөний эвсэл буюу хавсралттай гүйлт \20сек\, бөмбөг шидэх зэрэг дасгал орсон.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- Сонсголын бэрхшээлтэй 112 сурагчдаас бие бялдрын түвшин тогтоох сорилт авахад гэдэсний таталт, гар дээр суниалт, хавсралттай гүйлт 76,6% нь хангалттай буюу “А”, “В”, 12% нь дунд буюу “С”, 12,4% нь дунджаас доогуур буюу хангалтгүй “D”, “F” байна.
- Сорилын байрнаас уртад харайх, 50метрийн гүйлт, уян хатан, бөмбөг шидэлтийг нийт сурагчдын 16% нь хангалттай буюу “А”, “В”, 8.8 % нь дунд буюу “С”, 75.2% дунджаас доогуур буюу хангалтгүй “D”, “F” байна.

ХЭЛЦЭМЖ

Бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох судалгаагаар сонсголын бэрхшээлээс гадна хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөдөлгөөний чадвар хангалтгүй байсан нь Оросын эрдэмтэн Т.В.Розановагийн судалгааны хөдөлгөөнийг бие даан гүйцэтгэх чадвар нь сонсголтой хүүхдүүдтэй харьцуулахад дутагдалтай байдаг гэсэн судалгааны үр дүнтэй дүйж байна.

Сонсголоо алдснаар биеийн хөгжил дутуу, тулгуур-хөдөлгөөний гажиг үүсгэхээс гадна төрөлхийн ба олдмол хавсарсан бэрхшээлүүд тохиолдох нь элбэг байдаг гэсэн судалгааны үр дүнтэй бидний хийсэн судалгааны тархи болон мөчдийн саажилт, хөдөлгөөний хоцрогдол, тулгуур эрхтний бэрхшээлтэй гарсан үр дүн нь ойролцоо байна.

ДҮГНЭЛТ:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд биеийн тамир спортоор хичээллэх нь бие бялдрыг хөгжүүлэхэд шаардлагатай эмчилгээ болохоос гадна танин мэдэхүйн чадвар сайжирч, илүү өргөн хүрээнд дасгал сургуулилт хийснээр тэдний амьдрал баялаг, сонирхолтой болох хүчин зүйл болж байна.
2. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн бие бялдрын сорилыг дүнг сонсголтой хүүхэдтэй харьцуулахад хүчний дасгал, зарим төрлийн ахуйн хэрэгцээт дасгалуудыг эсвэл байнга

давтан хийдэг хөдөлгөөнүүдийг илүү сайн гүйцэтгэж, нарийн хөдөлгөөн эвсэл шаардсан дасгал хөдөлгөөнүүд, хурд, авхаалж самбаа сорьсон дасгалуудыг гүйцэтгэх тал дээр дутмаг байгаа нь харагдаж байлаа.

НОМ ЗҮЙ:

1. Абилова.Э.Н. Особенности развития двигательной сферы глухих детей школьного возраста. Дефектология. - 1992.
2. Козленко.Н.А. Физическое воспитание в системе коррекционно-вспомогательной работы вспомогательных школ. Дефектология. 1991.
3. Koica, Special Olympics Mongolia., Special physical education theory and practice./Биеийн тамирын тусгай боловсролын онол практик/. Улаанбаатар. 2017
4. Sida. Ганцаарчилсан сургалтын төлөвлөлт. Улаанбаатар. 2006
5. Адам Гудалефьский, Концепсион Маддума, С.Сэлэнгэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөр. Улаанбаатар. 2017

ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ХАМТАРСАН СПОРТООР ДАМЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Б.Ганболд¹, С.Эрдэнэбаатар¹

¹Нийслэлийн ерөнхий боловсролын 63 дугаар тусгай дунд сургууль

ХАМТАРСАН СПОРТЫН ТАНИЛЦУУЛГА

Тусгай олимпийн хамтарсан спорт нь олон улсад танигдсан нийгмийн харилцааг дэмжих зорилготой байгуулагдсан Дэлхийн тусгай олимпийн бүрэлдэхүүн хэсэг юм. Мөн тус байгууллага нь тусгай олимпийн хөдөлгөөн, нийгэмлэгийн байгуулсанаар илүү олон хүнд хүртээмжтэй болж байгаа юм.

ХАМТАРСАН СПОРТЫН ТҮҮХ

Хамтарсан спорт нь 1983 онд АНУ-ын Массачусеттс хотноо софтболын спортын төрлөөр анх зохион байгуулагдсан байна. 5 жилийн дотор хамтарсан спорт нь боулинг, софтбол мөн волейболын спортыг багтаан Тусгай олимпийн албан ёсны хөтөлбөр болсон. 1991 онд хамтарсан спорт нь АНУ-ын Миннеполисд болсон дэлхийн зуны тусгай олимпийн наадамд анх удаагаа тэмцээний төрөл болж орсон билээ. Ингээд 2019 оны байдлаар хамтарсан спорт нь 620000 гаруй оролцогчидтой олон улсын хэмжээний хөдөлгөөн болж чадсан юм. 2019 оны 3-р сар 7000 гаруй тамирчныг хамруулсан хамтарсан спортын тусгай олимпийн дэлхийн хэмжээний наадам боллоо.

ОЛОН УЛСАД ХӨГЖИЖ БҮЙ ХАМТАРСАН СПОРТЫН ТӨРЛҮҮД

- Волейбол, жүдо бөх, тусгай бочи, хоккей, сагсан бөмбөг, ширээний теннис, хөл бөмбөг, бодминтон, гандбол

МОНГОЛ УЛСАД ХӨГЖИЖ БҮЙ ХАМТАРСАН СПОРТЫН ТӨРЛҮҮД

- Волейбол, жүдо бөх, тусгай бочи, сагсан бөмбөг, ширээний теннис, хөл бөмбөг, заалны хоккей

МОНГОЛ УЛСАД ХАМТАРСАН СПОРТ ҮҮССЭН ТУХАЙ

Манай улсад 2015 онд хамтарсан волейбол, сагсан бөмбөг анхны тэмцээнийг Нийслэлийн 63 дугаар сургууль, Монголын Тусгай Олимпийн Хороотой хамтран зохион байгуулсан байна. Түүнээс хойш ширээний теннис, хөл бөмбөг,

заалны хоккей, хөнгөн атлетик, тусгай бочи, жүдо бөх зэрэг спортын төрлүүдээр хамтарсан спортын хөгжил эхний үе шатандаа явж байна. Мөн хамтарсан хөтөлбөрүүд их хэрэгжиж байна.

ХАМТАРСАН СУРГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хамтарсан сургалт гэдэг нь оюуны болон суралцахуйн бэрхшээлтэй мэдлэг, ур чадвар, бэлтгэл, дасгалжуулалт туршлага тутагдаж буй суралцагч нарыг тусгай бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу бусад ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, байнгын бэлтгэл сургалт хийж байдаг тамирчин болон биеийн тамир, спортоор хичээлэгч нарыг дагуулан сургах үйл явцыг хэлнэ.

ХАМТАРСАН СПОРТЫН ЗОРИЛГО

Оюуны бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүсийг нэг багт тэнцүү хуваан спортын бэлтгэл сургуулалт болон өрсөлдөөнт спортын төрлөөр дамжуулан нийгмийн харилцааны хөгжлийг дэмждэг байгууллага юм. Хамтарсан спортын тусгай олимпийн тамирчид болон хамтрагчид нь түншлэлийн гишүүд ганцаарчилсан болон багийн спортод тэнцүү тоотой байдаг. Бүх тамирчид болон хамтрагчид багийн үйл ажиллагаанд тэнцүү хувь нэмэр оруулж багийн нэг хэсэг болж бусадтай харилцан ойлголцож цаашлаад нөхөрлөлийн харилцааг тогтоож чаддаг.

- Тамирчдын ач холбогдол / үр өгөөж /
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийг спортлог болгож өсгөнө
- Бусадтай харилцаж чаддаг болгон.
- Өөртөө итгэлтэй нийгмийн харилцаатай болгоно.
- Асуудалтай зан авирыг засан сайжруулна.
- Бусадтай харилцан нөхөрлөх нийгмийн холбоо харилцаа нь өргөжнө.

ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СУРГАХ ЗАРЧМУУД

- ✓ Бүх хүүхдүүд суралцах чадвартай бөгөөд тэдний хэрэгцээг хангах сургалтын хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх

- ✓ Хүүхдийн суралцах явцад тохиолдох бэрхшээлийг хөнгөвчлөх, түүнийг даван туулахад туслах
- ✓ Бүх хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл хандлага, сургалтын орчин, багшийн сургалтын арга зүй, харилцааг өөрчлөх
- ✓ Нийгмийн тэгш ойлголтын талаарх үндэсний соёл, уламжлалыг хөгжүүлэх асуудлууд ордог.

ХАМТАРСАН СПОРТ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Оюуны ухааны бэрхшээлтэй хүүхдийг, хөгжүүлэх, төлөвшүүлэх явдал өнөөдөр тулгамдсан асуудлын нэг болоод байна. Иймд энэ асуудлыг багш бид өөрсдийн боломжийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлж “Оюуны ухааны бэрхшээлтэй хүүхдийг хамтарсан спортоор дамжуулан хөгжүүлэх нь” сэдвийг сонгож авлаа. Эцэг эх, асран хамгаалагч нараас авсан хэрэгцээг тодорхойлох судалгааны үр дүн энэхүү сэдвийг сонгож авах гол үндэслэл боллоо. Мөн судалгааны үндсэн дээр тулгуурлан дугуйлан болон уралдаан тэмцээний бэлтгэл дасгалжуулалтын хөтөлбөр, арга зүй боловсруулан ажиллах юм.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд ямар хэрэгцээ шаардлагатай байгааг тодруулах.

ЗОРИЛТ

- Сэдвийн хүрээнд хэрэгцээ тодорхойлох судалгааны ажил хийх
- Сургалтын үр дүнгийн судалгаа авах, үр дүнг тооцох
- Суралцагч нарт ямар хүчин зүйл нэн шаардлагатай байгааг нээн илрүүлэх судалгаа авах

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- Онолын материалыг судлах
- Асуулга, анкетын арга
- Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2015-2018 оны хооронд нийслэлийн 63 дугаар сургууль дээр волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, заалны хоккей, бочи зэрэг спортын төрлүүдээр хамтарсан секц, дугуйлан хичээлүүлж туршиж хэрэгжүүлэн гарсан үр дүнг нь тооцож гаргасан.

ТААМАГЛАЛ

Оюуны ухааны бэрхшээлтэй хүүхдийг Хамтарсан спортоор дамжуулан хөгжүүлэх арга зүйг боловсруулсанаар суралцагч нарт хэрэгцээтэй байгааг сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж болно гэсэн таамаглалыг дэвшүүлсэн.

Оюун ухааны болон суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшилд бусад суралцагч, хамтран хичээлэгчдийн нөлөөлөл нэлээд чухал юм. Иймд эдгээр суралцагч нарын төлөвшилд ямар хүчин зүйл сөргөөр нөлөөлж байдгийг судлан тогтоож авах арга хэмжээнүүдийг авч ажиллах шаардлагатай байна.

ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ ?

Оюуны бэрхшээл гэдэг нь танин мэдэхүйн чадвар, нийгмийн харилцаа холбоо, биеээ авч явах чадвар нь хязгаарлагдмал хүнийг хэлнэ. Энэ хязгаарлагдмал байдал хөгжих насан дээрээ байгаа хүүхдийг суралцах болон хөгжихөд бэрхшээл болдог. Оюуны бэрхшээл нь хүүхдийг төрөхөөс өмнө эсвэл 18 нас хүрэхээс өмнө бий болдог. Оюуны бэрхшээл бол хамгийн их тохиолддог хөгжлийн бэрхшээлийн төрөл юм.


Америкийн оюуны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэгийн судалснаар дараах 3 шинжээр оюуны хомсдолыг таньж болох аж.

1. Тухайн хүний IQ 70-с доош
 2. Нийгэмд амьдрах, ажиллах, харилцах чадвар хязгаарлагдмал
 3. 18 нас хүрэхээс өмнө энэ байдал нь илэрсэн бол оюуны бэрхшээл байх магадлалтай
- Оюуны бэрхшээл хэрхэн бий болдог вэ?

Оюуны бэрхшээл нь тархины бэртэл, гэмтэл болон өвчнөөс шалтгаалан сэтгэх чадвар муудахаас эхлэн мэдэгддэг

Эцэг эхээс авсан хүүхдийн хэрэгцээг тодорхойлох судалгааны анхаарал татсан асуулт

1. Та хүүхдээ сургалтын ямар хэлбэрийг ашиглан хөгжүүлэх хүсэлтэй байна вэ?



Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнгийн дагуу хэрэгжүүлсэн сургалт, түүний үр дүн



Тусгай бочи ЗААШТ Хонг Конг – 2018




ХАМТАРСАН СПОРТООС ГАРСАН ҮР ДҮН

Сургуулийнхаа урт богино хугацааны зорилтуудыг шалгаж, тэдгээрийг биелүүлэхэд хэнд, ямар сургалт хэрэгцээтэй байгааг тодорхойлж түүний үндсэн дээр тулгуурлан сүүлийн 4 жилийн хугацаанд 63 дугаар сургуулийн 100 гаруй мөн ЕБС-ийн 100 гаруй нийт 200 гаруй суралцагчийг 2015 оноос одоог хүртэл волейбол, жүдо бөх, сагсан бөмбөг, тусгай бочи, заалны хоккей, теннис зэрэг хамтарсан спортын төрлүүдээр хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. Хамтарсан спортын секц дугуйлан, бэлтгэл дасгалжуулалт, сургалтыг зохион байгуулснаар ЕБС-ийн суралцагч нарын хувьд суралцахуйн бэрхшээлтэй болон оюун ухааны бэрхшээлтэй суралцагчийг илүү сайн ойлгох эдгээр хүүхдүүдийн талаар эерэг ойлголттой болох тэдэнд туслах, тэднийг дэмжих, тэдэнтэй илүү сайн найзлах, нөхөрлөх тэднийг ялгаварлан гадуурхахгүй болох зэрэг олон давуу талууд бий болж байна.


Суралцахуйн бэрхшээлтэй суралцагч нарын хувьд бүтээмж, чанар өндөрсөж байна бусад суралцагч нартай хамтарсан спортоор хичээллэх, хамтдаа сургалтад хамрагдах сурагчдын тоо жилээс жилд өсөж байна. Оюун ухааны бэрхшээлтэй суралцагч нар сургалтын арга барил, технологийг эзэмших, сэтгэл ханамжтай суралцах, спортын төрлүүдээр хичээллэх илүү их сонирхолтой болсон байна. Багш, эцэг эхийн харилцаа холбоо сайжирч байна.

- Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийг хамтарсан спортын төрлүүдээр дамжуулан хөгжүүлсэн судалгаа /Хэрэгцээ тодорхойлсоны дараах сургалтын үр дүнгийн судалгаа/




Сургалтын үр дүнгийн дараах үеийн эцэг эхийн сэтгэгдэл / Судалгаа-2 /

- Таны хүүхдэд энгийн хүүхдүүдтэй хамтарч бэлтгэл хийж, уралдаан тэмцээнд оролцоноор ямар өөрчлөлт гарсан вэ?



Сургалтын дараах үеийн дэмжин тоглогчийн сэтгэгдэлийн талаар / Судалгаа-2/

- Оюун ухааны бэрхшээлтэй хүүхэдтэй хамтарсан дугуйланд хамрагдсан таны анхны болон тэмцээний дараа төрсөн сэтгэгдэл



ДҮГНЭЛТ

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийг энгийн суралцагчдийн дунд хөгжүүлснээр тэдний өөртөө итгэх итгэл, өөрийгөө дайчлах чадвар зэрэг нь маш сайн нэмэгдсэн байна.

Мөн суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд хамтарсан спортын төрлөөр хичээллэснээр дасгал гүйцэтгэх, тоглох чадвар эзэмших, тэсвэр тэвчээрээр хатуужилтай, тууштай байх зан чанар маш сайн төлөвшсөн байна. Мөн хичээл болон дугуйлан, секц орох үйл явцад хүлээлт үүсэх, уралдаан тэмцээнийг хүсэх зэрэг давуу талууд бий болсон байна.

НОМ ЗҮЙ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль 2016
- Хүүхдийн эрхийн конвенц, 2008
- Биеийн тамир, спортын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ 2007
- Тэгш хамруулах боловсрол УБ 2016 10х, 31х

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧНЫ ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Ч.Жаргал докторант¹

¹Багшийн мэргэжил дээшлүүлэх институт

Түлхүүр үг:

Хүртээмжтэй орчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, дэд бүтэц, өөрийн үнэлгээ

Хураангуй:

БСШУС-ын сайдын 2019 оны 05 сарын 14-ний өдрийн А/292 тушаалаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамуулан сургах журам батлагдан гарсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамран сургах тойргийнхоо ЕБС-д суралцах эрх зүйн орчин баталгаажж, эцэг эхчүүд хүүхдээ ердийн сургуульд сургах хүсэл сонирхол нэмэгдсэн юм.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт 2018-2019 оны хичээлийн жилд нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчийн 136 ерөнхий боловсролын сургуульд зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах явцдаа сургуулийн хүртээмжтэй орчин, дэд бүтцийн стандарт үзүүлэлтэд өөрийн үнэлгээ хийлгэн үр дүнг нэгтгэсэн юм. Энэхүү өөрийн үнэлгээг хийлгэж, үр дүнг нэгтгэх боломжийг олгосон БМДИ-ийн захирал асан Д.Сүрэнчимэгт талархаж байгаагаа тэмдэглэх нь зүйтэй юм.

Судалгаанд оролцсон Ерөнхий боловсролын сургуулиудын хүртээмжтэй орчин, дэд бүтцийн стандарт үзүүлэлтийг хөндлөнгөөс шалгаж үнэлгээ өгөхөөсөө өөрсдөө сургуулийнхаа орчин, ойлголт хандлага, бодлого төлөвлөлтөд үнэлгээ өгсөн нь одоогийн нөхцөл байдлаа илрүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх арга замаа тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цаашлаад хүн бүрт ээлтэй хүртээмжтэй сургууль болох гарааны үнэлгээ нь болсон юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлого шийдвэр гарах нь асуудлыг бүрэн шийдэж буй хэрэг биш юм. Тухайн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд сургууль, хамт олны ойлголт хандлага, орчин, багшлах арга зүйн бэлэн байдлыг урьдчилан харж, арга зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай арга хэмжээг авч байх зохицуулалтын асуудлууд орхигдсоор байна.

Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 132 сургуульд өөрийн үнэлгээний

судалгаа, бага анги, дотуур байрын багш, сургуулийн нийгмийн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх 93 хүнээс тоон болон чанарын судалгаа хослуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургахад орчны хувьд тулгарах хүндрэл бэрхшээл, цаашидын хэрэгцээ шаардлагыг тодруулах судалгааг хийж гүйцэтгэхийг зорилоо.

Үндэслэл

БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээнд төрийн болон хувийн хэвшлийн 803 ерөнхий боловсролын сургуульд 6518 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаагийн 1638 харааны, 712 сонсголын, 958 хэл ярианы, 931 сэтгэцийн, 956 хөдөлгөөний, 1323 хавсарсан бэрхшээлтэй байна. (2018-2019 оны статистик), ҮСХ-ны 2018 оны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 3.2 хувь (105,691) нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 11 орчим хувийг (10,512) 0-17 насны хүүхэд эзэлж байна. Үүнээс ЕБС-д 6518 хүүхэд хамрагдаж, 2907 хүүхэд хамрагдаагүй байна. (БСШУСЯ, 2019). ЕБС-д хамрагдсан хүүхдээс 2779 нь бага боловсролд хамрагдсан байх ба тусгай 6 сургуульд 1740 хүүхэд суралцжээ. Сүүлийн 7 жилээр үзүүлсэн Бага дунд боловсролын нэгдсэн үзүүлэлтээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт тогтмол буурсан үзүүлэлттэй байна.

2019-2020 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод нийт 226 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 140 нь төрийн өмчийн, 115 төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль байна. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа нийт 292458 хүүхдийн 254466 хүүхэд нь төрийн өмчийн, 37992 хүүхэд нь төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Төрийн өмчийн сургуульд суралцаж байгаа 254466 хүүхдийн 2430 нь буюу 0,95 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. (Нийслэлийн статистик мэдээ)

Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургахад сургуулийн хүртээмжтэй орчин, дэд бүтцийн стандарт үзүүлэлт хэр түвшинд байгааг судлах нь судалгааны ажлын үндэслэл болж байна

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжтэй орчин, дэд бүтцийн стандарт үзүүлэлтийг хэрхэн хангаж байгаа талаарх өөрийн үнэлгээнд шинжилгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолдох хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Зорилт:

- Ерөнхий боловсролын сургуулиудад хүртээмжтэй орчин, дэд бүтцийн өнөөгийн байдлыг үнэлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд суралцахад тохиолдох орчны хүндрэл бэрхшээлийг илрүүлэх

- Сургуулийн хүртээмжтэй орчинг сайжруулахад эцэг эх багш нарын санал санаачлагыг тодруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй, ээлтэй сургуулийн орчинг бүрдүүлэхэд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

ЕБС-ийн хүртээмжтэй орчинг судлахдаа Нийслэлийн төрийн өмчийн 132 сургуулиас авсан 3 чиглэл 7 үзүүлэлт бүхий хүртээмжийн үнэлгээ, дэд бүтцийн стандартын 19 үзүүлэлттэй өөрийн үнэлгээний асуулга судалгаа, сонгогдсон сургуулиудаас санамсаргүй түүврээр холбогдох ажилтан, эцэг эхтэй бүлгийн, ганцаарчилсан ярилцлага, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг баримт бичигт шинжилгээ хийх замаар тоон болон чанарын судалгааг хослуулан ашигласан болно.

Хүснэгт 1. Судалгааны аргуудын танилцуулга

Арга	Судалгааны бүлгүүд	Зорилго
Асуулга	Нийслэлийн ЕБС-ийн удирдах болон аж ахуйн ажилтнууд	<ul style="list-style-type: none"> • Асуулгын зорилго нь сургуулийн хүртээмжтэй орчны өнөөгийн нөхцөл байдлаа өөрийн үнэлгээгээр илрүүлэн цаашид авч хэрэгжүүлэх арга замаа тодорхойлж буйг илрүүлэх Үргэлжлэх хугацаа 2 цаг
Ярилцлага	Бага ангийн багш, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, эцэг эх	<ul style="list-style-type: none"> • Зорилтот бүлгийн ярилцлагын аргаар тоон мэдээллээ чанаржуулах, мөн илүү нарийн мэдээлэл олж авах зорилготой. Үргэлжлэх хугацаа: Ойролцоогоор 1 цаг 30 минут
Баримт бичгийн	БСШУСЯ-ны статистик мэдээ	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын тоо, тэнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо мэдээлэлд анализ хийх

Хүснэгт 2. судалгаанд хамрагдсан оролцогчдын мэдээлэл

Арга	Өөрийн үнэлгээ, асуулга										Ярилцлага	
	БЗД	БНД	БХД	БГД	НД	ЧД	СБД	СХД	ХУД	Нийт	Бүлгийн	Ганцаарчилсан
Оролцогч												
Сургууль	27	2	1	20	5	17	24	18	18	132		
Багш											48	
Эцэг эх											19	
Дотуур байрын багш												2
Нийгмийн ажилтан											24	
Нийт	27	2	1	20	5	17	24	18	18	132	91	2

Үр дүн:

1.Судалгаанд нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчийн 134 сургууль хамрагдсаны 128 нь ердийн, 6 нь тусгай сургууль байна. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 107 сургууль нь хичээлийн 1 байртай, 22 сургууль нь хичээлийн 2-оос дээш байртай, 3 сургууль нь шинээр барьж буй барилга ашиглалтад ороогүй, 2 сургууль түрээсийн байранд хичээллэдэг байна. Мөн дээрх сургуулиудын хичээлийн байрны ашиглалтад орсон хугацааг авч үзэхэд (17,5 хувь) нь 1970 оноос өмнө баригдсан, (51.9 хувь) нь 1971-2008 онуудад, (30,5 хувь) нь 2009 оноос хойш ашиглалтад орсон байна.

Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин үндсэн шаардлага /MNS 6055:2009/ батлагдснаас хойшхи хугацаанд нийт судалгаанд хамрагдсан сургуулийн хичээлийн байрны дөнгөж (30,5 хувь) нь баригдсан байгаа нь одоо дагаж мөрдөж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн дэд бүтэц, орчны стандартыг хангасан барилга байгууламж ховор,

дийлэнхэд нь стандарт мөрдөгдөөгүйгээс тэр дундаа хөдөлгөөний болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд ихээхэн хүндрэл учруулж, нийгмийн харилцаанд оролцох, ердийн сургуульд суралцах боломж нь хязгаарлагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамрагдан суралцахад сургалтын байгууллагын орчин бэлэн биш байгааг харуулж байна.

2.Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн удирдах болон аж ахуйн ажилтны бүлгээс ХНХЯ-наас гаргасан 3 чиглэл 7 үзүүлэлтээр /0-100/ оноогоор үнэлэх хуудсаар өөрийн үнэлгээ хийлгэж үр дүнг нэгтгэн үзлээ. Үр дүнг нэгтгэхдээ нийслэлийн сургуулиудын үнэлгээг дүүргээр нэгтгэн, дүүргийн үзүүлэлтээс өөрийн үнэлгээний дундажийг тооцон гаргав. Өөрийн үнэлгээг (0-25) муу, (25-60) дунд, (61-75) сайн, (76-100) маш сайн гэж түвшинчлэн авч үзэхэд дараах дүр зураг харагдаж байна.Та өөрийн байгууллагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настнууд болон бусад иргэдэд ээлтэй хүртээмжтэй гэж үзэж байна уу?

Хүснэгт 3. Өөрийн үнэлгээний шинжилгээ

№	Чиглэл	Дүүрэг /асуулт	БНД	БХД	БГД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	Дундаж оноо	Үнэлгээ
1	Хүртээмж	Танай байгууллагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй орж гарах боломжтой гэж Та үздэг үү?	33.3	100	0	21.4	20	31.6	8.3	22.2	5.9	27.0
2		Танай байгууллагын ариун цэврийн ерөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой гэж Та үздэг үү?	33.3	0	10	7.1	0	10.5	16.7	5.6	0.0	9.2
3		Танай байгууллагын үзүүлж буй үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүрэн авах боломжтой гэж Та үздэг үү?	33.3	0	15	3.6	40	15.8	29.2	22.2	23.5	20.3
4		Танай байгууллагын авто зогсоолыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой юу?	0.0	100	30	7.1	20	26.3	16.7	16.7	5.9	24.7
5	Ойлголт хандлага	Танай байгууллага үйлчилгээгээ хүртээмжтэй болгох чиглэлээр ямар нэг зохион байгуулалт төлөвлөлтийг хийсэн үү?	0.0	100	40	14.3	20	10.5	16.7	11.1	5.9	24.3
6		Танай байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилладаг үү?	0.0	100	15	7.1	0	15.8	12.5	0.0	23.5	19.3
7	Бодлого төлөвлөлт	Танай байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчин бий болгох арга хэмжээг байгууллагын төлөвлөгөө болон төсөвтөө тусгадаг үү?	0.0	0	30	7.1	0	5.3	4.2	11.1	17.6	8.4

3.Энэхүү өөрийн үнэлгээг ХНХЯ-аас гаргасан байгууллагын наад захын хүртээмжийг илрүүлэх (0-100) онооны хуудсаар авсан судалгаанд шинжилгээ хийж үзэхэд сургуулиуд ээлтэй, хүртээмжтэй орчны өнөөгийн түвшингээ дунджаар 19 оноо буюу муу түвшинд байна гэж үзсэн байна. Налуу зам, бие засах газар, авто машины зогсоолын хүртээмжийг (20.3), ойлголт хандлага (21.8), бодлого хөтөлбөртөө

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө, төсөв тусгадаг эсэхээ (8.4) оноо буюу сургуулиуд бүх үзүүлэлтэд хангалтгүй гэсэн өөрийн үнэлгээ өгсөн байгаа нь анхаарал татаж байна. Судалгааны үр дүнг нэгтгэхэд 136 сургуулиас 3 сургууль өөрийн үнэлгээ хийгээгүй байна. Дэд бүтцийн стандарт үзүүлэлтийг 133 сургуулийн өөрийн үнэлгээгээр авч үзлээ.

Хүснэгт 4. Дэд бүтцийн стандарт үнэлгээнд өгсөн өөрийн үнэлгээ шинжилгээ

№	Стандарт үзүүлэлт	Тийм	Хувь
1	1x12 метрийн налууулалттай /	64	48,1
2	Бариул \geq 90 см Тэргэнцэр явах цэвэр зай \geq 90 см /налуу зам/	58	43,6
3	Барилгын өрөө тасалгаа руу орох хаалга \geq 85 см-ээс багагүй өргөнтэй эсэх	75	56,3
4	Өрөө тасалгааны доторх шалны гадаргуу нэг түвшинд байгаа эсэх болон хаалганы босго \geq 2,5 см-ээс өндөргүй байх	109	81,9
5	Хонгил, коридор 90 см-150 см зайтай байх	109	81,9
6	Шат: Гишгүүрийн өндөр \geq 15	114	75
7	Гишгүүрийн өргөн \geq 30 см	104	78,1
8	Шатны бариулын өндөр \geq 90 см	103	77,4
9	Ариун цэврийн өрөөгэрэгтэй эмэгтэй тус бүрийг нэгээс доошгүй төлөвлөсөн эсэх Ханын бариул \geq 80 см-н өндөрт бэхэлсэн эсэх	71	53,3
10	Суултуураас хаалга хүртэл \geq 150 см зайтай эсэх	72	54,1
11	Угаалтуур \geq 80 см-н өндөрт бэхэлсэн эсэх	92	69,1
12	Жижүүр, өлгүүр хэсгийн тавцангийн нэг хэсэг \geq 80 см-ээс өндөргүй байх	59	44,3
13	Сургуулийн анги танхим, байгууламжийн зохион байгуулалтыг харуулсан мэдээллийн самбар байгаа эсэх	89	66,9
14	Явах чиглэл, ариун цэврийн өрөө, гарцыг заасан тэмдэг тэмдэглэгээ байгаа эсэх	94	70,6
15	Сургуулийн номын санг ХБХ ашиглах боломжтой эсэх /стандарт/	77	57,8
16	Хооллох болон зуушны газрын түгээх хэсэг ба зорчих хэсгийн өргөн 1200 мм-ээс багагүй, байгаа эсэх	73	54,8
17	Хоёр ширээний хоорондох зай 90 см-ээс багагүй, эсвэл хана болон ширээний хоорондох зай 120 см-ээс багагүй зайтай эсэх	73	54,8
18	Хараагүй хүний хөтөч зам байгууламжийн гадна болон дотор төлөвлөсөн эсэх	11	8,2
19	Сургуулийн гадна талбайд тэргэнцэртэйгээ явах тэгш гадаргуу болон налууулалтыг хийсэн эсэх	75	56,3
20	Цахилгаан шат байгаа эсэх	4	3,0
21	Гадна орчны гэрэлтүүлэг хангалттай сайн эсэх	102	76,6
22	Сонсголын бэрхшээлтэй иргэдэд гамшигийн мэдээллийг хүргэх гэрэл дохио байгаа эсэх	31	23,3

4.Ерөнхий боловсролын сургуулиудад дэд бүтцийн стандарт үзүүлэлт тусгай сургуулиуд дээр өндөр хувьтай байна. Тухайлбал цахилгаан шаттай 4 суруулийн 2 нь тусгай сургууль байна. Дээрх шинжилгээнээс харахад сургуулийн барилгын дотор талын орон зайд тавигдах стандартуудын үзүүлэлт (54 хувиас) дээш, хараа сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй хүний хэрэгцээнд шаардлагатай үзүүлэлтүүд хангалтгүй (3.0-8.2) хувь байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд тэгш хамран суралцахад орчин хүртээмжгүй байгааг нотолж байна.

5. Ярилцлагын судалгаа:

Эцэг эх: Дэд бүтэц бүрэн биш ч гэлээ сайжирч байна. Хүртээмжтэй орчин, багш ажилчид, жирийн хүүхдийн эцэг эхийн хандлага багшийн арга зүй хөтөлбөр үнэлгээ, тохирох хэрэглэгдэхүүн сургууль хамт олны хамтын ажиллагаа, эцэг эхийн үүрэг хариуцлага гээд сайжруулах зүйл зөндөө байна. Хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдэд тохируулгат орчин хэрэгтэй болдог. Орчин бүрдээгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ямар орчин хэрэгтэй талаар сургууль үнэлгээ хийдэггүй.

Миний хүү тархины саажилттай. Хойтон сургуульд сууна. Аав нь хамт л сургуульд сууна даа. Баг ангид яах вэ өргөж тээгээд болоод байдаг. Дунд анги руу ороод ирэхээр хүүхэд маань томорно. Машинаар зайлшгүй хүргэдэг. Зогсоол олдохгүй буулгаж суулгахад хүч хүрэхгүй байдлыг би ижил бэрхшээлтэй аав ээжээс харж байна. Сургууль ядахдаа машины зогсоолд нэг тэмдэг тавьчихаас эхлэх ёстой шүү дээ.

Охин маань 2 жил тэгш хамруулалтаар энгийн цэцэрлэгт явж энэ жил улсын энгийн сургуульд суралцана. СӨБ эзэмшиж байх явцад энгийн эрүүл хүүхдүүдтэй адил орчин нөхцөлд байсан ба тухайн үед өөрийн чадах зүйлээ л хийж, чадахгүй зүйлээ зүгээр хараад суудаг байсан. Үүнээс үзэхэд тэгш хамруулалтанд орсон нь сайн хэрэг боловч өөрийн хийж чадахгүй (биеийн бэрхшээлээс болж) зүйл гарах үед цаг нөхцөөх байдалтай байдаг байсан нь үнэхээр харамсалтай. Тэгш хамруулж байна гээд нэг ангид оруулаад орчих биш бүхий л нөхцөл бололцоог бодолцон үзэж хөгжүүлдэг байвал зүгээр.

Ярилцлагын тэмдэглэлээс....

Дэд бүтэц хүртээмжтэй орчинг сайжруулахад дараах зүйлийг хийх нь оновчтой гэж үзсэн байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргаж шаардлагатай орчин бүрдүүлэх төсөв санхүүг шийдвэрлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхээр орчны үнэлгээ хийлгэх, тэд хүүхдийг онцлогийг харгалзан бодит үнэлгээг хийж чадна. Асуудлыг сургууль эцэг эх хамтран шийдвэрлэх

Бага ангийн багш: Тэгш хамруулан сургах бодлого хөтөлбөрийг дэмждэг, ангидаа 1-2 хөгжлийн бэрхшээлтэй, хүүхдийг аваад сургахад багшид асуудал үүсэхгүй. Нэмэлт дэмжлэг, туслах хүн шаардлагатай хүүхдүүдтэй ажиллахад хүнд байдаг. Бага ангид нь аав ээжүүд өргөж тээгээд сургуульд нь авч өгөөд байдаг харин дунд ангиасаа ХБХ завсарддаг. Энэ нь сургуулийн хүртээмжтэй орчноос шалтгаалж байгаа тал бий.

Тархины саажилттай хүүхэд 5 жил суралцаад төгсөхөд ахиц амжилтыг нь сонсоод ийм хүүхэд манай сургуульд нь байдаг байсан юм уу? гэж захирал гайхаж байсан. Энд сургуулийн удирдлагыг шүүмжлэхээс өмнө багш ангидаа байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн талаар тэдэнд ойлгуулах, хүүхэд, багшид ямар дэмжлэг хэрэгтэй байгаагаа ярьж танилцуулах нь чухал санагдсан.

Сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш: Бодлого шийдвэр гаргахдаа “Цонхоор харж байгаад” журам шийдвэр гаргаж байгаатай холбоотойгоор сургууль дээр зөндөө асуудал үүсдэг. Бэлтгэл хангагдаагүй, Хандлага харилцан адилгүй байна. Ойлголт мэдээлэл багатайгаас ХБХ-ийг хүлээн авахгүй, тусгай сургуульд явуулахыг дэмжих хэсэг ч байна. Жирийн хүүхдийн эцэг эхчүүд дургүйцэх хандлагатай, орчин нөхцөл бүрдээгүй, ялгаатай хэрэгцээ гэдгийг ч мэдэхгүй багш нар байсаар байна. Харин үе тэнгийн хүүхдүүд ялгаварлан гадуурхах үзэгдэл бараг гаргадаггүй. Дотуур байранд оюун, хэл, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд ирдэг. Бие эрхтний /хөдөлгөөн/ бэрхшээлтэй хүүхэд бараг амьдардаггүй. Амьдрахгүй байгаа шалтгаан нь хүртээмжтэй орчин, дэд бүтэцтэй холбоотой гээд дараах шийдвэрлэх арга замуудыг нэрлэсэн байна.

- Хуучны барилга бүхий сургуульд налуу шат, бусад хэрэглэгдэхүүнийг стандартын дагуу

бий болгох, сайжруулах

- Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай орчин, хэрэгсэлээр хангах
- Сургуулийн удирдах ажилтнуудыг хүртээмжтэй орчны чиглэлээр сургалтад хамруулж, засвар үйлчилгээ хийхдээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаардаг байхад чиглүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний эцэг эхтэй хамтран хүртээмжтэй орчны үнэлгээ хийж, асуудал бэрхшээлийг хамтран шийдвэрлэх
- Сургуулийн төсөв төлөвлөгөөндөө дэд бүтэц, хүртээмжтэй орчныг сайжруулахад шаардагдах хөрөнгийг тусгах
- Аливаа орчны шинэчлэл хийхдээ норм стандартыг баримтлах, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авдаг байх зэргээр шийдвэрлэх арга замуудыг нэрлэсэн байна.

Хэлцэмж:

Судалгаанд оролцогч сургуулиудын ихэнх хувь нь /MNS 6055:2009/ батлагдан гарахаас өмнө баригдсан хичээлийн байртай. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд хамрагдсан сургуулиудын дөнгөж 30.5 хувь нь 2009 оноос хойш баригдсан хичээлийн байртай байна. Сургуулиудын өөрийн үнэлгээ болон чанарын судалгааны үр дүнгээс харахад дэд бүтэц, орчны хүртээмж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерийн сургуульд тэгш хамран суралцахад ээлгүй байгаа нь харагдаж байгаа нь Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн хүрээн хийгдсэн хүртээмжтэй орчны нөхцөл хангалтгүй гэж үзсэн үр дүнтэй ойролцоо байна.

Монгол улсад Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэмд БД 31-101-04 “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль”, MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин”, MNS 6056:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөсөн заавар” зэргийг мөрдөхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 305 тоот тушаалаар баталсан байдаг. Гэвч ерөнхий боловсролын сургуулиудад тус дүрэмд

заасан стандартууд болон хүртээмжтэй орчны нөхцөл байдал хангалтгүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамран сургах БСШУС-ын сайдын А/292 тоот тушаал амжилттай хэрэгжих боломж тааруу байна.

Дүгнэлт :

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд суралцах нь хүртээмжтэй орчин, дэд бүтцийн стандарт хангагдсан эсэхээс хамааралтай байна.
- Ерөнхий боловсролын сургуулиудын барилга / хичээлийн байр/ - ууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжгүй, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн орчин, тусламж үйлчилгээг үзүүлж чадахгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд суралцахад суурь орчин бүрдүүлэх, бэлтгэл үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхгүй байна.
- Сургуулийн удиргах ажилтнуудад сургалтын байгууллагын хүртээмжтэй орчин, дэд бүтцийн чиглэлээр сургалт семинарь зохион байгуулах хэрэгцээ байна.

Ном зүй :

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. Улаанбаатар: ХНХЯ, Жайка ОУХАБ. 2017.х.40-47
2. Багшийн мэргэжил дээшлүүлэх онлайн сургалтын “Тэгш хамруулан сургах боловсрол” гарын авлага. Улаанбаатар:Битпресс. 2019.х.49
3. Дэд бүтцийн стандартын гарын авлага. Улаанбаатар: ХБХХХЕГ.2019. х.6-12
4. <https://www.legalinfo.mn/>

ИРГЭДИЙГ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ

Б.Баттуяа¹, Ж.Нарантуяа¹, Г.Батням¹

¹Налайх дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв

Түлхүүр үг:

Бэрхшээл, Гэрээр сургах, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, Үр дүн

Хураангуй:

Налайх дүүрэг нь Улаанбаатар хотоос 45 км-ын зайтай алслагдсан дүүрэг. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль байдаггүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхүүд Улаанбаатар хотруу хүүхдээ зөөж сургах боломжгүй байна. Манай төвд суралцаж байгаа сурагчдын 62% нь амьжиргааны түвшний дунджаас доогуур орлоготой байгаа нь хотруу тусгай сургуульд зөөж авах боломжгүйг харуулж байна. Дээрх бүх шалтгаануудаас үндэслэн гэрээр боловсролын үйлчилгээг хүргэж байгаа нь хамгийн тохиромжтой хэлбэр юм. Бодит байдлын судалгааг гарган ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж богино болон урт хугацааны зорилтоо зөв тодорхойлох нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, нийгэмшүүлэх, нийгэм ахуйн баримжаа олгох хамгийн оновчтой шийдэл юм. Гэрээр боловсролын үйлчилгээ авдаг 18 суралцагсдаас 8-н суралцагч нь бусдаас илүү хөгжиж, нийгэмшиж байна. Үлдсэн 10 суралцагч мөн адил нийгэм ахуйн баримжаатай болж, хувь хүний хөгжлийн хувьд ахицтай байгаа. Сардаа 1 удаа танхимаар ирж суралцаж байгаа нь нийгэмших, гадаад орчныг мэдрэх бусадтай харилцах олон нийтийн дунд өөрийгөө илэрхийлж байгаа нь тэдний хөгжиж байгааг харуулж байна. Иймээс гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулаад зогсохгүй тэднийг нийгэмд эзлэх байр суурь, нийгэм ахуйн баримжаатай болгож байгаа нь хувь хүний хөгжлийг дэмжсэн үр дүнгээ өгсөн ажил болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах нь жирийн хүүхэдтэй ажиллахаас өөр байдаг. Жирийн хүүхэдтэй харьцуулбал үр дүн нь маш удаан явцын дундаа илэрдэгт байгаа юм.

Үндэслэл


Тэгш хамруулан сургах гэдэг нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагсдын хаилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн үйл явц юм¹.

Судалгаа хийх болсон шалтгаан

1. Алслагдсан 3 дүүрэгт тусгай хэрэгцээт боловсролын байгууллага байдаггүй

2. Налайх дүүрэг нь Улаанбаатар хотоос 45 км-ын зайтай алслагдсан дүүрэг. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль байдаггүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхүүд Улаанбаатар хотруу хүүхдээ зөөж сургах боломжгүй байна. Тиймээс манай төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах зорилгоор 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн гэрээр боловсролын үйлчилгээг монголдоо анх удаа нэвтрүүлж эхэлсэн.

Манай төвд суралцаж байгаа ХБХ-ийн ар гэрийн амьжиргааны түвшин



Үүнээс үзэхэд: Манай төвд суралцаж байгаа сурагчдын 62% нь амьжиргааны түвшний дунджаас доогуур орлоготой байгаа нь хүүхдээ хотруу тусгай сургуульд зөөж авах боломжгүй байгааг харуулж байна. Дээрх шалтгаануудаас үндэслэн гэрээр боловсролын үйлчилгээг хүргэж байгаа нь хамгийн тохиромжтой хэлбэр юм.

Судлагдсан байдал ба хууль эрх зүйн үндэслэл

Бүх нийтийн боловсролын зорилтуудад хүрэхийн тулд тэгш хамруулан сургах боловсрол

¹ Боловсролын ОУ-ын 48-р бага хурлын дүгнэлт зөвлөмж. Женев 2008 оны 11 сар

нэн чухал билээ. 1960 онд ЮНЕСКО-гоос баталсан “Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх тухай конвенц” нь тэгш хамруулах боловсролын гол тулгуур бөгөөд боловсролын салбарт үл ялгаварлал, тэгш хандлага, тэгш боломж гэсэн зарчмуудыг эрхэмлэдэг.

Монгол улс 1964 онд уг конвенцид нэгдэн орсон. 1948 оны НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон 1989 оны НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцид ялгаварлан гадуурхалыг хориглож хүүхэд бүр боловсрол эзэмших эрхтэйг заасан байдаг. 1993 оны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох НҮБ-ын стандарт дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд тэгш боломж олгохыг дэмжиж, 1994 оны ЮНЕСКО-гийн Саламанкагийн мэдэгдэлд “ Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн гарал, сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа болон бусад нөхцөл байдлыг үл харгалзан хүүхэд бүрийг авч сургах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Тэгш хамруулах боловсрол нь бүх хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн сурах хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд энэхүү үзэл баримтлал нь 1990 оны Бүх нийтийн боловсролын дэлхийн бага хурал болон Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх Саламанкагийн мэдэгдлийн суурь болж Дакарын боловсролын форумар дахин баталгаажсан билээ². Монгол улсын БСШУС-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан “ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах” журмыг баталсан.

Зорилго

Боловсролын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан, гэрээр боловсрол нөхөн олгож байгаа өнөөгийн байдал үр дүнг тооцон гаргахад оршино.

Зорилт

1. Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?
2. Гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тодорхойлох
3. Судалгаа авч нэгтгэх

² Саламанкагийн тунхаглал ЮНЕСКО

4. Үр дүнг тооцох

Судалгааны объект

Налайх дүүргийн Албан бус – Насан туршийн боловсролын төвийн гэрээр болон танхимаар боловсролын үйлчилгээ авдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд


Судалгааны арга зүй

- ✓ Ажиглах
- ✓ Асуулгын
- ✓ Математик статистик арга,
- ✓ Түүврийн

Үр дүн

Судалгаа 1


Налайх дүүргийн хэмжээнд сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй 128 хүүхэд байна үүнээс:



Дээрх сургуулиудад 105 хүүхэд танхимаар болон гэрээр боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдаж байна. Огт хамрагдаагүй 23 хүүхэд боловсролын үйлчилгээ авах боломжгүй маш хүнд хэлбэрийн хавсарсан бэрхшээлтэй байна.

Судалгаа 2

Албан бус-Насан туршийн боловсролын төвийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагсадыг танхимаар болон гэрээр боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан байдал. /Сүүлийн 5 жил /



Дээрх судалгаанаас үзэхэд: Гэрээр болон танхимаар боловсролын үйлчилгээнд хамрагдсан суралцагсдаас нийт 13 суралцагч суурь боловсрол. 1 суралцагч бүрэн дунд боловсрол эзэмшсэн. 2019-2020 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролыг 2 суралцагч, суурь боловсролыг 2 суралцагч эзэмших гэж байна.

Судалгаа 3

Гэрээр боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа 18 суралцагсдын гарсан үр дүн өөрчлөлт:

№	Хариуцсан багш	Сурагч	Анх байсан	Гарсан үр дүн
1	Ж.Нарантуяа	Ч.Эрдэнэчулуун	<p>- 2015 онд 10 настай байхдаа судалгаагаар илэрч манай төвд гэрээр боловсролын үйлчилгээ авч эхэлсэн. Онош нь. ДЦП.</p> <p>- Орилж хашгирдаг, хүн хараад зугтаадаг, буруу хардаг, үзэг бал болон хичээлийн хэрэглэгдэхүүний талаар анхан шатны мэдлэггүй. Хэвшмэл давтагдмал үйлдэлтэй байсан.</p>	<p>2018 онд Аутизм гэж оношлогдсон.</p> <p>Одоогийн байдлаар: Олны дунд орилж хашгирч гүйх нь багассан долоо хоногт 1 удаа танхимаар хичээлд суудаг. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг мэддэг болж зураасан зураг дуурайж зурдаг, Амьдрах чадварт маш сайн суралцсан бөгөөд ар гэрийн ажилд тусалдаг болсон.</p>
2	Б.Сарантуяа	У.Эрдэнэмөнх Эрдэнэмөнх	<p>2017 онд 10 настай байхдаа судалгаагаар илэрч манай төвд гэрээр боловсролын үйлчилгээ авч эхэлсэн. Онош нь.ДЦП</p> <p>-Шүлс нь мэдрэлгүй гоождог, хүний хэлсэн ярьсаныг ойлгохгүй, хичээлийн хэрэглэгдэхүүний анхан шатны мэдлэггүй, дураараа , хувийн ариун цэвэр сахидаггүй байсан.</p>	<p>Шүлсээ арчдаг болсон</p> <p>Цэг холбож зурдаг болсон .Хичээлийн хэрэглэгдэхүүнийг зориулалтаар нь хэрэглэж сурч байгаа.</p> <p>Хувцасаа өмсөх, хоолоо цэвэрхэн идэх зэрэг ахуйн баримжаатай болсон. Багштайгаа хамтран ажиллаж хийдэг байсан дасгалаа өөрөө бие даан хийж чаддаг болсон. Шүр сувсан урлалын дугуйланд хамрагдан бүтээл хийж сурч байгаа.</p>
3	Б.Баттуяа	Т.Гантогос	<p>2015 онд 9 настай байхдаа судалгаагаар илэрч гэрээр боловсролын үйлчилгээнд хамрагдаж ирсэн.</p> <p>Онош нь: ДЦП Тархи болон 4 мөчиндөө саажилттай, булчингын чангаралтай. Өөрийгөө илэрхийлэх чадваргүй, бие дааж сууж чадахгүй байнгын асаргаатай. Оюун ухаан хэвийн.</p>	<p>Одоогоор 13 настай. Ахуйн баримжаа сайн эзэмшсэн боловч бие дааж гүйцэтгэж чадахгүй байгаа, харааны ой тогтоолт хөгжиж байгаа, бүх үсгээ мэддэг богино үгийг уншина. Ойр зуурын тогтоосон үгээ Ipad ашиглан хамрынхаа тусламжтайгаар бичдэг. Өнгө болон монгол улсын мөнгөн тэмдэгтүүдийг ялгаж сурсан. Тоо танина, өөрийгөө үйл хөдлөл, дохиогоор илэрхийлнэ. Багштайгаа харьцах чадвартай</p>
4	З.Бейсен	Г.Энх-Од	<p>2018 онд 8 настайдаа судалгаагаар илэрсэн. Тархины гэмтэл саажилттай. Ярьж чадахгүй. Дохио зангаагаар харилцаж ярьдаг. Бие бялдрын хувьд сул алхаж чаддаггүй. Хичээлийн хэрэглэгдэхүүний анхан шатны мэдлэггүй байсан.</p>	<p>Одоо 9 настай. Өөрийгөө илэрхийлэх чадварт суралцаж байгаа. Зураг зурж өнгө ялгадаг болсон. Зургаар өөрийгөө илэрхийлдэг болсон.</p>
5	С.Баярмаа	Г.Мөнхшүр	<p>2013 онд 9 настай байхдаа судалгаагаар илэрч гэрээр боловсролын үйлчилгээнд хамрагдаж ирсэн.</p> <p>Онош нь: ДЦП Тархи болон 4 мөчиндөө саажилттай, булчингын чангаралтай. Өөрийгөө илэрхийлэх чадваргүй, бие дааж сууж чадахгүй байнгын асаргаатай. Оюун ухаан хэвийн.</p>	<p>Одоогоор 18 настай. Ахуйн баримжаа сайн эзэмшсэн боловч бие дааж гүйцэтгэж чадахгүй байгаа, харааны ой тогтоолт хөгжиж байгаа, бүх үсгээ мэддэг богино үгийг уншина. Өнгө болон монгол улсын мөнгөн тэмдэгтүүдийг ялгаж сурсан. Бичих болон унших чадварыг эзэмшиж байгаа ойр зуурын үгийг бичиж холбож тооцоолон бодох чадвартай болсон.</p>

6	Э.Элбэг	Б. Зулбаяр	2013 оны хичээлийн жилд. 10 настай байхдаа манай төвд ирсэн. Онош: ДЦП. Булчин чангаралтай учраас үзэг, бал барих боломжгүй, ахуйн баримжааг бие даан гүйцэтгэх боломжгүй, өөрийгөө илэрхийлэхгүй, өнгө ялгахгүй, гар хөлийн хөдөлгөөн хяналтгүй.	Одоо 16 настай. 1-200 хүртэл өгсүүлж тоолно. Эгшиг үсгээ таньдаг болсон. Өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг учраас бусадтай харилцаанд орж чадахгүй байсаар байна. 14 хоногт 1 удаа танхимаар ирж хичээлдээ сууж олон хүүхдүүдтэй хамт байснаар нийгэмшиж байна.
7	Л.Мөнгөнцэцэг	Б. Түшиг	2018 онд 8 настай, ЕБС-д суралцах боломжгүй шалтгаанаар манай төвд ирсэн. Онош: ДЦП. Булчингийн чангаралтай. Үзэг, бал барихад хүндрэлтэй. Эгшиг үсгээ мэддэг, өнгө, хэлбэр дүрс сайн ялгана, багштайгаа чөлөөтэй ярилцдаг суралцагч байсан.	2019 онд чөлөөтэй уншдаг, 100-ийн дотор тооцоолох чадварт суралцаж байгаа. Бичих чадвар бэрхшээлтэй нь холбоотойгоор сайжрахгүй байгаа, гэрээр болон танхимаар хичээллэдэг. Эцэг эхийн хүсэлтийг харгалзан дармалаар бичихэд суралцаж байна. нийгэмшихүйн болон ахуйн баримжаа сайтай.
8	А.Цэндсүрэн	Б. Тэмүүлэн	2018 оны хичээлийн жилд Хос-Уянга сургуулиас шилжин ирсэн. 14 настай байхдаа ирсэн. Ердийн ЕБС-д суралцах болмжгүй шалтгаантай. Онош: тулгуур эрхтний бэрхшээл, булчингийн агших хавсарсан. Оюун ухаан, дээд мөчний үйл ажиллагаа хэвийн боловч хязгаарлагдмал. Өнгө ялгана, бичиг үсэг мэдэхгүй, 100 хүртэлх тооны нэмэх, хасах үйлдлийг багшийн тусламжтайгаар хийнэ	2019 онд 15 настай. Хэт ачаалал өгөлгүйгээр суралцаж байгаа. Үзэг, бал, харандаа зэргийг бие даан барьж зориулалтын дагуу сургалтдаа хэрэглэж чаддаг. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг бүрэн ашиглаж мэднэ. Эгшиг 7 болон зарим гийгүүлэгч үсгийг таньдаг. Харааны ой тогтоолтоор богино үе, үгийг нүдлэн тогтоодог. Компьютерийн хэрэглээний зарим программыг ашиглаж чаддаг. /зураг зурах, цахим орчинд нэвтрэх, гарах чадвартай/


Гэрээр боловсролын үйлчилгээ авдаг 18 суралцагсадаас 8-н суралцагчийг жишээ болгон авсан боловч, үлдсэн 10 суралцагч мөн адил нийгэм ахуйн баримжаатай болж, хувь хүний хөгжлийн хувьд ахицтай байгаа. Сардаа 1 удаа танхимаар ирж суралцаж байгаа нь нийгэмших, гадаад орчныг мэдрэх бусадтай харилцах олон нийтийн дунд өөрийгөө илэрхийлэх аргад суралцаар байгаа нь тэднийг хөгжиж байгааг илэрхийлж байна.

Хэлцэмж:

Эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн байдал. Судалгаанд танхимаар болон гэрээр боловсролын үйлчилгээг авч байгаа 35 суралцагсдын эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хамрагдлаа.


1. Та энэ төвд хүүхдээ өгснөөр ямар бодолтой явдаг вэ?

■ Сэтгэл хангалуун байдаг ■ Хэлж мэдэхгүй байна ■ сэтгэл дундуур байдаг



Үүнээс үзэхэд манай төвд хүүхдээ хамруулснаар сэтгэл хангалуун байдаг гэж 71% нь хариулсан байна. Нийт суралцаж байгаа хүүхдүүдийнхээ 71% нь хүрч ажиллаж байгаа нь багш нарын ур чадвар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж гэсэн сэтгэл юм.

2. Та хүүхдээ УБ хотын тусгай сургуульд сургах боломжтой юу?



Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдээ Улаанбаатар хотод байдаг тусгай хэрэгцээт боловсролын сургуулиудад хүүхдээ сургах боломжгүй байгаа нь харагдаж байна.

Багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арг зүйд бэлтгэгдсэн байдал

2014 оноос хойш тус төв нь багш нараа тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх тал дээр анхаарч үе шаттайгаар бэлтгэж эхэлсэн.

№	Багш нарын нэрс	Тусгай хэрэгцээт боловсролоор бэлтгэгдсэн байдал	Сертификаттай сургалт болон бусад
1	Б. Баттуяа	3 удаагийн сургалтад хамрагдсан.	Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах аргазүй
2	С. Баярмаа	3 удаагийн сургалт	ХБХ-ийн эцэг эхийг чадавхжуулах АББ ба тэгш хамрах боловсрол сургалт Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах аргазүй
3	З. Бейсен	2 удаагийн сургалтад хамрагдсан	ХБХ-ийн эцэг эхийг чадавхжуулах Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах
4	Л. Мөнгөнцэцэг	2 удаагийн сургалтад хамрагдсан	ХБХ-ийн эцэг эхийг чадавхжуулах Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах
5	Ж. Нарантуяа	7 удаагийн сургалт	Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловруулах аргазүйн сургалт Хөгжлийн бэрхшээлийг таних, Дауны синдромтой хүүхэдтэй ажиллах аргазүй Кимико багшийн сургалтад 3 удаа хамрагдсан ХБХ-ийн эцэг эхийг чадавхжуулах Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах аргазүй
6	Б. Сарантуяа	Налайх дүүргийн тусгай хэрэгцээт боловсролоор бэлтгэгдсэн ахисан түвшний багш	
7	А. Цэндсүрэн	1 удаагийн сургалтад хамрагдсан	Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах
8	Э. Элбэг	1 удаагийн сургалтад хамрагдсан	Тусгай хэрэгцээт боловсролыг холимог бүлэгт зохион байгуулах

Дүгнэлт

Албан бус Насан туршийн боловсролын төв нь 2014 оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлж эхэлснээр Налайх дүүрэгтээ болон Монгол улсын хэмжээнд анх удаа шинээр санаачлан зохион байгуулсан ажил юм. 2014-2019 онуудад давтагдсан тоогоор 86 хүүхдэд гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлсэн байна. Гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлснээр дараах дэвшилтүүд гарсан. Үүнд.

1. Багш нар тусгай хэрэгцээт боловсролоор үе шаттайгаар чадавхжиж эхэлсэн
2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

боловсруулан ажиллаж байна.

3. Танхимаар суралцах боломжгүй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах эрх нь тодорхой хэмжээгээр хангагдсан.
4. Гэрээр боловсролын үйлчилгээ авч буй сурагчид нийгэм ахуйн баримжаатай болсон
5. Мөн цаашлаад унших, бичих, тооцоолох чадварт суралцсан.
6. Оюун ухааны бэрхшээлгүй 13 хүүхэд суурь, 1 хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 4 хүүхэд энэ хичээлийн жилд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшихээр суралцаж байна.

7. Хөгжлийн бэрхшээлтэй 3 суралцагчийн стандартыг нөхөн олгож “Эрдмийн Оргил” цогцолбор сургууль руу шилжүүлэн суралцуулсан нь энэ хичээлийн жилд бүрэн дунд боловсрол эзэмшинэ.

Эдгээрээс харахад гэрээр боловсролын үйчилгээг үзүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулаад зогсохгүй тэдний нийгэмд эзлэх байр суурь, нийгэм ахуйн баримжаатай болгож хувь хүний хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болох нь харагдаж байна.

Ном зүй

1. ADRA Mongolia., Тэгш хамруулах боловсрол., УБ., 2016 он
2. ADRA Mongolia., Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ., УБ., 2016 он
3. БСШУСЯ., Тэгш хамруулах боловсрол., УБ., 2019 он
4. UNICEF., Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй., 2019 он
5. БСШУЯ., Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй., 2007 он

ГУЯНЫ АРЫН БУЛЧИНГИЙН ЧАНГАРАЛ НЬ НУРУУНЫ ӨВДӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ SITSMART АШИГЛАН СУУХ БОЛОН ЭНГИЙН СУУХ ҮЕИЙН НУРУУН ДЭЭР ИРЭХ АЧААЛАЛ БОЛОН ААРЦАГНЫ ЭРГЭЛТИЙГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ

Н.Цэсэнжав¹ М.Эрдэнэтуяа №

№ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийн хөдөлгөөн засалч

Хураангуй

Дэлхий дахинд нурууны өвдөлт нь хүн амын дунд эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг үүсгэж буй шалтгааны нэг бөгөөд 10 хүний 8 нь амьдралын туршид ямар нэгэн байдлаар их бага хэмжээтэйгээр нурууны өвдөлтөнд өртсөн байдаг. Их Британийн үндэсний эрүүл мэнд болон тусламж үйлчилгээний интистутын удирдамжинд нурууны өвөрмөц бус өвдөлтийг “нурууны хэсэгт үүсэх хүчний сулрал, хөшүүн байдал болон уян хатан чанар алдагдах шинж тэмдгээр илрэх бөгөөд өвдөлтийн шалтгаан болон нарийн шалтгааныг тодорхойлох боломжгүй өвдөлт юм” хэмээн тодорхойлжээ. Уг өвдөлтийн улмаас ажилдаа сэтгэл ханамжгүй байх, сэтгэл гутрах болон ажлын үр бүтээмж муудах зэрэг сөрөг үр дагавар гардаг. Гуяны арын бүлэг булчин чангарснаар аарцаг арагш эргэлт (Pelvic posterior tilt) хийж буруу төрх байдалтай суух үндэс болдог. Ингэснээр нуруунд хэт ачаалал ирж нурууны өвдөлтийг үүсгэж байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон. Натул эмнэлэгт 2019 оны 1-2 сард хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдээс нурууны өвдөлттэй 15, нурууны өвдөлтгүй 15-н хүнийг сонгож судалгаанд хамруулсан. Судалгааг дараах аргачлал, тестээр явуулсан. Үүнд: VAS-ийн үнэлгээ, Papliteal Angle Test, Шобер тест, далайц хэмжих, Sitsmart зэргийг ашигласан. Нурууны өвдөлттэй үйлчлүүлэгчийн гуяны арын булчингийн чангарал их байна. Үүнээс шалтгаалан өвдөлт их байна. Судалгаанаас үзэхэд гуяны арын булчингийн чангарал нь суух үеийн аарцагны эргэлтийг дэмжиж нуруун дээр ирэх ачааллыг ихэсгэж нуруу өвдөх шалтгаан болж байна.

Түлхүүр үг:

Үнэлгээ, үений далайц, аарцаг, төрх байдал, өвөрмөц тест

Үндэслэл

Дэлхий дахинд нурууны өвдөлт нь хүн амын дунд эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг үүсгэж буй шалтгааны нэг бөгөөд 10 хүний 8 нь

амьдралын туршид ямар нэгэн байдлаар их бага хэмжээтэйгээр нурууны өвдөлтөд өртсөн байдаг¹. Нурууны өвдөлтийн 85%-г өвөрмөц бус өвдөлт эзэлдэг. Уг өвөрмөц бус өвдөлтийн үед эмгэг өөрчлөлт, шинж тэмдэг болон дүрс оношилгооны хооронд холбоо хамаарал сул байдаг. Харин дискийн цүлхийлт 4%, хугарал 4%, спондилит 3% болон хавдар 1%-г тус тус эзэлдэг². Их Британийн үндэсний эрүүл мэнд болон тусламж үйлчилгээний интистутын удирдамжид нурууны өвөрмөц бус өвдөлтийг “нурууны хэсэгт үүсэх хүчний сулрал, хөшүүн байдал болон уян хатан чанар алдагдах шинж тэмдгээр илрэх бөгөөд өвдөлтийн шалтгаан болон нарийн шалтгааныг тодорхойлох боломжгүй өвдөлт юм” гэж тодорхойлжээ³. Өвөрмөц бус өвдөлтийн шалтгаан одоог хүртэл нарийн тогтоогдоогүй байна. Гуяны арын булчингийн чангарал, булчин холбоосын гэмтэл, диск болон фасет үений дегенератив өөрчлөлт, дискийн цүлхийлт ойролцоох мэдрэлийн дарагдал, нугасны хөндийн нарийсалт, багана нурууны муруйлт болон дотрын өвчний улмаас нурууны өвдөлт үүсч болдог. Уг өвдөлтийн улмаас ажилдаа сэтгэл ханамжгүй байх, сэтгэл гутрах болон ажлын үр бүтээмж муудах зэрэг сөрөг үр дагавар гардаг⁴. Ажлын байранд хөдөлгөөнгүй удаан хугацаагаар буруу төрх байрлалтай сууснаар хүзүү, нуруугаар чилж төрх байдал алдагдах мөн үүнээс болоод нуруу өвдөх үндэс болдог. Зөв суух нь дээд зэргийн тав тухтай байдлыг хангаж өгдөг ба удаан суухад нуруунд ирэх ачааллыг багасгаж, ажлын ачааллаа бага ч гэсэн хөнгөвчлөх, ядрахгүй, стрессдэхгүй байх ач тустай.

Гуяны арын бүлэг булчинд (m.hamstring) хагас шөрмөслөг булчин (m.semitendinosus) суудал ясны төвгөрөөс эхэлж гуяны арын хэсгээр үргэлжлэн явж шаант ясны урд дотно гадаргууд төгсдөг. Хагас хальслаг булчин (m.semimembranosus) суудал ясны төвгөрөөс эхлэн шаант ясны дотно ёрвонд төгсдөг. Гуяны арын хоёр толгойт булчин (m.bicepsfemoris) - Урт толгой: суудал ясны төвгөрөөс эхлэн гуяны

арын хэсгээр үргэлжлэн тахилзуур ясны толгойд төгсдөг харин богино толгой нь дунд чөмөгний дотор шугамны гадна эрмэгээс эхлэн, гуяны арын хэсгээр үргэлжлэн тахилзуур ясны толгойд төгсдөг. Эдгээр булчин бүлгээрээ агшихдаа түнх тэнийлгэх, өвдөг нугалах үүрэгтэй булчин юм.⁵ Гуяны арын бүлэг булчин чангарснаар аарцаг арагш эргэлт (Pelvic posterior tilt) хийж буруу төрх байдалтай суух үндэс болдог. Ингэснээр нуруунд хэт ачаалал ирж нурууны өвдөлтийг үүсгэж байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Судалгааны зорилго

- Гуяны арын булчингийн чангарал нь нурууны өвдөлтөд нөлөөлөх нь
- Sitsmart ашиглан суух болон энгийн суух үеийн нуруун дээр ирэх ачаалал болон аарцагны эргэлтийг харьцуулна судлах

Судалгааны зорилт

1. Нурууны өвдөлтийг үнэлэх
2. Гуяны арын булчингийн чангаралыг тодорхойлох
3. Гуяны арын булчингийн чангаралтай болон чангаралгүй оролцогчийн аарцагны эргэлтийг харьцуулах
4. Багана нурууны хөдөлгөөнийг үнэлэх
5. Энгийн суух болон Sitsmart ашиглан суух үеийн аарцагны эргэлтийг үнэлэх

Судалгааны арга аргачлал

Натул эмнэлэгт 2019 оны 1-2 сард хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдээс нурууны өвдөлттэй 15, нурууны өвдөлтгүй 15-н хүнийг сонгож судалгаанд хамруулсан. Судалгааг дараах аргачлал, тестээр явуулсан. Үүнд:

1. VAS-ийн үнэлгээ (0-10) – 6с дээш бол өвдөлттэй
2. Rapliteal Angle Test – р гуяны арын булчингийн чангаралыг хэмжинэ
3. Шобер тест-р аарцагны арагш эргэлт хэмжих
4. ROM хэмжих- багана нурууны хөдөлгөөнийг үнэлэх
5. Dorsavi ViMove ашиглан – Багана нурууны төрх байдлыг тодорхойлох
6. Sitsmart ашиглана аарцагны эргэлтийг тодорхойлох
7. Стастик боловсруулалтыг SPSS 21paired тестээр харьцуулан судалсан.

Хэмжилт 1


Rapliteal Angle Test – р 60°-с доош градустай хүмүүсийг чангаралтай гэж үзсэн



Зураг 1. Гуяны арын булчингийн чангарлыг илрүүлэх тест

Хэмжилт 2

Шобер тест-р 10см-с доош байвал аарцаг хойш эргэлт хийсэн гэж үзсэн



Зураг 2. Аарцагны эргэлтийг илрүүлэх тест

Хэмжилт 3

ROM хэмжих - их бие нугалах 60°-с доош, түнх нугалах 120°-с доош, өвдөг тэнийлгэх 0°-с дээш байвал багана нурууны хөдөлгөөн хязгаарлагдсан гэж үзнэ.



A. Trunk flexion

B. Hip flexion

B. Knee extension

Хэмжилт 4

Оролцогчдын ландмаркын тэмтэрч PSIS дээр маркераар тэмдэглэгээ хийж өндрийн хэмжээгээр SENSOR FITTING ORDER тохируулан байрлуулж EMG DORSAVI нааж багана нурууны төрх байдлыг тодорхойлсон.



Хэмжилт 5

Sitsmart ашиглан болон энгийн суух үеийн аарцагны эргэлтийг хажуугийн хавтгайд үнэлэхэд

- А. Sitsmart ашиглан суухад аарцагны эргэлт болон багана нурууны төрх байдал хэвийн харагдаж байна.
- Б. Энгийн суух үед аарцаг хойш эргэлт хийж цээжний гифоз ихсэж төрх байдал алдагдсан байна.



А.

Б.


Судалгаанд ашигласан багаж

Ландмаркын цэг дээр стикер наах	Гениометр	Метр	VAS үнэлгээ	Биед эвтэйхэн хувцас
Dorsavi ViMove төхөөрөмж	Sensor fitting order		Sitsmart	

Судалгааны үр дүн

- Судалгаанд хамрагдсан 30 үйлчлүүлэгчийн Vas-ын үнэлгээгээр нурууны өвдөлтийг үнэлсэн.

Зураг 1. Vas-ын үнэлгээ



Хүснэгт 1. Нурууны өвдөлттэй болон өвдөлтгүй үйлчлүүлэгчдийн Гуяны арын булчингийн чангаралыг харьцуулсан үр дүн

Үзүүлэлт	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Тахимны өнцгийн хэмжээ	54.1±6.0*	77±13:3

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.

Хүснэгт 2. Нурууны өвдөлттэй болон өвдөлтгүй үйлчлүүлэгчдийн аарцагны хазайлтыг харьцуулсан үр дүн

Үзүүлэлт	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Шовер тест хэмжээ	9.4±0.6	14.2±0.9

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.

Хүснэгт 3. Нурууны өвдөлттэй болон өвдөлтгүй үйлчлүүлэгчдийн үений далайцыг харьцуулсан үр дүн

Үзүүлэлт	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Их биеийн нугалах	49.7±4.1*	60.0±0.0
Түнх нугалах	97.5±7.5*	120.0±0.0
Өвдөг тэнийлгэх	12.5±6.3*	0.0±0.0

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.


Хүснэгт 4. Нурууны өвдөлттэй үйлчлүүлэгчдийн Sitsmart ашиглан суух болон энгийн суух үеийн аарцагны эргэлт болон багана нурууны төрх байдлыг Dorsavi ViMove төхөөрөмжөөр үнэлж харьцуулсан үр дүн

№	Үений далайц	Эгц суух хэвийн хэмжээ	Smart суудал ашиглан суух	Энгийн өөрийн суултаар суух
1	Цээжний кифоз	5ө	9.0 ± 3.9	15.4 ± 5.6
2	Бүсэлхийн нугалах	17ө	15.0 ± 6.7	25.2 ± 7.9
3	Аарцагны арагш эргэлт	12ө	18.0 ± 12.0	34.0 ± 19.7

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.


Хэлцэмж -1

- Priliteal Angle Test-ийн үед 90° байвал хэвийн байдаг бол чангаралтай хүнд бүрэн тэнийхгүй байна. (Хүснэгт1)




Хэлцэмж -2

- Шобер тестийн үед 15 см байвал аарцагны эргэлт хэвийн гэж үздэг. Харин гуяны арын булчингийн чангаралтай хүнд аарцаг арагш эргэлт хийсэн байна.(Хүснэгт2)




Хэлцэмж -3

- Хэмжилтээр булчингийн чангаралтай хүний далайц хязгаарлагдаж багана нурууны хөдөлгөөн буурсан байна.(Хүснэгт3)



Хэлцэмж-4

- Хэмжилтээр гуяны арын булчингийн чангаралтай хүн энгийн суух үед аарцаг хойш эргэлт хийж цээжний кифоз ихсэж багана нуруун дээр ачаалал авч буруу төрх байдалтай сууж байна. Sitsmart ашиглан суух үед аарцагны арагш эргэлтийг хязгаарлаж багана нуруун дээр ирэх ачааллыг багасгаж байна.(Хүснэгт4)



- Нурууны өвдөлтийн үед үений далайц, аарцаг бүсэлхийн алдагдал элбэг тохиолддог. Нурууны өвдөлттэй болон өвдөлтгүй оролцогчдыг хамруулсан судалгаанд багана нурууны үений бүх далайц нурууны өвдөлттэй оролцогчдод багассан байсан нь ажиглагдсан(Laird, Gilbert, kent, & keating, 2014). Багана нурууны кинематик болон хөдөлгөөнд өөрчлөлт орох нь нурууны өвдөлтийн үндсэн эрсдэлт хүчин зүйлсийн нэг учир үнэлгээ болон эмчилгээний үед кинематик болон гуяны арын булчингийн чангарал, аарцагны эргэлт, хөдөлгөөний өөрчлөлтийг үнэлэх нь чухал ач холбогдолтой (Scholtes, Gombatto, &Van Dillen, 2009; Tafazzol, Arjmand, Shirazi-Adl, & Parnianpour, 2014; Van Dillen,Gombatto, Collins, Engsborg, & Sahrman,2007; Zhou, Ning,& Fathallah, 2016). Дээрх судалгаануудад багана нурууны хөдөлгөөнийг статик байрлалаас тодорхойлж, агшны судалгааны загварыг ашигласан байна. Олон улсын судлаачдыг харахад 3 гурван хэмжээст камер, өндөр хурдны камер, хурдатгал хэмжигч болон соронзон резонанст томографи зэргийг ашиглаж байна. Хэдийгээр манай улсад багана нурууны хөдөлгөөн, булчингийн чангарал, аарцагны эргэлтийг тодорхойлох олон төрлийн багаж хэрэгсэл байгаа боловч 3 гурван хэмжээст камер нь хамгийн нотолгоо өндөртэй буюу "Golden Stantard"-д тооцогдож байна. Гурван хэмжээст камер багана нурууны хөдөлгөөн, аарцагны эргэлтийг хамгийн зөв алдаа багатай

тодолхойлдог боловч өндөр зардал тусгай бэлдсэн лаборатори зэрэг нь манай улсад тутагдалтай байна. Мөн тухайн оролцогчдыг өдөр тутмын амьдралын үйл явцад нь багана нурууны хөдөлгөөн болон аарцагны эргэлтийг тодорхойлох боломжгүй зэрэг нь сул тал болж байна. Энэхүү судалгааг сүүлийн үеийн дэвшилтэд технологи Dorsavi ViMove төхөөрөмжөөр багана нурууны төрх байдал, аарцагны эргэлтийг тодорхойлсон давуу тал болж байгаа. Үүний зэрэгцээ нурууны өвдөлтийн улмаас багана нурууны далайц болон хөдөлгөөн алдагддаг эсэхийг тодорхойлохын тулд дагаж судлах судалгааны загвар ашигласан судалгааны ажлууд чухал шаардлагатай байна.

Судалгааны дүгнэлт

1. Нурууны өвдөлтэй оролцогчийг нурууны өвдөлтгүй оролцогчтой харьцуулахад гуяны арын булчингийн чангарал их байна. Үүнээс шалтгаалан өвдөлт их байна.
2. Гуяны арын булчингийн чангаралтай оролцогчдын аарцаг арагш эргэсэн байна.
3. Аарцагны эргэлт мөн булчингийн чангаралтай холбоотой их бие болон түнх, өвдөгний далайц буурсан байна.
4. Нурууны өвдөлтэй оролцогчдын гуяны арын булчингийн чангарал нь суух үед аарцагны арагш эргэлтийг дэмжиж багана нурууны төрх байдлыг алдагдуулж байна.
5. Удаан хугацаагаар нуруун дээр ачаалал авч буруу төрх байдалтай суух нь нурууны өвдөлт үүсэх шалтгаан болж байна.
6. Sitsmart ашиглаж суух нь аарцагны арагш эргэлтийг хязгаарлаж нуруун дээр ирэх ачааллыг бууруулж байна
7. Судалгаанаас үзэхэд гуяны арын булчингийн чангарал нь аарцагны эргэлтийг дэмжиж нуруун дээр ирэх ачааллыг ихэсгэж нуруу өвдөх шалтгаан болж байна.

Зөвлөмж :

- Та суухдаа сандлын түшлэг, нуруу хоорондын зайнд зузаан дэр хийх
- Суусан үед 2 хөлийн доор гэшгүүр тавьж суух
- Та газраас тонгоож юм авахдаа өвдгөөр бүрэн нугарч сууж авах

- Та унтах буюу амарч хэвтээд босох үедээ заавал хажуу тийш харж хэвтсэн байрлалтай болж орноос босно. Шууд өндийж босож болохгүй.
- Та зогсоо ажил хийдэг бол хөлийн гишгүүрийг ээлжлэн ашиглах хэрэгтэй.
- Та хүнд зүйл өргөх үедээ цээжиндээ нааж авч явах хэрэгтэй. Биенээс хөндий барьж явж болохгүй.
- Та унтах, амрахдаа хэт их өндөр болон нам дэр хэрэглэхгүй. Өөрт таарсан дэрийг биеийн түвшинд байрлуулж хэрэглэнэ.
- Та өөрт тохирсон дасгал хөдөлгөөнийг мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч тогтмол хийх шаардлагатай.
- Удаан хугацаагаар суух үед Sitsmart ашиглан суух нь нуруун дээр ирэх ачааллыг бууруулж таатай мэдрэмжийг төрүүлнэ.

Ном зүй

1. Balague, F., Mannion, A. F., Pellise, F., & Cedraschi, C. (2012). Non-specific low back pain. *Lancet*, 379(9814), 482-491. doi :10.1016/s0140-6736(11)60610-7
2. Deyo, R.A., Rainville, J., & Kent, D.L. (1992) What can they history and physical examination tell us about low back pain? *Jama*, 268(6), 760-765.
3. National Collaborating Center for Primary, C.(2009). National Institute for Health and Clinical Excellence: Guidance Low Back Pain: London: Royal Collage of General Practitioners (UK) Royal Collage of General Practitioners
4. Zho, j. ,Ning, X., & Fathallah, F.(2016). Differences in lumbopelvic rhythm between trunk flexion and extension *Clin Biomech* (Bristol, Avon), 32, 274-279 doi: 10.1016/j.clinbiomech.2015.10.012
5. Мөнх-Эрдэнэ.Б Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл Нурууны өвөрмөц бус өвдөлтийн үнэлгээ болон судалгааны асуудал (2018) 8-р дугаар (хуудас 23-25)

СУРГУУЛИЙН ӨМНӨХ АХЛАХ НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ЭРТ ҮЕИЙН ИЛРҮҮЛЭГ, ДЭМЖЛЭГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Х.Алтанхундага¹, Б.Туяа²

¹ОТИС-ийн СХСС-ын тэнхимийн багш,

²МУБИС-ийн Сэтгэл судлал, арга зүйн тэнхимийн эрхлэгч, Доктор, профессор

Хураангуй

Хөгжингүй орнуудад хүүхдийг 0-3 насанд, зарим улсад 0-5 насанд нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, сэргээн засах болон эмчилгээ, оношилгоо зэрэгт хамруулах талаар хууль тогтоомж, журам, дүрмийг тогтолцоондоо тусган хэрэгжүүлж ирсэн байна. Бид энэхүү судалгаагаар сургуулийн өмнөх ахлах насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт үеийн илрүүлэх аргыг турших, хүүхдийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэглэн үр дүнг тооцох зорилго тавилаа. Судалгаанд цэцэрлэгийн 4 настай 610 хүүхэд, 52 хүүхдийн эцэг эх асран хамгаалагч, багш нарыг сонгон хамруулав. Судалгааг Японы судлаач Reiko Kurosawa (2008) боловсруулсан “Хүүхдийн зан үйлийн асуулга”-ын аргаар хийхэд 610 хүүхдийн 2.7 % нь хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай гэж илрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай гэж илэрсэн 17 хүүхдийн 4 хүүхэд давхар бэрхшээлтэй байх магадлал илэрсэн. Сургуулийн өмнөх ахлах насны хүүхдийн дунд хөгжлийн бэрхшээлийн илрүүлгийн аргыг хэрэглэх боломжтой тул цаашид цэцэрлэгийг түшиглэн судалгааг хийх шаардлагатай байна.

Түлхүүр үг:

Аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, суралцахуйн бэрхшээл, зан үйлийн эмгэг

Удиртгал

Хүүхдэд хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэдэнд үүсэж байгаа аливаа гэмтэл согогийг амжилттай засах, боловсрол олгох зэрэг асуудал нийгмийн салбарын маш хязгаарлагдмал хүрээнд яригддаг байсан бол одоо нийт үндэстний хэмжээнд авч үзэх болсон. Монгол улс олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон орны хувьд хөгжлийн бэрхшээлийг нийгмийн үзэгдлийн

хувьд ойлгох, бодлого, үйлчилгээг төлөвлөх аргачлал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийн эрхийг хамгаалах, эрх зүй бодлогын таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллаж ирсэн байна. Харин үүнийг дагасан тогтолцоо, үйлчилгээ, олон нийтийн хандлагын өөрчлөлт шинэчлэл удаашралтай байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд чанартай, хүртээмжтэй, нийгмийн үйлчилгээг авахад хүндрэл байсаар байна. Тухайлбал цэцэрлэгт өдөр тутмын үйл ажиллагааны явцад үеийн хүүхдээс хөгжлийн хувьд хоцорсон, хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай хүүхдийг илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх ажлын зохион байгуулалт дутмаг байдал практикт харагдаж байна. Хүүхдийн хэрэгцээнд тохирсон дэмжлэг үйлчилгээ, сургалтыг зохион байгуулах нь бүх нийтийн боловсролд тэгш хамрагдах боломжийг бий болгоно гэж үзэж байна.

Тиймээс дээрх онцлог, нөхцөл байдалд үндэслэн бидний судлаачид сургуулийн өмнөх ахлах насны хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай хүүхдийг илрүүлэх, түүнд үндэслэсэн дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ үүсэж байна гэж үзэн энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн илрүүлэлтийн онол арга зүй, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэх асуудлаар Е.М.Мастокова, Н.Н.Печера, Э.Л.Фрукт бусад, Л.С.Выготский, Л.Я.Гальперин, А.В.Запорожец, А.Н.Лурия зэрэг эрдэмтэд судалж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, засан сайжруулах онол арга зүйн үндэслэлийг тодорхойлох, тэдэнд тохирсон нийгмийн дэмжлэг чухал болохыг дэвшүүлжээ. Манай улсын хувьд судалгаа, шинжилгээний ажил болон эрх зүйн орчны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай олон нийтийн дунд эерэг хандлага бий болгох, хүүхэд бүрийн хөгжих, суралцах эрхийг хангах зэрэгт чиглэгдсэн олон ажил хийгджээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг судлах талаас нь Д.Баттуяа “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай

хүүхдийн хөгжлийн судалгаа 4-7 настай хүүхдийн жишээн дээр” (2003), Б.Нарантуяа “Улаанбаатар хотын зургаа хүртэлх насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлсэн дүн” (2018), Ж.Мөнхнасан “Авианы буруу дуудлагыг засах арга замыг судалсан нь (2019) зэрэг диссертацийн ажил байна. Мөн “Бяцхан эрдэмтэн” ТББ-аас 2016 онд нийслэлийн цэцэрлэгийн 3-5 насны 864 хүүхдийн дунд хийсэн судалгааны үр дүнгээс авч үзэхэд нийт хүүхдийн 22,9% буюу 221 хүүхэд хэл яриа, харилцааны бэрхшээлтэй байна (Мөнхнасан.Ж,2019) гэжээ.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, суралцахуйн бэрхшээл, зан үйлийн эмгэгийн хүрээнд) эрт илрүүлэх аргыг турших, үр дүнд тулгуурлан хүүхдийг дэмжих үйл

ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэглэн үр дүнг тооцох

Зорилтууд:

- Япон судлаачдын боловсруулсан хөгжлийн бэрхшээлийн шинжийг илрүүлэх аргыг Монгол түүвэр дээр зохицуулах;
- Сургуулийн өмнөх ахлах насны хүүхдэд хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх аргыг турших, үр дүнг тооцох;
- Хөгжлийн бэрхшээлтэй байх магадлал илэрсэн хүүхдэд дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, тэдний хөгжлийн ахицыг үнэлэх

Судалгааны арга зүй

Судалгааны ажил 3 үе шаттай зохион байгуулагдсан болно. Арга зүй тус бүрийг зургаар харуулав.

Зураг.1 Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас - 1-р шат

<p>Аргын нэр: Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас (“Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулагдаж, цэцэрлэгт ашиглагдаж ирсэн.)</p>		
<p>Аргын онцлог: 7 чадамж 17 дэд хэсэг 115 асуулттай. Давтамж, тохироцоор 1-5 хүртэл оноогоор үнэлнэ. Хичээлийн жилд 2 удаа бүлгийн багш, судлаач үнэлгээг хийж болно.</p>		
<p>Хөдөлгөөн эрүүл мэндийн чадамж 3 дэд хэсэг 28 асуулт - Биеийн хөдөлгөөнөө удирдах - Гар хурууны хөдөлгөөнөө удирдах - Эрүүл мэндээ хамгаалах</p>	<p>Нийгэмшихүйн чадамж 3 дэд хэсэг 23 асуулт - Зан чанар - Сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах - Бусадтай харилцах</p>	<p>Хэл ярианы чадамж 3 дэд хэсэг 20 асуулт - Сонсох, ойлгох - Ярих - Унших, бичих бэлтгэл</p>
<p>Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж 2 дэд хэсэг 10 асуулт - Орчноо шинжлэн судлах - Орчинтойгоо харилцах</p>	<p>Математикийн чадамж 2 дэд хэсэг 14 асуулт - Тоолох - Хэмжих</p>	
<p>Дүрслэх урлагийн чадамж 2 дэд хэсэг 12 асуулт - Зурах - Урлах</p>	<p>Хөгжмийн чадамж 2 дэд хэсэг 12 асуулт - Дуулах, хөгжимдөх - Бүжиглэх, жүжиглэх</p>	

Зураг 2 Хүүхдийн зан үйлийн асуулгын аргачлал -2-р шат

<p>Аргын нэр: Хүүхдийн зан үйлийн асуулга Японы судлаач Reiko Kurosawa (2008) боловсруулсан.</p>	
<p>Аргын онцлог: 4 шкал 14 дэд шкал 125 асуулттай. Давтамжаар 1-5 хүртэл оноогоор бүлгийн багш, эцэг эх үнэлгээг хийнэ.</p>	
<p>Шкал-1: Аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлалыг илрүүлэх - Нийгэмшил - Бусадтай харилцах - Давтамжтай үйлдэл хийх гэсэн 3 дэд шкал 33 асуулт</p>	<p>Шкал-2: Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтэй байх магадлалыг илрүүлэх - Анхаарал төвлөрөхгүй байх - Хэт хөдөлгөөнтэй байх - Цочмог зан гаргах гэсэн 3 дэд шкал 30 асуулт</p>
<p>Шкал-3 Суралцахуйн бэрхшээлтэй байх магадлалыг илрүүлэх - Сэтгэн бодох чадвар - Сонсох чадвар - Ярих чадвар - Дуулах, зурах чадвар - Том, жижиг булчингийн хөгжил гэсэн 5 дэд шкал 33 асуулт</p>	<p>Шкал-4 Зан үйлийн эмгэгтэй байх магадлалыг илрүүлэх - Зан үйлдэл - Сэтгэл хөдлөл - Өдөр тутмын үйл ажиллагаа гэсэн 3 дэд шкал 33 асуулт</p>

Судалгааны аргын үнэлгээ: Багш, эцэг эхээс асуулт бүрийн ард 1-5 хүртэл тохирох оноог үнэлнэ.

Хүснэгт 1 Үнэлгээ

Давтамж	Огт үгүй	Хааяа	Заримдаа	Үе үе	Үргэлж
Оноо	1	2	3	4	5

Нэг дэх шатны судалгаанд хүүхдийн оноо ахих тутам хөгжлийн чадамжийн чанарын ахиц гарна. Хоёр дахь шатны судалгаанд хүүхдийн оноо ахих тутам хөгжлийн бэрхшээлтэй байх магадлал илэрнэ. Энэхүү арга нь оношилгооны аргачлал биш бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, багш нар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх зорилготой. Асуултын оноогоор дэд шкалын оноо гаргаж Радарын график байгуулна. Ингэхдээ төв цэгээс 1-5 хүртэл дугаарласан бүсэд тохируулан оноог байрлуулна. Хэрэв тухайн шкалд 3-аас дээш оноотой үнэлэгдсэн бол хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай гэж илэрнэ.

Бидний судлаачид “Хүүхдийн зан үйлийн асуулга” аргыг зохицуулан хэрэглэсэн бөгөөд найдвартай байдлыг авч үзье.

Хүснэгт 2 Асуулгын найдвартай байдлын үзүүлэлт

Шкал	Cronbach's Alpha	Rho_A	Composite Reliability	Average Variance Extracted
Аутизмын хүрээний эмгэг	0.884	0.884	0.927	0.809
Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг	0.882	0.884	0.927	0.809
Суралцахуйн бэрхшээл	0.897	0.903	0.925	0.712
Зан үйлийн эмгэг	0.904	0.905	0.940	0.840

Хүснэгтээс үзэхэд Cronbach's Alpha, Rho_A, Composite Reliability нь 0.8-аас дээш, Average Variance Extracted 0.7-аас дээш байгаа нь найдвартай, асуулт оновчтой, тухайн дэд шкалыг бүрэн илэрхийлэхүйц байна.


Хүснэгт 3 Илрүүлэгт хийсэн регрессийн шинжилгээ

Шкал	R Square	R Square Adjusted
Аутизмын хүрээний эмгэг	1.00	1.00
Анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг	0.999	0.999
Зан үйлийн эмгэг	0.999	0.999
Суралцахуйн бэрхшээл	1.00	1.00

R Square буюу детерминацын коэффициент 0.99-1.00 байгаа нь бидний авч үзсэн 125 асуулт нь аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, зан үйлийн эмгэг, суралцахуйн бэрхшээл болох 4 шкалыг 99-100% тайлбарлаж байна гэж үзэж болохоор болно.

Хүүхдийн хөгжлийн эрт үеийн илрүүлэг судалгааны үр дүн.

2018-2019 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын үндсэн сургалтад 4 настай 29555 хүүхдүүд хамрагдсан байна. (<http://www.edub.edu.mn>)



Судалгааны түүврийн хэмжээг 95 хувийн итгэх магадлалтай, алдааны нарийвчлал 2.8 байхаар тооцоолж <https://www.surveysystem.com/sscalc.htm> сайтын Sample Size Calculator программаар тооцоолоход боломжит түүврийн хэмжээ 1176 байвал болохоор байна. Бид үүний 50-аас дээш хувь болох 22 цэцэрлэгийн 28 бүлгийн 610 хүүхдээр судалгааны хамрах хүрээг тогтоосон.

Нэг дэх шатны судалгааны үр дүн: Судалгаанд хамрагдсан 4 нас 1сар- 4нас 12 сартай 610 хүүхдийг хүйсээр нь ангилан харвал 49.6 % эрэгтэй, 50.3% эмэгтэй хүүхэд эзэлж байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хүйсийн харьцаа ойролцоо байна. Судалгааг “Хүүхдийн хөгжлийн ахицын ажиглалтын хуудас”-ны үнэлгээний арга зүйг ашиглан зохион байгуулсан. Хүүхэд бүрийн хөгжлийг улсын дундажтай харьцуулан, гурваас дээш чадамж нь нэгдүгээр бүлэгт хамрагдаж буй бол эрсдэлтэй, хөгжлөөр хоцрогдолтой байх магадлалтай гэж үзэж болох бөгөөд хүүхдэд илүү анхаарал тавьж, учир шалтгааныг нь тодруулах шаардлагатай. (Норжхорлоо, 2017) гэж үздэг байна. Бидний судалгаагаар 610 хүүхдээс гурав болон түүнээс дээш чадамж нь нэгдүгээр бүлэгт 52 хүүхэд байна.

Хүснэгт 4 “Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ”ний үр дүн

Чадамж	I бүлэг	II бүлэг	III бүлэг	Нийт
Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж	26	23	3	52
Нийгэмшихүйн чадамж	21	26	5	52
Хэл ярианы чадамж	30	15	7	52
Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж	24	20	8	52
Математикийн чадамж	31	11	10	52
Дүрслэх урлагийн чадамж	31	12	9	52
Хөгжмийн чадамж	34	12	6	52
Нийт	197	119	48	364

Нийт 52 хүүхдийг 7 чадамж тус бүрийг үнэлгээний хүснэгтээс харахад нэгдүгээр бүлэгт 54.1% буюу 197 бол хоёрдугаар бүлэгт 32.6% буюу 119, гуравдугаар бүлэгт 13.4 % буюу 48 байна. Энэ нь 52 хүүхдийн үнэлгээнд нэгдүгээр бүлэг ихэнх хувийг эзэлж байгааг харуулж байна. Судалгаагаар илэрсэн 52 хүүхдэд хоёр дахь шатны судалгаа болох илрүүлгийг хийх асуудал зүй ёсоор тавигдаж байгаа гэж үзэж хамрах хүрээ болгон авсан болно.

Хоёр дахь шатны судалгааны үр дүн. Судалгааг “Хүүхдийн зан үйлийн асуулга”-ын аргаар 52 хүүхдийн эцэг эх, бүлгийн багш нарыг оролцуулан зохион байгуулсан. Судалгааны

дүнгээс үзэхэд нийт 52 хүүхдийн 17 хүүхэд буюу 32% нь хөгжлийн бэрхшээлтэй байх магадлал илэрсэн байна. Сургуулийн өмнөх ахлах насны хүүхдийн түүвэр болгож сонгогдсон 610 хүүхдийн 2.7 % нь хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай гэж илэрсэн 17 хүүхдээс 2,9,52,42 гэсэн кодтой хүүхдэд давхар бэрхшээлтэй байх магадлал илэрсэн гэж үзэж болохуйц байна. Судалгааны дүнг хүснэгт 5-д харуулья

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай хүүхдийг илрүүлсэн дүн

	Илэрсэн хүүхдийн тоо	Хүүхдийн код					
		2	6	8	10	30	52
Аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлал	6	2	6	8	10	30	52
Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй байх магадлал	6	7	9	13	26	29	49
Суралцахуйн бэрхшээлтэй байх магадлал	5	2	-	24	32	42	52
Зан үйлийн эмгэгтэй байх магадлал	5	-	9	20	25	42	52

Дээрх 17 хүүхэд тус бүр дээр байгуулсан Радарын графикийг тохиолдлын арга(Case study) ашиглан аутизмын хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээлтэй байх магадлалтай гэж илэрсэн 2 кодтой хүүгийн оноонд үндэслэн байгуулья.

Хүснэгт 6 “А “ хүүгийн мэдээлэл

Аутизмын хүрээний эмгэг	Оноо	Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөн	Оноо
I-1 Нийгэмшил	3.9	II-1 Анхаарал төвлөрөхгүй байх	3.7
I-2 Бусадтай харилцах	3.8	II-2 Хэт хөдөлгөөнтэй байх	3.0
I-3 Давтамжтай үйлдэл хийх	4.1	II-3Цочмог зан гаргах	2.8
Суралцахуйн бэрхшээл	Оноо	Зан авир - үйлдэл	Оноо
III-1 Сэтгэн бодох чадвар	3.4	IY-1Зан үйл	3.4
III-2 Сонсох чадвар	3.2	IY-2 Сэтгэл хөдлөл	4.0
III-3 Ярих чадвар	3.1	IY-3 Өдөр тутмын үйл ажиллагаа	2.8
III-4 Зурах, дуулах чадвар	3.4		
III-5 Том, жижиг булчингийн хөгжил	3.3		



Бид гурав дахь шатны судалгааг хийхийн өмнө аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлалтай гэж илэрсэн 6 хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж ажилласан болно. Хөтөлбөрийн бүтцийн зураг 3-д харуулав.

Зураг 3. Дэмжих үйл ажиллагааны бүтэц




Бид дэмжих үйл ажиллагааг 69 удаагийн үйл төлөвлөлтөөр 2018.09.25-2019.05.15 хүртэлх хугацаанд 7 хоногт 2-3 удаа дараах чиглэлийн дагуу зохион байгуулсан.

- харилцаа- нийгэмшихүй үйл ажиллагаа -16 удаа буюу 24%
- өөртөө үйлчлэх чадвар -15 удаа буюу 22%
- танин мэдэхүй -10 удаа буюу 16%
- хэл яриа-15 удаа буюу 22%

- хөдөлгөөн-13 удаа буюу 18% болно.

Нийт урт хугацааны 14, богино хугацааны 42 зорилтыг тодорхойлон ажилласан болно. Нэг удаагийн дэмжих үйл ажиллагааны үе шатны явцыг тодорхойлон илэрхийлбэл:

Зураг 4. Нэг удаагийн дэмжих үйл ажиллагааны үе шат



Хүүхдийн хөгжлийн үр дүн нь эцэг эх, багшийн хамтын ажиллагаанаас ихээхэн хамаардаг тул бид эцэг эхэд зориулсан зөвлөгөө, ганцаарчилсан уулзалт, ярилцлага, чөлөөт ажиглалтын тэмдэглэл зэрэг хэлбэрээр 15 удаа хамтран ажилласан болно.

Гурав дахь шатны судалгааны үр дүн. Бид аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлал илэрсэн 6 хүүхдэд дэмжих үйл ажиллагааг зохион байгуулсны дараа хоёр дахь шатны судалгаанд хэрэглэсэн арга зүйг ашиглан судалгааг хийсэн. Судалгааны үр дүнг харахад хөгжлийн түвшинд бага зэргийн ч гэсэн ахиц гарсан дүр зураг харагдаж байна.

Зураг 5 Хүүхдийн хөгжлийн ахицын үзүүлэлт

	Хүүхдийн код	2			6			8			10			32			52				
		II	III	A	II	III	A	II	III	A	II	III	A	II	III	A	II	III	A		
Аутизмын хүрээний эмгэгтэй	1.1	Нийгэмшил	3.9	3.0	0.9	3.0	2.8	0.2	3.7	3.5	0.2	3.8	3.5	0.3	3.2	3.0	0.2	4.1	3.5	0.6	2.4
	1.2	Бусадтай харилцах	3.8	3.5	0.3	3.3	3.0	0.3	3.5	3.0	0.5	2.7	3.5	0.8	3.0	2.8	0.2	3.6	3.0	0.6	1.1
	1.3	Давтамжтай үйлдэл хийх	4.1	3.3	0.8	3.5	3.5	0	2.8	2.9	0.1	3.5	3.0	0.5	3.4	3.0	0.4	3.2	3.8	0.6	1
Анхаарлын дутимшил хэт хөдөлгөөнтэй эмгэгтэй байх	2.1	Анхаарал төвлөрөхгүй байх	3.7	3.7	0	3.6	3.8	0.2	3.0	3.0	0	3.0	3.0	0	2.6	2.1	0.5	2.9	3.0	0.1	0.2
	2.2	Хэт хөдөлгөөнтэй байх	3	2.8	0.2	3.1	2.8	0.3	2.9	2.5	0.4	3.1	2.5	0.6	3.1	3.0	0.1	2.0	2.0	0	1.6
	2.3	Цочмог зан гаргах	2.8	2.8	0	2.8	2.6	0.2	3.0	2.0	1	3.6	3.0	0.6	2.7	2.3	0.4	2.7	2.0	0.7	2.9
Суралцауын бэрхшээлтэй байх магадлал	3.1	Сэтгэн бодох чадвар	3.4	3.0	0.4	3.4	3.0	0.4	3.1	2.8	0.3	3.4	2.8	0.6	3.0	3.0	0	3.7	2.8	0.9	2.6
	3.2	Сонсох чадвар	3.2	3.5	0.3	3.1	2.8	0.3	3.2	3.0	0.2	3.3	3.0	0.3	2.6	3.0	0.4	3.8	2.9	0.9	1
	3.3	Ярих чадвар	3.1	3.2	0.1	2.3	2.5	0.2	3.3	3.0	0.3	2.2	2.0	0.2	2.5	2.5	0	3.0	3.5	0.5	-0.3
	3.4	Зурах, дуулах чадвар	3.4	3.0	0.4	2.7	2.9	0.2	3.4	3.0	0.4	3.6	3.8	0.2	2.7	3.5	0.8	3.7	3.6	0.1	-0.3
	3.5	Том жижиг булчингийн хөгжил	3.3	3.0	0.3	3.1	3.0	0.1	3.1	2.6	0.5	3.5	3.5	0	3.0	3.0	0	3.8	3.5	0.3	1.2
Зан үйлийн эмгэгтэй байх магадлал	4.1	Зан үйл	3.4	2.8	0.6	3.7	2.9	0.8	3.3	3.0	0.3	3.8	2.8	1	3.6	2.6	1	4.0	3.3	0.7	4.4
	4.2	Сэтгэл хөдлөл	4.0	3.0	1	3.8	3.0	0.8	3.4	3.0	0.4	3.1	2.5	0.6	3.0	2.8	0.2	4.2	2.8	1.4	4.4
	4.3	Өдөр тутмын үйл ажиллагаа	2.8	2.5	0.3	3.6	3.0	0.6	3	2.8	0.2	2.5	2.5	0	2.4	2.0	0.4	3.9	3.3	0.6	2.1

Тайлбар: I - 2 дахь шатны судалгааны дүн, II- 3 дахь шатны судалгааны дүн

Хэлцэмж

Бид хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх ахлах насны хүүхдийг илрүүлэх зорилгын хүрээнд Японы эрдэмтэн Reiko Kurosawa (2008)-гийн боловсруулсан “Хүүхдийн зан үйлийн асуулга” аргыг зохицуулан хэрэглэж ажилласан. Энэхүү аргачлал нь олон улсад туршигдаж найдвартай, баталгаатай болох нь тогтоогдсон бөгөөд Манай улсад ч бас энэхүү аргачлалыг монгол хувилбарт буулган хэрэглэх боломжтой гэдэг нь бидний судалгааны дүнгээс харагдаж байна.

Цэцэрлэгт явж байгаа хүүхдийг үе тэнгийнхэнтэй нь жишиж үзээд хөгжлийн бэрхшээлийг илрүүлж болохыг судалгааны үр дүнгээс харж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай хүүхдийг илрүүлж, үр дүнг тооцож ажиллах нь хязгаарлагдмал боломжийг буй болгож байгаа анхдагч эх үүсгэвэр, түүний явцыг саармагжуулах, цаашид гарч болох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чухал ач холбогдолтойг харуулж байна. Цаашид цэцэрлэгийг түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, түүнд үндэслэн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэх чиглэлээр улс орон бүхэн өөр өөр шалгуур үзүүлэлтээр үнэлдэг учраас дэлхийн хэмжээнд нэгдсэн стандарт байдаггүй байна. Бидний судалгааны нэг дэх шатанд хамрагдсан 610 хүүхдээс хөгжлийн эрсдэлтэй гэж 52 хүүхэд илэрсэн. Хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан нийт 52 хүүхдээс 17 хүүхэд буюу 32% нь хөгжлийн бэрхшээл илэрсэн. Эдгээрээс 6 хүүхэд буюу 11% нь аутизмын хүрээний эмгэгтэй байх магадлалтай, 6 хүүхэд буюу 11% нь анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй байх магадлалтай, 5 хүүхэд буюу 9% нь суралцахуйн бэрхшээлтэй байх магадлалтай, 5 хүүхэд буюу 9% нь зан үйлийн эмгэгтэй байх магадлалтай гэж илэрсэн нь цэцэрлэгт үеийн хүүхдээс хоцорч буй, хөгжлийн бэрхшээлтэй байх магадлалтай хүүхэд байгааг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх ахлах насны хүүхдийг илрүүлэх гадаадын аргачлалын аргыг зохицуулан хэрэглэхэд

найдвартай байдлын Cronbach's Alpha, Rho_A, Composite Reliability нь 0.7-оос дээш, Average Variance Extracted 0.5-аас дээш гарсан нь асуултууд оновчтой, тухайн дэд шкалыг бүрэн илэрхийлэхүйц байна.

Хэдийгээр хүүхдэд хөгжлийн бэрхшээлтэй байх магадлал илэрсэн боловч хүүхдийн хөгжлийн давуу талд нь түшиглэн сул талыг нь хөгжүүлэх, дараагийн асуудлыг үүсэхээс сэргийлэх боломжтой юм. Иймээс бид хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж хамт олон дунд нь хөгжүүлж, хүүхэд бүр хөгжих эрхийг нь эдлүүлэхийг хичээн ажилласан болно. Бид судалгааны үр дүнд үндэслэн дараах санааг дэвшүүлж байна.

1. Хүүхдийг бага насных нь туршид хөгжлийн явцад хяналт тавих нь хөгжлийн ямар нэгэн хэвийн бус байдлыг илрүүлж, зохих арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул цэцэрлэгт үүнийг анхаарч ажиллах эрх зүйн орчин дутагдалтай байна.
2. Цэцэрлэгийн багш нарын зүгээс хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцсоны дараа хөгжлөөр хоцрох эрсдэлтэй байгаа хүүхэд илэрсэн тохиолдолд хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх судалгааг хийж эрт илрүүлэх шаардлагатай байна.
3. Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг хүүхдэд тохируулах бус, хүүхэд бүрт тохирсон сургалтын хөтөлбөрийг боловсруулж ажиллах нь үр дүнтэй юм.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд цэцэрлэгийн багш нарыг сургах бодит ажлыг хийх шаардлагатай байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх ажлын хүрээг өргөжүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоо болон тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах хэрэгцээ үүссэн байгааг анхаарах хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ:

1. Autism Association of Mongolia (2015)
Аутизмын хүрээний эмгэг
2. Autism Association of Mongolia (2018)
Аутизмтай хүүхэдтэй Монгол эцэг эхчүүдийн түгээмэл асуултууд. УБ
3. Батцэнгэл.Г. (2014). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэл зүйн зарим асуудал . УБ.
4. Баттуяа.Ц (2006) Боловсролын тусгай хэрэгцээт шаардлагатай хүүхдийн хөгжлийн судалгаа. 4-7 настай хүүхдийн жишээн дээр, УБ,
5. Мөнхнасан.Ж(2019) Хүүхдийн авианы буруу дуудлагыг засан сайжруулах , туршилт үр дүнгийн судалгаа
6. Норжхорлоо.Н. (2017). *Хүүхэд бүрийн хөгжлийн төлөө*. УБ.
7. Крайг.Г. (2001). *Психология развития*.
8. Колганова. В.С(2015) Нейропсихологические занятия с детьми. М
9. Назарова.Н. М(2010) Специальная педагогика
10. Reiko Kurosawa (2008) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах гарын авлага
11. A guide to Assessment an Early Childhood, Infancy to age eight, 2008
12. Лаура Е. Берк.(2006) Развитие ребенка. Москва
13. Стребелова, Е. (2005). Психологи-педагогическая диагностика развития детей раннего и дошкольного возраста.
14. World bank (2009) *Examining early child development in Low-income countries: a toolkit for the assessment of children in the first five years of life Washington,*
15. Feinberg.E, Silverstien.M, Donahue.S&Bilss.R. (2011). *Developmental and Behavioral Pediatrics (32/4)*

ГУЯНЫ АРЫН БУЛЧИНГИЙН (M.HAMSTRING) ЧАНГАРАЛ НЬ АЛХАА БОЛОН ТӨРХ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Э.Баасанхүү¹ Д.Батлхам²

Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төв Хөдөлгөөн засалч¹
АШУУИС Бие Бялдар Судлалын Тэнхимийн Эрхлэгч²

Хураангуй

Алхаа гэдэг нь тодорхой хэмнэлээр хөл, гар солбицож хөдөлснөөр хүний бие дэлхийн татах хүчний төвөөс урагш шилжиж буй, хөдөлгөөнийг хэлдэг.² Хөл улаар бүрэн газар тавих үеэс эхлэн түнх тэнийлгэх, өвдөг нугалах үүрэгтэйгээр гуяны арын булчин алхаанд оролцох ба алхааны явцад хөлийн өсгий газарт хүрэх (initial contact) үед аарцаг ясыг хойш татан бүсэлхий нурууны хотойлтын өнцгийг багасгах үүргийг гүйцэтгэдэг.³ Мөн алхааны үед дэлхийн татах хүчний эсрэг биеийг тогтвортой байлгах бас аарцагны эргэлтэнд оролцдог учир төрх байдалд нөлөөлдөг. 2019 оны 1-2 сард хийсэн Орхон аймгийн Бүсийн Эмчилгээ Оношилгооны Төвд хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдээс булчингийн чангаралтай 15, чангаралгүй 15 хүнийг сонгож судалгаанд хамруулсан. Судалгааг дараах арга аргачлал, тестээр явуулсан: Poplital angle test, алхах үед нь тодорхой ланд маркийн цэгүүдэд маркер байрлуулж өндөр хурдны камераар бичлэг хийсэн. Хийгдсэн бичлэгийн хөдөлгөөний анализ хийх тусгай программ (silicoach) руу оруулж алхах үеийн үений далайцыг хэмжсэн. Статистик боловсруулалтыг SPS- 21 программаар хийсэн. Гуяны арын булчингийн чангаралаас болж алхааны үе шатууд болон төрх байдал алдагдаж байна.

Түлхүүр үг:

Аарцаг, үений далайц, үнэлгээ, алхааны анализ

Үндэслэл

Гуяны арын (булчин m.hamstring) нь алхаанд оролцох ба алхааны явцад хөлийн өсгий газарт хүрэх (initial contact) үед аарцаг ясыг хойш татан бүсэлхий нурууны хотойлтын өнцгийг багасгах үүргийг гүйцэтгэдэг. Хөл улаар бүрэн газар тавих үеэс эхлэн түнх тэнийлгэх, өвдөг нугалах үүрэгтэй булчин юм. Тодорхой хэмнэлээр хөл, гар солбицож хөдөлснөөр

хүний бие дэлхийн татах хүчний төвөөс урагш шилжиж буй, хөдөлгөөнийг алхаа гэнэ. Гуяны арын булчин m.hamstring нь ерөнхийд нь гурав хувааж авч үздэг. Хагас шөрмөслөг булчин m.Semitendinosus-Суудал ясны төвгөрөөс эхлэн шаант ясны урд дотно гадаргууд төгсдөг, Хагас хальслаг булчин m.Semimembranosus-Суудал ясны төвгөрөөс эхлэн шаант ясны дотно ёрвонд төгсдөг, Хоёр толгойт булчин m.biceps femoris-Урт толгой: суудал ясны төвгөрөөс эхлэн тахилзуур ясны толгойд төгсөнө, харин богино толгой нь дунд чөмөгний дотор шугамны гадна ирмэгээс эхлэн, тахилзуур ясны толгой хэсэгт төгсдөг, булчин агшихдаа түнхээр тэнийлгэн өвдгөөр нугална. Өвдгөөр нугалсан байдалд шилбийг гадагш дотогш эргүүлэх үүрэгтэй. Мөн гуяны арын бүлэг булчин чангарснаар аарцаг арагш эргэлт (Pelvic posterior tilt) хийж буруу төрх байдал өөрчлөгдөж байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго

1. Гуяны арын булчингийн чангарал нь алхаанд нөлөөлөх нөлөөллийг судлах.
2. Гуяны арын булчингийн чангаралаас болж төрх байдлын өөрчлөлт гарч буйг судлах.

Зорилт

- Алхах үеийн хөл газар байх (stance phase) үений өнцөг тодорхойлох.
- Хөл агаарт байх (Swing phase) үений өнцөг тодорхойлох.
- Гуяны арын булчингийн чангаралтай хүний төрх байдлыг тодорхойлох.

Материал, арга зүй

Орхон аймгийн Бүсийн Эмчилгээ Оношилгооны Төвд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдээс чангаралтай 15 чангаралгүй 15 хүнийг сонгон авч судалгааг явуулсан. Арга аргачлал:

1. (Poplital angle) тестээр үнэлж гуяны арын булчин (m.Hamstring)
2. Судалгаанд оролцогчдыг алхах үед нь тодорхой ланд маркийн цэгүүдэд маркер

байрлуулж өндөр хурдны камераар бичлэг хийсэн.

- Хийгдсэн бичлэгийн хөдөлгөөний анализ хийх тусгай программ (silicoach) руу оруулж алхах үеийн үений далайцыг хэмжсэн.
- Хажуугийн хавтгайгаас харж ажиллаж төрх байдлыг тодорхойлсон.
- Төрх байдлыг үнэлж, далайц хэмжих
- Стастик боловсруулалтыг SPSS 21paired тестээр харьцуулан судалсан

Үр дүн

Хүснэгт – 1: Өсгий газарт хүрэх үе шат

Үзүүлэлтүүд	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Түнх нугалах	23.8±5.8	22.2±2.6
Өвдөг тэнийлгэх	20.8±5.1	2.8±3.5
Шагай ээтийлгэх	24.0±7.0	29.40±7.7*

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.

Хүснэгт – 2: ул бүтэн тавигдаж биеийн жин авах үе

Үзүүлэлтүүд	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Түнх нугалах	9.8±3.3	4.6±2.0
Өвдөг тэнийлгэх	14.2±5.5	3.4±1.8
Шагай ээтийлгэх	21.2±2.5	25.4±3.8

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой.


Хүснэгт – 3: төрх байдлын үнэлгээний харьцуулалт

Үзүүлэлтүүд	Туршилтын бүлэг	Хяналтын бүлэг
Их бие нугалах	45±4.3*	60±0.0
Түнх нугалах	101±9.5*	120±0.0
Өвдөг тэнийлгэх	9.2±5.5*	0.0±0.0

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.09 статистик ач холбогдолтой.


Хэлцэмж – 1:

Алхааны initial contact үеийн өвдөг тэнийлгэх үеийн далайц багассан байна. Хүснэгт - 1




Хэлцэмж – 2

Алхааны mid stance үенд өвдөг 0 градус тэнийсэн байдаг бол чангаралтай хүнд бүрэн тэнийхгүй байна хүснэгт - 2



Хэлцэмж – 3

Гуяны арын булчингийн чангаралтай оролцогчдийн төрх байдал алдагдсан байна. Хүснэгт – 3



Зарим гадаадын судлаачид гуяны арын булчингийн чангаралтай болон чангаралгүй оролцогчдын алхааны кинематикийн зөрүүтэйг тодорхойлсон байна [2, 5, 7]. Нөгөө талаас үзэхэд бидний гаргасан үр дүн зарим нэгэн гадаадын судлаачдын үр дүнтэй нийцэж байна.

Судалгааны дутагдалтай болон давуу тал: Судалгаанд оролцогчдын тоо цөөхөн болон хөдөлгөөн заслын мэргэжлийн лабораторт судалгаа хийгдээгүй бидний судалгааны дутагдалтай тал болно. Судалгааны ажлын давуу тал нь олон улсад хэрэглэгдэж буй орчин үеийн хөдөлгөөн заслын судалгааны арга, аргачлалыг монголд хэрэгжүүлсэнд оршино.

Дүгнэлт:

Гуяны арын булчингийн (hamstring) чангарлын үеийн алхааны (initial contact, mid stance) гэсэн 2 нь үе шатуудад алдагдалтай

байсан. Мөн төрх байдлын үнэлгээнд оролцсон нийт хүний 30 хүний гуяны арын булчингийн чангаралтай 15 хүн нь бүсэлхийн лордоз багасаж төрх байдал алдагдсан (sway back) төрх байдалтай, 15 хүн нь хэвийн төрх байдалтай байна. Гуяны арын булчин (hamstring) чангаралгүй хүмүүсийг бодоход гуяны арын булчин (hamstring) чангаралтай хүмүүс нь алхаа болон төрх байдлын өөрчлөлттэй их байна. Иймд гуяны арын булчин чангарснаас болж алхаа болон төрх байдал алдагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Angelo Matsas. Knee joint kinematics from familiarised treadmill walking can be generalized to overground walking in young unimpaired subjects Gait and Posture [2000] 46-53
2. Murray MP et al. Treadmill vs floor walking; kinematics electromyogram and heart rate. J Appl Physiol. 1985; 87-91
3. Parrick O.Riley et al. A kinematic and kinetic comparison of overground and treadmill walking in healthy subjects Gait and Posture 26 [2007] 17-24
4. Tateo Warabi et al. Treadmill walking and overground walking of human subjects compared by recording sole floor reaction force Neuroscience Research 53 [2005] 343-348
5. Kate L. Willoughby et al. Efficacy of partial body weight-supported treadmill training compared with overground walking practice for children with cerebral palsy ; A Randomized controlled trial Arch Phys Med Reh Vol 91 March 2010
6. J.A. Zeni Jr. et al. Two simple methods for determining gait events during treadmill and over-ground walking using kinematic data Gait and Posture 27 [2008] 710-714
7. Д.Батлхам, Б.Мөнх-Эрдэнэ, Г.Туул. МонголМед гүйлтийн зам болон газар дээр алхах үеийн алхааны кинематикийн ялгаа. Монголын анагаах ухаан,2011,3(159).
8. Helen J. Hislop. Muscle Testing Techniques of Manual Examination 2010 x- 156 – 161

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ХЭЛ ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНД ГАРСАН ҮР ДҮНГ СУДЛАХ

Б.Золбоо¹, Т.Цэцэгмаа¹, Б.Эрдэнэцэцэг¹, Г.Буянжаргал¹
¹СЦЯ-ийн 10 дугаар цогцолбор

ТҮЛХҮҮР ҮГ:

Хэл засал, Хэл ярианы хоцрогдол, Хэл ярианы хөгжил, Тархины саа

Үндэслэл

Хүүхдийн сэргээн засах тусламж үйлчилгээ гэдэг нь хүүхдийн төрөлхийн болон олдмол бие махбодын эмгэгийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх менежментийг олон мэргэжилтний багийн зарчмаар үзүүлэх сэргээн засах анагаах ухааны дэд салбар юм.

Сэргээн засах багийн ажиллагаа гэдэг нь: Эмч, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, багш, эцэг эх, нийгмийн ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй байдаг. Иймд зөвхөн нэг мэргэжилтэн ганцаараа тухайн хүүхэд болон гэр бүлд шаардлагатай бүх хэрэгцээг хангаж чаддаггүй тул багийн бүх гишүүдийн ур чадвар шаардлагатай болдог.

Хүүхдийн тархи хэрхэн хөгждөг вэ?

Тархи өвөрмөц үйл ажиллагаа гүйцэтгэдэг маш олон хэсгээс бүрдэнэ. Түүний нэг нь хэл яриа юм.

Цэцэрлэг, сургууль гээд нийгэмтэй харьцаж эхэлсэн үеэс ИЛҮҮ хүүхэд гэдсэндээ бүрэлдэж эхэлснээс хойших 1000 хоног хүүхдийн тархины хөгжил, хүмүүжилд хамгийн чухал.

Энэ 1000 хоног Эхийн хэвлийд бүрэлдэж эхэлснээс төрөх хүртэлх 270хоног Эхний хоёр жилийн 830 хоногоос бүрддэг байна.

Хүүхдийн тархи 2-3 насны хооронд хамгийн идэвхтэй холболт үүсэж хөгждөг.

Хүүхэд 3 настай байхад тархинд 1000 их наяд холболт үүсгэх боломжтой. /насанд хүрэгчдийнхээс хоёр дахин их/

Зорилго

СЦЯ-ийн 10 дугаар цогцолборт хамрагддаг тархины саатай хүүхдүүдийн хэл засал эмчилгээнд гарсан үр дүнг судлана.

Зорилт

Тархины саатай хүүхдүүдийн хэл ярианы хоцрогдолыг хооронд нь харьцуулан судлах.

Тархины саатай хүүхдүүдийн хэл ярианы түвшинг DENVER II үнэлгээ хийж эмчилгээний өмнө болон дараа харьцуулах.

Тархины саатай хүүхдүүдийн хэл ярианы хоцрогдолын үед:

- Өгүүлэхүйн эрхтэний дасгал
- Харж ойлгох, сонсож ойлгох чадварыг нэмэгдүүлэх дасгал
- Дуудлагын дасгал
- Үгийн утга болон үгийн баялаг нэмэгдүүлэх дасгалын арга хэрэглэж үр дүнг тооцох.

Арга аргачлал

СЦЯ-ийн 10 дугаар цогцолборын хэл засалын кабинетаар үйлчлүүлсэн 120 хүүхдээс, 2-5 насны 6 хүүхдийг 2018.09.15-2019.05.15 хооронд түүврийн аргаар хамруулсан.

Үүнд:


1. ТС-Доод мөч давамгайлсан хэлбэр 2 хүүхэд
2. ТС-4-н мөчний чангаралтай хэлбэр 2 хүүхэд
3. ТС-Эмх замбараагүй хөдөлгөөнтэй 2 хүүхдийг сонгон авч судалгаанд хамруулсан.

Хэл засалын эмчилгээг 30-45 минутаар 7 хоногт 1 удаа хамруулсан.

Хэл засалын эмчилгээнд:

1. Өгүүлэхүйн эрхтэний дасгал
2. Харж ойлгох, сонсож ойлгох чадварыг нэмэгдүүлэх дасгал
3. Дуудлагын дасгал
4. Үгийн утга болон үгийн баялаг нэмэгдүүлэх дасгал гэсэн 4 зарчимаар хийж, үйлчлүүлэгчдийг эмчилгээний өмнө болон дараа үнэлэхдээ DENVER II шалгуурын 3 дахь бүлэг болох “Хэл яриан”-ны үнэлгээгээр үнэлж гаргасан.

2018.09.15-2019.05.15 хооронд хэл засал эмчилгээнд гарсан үр дүн




Код	2018.09.15	2019.05.15
1	2.5-1.6 Цөөн үг хэлнэ. Үг холбож хэлнэ. Зарим үгээ ойлгомжгүй хэлнэ. Энгийн асуултууд болон энгийн командуудыг ойлгоно.	3.1-3.1 Үгийн нөөц нэмэгдсэн. Үгээ тод хэлдэг болсон. Хэл ярианы хөгжил насандаа хэвийн болж богино энгийн өгүүлбэр хэрэглэж сурсан.
2	2.1-1.2 Анхаарал төвлөрөлт дунд. Сонсож ойлгох чадвар дунд. Ганц нэг үг хэлнэ. Нэрээр нь дуудахад хариу үзүүлнэ. Энгийн заавар команд мэднэ.	2.9-1.9 Хэлэх үгийн тоо нэмэгдсэн. Сонсож ойлгох чадвар нэмэгдэж хүүхдийн ойлголт нэмэгдсэн. Хэлж чадахгүй үгээ дохиогоор илэрхийлнэ.
3	3.7-0.7 Ойлгоц сайн. Үг хэлэхгүй. Ойр зуур өдөр тутамд хэрэглэдэг зүйлсийн нэрсийг мэднэ.	4.3-1.1 Хүүхдийн сонсож ойлгох болон харж ойлгох чадвар нэмэгдсэн. Өдөр тутамд хэрэглэдэг үгийг хэлэх гэж оролддог болсон.
4	2.1-0.5 Гангана, гунганана. Үг хэлэхгүй авиа гарган. Нэрийг нь дуудахад хариу үзүүлнэ.	3.6-0.6 Шулагнана. Ойр зуур болон өдөр тутамд хэрэглэдэг зүйлсийн нэрсийг мэднэ.
5	4-3.6 Ойлгоц сайн. Үг өгүүлбэрээр ярина. Ярихдаа гацаж ээрч зарим хэлж байгаа үг нь ойлгомжгүй. Танин мэдэхүй сул.	4.8-4.6 Тайван ярих үедээ сайн ярина. Гацаж ээрч ярих нь багассан. Танин мэдэхүй нэмэгдсэн.
6	4.8-4 Ойлгоц сайн. Үг холбож хэлнэ. Зарим үг ойлгомжгүй хэлнэ. Үгийн утга сайн тайлбарлаж чадахгүй.	5.4-4.8 Анхаарал нэмэгдэж өгүүлбэрээр өөрийгөө илэрхийлж сурсан. Гэр бүлийн бус хүмүүс ярианы 90-100% ойлгогдохоор ярьж сурсан

Үр дүн

Эцэг эхийн хүсэл / Зорилго /

	1	2	3	4	5	6
2018-2019 оны хичээлийн жилийн эцэг эхийн хүсэл	-Өлмийдэхгүй сайн гишгэж, гүйдэг болгох -Л,Р,С гийгүүлэгч тод хэлж улам сайн хэлж яриж сургах.	-Өлмий жийлт багасгах, хөл дээрээ зөв зогсож сургах.	-Булчин суллах -Гартаа юм атгаж сургах.	-Толгойгоо дааж сургах.	-Савчсан хөдөлгөөнийг багасгах -Явуулж сургах -Булчингийн хүч нэмэгдүүлэх.	-Сургуульд оруулах -Савчсан хөдөлгөөнийг багасгах -Сайн бие дааж явуулах.

Эцэг эхийн хүсэл



Дүгнэлт

Бидний судалгаа статистик ач холбогдол нь үр дүн багатай гарсан хэдий ч DENVER II шалгуураар хүүхдүүдийг эмчилгээний өмнө болон дараа үнэлэхэд хэл ярианы чадвар, ярих эв дүйд сурах арга барил болон нийгэмших чадвар нэмэгдсэн үзүүлэлт гарсан нь цаашид хэл засал эмчилгээний давтамжийг нэмэх нь үр дүнтэй байна.

Хүүхдийн хэл ярианы хөгжлийн тухай ойлголтыг /эцэг эх гэр бүлд/ нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь шаардлагатай байна.

Хэлцэмж

Манай судалгаанд тархины саатай хүүхдийн хэл ярианы хоцрогдлыг тархины саагийн 3 хэлбэр болох (ТС-Доод мөч давамгайлсан хэлбэр 2 хүүхэд, ТС-4-н мөчний чангаралтай хэлбэр, 2 хүүхэд ТС-Эмх замбараагүй хөдөлгөөнтэй 2 хүүхдийг) сонгон авч хооронд нь харьцуулан судласан. Хүүхдүүдийг эмчилгээний өмнө болон дараа үнэлэхэд хэл ярианы чадвар, ярих эв дүйд сурах арга барил болон нийгэмших чадвар нэмэгдсэн үзүүлэлт гарсан нь цаашид хэл ярианы хоцрогдлыг болон тархины саагийн хэлбэр тус бүр дээр хэл ярианы хөгжлийг судлах нь нэн шаардлагатай байна. Манай хийгдсэн энэ төрлийн судалгаа нь цөөн байна.

НОМ ЗҮЙ:

1. Мэдрэл судлал Г.Цагаанхүү, Ц.Дэлгэрмаа 2014 он
2. Mongolian Journal of Rehabilitation Medicine 2019 он

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДЭД УРТ ХУГАЦААНД ХИЙГДСЭН ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ СУДЛАХ

А. Батчимэ¹, Т. Уянга^{2,1}, Т. Батгэрэл¹, Г.Буянжаргал¹
¹СЦЯ-ийн 10 дугаар цогцолбор

Түлхүүр үг:

Хөдөлгөөн засал, Хөдөлгөөний хөгжил, Тархины саа

Үндэслэл

Тархины саа нь олон шалтгаант хүчин зүйлсийн нөлөөгөөр ураг болон нярайн тархи гэмтэж, булчингийн хүчний гаж хуваарилалтаас үүссэн хөдөлгөөний хөгжлийн хоцрогдол, тэнцвэрийн өөрчлөлтийн бүрдмэл шинжээр илэрдэг, даамжрах явцгүй эмгэг юм. Тархины саатай хүүхдэд хөдөлгөөн засал нь эмчилгээний салшгүй нэг хэсэг болдог. Уг хүүхдэд сэргээн засах эмчилгээг:

- Эрт эхлэх
- Эмчилгээнд тасралтгүй хамруулах нь тухайн хүүхдийн амьдралын чанарыг дээшлүүлж, бие даах чадварт нь чухал ач холбогдолтой юм. **Зорилго** Тархины саатай хүүхдэд тасралтгүй хийгдэх хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнг судлах **Арга аргачлал** СЦЯ 10-р цогцолборт 2017- 2019 онуудад хамрагдаж байгаа 120 хүүхдээс тасралтгүй хамрагдсан 5 хүүхдийг сонгосон. Үүнд:
 - Тархины сааны доод мөч давамгайлсан хэлбэр- 3
 - Тархины саа жижиг тархитай- 1
 - Тархины саагийн булчингийн сул хэлбэр- 1хүүхдийг сонгож авч олон улсын хүүхдийн хөдөлгөөний хөгжлийг тодорхойлох шалгуураар үнэлсэн. **(GMFM-88)** Оролцогчдын картнаас хичээлийн шинэ жилийн үнэлгээ, жилийн эцсийн үнэлгээг түүвэрлэсэн. Эдгээр хүүхдүүд нь 2017 оны 9 дүгээр сараас 2019 оны 5 дугаар сарын хугацаанд 7 хоногт 2-3 удаа 45 минутаар хөдөлгөөн засал эмчилгээг хийлгэж байсан.

Олон улсын хүүхдийн хөдөлгөөний хөгжлийг тодорхойлох шалгуур (GMFM-88)

- Бодит үйлдлийг харж үнэлгээ хийнэ.
- Нийтдээ 5 бүлэг 88 үзүүлэлтээр үнэлдэг .
 1. Хэвтэх ба эргэх- 51оноо
 2. Суух- 60 оноо
 3. Мөлхөх ба өвдөглөх-42 оноо
 4. Зогсох-39 оноо

5. Явах, гүйх ба үсрэх-72 оноо Нийт: 264 оноо - 0-3 оноо ашиглан үнэлгээ хийнэ.

0 оноо: санаачлахгүй (үйлдлийг огт гүйцэтгэхгүй)


1 оноо: санаачлана (үйлдлийг 10% хүртэл буюу хийхийг оролдоно)

2 оноо: хэсэгчлэн гүйцэтгэнэ (үйлдлийг хагас буюу 90% хүртэл)

3 оноо : бүрэн гүйцэтгэнэ (100% үйлдлийг гүйцэтгэнэ)

Олон улсын хүүхдийн хөдөлгөөний хөгжлийг тодорхойлох шалгуур (GMFM-88)

Хөдөлгөөн засал эмчилгээнд гарсан үр дүн



Дүгнэлт

Хөдөлгөөн засал эмчилгээг хүүхэд бүрт тасралтгүй явуулах нь бие даан амьдрах чадварыг 87,8%- иар дээшлүүлж байгаа нь хүүхдийг ердийн сургууль цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж байна гэж харагдаж байна.

Хэлцэмж

Манай судалгаанд тархины саатай хүүхдэд урт хугацаанд хийгдсэн хөдөлгөөн засал эмчилгээг тархины саагийн 3 хэлбэр болох (Тархины сааны доод мөч давамгайлсан хэлбэр 3 хүүхэд, Тархины саа жижиг тархитай 1 хүүхэд, Тархины саагийн булчингийн сул хэлбэр хүүхэд 1 нийт 5 хүүхдийг сонгон авч хооронд нь харьцуулан судалсан. Хүүхдүүдийг эмчилгээний

өмнө болон дараа үнэлэхэд хэвтэх ба эргэх, суух, мөлхөх ба өвдөглөх, зогсох, явах ба гүйх үсрэх чадварууд нэмэгдсэн үзүүлэлт гарсан нь цаашид хөгжил хөдөлгөөний чадваруудыг судлах нь нэн шаардлагатай байна.

Ном зүй:

1. Мэдрэл судлал Г.Цагаанхүү, Ц.Дэлгэрмаа 2014 он
2. Mongolian Journal of Physical and Rehabilitation Medicine 2014 он
3. Нэг хүртэлх насны хүүхдийн хүчилтөрөгч-цус дутал тархины эмэгшил П.Отгонбаяр, Б. Баясгалантай 2004 он

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ЧАДВАРЫГ СУДАЛСАН НЬ

Т.Лхагвасүрэн¹, Д.Гэрэлмаа¹, Д.Жандаулет¹, Б.Анхбаяр¹, Г.Буянжаргал¹
 СЦЯ-ийн 10-р цогцолбор

Үндэслэл:

Тархины саа нь олон шалтгаант хүчин зүйлсийн нөлөөгөөр ураг болон нярайн тархи гэмтэж, булчингийн хүчдэлийн гаж хуваарилалтаас үүссэн хөдөлгөөний хөгжлийн хоцрогдол, тэнцвэрийн өөрчлөлтийн бүрдмэл шинжээр илэрдэг, даамжрах явцгүй эмгэг юм.

Сэргээн засах эмчилгээг :

- Эрт эхлэх
 - Эмчилгээнд тасралтгүй хамруулах нь тухайн хүүхдийн амьдралын чанарыг дээшлүүлж бие даах чадварт нь чухал ач холбогдолтой юм.
- Ахуй засал эмчилгээ нь салшгүй нэг хэсэг болдог.

Судалгааны ажлын зорилго :

Тархины саатай хүүхдийн өөрөө өөртөө үйлчлэх чадварыг судлах

Зорилт:

Өөрөө өөртөө үйлчлэх үйлдлийн шалгуурыг эмчилгээ эхлэхээс өмнө болон эмчилгээний дараа харьцуулан үр дүнг тооцох

Судалгааны арга зүй:

- Түүвэрийн арга
 - Харьцуулан жиших арга
- Өөрөө өөртөө үйлчлэх үйлдлийг ажиглалтын аргаар хэмжиж дараах оноогоор үнэлнэ.

Үүнд:

- 0 - огт чадахгүй
 - 1 - хийхийг оролдоно
 - 2 - тусламжтай хийнэ
 - 3 - бие дааж хийнэ
- Ахуй засал эмчилгээнд 7 хоногт 2-3 удаа 45 минутаар дасгалд хамрууллаа.
- Хүүхдүүдэд хийгдсэн дасгалууд
 Гарын булчинг суллах дасгалууд
 Гарны үений далайцыг нэмэгдүүлэх дасгалууд
 Гараар тулуулах дасгалууд
 Хоёр гарын нийлмэл хөдөлгөөнийг салгах дасгал
 Гарын нарийн хөдөлгөөнийг сайжруулах дасгалыг танин мэдэхүй болон сэтгэхүй хөгжүүлэх дасгалтай хослуулан хийлгэх

Хувцас тайлах

Хувцас өмсөх

Ариун цэвэр сахиx

Хооллох

Бие засах үйлдлүүдийн үр дүнг тооцох

Хамрах хүрээ:

СЦЯ-ийн 10-р цогцолборт хамрагдаж байгаа 120 хүүхдээс 5 хүүхдийг түүврийн аргаар сонгон авч 3 сар тутамд өөрөө өөртөө үйлчлэх үйлдлийн шалгуураар үнэлж \Зудаа\ судалсан.

Өөртөө үйлчлэх үйлдлийн шалгуурыг:

2018-09-15


2019-01-15

2019-09-15- нд үнэллээ.

Хүүхдүүдийн өөрөө өөртөө үйлчлэх үйлдлийн ахицын судалгааны нэгтгэл

№	Үзүүлэлт	Судалгааны өмнө			Явц			Судалгааны дараа			Ахицын түвшин
		Авах оноо	Авсан оноо	Эзлэх хувь	Авах оноо	Авсан оноо	Эзлэх хувь	Авах оноо	Авсан оноо	Эзлэх хувь	
1.	Хувцас тайлах	105	15	14,2	105	23	21,9	105	59	56,1	41,9
2.	Хувцас өмсөх	105	9	8.5	105	19	18	105	34	32,3	23,8
3.	Ариун цэвэр сахиx	60	17	28,3	60	23,0	38,3	60	25	41,6	13,3
4.	Хооллох	105	49	46.6	105	51,0	48,5	105	82	78	31.4
5.	Бие засах	60	12	20	60	17,0	28,3	60	23	38,3	18,3
БҮГД		435	102	23,4	435	133	30,5	435	223	51,2	27,8

Тархины саатай хүүхдийн өөрөө өөртөө үйлчлэх үйлдлийн ахицын судалгаа



Хэлцэмж:

Бидний хийсэн судалгаагаар ахуй засал эмчилгээ, дасгал хөдөлгөөнд тасралтгүй хамрагдсанаар хүүхдүүдийн өөрөө өөртөө үйлчлэх чадвар, гарын нарийн хөдөлгөөн, танин мэдэхүй, сэтгэхүйн хөгжилд ч ахиц гарч байна

Тархины саатай хүүхдүүдийн өөрөө өөртөө үйлчлэх чадварыг судалсан судалгаа манай улсад одоогоор байхгүй байгаа нь энэ чиглэлийн судалгааг цааш судлах шаардлагатайг харуулж байна

Дүгнэлт:

Судалгааны үр дүнд:

Хувцас тайлах - 41,9 %

Хувцас өмсөх - 23,8 %

Ариун цэвэр сахих - 13,3 %

Хооллох - 31,4 %

Бие засах - 18,3 %

Ахицын түвшин дунджаар 27,8 % гарлаа

Иймд тархины саатай хүүхдийг эрт илрүүлж, тасралтгүй ахуй засал эмчилгээнд хамруулсанаар хүүхдийн бие даах чадварт болон цаашид нийгэм хамт олны дунд орж хөгжиж, боловсроход чухал нөлөөтэй байна

Ном зүй:

1. FREDERIC J. KOTTKE, M.D. G. KEITH STILLWELL, M.D. JUSTUS F. LEHMANN M.D. KRUSEN'S HANDBOOK OF PHYSICAL MEDICINE AND REHABILITATION – Third Edition
2. HELEN L. HOPKINS, HELEN D. SMITH, WILLARD AND SPACKMAN'S OCCUPATIONAL THERAPY- Sixth Edition

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

Г.Ганбаатар¹

¹Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 3-р хэлтэс

Түлхүүр үг

Бэлгийн боловсрол, дарамт, хүний эрх, хариуцлага

Хураангуй

Хөгжлийн бэрхшээл гэдэг нь хувь хүндээ биш нийгэмд байгаа гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт Монгол Улсад хараахан нийтлэг болоогүй байгаа билээ. Тэр утгаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сул дорой хүмүүс гэсэн ойлголт давамгайлж, тэдний нийгмийн оролцоо бодит байдал дээрээ хангагдаж чадахгүй байгаа бөгөөд охид, эмэгтэйчүүд бэлгийн боловсролын мэдэгдэхүүн эрүүл мэндийн асуудал хамгийн тулгамдаж байна. Хүний аливаа эрх нь хоорондоо харилцан хамааралтай тул бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь бусад эрхтэй, ялангуяа нийгмийн амьдралд оролцох, хөдөлмөрлөх эрхтэй харилцан уялдаатай. Тиймээс энэ өгүүллээр хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн бэлгийн боловсролын олон улсад хамгаалах аргачлалтай жишэн хөгжүүлэх асуудлыг хөндөн тавьж шийдвэрлэх зарим арга өгүүлэх болно.

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил бие даан амьдарч, нийгмийн амьдралд оролцох хүсэлтэй байдаг ч сурах, хөдөлмөрлөх, нийгмийн үйл хэрэгт оролцох, гэр бүлтэй болох, эмнэлэг, сургууль, олон нийтийн байгууллагаас үйлчилгээ авах, тээврийн хэрэгслээр зорчих, хэрэгцээтэй мэдээллээр бүрэн хангагдах боломж, нөхцөл хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь нийгмийн олон хүчин зүйлээс хамааралтай ч нийгэм дэх буруу хандлага ихээхэн нөлөөлдөг.

Тухайлбал, Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамжийн үйлчилгээг хүргэхдээ гэр бүлийнхэнд нь даатгах, тэднийг асран хамгаалагчид мөнгөн тэтгэмж олгох зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрт хамаарах асуудлаар шийдвэр гаргах, бие даан амьдрах, гэр бүлтэй

болох, бэлгийн хамтрагчтай байх, хүүхэд төрүүлэх, эцэг эх байх эрхээ эдлэхэд гэр бүлийн гишүүд хөндлөнгөөс нөлөөлж байна.

Судалгааны арга, аргачлал

Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй 300 эмэгтэй хамруулснаас 42 хувь нь тулгуур эрхтний, 31 хувь нь хараа, сонсголын бэрхшээлтэй, 17 хувь нь оюуны, 10 хувь нь бусад хэлбэрийн бэрхшээлтэй байв. Судалгаанд оролцсон хоёр хүн тутмын нэг нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой бөгөөд нийт оролцогчдын 90 хувийнх нь гэр бүлийн сарын орлого хэрэгцээнд хүрэлцдэггүй учир хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тэтгэвэр, тэтгэмжийнхээ 84.5 хувийг гэр бүлийн хэрэгцээнд зарцуулдаг байна.

Дээрх эмэгтэйчүүдийн 40.2 хувь нь гэрлэсэн, 24.7 хувь нь ганц бие, 8.1 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, 5.5 хувь нь хамтран амьдрагчтай гэж хариулсан бол 88.6 хувь нь ам бүлийн тоо 1-2 гэжээ. Мөн нийт оролцогчдын 32.8 хувь нь боловсролын түвшин доогуур буюу уншиж, бичиж чаддаггүй бол ажил эрхлэлтийн түвшин дөнгөж 33 хувь байна. Тэдний боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртөмтгий, бусдаас хэт хараат болгож байгааг судалгааны дүн харуулж байна.

Асуудлыг шийдвэрлэх

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ихэвчлэн зохион байгуулалттай арга хэмжээний үеэр л нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэгт ордог. Бие дааж урьдчилан сэргийлэх үзлэгт орох боломжгүй. Урьдчилан сэргийлэх зорилгоор эмчид үзүүлэх гэвэл “Ачаалал ихтэй байна, юун чамтай харьцахтай манатай” гэж загнадаг. Утсаар мэдээлэл аваарай гэдэг ч “Үзүүлээгүй байж юун зөвлөгөө авах гээд байгаа юм бэ” гэдэг. Иймэрхүү байдал байнга гардаг гэж судалгаанд дурьдсан байсан. Мөн ганцаарчилсан ярилцлагын үеэр нэг ээж ярихдаа “Группэд

байдаг гэхээр эмч нар жирэмслэх шаардлагагүй гэж үздэг. Хүүхэд олоод эмчид хэлтэл “Чи одоо хүүхэд гаргаж болохгүй ээ” гэсэн. Тэгэхээр нь би нөхөртэйгээ ярилцъя гэж хэлээд зугтааж гараад хувийн эмнэлэгт хяналтанд байж байгаад, Эх нялхаст хүүгээ төрүүлсэн. Хоёр дахь хүүхдээ төрүүлсний дараа эмч нар “Чи мундаг байна, хоёр хүүхэд төрүүлчихлээ одоо болно” гээд үрийн сувгийг маань боосон гэх жишээтэй. Бэлгийн хүчирхийлэл, хувийн халдашгүй байдлын талаар ганцаарчилсан ярилцлага хийхэд ярилцсан эмэгтэй болгон хүчирхийлэлд өртсөн байсан. Бэлгийн хүчирхийлэл маш их байна. Мөн тэтгэврийг нь авах гэх мэт эдийн засгийн хүчирхийлэл ч олон.

Хэлцэмж

Тухайн судалгааг ярилцлагын аргаар хийсний сацуу хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид хэн нэгэнд хувийн асуудлаа тэр бүр ярихыг хүсдэггүй мөн сэтгэл зүйн гүн дарамттай нээлттэй бус байлаа. Тиймээс бэлгийн боловсролыг тусгайлан олгох нь зүйтэй.

Дүгнэлт

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэх” зорилгыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн тодорхойлсон ч хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн нийгэм, эдийн засаг, хөгжлийн үйлчилгээг орхигдуулж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрх зөрчигдөхөд хүргэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, нэгдмэл ойлголттой болох, шийдвэрлэх гарцыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

Ашигласан материал:

1. <https://www.legalinfo.mn/>
2. <http://nhrcm.gov.mn/>
3. <https://www.1212.mn/>
4. “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн эмхэтгэл 2017 он

СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ХӨТӨЛБӨР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН ХООЛ ШИМ ТЭЖЭЭЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДИТ НЭГЭН ИЛРЭЛ БОЛОХ НЬ

М.Пүрэвжав¹, С.Нямцэцэг¹, Ж.Нямцэцэг², Д.Энхмягмар³,
Н.Ууганцэцэг⁴, Ч.Өлзийбүрэн³, Ж.Балжинням¹
¹ШУТИС, ²Үйлдвэрлэлийн Технологийн сургууль, ³СЭМҮТ
⁴НЭМҮТ, ⁴Мэдрэлийн эмч нарын нийгэмлэг

Хураангуй

2018 оны статистикийн мэдээллээс үзвэл манай улсад 105730 [5] хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байгаа нь нийт хүн амын 3,26% эзэлж байна. Энэ үзүүлэлт хятад улсад 6,34% [12], БНСУ-д 4,8% [14], АНУ-д 12,8% [13] байгаа нь манай улсын хувьд харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.

Манай улсад зөвхөн 1-5 ангийн суралцагч “үдийн цай” хөтөлбөрт хамрагдах журамтай өнөө цагт хөгжлийн бэрхшээлтэй суралцагч сургууль дээрээ хоолны үйлчилгээнд нас харгалзахгүй хамрагдахаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд 2013 онд заалт орсон нь сайшаалтай хэдий ч 2017 оны 9 сараас төсөв батлагдан хоолны үйлчилгээ эхэлсэн.

Хоолоор үйлчлэх зөвхөн төсөв батлагдсаар илэрхийлэгдэхгүй хүнсний хангамж, зориулалтын гал тогоо, мэргэжлийн хүний нөөцтэй бүрдсэний үндсэн дээр амжилттай хэрэгжих бөгөөд эс бөгөөс үр дүнгүй зардал урсахад хүрдэг.

Сургуулийн үдийн хоолны төсөв харьцангуй өндөр батлагдсан тухайн үед дээр дурьдсан 6 ерөнхий боловсролын сургуулиас 25 дугаар сургууль нь цор ганц гал тогоогүй, хүний нөөцгүй, хамрагдах сурагчдын амьдралын түвшин доогуур, өвчлөлийн түвшин хүнд зэрэг олон шалтгаанаар төсөл хэрэгжүүлэх зайлшгүй нөхцлийг бидэнд үүсгэсэн болно.

Төсөл хэрэгжүүлэх явцад төслийн аргазүйг ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр батлуулсан ба судалгаанд хооллолт, шим тэжээлийн бодит байдал, мэдрэл болон сэтгэцийн мэргэжлийн эмчийн үзлэг, сорил бусад хоолтой холбоотой үзүүлэлтийг тодорхой стандарт аргазүйг ашиглан хэрэгжүүлэв.

Судалгааны аргазүйг ЭМЯамны “Ёсзүйн хороо”-гоор хэлэлцүүлэн албан ёсны зөвшөөрөл авсан болно.

Судалгааны эхэн ба интервенцийн дараах гэсэн 2 үе шаттайгаар үнэлгээг хэрэгжүүлж үр дүнг тооцсон ба сургуулийн хоолоор дамжуулан хүний хэрэглээний анхан шатны хэрэгцээ болох физиологийн хэрэгцээг хангаснаар хүүхдийн эрүүл мэнд, хоногийн шимт бодисын хангамжийг дээшлүүлэх, сэтгэл ханамж, нийгмийн халамжийн асуудлын нэгэн хэсгийг шийдэх бүрэн боломжтой болох нь илэрхий бөгөөд төслийг БСШУСЯамны Инновацийн төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Түлхүүр үг

Тэнцвэртэй хооллолт, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, сурагч, харьцуулсан судалгаа

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд жирийн хүүхдийн нэгэн адил боловсролын үйлчилгээнд хамрагдах нь тэдний ирээдүйн амьдралын баталгааг бий болоход чухал нөлөөтэй асуудал юм. Хүүхдэд ээлтэй сургуулийн орчны гол бүрэлдэхүүний нэг нь хоолны үйлчилгээ мөн болохыг олон улсын жишээ харуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгэм дэх оролцоо, тэдний амьдралын баталгаа, эрүүл мэнд, боловсрол эзэмших зэрэг олон асуудал тулгамдаж байдаг. Монгол улсад 1964 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль байгуулах ажлын эхлэл тавигджээ. Одоогоор нийслэл хотод улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг 6 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Дэлхийн 169 оронд сургуулийн хоолоор үйлчилж, тэдний эрүүл мэнд, өсөлт хөгжилт, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэсээр ирсэн бөгөөд Монгол улс 2019 оны 5 сард энэ асуудлыг хуульчиллаа. Энэ нь сургуулийн үдийн хоолны анхны хууль Дэлхийд батлагдсанаас даруй 73 жилийн дараах үйл болно.

Харин хөгжлийн бэрхшээлтэй суралцагч сургууль дээрээ хоолны үйлчилгээнд нас харгалзахгүй хамрагдахаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд 2013 онд заалт орсон хэдий ч 2017 оны 9 сараас төсөв батлагдан хоолны үйлчилгээ эхэлсэн.

Хоолоор үйлчлэх зөвхөн төсөв батлагдсаар илэрхийлэгдэхгүй хүнсний хангамж, зориулалтын гал тогоо, мэргэжлийн хүний нөөцтэй бүрдсэний үндсэн дээр амжилттай хэрэгжих бөгөөд эс бөгөөс үр дүнгүй зардал урсахад хүрдэг.

Сургуулийн үдийн хоолны төсөв харьцангуй өндөр батлагдсан тухайн үед дээр дурьдсан 6 ерөнхий боловсролын сургуулиас 25 дугаар сургууль нь

- зориулалтын гал тогоогүй (6 сургууль дотроо гал тогоогүй ганц сургууль)
- давчуу жижиг өрөөнд түрээслэгч ажиллах ба эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн боломжгүй нөхцөлд хоол хийж үйлчилдэг, эрсдэл өндөр
- мэргэжлийн, ур чадварлаг хүний нөөц байхгүй
- сурагчдын амьдралын түвшин доогуур
- өвчлөлийн түвшин хүнд
- нийслэлийн захын дүүргээс сургуульд ирдэг хүүхдийн тоо олон
- сургууль дээрээ олон цаг өнгөрөөдөг хүүхдийн тоо бага биш
- багш, ажиллагсад, эцэг эхийн хоол, шим тэжээлийн талаархи ойлголт нэн сул зэрэг олон шалтгаан нь судалгааны үндэслэл болно.

Судалгаа хэрэгжүүлэх үнэлгээг дээрх 6 сургуулийн хүрээнд 2015, 2016 онуудад хэрэгжүүлсэн.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагсадын нас, биемахбодын өсөлт, хөгжил, эрүүл мэндийн байдлыг дэмжих сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний загвар бий болгох, судалгаанд суурилсан хоол, шим тэжээл, эрүүл мэндийн үзүүлэлт бүхий үр дүн бий болгоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт

1. Төсвийн оновчтой зарцуулалттай, шим тэжээллэг, тэнцвэртэй өглөөний цай, үдийн хоол бүхий загвар цэс боловсруулалт, түүний хөгжүүлэлт хийх

2. Сургуулийн хоолны шим тэжээлийн агууламж, төсвийг хуучин ба шинэ үйлчилгээний хүрээнд тооцоолж, харьцуулах
3. Сургуулийн хоолны үйлчилгээний ач холбогдлыг тодорхойлох бие бялдрын үзүүлэлт, мэргэжлийн эмчийн сорил, оношилгоо, багажийн үзлэг зэрэг нотолгоонд суурилсан үр дүн бий болгох зэрэг болно.

Судалгааны арга зүй

- *Хоол, шимт тэжээлийн бодит байдал, шимт бодисын агууламж тооцох аргазүй*

Хоол тэжээлийн Хоол шим тэжээлийн судалгаанд 24 цагийн эргэн санах, хүнсний хэрэглээний давтамж (FFQ) зэрэг стандарт асуумж ашиглах ба хоолоор авах шимт бодисын агууламжийг тооцооны аргаар тодорхойлно. Асуумжийн тусламжтай хооллох зуршил, шим тэжээлийн мэдлэгийн түвшинг тодорхойлно.

Сурагчдын хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгөхдөө дараах хэмжилтийг ашиглана. Үүнд:

Нэгдүгээрт, жин, өндрийг нь шууд хэмжих боломжтой хүүхдэд биеийн жин, өндрийг хэмжин, хоол тэжээлийн байдлын үнэлгээ өгнө.

Хоёрдугаарт, тархины саажилттай, өндрийг нь хэмжих боломжгүй тохиолдолд тухайн хүүхдийн шилбэ, бугалга ясны уртыг стандарт аргачлалын дагуу хэмжин олон улсад ашигладаг өндөрт нь дүйцүүлэн шилжүүлж, хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгдөг.

- *Сурагчдын оюуны хөгжилд үнэлгээ өгөх аргачлал*

Оюун ухааныг судлах Векслерийн тест (WISC сорил)

Векслерийн сорил нь баталгаат чанар шалгагдсан, онолын үндэслэлтэй, эмнэлгийн болон боловсролын салбарт хэрэглэгддэг сэтгэц хэмжилтийн аргачлал юм. Уг сорил нь оюун ухааны хөгжлийг судлах 12 дэд сорилоос бүрдэнэ. Сорил нь хэлэхүйн болон хэлэхүйн бус даалгавруудтай. Хэлэхүйн даалгавруудад *ерөнхий мэдлэг шалгах, ойлгох чадвар, тоо бодох, ижил талыг нэрлэх, үгсийн сангийн, тоог давтах, дутуу хэсгийг нөхөх, зургийг дэс дарааллаар нь байрлуулах, Косын шоо эвлүүлэх, дүрс эвлүүлэх, тэмдэгт бичих* зэрэг үйлдэл гүйцэтгүүлэх даалгаврууд ордог.

- *Тархины саажилтын түвшинг үнэлэх аргачлал*

Тархины саажилтыг алхуулагч, гар хэрэгсэл, хүний тусламж, автомат тэргэнцэр, өөрөө

хөдөлгөх механик тэргэнцэр, тээвэрлэлт, алхаа, дугуйт хөдөлгөөнт хэрэгсэлийг ашигладаг эсэхээр эмчийн сорил хийгдэхээс гадна тархины цахилгаан бичлэгийн багаж ашиглана.

- *Ясны нягтийг тодорхойлох*

Яс сийрэгжилтийн үзүүлэлтийг Герман улсад үйлдвэрлэгдсэн Sonost 3000 багаж ашиглан тодорхойлно. Энэхүү багаж нь ультра ягаан туяаны нэвтрэлтийн ялгаа дээр хөлийн өсгийн ясны нягтийг хэмждэг.

- *Статистик боловсруулалт*

SPSS 23, nutrisurvey 2007, windows excel 2016 программыг ашиглан боловсруулсан.

Судалгааны үр дүн

Судалгаанд 1–9 дүгээр ангийн нийт 132 сурагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн оношийг харьцуулсан дүнгээс харахад аутизм 22,7%, дауны синдром 18,3%, оюуны хоцрогдолтой 29,3%, ярианы бэрхшээлтэй 6,9%, хөдөлгөөний бэрхшээлтэй 22,8% байна.

- *Зориулалтын гал тогооны засвар*

Зориулалтын бус **38,8м²** талбайтай гал тогоо гэгдэж байсан өрөөг сургуулийн захиргааны зөвшөөрлөөр хажуугийн ангийг хамруулан засварлаж, хүнсний агуулах, мах, ногооны бэлтгэл, талх нарийн боовны ажлын байр, халуун цех, үйлдвэрлэлийн сав угаалга, үйлчилгээний сав угаалга, хоол олгох хэсэг, хүчилтөрөгчийн коктейлийн байр, хоолзүйчийн ажлын байр зэргийг бүрэн багтаасан **78,38м²** урсгал шугам зөв зохион байгуулагдсан, агааржуулалт, цэвэр бохир усны шугамтай, стандартын шаардлага хангах гал тогоо бий болгов. Нэмж авах шаардлагатай тоног төхөөрөмжийг дотоодын зах зээл болон БНСУ-аас авчирч тоногдосон. Ажиллагсадын хувцас солих өрөөг гал тогооноос тусдаа бий болгосон (зураг 1). Гал тогооны зохион байгуулалт нь аюулгүй хоолоор үйлчлэх үндэс болно.



Зураг 1. Хуучин ба шинэ гал тогооны харьцуулалт

- *Төсвийн зөв зохицуулалт бүхий хоолны цэс, хоолны шим тэжээлийн агууламж*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үдийн хоолны төсөв нь төрөөс санхүүжилттэй бөгөөд 2400 төгрөгөөр батлагдан мөрдөж байна.

Төсөл хэрэгжихийн өмнө 2400 төгрөгөнд 1 удаа үдийн хоол өгдөг байсан бол одоо дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. *Өглөөний цай*

- а. Төрөл бүрийн будааны сүүтэй агшаамал, өөрийн гал тогоонд хийсэн талх, гурилан бүтээгдэхүүн

2. *Үдийн хоол*

- а. Төрөл бүрийн шөл

- б. Үндсэн хоол

- с. Хярам/ шүүс

3. *Сүү*

- а. Маамуу брендийн сүү, энэ сүү нь савлагаа ба хэмжээний хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хэрэглэхэд тохиромжтой, үнээний шингэн сүүгээр хийсэн, дээд зэргийн ариутгалтай, асептик савлагаатай, Д аминдэмээр баяжуулсан нь сонгох үндэслэл болно.

4. *Хүчилтөрөгчийн коктейль*

- а. Хүчилтөрөгчийн коктейлээр байнгын үйлчлэх боломжтойгоор суурилуулсан, одоогийн байдлаар судалгааны үр дүнг тооцох үүднээс зорилтот бүлгийн хүүхдүүдэд өгч байгаа.









Сургуулийн хоолны нийт шимт бодисын агууламж ба үнийн харьцуулалт Хүснэгт 1

Үзүүлэлт	шимт бодис, гр			илчлэг, ккал	Хоолны үнэ, ₮	
	Уураг	өөх тос	нүүрс ус		төсөв	гүйцэтгэл
1 Өмнө (Түрээсийн гал тогоо ажиллаж байсан)	23.3	11.2	96.1	458.7	2400	1210

2	Одоо (төсөл хэрэгжиж байгаа)	36	24.6	114.9	742.9	2400	2400
3	Зөвлөмж хэмжээ	30	20	121	784		


Хүснэгтээс харвал үдийн хоолоор авах шимт бодисын агууламж зохих түвшинд хүрсний дээр хоолны төсөв зөвхөн түүхий эдийн үнэнд зарцуулагдах тухай холбогдох журмын заалт биелэгдэж байгаа нь харагдаж байна.

Үдийн цай (өмнө)	Үдийн хоол (одоо, өдрийн хоол, өглөөний цай)	
		
<i>Будаатай шөл Бин Гоймонтой хуурга Үзэмний шүүс</i>	<i>Ногооны зутан шөл Комлет Чанасан гоймон, ногоотой Үзэмний шүүс Сүү</i>	<i>Сүүтэй шар будаа Жигнэмэг (гурилан бүтээгдэхүүн)</i>
		
<i>Гоймонтой шөл Бин Төмстэй хуурга Агшаасан будаа Сүүтэй цай</i>	<i>Шар хулууны зутан шөл Тэфтель Жигнэсэн ногоо Нэрсний шүүс Сүү</i>	<i>Сүүтэй овъёос Жигнэмэг (гурилан бүтээгдэхүүн)</i>

Нийт судалгаанд хамрагдсан сурагчдын сэтгэл ханамж үдийн хоолондоо өмнө нь 60% нь сэтгэл ханамжгүй байсан. Өглөөний цайгаа 55,2 хувь нь уудаг, 38,8% нь огт уудаггүй, 4,5% нь хааяа уудаг байна. Сүү цагаан идээг өдөр 61,2% нь огт уудаггүй, 4,5 хувь нь хааяа уудаг бол одоо бүх сурагч өдөр бүр нэг нэгж сүү ууж байна. Хүнсний бүтээгдэхүүнээс 76,9 хувь нь харшилдаггүй ба 8,2 хувь нь халуун ногоо, чихэрлэг зүйлсээс харшилтай тул хоолны цэс боловсруулахдаа анхаарч байна.

Нийт сурагчийн 57,1% тураалтай, 41,2% нь хэвийн жинтэй, 1,58% нь жингийн илүүдэлтэй байна.

Зураг 2. Сурагчдын ирцийн харьцуулалт



Үдийн хоолны чанар ба хүүхдэд ээлтэй байдлыг тэдний ирцээр илэрхийлэх боломжтой (Зураг 2). 2017 – 2019 онуудын сурагчдын ирцийн мэдээллээс харвал дараах байдалтай байна.

- **Эмнэлзүйн судалгааны үр дүнгээс**

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ясны чанарыг тодорхойлоход 43 хувь нь эрүүл, 43,8 хувь нь ясны эд цөөрсөн, 13,3 хувь нь яс сийрэгжсэн байсан. Үдийн хоолоор 5 сарын турш өдөр бүр 180 мл сүү өгснөөр сурагчдын ясны бүтэц 60,1 хувь нь эрүүл, 35,1 хувь нь ясны эд цөөрсөн, 4,6 хувь нь яс сийрэгжилттэй байна. Сурагчдын ясны бүтэц хэвийн буюу 17,1 хувиар сайжирсан, ясны эд цөөрсөн үзүүлэлт, яс сийрэгжилт 8,7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Сэтгэл зүйн шинжилгээнд хүүхдийн сэтгэц, танин мэдэхүйн үйл ажиллагааг судлах аргачлалуудыг ашигласан бөгөөд шинжилгээнд илэрсэн үзүүлэлтүүдийг авч үзье.

Шинжилгээнд хамрагдсан нийт хүүхдүүдийн 20,9 хувьд оюун ухааны ерөнхий түвшинг тогтоох боломжгүй байв. Учир нь сорилын даалгаврыг бүрэн биелүүлэх чадвар хангалтгүй байсан.

Оюун ухааны түвшин тогтоох сорилд хамрагдсан хүүхдүүдийн 28,7 хувь нь оюун ухааны хөгжил хэвийн, 19,6 хувь нь завсрын хоцрогдол, 28,7 хувь нь хөнгөн зэргийн, 23 хувь нь хүндэвтэр хомсдолтой гэсэн үзүүлэлт илэрч байна.

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хэмээн оноштойгоор шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшинг мэргэжлийн аргачлалаар судлан үзэхэд 45,5 хувьд оюуны хөгжлийн бэрхшээл илэрсэнгүй. Харин 27,3 хувь нь хөнгөн, 27,3 хувь нь хүндэвтэр зэргийн хомсдол илрэв.

Тархины саа саажилттай хүүхдүүдийн хувьд 50 хувь нь оюун ухааны хомсдолгүй хэвийн, 27,5 хувь нь хөнгөн зэргийн оюуны хомсдол хавсарсан, 22,5 хувь нь оюуны хүндэвтэр хомсдол хавсарсан үзүүлэлт илрэв.

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 81,8 хувьд ой тогтоолтын хөгжил сул, 10 хувьд дунд зэрэг, 8,2 хувьд сайн гэсэн үзүүлэлт илрэв.

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн хувьд Крепелины аргаар хялбар тоо нэмэх сорилоор 15 сек тутамд дунджаар 2-3 үйлдэл гүйцэтгэж чадаж байгаа бөгөөд оюуны хөгжлийн түвшингээс хамааран хэлбэлзэл илэрдэг байна. Хүүхдүүдийн 62,5 хувьд оюуны ажиллах чадварын хурд удаан, 27,8 хувьд дундаж, харин 9,7 хувьд өндөр байна. Анхаарлын алдаа гаргаж буй эсэхийг судлан үзэхэд 69,4 хувьд анхаарал тогтворгүй байдалтай, 19,4 хувьд анхаарлын төвлөрөлт жигд гэсэн үзүүлэлттэй байна.

Хүүхдүүдийн 45 хувь нь сэтгэл зүйн ачаалал

дундаж хэмжээнд, 19,2 хувьд сэтгэл зүйн ачаалал ихэссэн, тодруулбал, ядарсан, эрч хүч суларсан байдалтай байв. Хүүхдүүдийн 54,1 хувьд идэвх хэвийн, 15,6 хувьд хэт идэвхжсэн байдалтай, өөрөөр хэлбэл анхаарал тогтворгүй, сайн амарч чадахгүй байгаа, 3,7 хувьд мэдрэл сульдлын, 26,6 хувьд идэвх суларсан үзүүлэлт илрэв.

Хэлцэмж

Судалгааны үр дүнгээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хоол шим тэжээлийн байдлыг бодитоор үнэлсэн, тархины саажилттай болон оюуны хөгжлийн түвшинг үнэлсэн анхны судалгаа боллоо.

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хоногт хоол хүнснээс авах нийт илчлэгийн 35 хувийг үдийн хоолноос авах ёстой. Судалгаанд хамрагдаж буй нийт сурагчид өдөр бүр үдийн хоолоороо илчлэгээ хангалттай авснаар хоол, шим тэжээлээс үүдэлтэй далд өлсгөлөн буурах, биеийн дархлаа сайжрах, халдварын бус архаг өвчлөлөөс урьдчилан сэргийлж байна. Үдийн хоолыг үдийн цай хэлбэрээр олгодог байх үед сурагчдын ирц 2017 онд 3193 байсан ба үдийн хоол олгож эхлэснээр 2018 онд 3324, 2019 онд 3640 хүүхэд хамрагдсан ба 131 – 447 хүүхдээр буюу 13,9 хувиар өссөн байна. Энэ нь сурагчид болоод эцэг, эхчүүд үдийн хоолонд сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд үдийн хоолоороо өдөр бүр сүү хэвшсэн нь яс сийрэгжилтийг 17,1 хувиар сайжирсан, ясны эд цөөрсөн үзүүлэлт, яс сийрэгжилт 8,7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 81,8 хувьд ой тогтоолтын хөгжил сул, 10 хувьд дунд зэрэг, 8,2 хувьд сайн гэсэн үзүүлэлт илрэв. Хүүхдүүдийн 54,1 хувьд идэвх хэвийн, 15,6 хувьд хэт идэвхжсэн байдалтай, өөрөөр хэлбэл анхаарал тогтворгүй, сайн амарч чадахгүй байгаа, 3,7 хувьд мэдрэл сульдлын, 26,6 хувьд идэвх суларсан үзүүлэлт илрэв. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад оюуны бэрхшээлтэй хэмээнд суралцаж байгаа, сэтгэл зүйн шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 45,5 хувьд оюун ухааны хомсдол илэрсэнгүй.

Дүгнэлт

1. Төсвийн оновчтой зарцуулалтыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэснээр сургуулийн үдийн хоолыг амжилттай хэрэгжүүлэх бүрэн

боломжтой болохыг энэхүү загвар төсөл харуулж байна

2. Сургууль дээр хүүхдийг хооллох нь тэдний эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болохын зэрэгцээ эцэг эх, хүүхдийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн, өрхийн орлогыг дэмжих нийгмийн халамжийн илэрхийлэл болж байна.

Талархал


Төслийг БСШУСЯамны Инновацийн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн тул ШУТСан болон БСШУСЯаманд талархал илэрхийлж байна.

Ном зүй

1. Aviva Must, Carol Curtin, “Obesity Prevention for Children with Developmental Disabilities”, *J Curr Obes Rep.* 2014 Jun; 3(2): 156–170
2. USDA-FNS, “Accommodating Children with Disabilities in the School Meal Programs Guidance for School Food Service Professionals”, United States Department of Agriculture Food and Nutrition Service, 2017
3. WHO “World Mental Health Survey Consortium Prevalence, severity, and unmet need for treatment of mental disorders” World Mental Health Surveys. *JAMA.* 2004;291:2581–2590, doi: 10.1001/jama.291.21.2581
4. Үндэсний Статистикийн Хорооны тайлан, 2018
5. Sánchez-Lastres J, Eirns-Pucal J, Otero-Cepeda JL, “Nutritional status of mentally retarded children in north-west Spain”, *Acta Paediatr J.* 2003 Jun;92(6):747-53
6. Posey DJ, Stigler KA, Erickson CA, McDougale CJ., “Antipsychotics in the treatment of autism”, *Journal of Clinical Investigation.* 2008;118(1):6–14
7. Ч.Өлзийбүрэн, Ц.Энхжаргал, М.Пүрэвжав, Д.Энхмягмар, Сургуулийн үдийн цай, хоол хүнсний бүтээгдэхүүний төрөл, найрлагын шинжилгээний дүн, Монголын анагаах ухаан, 2013, 1(163)
8. Stevenson RD, “Use of Segmental Measures to Estimate Stature in Children with Cerebral Palsy”, *Arch Pediatr Adolesc. Med.* 1995;149:658–62.
9. WHO, “Multi Centre Growth Reference Study Group”. WHO Motor development study; Windows of achievement for six gross motor

development milestones, *Acta Paediatrica Supplement* 2006;450:86-95

10. Nalan Hakime Nogay, “Nutritional status in mentally disabled children and adolescents: A study from Western Turkey”, *Pak J Med Sci.* 2013 Apr; 29(2): 614–618.
11. ILO, “Facts on People with Disabilities in China”, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_142315.pdf
12. Rehabilitation Research and Training Center, USA “2017 Disability Statistics Annual Report” Disability Statistics and Demographics, https://disabilitycompendium.org/sites/default/files/useruploads/2017_AnnualReport_2017_FINAL.pdf
13. Jinwook Bahk, Hee-Yeon Kang, Young-Ho Khang, “The Life Expectancy Gap between Registered Disabled and Non-Disabled People in Korea from 2004 to 2017”, *International Journal of Environmental Research and Public Health*, Int. J. Environ. Res. Public Health 2019, 16, 2593; doi:10.3390/ijerph16142593
14. НХХЯ, ЭМЯ, БСШУСЯ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”, 2018, УБ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ТОГТООЛ		
2019 оны 03 дугаар сарын 18-ний өдөр	№101	210648 Улаанбаатар хот 6 Сурбалзар дурал, Олимпын гудамж-2, Засгийн газрын VIII байр, Эрүүл мэндийн яам, Утас: 261845, Факс:323541
Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар хурлын протоколыг үндэслэн ТОГТООХ нь:		
<ol style="list-style-type: none">1. “Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ, шим тэжээлийн менежментийг сайжруулах, тархины нөхөн төлжилт, эргэн сэргэлтийг хангах зохилцуулах үйлчилгээтэй хоол, хүнсний үйлчилгээ бий болгох туршилтын загвар” сэдэвт судалгааны ажлыг судлаач Ж.Балжиннямын удирдлаган дор 2019-2020 онд багтаан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.2. Судалгааны явцад тодорхой шалтгааны улмаас арга аргачлал өөрчлөгдөх, гадаад орон луу дахин сорьц тээвэрлэх, Хельсинкийн тунхаглалд туссан ёс зүйн асуудал хөндөгдсөн тохиолдолд анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэж, дахин хэлэлцүүлэхийг судалгааны багийнханд үүрэг болгосугай.3. Судалгааны явцын болон төгсгөлийн тайланг судалгаа дууссан хугацаанаас хойш 2 сарын дотор багтаан анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.		
ДАРГА		Н.ГЭРЭЛТ-ОД
1118270972 а.9037443		

ТӨРӨЛХИЙН ДҮЛИЙ БОЛОН СОНСГОЛ БУУРАЛТЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮР ДҮН

Ч.Саруул¹, Г.Оюун¹, Д.Ариунтуяа¹, Ц.Золзаяа¹,
Л. Раднаацэрэн¹, Б.Дэлгэрмаа¹, М.Баялаа¹ Пэйж Стрингер²
¹ЭХЭМҮТ, ²Сонсгол Бууралттай Хүүхдийн Дэлхийн Сан

Түлхүүр үг

Нярайн сонсголын скрининг, чихний акустик тархалт, дунгийн суулгац, тэнцсэн, дахин илгээх

Үндэслэл

Дүлийрэлт, сонсгол бууралт нь нэг ба хоёр чихний сонсох үйл ажиллагаа бүрэн ба хэсэгчлэн алдагдах үйл явц юм.

Дэлхийн хүн амын 466 сая хүн сонсголын бууралттай байгаагаас 34 сая нь хүүхэд байна. Хүүхдийн сонсгол бууралтын 60% нь сэргийлж болох шалтгаануудаар үүсгэгджээ (ДЭМБ, 2018).

1000 төрөлт тутамд 1,1-1,3 таг дүлий хүүхэд төрдөг ба сонсголыг скрининг-аппаратаар шалгахад статистик үзүүлэлт 3-4 болж нэмэгддэг байна (Lenarz et al. 2008).

Манай орны хувьд ойролцоогоор 240 мянган сонсголын бууралттай ба дүлий хүн байдгийн 2000 гаруйг хүүхэд эзэлдэг (Л.Шагдар, Б.Эрдэнэчулуун нар, 1999) гэсэн тоо мэдээ байна. 2001 онд Улаанбаатар хотод хийгдсэн судалгаагаар 2477 дүлийрэлтийн тохиолдол илэрсэн. 2011 оны Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр 1000 нярай тутмын 1-2 төрөлхий дүлий тохиолджээ.

Хүүхдийн хэл яриа, танин мэдэхүйн хөгжилд амьдралын эхний жил нь чухал байдаг тул ой хүртэлх насанд сонсголын бууралтыг эрт илрүүлэх нь нэн чухал ач холбогдолтой. Хүний тархи мэдрэлийн сонсголын хэсэг нь гаднаас дуу авианы цочролгүй үед 3,5 нас хүртэл хамгийн уян хатан байж дуу авианы цочролд сэрэх боломжтой (Sharma et al., 2002). Төрөлхийн дүлий хүүхдэд 2 наснаас эрт үед дунгийн суулгацын мэс засал хийгдэхэд хагалгааны дараах сонсгол хэл заслын эмчилгээний үр дүнд эрүүл хүнтэй ижил төстэй хэмжээнд сонсож ярих боломжтой⁹. Харин 3 наснаас хойш хугацаанд хожуу оношлогдвол нөхөн сэргээх, сонсгол оруулах эмчилгээний үр дүн муу, энгийн хэл яриа үүсэх боломж алдагдаж, хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болох

төдийгүй гэр бүл, нийгэмд асар их сөрөг үр дагаварыг үүсдэг.

Нярайн сонсголын скрининг гэж төрөлхийн таг дүлий болон сонсголын төрөл бүрийн бусад эмгэгийг эрт үед илрүүлэх арга юм.

Австрали, БНХАУ, АНУ, Шинэ Зеланд, ХБНГУ, БНСУ, Филиппин, Бразил, Серб, Швед, Энэтхэг зэрэг улсуудад нярайн сонсголын цогц хөтөлбөр хэрэгждэг байна. ХБНГУ-д хийсэн судалгаагаар нярай хүүхдийн 2% нь сонсголын төрөлхийн эмгэгтэй байсан (J.Helms, 1995, K. Schwager, 1999). Харин манай оронд нярайн сонсголын эмгэгийн талаархи тоо баримт хомс байна. Монгол улсад 2014 онд нярайн тандалтын хөтөлбөр батлагдаж нярайн сонсголын цогц хөтөлбөр хэрэгжих боломж бүрэлдсэн. Нярайн сонсголын скрининг хийгдсэнээр хүүхдийн сонсгол бууралт, дүлийрэлтийг эрт илрүүлэх, оношлох, нөхөн сэргээх, эмчлэх боломж бүрдэж, хүүхдэд хөгжлийн бэрхшээл үүсэхээс сэргийлж, нийгэм эдийн засгийн хувьд асар их хэмнэлт гардаг.

Хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгож, амьдралын чанарт нь нөлөөлөөд зогсохгүй нийгэм эдийн засагт ихээхэн хор хохирол учруулдаг сонсголын эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх, нярайн сонсгол шалгах дэвшилтэт арга технологийг өөрийн оронд цогц байдлаар нутагшуулах, энэ чиглэлд эмч, эмнэлгийн мэргэжилтэнг чадавхижуулах асуудлууд манай орны хувьд тулгамдсан хэвээр байна.

Судалгааны зорилго

Бидний судалгааны ажлын зорилго хүүхдийн төрөлхийн дүлий болон сонсголын бууралтын эрт илрүүлэг, оношлогоо эмчилгээний зарим үр дүнг судлахад оршино.

Судалгааны зорилтууд

Бидний судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв:

1. Төрөлхийн сонсгол бууралтын тархалтыг тодорхойлох

2. Сонсголын скринингээр илэрсэн тохиолдлуудад сонсголын цогц шинжилгээ хийж, сонсгол бууралтын хэлбэр ба зэргийг тодорхойлох
3. Сонсгол нөхөн сэргээх болон оруулах эмчилгээнд эрт хамруулах, үр дүнг тооцох

Судалгааны материал, арга зүй

Бид 2012 оны 12 сараас эхлэн ЭХЭМҮТ-ийн Эх Барих Эмэгтэйчүүдийн Эмнэлэгт төрсөн нярай болон сонсгол судлалын кабинетээр үйлчлүүлсэн нярайд сонсголын скринингийг хийж эхэлсэн. 2016-2019 онуудад АНУ-ын Сонсгол Бууралттай Хүүхдийн Дэлхийн Сангийн санхүүжилт, ЭХЭМҮТ-тэй хамтарсан “Нярайн сонсголын скринингийн төсөл”-ийн хүрээнд ЭХЭМҮТ, Нийслэлийн “Өргөө”, “Хүрээ”, “Амгалан”, “Багануур ЭМТ”, “Налайх ЭМТ”-үүдэд чихний акустик тархалтанд суурилсан сонсголын скринингийн аппаратыг хандивласанаар УБ хотод төрж буй нярайд сонсголын скрининг хийх, үр дүнг үнэлэх боломж бүрдсэн. Одоогоор Монгол улсад нярайн сонсголын скринингэд чихний акустик тархалт, сонсголын дуудлагат потенциалын автомат шинжилгээнд суурилсан байна.

Бид эмнэлзүйд суурилсан ретроспектив судалгааны аргыг сонгон авч, 2016-2018 онуудад нийслэл хотын улсын бүх амаржих газруудад сонсголын скринингэд хамрагдсан бүх нярайг оролцуулав. Нярайн сонсголын скринингийг гүйцэтгэхдээ Нярайн Сонсгол Судлалын Нэгдсэн Холбооноос гаргасан удирдамж, Нярайн сонсголын скринингийн эмнэлзүйн зааврыг тус бүр баримтлан 3 шатлалтайгаар гүйцэтгэв.

I шатанд нийслэлийн амаржих газрын төрсний дараах тасагт, амьдралын эхний 1-3 хоногуудад нярайд чихний акустик тархалт (transient evoked otoacoustic emission-TEOAE)-ын аргаар Герман улсын Пат Медикал компанид үйлдвэрлэгдсэн скринингийн багажийг ашиглан гүйцэтгэв. Сонсголыг шалгахдаа нярайн чихний гадна сувагт багажийн хошууг байрлуулан 35 дБ хүчтэй дуу чимээ сонсгож, түүнд дотор чихний гадна сормууслаг эсийн өгөх хариуг аппаратанд автоматаар бичив. Сонсголын скринингэд “тэнцсэн” буюу “ээрэг (pass)” хариуг “нярайн сонсгол хэвийн”- гэж үнэлэв. Харин “тэнцээгүй” буюу “дахин илгээх (refer)” хариу гарсан нярайг II шатны скринингэд илгээв.

II шатанд эхний сонсголын скринингэд

тэнцээгүй оролцогчдыг хамруулан, Герман улсын Пат MB11 Veraphone аппаратыг ашиглан, нярайг сонсголын скрининг хийх арга, аргачлалын дагуу бэлдсэний дараа нярайн чих, толгойн тодорхой хэсгүүдэд электрод байрлуулан, 35 дБ хүчтэй дуу чимээ сонсгож, түүнд сонсголын мэдрэлийн өгөх хариуг компьютерт автоматаар бичив. Энэ шатанд “тэнцсэн” буюу “ээрэг (pass)” хариуг “нярайн сонсгол хэвийн”- гэж үнэлэв. Харин “тэнцээгүй” буюу “дахин илгээх (refer)” хариу гарсан нярайг III шатны онош батлах шинжилгээнд илгээв.

III шатанд 2-3 сартайгаас эхлэн оролцогчдод сонсголын нарийвчилсан, багажийн цогц шинжилгээг хийж, сонсгол бууралтын хэлбэр болон зэргийг тогтоон, холбогдох мэс засалч эмчийн зөвлөгөө, сонсгол нөхөн сэргээх болон сонсгол оруулах эмчилгээнүүд шат дараалалтайгаар хийгдэв.

Дунгийн суулгац мэс заслын өмнө бүх өвчтөнийг үнэлэн, MAIS, CAP-ийн асуулгын дүнг дунджилан, бүлэг бүрт хуваарилсан. Судалгааны мэдээллийг SPSS болон Microsoft Excel програмуудад оруулан, үр дүнгийн болосруулалт хийсэн.

Судалгааны үр дүн

2016-2018 онуудад ЭХЭМҮТ, Нийслэлийн “Өргөө”, “Хүрээ”, “Амгалан”, “Багануур ЭМТ”, “Налайх ЭМТ”-ийн амаржих газруудад нийтдээ 54970 нярай хамрагдснаас сонсгол бууралт, дүлийрэлт 282 оношлогдсон.

Хүснэгт 1

Илэрсэн эмгэгийн хэлбэрүүд		Тохиолдол
Мэдрэл мэдрэхүйн	Хөнгөн зэргийн	26
	Дунд зэргийн	18
	Хүндэвтэр	12
	Хүнд зэргийн	25
Дамжуулах замын	Хөнгөн зэргийн	13
	Дунд зэргийн	7
	Хүндэвтэр	29
	Хүнд зэргийн	138
Төрөлхийн дүлий		8
Сонсголын мэдрэлийн эмгэг		6
Нийт		282

Гадна, дунд чихний хөгжлийн гажигтай (микроти) 138 оролцогч байсны 23 нь хоёр талынх байсан. Эдгээрээс 14 хүүхдэд Баха чичиргээнт суулгацыг ЭХЭМҮТ-д суулгаж, 6 хүүхдэд чихний гадна суваг гаргах мэс заслыг хийсэн. Бусад дамжуулах замын бууралттай 128

хүүхдэд агааржуулах гуурс тавих мэс заслыг хийсэн. ЭХЭМҮТ нь дунгийн суулгацын мэс заслыг 2014 оноос хийж эхэлсэн ба одоогоор 21 хүүхдэд уг мэс заслыг хийсний тал хувьг сонсолны скринингээр илэрсэн үйлчлүүлэгчид эзлэж байна. Дунгийн суулгац мэс засал хийгдсэн хүүхдийн хамгийн бага нь 1 нас 2 сартай байв. Хуваагдсан 3 бүлэгт MAIS, CAP, SIR, сонсох болон хэл ярианы үзүүлэлт сайжирсан. Бүх бүлэг мэс заслын өмнө дундаж үзүүлэлт MAIS-1,6/40, CAP-0,77, SIR-0,7/5, мэс заслын дараах 12 сарын хугацаанд MAIS-29.6/40, CAP-3.3/7, SIR-2,7/5 сонсох болон хэл ярианы үзүүлэлт сайжирсан.

Сонсгол нөхөн сэргээх эмчилгээ буюу сонсголын аппаратыг 23 хүүхэд сонсголын аппаратын төвүүдэд тохируулж, сонсгол хэл заслын эмчилгээнд хамрагдав.

Дүгнэлт

1. Бидний судалгааны урьдчилсан дүнгээр 54970 төрөлтөнд хүнд хэлбэрийн сонсголын бууралттай 51 тохиолдол илэрсэн нь бусад судалгааны үзүүлэлтэй ойролцоо байна (1000 төрөлт тутамд 1,1-1,3 таг дүлий хүүхэд төрдөг байна. Lenarz et al.2008).
2. Нярайн сонсголын скрининг хийгдсэнээр төрөлхийн дүлий эрт илрэхийн зэрэгцээ бусад төрлийн сонсголын эмгэгүүд, нэг талын дүлийрэлт, чихний хөгжлийн гаж хөгжил илрэн оношлогдож, сонсгол бууралтын хөнгөн, дунд, хүндэвтэр зэргүүдийг тодорхойлж байгаа нь эмнэлзүйн өндөр ач холбогдолтой байна. Тиймээс нярайн сонсголын скринингийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх шаардлагатай байна.
3. EARS судалгаагаар дүлий хүүхэд нь 3, 5 жилийн дараа MAIS сонсох чадвар 40 оноо хүрнэ. 3 нас дотор дунгийн суулгац мэс засал хийх нь илүү үр дүнтэй байна⁷. Цаашид сонсгол хэл ярианы нөхөн сэргээлтийн судалгааг мэс засал хийгдсэн насны бүлэг, хүйсийн харьцуулалт болон бусад сонсголын технологуудтай (сонсголын аппарат, чичиргээнт суулгац, ясан дамжуулалтын суулгац) харьцуулан судлах шаардлагатай байна. Сонсгол, хэл заслын эмчилгээний үр дүнд эцэг эхийн хүүхэдтэй ажиллах байдаол нөлөөлдөг тул эцэг эх, асран хамгаалагчийн суурь ойлголт, эрүүл мэндийн боловсролыг

дээшлүүлэх сайжруулах шаардлагатай байна. Сонсголын аппарат өндөр өртөгтэй, эцэг эхчүүдийн сонсголын аппаратын талаарх ойлголт тааруу, нийгэмд сонсголын аппаратыг хүлээн зөвшөөрөхдөө муу зэргээс шалтгаалан оношлогдсон, сонсголын аппарат зүүх шаардлагатай хүүхдүүд сонсголын нөхөн сэргээх эмчилгээнд муу хамрагдаж байна. Цаашид сонсголын аппаратын хүүхдийн хүртээмжийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Ном зүй

1. Дүлийрэлт, сонсгол бууралттай хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний удирдамж, ЭМЯ. 2010; хх 1-13.
2. Эрүүл мэндийн сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаал, Дугаар-303/126, 2009.09.17, “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах Үндэсний стратеги” батлах тухай.
3. Эрүүл мэндийн сайдын тушаал, Дугаар-182, 2014.05.30, “Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр (2014-2020)” батлах тухай.
4. ЭМЯ-ын ЧХХМСЗ-ийн шийдвэр, “Нярайн сонсголын скринингийн эмнэлзүйн заавар”-ыг батлах тухай, 2018
5. American Academy of Audiology Clinical Practice Guidelines. (2012). *Audiologic guidelines for the assessment of hearing in young infants and children* [Guidelines].
6. Cebulla M, Shehata-Dieler W. (2012). “ABR-based newborn hearing screening with MB11 Otorhinolaryngol. 76, 536-543.
7. Creswell J.B, Research design, qualitative, quantitative and mixed methods approaches. 2nd ed. California: Sage Publications 2003.
8. JCIH. 2000. Joint Committee on Infant Hearing – Year 2000 Position Statement. Principles and Guidelines for Early Hearing Detection and Intervention Programs. URL: www.jcih.org/JCIH. 2007.
9. Joint Committee on Infant Hearing – Year 2007 Position Statement. Principles and Guidelines for Early Hearing Detection and Intervention Programs. *Pediatrics* 120(4): 898–921.
10. Low WK, Pang KY, Ho LY: Universal newborn hearing screening in Singapore: the need, implementation, and challenges. *Ann Acad Med Singapore* 2005; 34:301-306.

11. Mason, J. A., & Herrmann, K. R. (1998). Universal infant hearing screening by automated auditory brainstem response measurement. *Pediatrics*, 101, 221-228.
12. Shehata-Dieler WE, Dieler R, Keim R, Finkenzeller P, Dietl J, and Helms J. (2000). “Universal hearing screening in newborns using the BERAphone newborn hearing screener,” *LaryngoRhino-Oto*. 79, 69-76.
13. Spivak, L. Dalzell, L. Berg, A. Bradley, M. Cacace, A. Campbell, D., Prieve, B. (2000). New York State universal newborn hearing screening demonstration project: Inpatient outcome measures. *Ear and Hearing*, 21(2), 92-103.
14. Stewart, D. L., Mehl, A., Hall, J. W., III, Thomson, V., Carroll, M., & Hamlett, J. (2000). Universal newborn hearing screening with automated auditory brainstem response: A multisite investigation. *Journal of Perinatology*, 20(8, Pt. 2), S128-S131.
15. Weichbold V, Nekahm-Heis D, Welzl-Muller K Evaluation of the Austrian Newborn Hearing Screening Program . *Int J Pediatr Otorhinolaryngol* 2006: (70) 235-240.
16. White KR. Early intervention for children with permanent hearing loss: Finishing the EHDI evolution. *Volta Review* 2007:106 (3):237-25813
17. http://www.infanthearing.org/ehdi-ebook/2012_ebook/Chapter2.pdf
18. http://www.maicodiagnostic.com/eprise/main/_downloads/com_en/Documentation/MB11BERAphone_e_12a.pdf <http://www.who.int/mediacentre/factsheets/fs300/en>
19. http://www.who.int/blindness/publications/Newborn_and_Infant_Hearing_Screening_Report.pdf
20. <http://www.who.int/mediacentre/factsheets/fs300/en/>

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН ТУРШЛАГААС

Г. Нямпагма¹

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хүүхдийн сэтгэл зүйч

Түлхүүр үг:

Оношлогоо үнэлгээ, ойлгох, дэмжих, хамтран ажиллах, үр дүн

Хураангуй

Хүүхдийн эрхийн тухай хуулийн Хүүхдийн хөгжих эрх 6.1.1. хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших, 6.1.3. хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах, эрхтэй боловч хүүхдэд тохирсон орчин, туршлагатай багш, онцлогт нь тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллах зэрэг нь дутагдалтай байна. 6.1.6. хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх, гэр бүлд хүүхэд хөгжих эрхтэй боловч эцэг эх энэхүү бэрхшээлийн талаарх ойлголт байхгүй хүлээн зөвшөөрөх хугацаа урт, ойлгож харилцах, цаашидаа хэнтэй яаж, хэрхэн хамтран ажиллах гэсэн олон талын мэдээлэл, мэдлэг туршлага, боломж байхгүй байна. 9-р зүйлийн Хүүхдийн хүмүүжил, төлөвшил 9.1.5. эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухаан дадал, чадвар эзэмшүүлэх, гэсэн заалтыг дэмжин ажиллах хэрэгцээ шаардлага байгаа боловч эцэг эх асран хамгаалагч хүүхдийн чадварыг хөгжүүлэн ажиллахад / хүүхэд өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг учраас хэл ярианы хоцрогдол үүсч, бие даах, нийгмийн харилцаанд оролцох зэрэгт чадваруудад тодорхой хэмжээний хоцрогдол ажиглагдаж байгаа нь / мэргэжлийн хүнээс дэмжлэг тусалцаа авах зайлшгүй шаардлагатай байна.

Бага, дунд боловсролын тухай хуульд зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамтран сургах” заалтыг дагуу харахад аутизмын хүрээний эмгэгтэй сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдийг энгийн сургууль, цэцэрлэг хүлээж авах, суралцуулах боломж, нөхцөл бага байгаа нь ажиглагдаж байна.

Аутизмын хүрээний эмгэгтэй гэж оношлогдсон хүүхдүүдтэй ажиллахдаа дараах аргуудыг ашигласан болно.

Ажиглалтын арга – хүүхдийн гаргаж буй зан үйлд ажиглалт хийх.

Мэдээлэл цуглуулах арга- эцэг эхийн харилцаа хандлага, хүүхдээ хүлээн зөвшөөрсөн байдал, хамтран ажиллаж буй багш, мэргэжилтэн, сургуулийн талаарх мэдээлэл

Хөгжлийн үнэлгээ - хүүхдийн гарааны үнэлгээ болон явцын үнэлгээ хийж мөн сургалтын төгсгөлд үнэлэн үр дүнг тооцох

Түүврийн арга – үйлчлүүлэгчдээс нэг хүүхдийг сонгон ажиллаж буй үйл явцын жишээ болгон авсан.

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллахад уг эмгэгийн онцлогийн талаарх өргөн хүрээний мэдлэг мэдээлэл, дадлага, туршлага, цаг хугацаа шаардлагатай байгаа нь ажиглагдсан. Тиймээс аутизмын хүрээний эмгэгтэй гэж оношлогдсон монгол хүүхдүүдтэй ажиллаж буй өнөөгийн туршлагаас хэрэгцээ шаардлага байгаа нь мэдрэгдсэн. Багш мэргэжилтнүүд аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдтэй ажиллах, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, үр өгөөжтэй болоход энэхүү арга дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна

Үндэслэл:

Аутизмын хүрээний эмгэгийг талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой “Би яагаад үсэрдэг вэ?”, “Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт”, эцэг эх хүүхдээ ойлгож харилцахад туслах “Үгээр хязгаарлагдахгүй харилцаа”, “Аутизмтай хүүхэдтэй монгол эцэг эхчүүдийн түгээмэл асуулт”, Autism – эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, “Багш, эмч, мэргэжилтнүүдэд зориулсан аутизмын тухай гарын авлага” гэх мэт онолын ном зохиол олон байна.

Харин аутизмын хүрээний эмгэгтэй монгол хүүхэдтэй ажилласан бодит жишээ буюу үнэлгээ, сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллах, тэмдэглэл хөтлөх, үр дүнг танилцуулсан байдал зэрэг нь хомс байна. Энэ нь эцэг эхчүүдийн сэтгэл ханамжгүй байдал мөн багш мэргэжилтнүүдийн тулгамдсан асуудал

болохоос гадна, хүүхдэд гарч буй бодит үр дүнгээс харагдаж байна. Хүүхэдтэй ажиллаж эхлэх эхний уулзалтаас дуусах хүртэл тодорхой зорилго, төлөвлөгөөтэй ажиллах хэрэгтэй. Үйлчлүүлэгчийг эцэг эх асран хамгаалагчийн оролцоотойгоор / өөрийн ажиллах чиглэлээр/ үнэлэх, харилцаа тогтоох, хөтөлбөр боловсруулах, онцлогт тохирсон сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, эцэг эхтэй хамтран ажиллах, эцэг эхийн оролцоог сайжруулан үйл ажиллагаанд татан оруулах, зөвлөмж зөвлөгөө өгөх, үр дүнг танилцуулах зэрэг олон талын мэдлэг, туршлага, ур чадвар нь хүүхэдтэй ажиллаж буй багш, мэргэжилтнүүдэд шаардлагатай байна.

Судалгааны зорилго:

Аутизмын хүрээний эмгэгтэй монгол хүүхэдтэй ажиллахдаа зан төлөв, сэтгэл зүйн засал, боловсролын эмчилгээнд чиглүүлж буй өнөөгийн туршлагаас хуваалцахад оршино.

Судалгааны зорилт:

Аутизмын хүрээний эмгэгийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх, аутизмийн хүрээний эмгэг гэж оношлогдсон хүүхдүүдийн тоон мэдээлэлд дүгнэлт хийх, ажиллах явцад ажиглалт хийсэн, тэмдэглэл хөтөлсөн байдлыг тусгах, үр дүнг тооцон дүгнэлт хийх.

Судалгааны арга зүй:

Ажиглалтын арга – хүүхдийн гаргаж буй зан үйлд ажиглалт хийж тухайн сөрөг зан үйлийг эерэг, зөв зан үйлээр сайжруулахад туслах.

Мэдээлэл цуглуулах арга - эцэг эхийн харилцаа хандлага, хүүхдээ хүлээн зөвшөөрсөн байдал, хамтран ажиллаж буй багш, мэргэжилтэн, сургуулийн талаарх мэдээлэл цуглуулан шаардлагатай тохиолдолд хамтран ажиллаж эцэг эх хүүхдээ ойлгох, дэмжих, гэр бүлийн гишүүдийн нийгмийн оролцоог өргөжүүлэх, багш мэргэжилтнүүдтэй туршлага солилцон бодит арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх

Хөгжлийн үнэлгээ - хүүхдийн гарааны үнэлгээ болон явцын үнэлгээ хийж мөн сургуулийн төгөсгөлд үнэлэн үр дүнг тооцох. үнэлгээ хийснээр эцэг эхэд хүүхдийн бодит хөгжлийн түгшиг шинжлэх ухааны үндэслэлтэй танилцуулан тайлбарлах, мөн хүүхдийн хөгжлийн төлөө хамтран ажиллах багш, мэргэжилтэн, гэр бүлд хүүхдийн биологийн нас

бус харин хөгжлийн наснаас эхлүүлэн тухайн хүүхдийн онцлог чадварт тулгуурлан хөгжлийн хөтөлбөр боловсруулан ажиллах, зөвлөмж зөвлөгөө өгөх.

Түүврийн арга – үйлчлүүлэгчдээс нэг хүүхдийг сонгон ажиллаж буй үйл явцын жишээ болгон авсан.

Судалгааны арга зүй буюу ажиллах дараалал:

1. Үнэлгээний талаарх танилцуулга

Үнэлгээний мэргэжилтэн өөрийгөө танилцуулан мөн үнэлгээний ач холбогдол, арга зүйн талаар мэдээлэл өгч үйлчлүүлэгч ба үйлчлүүлэгчийн асран хамгаалагчаас үнэлгээ хийлгэх хүсэлтэй байгаа талаар санал асуун үнэлгээг эхлүүлнэ.

2. Үнэлгээ:

Хүүхдийн хөгжлийн тест /0-7 нас/

- Хэл яриа
- Нийгэмшил
- Биеийн том булчин
- Гарын жижиг булчинг үнэлэх үнэлгээгээр хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлон, чадвар тус бүр дээр одоогийн хөгжлийг үнэлэн хамгийн хоцрогдолтой байгаа чадвараас эхлэн ажиллах

Оюуны бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх үнэлгээний тест /5-18 нас/

- Кагоны арга
- Үйл явдлын дарааллыг тогтоох
- Зүй тогтлоор байрлуулах
- Илүүг хасах даалгавар

3. Эцэг эхэд үнэлгээний хариуг танилцуулна.

Эцэг эхчүүдийн дунд үнэлгээний тухай ойлголтгүй мөн ач холбогдлыг нь мэдэхгүй, хариуг сонсоод хэрхэн хүүхэдтэйгээ ажиллах арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг авч чадахгүй байх зэрэг асуудал тулгардаг. Тиймээс эцэг эхчүүдэд хүүхдийн одоо байгаа бодит чадварт тулгуурлан гэртээ хэрхэн ашигтай цагийг гаргаж үр дүнтэй ажиллах талаар зөвлөмж зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлдэг. Мөн эцэг эхчүүд гэр бүлийн гишүүд нэг зорилготойгоор хүүхдээ сайжруулахын төлөө гэртээ ажиллах ба бусад багш, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах сэдлийн өгөх юм.

Ажиллах чиглэлээ тодорхойлох

- Үнэлгээн дээр суурилан тухайн хүүхдийн биологийн наснаас гадна илүү их анхааран ажиллах чиглэл бол одоогийн бодит чадвар

- юм. Тиймээс илүү хоцрогдсон чадваруудыг тодорхойлох хэрэгтэй.
- Тухайн хүүхдийн онцлогийг ойлгон / хүнтэй харилцах харилцаа ямар вэ? өөрийгөө илэрхийлэх чадвар, тоглоомоор зохистой тоглодог эсэх, юунд дуртай, дургүй, яаж тайвширдаг, / дэмжин ажиллах хөтөлбөр боловсруулна.
- Хүүхдийн хөгжлийн наснаас эхлэн хөтөлбөр боловсруулан ажиллана
- Эцэг эх, асран хамгаалагчтай зорилго тодорхойлон хамтран ажиллаж эхэлнэ. Мөн хүүхэдтэй гэрийн нөхцөлд хоцрогдсон байгаа чадварыг хэрхэн хөгжүүлж ажиллах талаар зөвлөгөө өгнө.

Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажиллаж эхэлнэ. Ганцаарчлан ажиллах арга зүй

А. Уйлж хүссэн юмаа авах арга - Tempertantrum
 Хүүхэд хүсэлтээ илэрхийлэхдээ уйлдаг арга бол энэ юм. Энгийн болон тусгай хэрэгцээ шаардлагатай ялгаагүй хүүхдүүдэд өөрийгөө зөв биш аргаар буюу уйлж илэрхийлдэг сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлыг бүрдүүлдэг сөрөг сэтгэлийн хөдөлгөөн юм. Аутизмын хүрээний эмгэгтэй буюу хэл ярианы чадвар хөгжөөгүй хүүхдүүдэд энэ арга нь /уйлах, өөрийнхөөрөө аашлах, дийлэх гэсэн хүсэлтэй байх, толгойгоороо савах, хэвтэж босохгүй байх, юм авч шидэх, өөрийгөө болон бусдыг бэртээх зэрэг / олон сөрөг үр дагавар илэрдэг. Хүүхэд сургалтын хугацаа /20-25 минут/ энэ аргатай

- тэмцэлдсэнээр хамгийн гол зорилго бол хүүхэд өөрөө өөрийгөө тайвшруулж сурах, хүсэлтээ зөвөөр илэрхийлэх нийгмийн харилцааны суурь чадварт суралцахад зөв дадал хэвшил олгох үүднээс “tempertantrum” багасгах хэрэгтэй. Ингэснээр хүүхэд шинэ юм сурах суурь чадвар хөгжиж эхэлдэг.
- Б. Давтагдмал үйлдэл багасгах – энэ нь аутизмын хүрээний эмгэгийн салшгүй гол хэсэг болдог. Доороо эргэх, гараа сэгсрэх, алгаа таших, юм тогших, өлмий дээрээ үсрэх зэрэг олон янзаар илэрч болдог. Харин явцуу сонирхол бол нэг төрлийн зүйлээ удаан хугацаанд сонирхох, олон удаагийн давтамжтайгаар үзэх зэрэг байдаг. Хүүхдийн давтагдмал үйлдэл юу вэ? гэдгийг тодорхой ойлгосны дараа багасгах зорилготойгоор ажиллаж эхэлнэ. Бага багаар давтагдмал үйлдэл багасахаар хүүхдийн шинэ зүйл сонирхох, танин мэдэх үйл явц бага багаар сэргэж тодорхой хугацаанд суух, анхаарал төвлөрөх, хэт явцуу сонирхол бууран сонирхдог зүйл өргөн болж эхлэдэг. Энэ үед хүүхдийн хөгжлийн түвшинд тохирсон сургалтын агуулгыг өргөжүүлэх, шинэ содон зүйлийг олон удаа давтан хийх, шинэ чадвар, дадалд суралцах юм.
- В. Сууж сурах
- Г. Сонирхол өргөжүүлэх
- Д. Анхаарал төвлөрөлтийг сайжруулах гэх мэт олон чадварыг сургах боломжтой.

*Түүврийн аргаар сонгон авч ажилласан кейс, ба тэмдэглэл
 2019 он 07 сар 29*

Нэр: 32

Нас: 4 нас 11 сар

Онош: Аутизм F.84.0

Он сар өдөр	Нийгэмшил	Хэл яриа	Өртөө үйлчлэх	Танин мэдэх	Нарийн булчин	Бусад
07.30	Нүд рүү харах дасгал	Амьтдын зураг нэрлэх / арслан, баавгай, муур, мэлхий, үхэр, туулай /	Команд биелүүлэх, өөрийнхөө юмыг хураах	Өнгө өнгийн савхыг ялган байрлуулах	Савхаа авч өнгө өнгийн нарийн зураас дээр чимхэн байрлуулах	Анхаарал төвлөрөлт, өөрөө тайвширч сурах
7.31	Нүд рүү харж харилцах, заавар ойлгох	Зурлага зурах, авиа дуудлагыг сайжруулах	Цүнхнээсээ хичээлийн хэрэглэгдэхүүнээ гаргах, хураах	Зурган карт үзэж ярилцах /10 ширхэг/ Сэтгэл хөдлөл	10 ширхэг соруул сүвлэх	Анхаарал төвлөрөлт ба сэтгэл хөдлөл ойлгох
8.1	Нүд рүү харах дасгал / тоглох дуртай тоглоомоор нь дамжуулан/	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “А” үсэг / алим, аалз, ам, цаг, утас, тагтаа, лаа, зараа, утаа/ нэрлэсэн.	Өөртөө үйлчлэх / хичээлийн хэрэгслээ гаргах, хураах/	Шар өнгө үзэх	Бийр ашиглан “А” үсгийг зурах	Сонирхол нэмэгдүүлэх /өнгө өнгийн аягаар өнгө ялган будах/

8.2	Үг давтах / эколялия / багасгах	Амьтан нэрлэх /дуу авиаг хамтдаа хийх, хаана амьдардаг, юу иддэг тухай ярилцах /	Хичээлд ашигласан хэрэгслээ хураахад багшид туслах, цүнхэндээ хийх	Өнгө өнгийн хавчаараар өнгө ялган хавчих	Хавчаараар хавчих даалгавар / хурууны өндгөөр барих/	Даалгаврыг тайван гүйцэтгэх, заавар ойлгох
8.5	Нүд рүү харах, команд биелүүлэх	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “О” үсэг / ор, од, онгоц, ном, хонь, тоорой, бороо, долоо, чоно/ хамтдаа хэлж нүдэлсэн	Хичээлийн хэрэглэгдэхүүнээ гаргах, хураах	Амьтдыгиддэг зүйлстэй нь харгалзуулан наах	Наах дадал нь гарын нарийн булчин болон эвслийг сайжруулах	Даалгаварт бие даан оролцоход нь дэмжих
8.6	Амьтдын иддэг хоолны тухай ярилцах	Амьтдын тухай ярилцах / дуу авиаг даган дуурайх /	Унагаасан зүйлээ шалан дээрээс авах, хогоо хогийн саванд хийх	Зүүн тархи хөгжүүлэх дасгал ном 4,5 хуудас ажилласан	Суурь өнгөн дээр дүрс хайчлан наах	Харилцан ярилцах дадалд суралцах
8.7	Команд биелүүлэх	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “У” үсэг / ус, уул, уурга, сум, муур, хун, шувуу, унага, галуу/ Баавгайн тухай ярилцах	Гараа салфеткаар арчих	Баавгай зурсан, өнгө үзсэн	Гараараа зурсан / гараараа/	Хүлээж сурах
8.8	Хуруунууд дуу дуулсан / хөдөлгөөнтэй/	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Э” үсэг /эм, ээж, зэрүүл, эвэр, сэнс, нэг, сэрээ, үхэр, хэрээ/	Цүнхнээсээ ном, дэвтэр, харандаа гаргах	Бүтэн өгүүлбэрээр өөрийгөө илэрхийлэх дасгал хийх /НАМАЙГ ... ГЭДЭГ БИ 5 НАСТАЙ/	Соруул сүвлэх /богино хугацаанд /	Анхаарал төвлөрөлтийн хугацааг уртасгах
8.12	Хоёр үг холбож өөрийгөө илэрхийлэх дасгал хийх / багшаа би жимс авъя / Орж ирээд багштайгаа мэндэлнэ, явахдаа баяртай	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Ө” үсэг /өд, өвс, өмд, мөр, мөөг, өндөг, өвөө, дөрөө, хөрөө/	Орж ирэхдээ хаалга хаана, хичээлдээ бэлдэнэ, дуусаад өөрөө хураах	Өмнөх өгүүлбэрээр давтан, би эмээдээ хайртай гэдэг үг сурсан.	0 тоо үзсэн. Тоон утга ойлгох хичээл хийсэн ба бичсэн.	Тоон утга ойлгох суурь, өөрийгөө илэрхийлэх чухал юм байна гэдгийг ойлгуулах
8.13	Хоёр үг холбож өөрийгөө илэрхийлэх, заавар ойлгох	Зурлага зурах Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Ү” үсэг /үнэг, үс, үүр, нүд, сүх, шүүр, сүү, хүү, цүү/	Номын хуудсаа өөрөө эргүүлэх, багшийн хэлсэн үгийг заах / долоовор хуруугаараа заах /	Багшийн асуултад хариулах /энэ ямар амьтан бэ? нүд хаана байна гэхэд заах /	1 тоо үзсэн. тоон утга ойлгох ба бичсэн.	Давтагдмал үйлдэл багасгах /давтагдмал үйлдэл болох гараа сэгс, эрүүгээ цохих, барисан зүйлээ тогших/
8.14	Гурван үг холбож өөрийгөө илэрхийлэх, заавар ойлгон биелүүлэх	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “И” үсэг / ишиг, индүү, илжиг, хивс, хувин, арьс, бээлий, тоорой, дугуй/	Номын хуудсаа өөрөө эргүүлэх, багшийн хэлсэн үгийг заах / долоовор хуруугаараа заах /	Багшийн суултад хариулах Улаан өнгө үзсэн. /20 минут үзсэн /		Давтагд мал үйлдэл багасгах
8.15	Нүд рүү харж өөрийгөө богино өгүүлбэрээр илэрхийлэх	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Я” үсэг / ямаа, янгир, яргуй, ялаа, янзага, аяга/	Унагаасан зүйлээ авах багшид туслах	Өмнө үзсэн улаан өнгөө дахин давтан хийж, цээжлэх	Жимс ногоо зүсэж / урамшуулсан/	Давтагдмал үйлдлийн багасгах
8.16	Нүд рүү харан өөрийгөө илэрхийлэх дасгал дахин давтах	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Ё” үсэг / ёотон, ёл, ёроол, соёо, хоёр, овъёос/	Номын хуудсаа эргүүлэн асуусан дүрсийг заах, заах оролдлого хийн	Өнгө өнгийн аяганд өнгө өнгийн шоог хийх /танин мэдэхүйн чадвар хөгжүүлэх/	Шинэ үзсэн үгийг хуруугаараа заасан.	Хүүхдийн аав ээж нь ирж хүүхдийн хичээлийн үйл ажиллагаатай танилцсан
8.19	Бүтэн өгүүлбэрээр өөрийгөө илэрхийлэхэд дэмжих	Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх альбом зурагт ном ашиглан “Е” үсэг / еэвэн, ес, ерөөл, Үенч, үер, хөөө/	Өмнөх өнгийг давтах, ногоон өнгийг үзсэн	Улаан, ногоон өнгөөр шаар зурж будсан.	Гарын булчин хөгжүүлэх зорилготой зураг зурж будсан	Бие дааж суух

Хүүхдэд гарсан ахиц өөрчлөлт:

Хүүхдийн өөрийгөө илэрхийлэх, сэтгэл хөдлөл ойлгох, биеийн хэлэмж ойлгох зэрэг чадвар мөн 2-3 үгээр өөрийгөө илэрхийлдэг болсон.

Хүүхдийн суух чадвар сайжирч, анхаарал төвлөрөлт, заавар биелүүлэх чадвар сайжирсан.

Гэр бүл сэтгэл хангалуун байгаа. Гэр бүлийн гишүүд жигд анхаарал хандуулан цаг гаргаж хамтран ажиллаж байгаа.

Үр дүн

Манай улсад аутизмын хүрээний эмэгтэй хүүхэдтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд байдаг боловч албан ёсны нэгтгэсэн тоон мэдээлэл байхгүй байсаар байна.

ХБХСЗХТ-өөр нийт 2019.06.01 эхлэн 2019. 11 сарын байдлаар 669 хүүхэд, эцэг эх асран хамгаалагчдад үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс Тэгш хамруулан сургах – Нийгмийн сэргээн засах газраар үйлчлүүлсэн хүүхдийн тоо 672 байна. Харин хүүхдийг сэтгэл зүйчээр үйлчлүүлж үйлчилгээ авсан 206 хүүхэд хөгжлийн үнэлгээ /0-7 нас/ болон оюуны хөгжлийн /3.5- 18 нас/ үнэлгээ хийлгэсэн байна. Үүнээс үзэхэд хүүхдийн сэтгэл зүйчээр үйлчилгээ авсан нийт 206 хүүхдээс 78 хүүхэд буюу 37,8% нь аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд байна.

Хүүхдийн сэтгэл зүйчээс үйлчилгээ авсан хүүхдүүдийн сургууль цэцэрлэгт хамрагдаж байгаа байдлыг тандахад нийт 78 хүүхдийн 8 буюу 10.2 % нь тусгай цэцэрлэгт сурдаг, 11 буюу 14.1 % нь ерөнхий боловсролын тусгай сургуульд сурдаг. Харин ерөнхий боловсролын сургуульд сурч буй хүүхдийн тоо 6 буюу 7.6 %, сургуулийн өмнөх боловсролд сурч буй хүүхэд 24 буюу 30.7 % тус тус байна. Харин огт сургалтын үйлчилгээ авч чадахгүй байгаа цэцэрлэг болон сургуулийн насны сургалтын үйлчилгээ авах ёстой хүүхэд нь 29 буюу 37.1% байгаа нь бага, дунд боловсролын тухай хуульд зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” заалтыг хэрэгжүүлэхэд хүртээмжийн асуудал байгааг харуулж байна. Шалтгаан тодорхойгүй ч энэ тоон үзүүлэлт өсөхгүй буурах дараалалтай байгаасай гэж хүсэж байгаа тул энэхүү сэдвийг сонгон судалгааны ажил хийсэн билээ.

Хэлцэмж:

- Аутизмын хүрээний эмгэгийг эрт илрүүлэх, засан сайжруулах, зөвлөн туслах
- Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй гэр бүлийг сэтгэл зүйн болон ажиллах арга зүйн сургалт, зөвлөмж зөвлөгөө өгөх
- Аутизмийн хүрээний эмгэгтэй хүүхдүүдийг хөгжих боломжтой үед нь үе шаттайгаар ажиллах
- Аутизмийн хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллаж буй мэргэжилтэн багшийг онолын болон практик дадлагад илүү тулгуурлан сургах
- Гүнзгийрүүлэн судлах, ажиллах боломжийн бий болгох
- Төрийн болон төрийн бус байгууллагууд мэдээлэл солилцон, хамтран ажиллах
- Аутизмын хүрээний эмгэгийн тоон мэдээллийг нэгтгэх зэрэг цаашдаа хамтран, санаачлан хийх олон үйл ажиллагаанууд байна.

Ном зүй:

1. Г.Батцэнгэл “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэл зүйн зарим асуудал”
2. Мэндийн Нарантуяа, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүй: онол ба хэрэглээ
3. Аутизм Монгол Анд ТББ - Autism – эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага

ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГАНЦААРДАХ МЭДРЭМЖ НЬ ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БУЙГ СУДАЛСАН НЬ

Л.Номин-Эрдэнэ¹, Н.Оюунжаргал¹, Д.Дарьмаа¹
¹Отгонтэнгэр Их Сургууль

Түлхүүр үг:

Хэрэгцээний шатлал, дутуу дулимгийн мэдрэмж, ялгаварлал

итгэх, өөрийгөө хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгддэг байна.

Хураангуй:

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн өөртөө итгэх итгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тэдний зан төлөв, өссөн орчин, хөгжлийн бэрхшээлийн түвшин, ангилал зэрэг олон хүчин зүйлээр тайлбарлаж болох боловч бидний тандан судалснаар хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны хүүхдийн өөртөө итгэх итгэлд тэдэнд нийгмээс ирж буй ялгаварлал болон тэдний ганцаардлын түвшин чухал нөлөөтэй хэмээн үзэж байна.

Судалгаанд онолын хэсгийг баримт бичиг судлах арга ашигласан бөгөөд судалгаанд оролцогчдоос өөртөө итгэх итгэлийг үнэлэх асуулга, хүүхдийн ганцаардах мэдрэмжийг үнэлэх сорилоор тус тус судалгаа авсан. Судалгааны үр дүнг “SPSS” программ дээр боловсруулсан болно.

Судалгаанд нийт БЗД-ийн Мэргэжлийн сургалттай 55-р дунд сургуулийн 7-9-р ангийн оюуны хөнгөн бэрхшээлтэй эрэгтэй 18, эмэгтэй 12 хүүхэд оролцсон. Бид судалгааныхаа зорилгыг хангахын тулд судалгаа авч буй хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл болон ганцаардлын түвшинг илрүүлэн хоорондын холбоо хамаарлыг тогтоосон.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт судлуулагчийн ганцаардлын түвшинг авч үзвэл дийлэнх буюу 66.7% нь ганцаардлын түвшин өндөр гарсан бол 33.3% нь дунд түвшний ганцаардалтай бөгөөд ганцаардлын түвшин бага хүн илрээгүй бөгөөд Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өөртөө итгэх итгэлийн түвшинг авч үзвэл 66.7% нь дундаж түвшин, 13.3% өндөр бол 20% бага түвшинд тогтоогдсон.

Мөн өөртөө итгэх итгэл нь ганцаардах мэдрэмжтэй -0.575 буюу дундаж урвуу хамааралтай байгаа нь ганцаардлын түвшин нэмэгдэх тусам өөртөө итгэх итгэл буурдаг бол ганцаардах мэдрэмж буурах тусам өөртөө

Үндэслэл:

Дэлхий нийтийн хэмжээнд үл хүндлэл, ялгаварлан гадуурхалтад хамгийн ихээр өртөн, нийгмийн амьдралаас тусгаарлагдсан хүмүүсийн тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багтдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрөхөд гэм буруу хайх, эсвэл айх юмуу ичиж хүлээж авдаг нийгэмд хөгжлийн бэрхшээлийг аль болох л олны нүднээс нууж, зүй бусаар харьцах, хөгжлийг нь дэмжих чухал үйл ажиллагаанд оролцуулахгүй байх явдал нэлээд элбэл гардаг. Өөрөөр хэлбэл Монгол орны хувьд тусгай хөтөлбөрийн бн сургууль байдаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмээс тусгаарлаж буйтай агаар нэг юм. Мөн бусад хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хэрхэн зохистой харилцах, туслах тал дээр наад захын ойлголтгүй байна. Үүний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэр бүл дотроо, сургууль, орон нутгийн түвшинд ялгаварлагдан тусгаарлагддаг. Ялгаварлан гадуурхалтын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эрүүл мэндийн байдал болон сурлагаар сул, өөртөө итгэл муутай, өөр бусадтай харьцдаггүй шахам байх магадлалтайн дээр мөн хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхралтад өртөх өндөр эрсдэлд байдаг хэмээн үзсэний улмаас тухайн сэдвийг сонгон судлах болсон.

Зорилго:

Оюуны бэрхшээлтэй хүүхдийн өөрийгөө хүндэтгэх, өөртөө итгэлтэй байдалд тэдний ганцаардах, ялгаварлагдах мэдрэмж хэрхэн нөлөөлж буйг судлан илрүүлэхэд чиглэнэ.

Зорилт:

1. Сэдвийн хүрээнд онол арга зүйн үзэл баримтталыг тоймлон судлах
2. Оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдийн ганцаардах мэдрэмжийг судлах
3. Оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдийн өөртөө итгэх итгэлийг судлах

4. Оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдийн ганцаардах мэдрэмж нь өөртөө итгэх итгэлд нь хэрхэн нөлөөлж буйг судлах
5. Оюуны бэрхшээлтэй хүмүүст хандах нийгмийн сөрөг хандлагийг өвчтөнд үүссэн сэтгэгдэл мэдрэмжинд тулгуурлан судлах
6. Судалгааны үр дүнг боловсруулах, санал зөвлөмж гаргах

Таамаглал:

Оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдүүдийн хувьд эргэн тойрны хүмүүс нь тэднийг төдийлөн сайн ойлгодоггүйгээс үүдэн бусадтай харилцах тал дээр хаагдмал болдог. Өөрөөр хэлбэл нийгмийн хандлагаас шалтгаалан тухайн хүүхдүүдийн бусдад хэрэгтэй хэмээн мэдрэх мэдрэмж алдагдах бөгөөд энэ нь цаашлаад өөртөө итгэх, өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ хангагдахгүй байх, бусдаас өөрийгөө тусгаарлах, дутуу дулимгийн мэдрэмж онцгой хурц илрэх зэрэг сэтгэл зүйн сөрөг үр дагаварыг бий болох магадлалтай хэмээн үзэж байна.

Шинэлэг тал:

Оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах нийгмийн сөрөг харилцаа, хандлага нь тэдний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж буйг судлан үр дүнд суурилсан зөвөлгөө, зөвлөмж гаргахад судалгааны шинэлэг тал оршино.

Практик ач холбогдол:

Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн гэр бүл болон нийгмээс ирж байгаа хандлага нь хүүхдэд хэрхэн нөлөөлж байгааг судалсанаар нийгмийн зүгээс тэдэнд хандах эерэг хандлага болон зохистой харилцааг бий болгох, зөвөлгөө зөвлөмж гаргахад судалгааны практик ач холбогдол оршиж байна.

Онол арга зүйн үндэслэл:

Оюун ухааны болон сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол давамгайлсан сэтгэцийн дутуу хөгжил бүхий шинж тэмдэгтэй даамжирдаггүй явцтай янз бүрийн шалтгаантай бүлэг эмгэгийг оюуны хомсдол гэнэ. Оюуны хомсдолыг “олигофрени” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь олиго – хомсдол, френи – сэтгэц, оюун ухаан гэсэн утгатай грек үг юм.

Оюун ухааны хомсдолд хүргэдэг шалтгаануудыг дотор нь (халдвар, хордлого, гэмтэл, амин чухал бодисуудын дутагдал) болон дотоод (эцэг, эхийн бэлгийн эсүүдийн удамшил

дамждаг өвчнүүд, бодисын солилцооны, ферменүүдийн эмгэгүүд) гарал үүслийн хүчин зүйлс гэж ангилдаг.

Оюуны хомсдолтой хүүхдийн 30 орчим хувь нь удамшлын шалтгаантай бөгөөд оюуны хомсдолд хүргэдэг олон шалтгааны (архи, эцэг эхийн өвчин, тархины халдвар г.м) нэг нь дотоод шүүрлийн булчирхайн эмгэг юм.

1. Альфред Адлерийн бие хүний тухай бодгалын онол:

Бусдаас дутуу байгаагаа мэдрэх мэдрэмж хүүхдэд багаас нь төрдөг. Харин зарим нэг шалтгааны улмаас зарим хүмүүст дутуу дулимагийн мэдрэмж онцгой хурц үүсдэг. Үүний улмаас өөрийн дутуу дулимаг байдлаа хэтрүүлэн үзэх хам шинж бий болно.

Дутуу дулимгийн хам шинж хүүхдэд бий болоход дараах гурван хүчин зүйл нөлөөлнө гэж Адлер үзсэн байдаг.

- Эрхтэн дутуу байдал: Хүүхдийн аль нэг эрхтэн согогтой сул байвал хүүхэд сэтгэл зүйн хувьд бусдаас дутуугаа хурцаар мэдрч болно.
- Хүүхдийг хэт халамжлах: Хүүхдийг хэт эрхлүүлэн түүний өмнөөс бүхнийг хийсээр өөрийн төлөө хариуцлага хүлээх чадваргүй болгон өсгөнө.
- Хүүхдийг гадуурхах хол хөндий харьцах: Эцэх эхдээ шоовдорлогдон гадуурхагдсан хүүхэд бусдад хэрэгтэй, хүний хайр хүлээсэн, хүнд үнэлэгддэг хүн болно гэсэн итгэлгүйгээр амьдралд хөл тавьдаг.

Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд өөрсдийгөө энгийн хүүхдээс өөр мэтээр мэдрэх бөгөөд бусдаас оюун ухаанаар дутуу хэмээн бодох нь дутуугийн мэдрэмж үүсгэх гол сэдэл болдог бол үүний дээр нэмэгдэн гэр бүл болон нийгмээс тэднийг гадуурхах хол хөндий харьцах нь оюуны бэрхшээлтэй тэр дундаа өсвөр насны хүүхдэд өөрийгөө хэнд ч хэрэггүй мэт үзэх, бусдад хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй байгаа мэт санагдах зэрэг нь ганцаардах, өөртөө итгэх итгэлгүй болох нь дутуугийн мэдрэмжийг хурцатгах эрсдэлтэй. Оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдэд дутуу дулимгийн хам шинж хурцаар илэрэх нь цаашлаад сэтгэл зүйд нь сөргөөр нөлөөлөх бөгөөд өөрийгөө хүлээн зөвшөөрөхгүй байх, өөртөө итгэлгүй байх шалтгаан болж байна.

2. Сэтгэл судлалын шинжлэх ухаанд хэрэгцээг олон талаас нь судлан авч үзсэн байдаг

бөгөөд З.Фрейд, Г.Хорни, Х.Мюррей зэрэг олон эрдэмтэн өөр өөрийнхөөрөө тодорхойлсон байдаг. Эдгээрээс хамгийн сонгодог онолын нэг бол Америкийн сэтгэл зүйч А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онол, үзэл баримтлал юм. Тэрээр хэрэгцээг тодорхой шатлалд ангилан авч үзсэн байдаг бөгөөд хүний хэрэгцээ төрөлхийн зөн билгийн шинж чаартай, эдгээр нь шаталчилсан зохион байгуулалтад оршино гэж үзээд дараах ангилалыг гаргасан байдаг.

- Физиологийн хэрэгцээ – хоол хүнс, дулаан, нойр, эрүүл мэндийг хамгаалах зэрэг физиологийн үндсэн хэрэгцээг хангах тааламжтай амьдралын нөхцлийг бий болгох
- Аюулгүй байдлын хэрэгцээ – ирээдүйдээ итгэлтэй байх хэрэгцээ нь орчны зүгээс бие махбодь, сэтгэл зүйд учруулах аюул заналаас хамгаалах, физиологийн хэрэгцээ ирээдүйд хангагдах итгэлтэй байх
- Харьяалагдах, хайрлах хэрэгцээ – бүлэгт харъяалагдах, хайрлах, хайрлуулах, хүлээн зөвшөөрөгдөх
- Өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ – нэр хүндтэй байх, амжилтанд хүрэх, сайшаагдах
- Танин мэдэх хэрэгцээ – мэдэх, чадах, ойлгох, судлах
- Ёс зүйн хэрэгцээ – гоо зүй, ёс заншил, тэдгээрт зохицох
- Өөрийгөө илэрхийлэх буюу төгөлдөржүүлэх хэрэгцээ – бие хүний өөрийн хөгжил, чадвар, зорилгоо ухамсарлах гэсэн үндсэн суурь хэрэгцээ байдаг

Эдгээр хэрэгцээнүүдээс авч үзэхэд оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд харъяалагдах хэрэгцээ бүрэн дүүрэн хангагдахгүй байна, өөрөөр хэлбэл оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдүүдийн хайрлах, хайрлуулах хэрэгцээ шаардлага нь тэдний насны онцлогоос шалтгаалан нэн тэргүүнд бий болох ба өсвөр насанд ертөнцийг үзэх үзэл бодол төлөвших бөгөөд энэ үед бусдад хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээ шаардагдана. Гэвч энэхүү хэрэгцээнүүд оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах нийгмийн хандлагаас болж хангагдахгүй байгаагаас үүдэн ганцаардал, дутуугаа мэдрэх мэдрэмж зэрэг шинжүүд үүсч, хүүхдийн орчиндоо дасан зохицох зохицолдлогоо алдагддаг. Үүний улмаас хүүхэд бусдаас өөрийгөө тусгаарлах, өөрийгөө хүлээн зөвшөөргөж чадахгүй хэмээн үнэлэх, өөртөө

итгэлтэй бус болох зэрэг олон сөрөг талууд бий болно.

Судалгааны арга зүй:

1. Баримт бичиг судлах арга, тестийн арга, ярилцлагын аргуудыг хэрэглэсэн болно.
2. Өөртөө итгэх итгэлийг үнэлэх асуулга (Судлаач багшийн гарын авлага хуудас 86-87)
3. Хүүхдийн ганцаардах мэдрэмжийг үнэлэх асуулга (Стивен Р.Ашер)
4. Судалгааны үр дүнг “SPSS” программ дээр боловсруулсан болно.

Судалгааны үр дүн:

Судалгаанд нийт БЗД-ийн Мэргэжлийн сургалттай 55-р дунд сургуулийн 7-9-р ангийн оюуны хөнгөн хомсдолтой 30 хүүхдийг хамруулсан. График №1-ээс үзэхэд судалгаанд эрэгтэй 18, эмэртэй 12 хүүхэд оролцсон.

График №1



Хүснэгт №1-ээс харахад нийт судалгаанд хамрагсан 30 судлуулагчийг насаар ангилан авч үзвэл 14-16 насны хүүхдүүд хамрагдсаны дийлэнх нь буюу 60% нь 16 насныхан байсан.

Хүснэгт №1

Нас			
14	4	13.3	13.3
15	8	26.7	26.7
16	18	60.0	60.0
Total	30	100.0	100.0


Судалгаанд хамрагдсан нийт судлуулагчдын ганцаардлын түвшинг авч үзвэл дийлэнх буюу 66.7% нь ганцаардлын түвшин өндөр гарсан бол 33.3% нь дунд түвшний ганцаардалтай бөгөөд ганцаардлын түвшин бага хүн илрээгүй. График №2

График №2



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өөртөө итгэх итгэлийн түвшинг авч үзвэл 66.7% нь дундаж түвшин, 13.3% өндөр бол 20% бага түвшинд илэрсэн.

График №2



Хүснэгт №2-оос харахад нийт судалгаанд хамрагсдын өөртөө итгэх итгэл нь ганцаардах мэдрэмжтэй дундаж урвуу хамааралтай хэмээн гарсан.

Хүснэгт №2

	Өөртөө итгэх итгэл	Ганцаардал
Өөртөө итгэх итгэл	1	-.575**
Ганцаардал	-.575**	1

Ерөнхий дүгнэлт:

1. Судалгаанд нийт БЗД-ийн Мэргэжлийн сургалттай 55-р дунд сургуулийн 7-9-р ангийн оюуны хөнгөн бэрхшээлтэй эрэгтэй 18, эмэгтэй 12 хүүхэд оролцсон. Бид судалгааныхаа зорилгыг хангахын тулд судалгаа авч буй хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл болон ганцаардлын түвшинг илрүүлэн хоорондын холбоо хамаарлыг тогтоосон.
2. Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт судлуулагчийн ганцаардлын түвшинг авч үзвэл дийлэнх буюу 66.7% нь ганцаардлын түвшин өндөр гарсан бол 33.3% нь дунд түвшний ганцаардалтай бөгөөд ганцаардлын түвшин бага хүн илрээгүй

бөгөөд Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өөртөө итгэх итгэлийн түвшинг авч үзвэл 66.7% нь дундаж түвшин, 13.3% өндөр бол 20% бага түвшинд тогтоогдсон.

3. Мөн өөртөө итгэх итгэл нь ганцаардах мэдрэмжтэй $-.575$ буюу дундаж урвуу хамааралтай байгаа нь ганцаардлын түвшин нэмэгдэх тусам өөртөө итгэх итгэл буурдаг бол ганцаардах мэдрэмж буурах тусам өөртөө итгэх, өөрийгөө хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгддэг байна.

Санал, зөвлөмж:

Оюуны бэрхшээлтэй хүмүүсд хандах өрсдийнхөө итгэл үнэмшил, хандлагыг өөрчлөхийг уриалан дуудаж, сайжруул

Оюуны бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон дотроо оролцуулах, хамруулахыг дэмж

Оюуны бэрхшээлтэй хүмүүсийг доромжлох, хүч хэрэглэх явдлын эсрэг тэмц

Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамрагдан суралцах боломжоор хангах

Гэр бүлийн зүгээс тухайн хүүхдүүдийн санаа бодол сонирхол зэргийг ярилцах, ойлгох, дэмжих
 Оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн харилцах, ойлгох, сэтгэл зүйн талаас дэмжих талаар гэр бүл болон сурган хүмүүжүүлэгчдэд тогтмол сургалт зохион байгуулах

Өсвөр насны хүүхдүүдэд оюуны бэрхшээл гэж юу болох, оюуны бэрхшээлтэй хүнд хэрхэн тусалж болох талаар мэдээлэлийг тогтмол хүргэж байх.

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Ц. Батчимэг¹, Д. Тэгшжаргал¹, Д. Билгүүн², О. Эрдэнэтуяа², Ц. Наранцэцэг³

¹ХБХСЗХТөв, Сэргээн засахын эмч

²ХБХСЗХТөв, Хөдөлгөөн засалч

³АШУУИС- АУС, СЗАУТэнхим, багш

Хураангуй

Сүүлийн жилүүдэд тархины саа (ТС)-гийн тохиолдол ихсэж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсээр байна. Иймд тархины саатай хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх шаардлага тулгарч байна. Монголд тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүнг насны бүлгээр харьцуулан судалсан судалгаа хомс байна. Тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүнг насны бүлгээр харьцуулан судлах. Судалгааг ретроспектив аргаар явуулж, үр дүнг тооцсон. Судалгаанд хөдөлгөөн засал ба үйл ажиллагааны цахилгаан цочруул (FES) эмчилгээнд 21 хоногийн турш хамрагдсан 12-144 сартай (68.7± 30.2), нийт 138 хүүхдийг хамруулсан. Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр 3 бүлэг (1-3 нас, 4-7 нас, 8-12 нас) болгон хувааж, бүлэг тус бүрт их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааг GMFM-88 шалгуураар эмчилгээний өмнө ба дараа үнэлсэн үзүүлэлтүүдийг харьцуулж, үр дүнг тооцлоо. Статистик боловсруулалтыг STATA-12.0 программ ашигласан. Судалгаанд эрэгтэй 63%, эмэгтэй 37%, балчир насны Бүлэг I - 48, торних насны Бүлэг II - 52, бага насны Бүлэг III - 38 хүүхэд хамрагдсан. Эмчилгээний өмнөх ба дараах үзүүлэлтүүдийг харьцуулахад хүүхдийн их биеийн хөдөлгөөний чадвар 3 бүлэгт гурвууланд нь сайжирсан ($p \leq 0.001$) байна. Бүлгүүдийг хооронд нь харьцуулахад их биеийн хөдөлгөөний чадвар нь балчир насны хүүхдүүдэд илүү сайжирсан байна. Тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүн балчир насны (Бүлэг I) хүүхдүүдэд хамгийн өндөр байгаа нь хүүхдийг сэргээн засах эмчилгээнд хэдийчинээ эрт хамруулна төдийчинээ үйл ажиллагааны чадвар сайжирдаг байна. Цаашид ТС-тай хүүхдийн сэргээн засах эмчилгээний давтамж, үргэлжлэх хугацааг судлах шаардлагатай байна.

Түлхүүр үг:

Хүүхдийн сэргээн засал, хөгжлийн бэрхшээл, хөдөлгөөн засал, GMFM-88, цахилгаан цочруул

ҮНДЭСЛЭЛ

Тархины саа (ТС) гэсэн нэр томъёог анх Английн мэс засалч William John Little 1860 онд анагаах ухаанд хэрэглэсэн. ТС нь хүүхдийн мэдрэлийн тогтолцооны эмгэгийн дотор элбэг тохиолддог ба тархины хөгжлийн эрт үеийн гэмтлээс үүдсэн байршлын болон хөдөлгөөний өөрчлөлтийн бүлэг хам шинжээр илэрдэг эмгэг юм¹. Хүүхдийн тархинд үүссэн гэмтэл цаашид даамжрахгүй боловч хүүхэд өсч томрох тусам хөдөлгөөний хоцрогдол гүнзгийрэх, биеийн төрх өөрчлөгдөх, үений хөшингө үүсэх, гарын нарийн хөдөлгөөний эвсэл алдагдах зэрэг хоёрдогч бэрхшээлүүд үүсгэхээс гадна өдөр тутмын үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд оролцох нь хязгаарлагддаг. Тархины саагийн тархалт 1000 амьд төрөлтөд дэлхийн дундаж 2.7 тохиолдол, монголд 1.89 тохиолдол бөгөөд УБ хотод 1.6, хөдөө орон нутагт 2.2 тохиолддог². ТС-тай хүүхдийн тоо цаашид ихсэх хандлагатай байгаа төдийгүй тэдэнд үзүүлэх сэргээн засах эмчилгээг олон улсын жишигт хүрэхүйц түвшинд гүйцэтгэх шаардлага зайлшгүй тулгарч байна. ТС-тай хүүхдийн хөдөлгөөний чадварыг үнэлэх үнэлгээний олон аргууд байдаг бөгөөд “GMFM-88” шалгуурыг дэлхий дахинаа хамгийн өргөн ашиглаж байна. ТС-тай хүүхдэд хөдөлгөөн засал ба үйл ажиллагааны цахилгаан цочруул эмчилгээ нь булчингийн агшилтыг сайжруулж, хөдөлгөөний үйл ажиллагааг нэмэгдүүлдэг, хүүхдийн эмнэлзүйн практикт үр дүнтэй эмчилгээ юм.

Монгол улсад ТС-тай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүнг судалсан цөөн тооны судалгаа хийгдсэн боловч хөдөлгөөн засал ба цахилгаан цочруулын хавсарсан эмчилгээний үр дүнг хүүхдийн насны бүлгээр харьцуулан судалсан судалгаа, баримт одоогоор байхгүй байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүнг насны бүлгээр харьцуулан судлах

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

1. ТС-тай хүүхдийн их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны чадварыг үнэлж, насны бүлэг тус бүрт сэргээн засах эмчилгээний үр дүнг тооцох
2. ТС-тай хүүхдэд хийгдсэн сэргээн засах эмчилгээний үр дүнг насны бүлгээр ангилсан 3 бүлгийг хооронд нь харьцуулан судлах

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Судалгааг эмчилгээний үр дүнг эргэмж байдлаар судлах (retrospective study) загвараар, 2019 оны 06 сараас 2019 оны 10 сар хүртэлх хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийг түшиглэн явуулсан. Тус төвд тархины саа оноштой 305 хүүхэд сэргээн засах эмчилгээнд хамрагдсанаас 21 хоног буюу 1 курс эмчилгээнд бүрэн хамрагдсан 12- 144 сартай (68.7 ± 30.2) нийт 138 хүүхдийг судалгаанд түүвэрлэн авсан. Судалгаанд оролцогчдод өдөр бүр 45 минутаар хөдөлгөөн засал, 20 минутаар үйл ажиллагааны цахилгаан цочруул эмчилгээ 21 хоног хийгдсэн байна. Эмчилгээний өмнө ба дараа оролцогчдын их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааг “GMFM-88” шалгуураар үнэлсэн байсан. Судалгаанд түүвэр болгон авсан хүүхдүүдийг Б. Оргил (2007 он) нарын “Хүний амьдралын үечлэл”-ийн дагуу насны бүлгээр “Бүлэг-I буюу балчир нас” (1-3 нас буюу 12-36 сар), “Бүлэг-II буюу торних нас” (4-7 нас буюу 37-84 сар), “Бүлэг-III буюу бага нас” (8-12 нас буюу 85-144 сар) гэсэн 3 бүлэг болгож, сэргээн засах эмчилгээний үр дүнг бүлэг тус бүрт болон бүлгүүдийг хооронд нь харьцуулан судалсан.

Судалгааны ажлын үр дүнг биостатистикийн үндсэн аргуудаар арифметик дундаж (M), стандарт хазайлт (s), стандарт алдаа (m), итгэх интервал (CI-95%) болон бүлэг тус бүрийн эмчилгээний өмнө ба дараах үр дүнг paired t- test, бүлэг хоорондын эмчилгээний харьцуулсан үр дүнг One Way ANOVA –р тооцож, боловсруулалтыг STATA 12.0 программыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 1. Оролцогчдын хүн амзүйн үзүүлэлт


Үзүүлэлтүүд				
	Нийт	Бүлэг-I	Бүлэг-II	Бүлэг-III
Хүйс (эр/эм)	87/51	28/20	32/20	27/11
Нас-сараар (mean±SD)	12 - 144 сар (68.7 ± 30.2)	26.6 ± 18.1	60.96 ± 27.8	118.68 ± 65.4
GMFM оноо (mean±SD)	129.93 ± 72.02	119.87 ± 67.74	121.09 ± 77.98	148.84 ± 70.34

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.05 статистик ач холбогдолтой

ҮР ДҮН


Судалгаанд оролцогчдын их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны чадварыг эмчилгээний өмнөх ба дараах GMFM-88 шалгуураар үнэлэхэд насны ангилалын 3 бүлэгт аль алинд нь сайжирсан ($p \leq 0.001$) болох нь харагдаж байна (Зураг 1).

Зураг 1. Эмчилгээний өмнөх ба дараах GMFM-88 үзүүлэлт



Харин 3 бүлгийн эмчилгээний үр дүнг хооронд нь харьцуулан судлахад их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны чадвар торних насны (Бүлэг-II) хүүхдүүдэд илүү сайжирсан ($p \leq 0.001$) байна (Зураг 2).

Зураг 2. Насны бүлгээр харьцуулсан GMFM-88 үнэлгээ



ХЭЛЦЭМЖ

Бид тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүнг насны бүлгээр харьцуулан судалсан бөгөөд бидний судалгаагаар хүүхдийн хөдөлгөөний үйл ажиллагааны чадвар нь бага насны хүүхдэд илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлт гарсан. Энэхүү дүгнэлт нь Н.Өлзиймаа, О.Чимэдсүрэн нарын “Тархины саатай хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх зарим асуудалд” нэг сэдэвт бүтээлдээ булчингийн чангаралтай хэлбэрийн ТС-тай 1-12 насны 30 хүүхдийг 6 сарын турш хөдөлгөөн засалд хамруулж, хөдөлгөөний хөгжлийн чадварыг GMFM-66 шалгуураар эмчилгээний өмнө болон дараа үнэлсэн ба хөдөлгөөн засал нь балчир нас болон бага насны хүүхдүүдэд илүү үр дүнтэй ($p < 0.01$) байна гэсэн дүгнэлттэй дүйж байна. ялгаатай тал нь эдгээр судлаачид тархины саатай хүүхдэд зөвхөн хөдөлгөөн засал эмчилгээ хийж үр дүнг тооцсон бол бид судалгаанд хөдөлгөөн заслаас гадна цахилгаан цочруул эмчилгээг хавсран хийж, үр дүнг тооцсон.

Ц.Наранцэцэг, А.Балжинням нарын “Тархины саатай хүүхдийн хэвлий, нурууны булчинг цахилгаан цочруулаар эмчилсэн үр дүн” АУ-ны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлд хөдөлгөөн засал ба цахилгаан цочруул эмчилгээг хавсран хийх нь хүүхдийн хөдөлгөөний чадварт илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлттэй дүйцэж байгаа хэдий ч бид эмчилгээний үр дүнгээ насны бүлгээр нь харьцуулан судалснаараа давуу талтай юм.

Шанхайн их сургуульд хийсэн судалгаанд (Wei S, Su Juan W, Hong Y et al) ТС-тай 3-36 сартай 171 хүүхдийг 6 сарын турш хөдөлгөөн засал эмчилгээнд хамруулан, хөдөлгөөний чадварыг GMFM-66 шалгуураар дасгалын өмнө болон дараа шалгахад эмчилгээний дараа хөдөлгөөний чадвар нь сайжирсан ($p < 0.001$) үр дүн гарсан нь бидний судалгааны балчир насны (12-36 сар) хүүхдүүдэд илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлттэй ижил байна.

Бидэнд цаашид тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үргэлжлэх хугацаа, давтамж зэргийг өөрийн орны нөхцөлд судлах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

ДҮГНЭЛТ

Тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээний үр дүн балчир насны (Бүлэг I) хүүхдүүдэд хамгийн өндөр байгаа нь хүүхдийг

сэргээн засах эмчилгээнд хэдийчинээ эрт хамруулна төдийчинээ үйл ажиллагааны чадвар сайжирдаг байна. Цаашид ТС-тай хүүхдийн сэргээн засах эмчилгээний давтамж, үргэлжлэх хугацааг судлах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Отгонбаяр П. Хүүхдийн тархины саа өвчний тархалт, түүнийг бага насны хүүхдэд илрүүлэх. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Улаанбаатар, 1998, х.45-46.
2. Цагаанхүү Г. Мэдрэл судлал. 2 дахь хэвлэл. Улаанбаатар: Адмон; 2011. х.547553
3. Pakula AT, Van Naarden Braun K, Yeargin-Allsopp M. Cerebral palsy: classification and epidemiology. Phys Med Rehabil Clin N Am 2009; 20:425-452.
4. Т.Батдулам, Д.Өлзийбаяр. “Тархины саатай хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнд эцэг эхийн сургалтын нөлөө” АУ-ны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 2005.
5. Н.Өлзиймаа, О.Чимэдсүрэн. “Тархины саатай хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх зарим асуудалд” АУ-ны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 2009.
6. Ц.Наранцэцэг, А.Балжинням. “Тархины саатай хүүхдийн хэвлий, нурууны булчинг цахилгаан цочруулаар эмчилсэн үр дүн” АУ-ны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 2014.
7. Wei S, Su-Juan W, Yuan-Gui L, Hong Y, Hiu-Juan X, Xiao-Mei S. Reliability and validity of the GMFM-66 in 0- to 3 year-old children with cerebral palsy. Am J Phys Med Rehabil 2006. Feb; 85(2):141-147.

НАСНЫ ДОРОЙТОЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛД ХҮРГЭХ НЬ

Д. Болор¹, Б.Золзаяа¹,
Т.Дулмаа¹, Б.Эрдэнэчимэг¹
¹Геронтологийн Үндэсний Төв

Түлхүүр үг:

Насны доройтол, чадвар алдагдал, сэтгэл гутрал, танин мэдэхүйн чадвар, дотоод чадавхи

Судалгааны ажлын үндэслэл:

дэлхий нийтэд насжилтын үйл явцын улмаас ахмад настны тоо хурдацтай өсөж байна. Настны тоо өсөж буй дэлхийн чиг хандлага саяхан залуучуудын орон гэж нэрлэгдэж байсан манай улсын хувьд ч тулгамдсан асуудал болох хандлагатай байна. Монгол улсад 2018 оны байдлаар 215,731 настан амьдарч байгаа бөгөөд энэ тоо 2030 гэхэд хэтийн тооцооллоор 538,807 болж нэмэгдэх хандлагатай байгаа ба манай улсын нийт хүн амын 14,9 хувийг эзлэх юм. /*Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо*

Амьдралын хугацаа уртсаж, ахмад настны тоо нэмэгдэж байгаа нь дэлхий дахинд 60-аас дээш насны бүлгийн хүмүүст хөгжлийн бэрхшээлийн тархалт нэмэгдэхэд хүргэсэн. /*Agnieszka Ćwirlej-Sozańska, Agnieszka Wiśniowska-Szurlej, Anna Wilmowska-Pietruszyńska & Bernard Sozański /BMC Geriatrics volume 19,2019 /*

Системчилсэн тойм мета-шинжилгээний дүгнэлтээр насны доройтолтой настан хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг харуулсан бөгөөд тоон үзүүлэлтүүд нь насны доройтол буюу бие даасан байдалын чадвар алдагдал болох ADL, IADL нь хөгжлийн бэрхшээлд оруулдаг болохыг батлан үзүүлсэн байна. /*Kojima,G /Japan Green Medical Centre , London , UK. 2017 Sep;39(19):1897-1908/*

Настангууд нь бусад бүлгийн хүмүүсийг бодвол олон төрлийн архаг өвчинтэй, эрхтэн системийн ажиллагааны алдагдалтай тул доройтолд орох нь элбэг байдаг бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлд хүргэдэг байна.

Судалгааны зорилго:

дЭМБ-ын тодорхойлолтоор Насны доройтол нь насжилтын явцтай хамааралтайгаар бие махбодийн чадамж алдагдах эрүүл мэндийн байдал юм. Энэхүү судалгааны зорилго

нь биемахбодийн чадамж алдагдан насны доройтолд орсноор 60-аас дээш насны бүлгийн хүмүүсийн дунд хөгжлийн бэрхшээлийн тархалт нэмэгдэхэд хүргэдэг болохыг судлах зорилготой.

Судалгааны зорилт :

гҮТ-өөр үйлчлүүлж байгаа настангуудын насжилтын явцтай хамааралтайгаар бие махбодын чадвар алдагдалыг /насны доройтол/ үнэлэх

Судалгааны ач холбогдол:

монгол улсад нийт хүн амд болон эмнэлэгт суурилсан насны доройтол, чадвар алдагдалыг судласан тархвар зүйн болон эмнэлзүйн судалгаа хийгдээгүй бөгөөд энэхүү судалгаагаар настны бие махбодид зонхилон тохиолдох насны доройтолын үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг судлан мэдээлэл нотолгоог бий болгох, бодлогын түвшинд асуудал болгон дэвшүүлж байгаагаараа тухайн судалгаа нь шинэлэг, практик ач холбогдолтой юм.

Судалгааны арга зүй:


судалгаанд Геронтологийн үндэсний төвөөр 2017-2019 үйлчлүүлсэн 60-аас дээш насны 496 настан үйлчлүүлэгчид Бие даах чадвар /ADL/ -ын үнэлгээ 12 асуумжтай, багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар (IADL)-н 16 асуумжтай, настны сэтгэцийг үнэлэх 11 асуумжтай, Унах эрсдэлийг үнэлэх Морсын шалгуурын нээлттэй асуумжыг ашиглан үнэлгээ хийсэн хоёрдогч дата мэдээллийг ашигласан. Судалгаанд хоёрдогч мэдээллийг ашиглах шалгуурт үнэлгээ хийгдсэн он, хамрагдсан хүн амзүйн мэдээлэл, асуумж зэргийг бүрэн байгаа эсэхийг тооцож үзсэн.Судалгааны үр дүнг “SPSS-20” программ ашиглан боловсруулж үр дүнд дескриптив статистик шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүн:


Судалгаанд нийт Геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлсэн Улаанбаатар хотын 4 дүүрэг, Дорноговь, Хэнтий аймгийн 3 сумын 60 дээш насны 496 хүн хамрагдсан. Судалгаанд

хамрагдсан хүмүүсийн дундаж нас 63.8 ±6.2 байсан бол 74,1% эмэгтэй, 25.9% эрэгтэй үйлчлүүлэгч эзэлж байсан. Судалгаанд хамрагдсан хүмүүсийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд дээд боловсролтой 42%, бүрэн дунд боловсролтой 21,7%, дунд мэргэжилтэй 23,3%, боловсрол эзэмшээгүй үйлчлүүлэгч 13% эзэлж байна.

Зураг 1 Судалгаанд хамрагдсан хүмүүсийн боловсролын байдал



Хүснэгт 1. Бие даах чадварын үнэлгээ (adl)



Өдөр тутмын бие даах чадварыг Катзын үнэлгээгээр үнэлэхэд нийт 486 настан хамрагдсаны 73% (n=355) нь хэвийн, 23% (n=110) нь алдагдсан, 4% (n=21) нь бусдаас бүрэн хараат байв.


Хүснэгт 2. Багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын үнэлгээ (iadl)



Багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын Лавтоны үнэлгээнд нийт 496 настан хамрагдсаны 63% (n=310) нь хэвийн, 19% (n=95) нь алдагдсан, 18% (n=91) нь бусдаас бүрэн хараат байв.

Хүснэгт 3. Танин мэдэхүй чадвар

Танин мэдэхүйн чадвар



Настнуудын танин мэдэхүйн чадварыг үнэлэхэд нийт 496 ахмадын 48% (n=240) нь хэвийн, 37% (n=185) нь бага зэрэг алдагдсан, 15% (n=71) нь хүнд зэргээр алдагдсан байв.

Судалгаанд оролцогчдоос явганаас унах эрсдэлийг Морсын шалгуураар үнэлэхэд нийт 496 настан хамрагдсаны 42% (n=210) нь унах эрсдэлгүй, 17% (n=82) нь бага зэргийн эрсдэлтэй, 41% (n=204) нь өндөр эрсдэлтэй байв.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлтийн нэгтгэсэн үзүүлэлт

№	Шалгуурын нэр	Чадвар алдагдал хэвийн	Бага зэрэг алдагдсан	Бүрэн алдагдсан
	Бие даах чадварын үнэлгээ (ADL)	n=355	n=110	n=21
		73%	23%	4%
2	Багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын үнэлгээ (IADL)	n=310	n=95	n=91
		63%	19%	18%
3	Танин мэдэхүйн чадвар	n=290	n=185	n=71
		48%	37%	15%
4	Явганаас унах эрсдэлийн үнэлгээ	Унах эрсдэлгүй n=210	Бага зэрэг эрсдэлтэй n=82	Өндөр эрсдэл n=204
		42%	37%	41%

Үр дүн:

Судалгаанд хамрагдсан ГҮТ-өөр үйлчлүүлэгчдийн 23% нь хувь нь өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны алдагдалтай (ADL) бол 4% нь бүрэн алдагдалтай байна. Мөн 19% хувь нь өдөр тутмын багаж хэрэгсэлтэй харьцах үйл ажиллагааны алдагдалтай (IADL) бол 18% нь хувь нь бүрэн алдагдсан байна. Судалгаанд оролцогчдын 37% нь танин мэдэхүйн чадвар буурсан, 15% нь сэтгэл гутралтай байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар нас ахих тутам насжих үйл явцын үр дүнд үүсэх Насны доройтолыг үзүүлэх хэмжигдэхүүн болох настны өдөр тутмын бие даах чадвар (ADL), багаж хэрэгсэлтэй харьцах чадвар (IADL), танин мэдэхүйн чадварыг эмнэлэгт суурилсан үнэлгээний асуумжаар авсан хоёрдогч дата-г ашиглан дескриптив статистик шинжилгээ хийсэн. ДОТООД ЧАДАВХИ БУУРАЛТ буюу сонсох, харах, санах, хөдлөх, өдөр тутмын болон нийгмийн амьдралд оролцох зарим хүндрэл гарснаар Насны доройтол илрэн хөгжлийн бэрхшээлд хүргэдэг байна. Иймээс, цаашид үндэсний хэмжээнд насны доройтол, чадвар алдагдалын тархвар зүйн болон эмнэлзүйн судалгаа хийх шаардлагатай байна.

Хэлцэмж

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2019 онд “Насны тэгш байдлыг хангацгаая” уриалга гарган гишүүн орнуудадаа уриалсан (UNDP 2019). Манай улс Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратегитай боловч нэгдсэн бодлого байхгүй, мөн салбар дундын бодлого үйл ажиллагааны уялдаа холбоо сул, настны нийгэм, эдийн засгийн талаарх нарийвчилсан судалгаа, статистик мэдээ хангалтгүй байдаг нь урт хугацааны бодлого боловсруулах, бодит ажил төлөвлөхөд хүндрэл учруулж байгааг зарим судалгаагаар хөндсөн байдаг. / Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал, Судалгааны тайлан 2015/

Настнууд өвчлөлд өртсний улмаас хэвтэрт орох, хөдөлгөөн хязгаарлагдах эсвэл дэмийрэлд орох хүртэл насны доройтолд орох ба эдгээр хүмүүс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бага хүртдэг төдийгүй эмч нар ихэвчлэн оношлохгүй байх нь элбэг. Дэлхий дахинд насны бүтцэд гарч буй өөрчлөлтийг дагаад нийгэм хамгаалал,

эрүүл мэндийн зардал хурдацтай өсч байна. Улс орнууд ямар бодлого баримтлахаа өсөн нэмэгдэж буй өөрчлөлт, хэрэгцээ хандлаганд тулгуурлан төлөвлөлтийг ойрын ирээдүйн ба олон жилээр боловсруулдаг байна. Манай улс эрүүл мэндэд хүрэлцэхүйц сан хөмрөгийг үүнд онцгойлон асаргааны даатгалын санг бий болгож чадвал өсөн нэмэгдэх хэрэгцээнд зөв шийдэл болох байх (Насжилт, настны эмгэг судлал сэтгүүл 2019, №3)

Үүнээс гадна үндэсний хэмжээний мэдээллийн сантай болж, нотолгоо мэдээллийг бий болгох, судлах, олон нийтэд тулгуурласан ЦОГЦ ТУСЛАМЖ-ийг боловсруулах, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлж, настай хүмүүсийн бие махбодийн үйл ажиллагаа, бие даасан байдал, амьдралын чанарыг хадгалахад чиглэсэн хөндлөнгийн оролцоог бий болгох нь нэн тэргүүний зорилт юм.

Номзүй:

1. Agnieszka Ćwirlej-Sozańska, Agnieszka Wiśniowska-Szurlej, Anna Wilmowska-Pietruszyńska & Bernard Sozański /BMC Geriatrics volume 19, Article number: 297 (2019)/ Determinants of ADL and IADL disability in older adults in southeastern Poland
2. Dulmaa T, Erdenechimeg B, Frailty, National Gerontology center of Mongolia, (Ulaanbaatar 2017)
3. Frailty as a predictor of disabilities among community-dwelling older people: a systematic review and meta-analysis. Kojima,G /Japan Green Medical Centre, London, UK. 2017 Sep;39(19):1897-1908
4. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО, МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр 2018
5. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_003V1&SEX_select_all=1&SEXSingleSelect=&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_1_14_15_16&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2018&viewtype=table
6. НАСЖИЛТ, НАСТНЫ ЭМГЭГ СУДЛАЛ СЭТГҮҮЛ 2019, №3
7. UNITED NATIONS 2019 <https://www.un.org/development/desa/dspd/2019/09/2019-un-international-day-of-older-persons-on-the-journey-to-age-equality/>

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН УХААЛАГ ТАЯГ

Б.Билгүүн¹, Х.Гомбо¹, Б.Дорж¹, Т.Амартүвшин¹
Монгол улс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль,
Мэдээлэл, холбооны технологийн сургууль

Хураангуй

Техник технологи, электроникийн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр хүний хэрэгцээ шаардлага ч нэмэгдэн, хэрэглэж буй бүхий л зүйлс нь улам боловсронгуй, авсаархан, ухаалаг болж байна. Нийгмийн нэгээхэн хэсэг болсон харааны бэрхшээлтэй иргэд ч гэсэн өөрсдийн хэрэглэж буй зүйлсээ ухаалаг болгож илүү их боломжийг хүртэх эрхтэй. Энэ утгаар дэлхийн олон улсад ухаалаг цагаан таягийг хэрэглэж эхэллээ. Иймд электроникийн чиглэлээр суралцаж буй оюутнууд бид харааны бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэдэг цагаан таягийг Монгол улсын нөхцөл байдалд зориулсан, ажиллагааны шинэлэг загвартай, ухаалаг болгох зорилгоор өөрсдийн техникийн шийдэл гаргаж, програмчилахыг зорьсон. Энэхүү өгүүлэлд “Ухаалаг цагаан таяг”-ийн техник болон програм хангамжийн шийдэл, загвар, туршилтын үр дүнгээ танилцуулах болно. Таягаа ухаалаг болгохын тулд мэдрэгч элементээрээ ультра-соник зайн мэдрүүр болон GPS модулийг сонгосон бөгөөд тэдгээрийг ашиглан хэрэглэгчийг урдаа таарсан, цээжин биенээс дээших саадыг мөргөхөөс сэргийлэх, хэрэглэгчийн явж буй байршлыг тодорхойлох асуудлыг шийдсэн. Мөн ухаалаг утсанд зориулсан хэрэглэгчийн програмыг бүтээснээр хэрэглэгчийн байрлалыг өөрт нь мэдээлэх, хэрэв аюул тохиолдвол ойр дотны хүндээ тусламж хүссэн мессэж илгээх боломжоор хангаж өгсөн.

Түлхүүр үг:

Ультра-соник, GPS модуль, цагаан таяг, Bluetooth

Удиртгал

Харааны бэрхшээлтэй иргэд ганцаараа гадуур явах үедээ зориулалтын цагаан таяг эсвэл хөтөч нохой ашигладаг. Манай улсын хувьд хөтөч нохойн үйлчилгээ байдаггүй бөгөөд жирийн цагаан таягийг ашигласнаар урдаа байгаа саадыг заавал цохиж мэдрэх шаардлагатай байдаг. Мөн

дээрээс унжсан эсвэл цээжин биений зэргэлдээ байгаа саадыг мөргөж, бэртэж гэмтэх өндөр эрсдэлтэй тулгардаг. Энэ болон олон асуудлыг түгээмэл ашигладаг мэдрүүрүүдийг тус таяг дээр байрлуулж өгснөөр шийдэж чадна. Бид төхөөрөмжөө ердийн цагаан таягт суурилуулах боломжтой байхаар загварчилсан бөгөөд хэрэглэгч нь таягт байрлуулсан GPS модуль, гар утсанд бичиж өгсөн хэрэглэгчийн програм ашиглан өөрийн явж буй байршлаа мэдэх, өөрийн одоогийн байршлыг google.map дээр харуулах мессэжийг дотны хүндээ илгээх боломжтой юм. Энэ өгүүллийн I хэсэгт таягийн бүтэц, II хэсэгт ультра-соник зайн мэдрүүрийн ажиллагааны зарчим, III хэсэгт хэрэглэгчийн байршлыг хэлэх систем, IV хэрэглэгчийн програмын ажиллагаа, V хэсэгт бодит туршилтын үр дүнгүүдийг харууллаа.


Судалгааны ажлын зорилго

Харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан, өмнөх саадыг мэдэрч анхааруулах үүрэгтэй, явж буй байршлыг мэдээлэх таягийн техник, програм хангамжийн шийдэл гарган өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэхэд оршино.

Судалгааны ажлын зорилтууд

- ❖ Харааны бэрхшээлтэй иргэдтэй уулзаж судалгаа авч, ерөнхий ажиллагааны шийдэл гаргасан.
- ❖ Техник хангамжийн шийдэл тодорхойлсон.
- ❖ Туршилт, хөгжүүлэлт хийн ажиллагаанд оруулсан.

1. Бүтэц




Зураг 1. Бүтцийн схем

Зураг 1-т ухаалаг таягны ерөнхий бүтцийн схемийг харуулав. Хэрэглэгчийн байршлыг тогтоохын тулд Neobm төрлийн GPS модуль, өмнө нь байгаа ямар нэг саадыг мэдрэхийн тулд ультра-соник зайн мэдрүүр ашигласан. Харин саад мэдрэгдсэн тохиолдолд төхөөрөмж дээр байрлах дуут дохио дуугарах болно. Төхөөрөмжөөс хэрэглэгчийн утас руу холбогдохын тулд HC-05 загварын Bluetooth модульг хэрэглэсэн. Уг модуль нь USART протокол ашиглан 10 метр зайд өгөгдөл дамжуулах боломжтой. Хэрэглэгчийн утсан дээр App Inventor програмыг ашиглан хэрэглэгчийн програм бичсэн.

2. Ультра - соник зайн мэдрүүрийн ажиллагааны зарчим

Ультра-соник мэдрүүр нь дуу авианы болон радарын системд ажилладаг. Ультра-соник мэдрүүр нь өөрөөсөө өндөр давтамжийн дуун дохио гаргадаг. Энэхүү эхо дохио объектыг цохиж буцаж ойн хүлээн авагч хөл дээр ирдэг. Бусад ижил төрлийн мэдрүүртэй харьцуулахад гэрлийн эрчимээс хамааралгүй ажилладаг учир гадаа орчинд ажиллах боломжтой.



Зураг 2. Ультра-соник мэдрүүрийн ажиллагааны зарчим

Радио дохио цацагдаж эхлэх мөчөөс эхлэн түүнийг хүлээн авагч хөл дээр ирэх хүртэлх хугацааг хэмжин мэдрүүрээс объект хүртэлх зайг хэмжинэ. Энэ бол ультра-соник мэдрүүрийн үндсэн ажиллагааны зарчим юм.



Зураг 3. Ультра-соник мэдрүүрийн зураг

Бид таягт HC-SR04 загварын ультра-соник мэдрүүр ашигласан. Мэдрүүрийн триггер хөлөнд импульс өгснөөр мэдрүүр 40kHz давтамжтай ультра дохио цацдаг. 8 удаа 40kHz давтамжтай ультра дохио цацсаны дараагаар мэдрүүрийн эхо хөл өндөр төлөвт орно. Мэдрүүрийн цацсан эхо дохио буцаж иртэл эхо хөл төлөвөө хадгална. Ингэснээр эхо хөлний өндөр төлөвийн импульсийн өргөн нь дохионы объектэд хүрээд буцаж ирсэн хугацаа болно. Бид тэрхүү хугацаа болон дууны хурдыг ашиглан мэдрүүрээс объект хүртэлх зайг олох болно.

HC-SR04 мэдрүүр нь 2см-400см хүртэлх зайг хэмжихэд тохиромжтой.

Мэдрүүрийн өгөгдлийг ашиглан зайг олох нь

$$S = v \times T \quad (1)$$


Энд, S – мэдрүүрээс объект хүртэлх зай
 v – дууны хурд 343 м/с
 T – хугацаа

$$T = \frac{2^n \times N}{M} \quad (2)$$

Энд:

- n – битийн хэмжээ
- N – дүүрэлтийн утга
- M – контроллерын кварцын хэмжээ

Мэдрүүрээс объект хүртэлх зай 80см болон түүнээс бага болоход таяг дээр байрлах хонх дуугарч, объект ойртох тусам хонх илүү өндөр давтамжтайгаар дуугарах болно.



Зураг 4. Таягны саад мэдрэх нөхцөлийг харуулсан бүдүүвч зураг

Таягны өмнөх загвар дээр ультра-соник мэдрүүр таягны дунд хэсэгт байрлаж байсан боловч хараагүй иргэд дээрээс дүүжлэгдсэн болон өндөрт байгаа саадыг мэдрэх боломжгүй байдаг гэсэн учир мэдрүүрийн байршлыг дээшлүүлэн өөрчилсөн.


3. Хэрэглэгчийн байршил хэлэх систем

GPS систем нь дэлхийн гадаргуугаас 20,000км өндөрт, экватораас 55°-ийн зайтайгаар байрласан 31 идэвхтэй хиймэл дагуултай холбогдож ажилладаг. GPS нь маш олон цогц технологиудыг хэрэглэдэг боловч ойлголт нь энгийн юм. Бид өөрсдийн таяганд Neobit загварын GPS модулийг ашигласан. Уг модуль нь өөртөө 25x25x4 мм хэмжээтэй керамик антиннтай байдаг.



Зураг 5. Neobit GPS модулийн зураг

GPS хүлээн авагч нь хиймэл дагуул тус бүрээс дохио хүлээн авдаг. 4 хиймэл дагуулаас ирсэн дохионы явсан хугацаа болон тэдний тухайн үеийн тэнгэр дэх байрлалын тусламжтайгаар GPS модуль өөрийнхөө одоогийн хаягийг өргөрөг болон уртраг гэсэн байрлалаар тодорхойлж чадна. Ингэснээр ямар нэг цагийн алдагдалгүй, интернэт орчин шаардахгүй мөн маш өндөр нарийвчлалтайгаар одоогийн байршилаа тодорхойлох болно.



Зураг 6. GPS модулийн хиймэл дагуулуудтай холбогдсон байдал

Энэхүү систем нь автобусны байршил хэлэх системтэй ижил байдлаар ажиллах болно. Бид эхний удаа төв зам дагуух автобусны буудлын уртрага болон өргөрөгийн өгөгдлүүдийг аван сан үүсгэсэн. Жишээ нь : БЗД-н хойд буудал 47.9165131, 106.9644572 гэсэн байрлалтай. Таяг дэр байрлуулсан GPS модулын тусламжтайгаар хэрэглэгчийн одоогийн байршилын уртрага, өргөрөгийн утгыг авч бидний үүсгэсэн сангийн аль нэг утгатай ойр байгаа эсэхийг шалгана. Хэрэглэгч болон аль нэг байршилын хоорондоо зай 5 метр болсон тохиолдолд тухайн байршилын нэрийг хэрэглэгчид хэлэх болно. Хэдий харааны бэрхшээлтэй иргэд явж буй байршилын талаар өөрсдийн гэсэн баримжаа байдаг боловч энэхүү системийн тусламжтайгаар баталгаатай мэдээлэл авч илүү итгэлтэй явах боломжтой юм. Мөн дараагийн шатанд бид хэрэглэгчийн тэмдэглүүлсэн автобусны явж буй байршилыг мэдээлэх систем хийхээр судалж байгаа бөгөөд одоогийн энэ систем нь түүний суурь болж өгөх болно.

4. Хэрэглэгчийн програмын ажиллагаа

Дуу тоглуулах болон мессэж илгээх хэсгийг нэмэлт модул ашиглан хийхэд овор хэмжээ ихтэй мөн алдаа их гарч байсан учир бид хэрэглэгчийн гар утсан дээр аппликашин бичих шийдэлд хүрсэн. Энэхүү аппликашин нь хэрэглэгчийн одоогийн байршилыг харуулсан мессеж илгээх болон аль нэг байршилын нэрийг тоглуулах гэсэн 2 үндсэн ажиллагаатай байна.

4.1 Байршилын нэрийг тоглуулах


Хэрэглэгчийн явж буй байршилын утгыг хадгалсан утгуудтай 10 секунд тутам харицуулан аль нэг утгатай 5 метр зайд ойртох үед тухайн байршилд харгалзах кодыг утас явуулах болно. Жишээ нь : БЗД-т ирсэн тохиолдолд 1 гэсэн утгыг утас явуулна. HC-05 Bluetooth модулыг ашиглан төхөөрөмжөөс утас руу өгөгдөл дамжуулж байгаа. Уг модул нь 10 метр радиус дотор USART протокол ашиглан 2 төхөөрөмжийн хооронд өгөгдөл дамжуулдаг. Bluetooth-ээр авсан өгөгдлийг аппликашин шалган түүнд харгалзах дууг тоглуулна.

4.2 Мессэж илгээх

Харааны бэрхшээлтэй иргэд төөрсөн тохиолдолд цагаан таягаа урдаа барин бусдаас тусламж хүсэн зогсдог. Гэвч ихэнх иргэд тэрхүү


дохиог ойлголтгүй, тоохгүй өнгөрдөг. Харин энэхүү мессэж илгээх системийн ачаар хараагүй иргэд ганц товчлуур даран өөрийн одоогийн байршилыг заасан мессэжийг дотны хүн рүүгээ явуулах боломжтой. Мессэж хүлээн авсан иргэн https://www.latlong.net/c/?lat=***.***&long=***.*** гэх линк өргөтгөлтэй мессэж хүлээн авна. Мессэжин дээр дарж ороход хараагүй иргэний одоогийн байршил Google Map дээр харагдах болно. Ингэснээр хараагүй иргэн заавал танихгүй хүнээс тусламж гуйж зогсох шаардлагагүй мөн шөнө орой хүн газар байсан ч гэсэн төөрөх эрсдэлгүй болж байна.

5. Бодит туршилтын үр дүн




Зураг 7. Төхөөрөмжийн 3D харагдалт

Зураг 8-т төхөөрөмж дээр байрлах модулуудыг симуляцын орчинд угсарсан байдлыг харуулав. Төхөөрөмжийн схемийг Altium Designer програм дээр зурсан.




Зураг 8. Төхөөрөмжийн туршилтын загвар

Зураг 9-т төхөөрөмжийн эцсийн туршилтын загварыг харуулав. Төхөөрөмжийн хэмжээ 12x6x4 см. Кейсний доод хэсэгт таягтай бэхлэгдэж чангалдаг хэсэг байгаа.



Зураг 9. Аппликашин ашиглан явуулсан хэрэглэгчийн одоогийн байрлалыг илэрхийлэх мессэж

Таяг хэрэглэгч таягны дээд хэсэгт байрлах товчлуурыг дарахад түүний дотны хүний утас руу Зураг9-т харуулсантай адил хэрэглэгчийн байршилыг харуулах линк бүхий мессэж очих болно.



Зураг 10. Хэрэглэгчийн явуулсан мессэжийг нээхэд түүний байршилыг газрын зураг дээр харуулах байдал

Мессэж хүлээн авсан хүн линк дээр дарж ороход таяг хэрэглэгчийн мессэж явуулсан байршил 3-10 метрийн алдаатайгаар харагдах болно.

Дүгнэлт

Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан ухаалаг таяг нь хэрэглэгч урдаа байгаа дээрээс унжсан эсвэл цээжин биений зэргэлдээ байгаа саадыг мөргөж, бэртэж гэмтэхээс сэргийлэх, өөрийн явж буй байршилаа мэдэх мөн төөрсөн тохиолдолд хэрэглэгчийн одоогийн хаягийг дотнын хүн рүү нь мэдээлэх зориулалттай хийгдсэн. Туршилтын загварыг амжилттай хийн

ажиллуулсан. Бодит орчинд мэдрүүрүүд хэвийн ажиллагаатай ажиллаж байсан бөгөөд таягийн их бие хийх материалыг солих шаардлагатай байсан. Харааны бэрхшээлтэй зарим иргэдтэй уулзан өөрсдийн хийсэн таягийг хэрэглүүлж үзсэн бөгөөд хүмүүст маш их таалагдаж, сайшаалтайгаар хүлээж авсан. Яг одоо манай баг таягны нэмэлт хөгжүүлэлт дээр ажиллаж байна.

Ирээдүйд зөвхөн харааны бэрхшээлтэй иргэдийн таягийг ухаалаг болгон хөгжүүлэх биш бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй асуудлыг технологийн шийдэл ашиглан шийдэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. AlAmeri Mohammadi Ziaei Self Energized Smart Vision Stick for Visually Impaired People
2. EHow. How Does GSM Phone Work? [Online]. http://www.ehow.com/howdoes_5041190_gsm-phone-work.html https://www.maptoaster.com/maptoaster-topo-nz/articles/how-gps-works/how-gps-works.html?fbclid=IwAR3I6I1t8-R86gi4e49tw3z44SFp_C0CU5IDOSJ6Jw85dWY0hJPK0WEvr4c
3. NEO-6_DataSheet_(GPS.G6-HW-09005).pdf
4. Stephen P Beeby and Terence O'Donnell, "Electromagnetic Energy Harvesting," in Energy Harvesting Technologies, Shashank Priya and Daniel J Imman, Eds.: Springer.
5. UltraCane. How to choose the correct length UltraCane. [Online]. http://www.ultracane.com/ultracane_size

ХЭЛ ЯРИАНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН УХААЛАГ БЭЭЛИЙ

Ө.Өлзийбадрах¹, Н.Мягмаржав¹, Т.Амартүвшин¹, Б.Дорж¹
Монгол улс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль,
Мэдээлэл, холбооны технологийн сургууль

Хураангуй

Энэхүү өгүүллээр хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэдэг дохионы хэлийг технологийн шийдэл ашиглан ярианы хэлэнд хөрвүүлэх бүтээлийг танилцуулах болно. Хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн дохио зангааны хэлийг ихэнх хүмүүс мэддэггүй учраас тэд энгийн хүмүүстэй харьцан санаа бодлоо хуваалцах, нийгмийн харилцаанд оролцон бусдын адил үйлчилгээ авах, мэдээ мэдээлэл солилцоход хүндрэл үүсдэг. Энэ асуудлыг дохионы хэлийг дуу авиа болгон хөрвүүлдэг төхөөрөмжөөр шийдэх боломжтой ч одоогийн байдлаар монгол хэл дээр суурилсан төхөөрөмж бүтээгдээгүй байна. Тиймээс бид уян мэдрүүр, хурдатгал хэмжигч, гироскопыг ашиглан гар, хурууны хөдөлгөөнийг таньж, улмаар гар утсанд дээрх хэрэглэгчийн програмаас дуу авиа гаргах ухаалаг бээлий бүхий төхөөрөмжийн техник, програм хангамжийн шийдлийг гарган туршлаа. Гар утас дээр ажиллах хэрэглэгчийн програмаа MIT app inventor ашиглан бичсэн. Бид өөрсдийн шийдлийг гаргахын тулд зарим өндөр хөгжилтэй орнуудад зохион бүтээсэн ижил төстэй төхөөрөмжүүдийг судалсан бөгөөд энд өгүүлж буй шийдэл нь монгол хэл дээр суурилснаараа, үндэсний инженерүүдийн шийдэл гэдгээрээ онцлог юм. Өртөг багатай, эх хэл дээрээ хэрэглэх боломжтой, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц төхөөрөмжийг хэрэглээнд нэвтрүүлэхийг инженерүүд бид зорьж байна.

Түлхүүр үг:

Уян мэдрүүр, хурдатгал хэмжигч, гироскоп, MIT app inventor, дохионы хэл

Удиртгал

Хэл ярианы бэрхшээлтэй иргэд нийгэмтэй харьцахдаа өөрийн хүсэл сонирхлоо ойлгуулах, үзэл бодлоо илэрхийлэх, харилцан нээлттэй ярилцлах шаардлага ямагт гардаг. Энгийн иргэд тэр бүр дохио зангааны хэл мэддэггүй учраас дээрх шаардлага, хэрэгцээгээ хангахад

хүндрэл үүсдэг. Хэрэв дохионы хэлийг дуу авиа болгон хөрвүүлдэг бол энэ асуудлыг бүрэн төгс биш ч тодорхой хэмжээгээр шийдэх боломжтой. Бидний санал болгож буй төхөөрөмж нь мэдрэгч бүхий бээлий болон утсан дээрх хэрэглэгчийн програмаас бүтнэ. Энэхүү өгүүллийн I хэсэгт төхөөрөмжийн бүтэц, II хэсэгт хуруу, гарны хөдөлгөөнийг таних зориулалттай хэрэглэсэн уян болон хурдатгал, өнцөг хэмжигч мэдрүүрүүдийн ажиллагааны зарчим, III хэсэгт хэрэглэгчийн програмын ажиллагаа, IV хэсэгт туршилтын үр дүнгүүдийг харууллаа.

Судалгааны ажлын зорилго

Хэл ярианы бэрхшээлтэй иргэнд зориулсан, дохио зангааны хэлийг ярианы хэлэнд хөрвүүлж дуу авиа гаргадаг, ухаалаг бээлийний техник, програм хангамжийн шийдэл гарган хэрэглээнд нэвтрүүлэхэд оршино.

Судалгааны ажлын зорилтууд

- Дохионы хэлний багштай уулзаж, мэргэжлийн зөвлөгөө авах, ижил төстэй төхөөрөмжийн судалгаа хийх, судалгааны үр дүн дээрээ суурилан ажиллагааны шийдэл гаргана.
- Ашиглах электрон элемент, техник хэрэгслийн сонголт хийж, системийн шийдлийг тодорхойлно.
- Биет төхөөрөмж бүтээн, туршилт, хөгжүүлэлт хийнэ.

1. Ухаалаг бээлийний ерөнхий бүтэц




Зураг 1. Бүтцийн схем

Зураг 1-д төхөөрөмжийн ерөнхий бүтэц, дэд хэсгүүд хоорондын мэдээлэл дамжуулах шугамуудыг харуулав. Хэсэг тус бүрийн үүргийг тайлбарлавал:

- Уян мэдрүүрүүдийг гарын хуруу тус бүр дээр байрлуулсан ба хурууны нугаралтаас хамаарч мэдрүүрийн өгөгдлүүд өөрчлөгдөнө. Таван хурууны мэдрүүрийн аналог дохиог удирдлагын микроконтроллер хүлээн авч боловсруулна.
- 3 хэмжээст хурдатгал ба өнцөг хэмжигчийн тусламжтайгаар ижил төстэй дохионуудыг ялгах боломжтой. Микроконтроллер нь мэдрүүрүүдийн x , y болон z тэнхлэгийн зургаан сувгийн өгөгдлийг I2C протоколоор хүлээн авна.
- Микроконтроллер нь мэдрүүрүүдийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, ямар дохио болохыг таньсны дараа үр дүнгийн өгөгдлийг утасгүй дамжуулагч модулиар гар утсанд илгээнэ.
- Хэрэглэгчийн програм өгөгдлийг хүлээн авснаар тухайн өгөгдөл буюу дохионд харгалзах аудио файлыг тоглуулна.

2. Мэдрүүрүүдийн ажиллагааны зарчим

Хурдатгал, өнцгийн мэдрүүрээр 3-хэмжээст MPU6050 модулийг ашигласан (Зураг 2). MPU6050 нь хурдатгал болон өнцөг хэмжигчийн аналог дохиог 16 битийн тоон дохио болгон хувиргаж боловсруулах удирдлагын микроконтроллер, өгөгдөл хадгалах санах ойн болон утасгүй дамжуулалт хийх хэсгүүдтэй [1]. Бидний хэрэглэж буй MPU6050 шугаман хурдатгал болон өнцөг хурд хэмжигч нь 6 тэнхлэгтэй (Freescale $\pm 2g/\pm 16g$, $\pm 2500/s/\pm 20000/s$) [2].



Зураг 2. MPU6050 мэдрэгчийн өнцгийн шилжилтийн чиглэлийн утга

MPU6050 нь өнцөг хурд хэмжигч болон өнцөг хурдатгал хэмжигчдийн өгсөн хоёр утгыг хооронд нь харьцуулж хэмждэг тул шуугианд бага өртдөг. Хурдатгал хэмжигчийн утгуудаас x -тэнхлэгийн дагуу хазайсан өнцгийг Томьёо (1)-ээр тооцоолно.

$$\theta_x = \arcsin \frac{a_x}{\sqrt{a_x^2 + a_y^2 + a_z^2}} \quad (1)$$

Энд:

a_x, a_y, a_z – x, y, z тэнхлэг дагуух хурдатгал
Харин өнцөг хурд хэмжигчийн утгуудаас x тэнхлэгийн дагуу хазайсан өнцгийг Томьёо (2)-оор тооцоолно.

$$\phi_x = \phi_{x0} + \int w_x dt \quad (2)$$

Энд:


ϕ_{x0} - анхны өнцөг

w_x - x тэнхлэгийн дагуух өнцөг хурд

Уг хоёр утгаас комплементар шүүлтүүр ашиглан жинхэнэ хазайсан өнцгийг олно [4].


Хурууны нугаралтыг мэдрэх уян мэдрүүр нь нугаралтын радиусаас хамааран тодорхой хэмжээний даралт үүсдэгт тулгуурладаг. Мэдрүүр нугарах үед бичил ан цавуудын хоорондох зай холдосноор материалын эсэргүүцэл ихсэнэ. Эсрэгээр мэдрүүр дэлгэгдсэн байхад ан цавуудын хоорондох зай багасч, эсэргүүцэл багасна [4]. Бидний хэрэглэсэн FS-L-0055-253-ST загварын уян мэдрүүрийн зарим техникийн үзүүлэлтийг дурьдвал:

- Нийт урт: 73.66мм
 - Идэвхтэй хэсгийн урт: 55.37мм
 - Хэвийн ажиллах температур: -35°C -аас $+80^\circ\text{C}$ хүртэл
 - Эсэргүүцлийн зөвшөөрөгдөх зөрүү: 30%
 - Нугаралтын эсэргүүцлийн хязгаар: 25кОм -125кОм (нугаралтын радиусаас хамаарна)
- Хүчдэл хуваагуурын схем ашиглан уян мэдрүүрээс аналог өгөгдөл авна (Зураг 4). Мэдрүүртэй харьцуулах эсэргүүцэл нь 10кОм - 100кОм байж болно [3].



Зураг 3. Уян мэдрүүрээс өгөгдөл авах хэлхээ


Зураг 4-д мэдрэгчүүдийг бээлийнд хэрхэн байрлуулсныг харуулав.



Зураг 4. Бээлийний мэдрүүрийн байрлалууд

3. Хэрэглэгчийн програмын ажиллагаа

Дуу тоглуулах төхөөрөмжийг нэмэлт модуль ашиглан хийхэд овор хэмжээ ихтэй мөн алдаа их гарч байсан учир бид хэрэглэгчийн гар утсан дээр аппликешин бичих шийдэлд хүрсэн. Энэхүү аппликешин нь хэрэглэгчийн дохио зангаагаар хэлсэн үгийн гарын хөдөлгөөнд харгалзах аудио тоглуулах үндсэн ажиллагаатай байна. Энэ аппликешин нь төхөөрөмжтэй Bluetooth-ээр холбогдох ба төхөөрөмжөөс боловсруулалт хийгдээд ирсэн өгөгдөлд харгалзах аудио тухайн утасны speaker-ийг ашиглан тоглуулах болно.



[5]

Зураг 5. Хэрэглэгчийн програмын загвар

4. Туршилтын үр дүн

Төхөөрөмж нь хэрэглэгчийн дохио зангаагаар хэлсэн үгийг ярианы хэлрүү хөрвүүлэн түүнд харгалзах аудио тоглуулж ажилладаг учир ажиллаж буй байдлыг харуулах боломжгүй байна. Тиймээс жишээ болгоод дохио зангаагаар хэлсэн цагаан толгойн үсгийг таньж түүнд харгалзах аудио-г тоглуулж буй видео бичлэгийг хавсралтаар явуулж байна.

Дүгнэлт

Хэл ярианы бэрхшээлтэй хүнд зориулсан дохионы хэлийг ярианы хэлрүү хөрвүүлэх зориулалттай хийгдэж буй төхөөрөмж юм. Туршилтын загварыг амжилттай хийж одоогоор цагаан толгойн үсгүүдийг дохионы хэлнээс ярианы хэлрүү хөрвүүлж эхлээд байна. Яг одоо манай баг төхөөрөмжид хөгжүүлэлт хийж илүү олон үг хөрвүүлэх тал дээр ажиллаж байна.

Хэл ярианы бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцуулж тэднийг нийгмээс тусгаарлах бус, технологийн шийдэл ашиглан тэдгээр иргэдийн асуудлуудыг шийдэж, техник технологийн шийдлийг хүн бүрт ашигтайгаар байлгахад хичээж байна.

Ном зүй:

1. Liu J, Wang Z, Zhong L, Wickramasuriya J, Vasudevan V, "Accelerometer based Personalized Gesture Recognition and its Applications". in Proceeding of Pervasive Mob Compute Forum, 5(6):657–675, 2009.
2. J. Lach, "SBFS: Steganography based file system" in Proceeding of the 1st International Conference on Information Technology, IT 2008, 19-21 May 2008, Gdansk, Poland. Available: IEEE Xplore, <http://www.ieee.org>. [Accessed: 10 Sept. 2016].
3. <http://www.alselectro.com/flex-sensor.html>
4. <https://howtomechatronics.com/tutorials/arduino/arduino-and-mpu6050-accelerometer-and-gyroscope-tutorial/>
5. <https://www.invensense.com/products/motion-tracking/6-axis/mpu-6050/>
6. <https://github.com/BSP-Embed/Smart-Gloves/>
7. <https://appinventor.mit.edu/>

ХОТ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СУРАХ ОРЧИН, АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ХҮРТЭМЖИЙН СУДАЛГАА

Н.Нарантуяа¹, И.Гончигбат¹

¹ШУТИС, БАС, Архитектурын салбар

Хураангуй

Орчин үед ямар ч хот төлөвлөлтийн орон зайн шийдэлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зориулалттай тав духтай орчин бүрдүүлэх гол тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байдаг. Улаанбаатар хотын архитектур төлөвлөлтийн хөгжлийн талаас тухайн сэдвээр орон зайн бүтцийн байдлыг судалж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудын нийгмийн орчны архитектур, орон зайн төлөвлөлтийн оновчтой шийдлийн загварчлан боловсруулах судалгааг онцлог авч судалсан нь гол үндэслэл. Энэхүү судалгаа хотын барилгажилтын орчин үеийн онцлогт, шаардлагатай хэв загвар, мөн нийгмийн ач холбогдол, тулгамдсан асуудалд үндэслэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудын сурах орчны архитектур төлөвлөлтийн мэргэжлийн түвшний судалгаа ховор байна. Энэхүү судалгааны ажилд архитектур орон зайн төлөвлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудын сурч боловсрох орчны нөхцөл, тохирсон тоног төхөөрөмж, элементийн суурилуулах, тохиромжтой орон зайг судлах, орчин үеийн ашиглалтын элементийн архитектур төлөвлөлтийн шинэлэг санал, гаргалгааг судлан асуудлыг боловсруулан илэрхийлэх зорилготой. Судалгааны ажлаар дээрх гол санааг дэвшүүлэхийн тулд хотын олон нийтийн барилга, их сургуулиудын барилгын архитектурын хэв маяг, уран сайхны ба архитектур орон зайн шийдэлд тулгуурлан, хот төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан бодит орчин үед ашиглагдаж буй их сургуулийн объектууд дээр бодит судалгааны аргачлалаар хийгдсэн.

Түлхүүр үг:

Улаанбаатар хот, Хот төлөвлөлт, хот байгуулалт, барилгажилт, загвар, хэв маяг, орчин үе, өөрчилт,

Оршил

Монгол улсын орчин үеийн барилгын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (Цаашид ХБИ гэнэ) эрхийг хангах, амьдралын оролцоог дээшлүүлэх, сурч хөгжих орчныг сайжруулах хүрээнд архитектур төлөвлөлт, орон зайн шийдэл, эрх зүйн орчинг мөн янз бүрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч байгаа боловч архитектур төлөвлөлт орчныг бүрдүүлэх элементийн асуудал дээр дутагдалтай зүйлүүд байна.

Архитектур хот байгуулалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийн ашиглах орон зайн зөвшөөрөгдсөн орчин нөхцөлөөр хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах орон зай, ашиглалт, бүх мэргэжлийн сургалт боловсрол олгох, оролцох нөхцөл, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулан оролцох нөхцөл, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх боломж олгох нөхцөлөөр хангах орчин, архитектур төлөвлөлтийн шийдлийг гарган боловсруулж байна.

Монгол улсын хот төлөвлөлтийн түүхэнд шинжлэх ухааны үндэслэлтэй хотжилтын архитектур төлөвлөлтийн асуудал 1954 онд анхны ерөнхий төлөвлөгөөний боловсруулалт хийгдсэнээр эхэлсэн ч суурьшлын төлөвлөлт хувьсгалын өмнөх үеэс уламжлалт гэр сууцны шийдлээр суурьшлын архитектур төлөвлөлт үүссэн түүхтэй хот юм. Орчин үед хот төлөвлөлтийн зохион байгуулалтыг мэргэжлийн талаас судлахад хотын бүсүүдийн зохиомжийн орон зайн шийдэлд суурьшлын бүс болох орон сууцны хорооллын архитектур төлөвлөлтийн тулгамдсан асуудал байсаар өнөөдрийг хүрлээ. Улаанбаатар хотын архитектур, орон зайн төлөвлөлтийн бодлогогүй, цэгцгүй зохиомжийн дунд орон сууцны хорооллын хэв маяг, шийдлийг шинжлэх ухааны талаас онол практикийн бодит нөхцөлийг судалж дэвшүүлэн оновчтой шийдлийг боловсруулан дэвшүүлэх асуудал зайлшгүй шаардлагатай байна. Өнөөгийн нөхцөл

хот төлөвлөлтийн тулгамдаж буй асуудал нь хүн амын хамгийн аюулгүй тав духтай байх орон сууцны орчин ба хүрээлэн буй архитектур орон зайн шийдэл юм. Улаанбаатар хотын хүн амын өнөөдрийн амьдарч байгаа орон сууцны нөхцөл байдал хүн амд зориулагдсан шийдэл бүрэн бус, санхүү бизнесийн ухагдахуунд үндэслэгдсэн төлөвлөлт байдаг нь орон сууцны барилгын архитектур төлөвлөлт ихээхэн өртөж байдагт хот төлөвлөлтийн чиглэлийн эрдэмтэн, архитектор мэргэжилтэн нар санал нэгтэй байдаг ба судалгаа шинжилгээ, оновчтой гаргалгаа төлөвлөлтийг боловсруулахад чиглэгдэж байх шаардлагатай гэж үздэг.

Судалгааны ач холбогдол

Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын ашиглах боломжтой сурч боловсрох, амралт чөлөөт цаг өнгөрөх орчны мэргэжлийн түвшинд боловсруулсан оновчтой шийдэл, хэрэгжүүлэхэд хялбар бодитоор хэрэгжүүлэх сэдвийг хөндөж дэвшүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудын хялбар ашиглах элемент, архитектур орон зайн төлөвлөлтийг хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоор ач холбогдолтой.

Судалгааны онцлог

Монгол улсын ирээдүй болсон хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын энгийн залуусын нэгэн адил бие даан амарч сурах орчны архитектур төлөвлөлтийн шийдлийг дэвшүүлэн судалсан нь гол онцлог юм.

Сэдвийг судлагдсан байдал

1. Монгол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн (ХБХ) саадгүй зорчих, орчин нөхцөлийг хангах асуудлыг судалж батлагдсан хууль журмын дагуу төлөвлөлт хэрэгжиж байдаг. Үүнд:

- Барилгын тухай хууль
- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” (БНБД 30.01.04)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт барилгын дүрэм
- ХБХ-ийн Эрхийн тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон

орон зай, орчин

- Үндсэн шаардлага MNS 6055: 2009”
 - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар. MNS 6056:2009
 - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам Техникийн шаардлага. MNS5682-2006,
 - Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД
 - Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт (БД 31-111-11)
 - Эмнэлгийн барилга” БД 31-115-11
 - Авто зогсоол БНБД 21-05-10 зэрэг судалгаанд үндэслэгдсэн норм, дүрэм, стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагуудыг тусган барилга байгууламжийн зураг төсөлд мөрдөн, мөн ХБИ-ийн амьдрах нөхцөлийн орон зайн тухай судалж олон хууль журмын дотор суулгаж мөрдөж байгаа ч чөлөөтэй явах, нэвтрэх архитектур орон зай барилга байгууламжийн гадна орчин, дотор орон зай хангалтгүй байна.[8]
1. Герман Улсын их сургуульд сурах, боловсрол эзэмших боломж. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Германы аль ч их сургуульд элсэн суралцах мэргэжил эзэмших хууль ёсны эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэх үүднээс их, дээд сургуулиуд тусалцаа үзүүлэх, дэмжих зэрэг нөхцөлийн бүрдүүлсэн байдаг. Сургалтын тусгай хэмнэл, туслах үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг гэх мэт хөтөлбөрүүд байдаг бөгөөд тэдгээр нь идэвхтэй ажиллаж байдаг.
 2. Герман Улсын хөгжлийн бэрхшээлтэй оюутны дэмжлэг: Нэгдүгээрт – нийгмийн орон нутгийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах үүрэгтэй мэргэжлийн хүн ажиллаж байдаг. Хоёрдугаарт – Хөгжлийн бэрхшээлтэй оюутантай уулзахдаа сэтгэл санааг дэмжих: Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг их сургуульд элсүүлэх нь их сургуулийн нэр хүндэд өсөх боломжтой байдаг.[1]
 3. НҮБ-аас 2006 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц ийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх асуудал, үндсэн эрх чөлөөг бүрэн, тэгш хүртэх

боломжийг хангах, хамгаалах, мөн тэдний өвчин, нөхцөл байдалд хүндэтгэлтэй хандахад оршино. Энэхүү конвенц нь хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, түүнд үзүүлэх хариу арга хэмжээний томоохон өөрчлөлтийг тусгасан судалгаа байдаг.[4] Нийгмийн үйл ажиллагаа, тодотголын маш сайн судалсан ба архитектурын мэргэжлийн орон зайн төлөвлөлтийн хүртээмжийн асуудал, барилгын ашиглалтын шийдэл зэрэг бага судлагдсан байна.

Судалгааны зорилго

Улаанбаатар хотын ХБИ, оюутнуудын тав духтай амьдралын үндсэн орон зайн шийдэл, сууцны орчин үеийн хэв загвар, амралт чөлөөт цаг өнгөрөөх орчин түүнээс онцлон объект доторх сурч боловсрох орон зайн тулгамдаж буй асуудлыг оновчтой шийдэл гаргалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй дэвшүүлэн боловсруулах, орчин үеийн боломжит загварчлалыг илэрхийлэх нь судалгааны гол зорилго юм.

Судалгааны шинэлэг талууд

- ХБИ-д зориулсан ашиглалтын элементийг архитектурын шийдэл, төлөвлөлтийн хамт уялдуулан төлөвлөх асуудлыг судлан тохиромжтой орон зайн төлөвлөлтийг санал болгон судлах
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, оюутнуудын сурч боловсрох орчны архитектур төлөвлөлтийн шийдлийг дагнан судлах
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын амралт зугаалгын орон зай, элемент, зэргийг ногоон байгууламжтай уялдуулан судлах зэрэг шинэлэг талуудтай.

Судалгааны аргачлал

- Мэдээлэл цуглуулах, цуглуулсан материалын боловсруулалтын явцад ХБИ-ийн орон зайн төлөвлөлтийн элементүүдийн системийн судалж ажиглах, компьютерийн аргуудыг ашигласан мэдээллийг нэгтгэх, анализ дүн шинжилгээ хийх
- ОХУ-ын их сургуулиудийн барилга, орон сууц, хорооллын архитектур, олон нийтийн барилга байгууламжийн ХБИ-д зориулсан архитектур төлөвлөлтийн материалд орчуулга хийх, гадаадын өндөр хөгжилтэй

орны жишээ, туршлагаас харьцуулсан дүн шинжилгээ хийж дүгнэлтийг гаргах

- Судалгааны арга зүй материал цуглуулах, график бүдүүвч зураглал хийх, зураглалын явцыг (AutoCAD, Photoshop, гэх мэт) програмыг ашиглан гүйцэтгэсэн.
- МУИС, ШУТИС, МУБИС – гэх мэт боловсролын байгууллагын орчинд судалгааны объектоор сонгон бодит судалгааны аргачлалыг хэрэглэх.
- Норм, нормативын баримт бичгүүдтэй уялдуулах, ШУТИС-ийн БАС-ийн Архитектурын салбарт хэлэлцүүлэх, саналыг тусгасан болно

Тулгамдаж буй асуудал

Оновчтой орчинг бүрдүүлэх тэдгээрийн архитектур орон зайн төлөвлөлтийг шийдэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж илэрхийлсэн.

1. Архитектур орон зайн оновчтой шийдлийн үндсэн ойлголт – Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүн, оюутны ажиллаж, амьдрах орчны архитектур төлөвлөлт, тав духтай байдлын талын ойлголт бага байдаг. Мөн мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах асуудал сул байдаг.
2. Тав духтай орчинг бүрдүүлэх хандлага дэмжлэг, тусламжаас гадна шаардлагатай орон зайн шийдэл дутмаг
3. Орчинг бүрдүүлэх хууль эрх зүйн зохион байгуулалт мэдээлэл бага
4. Архитектурын мэргэжлийн эрдэмтэн судлаачдын оролцоо судалгаа, шинжилгээ цөөн
5. Архитектур, орон зайн төлөвлөлтийн шийдлийн гүйцэтгэлийн улсын санхүүжилт тодорхойгүй
6. Мэргэжилтэн бэлтгэн гаргах (Тухайн төрлийн барилгын төлөвлөлтөөр дагнасан мэргэжилтэн бэлтгэх)
7. Архитектур орон зайн оновчтой шийдлийн үндсэн ойлголт бага байх (Зөвхөн дэмжлэг туслалцааны мэдлэгтэй байх)
8. Тав духтай орчинг бүрдүүлэх боломжтой орон зайн шийдэл бий болгох нөхцөл, архитектур төлөвлөлтийн элементүүдийн шаардлага хангасан цогц шийдэлтэй орчин дутмаг.
9. Орчинг бүрдүүлэх хууль эрх зүйн зохион байгуулалтын олон нийтийн оролцоог

сайжруулах

10. Архитектурын мэргэжлийн эрдэмтэн судлаачдын оролцоо судалгаа, шинжилгээний гаргалгааг нийгэмд мэдээлэх, хүртээлтэй байх

Судалгааны үндсэн хэсэг

Судалгааны ажлаар Улаанбаатар хотын архитектур төлөвлөлтийн шийдэл, хот төлөвлөлтийн нөхцөлд уялдуулан ХБ-тэй сурах хүсэлтэй оюутан залуусын оновчтой орчны хүртээмжийн архитектур төлөвлөлтийн нөхцөлд байдалд, шаардлагатай элементийн шийдлийн төлөвлөлтөд дүгнэлт өгч, хот төлөвлөлтийн зөв оновчтой хослуулсан шийдлийг боловсруулах, аргачлалыг дүгнэж тодорхойлохын тулд орчин үеийн шинэ баригдаж буй боловсролын барилга байгууламжийн шийдэлд бодит байдалд тулгуурлан сэдвийг сонгосон нь судалгааны үндэслэл болно.

Дэлхийн бүх улс оронд, нийгмийн аль ч бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Дэлхийд тэдний тоо өссөөр байна. Хөгжлийн бэрхшээлийн шалтгаан, үр дагавар нь өөр өөр байдаг. Нийгэм, эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдал, иргэдийнхээ сайн сайхан байдлыг хангах үүднээс дэлхийн улс орнууд зориулалтын архитектур орон зайг шийдлийн арга хэмжээнүүдийг явуулж байдаг. Өнөөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ, архитектур төлөвлөлт, баримталж буй бодлого нь өнгөрсөн жилүүдийн нийгмийн хөгжлийн үр дүн гэж үзэж болно. Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг анхаарч ирсэн үе 1800 оноос хойш тоо мэдээллийг гарган судалж эхэлсэн. АНУ, Энэтхэг, Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын нэг хэсэгт хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан түүхтэй байдаг [3].

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах болон сурч, боловсрол эзэмших асуудлын орчны архитектур төлөвлөлт, таатай нөхцөл бүрдүүлэх асуудлыг онцлон авч судалж, амьдрах, сурах нөхцөлийг сайжруулах аргачлалыг боловсруулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүл, дэмжигч байгууллагууд олон болсон үе гэж тодорхойлж байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатарт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сурч боловсрохыг хүссэн оюутан залуучуудад

тулгамдсан асуудал байдаг. Хүн төрөхөөс эхлээд насан эцэслэх хүртэл хүний амьдралын бүхий л цаг хугацаатай шууд холбоотой хөдөлмөрлөх, нийгмийн нөхцөл байдал, тэднийг дэмжих салбарын үйл ажиллагаа, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хүн амын орлого багатай сэтгэл санааны хүнд нөхцөлтэй байх зэрэг нийгмийн эмзэг хэсэг байдаг. Амьдрах, сурах, боловсрол олж авах орчны архитектур төлөвлөлт, оновчтой шийдлийг бүрдүүлж өгөх, эрх ашгийг хамгаалах нөхцөлт боломжтой орчинг бий болгон ажиллах онцлогтой тухайн салбарын бүхий л шаардлагатай мэргэжлийн байгууллага, судлаач, мэргэжилтнүүдийн оролцоо шаардлагатай.

Ойлголт, тодорхойлолт – Архитектур орон зайн шийдлийг боловсруулахад эхний асуудал хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхцөл байдал, байрлах нутаг дэвсгэрийг тодорхойлох шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн – Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн бэрхшээл – Тухайн нэр томъёогоор хоёр үндсэн ангиллаар тодорхойлсон байдаг.

1. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй
2. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй гэсэн.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй – Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн гэж тодорхойлно.

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй – амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж тодорхойлдог байна.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр - Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн ангиллуудаар авч үздэг. Монгол улсад дэлхийд байдаг бүхий л төрлийн ХБИ амьдардаг. (Зураг. 1)



Зураг. 1 Монгол улсад ХБИ-ийн оролцоо ба нийгмийн үйл ажиллагаа.

Эх сурвалж: [Википедия: свободная энциклопедия]



Зураг. 2 ХБ хүүхдүүдэд зориулсан цахилгаан шат. Эх сурвалж: [Википедия: свободная энциклопедия]

Монгол улсын ХБИ-ийн нийт тоо (2017 оны байдлаар) 103 630 иргэд оршин амьдарч байна. (Хүснэгт. 1)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик үзүүлэлт. Хүснэгт. 1								
Улсын дүн бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Төрөлхий	Олдмол				
				Өвчгөөр		Осол гэмтлээр		
				Ердийн өвчин	мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийт тоо								
103 630	57310	46320	44384	44718	5073	2109	1473	5873
Хөгжлийн бэрхшээлтэй сурч боловсрох насны хүүхэд залуучууд								
11 453	6423	5030	8415	2598	24	77	11	328
Эх сурвалж. [http://www.ubstat.mn]								

Гадаад орны туршлага

Герман Улсын туршлага - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Хөдөлмөрийн Агентлагийн газруудаар дамжуулан бүхий л арга хэмжээ, дэмжлэгт хамрагдах боломжтой. Энэ төрлийн боловсролыг Герман улсад амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хэн бүхэн авах боломжтой. Тусгай зөвлөгөөнүүд - асуудлын гол шийдэл нь зөвхөн сэтгэцийн хүнд өвчтэй хүмүүст зориулагдсан программтай байдгаар онцлогтой. Бусад хүмүүсийн хувьд нийтлэг хөдөлмөрийн зах зээлд бүрэн тэгш эрхтэй оролцох боломжоор хангагдсан байдлыг судалж дэвшүүлсэн байна.

2016 онд Сочи хотын 8-р гимназийн хичээлийн корпуст ХБ-тэй хүүхдүүдэд зориулсан цахилгаан шатыг суурилуулсан байна. Энэхүү гимназид одоогоор ХБ-тэй суралцагч нэг л байдаг. (Зураг. 2)

Сочи хотын 8-р гимназийн хичээлийн корпуст ХБ-тэй хүүхдүүдэд зориулсан цахилгаан шатыг суурилуулсан ажил ХБ-тэй хүүхдүүдэд сурч боловсрох боломжит орчин бий болсон, тааламжтай шийдэл хийгдсэн байдаг. Тэргэнцэртэй хүүхдүүд, бусад хөдөлгөөний дутагдалтай хүүхдүүд саадгүй бүх давхрын хичээлийн анги, сургуулийн бүхий л орон зайд хүрч, өөрсдөө бүх асуудалд оролцож чадахаар болсон.[8]

Нийгмийн хүн амын нэг хэсэг ХБИ, оюутнуудын тав духтай амьдрах, сурах орчин амьдрах орчны

зохиомж, тэдний хүрээлэн буй орчин цогцоор байдаг. ХБИ, оюутнуудын ашиглалтын шаардлагатай орон зайг хот төлөвлөлтийн нэгжийн системд оновчтой шийдэл уялдаа холбоо гэх мэт архитектур, зохиомж, цогцолбор шийдлийг хослуулан судалж тодорхойлж байвал нийгмийн ач холбогдолтой юм.

Тухайн судалгаа цаашдын архитектурын мэргэжлийн судалгаанд гарын авлага, материал болж үлдэх, төлөвлөлтийн зарчмын бодлого алдагдсан өнөө үед архитектурын зохиомжийн оновчтой шийдлийн гаргалгааг дэвшүүлж байгаа зэрэг нь судалгаа мэргэжлийн хүрээнд дахин цааш судлах хийх асуудал олон байна.






Тухайн цахилгаан шат ашиглалтанд орж 8-р гимназийн захирал бусад бүс нутгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхээс элсэх санал өргөдөл олон хүлээн аваад байна. Үүнд ХБИ-д, залуусд амьдрах, сурах орчин хэрэгцээтэй илэрхийлэл гэж үзэж байна. Судалгааны шинэлэг шийдэл ХБИ, оюутан залуусын сурч боловсрох орон зайн

шийдэл, хот төлөвлөлтийн архитектур орон зайн хосолсон төлөвлөлтийг хийж байх ёстой. Жишээ нь амрах бүсийн орон зайн шийдэлд налуу замыг хослуулах, барилга байгууламжийн орц гарцын элементийн шийдлийг хот төлөвлөлтийн ухаалаг шийдэлд хослуулах гэх мэт.

Хосолсон төлөвлөлт шийдэл: Практикт хотын орчинд цэцэрлэгт хүрээлэн, эко ногоон бүс нь хүнийг сэтгэлзүйд сайнаар нөлөөлдөг. Ногоон байгууламжийг төлөвлөхдөө барилга байгууламж, тохижилтын элементүүдийг

зөвхөн энгийн хүн төдийгүй ХБИ, оюутан залуусын ашиглалтын тохиромжтой орон зайн төлөвлөлтийг хослуулан хийж байх.

Төлөвлөлтийн ухаалаг систем: Тэргэнцэртэй болон хөдөлгөөний дутагдалтай, хараагүй гэх мэт ХБИ-ийн ашиглах элемент ухаалаг системд шилжвэл тэдний ашиглалтыг хялбар болгох, цаг хэмнэх, сэтгэл санааны өндөр ханамж авч амьдрах гэх мэт төлөвлөлтийн дэвшил юм. (Жишээ нь: автомат удирдлагын системийг ХБИ, оюутан залуус ашиглах) (Зураг. 3)

Хосолсон төлөвлөлт	Төлөвлөлтийн ухаалаг систем
	
	
	
<p>Амралтын орчинд ХБИ, оюутан залуусын нэвтрэх хүртээмжийг хангасан, хот төлөвлөлтийн ногоон байгууламжийн архитектур төлөвлөлтийн хослол</p>	<p>Орчин үеийн хөгжлийг дагаад хүний үйл ажиллагааг ухаалаг системтэй хослуулан төлөвлөх, ХБИ, оюутан залуусын амьдралын орон зайг бүрдүүлэх архитектур төлөвлөлт</p>
<p>Эх сурвалж: [Википедия: свободная энциклопедия]</p>	

Зураг. 3 ХБ-тэй оюутан залуус, хүмүүсийн орчин үеийн ашиглалтын элемент, архитектур орон зайн төлөвлөлт

Дүгнэлт

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах сурах эрхийг хангах төлөвлөлт хийх
- Барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалт боловсролын чиглэлийн байгууламж руу зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаа орон зайн шийдэл, элементийг зохиогчийн эрхийн дагуу хянах хүлээлгэж өгөх
- Дээрх асуудлууд баригдаж буй бүх сургалт хүмүүжлийн чиглэлийн барилгад онцгойлон мөрдөж байх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудад зориулсан архитектурын элементийг бусад амьдралын орон зай, орчинтой уялдуулан төлөвлөх (амралт зугаалга, парк, цэцэрлэгт хүрээлэнгийн энгийн ашиглалт ийн архитектурын жижиг элементийг хослуулан олноор төлөвлөх зурагт харуулснаар)
- Мэргэжилтэн бэлтгэж гаргах(Тухайн төрлийн барилгын төлөвлөлтөөр дагнасан мэргэжилтэн бэлтгэх)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудад зориулсан орон зайн төлөвлөлт, барилгын элемент, интерьер төлөвлөлтийн шийдэл гэх орчин бүрдүүлэх мэргэжилтэн бэлтгэх, мэдлэг олгох зохих хэмжээгээр архитектурын боловсролын хичээлийн программд тусгаж өгөх
- Их дээд сургуулиудын багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудын орчныг бүрдүүлэхэд мэргэшүүлэн судалгаанд чадваржуулах
- мэргэжилтнүүдийн оролцоотой хэрэгжүүлэлт, багийн ажлын үйл ажиллагааны орчин бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 8 оюутнуудад архитектурын талаарх тэдний амьдрах орон зайн шийдлийн мэдлэгийн олгох хөгжүүлэх, судалгаа шинжилгээ, бодлогыг цаашид сайжруулах шаардлагатай байгааг онцлож байна.
- Дээрх тухайн асуудлуудыг мэргэжлийн боловсон хүчний оролцоотой шийдэж байх шаардлагатайг зөвлөж байна.
- Хотын доторх ХБИ, оюутнуудын ашиглах элементийг өөр архитектур, орон зайн шийдэлтэй хамт хослуулан төлөвлөх

Ашигласан ном, хэвлэл

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаархи монгол улсын анхдугаар илтгэл. УБ. 2011.он. 88.х
2. Маргарет Чен, Роберт. Б. Зеллик “Всемирный доклад об инвалидности” Отделе прессы ВОЗ, Всемирная организация здравоохранения. Женевийн 27, 2011г. 2-28стр.
3. Тунгалагтамир. С. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах. УБ. 2017. 103х
4. Амаржаргал.П. (Бусад). Судалгааны тайлан. УБ. 2018. 46х

Электрон эх сурвалж

5. Статистика[Электрон эх сурвалж].URL: <http://www.ubstat.mnStatTable=20>
6. Google Earth [Электрон эх сурвалж]. URL: <https://www.google.com/earth/> (22.08.2016)
7. maps [Электрон эх сурвалж]. URL: <https://yandex.ru/maps/> (22.08.2018)
8. Википедия: свободная энциклопедия [Электронный ресурс]. URL: <http://www.Wikipedia.org/> (22.08.2016)

Норм дүрэм

9. БНБД 30.01.03. Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм. -УБ., 2003 он. х 85
10. БД 31-112-11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм. УБ.: 2011 он. 32 х

О.ТЛЕЙХАНЫ НЭРЭМЖИТ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН БАРИЛГЫН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Н.Шаарийбуу¹, С.Батцэрэн¹, А.Дөлгөөнхангай¹, А.Өэлүн^{1,2}

¹ШУТИС-ийн БАС

²Ландшафтын архитектур, задгай орон зайн төлөвлөлт ба хотын экологи

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд (ХБИ) зориулсан орон зайг норм дүрэм стандартын дагуу анхандаа төлөвлөдөггүй байсан нь эдгээр хүмүүсийн оролцоог нийгэмд хүлээн зөвшөөрдөггүй байсантай холбоотой. Харин сүүлийн үед эдгээр хүмүүс нийгэмд оролцох шаардлагатайг ойлгон тэдгээр хүмүүст зориулсан тусгай орон зайг бий болгосон боловч энэ нь энгийн хүмүүс ба хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн 2 тусдаа ойлголтыг нийгэмд төрүүлсэн. Ингэснээр ялгаварлан гадуурхах хандлага нийгэмд бий болж ХБИ-ий сэтгэлзүйд хүндээр нөлөөлөх болсон. Тиймээс бид ХБИ-ийн нийгэмд оролцох оролцоог дээшлүүлэх мөн ХБИ, өндөр настан, хүүхэд гэж ялгалгүй бүх насныхан хэрэглэх боломжтой түгээмэл загварыг бий болгоход судалгааны гол зорилго оршино. Иймээс бид О.Тлейханы нэрэмжит Барилгын политехник коллежийн барилгыг сонгон хэмжилт биет судалгаа ажиглалт зэрэг судалгааны арга зүйгээр асуудлыг тодорхойлж тухайн асуудлыг норм дүрэм стандартын дагуу бүх хүнд зориулагдсан, тэр дундаа ХБИ рүү чиглэсэн төлөвлөлтийн шийдлүүдийг гаргасан. Үүний үр дүнд ХБИ-ийн нийгэмд бие даан оролцохыг дэмжиж, барилгын хүртээмжийг сайжруулсан эерэг үр дүнд хүрсэн. Цаашид ижил төстэй барилгуудын ашиглалтыг сайжруулж, хүн бүрд хүртээмжтэй нөхцөлийг бий болгох талаар судалгаагаа үргэлжлүүлж хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлнэ.

Түлхүүр үг:

Төлөвлөлт, түгээмэл загвар, стандарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн

Удиртгал

Улаанбаатар хотод баригдсан болон баригдаж буй олон нийтийн барилгуудын дийлэнх нь хүн бүр ашиглах, хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан зорчиход төвөгтэй, тусгай хөтөч зам, тэмдэг тэмдэглэгээ, амрах

талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн чанар хангалтгүй, аюулгүй хүрч очих боломж зэрэг шаардлагатай нөхцөл байдлуудыг хангаж чадахгүйн улмаас барилгын ашиглалтын болон орчны хүртээмж нь буурч байна [9]. Энэхүү нөхцөлүүд нь хүний сурч боловсрох ажиллах нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна. Аливаа хот, суурин газарт барилга байгууламж нь бүх хүнд тэгш хүртээмжтэй, ээлтэй байх ёстой. Энэ асуудлын хүрээнд Улаанбаатар хотод буй олон нийтийн барилга байгууламжаар өдөр тутам үйлчлүүлж буй иргэдийн тэгш хүртээмжтэй байдлыг хангаж байгаа эсэх, түүнчлэн нийгмийн зорилтот бүлгүүдэд хандсан тусгай хэрэгцээт орчинг бүрдүүлж чадсан эсэхт харьцуулсан судалгаа хийв.

Онолын хэсэг

Монгол улсын хувьд 2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт хүн амын 3.3% буюу 105 мянган иргэн байна. Улаанбаатар хотын хувьд 34.2 мянган иргэн байгаа [1] боловч тэдэнд зориулагдсан олон нийтийн барилга саадгүй зорчих, хөгжих боломж тулгамдаж байна. Энэ нь эдгээр иргэдийг нийгмийн харилцаанд бүрэн оролцох боломжийг хязгаарладаг. Тиймээс сүүлийн жилүүдэд олон улсад “Universal Design” - “Түгээмэл загвар”-гэх ойлголт шинээр гарч ирсэн.

Барилга байгууламж, зам тээврийн сүлжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн саадгүй орох, зорчих эрхийг дээдэлсэн байх ба уг хүмүүс нь нийгмээс ялгаварлан гадуурхагдахаас илүү энгийн хүмүүстэй хамтдаа амьдарч, ажиллаж байх эрхтэй юм. ХБИ хэмээх ойлголтод хөгшин, бие даан явах чадваргүй энгийн хүүхдүүдийг ч хамруулан ойлгодог. Аливаа бүтээгдэхүүний загвар, барилгын төлөвлөлтийг гаргахдаа “Түгээмэл загвар”-ийн үндсэн 7 зарчмуудыг анхааран тусгах шаардлагатай байна.

1. Тэгш хэрэглээ: Ялгаатай чадамжтай хүмүүс /ХБИ/-д тустай, хэрэглэж болохуйц байх.

2. **Уян хатан хэрэглээ:** Хувь хүний чадамж, сонголтын өргөн хүрээг хамарсан байх
3. **Энгийн ба аяндаа хэрэглэх байдал:** Хэрэглэгчийн мэдлэг, туршлага, хэлний төвшин эсвэл анхаарал хандуулах чадвар зэргээс үл хамаарч ойлгоход амархан байх.
4. **Мэдээллийг таних байдал:** Орчны нөхцөл, хэрэглэгчийн мэдрэх чадвараас үл хамаарч хэрэгцээт мэдээллийг хэрэглэгчдэд хүргэдэг байх.
5. **Аюулгүй байдал:** Санаандгүй үйлдэлослоос гарах сөрөг болон аюултай үр дагаврыг бууруулахад чиглэсэн байх.
6. **Хялбаршуулсан байдал:** Их хүч зарцуулахгүй бүтээмжтэй, таатай байх талыг бодолцсон байх.
7. **Зай хэмжээсний хандлага:** Хэрэглэгчийн биеийн хэмжээ, байдал эсвэл хөдөлгөөнөөс үл хамаарч хүрэх, ойртох боломжтой хэмжээ, зайг ашигласан байх [3].

Бие даан амьдрах гэдэг нь юу вэ? гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын адил эрх, үүргээ эдлэх, бусадтай адил сонголт хийж, шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ үр дагавар, үүрэг хариуцлагыг хүлээж амьдрах эрмэлзлийг илэрхийлж байдаг. Эндээс л бие даан амьдрах гэдэг ойлголт гарч байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маш удаан хугацаанд гэрээсээ гарч чадахгүй, зөвхөн гэр бүлийнхээ хараа хяналтад байснаар нийгэмшиж чаддаггүй [8].

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шууд бусад хүүхдүүдээс тусгаарладаг. Ингэснээр тухайн хүүхэд сайн хөгжиж чаддаггүй гэсэн судалгаа гарсан. Олон улсын жишгээр бол хүүхдүүдийг тусгаарлах ёсгүй. Бусад энгийн хүүхдүүдтэй хамт сургаж байж нийгэмшиж хөгжих боломжийг олгодог [5].

1. Шаардлагатай норм дүрэм

1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зай хэмжээ

1.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэргэнцрийг байрлуулах талбайн өргөн нь 0.9 м, урт нь 1.5 м-ээс багагүй байна.

1.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих замын өргөн нэг талын хөдөлгөөнтэй үед 1.2 м-ээс багагүй, хоёр талын хөдөлгөөнтэй үед 1.8 м-ээс багагүй байна.

1.1.3. Нэвтрэх хаалганы өндөр 2.1 м-ээс багагүй байна.

1.1.4. Тэргэнцрийг 90 градуст эргүүлэх талбай 1.3x1.4 м, 180 градуст 1.3x1.7 м, 360 градуст 1.5x1.7 м-ээс багагүй байна. Барилгын тодорхой нэг хэсэг, элементүүдийн доорх орон зай, тэргэнцэртэй хүний ашиглахад тохиромжтой байх тоног төхөөрөмж, шүүгээний өргөн 0,6 м-ээс багагүй, өндөр нь шал болон явган хүний замын түвшингөөс 0,6 м-ээс багагүй байна. Тоноглол болон тавилга руу очих замын өргөн 0,9 м-ээс багагүй, тэргэнцэртэй 90 градуст эргэх тохиолдолд 1.2 м-ээс багагүй талбай төлөвлөнө.

1.1.5. Барилга байгууламжийн хананд байрлуулсан тоноглол, шуудангийн хайрцаг, харилцах утасны мэдээллийн самбар гэх мэт ил гарсан хэсгүүд нь хөгжлийн бэрхшээлтэй болон тэргэнцэртэй иргэдийн явах, эргэлт хийх зам талбайд саад учруулхааргүй байна.

Барилга байгууламжийн ил гарсан хэсгүүдийн доод ирмэг нь явган хүний замын гадаргуугаас 0.7-2.1 метрийн түвшинд байрлаж байгаа тохиолдолд барилгын үндсэн даацын болон хананы гадаргуугаас 0.1 м-ээс ихгүй байх ба харин тусгай тулгууртай тохиолдолд 0.3 м-ээс ихгүй байна. Энэ хэмжээнээс их гарсан тохиолдолд өнгийж гарсан хэсгүүдийн доорх зай нь 3 см-ээс багагүй өндөртэй хашлагаар тусгаарлагдсан байна.

1.2. Явган хүний зам

1.2.1. Тэргэнцэртэй болон өндөр настай иргэд явахад зориулсан явган хүний замын налуу уртаашаа 5%, хөндлөн чиглэлд 1%-иас илүүгүй байна. Газрын гадаргын нөхцөлөөс хамаарч заагдсан хязгаарыг баримтлах боломжгүй бол 12 м-ээс багагүй урттай замын налууг 10%-иар нэмж болно. Тэгэхдээ уруудах замын дунд хэсэгт хэвтээ талбай төлөвлөнө.

1.2.2. Явган хүний зам гудамж замын зорчих хэсгийн огтлолцолд хэсэгт нарийн замын чулуун хашлаганы өндөр нь 2.5 см-ээс багагүй, 4 см-ээс өндөргүй байх хэрэгтэй. Замын хөндлөн гарцанд хурц үзүүртэй хашлага, чулууг хэрэглэх мөн оролт болон хөдөлгөөний хэсгийн өргөнийг нарийсгахийг хориглоно. Тээврийн хэрэгслийн нягтрал ихтэй газарт хамгаалах хаалтыг төлөвлөнө.

1.2.3. Гудамжны зорчих хэсэг дэх аюулгүйн зурвасыг дайран өнгөрөх явган замын өргөн нь 3 м-ээс багагүй, урт нь 2 м-ээс багагүй байна.

1.2.4. Орон сууцны бичил хороололд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явахад зориулагдсан явган хүний замын дагуу 300 м тутамд амрах сандал төлөвлөнө.

1.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг болзошгүй аюултай хэсгээс хамгаалах зорилгоор 5 см-ээс багагүй өндөртэй чулуун хашлагаар тухайн хэсгийг хашиж өгнө.

1.2.6. Аваарын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нүүлгэн шилжүүлэх гарцыг чөлөөтэй орж гарахаар төлөвлөнө.

1.3. Шат ба налуу зам

1.3.1. Явган хүний зам, талбайн түвшин барилга байгууламжийн шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их хэсэгт налуу зам, шатыг урьдчилан тооцож төлөвлөнө. Налуу замын бүтээц, тэдгээрийн хаалт хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийж галд тэсвэрлэлтийн хязгаар 2 цагаас багагүй байна. Зарим тохиолдолд дугуй хэлбэрийн налуу зам төлөвлөхийг зөвшөөрөх бөгөөд дотор радиусын хэмжээг хавсралт 2-т тооцсоны дагуу авна. Дугуй хэлбэртэй налуу замын завсар хоорондын талбайн урт түүний радиусаас хамаарч 2 м-ээс багагүй байна.

1.3.2. Налуу замын налууг түүний уртаас хамаарч хавсралт 1-д заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй.

1.3.3. Налуу замын өгсөлт бүрийн эхлэл төгсгөл дээр тэгш талбайг төлөвлөх ба өргөн нь налуу замын өргөнөөс багагүй, урт нь 1.5 м-ээс багагүй байна. Налуу замын чиглэлийг өөрчлөх тохиолдолд тэгш талбайн өргөн нь дугуйт тэргэнцэр эргэхэд саадгүй байна.

1.3.4. Налуу зам болон тэгш талбайн захаар 5 см-ээс багагүй өндөртэй хашлага хийх шаардлагатай.

1.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явах чигийн дагуух шатны гишгүүр нягт, тэгш, тээглэх зүйлгүй, гадаргуу нь бага зэрэг барзгар байна. Гишгүүрийн ирмэг 5 см-ээс багагүй дугуйралттай байна. Шатны гишгүүрийн захаар 2 см-ээс багагүй хашлага хийнэ. Гадна шатны гишгүүрийн өргөн 40 см-ээс багагүй, барилгын дотор шатны гишгүүрийн өргөн 30 см-ээс багагүй, гишгүүрийн өндөр гадна шатанд 12 см, дотор шатанд 15 см-ээс ихгүй байна.

1.3.6. Налуу замын 2 талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон бусад хүмүүс барьхад зориулагдсан хаалт болон бариулын дээд ирмэг хүртлэх өндөр 0.7-0.9 м-ээс багагүй байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд бариулын өндөр 0,5 м байна. Налуу замын эхлэл төгсгөлд бариулыг 0.3 м-ээс ихгүй илүү гаргаж төгсгөнө. Бариулын хөндлөн огтлолын диаметр 3 см-ээс

багагүй 5 см-ээс ихгүй, тэгш өнцөгт огтлолтой бол зузаан нь 0.04м-ээс ихгүй байна.

1.3.7. Хоёр болон түүнээс дээш давхруудаас аврах зориулалттай налуу зам нь барилга байгууламжаас гадагшаа гарах хаалгатай шууд холбогдсон байна [2].

2. Объект сонгосон шалтгаан

Хөдөлмөр эрхлэх насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20% нь ажил хийдэг. Тухайн иргэд нь хүссэн мэргэжлээ эзэмшээд, хөдөлмөрлөхийг хүсдэг хэдий ч тус байгууллагын хандлага, энгийн хүнтэй харьцуулахад ажлын бүтээмж тааруу зэрэг шалтгаанаар эдгээр хүмүүсийг ажилд авахаас татгалздаг. Тиймээс ажилтай орлоготой болохын тулд ихэнх нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөр дамжуулан боловсрол эзэмшдэг[7]. Иймд тэдгээр иргэдийн сурч боловсрох орчинг бүрдүүлэх энгийн хүмүүстэй нийгмийн харилцаанд ямар ч саадгүй оролцох боломжийг хангахын тулд О.Тлейханы нэрэмжит политехник коллежийн барилгын хүртээмжийг сайжруулах судалгааг хийсэн юм.

3. Судалгааны ажлын үндэслэл

Барилгын политехникийн коллеж нь 1954 он барилгын үндэсний мэргэжилтэн бэлтгэх зорилгоор байгуулагдсан анхны сургууль бөгөөд тухайн үед нийгмийн хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмээс тусгаарладаг байсан нь эдгээр хүмүүст зориулсан орон зайн шийдэл, тусгай тоноглол, тэмдэг тэмдэглэгээ зэргийг төлөвлөлтдөө тусгадаггүй. Харин өнөө үед нийгмийн хандлага хувьсан өөрчлөгдөж ХБИ-ийг хүлээн зөвшөөрч тэдний хэрэгцээг хангахын тулд нэмэлт тоног төхөөрөмж, төлөвлөлт зэргийг шаардах болсон. Иймд дээрх объектод шинэчилсэн төлөвлөлт хийж орчныг сайжруулж, хүртээмжийг дээшлүүлэх шаардлага.

4. Судалгааны ажлын ач холбогдол

Тус судалгааг хийснээр барилгын политехникийн коллежийн ашиглалт болон орчинг сайжруулснаар өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, залуучуудад хүртээмжтэй орчныг бий болгож түгээмэл загварыг эрэлхийлэхэд дөхөм болох юм. Энэхүү асуудлыг шийдсэнээр ХБИ-ний орон зайг бодолцоогүй төлөвлөсөн барилгад ХБИ бие даан саадгүй зорчих боломжийг олгох.

Цаашлаад төлөвлөлтгүй байгаа бүх барилгад энэхүү асуудлыг хөндөн шинэчилсэн төлөвлөлт хийх, шинээр баригдах барилгуудад норм дүрмийн дагуу шаардлагыг тавьснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

5. Судалгаа боловсруулсан арга зүй

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын орчны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагатай орон зай, тоноглол, таних тэмдэг, тус барилгад зорчиход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг олж илрүүлэх тэдгээрийг шийдвэрлэх цаашид хэрэгжүүлэх зэрэг зорилтын дор дараах арга зүйг ашиглан судалгаа явуулав.


- **Объект дээрх судалгаа:** Одоо байгаа сургууль дээр хэмжилт хийн архиваас авсан анхны зураг төсөлтэй харьцуулан хэмжилтийн дэвсгэр зураг гаргасан.
- **Хэмжилт:** Ойролцоох автобусны буудлаас тус байршил хүртэлх явган замын өргөн, зорчих хэсэг, явган зам дээрх тохижилтын элементүүд, авто замтай огтлолцох хэсгийн хэмжээ, барилгын өмнөх орчин, авто зогсоол зэргийг хэмжиж зураглалд тусгасан.
- **Зураг авч баримтжуулах ажиглалт:** Судалгааны объектын хүрээнд 4.22-26-ны өдрүүдэд ажиглалт хийн хөдөлгөөний эрчим ихтэй хэсгүүдэд шаардлагатай зам талбайн хэмжээг тодорхойлсон.
- **Ярилцлага, асуудлыг олох:** Тэргэнцэртэй хүнтэй хамт тухайн барилгад зорчин хөдөлгөөнд саад учруулж буй зүйлсийг хайн олж дэвсгэр зурагт тэмдэглэж хүндрэлтэй зүйлсийн талаар ярилцсан.
- **Сэдвийн хүрээнд шаардлагатай норм, дүрэм судлах:**
 - ✓ БД 31-101-04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль
 - ✓ БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
 - ✓ БД 31-113-11 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт
 - ✓ MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц. 2007 он.

6. Объект дээрх судалгаанаас илрүүлсэн асуудлууд

- ✓ Дараах асуудлуудыг хөндөж өгсөн. Үүнд:
 - Сургуулийн бүс рүү нэвтрэх хөдөлгөөний чиглэл
 - Явган замын хүртээмж
 - Орц гарцын хүртээмж
 - Амрах талбайн хүртээмж
 - Аюулгүй зорчих хүртээмж
 - Харааны бэрхшээлтэй хүн саадгүй зорчих
 - Өргөтгөлийн шатны пандусын шийдэл
 - Хүзүүвчний шат
 - Гэрэлтүүлгийн хүртээмж зэрэг асуудлуудыг дэвшүүлсэн.
- ✓ Судалгааны үр дүнд гарсан асуудал. Үүнд:
 - Сургуулийн бүс рүү нэвтрэх хөдөлгөөний чиглэл
 - Явган замын хүртээмж
 - Орц гарцын хүртээмж
 - Амрах талбайн хүртээмж
 - Аюулгүй зорчих хүртээмж
 - Харааны бэрхшээлтэй хүн саадгүй зорчих
 - Өргөтгөлийн шатны пандусын шийдэл
 - Хүзүүвчний шат
 - Гэрэлтүүлгийн хүртээмж зэрэг асуудлуудыг дэвшүүлсэн.

6.1 Сургуулийн бүс рүү нэвтрэх хөдөлгөөний чиглэл

Баруун дөрвөн замын автобусны буудлаас явган зорчигч 110 метр 2 минут зорчино. Сургуулийн бүс рүү нэвтрэх замд орц гарцын хүртээмж бага, барилгын орц тойруу, явган хүний хөдөлгөөний ачаалал ихтэй. (1 дүгээр зураг.)



1 дүгээр зураг. Баруун 4н замын буудлаас орц хүртэлх явган хүний зам


Барилгын политехникийн дотуур байрнаас сургуулийн бүс рүү 220 метр 3 минут зорчино. Дотуур байрны ойролцоо гарцгүй тул зам хөндлөн гарахад хүрдэг. Үүнээс үүдэн осол аваар гарч болзошгүй. (2 дугаар зураг.)



2 дугаар зураг. Барилгын политехникийн коллежийн дотуур байр

ТҮЦ, гэрлийн шон, шугам сүлжээний худаг зэрэг нь баруун дөрвөн замын автобусны буудлын явган хүний зам дээрх хүмүүсийн хөдөлгөөнд, тэр дундаа тэргэнцэртэй хүн зорчиход саад учруулж байна.

(3,4 дүгээр зургууд)




3 дугаар зураг. Автобусны буудал дээрх ТҮЦ хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулж байна



4 дүгээр зураг. Гэрлэн шон болон худаг хоёрын хоорондох хэмжээ

6.2. Явган замын хүртээмж


Автобусны буудлаас сургуулийн бүс рүү явах явган замд норм дүрмийн дагуу харааны бэрхшээлтэй хүний хөтөч зам, дугуйн зориулалттай зам, ногоон зурвас төлөвлөгдөөгүйн улмаас үүдэх хөдөлгөөний эмх замбараагүй нөхцөл үүсэж байна. (5 дугаар зураг.)



5 дугаар зураг. Баруун дөрвөн замаас сургуульруу явах явган хүний замын хэмжээ.

6.3 Амрах талбайн хүртээмж

Хичээлийн 1 болон 4-р-байрны дундах 6 метр өргөнтэй талбай нь зориулалтгүй учраас хог хаягдал, орчны бохирдол ихтэй ашиглалтгүй орон зай үүссэн. (6 дугаар зураг.)



6 дугаар зураг. А. 4-р байрны баруун тал
Б. 4-р байрны зүүн тал

6.4 Аюулгүй зорчих хүртээмж

Барилгын политехникийн коллеж руу нэвтрэх болон дотоод орон зайд саадгүй, аюулгүй зорчиход асуудал болж байгаа хүчин зүйлүүдийг доор дурьдав.

6.4.1. Харааны бэрхшээлтэй хүн саадгүй зорчих

Харааны бэрхшээлтэй хүн барилга дотор явахад зориулалтын тоноглол нэмэлт тэмдэг тэмдэглэгээ байхгүйн улмаас зорчиход хүндрэлтэй. Энэ нь харааны бэрхшээлтэй хүн гэмтэх бэртэх зэрэг нөхцөл үүсгэдэг. (7 дугаар зураг.)



7 дугаар зураг. Коридорын харагдац

6.4.2. Өргөтгөлийн шатны пандус

Барилгын политектикийн төв байрнаас хүзүүвчээр дамжин өргөтгөлийн байр луу зорчих замд үүссэн төвшний ялгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн болон өндөр настан хүүхдийн зорчиход хүндрэлтэй нөхцөлийг үүсгэж байна. (8 дугаар зураг.)



8 дугаар зураг. Хүзүүвчээс өргөтгөл хүртэлх шат

6.4.3 Гэрэлтүүлгийн хүртээмж

2-р байрны коридор нь байгалийн гэрэлтүүлэг бага үздэг, коридорын цонхыг хааж номын фонд, сантехникийн өрөө гаргасан учир гэрэлтүүлгийн хэмжээ багасгасан. (9 дүгээр зураг.)



9 дүгээр зураг. 2-р байрны коридорын гэрэлтүүлгийг хаасан өрөө

6.4.4 Ариун цэврийн өрөөний төлөвлөлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний стандартад нийцсэн ариун цэврийн өрөө төлөвлөлт нь эргэх талбай болон бие даан бие засах нөхцөлийг дутагдалтай бүрдүүлж өгсөн. Мөн ариун цэврийн шаардлагыг хангасан тасалгаа хаалт байхгүй. (10 дугаар зураг.)




10 дугаар зураг. Ариун цэврийн өрөөний одоогийн байдал

7. Шийдэл

7.1 Явган замын хүртээмж

Хот суурин газрын барилга байгууламж авто замын дундах улаан шугам нь дуу чимээ тусгаарлах экологи, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах, хүн зорчих ая тухтай орчныг бүрдүүлсэн.


Бд31-01-04 “3.1.5д зааснаар” замын хөдөлгөөн байгаа хэсгийн өмнө, замаас барилга хүртэлх чиглэл, нийтийн үйлчилгээний замаас нийтийн тээвэр явах зогсоол руу явах чиглэлд байрлуулна [4]. (11 дүгээр зураг.)



11 дүгээр зураг. Баруун дөрвөн замаас суруульруу явах явган хүний замын хэмжээ


7.2 Орц гарцны концепц

Нэмэлт орц төлөвлөсөн үндэслэл: 1-р байрны урд талбай нь автобусны буудлаас ойр нарны эзвэрлэлт сайн, нөмөр газар мөн цугларах талбай гол орц хийхэд тохиромжтой. (12 дугаар зураг.)




12 дугаар зураг. Нэмэлт орц төлөвлөсөн үндэслэл

Гол болон туслах орцны концепц: Босоо\Y\ тэнхлэгийн дагуу барилга руу нэвтрэх гол орц, хэвтээ \X\ чиглэлийн дагуу барилга руу нэвтрэх туслах орц. (Зураг 13)




13 дугаар зураг. Гол болон туслах орцны концепц

Явган зорчигчийн хөдөлгөөн: Гол болон туслах орцны чиглэлээс хамаарсан хүний зорчих хөдөлгөөн. (14 дүгээр зураг.)



14 дүгээр зураг. Явган зорчигчийн хөдөлгөөн

Энэхүү гол орцыг төлөвлөснөөр гадна болон дотор орон зайд туулах замыг багасгаж өгнө. (15 дугаар зураг.)



15 дугаар зураг. Гадна болон дотор холболтын шийдэл

7.2.1 Орц гарцын хүртээмж

Барилгын баруун талаас хаалттай ашигладаггүй орцыг ашиглалттай нээлттэй туслах орц болгосон. Одоо байгаа гол орцны байрлал нь буудлаас хүрч очиход хол, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан зорчиход хүндрэлтэй учир туслах орцны зориулалтаар ашиглана. (16 дугаар зураг.)

Туслах орц \Баруун тал\



16 дугаар зураг. Гол болон туслах орон зайн харагдац

Үүдний хэсэгт шат, налуу зам, амрах сандал, ногоон байгууламж зэргийг нэгдмэл байдлаар хамтад нь төлөвлөж өгсөн. (Зураг 17)



17 дугаар зураг. Гол орцны шийдэл

Шат болон пандусны эхлэл төгсгөл дээр хөтөч хавтан шатны гишгүүрээс 150 мм-ийн

зайд байрлуулна. Шатны болон хананы бариул дээр хараагүй хүний зориулсан бареил тэмдэг байрлуулж өгсөн. Шатны марш нь тэргэнцэртэй хүн эргэх зайг бодолцон хангалттай өргөн хийсэн. Мөн гишгүүрийн ирмэг дээр халтирахаас сэргийлж ховил татна [4]. (18,19 дүгээр зургууд.)



18 дүгээр зураг. Одоо байгаа гол орцны шийдэл



19 дүгээр зураг. Барилгын хаалттай ашиглалтгүй орц гарцын шийдэл

Автомашин болон хүний хөдөлгөөнийг огтлолцохгүй байхаар эмх цэгцтэй төлөвлөж өгсөн. Авто зогсоолын налуу 30-н градусын өнцгөөр байрлуулж төлөвлөсөн. Мөн барилгаас 30м зайд авто зогсоолыг байрлуулсан. Налуу замын хажууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоол төлөвлөсөн [2]. (20 дугаар зураг.)



20 дугаар зураг. Гол болон туслах орон зайн харагдац

7.3 Амрах талбайн хүртээмж

Хичээлийн 1-р байр болон 4-р байр хоорондын зайн ашиглалтгүй орон зайг оюутан сурагч багш ажилчид дадлагын талбайд буй хүмүүс ашиглах зорилготой павильон төлөвлөх. Ингэснээр тухайн ашиглалтгүй талбайг ашиглах, амрах талбайн хүртээмжийг дээшлүүлнэ. (21 дүгээр зураг.)





21 дүгээр зураг. Амрах болон хичээллэх гадна амрах нээлттэй байгууламж А. 2-р байр болон 4-р байрны дундах орон зай Б. 1-р байр болон 4-р байрны дундах орон зай


7.4 Харааны бэрхшээлтэй хүн саадгүй зорчих

Харааны бэрхшээлтэй хүний бариул нь ханандаа бат бэх суурилагдсан, шалнаас дээш тохирсон өндөрт барихад эвтэйхэн байхаар төлөвлөсөн. Мөн шалнаас дээш 150мм өндөрт 200мм өндөртэй зөөлөвч бэхэлж өгсөн.

Хонгилыг тэргэнцэртэй хүн чөлөөтэй эргэх боломжтой байхаар өргөн төлөвлөж өгсөн [6]. (22,23 дугаар зургууд.)



22 дугаар зураг. Дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн байгуулалт




23 дугаар зураг. Зураг төслийн дагуу хийгдсэн 3н хэмжээст зураглал


7.5 Гэрэлтүүлгийн хүртээмж

Ангиудын ханыг шилэн болгож байгалийн гэрлийг дамжуулан гэрэлтүүлж, мөн коридорын гэрлийг хааж буй өрөөг шилжүүлснээр коридорт тусах байгалийн гэрэлтүүлгийг ихэсгэх.

Ангиудын хана нь 380 мм-ийн даац авч буй тоосгон хана учир” БД 22-101-07 зааснаар газар хөдлөлийн эрчмээс (8 балл) хамааруулж хананд гаргах нүхний өргөнийг 2,6м (нормд зааснаар хамгийн ихдээ 3м)-ээр авсан. (24,25-р зургууд.)




24 дүгээр зураг. Коридорын дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн байгуулалт



25 дугаар зураг. Өргөтгөлийн коридорын дахин төлөвлөлтийн 3н хэмжээт огтлол

7.6 Харааны бэрхшээлтэй хүн саадгүй зорчих хүртээмж



Харааны бэрхшээлтэй хүн аюулгүй зорчихын тулд БД 31-101-04 3.1.5 заасны дагуу замын хөдөлгөөн байгаа хэсэгт, орц гарцын өмнө, замаас барилга руу хүрэх чиглэлд, нийтийн тээврийн зогсоол руу явах чиглэлд сэрэмжлүүлэх дохио өгөх цэг маягийн хээтэй хавтанцар, дагаж явах чиглэлд шугаман хэлбэрийн хээтэй хавтанцар байршуулсан. (26 дугаар зураг.)




26 дугаар зураг. Зураг төслийн дагуу хийгдсэн 3н хэмжээст зураглал

7.7 Өргөтгөлийн налуу шатны шийдэл

Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин нь “MNS 6055:2009” үндсэн шаардлага дээрээс үндэслэн 5.3-р зүйлд зааснаар <1:12 хэвийлттэй өндөр нь <200мм байхаар төлөвлөж өгсөн. (27, 28 дугаар зургууд.)




27 дугаар зураг. Налуу шатны дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн байгуулалт



28 дугаар зураг. Зураг төслийн дагуу хийгдсэн 3н хэмжээст зураглал

7.8 Ариун цэврийн өрөөний төлөвлөлт

Барилгын гол орцоос ариун цэврийн (АЦӨ) өрөө хүртэл хөтөч хавтан болон бариулыг Бд31-101-04 “3.9.0” зааснаар төлөвлөж өгсөн. Угаагуурыг тэргэнцэртэй хүн ашиглаж болох өндөрт байрлуулсан. Хөдөлгөөн хийхэд саадгүй эргэж ашиглах боломжтой орон зайг төлөвлөж өгсөн. (29 дүгээр зураг.)



29 дүгээр зураг. АЦӨ дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн байгуулалт

Хэрэглэхэд дөхөм бие засах газар нь зөвшөөрөгдсөн тэмдэг тэмдэглэгээтэй байна.

Бд31-101-04 “3.9.0” Савангийн тавиур, гар хатаагч, толь, карант зэрэг нь тэргэнцэртэй хүнд тохирсон, шал нь халтирдаггүй материалаар хийж өгнө. Одоо байгаа нөхцөл дээр нэмэлт шаардлагатай бариул төлөвлөж өгсөн. (30 дугаар зураг.)



30 дугаар зураг. Зураг төслийн дагуу хийгдсэн 3н хэмжээст зураглал

8. Үнэлгээ

Барилгын зураг төслийн иж бүрэн үнэлгээ хийдэг аппликейшн ашиглан барилгадаа мэргэжлийн эксперт Д.Ганбат, Н.Ням-Очир, Д.Бат-Орших нараар үнэлгээ хийлгүүлсэн. (31 дугаар зургууд.)



31 дүгээр зураг. А: АЦӨ-ний үнэлгээ, Б: Явган хүний гарц, В: Гадна шатны налуу замын үнэлгээ

Дүгнэлт

Барилгын политехникийн коллеж нь хүн бүрт ашиглахад саадгүй байх ашиглалтын болон орчны хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нэмэлт төлөвлөлт, орон зай, зэргийг бий болгосноор барилгын ашиглалтыг тодорхой хэмжээнд дээшлүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайг бодолцоогүй хийсэн барилга байгууламжид

нэмэлт засвар үйлчилгээ хийж хүртээмжийг дээшлүүлж болохыг харуулсан.

Шинээр баригдаж буй барилгууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэвтрэх боломж, орон зай, зорчих хөдөлгөөнийг бодолцож төлөвлөдөг болсон ба хуучин барилгад эдгээр нөхцөлийг бий болгохын тулд нэмэлт засваруудыг хийх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Барилгын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэмэлт төлөвлөлт, тоноглол, налуу зам орон зайг бий болгосноороо тэдгээр хүмүүсийн нийгмийн оролцоо нэмэгдэж гадуурхагдах, тусгаарлагдах нөхцөлийг бууруулах боломжтой.

Барилгын ашиглалтанд үнэлгээ дүгнэлт хийдэг “ҮНЭЛГЭЭ” аппликейшныг ашиглаж өөрсдийн зураг төслөө шалгуулахад тусгай мэргэжилтнүүд үнэлэлт дүгнэлт хийж 90%-ийн ашиглалтын шаардлагыг хангасан. Үүнээс үзэхэд ХБИ-ийн орон зайг бодолцоогүй төлөвлөгдсөн барилгуудад нэмэлтээр засвар үйлчилгээ хийж орчныг сайжруулах боломжтой гэж дүгнэж байна.

Нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн зөвшөөрч тэдний үйл ажиллагааг дэмжихийн тулд саадгүй зорчих бололцоог олгох хэрэгтэй. Тиймээс барилгын политехникийн коллежийн барилгын хүртээмжийг дээшлүүлсэн эерэг үр дүнтэй гарснаар цаашид ижил төстэй барилгуудын ашиглалтыг сайжруулж хүн бүрт хүртээмжтэй бий болгох талаар судалгаагаар үргэлжлүүлж хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлнэ.

Ном зүй:

- [1] Үндэсний статистикийн хороо 1212.mn
- [2] Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм БД 31-112-11
- [3] Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц. 2007 он.
- [4] БД 31-01-04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль
- [5] С.Юмчин, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон гудамжны орон зайн судалгаа.
- [6] MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин.
- [7] М.Алтансүх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирал
- [8] “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагаа” мэдээллийн лавлах, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам
- [9] Монголын барилгыг нэгдсэн портал Барилга. МН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ХАМРУУЛАН СУРГАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ

Магистр Б. Дэлгэржаргал¹
¹СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн багш

Түлхүүр үг

Хамран сургалт, хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ

Удиртгал

Хөгжиж буй улс орнуудад оршин буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал хүнд, ээдрээтэй асуудал бөгөөд олон бэрхшээл саад тулгардаг. Тэдний ихэнх нь ядуу бусдын тусламж шаардсан байдаг. Нийт хүн амын 10 гаруй хувийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж байгаа бөгөөд тэдний 98 орчим хувь нь огт анхаарал халамжгүй байгаа гэж ДЭМБ үзэж байна. Сүүлийн 20 жилийн нийгмийн бодлогын шинэ чиглэл, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн амьдралд оролцох, хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхах үзлийг таслан зогсоох явдал хэмээн тодорхойлогдож байна.

Хүн төрөлхтний түүхийн хөгжлийн бүхий л үеүдэд, нийгмийн аль ч давхарга, газар нутаг, улс үндэстэн, баян ядууг ялгахгүй оршиж, хөгжлийн янз бүрийн шатыг даван туулж, тухайн оршин амьдарч буй нийгмээрээ ямагт дутуу үнэлүүлсээр ирсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлуудын нэг болох сурч, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нийгмийн ажлын шинжлэх ухааны үндэслэлтэй судалж буйгаараа онцлог юм. Өөрөөр хэлбэл:

Нэг талаас ХБИ хөдөлмөр эрхлэх нь улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулдаг төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улсаас олгох тэтгэмжийн зардал хэмнэгдэж ядуурлыг бууруулахад нөлөөлж буй хэрэг. Нөгөө талаас ХБИ удаан хугацаагаар хөдөлмөр эрхлэхгүй байх нь сул дорой байдлыг үүсгэж, ганцаардах, сэтгэл гутралын байдалд ордог.

Иймд ХБИ хөдөлмөр эрхлэх нь хийж буй зүйлдээ анхааран шаналгаа зовлонгоосоо ангижирч хамт олонтой болох, улмаар ердийн амьдралын хэм хэмжээнд ороход дэм болдог чухал ач холбогдолтой. Нийгмийн амьдралд оролцох явдал нь хүн төрөлхтөнд нэр хүнд, аз жаргал авчирч, хүний эрхийг хүндэлж байгаа хэрэг юм.

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурах, хөдөлмөр эрхлэхэд нөлөөлж буй зарим хүчин зүйлийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх

Зорилтууд:

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжил, ур чадвар эзэмших боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сурч, хөдөлмөрлөхөд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судлах
- ✓ Саад бэрхшээлийг илэрүүлж, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх

Судалгааны арга зүй:

Судалгааны ажлын хүрээнд нийгмийн системийн онолыг судалж нэгтгэн дүгнэж судалгаа хийсний зэрэгцээ ажиглалтын аргыг ашиглан ХБИ-ийн сургах боловсролын салбарт ажиллаж буй туршлагадаа тулгуурлан практикт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохыг зорьсон.


Судалгааны үр дүн

ХБИ-ээс мэргэжлийн талаар асуусан нээлттэй асуумжинд дийлэнхи нь өөрсдийн онцлогт тохирсон өргөн хэрэглээний мэргэжил эзэмшихийг хүссэн байна.

№	Бэрхшээлийн төрөл	Сонирхсон мэргэжил
1.	Хөдөлгөөний бэрхшээлтэй	- компьютерийн програмист - операторчин - эх бэлтгэгч - дизайнер - багш
2.	Оюун ухаан, сонсгол хэл ярианы бэрхшээлтэй / хэлгүй дүлий/	- мужаан - барилгын өргөн хэрэглээний мэргэжил - зураач, гагнуурчин - тогооч, нарийн боов

Яагаад ийм мэргэжилтэй болох шаардлагатай вэ? гэсэн асуултанд ажлын байр олдох магадлалтай, энэ чиглэлээр ажиллаж чадна гэж 65% нь хариулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжил эзэмшихэд тулгарч буй бэрхшээл:



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулахад тулгарч байгаа

бэрхшээлүүдийг тодруулахад 8 нь ХБ-ээсээ болоод суралцах боломжгүй, 22 нь хичээлдээ ирж очиход хүндрэлтэй, 22 нь сургалтанд хамрагдаж үзээгүй, 25 нь хаана хандахаа мэдэхгүй, 33 нь эрүүл хүмүүстэй харилцахад бэрхшээлтэй гэсэн нь нийгэмд ХБИ-ийн талаарх эерэг ойлголт хандлагын талаар нөлөөллийн ажлуудыг хийх, шаардлагатай байгааг харуулж байна. Дэд бүтэц бүрдээгүйгээс болж 22 хичээлдээ ирж очих хүндрэлтэй тулгардаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан сургах

№	Нөлөөлж буй хүчин зүйлүүд	
1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд:	<ul style="list-style-type: none"> - Хамт олны дунд орж нийгэмшиж найз нөхөдтэй болж тусгаарлагдахгүй болдог. - Хүүхдийн оюун ухаан хөгжиж орчиндоо дасан зохицох биеэ авч явах чадвар дээшилдэг. - Сургуульдаа явах их дуртай байдаг. - Цаашид бие дааж хөдөлмөр эрхлэж ажиллах амьдрахад гол суурь нь болж өгдөг.
2.	Багш нарын хувьд тулгарч буй бэрхшээл:	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг - Тэднийг ялгаж оношилж, үнэлгээ хийж, тэдэнтэй ажиллах аргачлалын талаар мэдлэг хоцрогдолтой - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд анхан шатны тусалцаа, сэтгэл зүйн дэмжлэг хэрхэн үзүүлэх талаар мэдлэг муутай - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйн сургалтуудад хамрагдаж чаддаггүй - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйн гарын авлага сургалтын материал хангалтгүй байдаг - Сургуулийн захиргаа болон багш нарын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хандлага, ойлголт тааруу
3.	Эцэг эхийн / асран хамгаалагч/ хувьд тулгарч буй бэрхшээл:	<ul style="list-style-type: none"> - Хүүхдээ сургуульд энгийн хүүхдүүдтэй сурч чадна гэдэгт итгэл муутай байдаг - Сургууль тийм дуртай авдаггүй - Сургуульд сурч байх үед нь багш нар тэр болгон бэрхшээлтэй хүүхдүүдтэйгээ тулж ажиллаж чаддаггүй /ачаалал/ - Эцэг эхчүүд ч гэртээ тэр болгон хүүхэдтэйгээ ажиллаж чаддаггүй /ажил/ - Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сургуульд өдөр бүр зөөж чадахгүйгээс заримдаа хамрагдуулж чаддаггүй

Хувь хүн, гэр бүл, байгууллага, олон нийтийн хоорондын харилцан холбоо, нөлөөлөл нь аливаа хувь хүний амжилттай, өсөн дэвжих, амжилтгүй байхын гол шалтгаан болдог гэж үздэг. Ийм учраас тухайн системийн дотоод, гадаад орчинтой хувь хүний харилцах холбооны мөн чанараас түүний амжилт төдийгүй нийгэмд дасан зохицоход итгэл үнэмшлийн хөгжил хамаардаг гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.


Нийгмийн оролцоо гэдэг нь нийгмийн аливаа үйл ажиллагаанд хамрагдаж, оролцох үйл явц юм.

Зорилгот үйлийн хязгаарлалт гэдэг нь тухайн хувь хүн зорилгот үйлийн гүйцэтгэх явцад бэрхшээл учрахыг хэлнэ.

Нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдал нь тухайн хувь хүн нийгмийн ямарваа нэг үйл ажиллагаанд оролцоход хүндрэл бэрхшээл учрахыг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан сургах нь нийгмийн ажлын үйлчилгээний нэг систем болох нь:

Системийн онолыг Ф. Бертиланфи 1971 онд ерөнхий системийн онолоос нийгмийн ажлын шинжлэх ухаанд оруулсан гэж үздэг. Системийн онолыг гэр бүл, бүлэг, нийгэм гэх мэт нийгмийн системүүдэд ашигладаг. ХБИ-ийн хэрэгцээний асуудлыг томоохон систем, тогтолцооноос ангид авч үзэж болохгүй юм. Систем хувь хүн бүрийн



Схем 2. Амьдралын үйл ажиллагааны бүтэц, тэдгээрийн харилцан үйлчлэл¹

¹ Ишикура.К, Исава. Ш, Батцэнгэл. Г, /2010/ “ХБИ – тэй хүүхэдтэй ажиллах онол арга зүйн зарим асуудал”

хүрээлэн байгаа орчны нэгэн хэсэг болж өгдөг. Нийгмийн системийн онол нь ХБИ-ийн сурч боловсрох арга зам, хамруулан сургах хэрэгцээг тодорхойлох аргачлал болно. Нийгмийн системийн онолын үндсэн үзэл санаа нь ямар нэг зүйлийн нэгдэл биш, харин зан байдал, харилцаа холбооны нэгдлийг илэрхийлж байдаг. Аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд нийгмийн ажилтнууд түүний мөн чанар, тогтолцоог ойлгох нь хамгийн чухал байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах сөрөг хандлагын нэг жишээ нь ХБИ-ийг суралцах, мэргэжил боловсрол эзэмшихэд учирч байгаа саад тотгор юм. Сөрөг хандлагууд нь аль ч системээс илэрч болох бөгөөд эцэг эхчүүд, нийгмийн бусад гишүүд, сургууль, багш нар түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс өөрсдөөс нь илэрч байна. Гэр орны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийнхэн өөрсдийгөө доогуур үздэг тул нийгмийн харилцаанаас зайлсхийж тэр нь өөрсдийгөө нийгмээс тусгаарлахад шууд хүргэдэг. Эдгээр сөрөг хандлагыг даван туулах нь ихээхэн сорилт бэрхшээлийн туулдаг бөгөөд хамруулан сургах сургалтыг дэмжих хамгийн чухал зүйл юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрон мэргэжил эзэмших асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлын үүсэх болсон шалтгаан, нөхцөл, түүнээс гарч болох үр нөлөөг тооцон шийдвэрлэхийг нийгмийн системийн онолын үзэл баримтлалаар тайлбарлахыг зорилго.

Пинкус ба Минахан нар хүмүүсийн амьдралд дараах системүүд чухал үүрэгтэй гэж үзжээ. Үүнд:

- Албан бус буюу натурал систем /гэр бүл, найз нөхөд, айл хөрш, хамт ажиллагсад /
- Албан ёсны систем /олон нийтийн бүлэг, эвслүүд/
- Нийгмийн систем /эмнэлэг, сургууль/

Хүснэгт 1. Хүндрэлтэй асуудалтай тулгарсан ХБ-тэй хүмүүс эдгээр системээ ашиглаж чадаагүй байж болно.

Системүүд		ХБИ-ийн хувьд	
Албан бус буюу натурал систем	гэр бүл, найз нөхөд, айл хөрш, хамт ажиллагсад	Энэ системүүд нь амьдралд байхгүй юмуу, байлаа ч гэсэн шаардлагатай нөөц бололцоо байхгүй, тэдний хүндрэлтэй асуудалд тохирохгүй байж болно.	Эдгээр системүүд нь ихэнхэд нь байхгүй эсвэл
Албан ёсны систем	олон нийтийн бүлэг, эвслүүд	Системийн барьж байгаа бодлого нь үйлчлүүлэгч нар өөр шинэ хүндрэлтэй асуудлуудыг бий болгож байж болно.	тэдний хүндрэлтэй асуудалд тохирохгүй байж болно.
Нийгмийн систем	эмнэлэг, сургууль	Системүүд бие биетэйгээ зөрчилтэй байж болно.	

Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгч болон түүний орчин хоёрын харилцаа холбоо нь хаанаа хүндрэлтэй асуудал гараад байгааг олж харахыг хичээдэг. Түүнээс үйлчлүүлэгч юмуу систем нь ямар нэг хүндрэлтэй асуудалтай гэж үзэж болохгүй. Зөвхөн тэд хоорондоо харилцсанаар хүндрэл гарч ирнэ. Иймээс гол зорилго нь ХБ-тэй хүмүүсийн өөрсдийн амьдрах үүргээ биелүүлэх, стрессийг багасгах, мөн үйлчлүүлэгчид нэн чухал байгаа зорилго, үнэт зүйлст хүрэх явдал юм. Нийгмийн ажилтнууд ХБ-тэй хувь хүний хүндрэлтэй асуудлыг нийтийн асуудалтай хэрхэн холбогдож байгаад анхаарах хэрэгтэй. Тэд хувийн асуудлаас гарах үр дагавартай ажиллахаас гадна нийтлэг асуудлууд дээр хувь хүнд нөлөөлөх үйл ажиллагаа явуулдаг. Нийгмийн ажилтны үүрэг нь:

- ХБ-тэй хүмүүст хүндрэлтэй асуудлаас шийдэх өөрийн чадавхийг ашиглах, түүнийг сайжруулахад туслах. Жишээ нь: гэр бүл дэх харилцаагаа сайжруулахын тулд өөрийнхөө өдөр дутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар эзэмших
- ХБ-тэй хүмүүсийг тэдний нөөц бололцоотой холбож өгөх. Жишээ нь: Саяхан ХБ-тэй болсон хүнд Хөдөлмөр халамж

үйлчилгээний газар дээр очихдоо сэтгэл хангалуун байх, ХБ-тэй гэдгээсээ болоод хүлээж авахгүй байх гэж бодолгүйгээр өөрийгөө хүлээж авахуйцаар болгоомжтой танилцуулахад нь туслах

- Хүмүүс болон ХБ-тэй иргэдийн нөөц бололцооны системийн хоорондын уялдаа холбоог сайжруулах
- Тухайн нөөц бололцооны хүрээнд хүмүүс хоорондын харилцааг сайжруулах
- Нийгмийн бодлого боловсруулах, түүнийг өөрчлөхөд туслах
- Практик туслалцаа үзүүлэх
- Нийгмийн хяналтыг хэрэгжүүлэх гол агент болж ажиллах

Пинкус, Минахан нар нийгмийн ажлын үндэс болсон 4-н системийг гаргаж ирсэн. Нийгмийн ажилтан нь тухайн үйлчлүүлэгч аль системд хамрагдаж байгаад дүн шинжилгээ хийх нь нийгмийн ажлыг улам тодорхой болгож өгдөг.

Хүснэгт 2. Системд хамрагдаж буй байдал

Систем	Тодорхойлолт	Нэмэлт мэдээлэл
Өөрчлөлтийн агент систем	Нийгмийн ажилтнууд болон тэдний ажилладаг байгууллагууд	
Үйлчлүүлэгч систем	Өөрчлөлтийн агент системээс тусламж дэмжлэг хүссэн ХБ-тэй хувь хүн, бүлэг, гэр бүл, орон нутаг /олон нийт/	Жинхэнэ үйлчлүүлэгч гэдэг нь тусламж авахыг хүлээн зөвшөөрсөн холбоотой ажилладаг ХБ-тэй хүмүүс юм. Болзошгүй үйлчлүүлэгч гэдэг нь ажилтан тэдэнтэй холбоо тогтоохыг оролдож байгаа хүмүүс
Зорилтот бүлэг	Өөрчлөлтийн агент систем нь зорилгодоо хүрэхийн тулд өөрчлөхөөр ажиллаж байгаа ХБ-тэй хүмүүс	Үйлчлүүлэгчийн болон зорилтот бүлгүүд нь нэг бүлэг ч байж болно, ижил биш ч байж болно.
Үйл ажиллагааны систем	Өөрчлөлтийн агент систем нь зорилгодоо хүрэхийн тулд хамтран ажиллаж байгаа төрийн болон ТББ, олон нийт	Үйлчлүүлэгчийн, зорилтот болон үйл ажиллагааны бүлгүүд нь нэг ч байж болно, ижил биш ч байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тааламжтай нийгмийн орчныг бүрдүүлхийн тулд хөршийн холбоо, бүлэг, олон нийтийн харилцаа, нийгмийн системүүдийг өөрчлөх шаардлага гардаг. Энэ үүргийг нийгмийн ажилтан гүйцэтгэхийн тулд 3-н гол асуудлыг анхаардаг. Үүнд: нийгмийн асуудал, бодлогод дүн шинжилгээ хийх, олон нийт бүлгийн хэрэгцээ шаардлагыг идэвхижүүлэх, нийгмийн нөөц баялгийг хөгжүүлэх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ:

- **Зуучлах:** Нийгмийн ажилчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага, нөөц боломжийг тодорхойлж улмаар түүнд тохирсон зуучлалын үйлчилгээг үзүүлнэ. Жишээ нь: ажил хөдөлмөр, мэргэжил ур чадвар эзэмших сургалт гм.
- **Нөлөөлөх:** Нөлөөлөл нь эерэг өөрчлөлт гаргах зорилгоор хийж байгаа үйлдэл юм. Нөлөөллийн үүрэг нь хувь хүн, бүлэг, олон нийтийн тусын тулд нийгмийн шударга ёсыг тогтоох, хадгалах, хамгаалхын төлөөх үйл ажиллагаанд тэднийг төлөөлөх, хамгаалах, дэмжлэг үзүүлэх, тэдний өмнөөс санал болгох үйл ажиллагааг багтаадаг.
- **Сургах:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх, улмаар өөрсдийн ахуй амьдралаа сайжруулахад шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшүүлэхэд энэ үүрэг чиглэгддэг. Жишээ нь: ХБ-тэй хүмүүст ажил амралтаа хэрхэн зөв зохицуулахад сургах, зан байдлаа өөрчлөхөд нь туслах, биеэ зөв боловсон авч явах, нийгэм хамт олны харилцаанд сургах гм.
- **Зөвлөгөө өгөх:** ХБ-тэй хүмүүст аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх, ахуй амьдралаа сайжруулахад шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшихөд энэ үүрэг чиглэгдэнэ. Хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн нийгэм сэтгэл зүйн үйл ажиллагааг дэмжих сайжруулах зорилгоор нийгмийн ажлын практикын бүх түвшинтэй хослон хэрэгжинэ хэмээн тодорхойлжээ. Энэ үүргийн хүрээнд нийгмийн ажилтан ХБИ-ийг хамруулан сургах сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд дараах үйлчилгээг үзүүлнэ.

- ✓ Мэргэжил ур чадвар эзэмших сургалттай холбогдох мэдээлэл өгөх
- ✓ Ажилтанд хүрэхэд нь туслах зөвлөгөө өгөх
- ✓ Биеэ хэрхэн хамт олны дунд зөв зохистой авч явах талаар бие даасан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөгөө өгөх
- ✓ Эрүүл мэнд нөхөн сэргээлтийн зөвлөгөө өгөх
- ✓ Гэр бүл нийгэм хамт олонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн суралцах нөхцөл байдлыг сайжруулах, адил тэгш эрхтэй байх талаар зөвлөгөө өгөх
- **Кейс менежерийн үүрэг:** Хувь хүн, гэр бүл нийгмийн хэрэгцээг хангахад чиглэсэн нийгмийн үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа, кейс менежерийн үүрэг нь хоёр загвараар хэрэгждэг.
- **Өөрчлөх үүрэг:** Хувь хүний тааламжтай нийгмийн орчныг бүрдүүлхийн тулд хөршийн холбоо, бүлэг, олон нийтийн харилцаа, нийгмийн системүүдийг өөрчлөх шаардлага гардаг.
- **Идэвхжүүлэх үүрэг:** үйлчлүүлэгчийн өмнө тулгарсан аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд хувь хүн, бүлэг, олон нийтийг хөдөлгөөнд оруулах, идэвхжүүлэх, тэдгээрийн хамтын хүч бололцоог ашиглах, нийгмийн баялаг нөөцийг хөдөлгөөнд оруулснаар шаардлагатай санхүүгийн болон хүн хүчний, мэдээллийн, эрх мэдлийн болон бусад нөөцийг бүтээх ёстой.
- **Холбох үүрэг:** Энэ үүргийн гол зорилго нь үйлчлүүлэгчийг түүнд шаардлагатай нийгмийн үйлчилгээ болон бусад нөөц боломжтой холбох, нийгмийн орчинтойгоо харилцахад нь туслах асуудлыг онцлон авч үздэг. Нийгмийн ажилтан нь энэ үүргийн дагуу үйлчлүүлэгчид нөхцөл байдлын үнэлгээ хийж, хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардлагатай нөөц боломжийг олж авах, үйлчилгээнд хамрагдахад нь тэдэнд тусалдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамруулан сургалтыг дэмжихэд нийгмийн ажилтан энэ үүргийн дагуу тэдний нөхцөл байдалд байнга үнэлгээ хийж байх бөгөөд үр дүнтэй хэрэгжиж буй төрөл бүрийн үйлчилгээ болон төсөл хөтөлбөрийн талаар маш сайн мэдлэгтэй байх ёстой.
- **Судлах, оношлох үүрэг:** Үйлчлүүлэгчид тулгарсан асуудлын талаар мэдээлэл

цуглуулж дүн шинжилгээ хийх, үйлчилгээ хүргэх явцад тооцоолоогүй болон тооцоолсон хүчин зүйлүүдийн нөлөөллийг байнга үнэлж дүгнэх, гүйцэтгэлийн чанараа сайжруулахад судалгаа, үнэлгээ хийх, үйлчилгээгээ төгсгөхдөө үйлчлүүлэгч болон түүний орчинд гарсан үр нөлөөг судлах ёстой байдаг.

- **Санаачлах үүрэг:** Нийгмийн ажилтан байнга шинийг эрэлхийлэгч байх ёстой ба нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд байнга шинийг санаачилж төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байх хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

1. Гэрэлтуяа.Ц, /2005/, Бүх нийтийн сургууль /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулах нь/
2. ДЭМБ, ОУХБ, НҮБ-ын БСШУБ. /2004/ “Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хандлага”
3. Ишикура.К, Исава. Ш, Батцэнгэл. Г, /2010/ “ХБИ – тэй хүүхэдтэй ажиллах онол арга зүйн зарим асуудал” Улаанбаатар
4. Нийгмийн хөгжлийн төв, “Нийгмийн ажлын сургалтын гарын авлага” УБ 2006 он
5. МУБИС., Нийгмийн ажлын тэнхим., Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага., УБ,2000он
6. Мягмар.О, Цэндсүрэн.Т, Нямдорж. М, Нямсүрэн. Б, Нарангэрэл.Я,2002 он “Нийгмийн ажлын практик аргууд” Улаанбаатар
7. Нийгмийн ажлын үйлчилгээ БНА-ын гарын авлага, 2009 он
8. “Тэгш хамруулан сургагч багш” бэлтгэх сургалтын арга зүй, УБ 2008он
9. “Хүүхэд ба хууль ёс” нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага, УБ2008он
10. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа” Д.Бямбаа, Д.Жанцан 2010 он
11. “Disabilitu, Povertu and develorment” DFID, 2000
12. Болор.Б, “Тахир дутуу хүмүүсийг НХОТСЗ нь”. УБ.,2000 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Б.Одончимэ

ҮНДЭСЛЭЛ

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилгоор 1995 онд Хөгжлийн 12 бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг баталж, уг хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ, тэдэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт олгох хууль эрх зүйн суурийг бий болгосон. 2009 онд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг соёрхон баталснаас хойш хууль эрх зүйн орчин конвенцийн үндсэн зарчимд нийцэхгүй, тэднийг зөвхөн халамж, хамгаалал хүртэгч, нийгмийн идэвхгүй гишүүн мэтээр хардаг байв.

2016 оны 2 дугаар сард шинэчлэн баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дээрх нөхцөл байдлыг эвдэж, нийгмийн идэвхтэй гишүүн болохын тулд үндсэн эрхээ эдэлж, эрхэм зэргийг хүндэтгэсэн, хөгжих боломж олгосон хууль болсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудлууд болох нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, хэрэгцээ, шаардлагыг нь хангасан байдлаар төлөвлөж, барьж байгуулах, тэдний ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг нь сайжруулах арга хэмжээг хуульчлан заасан болно.

Түүнчлэн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх асуудлыг боловсронгуй болгох зохицуулалтыг мөн тусгасан болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, бүртгэх, сэргээн засах үйл ажиллагааг хуульд тодорхой заагаагүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэгдсэн тоо байхгүй, Үндэсний статистикийн хороо

болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар гаргасан статистик мэдээллүүд хоорондоо зөрөөтэй байдаг. 2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бусдын адил эдэлж нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлсэн томоохон баримт бичиг болсон юм. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци болон түүний нэмэлт протоколд 2008 онд нэгдэх тухай хүсэлтээ гаргаж, 2009 онд нэгдэн орсон. Нэмэлт протоколд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хувь хүн болон байгууллагаас конвенцийн гишүүн улс болох Монгол Улсын эсрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдсөн тухай гомдол хүлээн авч болох тухай заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 33-р зүйлийг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцэд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн анхдагч нэгж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх, төр, төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чиглэлээр бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд томоохон дэвшил болсон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан зорилтууд, салбар дундын болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог ханган, олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран ажиллаж ирлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын 13 Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 281 тоот тогтоолоор баталсан. Энэхүү төлөвлөгөө батлагдсанаар

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг системчлэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд нь дүн шинжилгээ, үнэлгээ хийх нөхцөл бүрдсэн юм. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй нийгэм, хүрээлэн буй орчны сорилт, ялгаварлан гадуурхах, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгмийн хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг тусгасан. Хот хөдөөгийн хөгжлийн ялгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал, ахуйд сөргөөр нөлөөлж, нийгмийн хамгааллын үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ тэгш хүртэх, хөдөлмөр эрхлэх, бие даан амьдрах зэрэг эрх нь зөрчигдөж, ялгаварлан гадуурхагдаж байна. Монгол Улсын Засгийн газар 2011 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн тухай анхны тайлангаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд хүргүүлсэн ба 2015 оны 4 дүгээр сард Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн тайланг хүлээн авч, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны 199 дүгээр уулзалтаар дүгнэлтээ гаргасан. Дүгнэлтэд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн ерөнхий зарчмууд болон конвенцийн хүрээнд хүлээсэн үүргүүдээ хууль эрх зүй, бодлогодоо тусгах шаардлагатай талаар дурдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг боловсруулах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж өгсөн нь тэдний хэрэгцээг тусгах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах, хэрэгжүүлэх тухай харилцааг зохицуулсан бөгөөд энэ нь НҮБ-ын конвенцийн зарчимд нийцсэн бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах суурь болж байгаа юм. Хуулийг хэрэгжүүлэхийн тулд холбогдох дүрэм, журам, стандарт боловсруулан асуудлыг цогцоор шийдэхэд үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулах зайлшгүй шаардлага гарсан. Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн бүх төрлийн харилцаанд бүрэн оролцох нөхцлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт,

хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд оролцуулах, дуу хоолойг нь олон нийт, шийдвэр гаргах түвшинд хүргэх шаардлага, хэрэгцээ зайлшгүй бий болж бай

СУДАЛГААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Манай улсад 2017 оны байдлаар 103.6 мянган ХБИ байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. 92.5% - 15, түүнээс дээш насны иргэн байна. Үүнээс: • 21.1% - 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. /Нийт ажиллагчдын 1.6%/ • 78.9% - 73285 хүн хөдөлмөр эрхлээгүй¹.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1. Хуулийг хэрэгжүүлэхэд ААНБ-уудад тулгардаг бэрхшээлийг илрүүлэх
2. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох
3. Холбогдох захиргааны мэдээнд дүн шинжилгээ хийх
4. Зөвлөмж боловсруулах

Судалгааны зорилго

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дах заалтын хэрэгжилтийг судлах, дүн шинжилгээ хийх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах арга замуудыг тандах. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар мэдлэг, ойлголтыг нийгмийн бүх түвшинд түгээх, төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгах, тэдэнд хүргэх үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарт бодит өөрчлөлт оруулах. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах хөдөлмөрлөх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Судалгааны зорилт

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

1. Хагжлийн бэрхшээлтэй иргэдийг суралцах нөхцөл боломжоор хангах, сурах орчныг хүртээмжтэй болгох
2. Суралцаад төгссөн иргэдийг ажлын байранд жуучлах

¹ ҮСХ-ны Ажиллах хүчний судалгаа - 2017

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах

Хөдөлмөр эрхлэлт - Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж хангалтгүй, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого дутагдаж байна. Хөдөлмөрийн тухай хуульд заасан 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах хуулийн заалтыг биелүүлээгүй тохиолдолд ноогдох торгуулийн хэмжээ хэт бага байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж чадахгүй байна. Тэднийг дэмжсэн нийгмийн хариуцлагын бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах шаардлага зүй ёсоор тулгарч байна. ҮСХ-ны 2018 оны тайланд дурдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлт дөнгөж 19.37 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аж ахуй эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн шинэ бодлого боловсруулах шаардлага гарч байна.

- Ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, тохируулгатай ажлын байраар хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажиллах орчны стандартыг боловсруулж, батлах
- Тохируулгатай ажлын байр бий болгоход “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас дэмжлэг үзүүлэх;
- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулгыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй форматаар хэвлэж, бэлтгэх;
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хүрээнд
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын стратегийг сайжруулж, шинэчилэн боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах;
- ХБИ-ийг үнэлэх, тохирох мэргэжлийг сонгох зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх;
- Сайн туршлагыг сурталчлах олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах;

- ХБИ-ийг ажилд зуучлах үйл ажиллагааг боловсронгуй болгож,
- ХБХ-т боломжит ажлын байр санал болгох нөхцлийг бүрдүүлэх;
- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, судалгаа, хөгжлийн төв байгуулах;
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын бүх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах агуулга, арга зүйг тусган боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөрт бэлтгэх механизм бий болгох / Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10-р зүйлийг хэрэгжүүлэх/;
- Хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил санал болгох, зуучлах үйлчилгээг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтын модуль, хөтөлбөр боловсруулах;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны Сургагч багш бэлтгэх;
- Хувь хүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр боловсруулах;
- Худалдаа аж үйлдвэрийн тэнхимээс гадаадад явдаг бизнесменүүдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг оролцуулах;

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖИЛГҮЙДЭЛ Төрийн бодлогод: § ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах § Хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх § Дэд бүтцийг хүртээмжтэй болгох § Төрийн, ТББ-ын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах § Группд байгаа хүн бүрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх нь өрөөсгөл тул ойлголт, тодорхойлолтыг тодруулах Ажил олгогчдод хандаж: • Ялгаварлан гадуурхахгүй байх • Цалин нэмэгдүүлэх, ажлын байрыг тогтвортой байлгах • Ажлын байранд тохируулга хийх ХБИ-ийн хувьд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг тус хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэгч буюу ХБИ-ийг квотын дагуу бүрэн ажиллуулсан болон ХЭДС-д төлбөр төлсөн байгууллагыг тооцвол 20.6 хувь, квотын хувь, хэмжээнд хүрээгүй ч тодорхой тооны ХБИ ажиллуулсан, төлбөр төлсөн байгууллагыг тооцвол 44.6 хувьтай байна. Хуулийн хэрэгжилт эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л салбарт

хангалтгүй байгаа бөгөөд тээвэр, барилгын салбарт бусад салбаруудаас харьцангуй доогуур байна. Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж чадвал 14.6 мянга гаруй ХБИ-ийг ажлын байртай болгох боломж байгаа юм. Хөдөлмөрийн тухай хуулийн тус заалтын хууль санаачлагчийн хүсэл зоригийг ААНБ-ын ажил олгогч болон төрийн байгууллагын шийдвэр гаргагчдад ойлгуулах, сурталчлах. Хуулийн хэрэгжилтийг төлбөр төлснөөр хязгаарлах биш ХБИ ажиллуулах нь давуу тал болохыг таниулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй

Дүгнэлт

Улсын хэмжээгээр 105 700 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэсэн статистик бий. Тэдний 44,4 хувь нь төрөлхийн, үлдэх хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Тиймээс цаашдаа олдмол хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх онцгой анхаарал хандуулах шаардлага байна. Хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 30 орчим хувь нь буюу 30 мянга гаруй нь ажил хөдөлмөр эрхэлж байна гэсэн судалгаа бий. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-д 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулна гээд заачихсан байгаа. Энэ заалтыг биелүүлээгүй бол сар бүр ажлын байрны төлбөрийг ХЭДС-д төлөхөөр заасан. Гэвч хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалтгүй. Тодруулбал судалгаагаар 25-аас дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж байгууллага 5230 байгаагаас 39,4 хувь нь буюу 2061 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна. Эдгээрийн 41,9 хувь нь буюу 863 нь хуульд заасан квотын дагуу, үлдсэн нь хуульд зааснаас цөөн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Цөөн хүн ажиллуулдаг болон огт авч ажиллуулдаггүй 4367 аж ахуйн нэгж байгууллагын 300 орчим нь хуулийн дагуу ажлын байрны төлбөрийг ХЭДС-д төвлөрүүлдэг нь жилдээ 1,0 тэрбум орчим төгрөг болдог юм. Тус сангийн дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан ажиллуулж жилдээ 4,0 гаруй тэрбум төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд зарцуулдаг. Гэтэл орон нутгийн зарим удирдлага төсвийн боломжгүй

байдлаас шалтгаалаад хуульд зааснаар ажлын байрны төлбөр төлж чаддаггүй гэсэн тайлбар хэлж байна билээ. Ажлын байрны төлбөр төлүүлэхэд биш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын тогтмол ажлын байраар хангах, тэднийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь таарсан хүртээмжтэй орчныг бий болгох, ажил олгогч, олон нийтийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэхийг зорих шаардлагатай байна.

Зөвлөмж

Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, татварын болон ХЭДСгийн урамшууллыг сурталчлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Мөн тохируулгатай ажлын байр бүрдүүлсэн тохиолдолд гаргасан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах. Хуулийн тус заалтын хэрэгжилттэй холбоотой захиргааны тоон мэдээллийн загвараар хандлагыг улирал бүр гаргаж, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах. ХБИ ажиллуулах квотыг ХБИ ажиллах боломж, бололцоог харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоож болох боломжийг нарийвчлан судлах. ХБИ-ийн бүртгэл, хөдөлмөр эрхлэх чадавхийг зөв тодорхойлсон мэдээллийн санг хөгжүүлэх, чадавхийг сайжруулсан сургалтыг зохион байгуулах. ХБИ-ийг хөдөлмөрт зуучлах ажлыг эрчимжүүлэх, энэхүү ажилд мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг уялдуулах.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Д.Энхжаргал¹, Н.Баяртуяа¹, Б.Батбаяр¹

¹Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн багш

Сэдвийн үндэслэл:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар судлах, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон бусдад мэдээлэх, ерөнхий боловсролын сурагчдад мэргэжил сонгох болон эрэлттэй мэргэжлийн талаар мэдээлэл өгөх, ажлын байранд гарсан ХБИ-д ажлын байранд эдлэх ёстой эрх, үүргийг таниулахын тулд энэ сэдвийг сонгосон болно.

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг судлан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжил сонголтын тухай мэдээлэл өгөх.

Зорилт:

- ХБИ-ийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль, эрхийн тухай хуулийг судлах
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны инситуаас гаргасан ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистик судалгаатай танилцах
- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа авах санал асуулга хийх.
- Санал асуулга дээр тулгуурлан дүгнэлт гаргах

Онолын хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг. Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг

дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн. Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, тусалцаа үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгасан. Тухайлбал:

Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах;

Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулинд монгол иргэдийг авч ажиллуулж буй гадаад орны аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн нөхцөлд Монгол Улсын иргэн гадаад улсад хөдөлмөр эрхэлж байхдаа хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрэн алдсан тохиолдолд ажил олгогчоос ажилтанд олгох төлбөр, тэтгэмж, нөхөн төлбөрийн хэмжээг тусгах заалтыг шинээр нэмж оруулсан нь гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжийг дээшлүүлэх;

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хараагүй ажилтан эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийг орлогыг албан татвараас чөлөөлөх, 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн

нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийн хандивыг тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцож байх;

ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийн хуулиас:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт

8.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж түүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлүүлнэ.

8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг хориглоно.

8.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний ажлын цагийг Хөдөлмөрийн тухай[2] хуулийн 71.5-д заасны дагуу богиносгож болно.

8.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хараагүй хүнийг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг

Засгийн газар батална.

8.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд цалин хөлс авч байгаа гэсэн шалтгаанаар нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг нь зогсоохыг хориглоно.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ

8.1.Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

8.3.Төрийн байгууллага нь нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба холбогдох зардлыг улсын төсөвт тусгана.

8.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

НИЙТ 3963 ААНБ
нийт **7 199** ХБИ ажиллаж байна


25 түүнээс дээш ажиллагчидтай
2 061 ААНБ

25-аас доош ажиллагчидтай **1 908**
ААНБ

4 921 ХБИ ажиллаж байна.

2 278 ХБИ ажиллаж байна

- 25-аас дээш ажилтантай нийт ААНБ ын нийт ажиллагчдын тоо **4886** мянга
- Хөдөлмөрийн тухай хуулийн 1111 дэх заалтын дагуу ХБИ ажиллах боломжтой орон тоо **19544**
- ХБИ ажиллаагүй орон тоо **14623**



ХБИ-ийг ажиллуулсан байгууллага:

Сул тал

- 19.7% - Ажлын байрны тохируулга хийх
- 15.5% - Ажлын ачаалал даах чадвар муу
- 12.7% - Хурд удаан, бүтээмж бага
- 9.9% - Мэргэжлийн ур чадвар хангалтгүй, аргэрийн асуудал
- 5.6% - Үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй, тогтвортой ажиллах хүсэлгүй

Давуу тал

- ✓ 62% - Хуулиа сахин биелүүлэх
- ✓ 59.2% - ХБИ тогтвортой ажилладаг
- ✓ 54.9% - Нийгмийн хариуцлагаа ухамсарлах
- ✓ 53.5% - Хүний нөөцөө хангах
- ✓ 26.8% - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог дэмжих, хамгааллыг сайжруулах хүрээнд бодлого, эрх зүйн орчноо сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч яг амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй маш цөөхөн хүмүүс ажил эрхэлж байна. Ажлын байрандаа эсвэл

тухайн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авъяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх талаар байгууллагын албан тушаалтан, эрх бүхий хүмүүс тэр бүр хэрэгцээ шаардлагыг хангаж чаддаггүй. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байраар хангаснаар тухайн байгууллага ямар, ямар хөнгөлөлт эдлэх вэ? гэдгийг таниулах, давуу талуудыг ойлгуулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

Ном зүй

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний “Нийгмийн хамгааллын хууль” шинэчилсэн найруулга
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ БАЙНГЫН ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙРТАЙ БОЛГОХОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ИЛРҮҮЛЭХ, ХОЙШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Б.Гүнжилмаа¹, Г. Осоржалам¹, М. Чулуун-Эрдэнэ²

¹Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес Инкубатор төв, 96610239

ТҮЛХҮҮР ҮГ

Ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олгогч, мэдлэг, чадвар, дадал

ХУРААНГҮЙ

Бид хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тулгуурлан ажил олгогчийн эрэлтэд нийцхүйц хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг бэлтгэж тэдний хөдөлмөрлөх эрхийг хангахад нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлд анализ хийн тулгамдаж буй асуудалд тулгуурлан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний хөтөлбөр” түүнийг хэрэгжүүлэх зааварчилгааны хамт боловсруулан улмаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулахыг зорин судалгааг хийж гүйцэтгэлээ. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжүүдийн нийт ажилчдийн тоо 488,6 мянга байхад хөдөлмөрийн хуулийн 111 дэх заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжтой ажлын байр 19544 байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй ажлын байр 14623 байгаагийн шалтгааныг тодруулах асуумжийг 2018-2019 онд ажлаас халагдсан 100 ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс асуулаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 50 аж ахуйн нэгжийн хүний нөөцтэй ярилцлага хийж тандалтын судалгаа хийлээ. Цуглуулсан өгөгдөл дээр үр дүнгүй ажил зуучлалын хүчин зүйлийн хамаарлыг хамруулан анализ хийлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд зуучлахдаа бүртгээд шууд ажилд зуучилж байгаа нь судалгаанд оролцогч талуудын аль, алинд нь хүндрэл учруулж ажлын байраа хадгалж чадахгүй шалтгаан болж байна. Ажилд зуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шинэ ажилдаа очиход ажил олгогч болон хамт олон нь түүний онцлог байдал, мэдлэг, чадвар, ажлын байрны тохируулга, харилцаа хандлагын талаар ямарч мэдээлэлгүй байдаг нь хэн, хэнд нь тааламжгүй сэтгэгдэл үүсгэдэг ба бодит бус хүлээлтийг бий болгодог. Хөгжлийн

бэрхшээлтэй ажилтан ажлын байран дээр тулгамдаж буй асуудлаа яаж шийдвэрлэх арга замаа олохгүйн улмаас өөрт байгаа мэдлэг, чадвараа гаргаж чадалгүй шантрах нь олон байна.

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн Конвенц, нэмэлт протоколд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрч, тэгш боломж бүрдүүлэх талаар тэмдэглэсэн байдаг ба Монгол улс энэ конвенцид 2009 оны 5-р сарын 13нд нэгдсэн орсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчныг бүрдүүлэхэд бүх талуудын идэвхитэй хамтын ажиллагааг дэмжих асуудлыг Дэлхий нийтийн Тогтвортой хөгжлийн зорилтод /2015-2030/ онцгойлон дурьдсан байдаг.

Түүнчлэн, Ази номхон далай бус нутгийн Төр засгийн тэргүүн нарын чуулга уулзалтаар “Эрхийг бодит болгоё” стратеги /Инчеон стратеги 2013-2022 он/ батлагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх талын эрхийг хамгаалахад Ази номхон далай бус нутгийн улс орнуудын Засгийн газрын үүрэг амлалтыг бодитой болгох чиглэл гарсан.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ” хуулийн 5-р бүлэгт² “Хөгжлийн бэрхшээлтэй хүний” хөдөлмөр эрхлэлтийн тухай асуудлыг тусган хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрыг дэмжих үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг 2018 оны 9-р сарын 04 дугаар 128-н тоот тушаал зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн эрх зүйн орчин бий болсон байна.

Монгол улсад 105,730 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагаас 18 мянга орчим нь буюу 16% төр, төрийн бус, хувийн хэвшил, ба өөрөө өөртөө ажлын байр гарган ажиллаж байгаа тэдний 1% нь албан ёсоор байнгын ажлын байраар хангагдаж байна.

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зуучлалын асуудал туйлын хангалтгүй байгааг харуулж байна. Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрт зуучлахдаа хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ огт үзүүлэлгүй шууд зуучлаад, зуучлагдсан 20 хүн тутамын 16 нь ажлын байрандаа тэнцэхгүй, эрүүл мэндээр тэнцээгүй гэсэн шалтгаанаар халагдаж байгаа ба хийсвэр зуучлал хийгддэг нь дараах шалтгаануудаас үүдэлтэй билээ. Үүнд:


- А. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн үндэсний хэмжээний судалгаа байхгүй.
- Б. Хөдөлмөрийн нөхөн сэргээлт хийгддэггүй.
- В. Хөдөлмөр зуучлал амжилттай, бодитой байх, үндэс болсон хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээг зөвхөн тав хоногийн сургалтаар хийдэг, хугацаа хэт богино учир зуучлал үр дүнгүй хий хоосон үргүй зардал гардаг.
- Г. Мэргэжлийн нөхөн сэргээлт буюу богино хугацаанд мэргэжил олгох сургалтыг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ, хөдөлмөрийн нөхөн сэргээлт гэж тооцон алдаатай бодлого хэрэгжүүлдэг.
- Д. Хөдөлмөр зуучлалын үйлчилгээг бүх хүнд ижил түвшинд үзүүлдэг ангилал байхгүй.
- Е. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн хэлбэрт тохирсон хөдөлмөрт бэлтгэх, зуучлах, хөдөлмөрийн нөхөн сэргээлт хийх арга аргачилал байхгүй зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хэлбэрээр, 2018 он

ХБ хэлбэр	Улсын хэмжээнд		УБхот	
	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь
Бүгд	103,630	100	34 246	100
Хараа	11,071	10,6	3,068	8,9
Хэл Яриа	4,228	4,0	1,588	4,6
Сонсгол	8,554	8,2	2810	8,2
Сэтгэц	19,733	19,0	6,093	17,7
Хавсарсан	7,842	7,5	3,502	10,2
Хөдөлгөөн	20688	19,9	6,093	17,7
Бусад	31,514	30,4	11,547	33,7

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.0 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 69.3 мянга буюу 66.9 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна.

ХБ хөдөлмөрийн насны 19974 хүн



Эх сурвалж: ҮСХ-ны Ажиллах хүчний судалгаа – 2018

Сэдвийн судлагдсан байдал

Энэ сэдэв нь Хөгжлийн Бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт гэсэн ерөнхий нэрийн дор Хөгжлийн Бэрхшээлийн хэлбэрүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн чадвар алдалт, хөдөлмөрийн зах зээл гэсэн чиглэлээр сүүлийн 2 жилд дараах байдлаар судлагдсан байна.

Үүнд:

- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй ажилгүй иргэдийн логистик завгар: Ш.Ариунболд, Урангоо, Н. Хүрэлчулуу 2017
- ✓ Хөдөлмөрийн чадвар алдалтын өвчлөлын судалгаа: Ц.Цэнд аюуш 2017
- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний хөдөлмөр эрхлэлт, тулгамдаж байгаа асуудал: Г. Намуун, Б.Санжаа, Г.Хүслэн 2018
- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудал: Б.Мөнх үндэс, Б.Анхзаяа 2018
- ✓ Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудал: Оюунсүрэн 2018
- ✓ Монгол улсын ХБИ эдийн засгийн эрхийг үнэлэх судалгаа: Тэгш нийгэм ТББ, Европын холбоо, AIFO 2018

Судлагдсан байдлаас үзэхэд ажлын байр хадгалах, тогтвортой ажлын байр бий болгох, хөдөлмөр зуучлалыг үр дүнтэй болгох чиглэлээр судлагдаж байгаа нь цөөхөн байна.

ЗОРИЛГО

Хөгжлийн Бэрхшээлтэй хүнд үр бүтээлтэй ажил олгогчийн эрэлтэд нийцсэн мэдлэг, чадвар дадал эзэмшүүлэн, тогтвортой, байнгын ажилын байрыг бий болгох хүчин зүйлийг судлаж хойшд авах арга хэмжээг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

ЗОРИЛТУУД

1. Албан статистик мэдээлэлд анализ хийх
2. Хөгжлийн Бэрхшээлтэй хүний ажлын байр тогтвортой биш байгаа шалтгааныг тодорхойлох.
3. ААН байгуулалгуудаас яагаад Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэнийг ажилд авч ажиллуулахгүй байгааг тодруулах
4. Ажил олгогч болон ажлаас халагдсан Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн нөхцөл байдлыг уялдуулан шалтгааныг гаргаж, хойшд авах арга хэмжээг тодорхойлох.

МАТЕРИАЛ, СУДАЛГААНЫ АРГА:

- ✓ 2018- 2019 оны 7-р сар хүртэл хугацаанд ажил хийж байгаад ажлаасаа гарсан 100 Хөгжлийн Бэрхшээлтэй хүний ажлаас гарсан шалтгаан, ажил эрхэлж байсан хугцааг асуумжийн аргаар тодруулсан
 - ✓ 2018- 2019 оны 7-р сар хүртэл хугацаанд ажиллаж байсан Хөгжлийн Бэрхшээлтэй ажилтан нь ажлаас гарсан 30 байгууллага, огт Хөгжлийн Бэрхшээлтэй хүн ажилд аваагүй буюу хөдөлмөрийн хуулийн 111-ийн хэрэгжилтийг хангаагүй 20 байгууллагийн захирал болон хүний нөөцийн менежерээс ярилцалгын аргаар яагаад ХБ хүн ажилд аваагүй байгаа шалтгааныг тодрууллаа
- Энэ нь тогтвортой ажлын байртай болж чадахгүй байгааг судлах судалгааны ажлын үндэслэл болж байна.

Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэнийн хөдөлмөр эрхлэлт болон орлогын төрөл

Үйл ажиллагааны хэрэгжилт Үндэсний статистикийн хорооны 2018 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 1974 хүн хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 73285 байна. “Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад:


- ✓ 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч
- ✓ 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч
- ✓ 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч
- ✓ 1.6 хувь нь ажил олгогч
- ✓ 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад

буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бусаар ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байна.


ҮР ДҮН

Хөдөлмөр эрхэлж байсан ажил хайгч 100 хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилласан хугацаа



Садалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 66,8 хувь нь 1 жил хүртэл ажиллаж байгаа харахад тэд ажлын байраа удаан хадгалж чаддаггүй байна шалтгааныг дараагийн зураг харуулна.

Зураг: 4 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажлаас гарсан шалтгаан



2018-2019 оны 7-р сар хүртэл хугацаанд ажлаас гарсан 100 хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлаас гарсан шалтгаан

Аж ахуйн нэгж байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд ажилд аваагүй байгаа шалтгаан



Хөдөлмөрийн хуулийн 111-р заалтын хэрэгжилтыг хангаагүй 50 аж ахуйн нэгжийн хүний нөөцийн менежертэй хийсэн ярилцалга. Эх үүсвэр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бизнес инкубатор төв :2019 9-р сар

“Хөгжлийн Бэрхшээлтэй Хүнийг байнгын тогтвортой ажлын байртай болгоход тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, хойшид авах арга хэмжээг тодорхойлох” судалгаанаас өнөөгийн байдлаар дээрх үр дүн харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцогчид ажил олгогчид болон ажлаас гарсан, ажил хайгч Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэн байсан.

- ✓ Ажил хайгч Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүс ажлаас гарсан шалтгаанаа олонх нь буюу 30% нь хамт олонтойгоо тохиромж муутай байсан гэж хариулсан байхад нөгөө талаас ажил олгогч 22% нь харилцахад хүндрэлтэй байсан гэж хариулсан байгаагаас үзэхэд тэднийг асуудлаа хамтдаа шийдхэд туслах хөтөчгүй, ажилд орхоос нь өмнө шаардлагатай мэдээллийг аль, аль нь авч харилцан ойлгоцоогүйгээс Хөгжлийн Бэрхшээлтэй ажилтан ажлаас гарах шалтгаан болсон байна.
- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй хүн ажлаас гарсан шалтгаанаа ажлын байрын тохируулгагүй учир хэцүү байсан гэж 23% хариулсан харин нөгөө талаас ажил олгогчдын 18% ажлын байрны тохируулга хийхэд зардал их гардаг гэж хариулсан байгаагаас харахад Хөгжлийн Бэрхшээлтэй ажилтан ажилдаа амжилт гаргах, ажлын байраа хадгалхад чухал ач холбогдолтой ажлын байрын тохируулга хийх зардлын тодорхой хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох зохицуулалт хийх, ажил олгогчид хувь хүний ажлын байрын тохируулгын талаар зөв мэдлэг, ойлголт өгч хандалгыг өөрчлөх.
- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй хүн ажлаас гарсан шалтгаанаа хэт их ачаалалтай байсан гэж 12%, харин ажил олгогчид Хөгжлийн Бэрхшээлтэй хүн ачаалал даах чадваргүй гэж 11% нь хариулсан байгаагаас харахад зуучлагч болон ажил олгогч Хөгжлийн Бэрхшээлтэй ажилтны ажил үүргийн хувиар дээр хамтран ажилдаггүйг илтгэж байна.
- ✓ Хөгжлийн Бэрхшээлтэй хүн ажлаасаа гарсан шалтгаанаа цалингүй ажиллаж байсан гэж

8% тодорхойлсон, харин ажил олгогчид Хөгжлийн Бэрхшээлтэй хүн чадвар муутай байдаг өөрөөр хэлбэл ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцээгүй гэжээ. Хөгжлийн Бэрхшээлтэй хүнийг ажилд зуучлахдаа тэдний онцлог хэрэгцээг үл анзааран шууд зуучлаад орхидог учраас хөдөлмөрийн харилцаа үүсгэж чадалгүй ажлаас гарсан байна.

Судалгаанаас үзэхэд Хөгжлийн Бэрхшээлтэй хүнийг тогтвортой, ажил олгогчийн эрэлтэд нийцсэн, тэдний онцлог хэрэгцээ шаардлага, бэрхшээлийн хэлбэрт тохирсон ажлын байраанд зуучлахад Хөгжлийн Бэрхшээлтэй хүнийг тодорхой хугацаанд хөдөлмөрт бэлтгэж, ажил олгогчтой холбоо тогтоож ажлын байран дээр дадлагажуулах үйлчилгээний цогц хөтөлбөртэй байх хэрэгцээ шаардлага байна.

Хэлцэмж

Судалгаанаас үзэхэд:

1. Хөгжлийн Бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтууд үр дүнгүй хийгдэж, сургалт, зуучлал хоёроос бодит, тогтвортой ажлын байр гарахгүй байна.

2. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээг цогцоор нь үзүүлэхгүй тав хонгийн сургалтаар хязгаарлаж байгаа нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн Хөгжлийн Бэрхшээлтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагаанд хүндрэл учруулж ямар ч үр дүнгүй байна

3. Ажил хөдөлмөрт бэлтгэгдээгүй зөвхөн ажил хийх хүсэлтэй хүнийг бүртгэж аваад шууд зуучилж байгаа нь ажил олгогчдод Хөгжлийн Бэрхшээлтэй хүн мэдлэг, чадваргүй, ачаалал дааж ажиллах боломжгүй гэдэг сөрөг хандлагыг бий болгож байна.

4. Хөгжлийн Бэрхшээлтэй хүнд би ажил хийж чадахгүй юм байна гэж өөрийгөө голох, хүмүүс намайг Хөгжлийн Бэрхшээлтэй болхоор дорд үзээд байна гэдэг сөрөг бодлыг бий болгож улмаар хөдөлмөр эрхлэх хүсэлгүй болгодог.

5. Үүнээс үзэхэд ажил олгогчийн эрэлтэд нийцсэн хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг бэлтгэж улмаар тогтвортой байнгын ажлын байруудыг бий болгох цогц үйлчилгээний бие даасан хөтөлбөртэй байх.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн үндэсний хэмжээний нарийвчилсан судалгаатай байх хэрэгцээ шаардлага.

НОМ ЗҮЙ

1. Хөдөлмөр эрхлэх боломж: Б. Гүнжилмаа, Д. Тулгамаа хуудас: 19- 29
2. Ажилд орох замд “Ажил хайгч ХБИ зориулсан гарын авлага” ОУХБ Хуудас 4- 9
3. ХБИ ажил олоход нь туслах ОУХБ хуудас 4- 14
4. ҮСХ Хүн ам, орон сууцны тооллого 2010s: ХБ хүн ам, Монограф ҮСХ, Улаанбаатар
5. Ажиллах хүчний судалгаа 2018 Монгол улсын ХБИ эдийн засгийн эрхийг үнэлэх судалгааны тайлан
6. Тэгш нийгэм ТББ,Европын холбоо, AIFO 2018 хуудас 17- 25

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ СУДЛАХ НЬ

Г.Уянга¹

¹АДТГ-ын НБХ-ийн хүн амзүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж заасан. Манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ болон олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог дэмжих, хамгааллыг сайжруулах хүрээнд бодлого, эрх зүйн орчноо сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал 2016 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль батлагдаж, хуулийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Дээрх хууль, тогтоомж хэрэгжсэнээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмж гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэс бүрдсэн. Харамсалтай нь Монголын өнөөгийн нийгэмд Хөгжлийн бэрхшээл гэдэг ойлголтыг зөвхөн тухайн хувь хүнтэй холбон ойлгож хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг юу ч хийж, бүтээж чадахгүй сул дорой хүн гэсэн ойлголт давамгайлж, тэдний нийгмийн оролцоо бодит байдал дээрээ бүрэн хангагдаж чадахгүй байсаар байна. Гэтэл дэлхийн бусад олон улсад Хөгжлийн бэрхшээл гэсэн ойлголт нь зөвхөн хувь хүндээ биш нийгэмд хамааралтай хэмээн үзэж “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт хандлага давамгайлах байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл бидний хүссэн үедээ авч чаддаг эрүүл мэнд, боловсрол, үзвэр үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, тээвэр гэх мэт олон зуун үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй

иргэд яг ижил хүртэж чадалгүй нийгмээс тусгаарлагдадаг. Тэгэхээр “бэрхшээл гэдэг бол эдгээр үйлчилгээг авахад үүсэж буй орчны саад юм” гэж үзэж тэдгээр саад бэрхшээлүүдийг арилгах тал дээр түлхүү анхаарал тавьж, шийдвэрлэдэг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд бидэнтэй ижил хүссэн үйлчилгээгээ авах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжих, ажиллаж хөдөлмөрлөх, хэн нэгний тусламжгүйгээр чөлөөтэй үйлчлүүлэхэд нь ямар нэгэн саадгүй байх нийгмийн болоод орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оруулах, ажилтай, орлоготой болгож хамт олон дунд хөгжүүлэх нь нэн чухал үйл явц юм. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй ч ажиллая, хийж бүтээе гэсэн хүсэл эрмэлзэлтэй боловч хувийн болоод нийгмийн олон арван шалтгаанаас болоод бусдын адил ажиллаж, хөдөлмөрлөж чадахгүй гэртээ сууж байгаа олон зуун хүн байгаа билээ.

Үндэслэл

“Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030”-ийн 8 дугаар зорилт нь “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих”-д чиглэнэ гэсэн байдаг. Энэхүү зорилгынхоо хүрээнд 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн.

Тэгвэл яг энэ зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай ижил хөдөлмөрлөж, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэн хүн болж төрснийхөө үнэ цэнийг мэдэрч идэвх оролцоотой, өөртөө итгэлтэй иргэн болгон хөгжүүлэх нь төр засгийн бодлого шийдвэр, иргэдийн ойлголт хандлагаас шууд хамааралтай юм. Тиймээс энгийн иргэд бид ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг харах өнцөг, ойлгох

ойлголтоо өөрчлөн биднээс өөр хүмүүс биш харин ажлын хамтрагч, анд найзууд хэмээн үзэж тэдэнд тулгардаг саад, бэрхшээлүүдийг хамт шийдвэрлэж, хамтдаа хөгжих нь улс орны хөгжил дэвшилд оруулах үнэтэй хувь нэмэр билээ.

Хэнтий аймгийн хувьд хүн амын тоо 76 мянга бөгөөд нийт хүн амын 4.2 хувь буюу 3200 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Үүнээс хөдөлмөрийн насны 2624 иргэн байгаагаас ажил эрхэлдэг 575, ажилгүй 2049 иргэн байна. Ажилтай иргэдийн 156 нь төрийн байгууллагад, 419 нь хувийн байгууллага болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд эдгээр ажиллагсдын 217 нь эмэгтэй байна. Харин хөдөлмөр эрхлэх боломжтой боловч ажилгүй байгаа 1129 иргэн байгаагаас эмэгтэй 786 байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 61 иргэнийг хамруулж 164 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн энэ хугацаанд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажил хайгчаар бүртгүүлсэн 110 хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн байгаа бөгөөд тэдний 61 хувь нь ажлын байранд зуучлагдсан байна.

Дээрх мэдээллээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрт тохирсон ажил хөдөлмөр эрхлэх боломж байна. Гэтэл яагаад 1129 иргэн ажилгүй орлогогүй байна вэ? Тиймээс хөдөлмөрийн чадвартай ч ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүй байгаа шалтгаан, тэднийг ажилтай, орлоготой болгох боломж цаашлаад Хэнтий аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг судлах шаардлага, хэрэгцээ байна.

Зорилго

Хөдөлмөрийн чадвартай ч ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүй байгаа шалтгаан нөхцөлийг судлан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох

Зорилт

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дахь заалтыг хэрэгжүүлдэг болон хэрэгжүүлдэггүй байгууллагуудын давуу болон сул талыг судлах
2. Хөдөлмөрийн чадвартай ч ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүй байгаа шалтгаанд дүн шинжилгээ хийх

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох

Судалгааны арга зүй

- **Түүврийн арга:** Аж ахуйн нэгж байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгох
- **Ганцаарчилсан ярилцлага:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаг болон 25, түүнээс дээш ажилтантай боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаггүй аж ахуйн нэгж байгууллагын хүний нөөцийн ажилтан, Хөдөлмөр эрхэлж буй болон ажилгүй байгаа ХБИ
- **Баримт бичгийн судалгаа:** 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагын мэдээ, хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээ – Нийгмийн даатгалын хэлтэс, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээ – Татварын хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлсөн аж ахуйн нэгж байгууллагын мэдээ, Ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээ – Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- **Харьцуулалтын арга:** Хөдөлмөр эрхэлдэг болон эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаг болон ажиллуулдаггүй аж ахуйн нэгж байгууллага
- **Асуумжийн арга:** Урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс авах

Судалгаа, судалгааны үр дүн

2018 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 25, түүнээс дээш ажилтантай 92 аж ахуйн нэгж байна. Үүнээс 56.5 хувь нь буюу 53 байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна. Гэвч Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалт дахь квотын дагуу ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага 36.9 хувьтай буюу 34 байна. Харин огт хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаггүй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлдөггүй 35 байгууллага байгаа бол төлбөрөө төлдөг 4 байгууллага байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаг 10

байгууллагын хүний нөөцтэй дараах асуултын дагуу Фокус ярилцлага хийсэн.

1. Танай байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх заалтан дахь квотын дагуу ажиллуулж байгаа юу? гэсэн асуултад 4 байгууллага тийм, 6 байгууллага квотдоо хүрэхгүй гэж хариулсан.
2. Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх заалтыг хэрэгжүүлдэг үү? гэсэн асуултад 3 байгууллага тийм, 7 байгууллага үгүй гэж хариулсан бөгөөд хуулийн энэ заалтыг мэдэхгүй байгаа 2 хүний нөөц байсан.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулахад хүндрэлтэй зүйл байдаг уу? гэсэн асуултад тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тааруулж ажлын байрны тохируулга хийж богиносгосон цагаар ажиллуулах болдог, ажлын ачаалал даах чадвар муу байдаг учир цаг үеийн шинжтэй зарим ажлыг илүү цагаар хийх боломжгүй, хурд удаан, бүтээмж бага байдаг, мэргэжлийн ур чадварын хувьд хангалтгүй, ар гэрийн асуудал их бөгөөд ойр ойрхон чөлөө авдаг, үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй, тогтвортой ажиллах хүсэлгүй гэх мэт хариулт өгч байв.
4. Тэгвэл давуу тал байдаг уу? гэхэд хуулиа сахин биелүүлж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байна, татварын хөнгөлөлт, чөлөөлт эдэлдэг гэх мэтээр хариулсан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй 10 байгууллагын хүний нөөцтэй ярилцахад

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтан дахь квотын дагуу танай байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн ажиллуулах ёстойг мэдэж байна уу? гэсэн асуултад 7 нь тийм, 3 нь үгүй гэж хариулсан.
2. Ямар шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй вэ? гэсэн асуултад мэдлэг, ур чадвар шаардлагад нийцдэггүй, удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах сонирхолгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжтой

ажлын байр байхгүй, ажлын байрны орчин нөхцөлөө хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохируулан өөрчлөх шаардлага гарна, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орохоор хандаж байгаагүй гэсэн хариултауд өгсөн.

3. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2 дахь заалтыг хэрэгжүүлдэг үү? гэсэн асуултад 4 нь тийм, 5 нь үгүй, 1 нь мэдэхгүй гэж хариулав.
4. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах талаар ямар бодолтой байна вэ? гэхэд 2 нь сар бүр төлбөр төлж байхаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах тал дээр анхаарч ажиллана, 3 нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бол 4 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах сонирхолгүй бөгөөд боломжгүй учир хуулиа хэрэгжүүлж сар бүр төлбөрөө төлж байна, 1 нь сайн мэдэхгүй байна гэж хариулсан юм.

Харин ажил хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнээс санамсаргүй түүврээр 10 хүнтэй ярилцахад


1. Тухайн ажлын байрандаа хэр удаан хугацаанд ажиллаж байна вэ? гэсэн асуултад 1 хүн 11 жил ажиллаж байна гэсэн бол 9 нь 1-6 жилийн хугацаанд ажиллаж байгаа гэсэн.
2. Таны боловсролын түвшин, эзэмшсэн мэргэжил юу вэ? гэсэн асуултад 3 нь дээд боловсролтой, 2 нь мэргэжлийн боловсролтой, 1 нь дипломын, 4 нь мэргэжилгүй гэж хариулсан.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй зүйл байдаг уу? гэсэн асуултад гадаад төрх, бие бялдрын хөгжил муу учир өөртөө итгэлгүй байдаг, боловсролын түвшин ажлын туршлага дутдаг, ажилдаа ирж очиход зам талбай, замын хөдөлгөөний асуудал хүндрэлтэй байдаг, ар гэрийн дэмжлэг муу, хүмүүсийн харилцаа хандлага тааламжгүй байдаг гэх мэтээр хариулсан.

Хөдөлмөрийн чадвартай ч ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй 180 иргэнээс асуумжийн аргаар авсан судалгааны үр дүн:

1. Та өмнө нь ямар нэг ажил, хөдөлмөр эрхэлж байсан уу?




2. Хөдөлмөрийн чадвар алдсанаасаа хойш хийж байсан ажлаа хэр удаан хугацаанд хийсэн бэ?



3. Дээрх хугацаанд хийж байсан ажлаасаа ямар шалтгаанаар гарсан бэ?



4. Хөдөлмөрийн хэлтсээр болон хувиараа ажил хайж, бүртгүүлж байсан уу? /1 дүгээр асуултанд "үгүй" гэж хариулсан бол хариулна/





Асуулт 7: Та нийгмийн даатгалын болон халамжийн сангаас ямар ямар тэтгэмж авдаг вэ? /тэтгэмжийн төрөл болон мөнгөн дүнг бичих/ гэсэн асуултад хариулсан 137 хүний 82 хувь нь 140-320 мянган төгрөгийн 2-3 төрлийн тэтгэмж авдаг гэж хариулжээ.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаг болон ажиллуулдаггүй байгууллагын хүний нөөцийн ажилтан, ажиллаж байгаа болон ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авсан судалгааны үр дүнгээс дүгнэж үзэхэд:

25, түүнээс дээш ажилтантай байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаг боловч Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын дагуу квотдоо хүрдэггүй бөгөөд тус хуулийн 111.2 дахь заалтын хэрэгжилт ч мөн адил хангалтгүй байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай 111.1, 111.2, 71.1 дэх заалтуудыг мэддэггүй аж ахуйн нэгж байгууллагууд цөөнгүй байдаг нь фокус ярилцлагаар харагдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаг байгууллагын хувьд тэдний онцлогт тохируулан ажлын байрны тохируулга хийдэг, ажлын ачаалал даах чадвар муу, хурд удаан, бүтээмж бага, мэргэжлийн ур чадвар хангалтгүй, ар гэрийн асуудал ихтэй, үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй, тогтвортой ажиллах хүсэлгүй гэх мэт олон хүндрэлүүд байдаг бол хуулиа сахин биелүүлж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, татварын хөнгөлөлт, чөлөөлт эдлэх боломжтой байдаг нь давуу тал болдог байна.

Харин зарим байгууллагын хувьд удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах сонирхолгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжтой ажлын байр байхгүй,

хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орохоор хандаж байгаагүй гэсэн шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй байна. Эдгээр байгууллагын ихэнх нь цаашид сар бүр төлбөр төлж байхаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах тал дээр анхаарч ажиллана гэсэн бол үлдсэн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах сонирхолгүй бөгөөд боломжгүй учир хуулиа хэрэгжүүлж сар бүр төлбөрөө төлж байгаа илэрхийлжээ.

Ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд ярилцсан 10 хүний 9 нь тухайн байгууллагадаа 1-6 жилийн хугацаанд ажиллаж байгаа бөгөөд гадаад төрх, бие бялдрын хөгжил муу учир өөртөө итгэлгүй байдаг, боловсролын түвшин ажлын туршлага дутдаг, ажилдаа ирж очиход зам талбай, замын хөдөлгөөний асуудал хүндрэлтэй байдаг, ар гэрийн дэмжлэг муу, хүмүүсийн харилцаа хандлага тааламжгүй байдал нь ажиллахад хүндрэлтэй байдаг гэсэн юм. Боловсролын хувьд тэдний ихэнх нь мэргэжилгүй ажилтан байлаа.

Хөдөлмөрийн чадвартай ч ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй 180 иргэнээс авсан асуумжийн хувьд Хөдөлмөрийн чадвар алдахаасаа өмнө ажиллаж байсан 78 иргэн байсан бол урьд нь ямар нэг ажил огт хийж байгаагүй 63 иргэн байгаа бөгөөд тэдний талаас илүү хувь нь хөдөлмөрийн хэлтсээр болон хувиараа ажил хайж байгаагүй гэсэн байна. Харин хөдөлмөрийн чадвар алдсанаасаа хойш ажил хийж байсан хүмүүс тухайн ажилдаа удаагүй бөгөөд 3 сараас 2 жилийн хугацаанд ажиллаж байжээ.

Тэдний ихэнх нь ажиллаж байх хугацаандаа ядарч, биеийн байдал муудсан учир ажлаасаа гарсан бол үлдсэн хувь нь ажлын байрны

нөхцөл, орчин хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирохгүй хүндрэлтэй байсан, ар гэрийн зүгээс тусламж дэмжлэг муу, нийгэм хамт олны зүгээс хандах хандлага тааламжгүй байсан зэрэг шалтгаанаар ажлаасаа гарчээ.

Өөрт тохирсон ажил, хөдөлмөр эрхэлбэр гэж боддог уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 62 хувь нь үгүй, заримдаа гэж хариулсан нь маш өндөр тоо бөгөөд 82 хувь нь халамжийн тэтгэмж, хүнсний талон авдаг иргэд байна.

Мөн эдгээр иргэдийн 85 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг мэддэггүй нь 6 дугаар асуултанд хариулсан байдлаас харагдаж байна.

Дээрх судалгаанд хамрагдсан 180 хүнийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл харааны бэрхшээлтэй – 8%, хэл ярианы бэрхшээлтэй – 12%, сэтгэц – 7%, туслах эрхтний бэрхшээлтэй – 27%, дотор эрхтний бэрхшээлтэй – 19%, тулгуур эрхтний бэрхшээлтэй – 14%, саажилттай – 6%, сонсголын бэрхшээлтэй – 7% байна.

Эдгээр иргэдийн 39 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй бол 61 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар нь авч үзвэл 4% нь хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсан бол 40-с бага хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай 14%, 40-50 хувийн алдалттай 25%, 60-70 хувийн алдалттай 42%, 80-90 хувийн алдалттай 15% байна. Дээр дурдсан хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг харахад 70-80 хувь нь өөрт тохирсон хөдөлмөр эрхлэх бүрэн боломжтой иргэд байна.

Санал, зөвлөмж

Төрийн бодлогод оруулах санал:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2, 71.1 дэх заалтууд болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, ажил олгогчийн урамшууллын талаарх мэдээллийг хүртээмжтэй болгож төлбөр төлөх нь чухал биш тухайн иргэнийг ажлын байраар хангах нь чухал гэдгийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж, бололцоог харгалзан квотыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоох
- Ажил олгогчийн урамшууллын дүнг нэмж

квотоос илүү ажиллуулсан ажил олгогчдыг урамшуулах, олон нийтэд сурталчлах, тохируулгатай ажлын байр бүрдүүлсэн тохиолдолд гаргасан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй болон одой иргэнийг ажиллуулаагүй 51-ээс дээш ажиллагсадтай байгууллагын төлбөр төлөх хувийг нэмэгдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 1 жил төлбөр төлсөн байгууллагад дараагийн жил хөнгөлөлт үзүүлэх
- Группд байгаа хүн бүрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх нь өрөөсгөл тул хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэх чадварыг зөв тодорхойлсон мэдээллийн санг хөгжүүлж ойлголт, тодорхойлолтыг тодруулах

Аймаг орон нутгийн бодлогод оруулах санал:

- Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд ажил хайгчаар бүртгүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээллийг аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэх, санал болгох, зуучлалын үүргээ сайжруулах, төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг хүртээмжтэй болгох
- Хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх
- Дэд бүтцийг хүртээмжтэй болгох
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Төрийн болон Төрийн бус байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг чадвахжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, боломж бололцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглүүлэх

Ажил олгогчдод хандсан санал:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дахь заалтыг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах орон тоог бүрэн ашиглаж одоо байгаа сул орон тоог дүүргэх
- Тухайн иргэний онцлогт тохируулан ажлын байрны орчин нөхцөлийг бүрдүүлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 71.1 дэх

заалтыг хэрэгжүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ялгаварлан гадуурхалгүй харилцах, ижил хөдөлмөрт адил цалин хөлс олгох

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан санал:

- Аймаг орон нутгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгчаар бүртгүүлэх
- Өөрийн хийж чаддаг зүйл авьяас чадвараа илрүүлж, хөгжүүлэх
- Өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэн амьдралын үнэ цэнийг мэдрэх
- Өөрийн хийж чадах зүйлээр хувиараа хөдөлмөр эрхлэх
- Мэдээллийн олон эх сурвалжуудаас хууль зүйн болон төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг байнга авч байх
- Аль болох бие дааж нийгмийн идэвх оролцоогоо нэмэгдүүлэн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох гэх мэт

Ном зүй

1. “Хөдөлмөрийн тухай” хууль УБ., 1999
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль УБ., 2016
3. Хэнтий аймгийн статистикийн хэлтэс “Хэнтий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал” 2018/12
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа” мэдээллийн лавлах УБ., 2017
5. Алтансүх М. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа УБ., 2019

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

М.Уянга¹, Т.Золзаяа¹

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

Хураангуй

Манай улсад 2018 оны байдлаар 105.7 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн /ХБИ/ байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Энэхүү судалгаагаар Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2 дах заалтыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага /ААНБ/-уудын захиргааны тоон мэдээнд баримт бичгийн судалгаа хийж, мөн уг заалтуудыг хэрэгжүүлж байгаа болон хуулийг үл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл болсон 117 ААНБ, хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хайж буй 142 ХБИ-ээс ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авч ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, цаашид тэдний хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн нэмэгдүүлэх арга замыг тодорхойлохыг хичээлээ.

НДЕГ-ын мэдээллийн санд 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 25, түүнээс дээш ажиллагчидтай буюу Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх нийт 5.2 мянган шимтгэл төлөгч байгууллага бүртгэлтэй байгаагаас 2.0 мянга гаруй байгууллагад 4.9 мянган ХБИ хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн тус заалт бүрэн хэрэгжсэн бол 5.2 мянган байгууллагад 19.5 мянган ХБИ ажиллах боломжтой бөгөөд одоо ажиллаж буй иргэдээс гадна 14.6 мянган ХБИ ажлын байртай болох боломж байгаа юм.

Түлхүүр үг

Хуулийн хэрэгжилт, тусгай ажлын байр, ажлын байрны тохируулга

Үндэслэл

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил, хөдөлмөрийн бүхий л түвшинд ажиллаж хувь нэмрээ оруулж байна. Гэсэн хэдий ч ажил, хөдөлмөр хийхийг хүсч байгаа боловч олон саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон бий. Манай улсад 2017 оны байдлаар хөдөлмөрийн насны 73.2 мянган ХБИ ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод буй юм.

Өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, чадавхид үндэслэн тусгай ажлын байр бий болгох, тэдний боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядууралд өртөхөөс хамгаалах зайлшгүй шаардлагатай байгаа тул тэдэнд хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох хэрэгцээ байгаа юм.

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар төрийн болон ТББ-аас зохион байгуулж хийсэн судалгаа шинжилгээний ажил цөөнгүй байгаа ба томоохон ажлуудаас дурдахад:

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай” Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, 2017 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн үнэлгээ” IRIM судалгааны хүрээлэн, 2016 он
- “Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох” судалгаа IRIM судалгааны хүрээлэн, 2015 он

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1¹, 111.2² дах хэсэг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, тушаал, журмын хэрэгжилтийг үнэлэх, биелэлийг сайжруулах арга замыг тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулах юм.

Судалгааны зорилтууд

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Холбогдох захиргааны мэдээнд дүн шинжилгээ хийх;

¹ 111.1. 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна.

² 111.2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.

- Хуулийг хэрэгжүүлэхэд ААНБ-уудад тулгардаг бэрхшээлийг илрүүлэх;
- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох, зөвлөмж боловсруулах;

Судалгааны арга зүй

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль нь бүх нийтэд ижил үйлчилдэг учир судалгаанд газар зүйн бүс бүрээс нэг аймаг хамруулахаар төлөвлөж, сонгогдсон аймаг бүрд төвийн болон алслагдмал 1 сумыг, нийслэлийн хувьд төвийн 6 дүүргийг сонгож судалгаанд хамруулав.

Ганцаарчилсан ярилцлага: Судалгааны мэдээллийг Байгууллагын болон Хувь хүний гэсэн үндсэн 2 төрлийн асуулгаар цуглуулсан. Судалгаанд оролцогчдоос цуглуулсан мэдээллийг программд хөрвүүлэхэд CPro, үр

дүнг боловсруулж, анализ хийхэд Stata програм хангамжийг ашигласан.


Баримт бичгийн судалгаа: Холбогдох захиргааны тоон мэдээнд дүн шинжилгээ хийсэн.

Өнөөгийн байдал

2018 оны 3 дугаар улирлын байдлаар ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, 25-аас дээш ажилтантай 5.4 мянган ААНБ байна.

НДЕГ-ын мэдээгээр 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 25, түүнээс дээш ажиллагчидтай 5.2 мянган ААНБ байгаагаас 2061 ААНБ-д 4921 ХБИ ажиллаж байна. Эдгээрээс хуулийн дагуу буюу квотыг ханган ажиллуулж байгаа 863 ААНБ байгаа бол 1198 ААНБ нь хуулинд заасан квотоос бага хэмжээнд ХБИ ажиллуулж байгаа юм.

Зураг 1: Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтийн хэрэгжилт, салбараар



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зургаас харахад эдийн засгийн 18 салбарт ХБИ-ийг 50-иас доош хувьтай ажиллуулж байна. ХБИ-ийг хамгийн ихээр ажиллуулж буй салбарууд нь ус хангамж, боловсрол, эрүүл мэндийн салбарууд байгаа тээвэр болон барилгын салбарууд хамгийн бага хувьтай ажиллуулж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2 дах заалтын дагуу ХЭДС-д төлбөр төлөгч ААНБ-уудын мэдээг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. ХЭДС-д төлбөр төлсөн ААНБ-ын тоо, өмчийн хэлбэрээр

	2017.12.31	Дүнд эзлэх хувь	2018.11.30	Дүнд эзлэх хувь
Төлбөр төлсөн байгууллагын тоо	300	100.0	266	100.0
Үүнээс: Төрийн өмчит	71	23.7	27	10.1
Хувийн	229	76.3	239	89.9

Эх сурвалж: ХХҮЕГ


Хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалан уул уурхай, олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ууд ХБИ-ийг ажиллаагүй орон тоонд ногдох төлбөрийн 37.4 хувийг бүрдүүлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Судалгааны үр дүн

1. Аж ахуйн нэгж, байгууллага дахь хуулийн хэрэгжилтийн байдал

Судалгаанд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг үндэслэн 25, түүнээс дээш ажилтантай ААНБ-аас түүвэрлэн 117 ААНБ-ыг хамруулсаны 50.4 хувь нь хувийн, 39.3 хувь нь төрийн, 10.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ байлаа.

Зураг 2: Судалгаанд хамрагдсан ААНБ-уудын дэд бүтцийн хүртээмжтэй байдал, өмчийн хэлбэр, хувиар




Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувьд хүртээмжтэй орчин хангалттай бүрдээгүй байна. Судалгаанд хамрагдсан гурван ААНБ тутмын хоёр (59.0 хувь) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж, гарахад зориулсан налуу замтай байсан боловч тэдгээрийн ихэнх нь стандартийн бус, огцом замтай байлаа. Харин хараагүй хүнд зориулсан хөтөч зам (8.5 хувь) болон өрөөний дугаарын брайль тэмдэглэгээ (7.7 хувь)-тэй байгууллага цөөн байна. Дээрх үзүүлэлтийг өмчийн хэлбэрээр тодруулвал гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын орчин нь бусад өмчлөлийн ААНБ-аас илүү ХБИ-д хүртээмжтэй байна. Харин төрийн ААНБ-уудын орчны хүртээмж нь бусад өмчлөлийн ААНБ-аас бага байна.

1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ажил олгогч

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-аас 46.2 хувь нь хуулийн дагуу ХБИ ажиллуулж байна. ААНБ-уудад ажиллаж буй ХБИ-ийн 38.9 хувь нь бусад буюу ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан, 21.9 хувь нь хөдөлгөөний, 13.3 хувь нь сонсголын, 8.0 хувь нь харааны, 8.0 хувь

нь ярианы бэрхшээлтэй иргэд байсан.


Зураг 3: ХБИ-ийн дундаж цалин, ААНБ-ын өмчийн хэлбэр, мянган төгрөгөөр



Мөн судалгааны дүнгээр ХБИ-ийн дундаж цалин 576.1 мянган төгрөг байгаа нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх улсын дундаж цалин /1,031.8 мянган төгрөг/-тай харьцуулахад ойролцоогоор 1.8 дахин бага байна. Өмчийн хэлбэрээр харвал төрийн өмчийн ААНБ-д ажиллаж буй ХБИ дунджаар 546.5 мянган төгрөг, хувийн ААНБ-д ажиллаж буй ХБИ 607.2 мянган төгрөгийн цалин авч байна.

Судалгааны дүнгээр ажил олгогч байгууллагуудын 27.1 хувь нь эрүүл мэнд, 19.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 10.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байсан.

Зураг 4: ААНБ-ууд ХБИ-д зориулж ажлын байрны тохируулга хийдэг хувь, хэлбэрээр



Дээрх графикаас харахад төрийн өмчит ААНБ ажлын байрны тохируулга хамгийн бага хийдэг бол гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-уудад тус үзүүлэлт харьцангуй өндөр байна.


ААНБ-уудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаа сургалтад хамруулах нь харьцангуй сайн (78.6) байна. Төрийн өмчийн ААНБ-ууд ХБИ-ийг ажиллуулахдаа ажлын байрны тохируулга бага хийдэг хэдий ч тэднийг мэдлэг чадвараа хөгжүүлэх чиглэлийн сургалтад хамгийн сайн (81.8 хувь) хамруулдаг байна. ХБИ-ийг ажиллуулсанаар тухайн ААНБ-д ямар давуу тал болон бэрхшээл тулгардаг эсэхийг тодруулав.

Хүснэгт 2: ХБИ-ийг ажиллуулахын давуу тал болон хүндрэл, бэрхшээл

Давуу тал	Хүндрэл бэрхшээл
<ul style="list-style-type: none"> ✓ 61.4% - Хуулиа сахин биелүүлэх ✓ 58.6% - ХБИ тогтвортой ажилладаг ✓ 55.7% - Нийгмийн хариуцлагаа ухамсарлах ✓ 54.3% - Хүний нөөцөө хангах ✓ 25.7% - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх ✓ 14.3% - Мэргэжлийн ур чадвар, ховор авьяас ашиглах 	<ul style="list-style-type: none"> • 20% - Ажлын байрны тохируулга хийх • 15.7% - Ажлын ачаалал даах чадвар муу • 12.9% - Хурд удаан, бүтээмж бага • 10% - Мэргэжлийн ур чадвар хангалтгүй, ар гэрийн асуудал их • 5.7% - Үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй, тогтвортой ажиллах хүсэлгүй

1.2 ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлж буй байгууллагууд

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-аас 29.9 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-т заасны дагуу буюу хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлж байна. Төлбөр төлж буй байгууллагуудын 54.3 хувь нь 1 жил хүртэлх хугацаанд, 28.6 хувь нь 1-2 жил, үлдсэн 17.1 хувь нь 2-оос дээш жил төлж байна.



Зураг 5: Төлбөр төлж буй шалтгаан

Тэдгээр байгууллагуудын 82.9 хувь нь сар бүр төлбөр төлөх нь хүндрэлтэй байдаг тул цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн

бол 17.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахгүй, цаашид хуулиа хэрэгжүүлэн сар бүр төлбөрөө төлнө хэмээн хариулжээ.

1.3 Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй ААНБ-ууд

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-аас 23.9 хувь нь буюу Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй байгууллагыг сонгосон. Судалгаанд хамрагдсан хуулийг үл

хэрэгжүүлэгч ААНБ-уудын хувьд ажилчдын тооноос хамаараад хамгийн их нь 25, бага нь 1 орон тоонд, нийт 120 орон тоонд ХБИ ажиллах үүрэгтэй хэдий ч ХБИ ажиллуулаагүй, ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлөөгүй байна.

Зураг 6: Хуулийг хэрэгжүүлдэггүй шалтгаан, хувиар




Уг хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй ААНБ-уудыг шалтгаанаар авч үзвэл дөрөвний гуравт (74.1 хувь) ХБИ ажилд орохоор хандаж байгаагүй бөгөөд 55.6 хувьд нь ХБИ-ийн ур чадвар шаардлагад нь нийцдэггүй, 40.7 хувь нь ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй, 22.2 хувь нь ХБИ ажиллуулах сонирхолгүй байдаг гэжээ. Судалгаанд оролцогчдын 63.7 хувь нь цаашид хуулиа хэрэгжүүлэн ХБИ-ийг ажиллуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бол 24.2 хувь нь мэдэхгүй, 12.1 хувь нь ажиллуулах сонирхолгүй байна хэмээн хариулсан байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн санал бодлыг сонсох, тэдэнд хөдөлмөр эрхлэхэд тохиолдож буй хүндрэл бэрхшээл, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан зэргийг тодруулахаар хөдөлмөрийн насны 142 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг судалгаанд хамрууллаа. Тэдний 50.7 хувь нь хөдөлмөр эрхэлж буй, 49.3 хувь нь ажилгүй иргэд байсан бөгөөд хүйсээр авч үзвэл 45.8 хувь нь эрэгтэй, 54.2 хувь нь эмэгтэй байна.

Зураг 7: Судалгаанд хамрагдсан иргэд, хөдөлмөр эрхлэдэг эсэх, боловсролын түвшин, хувиар



Ажил эрхлэх нь тухайн хүний эзэмшсэн боловсролын түвшинтэй шууд хамааралтай байна. Боловсролын түвшин нэмэгдэх тутам хөдөлмөр эрхлэж буй хувь нэмэгдэж байна.


Суурь боловсролтой иргэдийн 20.0 хувь нь хөдөлмөр эрхлэж байгаа бол дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэдийн 73.5 хувь, магистр түүнээс дээш боловсролтой

ХБИ 100.0 хөдөлмөр эрхлэж байна. ҮСХ-ны мэдээгээр 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өрхийн сарын дундаж мөнгөн орлого 1074.8 мянган төгрөг, өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 1123.2 мянган төгрөг байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 90.1 хувь нь улсын дунджаас доогуур өрхийн сарын орлоготой байна.

2.1 Хөдөлмөр эрхэлж буй ХБИ

Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 94.3 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 4.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.4 хувь нь ажил олгогч байна. Судалгааны дүнгээр хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 12.5 хувь нь ажлын онцлог, шинж байдлаас хамааран ажлын цагаа богиносгох хүсэлт гаргасан бөгөөд тэдний 44.4 хувийг удирдах ажилтан нь хүлээн зөвшөөрчээ.

Зураг 8: ХБИ-ийн цалин бусад ажилчдын цалинтай харьцуулахад ямар байдаг эсэх



Хөдөлмөр эрхэлж буй ХБИ-ийн цалингийн хэмжээ ижил түвшний бусад ажилчдын цалинтай харьцуулан, тодруулвал 55.6 хувь нь адилхан, 22.2 хувь нь бага, 19.4 хувь нь мэдэхгүй, 2.8 хувь нь өндөр байдаг хэмээн хариулт өгчээ. Мөн тэдний дөрвөн хүн тутмын нэг нь цалин болон ажилдаа сэтгэл ханамж бага тул одоогийн ажлаа өөрчлөхийг хүсэж байгаагаа илэрхийлж байлаа.


Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 30.6 хувьд ажлын байрны онцлогт тохирсон тохируулга хийж өгсөн бол 69.4 хувьд ямар нэгэн тохируулга хийгээгүй байна.

2.2 Ажилгүй ХБИ:

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 52.9 хувь нь мэргэжил эзэмшсэн, 47.1 хувь нь мэргэжил эзэмшээгүй байна. Мөн тэдний гуравны хоёр нь сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн байсан хэдий ч зөвхөн 32.9 хувь нь сүүлийн долоо хоногт ажил идэвхтэй хайсан байна. Ажил хайгаагүй ХБИ-ийн 29.2 хувь нь ажил олгогчийн шалгуурт тэнцэхгүй, 22.9 хувь нь ажил олдохгүй гэж бодсон тул ажил хайгаагүй нь зонхилох шалтгаан болсон байна.

Ажилгүй байгаа ХБИ-ээс ямар шалтгаанаар ажилд орж чадахгүй байгаа, ажил хийхэд гол хүндрэл бэрхшээлийг тодрууллаа.

Зураг 9: ХБИ ажил хийхэд тулгардаг бэрхшээлүүд, хувиар



Гэр бүлийн гишүүд нь хөдөлмөр эрхлэхийг дэмжсэн эсэхийг тодруулахад 88.6 хувь нь дэмждэг, 11.4 хувь нь дэмждэггүй хэмээн хариулжээ.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт талаас нь цогцоор авч үзсэнээр нэлээд онцлог болно.

ХЭДС-д төлбөр төлсөн байгууллагыг тооцвол 20.6 хувь, квотын хувь, хэмжээнд хүрээгүй ч тодорхой тооны ХБИ ажиллуулсан, төлбөр төлсөн байгууллагыг тооцвол 44.6 хувьтай байна. Хуулийн хэрэгжилт эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л салбарт хангалтгүй байгаа бөгөөд тээвэр, барилга, мэргэжлийн болон шинжлэх ухааны салбарт бусад салбаруудаас харьцангуй доогуур байна.

Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж чадвал 14.6 мянга гаруй ХБИ-ийг ажлын байртай болгох боломж байгаа юм.

Зөвлөмж

- ✓ Хуулийн хэрэгжилтийг төлбөр төлснөөр хязгаарлах биш ХБИ ажиллуулах нь давуу тал болохыг таниулах
- ✓ Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, татварын болон ХЭДС-гийн урамшууллыг сурталчлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- ✓ Хуулийн тус заалтын хэрэгжилттэй холбоотой захиргааны тоон мэдээллийн загвараар хандлагыг улирал бүр гаргаж, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах
- ✓ ХБИ ажиллуулах квотыг ХБИ ажиллах боломж, бололцоог харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоож болох боломжийг нарийвчлан судлах
- ✓ ХБИ-ийг хөдөлмөрт зуучлах ажлыг эрчимжүүлэх, энэхүү ажилд мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг уялдуулах.

Ном зүй

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2016 оны 02 05). Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол улс.
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2011 оны 06 17). Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. Монгол улс.
3. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2012 оны 01 19). Нийгмийн халамжийн тухай хууль. Монгол улс.
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn